

ХУДАЛДААНЫ
БОДЛОГЫН
НЭР ТОМЬЁОНЫ
ТАЙЛБАР
ТОЛЬ БИЧИГ

2020 он

ДАА 380.1
ННА 65.42
Х-667

Хянан тохиолдуулсан: Доктор, профессор Нямдаагийн Отгонсайхан
(Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль)

Орчуулсан: Ахлах синхрон орчуулагч Дашнямын Сэнгэлмаа

“Интерпресс” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

Хэвлэлийн дизайнер: С.Мөнхмаа



Энэхүү хэвлэлийн агуулгыг Зөвлөх Компани
бүрэн хариуцах ба Европын Холбооны үзэл
санааг ямар нэгэн байдлаар тусгаагүй болно.

ISBN: 978-9919-20-651-2

Гадаад худалдааны бодлогоор дамжуулан эдийн засгаа тэлэх, хөгжүүлэхэд хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд ихээхэн анхаардаг. Тухайн орны эдийн засагт гадаад худалдааны үзүүлэх эерэг нөлөө өндөр байх эсэх нь төрийн оновчтой бөгөөд тогтвортой бодлого, түүнийг хэрэгжүүлэх институцийн болон хүний нөөцийн чадавх зэргээс ихээхэн шалтгаалдаг аж.

Монгол улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д гишүүнээр элсэн орсноор тус байгууллагын 160 гаруй гишүүн оронтой олон талт худалдааны тогтолцооны орчинд, 2016 оны 6 дугаар сараас Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ)-ийн, 2021 оноос Ази, номхон далайн бүсийн 6 оронтой (БНХАУ, БНСУ, БНЭУ, Бангладеш, БНАЛАУ, Шри-Ланка) Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд худалдаа эрхлэх болсон. Цаашид худалдааны зарим түнш орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудал судалгааны түвшинд яригдаж байна. Ийнхүү дэлхийн зах зээл илүү нээлттэй болж байгаагийн зэрэгцээ худалдааны түнш орнуудын хоорондын “худалдааны дайн”, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйл (тухайлбал Ковид-19) зэрэг нь бидэнд ихээхэн сорилтыг бий болголоо.

Гадаад худалдаанаас бий болох үр ашгийг нэмэгдүүлэх, худалдааг хөнгөвчлөхийн тулд олон талт болон бүс нутгийн, мөн хоёр талт худалдааны тогтолцооны үндсэн зарчимд үндэслэн Монгол улсын худалдааны бодлого, эрхзүйн орчныг улам бүр шинэчлэн сайжруулах, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах арга механизмыг үр ашигтай ашиглах шаардлага бий болсоор байгаа билээ. Түүнчлэн үүсэж болох эрсдэлийг урьдчилан харж өөрчлөлтөд бэлдэх, ирж буй боломжуудыг ашиглахад бэлэн байх нь чухал болж байна.

Тиймээс олон улсын худалдааны бодлогын нийтлэг нэр томьёо, ойлголтыг эх хэлээр оновчтой буулгах, тухайн салбарын хүрээнд нэгдмэл ойлголттой болох нь онцгой ач холбогдол өгөх чухал асуудлуудын нэг болоод байгаа юм.

“Худалдааны бодлогын нэр томьёоны тайлбар толь бичиг”-т худалдааны бодлогын үндсэн нэр томьёо төдийгүй ДХБ-ын болон худалдааны бусад олон талт хэлэлцээрүүд, тэдгээрийн хүрээнд гишүүн орнуудын хооронд үүссэн зарим гол маргааныг шийдвэрлэсэн тохиолдол, бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийг хамруулснаас гадна хөдөө аж ахуй, нэхмэл сүлжмэл, тээвэр, хөрөнгө оруулалт, үйлчилгээ, оюуны өмч, санхүүгийн зэрэг салбарын худалдааны бодлого болон салбар дундын бодлогын асуудал, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого зохицуулалтын талаар 1500 гаруй нэр томьёог тусгасан нь уншигчид олон улсын худалдааны бодлогын өргөн цар хүрээтэй ойлголтыг өгч чадна хэмээн үзэж байна.

Уг тайлбар толь нь Монгол улсын гадаад худалдааны салбарын бодлого, эрхзүйн баримт бичгийг боловсруулах болон хэрэгжүүлэхэд шууд болон шууд бусаар оролцох боломжтой төрийн болон төрийн бус байгууллага, хөгжлийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоод, бизнес эрхлэгчид, судлаачид, хуульч, арбиртч, өмгөөлөгч, их дээд сургуулийн багш, суралцагчид болон худалдааны бодлогыг сонирхон уншигч хэн бүхний мэдлэгийн хүрээг тэлж, шинэ мэдлэг эзэмшихэд тань томоохон хувь нэмэр оруулна буй заа.

Энэхүү толь бичгийг Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Монголын худалдааг дэмжих” ТРАМ төслийн дэмжлэгтэй боловсруулсан ба хамтран ажиллаж үнэтэй хувь нэмэр оруулсан ахлах синхрон орчуулагч Д.Сэнгэлмаа, Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн профессор Н.Отгонсайхан, Гадаад Харилцааны Яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Уншигч танд уг тайлбар тольтой холбоотой аливаа үнэтэй санал, зөвлөмж, шүүмж байх аваас trade@nucb.edu.mn хаягаар ирүүлнэ үү.

ЕХ-ны ТРАМ төсөл

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1	Absolute advantage	<p>Үнэмлэхүй давуу тал. Адам Смит “Үндэстнүүдийн баялаг” хэмээх бүтээлдээ энэ ойлголтыг тайлбарласан бөгөөд улс орнууд бараа бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэхээс илүү хямд үнээр бусад орноос олж авахын тулд олон улсын худалдаанд оролцдог гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, улс орнууд өөрийн үнэмлэхүй давуу талтай бараа бүтээгдэхүүнээрээ төрөлжиж, тэрхүү бараагаа харилцан солилцоо хийвэл, эцсийн дүнд уг солилцоо талуудад харилцан ашигтай байх болно гэсэн санаа юм. Адам Смитийн үзэж байснаар эдийн засгийн хувьд улс орны бие даасан системээс илүүтэйгээр, олон улсын худалдаа нь илүү нарийн мэргэшил олгодог тул нөөц эх үүсвэрүүдийг илүү үр дүнтэй ашиглах боломжийг олгодог байна. Тэрээр гэр бүлүүд өөрсдөө хийж бүтээхээсээ илүүтэйгээр яагаад аливаа зүйлийг худалдан авдаг учир шалтгааныг “хэрэв гадаадын улс орнууд бидний өөрсдөө хийж чадахаас маань илүү хямд үнээр бараа түүхий эдийг бидэнд нийлүүлж чадаж байгаа бол, бид өөрсдийн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийхээ зарим хэсгийг ашиглан түүнийг нь худалдаж авсан нь дээр бөгөөд энэ нь бидэнд ямар нэгэн давуу талтай хэлбэрээр ашиглагддаг” хэмээн тайлбарласан байна.</p> <p>Мөн Автократ дээд эрх мэдлийг хязгаарлалтгүйгээр захирагч/ганцаар захирах ёс (autarky), харьцангуй давуу тал (comparative advantage), худалдаанаас ашиг олох онол (gains-from-trade theory), Хекшер - Олин теорем (Heckscher-Ohlin theorem), өөрийн хүчинд тулгуурлах (self-reliance), өөрөө өөрийгөө хангадаг байх (self-sufficiency) зэрэг нэр томьёог үзнэ үү.</p>
2	Accelerated tariff liberalisation	<p>Тарифын түргэвчилсэн либералчлал. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаанаас (АПЕК) гаргасан салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх санаачилга. 1998 онд Куала Лампур хотод болсон уулзалтын үеэр АПЕК-ийн гишүүн орнуудын сайд нар энэхүү санаачилгын эхний 9 салбарын тарифын бүрэлдэхүүн хэсгүүдийг ДХБ-руу шилжүүлэхээр шийдсэн байна. Эдгээр 9 салбарт, ойн аж ахуйн бүтээгдэхүүн, загас ба загасан бүтээгдэхүүн, тоглоом, үнэт чулуу ба үнэт эдлэл, химийн бүтээгдэхүүн, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, байгаль орчны бүтээгдэхүүн ба үйлчилгээ, эрчим хүч, цахилгаан харилцаа холбооны салбар дах харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрүүд багтана. Аукландын (Auckland) сорилт хэмээх тунхаг бичигт АПЕК-ийн гишүүн орнууд 2000 оны эцэс хүртэл уг санаачилгыг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Энд хүрээд уг санаачилга төгссөн мэт байдаг.</p>
3	Acceptable level of risk	<p>Эрсдэлийн хүлээн зөвшөөрөхүйц түвшин. Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Эрүүл ахуйн болон ургамлын хорио цээрийн арга хэмжээний тухай хэлэлцээрт “Гишүүн орнууд өөрийн нутаг дэвсгэрийнхээ хүрээнд хүн, мал амьтан, ургамлын эрүүл мэндийг хамгаалахын тулд тогтоосон эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээний зохистой гэж үзсэн хамгаалалтын түвшин” хэмээн тодорхойлжээ.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
4	Accession	<p>Нэгдэн орох. Дэлхийн худалдааны байгууллага, эсхүл бусад олон улсын байгууллага, эсхүл хэлэлцээрт нэгдэн орох, гишүүнээр элсэх үйлдэл. ДХБ-д нэгдэн орохын тулд өргөдөл гаргагч орны худалдааны дэглэмийг ДХБ-ын дүрэм журамтай нийцүүлэх талаар, гишүүн орнууд болон өргөдөл гаргагч орны хооронд хэлэлцээ хийгдэх шаардлагатай. Шинэ гишүүний ДХБ-д нэгдэж орохдоо санал болгож буй тарифын болон үйлчилгээний талаарх үүрэг амлалтын дэлгэрэнгүй жагсаалт нь өмнөх гишүүн орнуудынхтай ижил төстэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн улс бусад гишүүн орны адил үр ашгийг нь хүртэхийн зэрэгцээ, ижил төрлийн нөхцөл олгоход бэлтгэх хэрэгтэй болно. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад (OECD) шинэ гишүүд нэгдэж орох үед тэднийг эдийн засгийн дэглэм нь одоо байгаа гишүүдийнхтэй өргөн хүрээнд зохицож байгаа болохыг харуулахыг шаарддаг байна. Харин НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) болон НҮБ-ын бусад байгууллагад гишүүнээр нэгдэж ороход ийм төрлийн үүрэг амлалт авах шаардлагагүй байдаг.</p> <p>Мөн Өргөжилт (enlargement), үйлчилгээний салбарт авсан үүрэг амлалтын жагсаалт (schedules of commitments on services), тарифын хөнгөлөлт, буултын жагсаалт (schedules of concessions) зэрэг нэр томьёог үзнэ үү.</p>
5	Actionable subsidies	<p>Хариу арга хэмжээ авах үндэслэл бүхий татаас. ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрээр уг татаасыг тайлбарласан. Татаас нь бусад гишүүн орны дотоодын аж ахуйн нэгжүүдэд хохирол учруулж, Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу авсан үүрэг амлалтуудыг үгүйсгэж, эсхүл бусад гишүүн орны ашиг сонирхлыг ноцтой ялгаварлан гадуурхаж байвал хариу арга хэмжээ авах үндэслэл бүхий татаас (хууль бус) гэж үздэг. Ийм татаас олгож байгаа орон үүнээсээ татгалзах, эсхүл уг татаасны сөрөг нөлөөг арилгах ёстой.</p> <p>Мөн татаасны хохирлыг саармагжуулах буюу нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties), хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаас (non-actionable subsidies), хориглосон татаас (prohibited subsidies), татаас (subsidies) зэрэг нэр томьёог үзнэ үү.</p>
6	Administered trade	Захиргааны зохицуулалттай худалдаа. Мөн зохицуулалттай худалдааг (managed trade) үзнэ үү.
7	Administrative international commodity agreements	Захиргааны зохицуулалттай олон улсын барааны хэлэлцээр. Зах зээлд орж ирэх тоо хэмжээг овжин ашиглаж удирдах замаар, бараа түүхий эдийн үнэд нөлөөлөх зорилготой нөөц бараа түүхий эд, экспортын тоон хязгаарлалт, эсхүл бусад механизмуудыг хэрэгжүүлдэггүй. Энэ төрлийн хэлэлцээр нь зах зээлийн ил тод байдал, илүү үр дүнтэй үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, мөн статистикийн мэдээллийг цуглуулах ба түгээх зэрэг асуудлуудыг авч үздэг. Мөн Эдийн эдийн засгийн хувьд ашигтай олон улсын түүхий эд, материалын хэлэлцээр (economic international commodity agreements) үзнэ үү.
8	Administrative protection	Захиргааны хамгаалалт. Болзошгүй хамгаалалт (contingent protection) болон тарифын бус арга хэмжээ (non-tariff measures) үзнэ үү.
9	Administrative regulation	Захиргааны зохицуулалт. Зохицуулалт (regulation) гэдгийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
10	Ad notes	Тэмдэглэл болон тайлбар. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ийн 1 дүгээр Хавсралт дах тэмдэглэл болон тайлбар бөгөөд эдгээрийг холбогдох зүйл, заалттай нь байнга хамт уншиж байх хэрэгтэй байдаг.
11	Ad-referendum agreement	Энэ нь багц хэлэлцээнүүдийн үр дүнг түр хугацаагаар хүлээн авах тухай юм. Эцсийн байдлаар хүлээн зөвшөөрөх асуудал нь холбогдох хэлэлцээнүүдийн үр дүн, тухайн засгийн газрынх нь зөвшөөрөл эсвэл бусад зарим нөхцөлүүдийг бүрэн биелүүлсэн нөхцөлөөс хамаарч эцсийн байдлаар хүлээн зөвшөөрч болно.
12	Ad valorem equivalent	Барааны үнийн дүнгээс хувиар тооцох тарифтай дүйцүүлсэн хэмжээ. Импортлох, эсхүл экспортлох барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тооцох тарифын (specific) хэмжээг барааны үнийн дүнгээс хувиар (ad valorem) тооцох тарифтай дүйцүүлэн тооцоолох замаар гаалийн тарифын хамгаалалтын түвшинг харж болно. Жишээлбэл, нэг компакт диск нэг ам.долларын тарифтай, 10 ам.долларын үнэтэй бол үнийн дүнгээс хувиар тооцох тарифтай дүйцүүлсэн хэмжээ нь 10%, харин уг диск 20 ам. долларын үнэтэй бол 5% болно. Хосолсон тариф (compound tariff) гэдгийг үзнэ үү.
13	Ad valorem tariff	Барааны үнийн дүнгээс хувиар тооцох тариф. Импортлох, эсхүл экспортлох барааны үнийн дүнгээс хувиар тооцох тариф. Ихэнх барааны тариф энэ хэлбэрээр илэрхийлэгддэг. Гаалийн үнэлгээ (customs valuation), барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон тариф (specific tariff) үзнэ үү.
14	African Economic Community	Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг. Уг байгууллага нь Африкийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд чиглэсэн байгууллага, 1994 оны 5-р сарын 12-нд хүчин төгөлдөр болсон. Африкийн эв нэгдлийн байгууллагын бүх гишүүн улс орнуудад нээлттэй бөгөөд гишүүд нь 50 гарсан байна. Африкийн эдийн засгийн нийгэмлэг нь урт хугацаандаа Африкийн нэгдсэн зах зээлийг буй болгохыг зорьж байгаа боловч, дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө нь худалдааны хамтын ажиллагаа ба худалдааг хөнгөвчлөх ажилд төвлөрнө. Нарийн бичгийн дарга нарын газар нь Аддис Абаба-д байрладаг.
15	African Union	Африкийн холбоо. Энэ нь Лусакад болсон Африк тивийн улс орнуудын төрийн тэргүүнүүдийн уулзалтын үеэр, Африкийн эдийн засгийн нийгэмлэгийг уламжлан оронд нь 2001 оны 7-р сард байгуулагдсан.
16	AFTA	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АСЕАН) Чөлөөт худалдааны хэлэлцээр. Энэ нь 1993 оны 1-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. АСЕАН-ын гишүүн орнуудын хоорондын бараа бүтээгдэхүүний худалдааг хамардаг. Тарифыг бууруулах зорилгодоо хүрэх гол механизм нь нэгдсэн гадаад хөнгөлөлттэй тариф (CEPT). Энэ нь анх хөнгөлөлтийн тарифуудыг шууд хэрэглэдэг Хөндлөнгийн этгээдийг хамруулах жагсаалт болон Түр зуур хассан жагсаалтуудаас бүрэлдэж байв. Эдгээрийн сүүлийнх нь жагсаалтад орсон бүтээгдэхүүнүүдэд ногдуулах хөнгөлөлтийн тарифыг хамгийн оройдоо 2003 он гэхэд халсан байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>1995 оны 12-р сард баталсан Хөдөө аж ахуйн боловсруулаагүй эмзэг бүтээгдэхүүнүүдийн харьцангуй жижиг жагсаалтад багтсан бүтээгдэхүүний хувьд харьцангуй удаан хугацаанд тарифыг бууруулна гэсэн хүлээлт байгаа. Хөдөө аж ахуйн тарифыг бууруулах шинэ иж бүрэн жагсаалтыг хэрэгжүүлэх ажил 1996 оны 1 сарын 1-нд эхэлсэн. Үүнд мөн тарифын бус арга хэмжээнүүдийг бууруулах үйл ажиллагааны хөтөлбөр гэж бий. Мөн АСЕАН - Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (ASEAN) Үйлчилгээний тухай суурь хэлэлцээр (ASEAN framework agreement on services), АСЕАН - Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Хөрөнгө оруулалтын бүс (ASEAN Investment Area) үзнэ үү.</p>
17	<p>AFTA-CER (ASEAN Free Trade Agreement-Closer Economic Partnership)</p>	<p>АСЕАН-ий Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ)-ийн гишүүд болон Австрали, Шинэ Зеландын хамтын ажиллагааны хөтөлбөр. АСЕАН-ЧХХ-ийн гишүүд (Бруней, Бирм, Индонез, Лао, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам) болон Эдийн засгийн ойр дөт харилцааны (CER - Австрали, Шинэ Зеланд) хооронд байгуулсан хамтын ажиллагаа ба худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр.</p>
18	<p>Agenda 21</p>	<p>21-р зууны Хөтөлбөр. Рио-де-Жанейро хотод 1992 оны 6 сарын 4-нд болсон НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн бага хурлын (UNCED) хуралдаанаар батлагдсан худалдаа ба байгаль орчны асуудлууд харилцан огтлолцох уулзвартай холбогдолтой зарчмууд болон үйл ажиллагааны хөтөлбөр. Хөтөлбөрийн А хэсэг нь худалдаагаар дамжуулан тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихийг эрэлхийлдэг. Үүний зорилго нь (a) эдийн засгийн бүтцийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах замаар хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нээлттэй, үл ялгаварласан, шударга худалдааны тогтолцоог дэмжих, (b) хөгжиж буй орнуудын экспортыг дэмжих үүднээс зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах, (c) түүхий эдийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах, байгаль орчны төлөв байдлыг харгалзан тогтвортой хөгжилд түүхий эдийн салбарын оруулах хувь нэмрийг оновчтой болгох үүднээс, үндэсний болон олон улсын түвшинд тогтвортой, өрсөлдөхүйц, тууштай түүхий эдийн бодлогыг бий болгох, (d) эдийн засгийн өсөлт болон хүрээлэн буй орчныг хамгаалах асуудал нь бие биеэ харилцан дэмжсэн хэлбэртэй болгоход чиглэсэн дотоодын болон олон улсын бодлогыг хөхиүлэн дэмжих явдал. Үүнийг ерөнхийд нь тайлбарласан олон төрлийн үйл ажиллагаа болон түүхий эдийн салбар дахь НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) зарим талаараа уламжлалт үйл ажиллагаануудаар дамжуулан хийх юм. Хөтөлбөрийн В чиглэл нь (a) худалдаа ба хүрээлэн буй орчин хоёрыг тогтвортой хөгжилд харилцан хувь нэмэр оруулах замаар дэмжих, (b) Худалдаа ба байгаль орчинтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд, шаардлагатай тохиолдолд эвлэрүүлэн зуучлах журам, маргааныг шийдвэрлэх зэрэг механизмуудаар нь дамжуулан Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ),</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) болон бусад олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог илүү тодорхой болгох, (с) олон улсын бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх мөн байгаль орчин, хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд аж үйлдвэрлэлийн салбарын зүгээс гүйцэтгэх бүтээлч үүргийг хөхиүлэн дэмжих зэрэг болно. Эдгээр зорилтуудыг мөн практик үйл ажиллагаануудаар дэмждэг. 21-р зууны Хөтөлбөрийг ДХБ-ын Худалдаа ба хүрээлэн буй орчны хорооны ажил үүргийн удирдамжид, түүний сайтар бодож төлөвлөх хэлэлцээрүүдэд холбогдох бичвэр болгон дурдсан байдаг. Мөн түүхий эд, материалын бодлого (commodity policy), Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаглал (Rio Declaration on Environment and Development) үзнэ үү.</p>
19	Agenda 2000	<p>2000 оны Хөтөлбөр. Европын Холбоонд шинэ гишүүдийг хүлээн авах үүднээс уг холбоог бэхжүүлэх зорилгоор Европын Комиссоос гаргасан 2000-2006 оны санхүүгийн шинэчлэлийн төлөвлөгөө. 21-р зууны эхэн үед Европын Холбоог бэхжүүлэх, өргөжүүлэх зорилгоор 1997 оны 6-р сард Европын Комиссоос Европын Парламентад танилцуулсан стратеги. Энэхүү баримт бичигт дараах гурван гол сорилтыг тодорхойлсон. (а) Европын Холбооны бодлогыг хэрхэн бэхжүүлж, шинэчлэх үү, ингэж чадсанаар Европын иргэдэд эдийн засгийн тогтвортой өсөлт, илүү их ажлын байр, амьдрах нөхцөлийг сайжруулах, (b) элсэж орох цаг мөчид өргөдөл гаргагч бүх улс орнуудыг үүнд нэгэн зэрэг бэлтгэж байх явцдаа өргөжүүлэлтийн талаар хэрхэн зөвшилцөх үү, мөн (с) Европын Холбооны өргөжүүлэлтийг хэрхэн санхүүжүүлж, урьдчилсан бэлтгэл ажлыг гүйцэтгэж, Холбооны дотоод бодлогуудыг хөгжүүлэх үү гэсэн асуудлууд байдаг. Энэхүү стратегийн хүрээнд зүүн зүг рүү өргөжин тэлэхээр болж байгаа нь Европын хамтын нийгэмлэгийн газар тариалангийн талбай 50%-иар нэмэгдэж, фермийн ажиллах хүч хоёр дахин нэмэгдэхэд хүргэж болзошгүй тул, Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогод томоохон өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Европын хэлэлцээр (Europe Agreements) үзнэ үү.</p>
20	Aggregate measurement of support	<p>Дэмжлэгийн цогц хэмжүүр (Уругвай). ХАА-н тухай хэлэлцээрүүдэд хэрэглэгддэг нэр томьёо. Төрийн сангуудаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон салбарын орлогыг дэмжин татаас олгоход ашигладаг, дотоодод үзүүлдэг бүх дэмжих арга хэмжээнүүдэд зориулсан, жил бүрийн дэмжлэгийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн дүн. Уругвайн үе шатны хэлэлцээнүүдийн үр дүнд, жил бүр үзүүлж буй дэмжлэгийг бууруулах ёстой. Дотоодод үзүүлж буй дэмжих арга хэмжээнүүд нь худалдаанд маш бага хэмжээний нөлөөлөл үзүүлж байгаа бол бууруулах шаардлагагүй. Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр (Agreement on Agriculture), хөх ангилалд хамаарах татаас (blue box), дэмжлэг үзүүлэхтэй дүйцэхүйц арга хэмжээ (equivalent measure of support), ногоон ангилалд хамаарах татаас (green box), татаас (subsidies) зэргийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
21	Aggressive reciprocity	Түрэмгийгээр харилцан адил байх. Тухайн орон (эдийн засаг) худалдааны түнш орныг илүү өөрийнхөө хүссэн байдлаар өөр багц арга туршлагуудыг батлан, хэрэгжүүлэхийг хүчлэн шаардахыг эрэлхийлсэн, нэг талыг баримталсан үйл ажиллагаа. Үүнд ашигладаг ятган итгүүлэх арга хэмжээнүүдэд, шударга бус гэж үзсэн үйл ажиллагаануудын эсрэг авсан хариу арга хэмжээ, дотоодын худалдааны хууль тогтоомжуудыг ашиглах зэрэг арга хэмжээнүүд багтдаг. Түрэмгийгээр харилцан адил байснаар, худалдааны зарим асуудлыг шийдэх боломжтой боловч, ихэнх тохиолдолд улс төрийн ихээхэн дайсагнасан байдлыг бий болгодог. Үүнийг "Кроу-бар" худалдааны бодлогын онол (crow-bar theory of trade policy) ч гэх нь бий. Хоёр талт харилцааны онол (bilateralism), идэвхгүйгээр харилцан адил байх (passive reciprocity), 301-р хэсэг (Section 301), 301-р тусгай хэсэг (Special 301), Шударга бус худалдааны арга туршлагууд (unfair trading practices), нэг талыг баримталсан харилцааны онол(unilateralism) үзнэ үү.
22	Agreement Concerning the International Registration of Marks	Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай хэлэлцээр. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр (Madrid Agreement Concerning the International Registration of Marks) үзнэ үү.
23	Agreement for the Protection of Appellations of Origin and their International Registration	Гарал үүслийн нэршлийг хамгаалах болон тэдгээрийн олон улсын бүртгэлийн тухай хэлэлцээр. Лиссабоны хэлэлцээр (Lisbon Agreement) үзнэ үү.
24	Agreement for the Repression of False or Deceptive Indications of Source on Goods	Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх худал ба хуурамч үзүүлэлтүүдийг таслан зогсоох хэлэлцээр. Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх худал ба хуурамч үзүүлэлтүүдийг таслан зогсоох Мадридын хэлэлцээр (Madrid Agreement for the Repression of False or Deceptive Indications of Source on Goods) үзнэ үү.
25	Agreement on Agriculture	Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр. Уругвайн үе шатны хэлэлцээрээс гарсан үр дүнгүүдийн нэг. Хөдөө аж ахуйн (ХАА) барааны худалдааны урт хугацааны шинэчлэл ба либералчлалд зориулсан анхны үр дүнтэй олон талт тогтолцоог хангаж өгсөн. Уг хэлэлцээр нь, зах зээлд нэвтрэх, дотоодын дэмжлэг, экспортын дэмжлэгийн (жишээ нь, татаасыг зохицуулах) хувьд шинэ дүрэм журмууд болон үүрэг амлалтуудыг тогтоож өгсөн. Худалдааг арай багаар гуйвуулсан дотоодын дэмжлэгийн бодлогуудыг батлахыг энэ нь хөхиүлэн дэмждэг бөгөөд үүнд дотоодын зохицуулалтын хүндрэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн үйл ажиллагаануудыг зөвшөөрдөг. Уг хэлэлцээрийн шаарддаг зарим арга хэмжээнүүдээс гэвэл, (а) өндөр хөгжилтэй орнууд экспортын татааст зориулдаг зардлуудаа зургаан жилийн хугацаанд ижил тэнцүү дүнгээр хэсэгчлэн 36%-иар бууруулах, хөгжиж буй орнуудын хувьд 10 жилийн хугацаанд 24%-иар бууруулах; (б) өндөр хөгжилтэй орнууд зургаан жилийн хугацаанд татаасны дэмжлэгтэй экспортын хэмжээгээ 21%-иар хасах, хөгжиж буй орнуудын хувьд 10 жилийн хугацаанд 14%-иар хасах; дэмжлэг үзүүлсэн нийт арга хэмжээний дүнгээр тооцоолдог дотоодын дэмжлэгийг зургаан жилийн хугацаанд 20%-иар хасах ёстой,

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>1986-88 оныг суурь он гэж тооцоолсон; мөн (в) одоо байгаа тарифын бус арга хэмжээнүүдийг тариф болон тарифын дээд хэмжээнд хувиргах хэрэгтэй, дараа нь мөн зургаан жилийн хугацаанд ижил тэнцүү хэмжээгээр, жигнээгүй дундаж 36%-иар бууруулахдаа мөн 1986-88 оныг суурь он гэж авна. Хөгжиж буй орнуудын хувьд, хасах дүн нь 10 жилийн хугацаанд 24% байна. Уг хэлэлцээр нь, өмнө нь хаалттай байсан зах зээлүүдэд зориулан зах зээлд нэвтрэхтэй холбоотой хамгийн бага үүрэг амлалтуудыг болон тарифжуулах үйл ажиллагааны дараа үүсэх импортын их хэмжээний давлагаатай тулж ажиллахын тулд хатуу заасан нөхцөлүүдийн дор хэрэглэж болох хамгаалалтын тусгай арга хэмжээнүүдийг үүсгэсэн. ХАА-н худалдааг улам их либералчлах асуудлыг хөндсөн хэлэлцээнүүд 2000 онд дахин эхэлсэн. Гишүүн улс орнуудын хувьд, зөвшилцсөн эцсийн цэгтээ хүрч л байвал авсан үүрэг амлалтуудаа хэрэгжүүлэх тал дээр, хязгаарлагдмал хүрээнд зарим талаараа уян хатан байх боломжтой. Хөдөө аж ахуй ба ТХЕХ (agriculture and the GATT), хөх ангилалд хамаарах татаас (blue box), ногоон ангилалд хамаарах татаас (green box), Үргэлжлүүлэх тухай заалт (continuation clause), Энхийн тохиролцооны нэмэлт зүйл (peace clause) зэргийг үзнэ үү.</p>
26	<p>Agreement on Basic Telecommunications Services</p>	<p>Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээний тухай хэлэлцээр. Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнд анх удаа үйлчилгээний худалдааны талаар авч хэлэлцсэн ДХБ-ын хэлэлцээр бөгөөд 1997 оны 2-р сарын 15-нд эцэслэсэн. Үүнд, худалдааны бие төлөөлөл/төлөөлөгчийн газраар дамжуулан хийх болон хил дамнасан худалдааны асуудлыг хамардаг, зах зээлд нэвтрэхтэй холбоотой асуудлаар 69 улс орнуудын авсан үүрэг амлалтуудыг агуулсан байдаг. Уг хэлэлцээр нь 1998 оны 1-дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. Хил дамнасан үйлчилгээний худалдаа (cross-border trade in services), Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (International Telecommunication Union) үзнэ үү.</p>
27	<p>Agreement on Customs Valuation</p>	<p>Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээр. Үүнийг албан ёсоор Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 7-р Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр гэдэг. Энэ нь гаалийн байгууллагын зүгээс гаалийн татварыг ногдуулах үүднээс импортын барааны үнийг үнэлж тооцоолоход баримтлах, үл ялгаварлах журам бүхий системийг зааж өгсөн байдаг.</p>
28	<p>Agreement on Government Procurement</p>	<p>Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр. ДХБ-ын хязгаарлагдмал оролцогчтой хэлэлцээрүүдийн нэг. Өөрсдийн хэрэгцээнд зориулан засгийн газрын зүгээс бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтууд нь ҮХЕХ (GATS), эсхүл ТХЕХ-ийн (GATT) дүрэм журмын алинд нь ч тусгагдаагүй болно. ТХЕХ-ийн зарим гишүүн орнууд үүнийг томоохон дутагдалтай тал гэж үзсэн бөгөөд тэд Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээрийг байгуулахаар тохиролцсон. Өнөөгийн гэрээ нь Токиогийн үе шатны хэлэлцээний текстийг авсан бөгөөд Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр тохиролцсон. Үүнд төв засгийн газар, улс, орон нутгийн засаг захиргааны түвшинд, засгийн газрын зүгээс бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахаар хийсэн болон тодорхой хэмжээнээс дээш ахуйн үйлчилгээний гэрээнүүдийг хамардаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Уг гэрээгээр, хилийн хууль ёсны арга хэмжээнд хамааралтай (жишээ нь, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, оюуны өмчийг хамгаалал, гэх мэт) субъектүүд болох гадаадын ханган нийлүүлэгчдэд, засгийн газрын холбогдох худалдан авалтын гэрээнүүдтэй холбогдуулан дотоодын ханган нийлүүлэгчдэд олгодог таатай нөхцөлөөс багагүй нөхцөлийг олгох, жишээ нь, тэд бие биедээ үндэсний нөхцөлийг олгох зэрэг нөхцөлүүдийг хангаж байх зорилготой. Мөн уг Гэрээнд хамруулсан засгийн газрын бараа, үйлчилгээ худалдан авалттай холбоотойгоор, талууд бие биедээ үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) олгохыг хүлээн зөвшөөрнө гэдгийг зааж өгсөн байдаг боловч, гишүүн улс орнууд бусад гишүүн улс орнуудынхаа компаниудыг өөрсдийн засгийн газрынхаа зарласан тендерт өрсөлдөхийг зөвшөөрөх цар хүрээнд шууд харилцан адил байх элемент байдаг. Энэ нь ялангуяа холбооны засгийн газраас доорх түвшинд болон төв засгийн газраас доорх түвшинд хийгдэж байдаг худалдан авалтуудад хэрэглэгдэх юм. Уг хэлэлцээр нь засгийн газрын худалдан авалтын ил тод журам, арга туршлагаудыг эрэлхийлдэг.</p> <p>Засгийн газрын худалдан авалтын асуудлын хүрээнд, хоёрдугаар түвшний үүрэг, үүрэгчлэлүүд (second-level obligations) болон Засгийн газрын худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлын талаарх [талуудын] ажлын хэсгийн (Working Party on Transparency in Government Procurement) талаар үзнэ үү.</p>
29	<p>Agreement on Implementation of Article VI of the General Agreement on Tariffs and Trade 1994</p>	<p>1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6 дугаар Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр буюу ДХБ-ын Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр</p> <p>Демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) болон демпинг (dumping) үзнэ үү.</p>
30	<p>Agreement on Implementation of Article VII of the General Agreement on Tariffs and Trade 1994</p>	<p>1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр буюу ДХБ-ын Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээр. Хэлэлцээрийн зорилго нь гаалийн үнэлгээг бодит үнийг үндэслэн хийх, шударга импортлогчдын эрх ашгийг хамгаалах. Хэлэлцээрээр оролцогч орнуудын хувьд нийтлэг, барааны гаалийн үнийг тодорхойлох журам, зарчмыг тогтоосон. Барааны "хэлцлийн үнэ" (transaction value), эсхүл бодитоор төлсөн буюу төлбөл зохих үнийг гаалийн зорилгоор барааны үнийг тогтоох үндсэн арга болгон ашиглахыг үүрэг болгодог.</p>
31	<p>Agreement on Import Licensing Procedures</p>	<p>Импортын тусгай зөвшөөрлийн (лицензийн) журмын тухай хэлэлцээр. Энэ хэлэлцээрт ДХБ-ын гишүүн улс орнууд импортын лиценз олгохдоо баримтлах журмыг зааж өгсөн ба гол зорилго нь лицензийг олгохдоо шударга, эрх тэгш бөгөөд ил тод нээлттэй удирдан зохион байгуулах явдал.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
32	Agreement on Preshipment Inspection	<p>Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр. ДХБ-ийн олон талт худалдааны энэхүү хэлэлцээр нь, ачилтын өмнөх хяналт шалгалтуудыг явуулахдаа, ачилт хийгдсэн бараа бүтээгдэхүүний үнэ өртөг нь нэхэмжилсэн үнэ өртөгтэйгөө тохирч байх нөхцөлийг хангах үүднээс, гишүүн улс орнууд ачилтын өмнөх хяналт шалгалтуудыг явуулж болох нөхцөлүүд, дүрэм журмуудыг зааж өгсөн байдаг. Иймэрхүү хяналт шалгалтуудыг гол төлөв хөгжиж буй улс орнууд, их хэмжээний хөрөнгө хилээр урсан гарах, арилжааны луйвар, гаалийн татваруудаас бултаж зайлах ба бусад ижил төстэй арга заль, луйвруудаас урьдчилан сэргийлэх үүднээс хэрэглэдэг. Уг хэлэлцээр нь, үүнийг хэрэгжүүлэгч гишүүн улс орнуудыг ийм арга ажиллагаануудыг удирдан зохион байгуулахад, ТХЕХ-ийн үндсэн зарчмууд болон үүрэг хариуцлагыг хэрэглэхийг шаарддаг. Үүнд, үл ялгаварлах, ил тод байдал, бизнесийн нууцтай холбоотой мэдээллийн хамгаалал, шалтгаангүйгээр удаашруулах явдлаас зайлсхийх, үнийг хянан баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулах тодорхой зааварчилгааг ашиглах, ачилтын-өмнөх хяналт шалгалт хариуцсан агентлагуудын ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх зэрэг асуудлуудыг үүнд хамруулсан байдаг.</p>
33	Agreement on Rules of Origin	<p>Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр. ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдийн нэг. Барааны гарал үүслийн дүрмийг урт хугацаанд уялдуулан зохицуулахын тулд, Гарал үүслийн дүрмийн хорооны ажлын хөтөлбөрийг зааж өгсөн. Уг Хорооны ажлыг тус Хэлэлцээрт зааж өгсөн зарчмуудын дагуу чиглүүлдэг. Жишээлбэл, үндэсний нэн тааламжтай нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн бараа бүтээгдэхүүний гарал үүслийн орныг тодорхойлохын тулд гишүүн улс орнуудын хэрэглэдэг хууль, дүрэм журмууд, захиргааны шийдвэрүүд нь гарал үүслийн дүрэм юм хэмээн тодорхойлсон. Үүнийг хөнгөлөлттэй тарифтай импортын бүтээгдэхүүнд хэрэглэдэггүй.</p> <p>БТКУС-ийн зүйлийн түвшний өөрчлөлт (change in tariff heading), гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм (preferential rules of origin) үзнэ үү.</p>
34	Agreement on Safeguards	<p>Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр. Энэ нь ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээр. ТХЕХ-ийн 19-р зүйлийн үйл ажиллагааг хэзээ, яаж дагаж мөрдөн ажиллаж болохыг зааж өгсөн байдаг ба үүнийг мөн Зугтаах заалт буюу гэрээний хариуцлагаас чөлөөлсөн заалтын (escape clause) арга хэмжээ гэж нэрлэх нь бий. Уг хэлэлцээрт урьдаас тооцоолоогүй их хэмжээний импортын өсөлтийн улмаас дотоодын ижил төрлийн барааны үйлдвэрлэлд “ноцтой хохирол” учруулсан, эсхүл “ноцтой хохирол учруулах аюул” бий болсон үед дотоодын үйлдвэрийг хамгаалах яаралтай арга хэмжээ авах боломжийн талаар авч үздэг. “Ноцтой хохирол” гэдэгт дотоодын үйлдвэрлэлийн нөхцөл байдал доройтохыг ойлгоно (Хэлэлцээрийн 4-р зүйлийн 1 (а) заалт) “Ноцтой хохирол учруулах аюул” гэдэгт ноцтой хохирол учруулах нь зайлшгүй гэдэг нь тодорхой байхыг ойлгоно (Хэлэлцээрийн 4-р зүйлийн 1 (б) заалт). Эдгээр нөхцөл бий болсон эсэхийг хянан магадлахдаа зөвхөн мэдэгдэл, таамаглал, магадлалаар бус бодит баримтыг үндэслэх шаардлагатай. Хэлэлцээрт нийтийн сонсголоор дамжуулан</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>ард иргэдэд мэдээлэл хүргэх, сонирхогч талуудад нотлох баримтыг танилцуулах, хохирлыг тодорхойлоход зориулсан шалгуур үзүүлэлт, хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх болон хамгаалалтын түр арга хэмжээ, тэдгээрийн зэргийг тусгасан байдаг. Хамгаалалтын арга хэмжээ нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэх эсэх асуудлыг шалгуурт хамруулна. Хэрэв хамгаалалтын арга хэмжээ яаралтай хэрэглэхгүй байх нь дотоодын үйлдвэрлэлд дараа нь засаж залруулахад бэрхшээлтэй ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах аюулыг бий болгож байгаа бол хамгаалалтын түр арга хэмжээг (гаалийн тарифыг өсгөх хэлбэрээр) хэрэглэж болох ба энэ 200 өдрөөс хэтрэхгүй байхаар заасан. Хамгаалалтын арга хэмжээний үргэлжлэх хугацаа дөрвөн жилээс хэтрэхгүй байх ёстой, уг хугацааг сунгасан тохиолдолд дээд тал нь найман жил (хөгжиж буй орон 10 жил) байна. Хамгаалалтын арга хэмжээг импортлосон барааны гарал үүслээс үл хамааран үл ялгаварлан гадуурхах зарчмын дагуу хэрэглэх ёстой. Хамгаалалтын арга хэмжээ авч байгаа гишүүн орнууд хариуд нь нөхөн төлбөр өгөх шаардлага гарч магадгүй учраас сайтар хянан магадлах хэрэгтэй. Тус хэлэлцээр нь сайн дурын хязгаарлалтын арга хэмжээг хамруулсан саарал бүсийн гэж нэрлэдэг арга хэмжээг хориглодог. 1995 оны 1-р сарын 1-ний өдөр гэхэд хүчин төгөлдөр байгаа бүх хамгаалалтын арга хэмжээг таван жилийн дотор үе шаттайгаар арилгаж дуусгах ёстой.</p> <p>Де-минимис буюу дотооддоо үзүүлж болох дэмжлэгийн хамгийн доод хувь хэмжээ бүхий хамгаалалтын дүрмийг (de minimis safeguards rule) үзнэ үү.</p>
35	<p>Agreement on the Application of Sanitary and Phytosanitary Measures</p>	<p>Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (SPS). Хүнсний аюулгүй байдал болон мал амьтан, ургамлын эрүүл ахуйн дүрэм журмуудыг хэрэглэхтэй холбоотой ДХБ-ын олон талт хэлэлцээр бөгөөд олон улсын худалдаанд тэдгээр дүрэм журмуудыг далд хэлбэрийн саад тотгор байдлаар хэрэглэхгүй байх юм. Уг хэлэлцээр нь засгийн газруудыг ургамал, мал амьтны эрүүл ахуй хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг нь баталгаажуулдаг боловч, яг ижил, эсхүл ижил төстэй арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ДХБ-ын гишүүн орнуудын дунд эдгээр арга хэрэгслийг дур зоргоороо ба үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхахад ашиглах ёсгүй. Энэ нь гишүүн улс орнуудыг өөрсдийн дотоодод хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ олон улсын стандарт, заавар журам, зөвлөмжүүдэд үндэслэсэн байхыг хөхиүлэн дэмждэг. Хэрэв шинжлэх ухааны үндэслэл, эсхүл эрсдэлийн үнэлгээний үр дүнд энэ нь зүй зохистой гэж гарсан тохиолдолд, гишүүн улс орнууд арай өндөр түвшний стандартуудыг нэвтрүүлж болно. Хэрэв экспортлогч орон үнэхээр тийм гэдгийг батлан харуулж чадвал, импортлогч орон экспортлогч орны хэрэгжүүлсэн стандартыг өөрийн орны стандарттай ижил тэнцүү гэж авч үзэх ёстой. Уг хэлэлцээрт, эрх зүйн зохицуулалтуудын ил тод байдал, мэдэгдлүүд, үндэсний лавлагаа хариуцсан албаны хүмүүсийг томилох асуудлыг удирдан чиглүүлэх нарийвчилсан журмуудыг зааж өгсөн байдаг.</p> <p>Эпизоотик буюу амин тахлын олон улсын алба (International Office of Epizootics), Ургамал хамгааллын олон улсын конвенцыг (International Plant Protection Convention) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
36	Agreement on Subsidies and Countervailing Measures	<p>Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр. Татаасны ангилал болон тэдгээртэй холбоотой дүрэм журмыг заасан ДХБ-ын олон талт хэлэлцээр. Хэлэлцээрт Татаасны гурван хэлбэрийг авч үзсэн. Үүнд: 1) хориглосон татаас (экспортын гүйцэтгэлээс хамааралтай татаас, эсхүл импортын гэхээс илүү дотоодын бүтээгдэхүүнд ашиглахаар бол), 2) хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаас (эдгээр татаас нь өөр нэг гишүүн орны дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулаагүй, үр ашгийг хүчингүй болгож эсвэл үнэ цэнийг бууруулаагүй, эсвэл өөр нэг гишүүн орны ашиг сонирхлыг ноцтой хохироогоогүй тохиолдолд л хэрэгжүүлэх боломжтой татаас), 3) хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаас (гишүүн улс орнууд хэрэгжүүлж болох татаас). Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн маргааныг шийдвэрлэх тохиолдолд зориулсан түргэвчилсэн хуваарийг энэхүү гэрээнд нарийвчлан заасан байдаг. Мөн энэ хэлэлцээрт Татаасны хохирлыг саармагжуулах үүрэг бүхий нөхөн тэгшитгэх татварыг ногдуулж болох нөхцөлүүдийг зааж өгсөн байдаг. Энэ хэлэлцээр нь хөдөө аж ахуйн бараанд олгодог татааст хамаарахгүй. Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр (Agreement on Agriculture), хөх ангилалд хамаарах татаас (blue box), ногоон ангилалд хамаарах татаас (green box), Шинжээчдийн байнгын бүлэг (Permanent Group of Experts), Татаасны хохирлыг саармагжуулах нөхөн тэгшитгэх татвар (provisional countervailing duties) зэрэг нэр томьёог үзнэ үү.</p>
37	Agreement on Technical Barriers to Trade	<p>Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр. ДХБ-ын олон талт хэлэлцээр нь сав баглаа боодол, хаяглалт, шошгожуулалтын шаардлагууд, техникийн зохицуулалтууд болон стандартуудад нийцүүлэхээр авсан арга хэмжээг үнэлж дүгнэх дүрэм журмууд зэрэг нь олон улсын худалдаанд шаардлагагүй саад бэрхшээлийг бий болгохгүй байлгахад чиглэсэн байдаг. Энэхүү хэлэлцээр нь Токиогийн үе шатны хэлэлцээний стандартуудын тухай хуулийн залгамжлагч. Энэ нь гишүүн улс орнуудыг олон улсын зохих стандартуудыг ашиглахыг хөхиүлэн дэмждэг боловч, стандартжуулалтаас болоод хамгаалалтынхаа түвшинг өөрчлөхийг шаарддаггүй. Үүнд тухайн бүтээгдэхүүнд нь хэрэглэгдэх стандартуудыг хамруулаад зогсохгүй, мөн бүтээгдэхүүн боловсруулах үе шатууд болон үйлдвэрлэлийн аргачлалуудтай холбогдох стандартуудыг хамруулдаг. Мэдэгдэл хүргүүлэхтэй холбоотой урьдчилан зааварласан дүрэм журмуудыг хэрэглэдэг. Гэрээний хавсралтад Стандартуудыг бэлтгэх, батлах, хэрэглэхтэй холбоотой Зохистой дадлын хэм хэмжээг (Agreement contains a Code of Good Practice for the Preparation, Adoption and Application of Standards) агуулсан байдаг. Төв засгийн газрын стандартжуулалтын асуудал хариуцсан хуулийн этгээд нь үүнийг баримталж ажиллах хэрэгтэй болно. Орон нутгийн засгийн газар болон төрийн бус байгууллагууд мөн тийнхүү үйлдэж болно.</p> <p>Тохирлын үнэлгээ (conformity assessment), Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission), Олон улсын стандартчиллын байгууллага (International Organisation for Standardisation) зэргийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
38	Agreement on Textiles and Clothing	<p>Нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр. Энэ нь ДХБ-ын нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийн (MFA) залгамжлагч. Энэ хэлэлцээр нь 2005 оны 1-р сарын 1-н гэхэд сүлжмэл, нэхмэл болон бэлэн хувцасны салбарын олон улсын худалдааг дахиад хэвийн либералчлал болон ДХБ-ын үл ялгаварлах худалдааны дүрэм журамд захируулахыг зорьсноороо, Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрээс (MFA) ялгаатай. 1995 оны 1 сарын 1-нд гишүүн орнууд 1990 оны нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний худалдааны хэмжээнийхээ 16%-ийг интеграци хийх ёстой байв. 1998 оны 1 сарын 1-нд 17%-ийг, 2002 оны 1 сарын 1-нд 18%-ийг, 2005 оны 1 сарын 1-нд үлдсэн хувийг интеграцчилах ёстой байсан. Энэ нь ачааны хүндийг хамгийн сүүлд нь их хэмжээгээр үүрүүлэх магадлалтай байсан боловч, хэрэгжилтийн хувьд харьцангуй нарийн заасан нөхцөлүүд үйлчилдэг. Жишээ нь, үе шат бүрд дараах дөрвөн бүлгээс бүтээгдэхүүнүүдээ сонгох хэрэгтэй болно. Үүнд: топс болон ээрсэн утаснууд, даавуу, нэхмэл сүлжмэл болон оёмол бэлэн бүтээгдэхүүнүүд. Уг хэлэлцээрийн дор байгуулагдсан. Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний Хяналтын алба (СНОБХА) нь гарч буй ахиц дэвшлийг хянан удирдаж байдаг бөгөөд уг хэлэлцээртэй холбоотой гарсан зарим маргааныг шийдвэрлэх чиг үүрэгтэй ажилладаг. Мөн ДХБ-ын маргаан шийдвэрлэх механизм гишүүдэд нээлттэй байдаг.</p>
39	Agreement on Trade in Civil Aircraft	<p>Иргэний агаарын тээврийн онгоц худалдаалах тухай хэлэлцээр. Дэлхийн худалдааны байгууллагын хязгаарлагдмал тооны оролцогчидтой (plurilateral) хэлэлцээрүүдийн нэг ба анх Токиогийн үе шатны хэлэлцээний нэгэн хэсэг болж батлагдаж байсан. Уг хэлэлцээрийг үзэглэсэн улс орнуудын хувьд, а) иргэний агаарын тээврийн онгоц, б) иргэний агаарын тээврийн онгоцны мотор, эд ангиуд, бүрэлдэхүүн хэсгүүд, с) иргэний агаарын тээврийн онгоцны бусад эд ангиуд, бүрэлдэхүүн хэсгүүд болон дэд-бүрэлдэхүүн хэсгүүд, d) газар дах нислэгийн үеийн дадлагажуур зэрэгт ногдуулах бүх гаалийн татварууд болон бусад татваруудыг бууруулах арга хэмжээ авах юм. Уг хэлэлцээрийн дагуу худалдан авагчид нь арилжааны болон технологийн хүчин зүйлүүдэд тулгуурлан, ямар нэгэн тоо хэмжээний хязгаарлалтгүйгээр, ханган нийлүүлэгчдийгээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой гэдгийг шаарддаг. ДХБ-ын татаасны тухай дүрэм журмыг хэрэглэдэг.</p>
40	Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights	<p>Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (TRIPS). Энэ нь Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр хэлэлцээрт хүрч чадсан ДХБ-ын хэлэлцээрүүдийн нэг. Оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлэхэд маш өргөн хүрээний олон төрлийн стандарт, хэм хэмжээнүүдийг хэрэглэж байсны улмаас өсөн нэмэгдэх болсон сөргөлдөөн болон хуурамч бүтээгдэхүүний олон улсын худалдааны эсрэг олон талт дүрэм журмууд хангалтгүй байсан нөхцөл байдлыг шийдэхийн тулд уг Хэлэлцээрт хүрч хэлэлцэн тохиролцсон байдаг. Үүнд, зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхүүд, худалдааны тэмдэгтүүд, газар зүйн заалтууд, бүтээгдэхүүний загвар, патент,</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Интеграл ороомгийн байршлын загвар, худалдааны нууцлалуудын хамгаалалт зэрэг хамаарна. Хэрэглэж болохуйц хамгаалалтын стандарт хэм хэмжээнүүдийг Парисын Конвенц (1967 онд шинэчилсэн хувилбар), Бернийн Конвенц (1971 онд шинэчилсэн хувилбар), Ромын Конвенц, Интеграл цахилгаан шугам бүхий микро схемүүдтэй холбоотой Оюуны өмчийн тухай олон улсын гэрээ зэрэгт зааж өгсөн байдаг боловч, уг хэлэлцээрийн шаардлагуудад бүрэн нийцүүлэхийн тулд заавал эдгээр эрх зүйн актуудад элсэж орох шаардлагагүй байдаг. Гишүүн улс орнууд өөрсдийн хууль эрх зүйн систем болон практик арга ажиллагаанд уг гэрээний нөхцөлүүдийг хэрэгжүүлэх зохистой аргуудыг тодорхойлж тогтоох эрх чөлөөтэй байна. Өндөр хөгжсөн улс орнууд 1995 оны эцэс гэхэд өөрсдийн хууль тогтоомж болон практик арга ажиллагаануудаа уг хэлэлцээрт нийцүүлэх шаардлагатай байсан. Хөгжиж буй улс орнууд болон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явцдаа байгаа улс орнуудын хувьд 1999 оны эцэс гэхэд тийнхүү хийж гүйцэтгэх хэрэгтэй байлаа.</p> <p>Аж үйлдвэрийн өмч (industrial property) болон оюуны өмчийг (intellectual property) үзнэ үү.</p>
41	<p>Agreement on Trade-Related Investment Measures</p>	<p>Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (TRIMS). Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр байгуулсан ДХБ-ын хэлэлцээрүүдийн нэг. Энэ нь бараа бүтээгдэхүүний худалдааг гуйвуулах, эсхүл хязгаарлах нөлөө үзүүлэхүйц хөрөнгө оруулалтыг зөвшөөрөхтэй холбоотой нөхцөлүүдийг халахад чиглэсэн байдаг. Энэхүү хэлэлцээрийн хавсралтад, ТХЕХ-ийн 3-р Зүйл (Үндэсний нөхцөл) ба 11-р Зүйлтэй (Тоо хэмжээний хязгаарлалтуудыг нийтэд нь цуцлах) нийцэхгүй байна гэж үзсэн TRIMs-ийн тайлбар бүхий жагсаалтыг агуулсан байдаг. Эдгээр нь (а) тухайн аж ахуйн нэгж нь дотоодын гарал үүсэлтэй тодорхой хэмжээний бүтээгдэхүүнийг ашиглах ёстой гэсэн шаардлагууд, (б) экспортын гүйцэтгэлтэй холбогдсон импортын зөвшөөрөл, (с) импортын тоон хязгаарлалтуудтай холбоотой аливаа шаардлагууд юм. Өндөр хөгжсөн улс орнуудын гишүүд [хуульд] нийцээгүй арга хэмжээнүүдээ 1997 оны 1 сарын 1 гэхэд, хөгжиж буй улс орнууд 2000 оны 1 сарын 1, нэн буурай хөгжилтэй орнууд 2002 оны 1 сарын 1 гэхэд халж дуусгах ёстой. Уг хэлэлцээрийн хүрээнд, 9-р Зүйлд үүний хожуу үе шатанд нь хөрөнгө оруулалт ба өрсөлдөөний бодлогын нөхцөлүүдийг оруулж магадгүй гэсэн боломжийн талаар тэмдэглэсэн байдаг.</p> <p>Гадаадын шууд хөрөнгө оруулалт (foreign direct investment), хөрөнгө оруулалт (investment), дотоодын/орон нутгийн агуулгын шаардлагууд (local content requirements), худалдааг тэнцвэржүүлэх шаардлага (trade-balancing requirement) зэргийг үзнэ үү.</p>
42	<p>Agreement Regarding International Trade in Textiles</p>	<p>Сүлжмэл, нэхмэл, оёмол эдлэлийн худалдааны асуудлаарх олон улсын хэлэлцээр. Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийг (Multi-Fibre Arrangement) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
43	Agreement Respecting Normal Competitive Conditions in the Commercial Shipbuilding and Repair Industry	Арилжааны усан онгоцны үйлдвэрлэл, засвар үйлчилгээний хэвийн өрсөлдөөнт нөхцөлтэй холбоотой хэлэлцээр. Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагын Хөлөг онгоц үйлдвэрлэх тухай хэлэлцээрийг (OECD shipbuilding agreement) үзнэ үү.
44	Agriculture and the GATT	Хөдөө аж ахуй ба Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр. ТХЕХ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд болон бусад бүтээгдэхүүнүүдийг хооронд нь, зарим жижиг арга замаас бусад тохиолдолд ялгаж салгаж үздэггүй. 11-р Зүйл нь бүхий л тоо хэмжээний хязгаарлалтуудыг ерөнхийд нь халахыг шаарддаг боловч, 11-р Зүйлийн 2-т маш нарийн тодорхойлсон нөхцөлүүдийн дор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн хувьд импорт, экспортын зарим хязгаарлалтууд ногдуулахыг зөвшөөрсөн байдаг. 16-р Зүйлд (Татаас) хэлэлцээрт нэгдсэн улс орнуудыг анхдагч түүхий эдийн барааны экспортод татаас хэрэглэхээс зайлсхийхийг үүрэг болгосон байдаг, 20-р Зүйлд (General Exceptions буюу эс хэрэглэх нийтлэг тохиолдол) гишүүн улс орнуудыг түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрүүдэд элсэн орсон гишүүнчлэлийнхээ нэгэн хэсэг болгон хүлээн зөвшөөрсөн арга хэмжээнүүдийг мөрдөж ажиллахын тулд хүлээсэн зарим үүрэг амлалтуудаасаа түдгэлзэхийг зөвшөөрсөн байдаг. Эдгээр хэлэлцээрүүдийн дор явуулсан худалдаа нь ТХЕХ-ийн дүрэм журамд захирагдахгүй байсан. ТХЕХ-ийн оршин тогтнолын эхний хэдэн жилүүдэд энэхүү нөхцөл байдал ямар нэгэн бодитой хүндрэл бэрхшээл учруулаагүй байна. Баруун Европ дайны үр нөлөөний гамшгаас сэргэн босож л байсан ба арван жилийн дараа гэхэд дэлхийн хөдөө аж ахуйн худалдааны онцлог шинж чанар болох байсан байнгын илүүдлийн цөөн хэдэн шинж тэмдэг бас л байсаар байлаа. Ялангуяа, АНУ-ын сүү сүүн бүтээгдэхүүнээс бусад төрлийн дотоодын илүүдэл бүтээгдэхүүнүүдийн хувьд борлуулах зах зээл байсаар байсан байна. 1955 онд болсон ТХЕХ-ийг Нягтлан дүгнэх хурлын үеэр, түүхий эд, материалын зохицуулалтыг мөн ТХЕХ-ын хяналт удирдлага дор оруулах цаг нь иржээ гэсэн сэтгэгдэл гишүүн улс орнуудын дунд үүссэн байлаа. Гэвч АНУ-ын хувьд асуудалд орсон байдаг. Түүний хувьд дотоодынхоо хэт их үйлдвэрлэлийг хазаарлан зогсоох чадваргүй мэт санагдах болсон ба түүний импортын зах зээл нь гадаадын ханган нийлүүлэгчдийн анхаарлыг ихээхэн татах болсон байна. 1951 оны АНУ-ын Худалдааны тухай хуульд тусгайлан зааснаар бол, өнөөгийн хөдөөд аж ахуйн хөтөлбөрүүдтэй зөрчилдөх байдлаар худалдааны шинэ худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах боломжгүй гэжээ. ТХЕХ-ийн 11-р Зүйлийн 2-рт зөвшөөрсөн импортын хязгаарлалт нь энэхүү асуудлыг шийдэхэд хангалтгүй болж ирсэн байна. 1951 онд ТХЕХ-ийн дүрэм журмын дагуу АНУ-ыг авсан үүрэг амлалтаа цуцалж/үүрэг амлалтаасаа чөлөөлөгдөж, сүү сүүн бүтээгдэхүүнүүдийн импортод хязгаарлалт тавихыг нь зөвшөөрсөн байна. Улмаар 1954 онд АНУ-ын гаргасан хүсэлт болон 1955 онд үүрэг амлалтаа цуцлах/чөлөөлөгдөх хүсэлтийн хариуд, ТХЕХ-ийн хүрээнд авсан үүрэг амлалтуудтайгаа

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Хөдөө аж ахуйн зохицуулалтын тухай хуулийнхаа заалт нөхцөлүүдийг нийцүүлэн тохируулах хүртэл, ямар нэгэн цаг хугацааны хязгаарлалтгүйгээр үүрэг амлалтаа цуцлах зөвшөөрөл олгосон байна. Энэ нь 22-р Хэсэгт тусгасан үүрэг амлалтын цуцлалт байлаа. Шаардлагатай гэсэн үедээ, АНУ-ыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд импортын хязгаарлалт ногдуулахыг нь зөвшөөрөөгүй байдаг. Энэхүү үйлдэл нь ТХЕХ-ийн дүрэм журмын дор ирээдүйд хөдөө аж ахуйн асуудлыг зохицуулах ерөнхий чиг хандлагыг тогтоосон байна.</p> <p>Баумгартнерийн саналууд (Baumgartner proposals), Маншолтын саналууд (Mansholt proposals) and Плафшерсийн дайныг (Ploughshares War) үзнэ үү.</p>
45	ALADI (Latin American Integration Association)	<p>Латин Америкийн интеграцийн холбоо (LAIA). 1980 онд ЛАФТА буюу Латин Америкийн Чөлөөт худалдааны холбоо нуран унасны дараа Аргентин, Боливи, Бразил, Чили, Колумб, Эквадор, Мексик, Парагвай, Перу, Уругвай, Венесуэл улсууд байгуулсан. Уг холбооны зорилтууд нь Монтевидео-гийн олон улсын хэлэлцээрт заасан байдаг ба аажмаар дэвших замаар Латин-Америкийн нэгдсэн зах зээлийг бий болгохыг зорьдог.</p>
46	Alternative dispute resolution	<p>Маргаан шийдвэрлэх өөр хувилбар. Энэ нь арбитрын шүүх, зөвлөгөөн, маргаан зуучлах гэх мэт аргаар шүүн таслах ажиллагааны албан ёсны бүтэц тогтолцооноос гадуур маргаан шийдвэрлэх арга. Маргалдаж буй талууд голдуу уг маргааны хувьд ямар нэгэн ашиг сонирхолгүй нэг ба түүнээс дээш тооны хүмүүсийг тохоон томилдог бөгөөд ингэснээр тэд маргааны үр дүнг эцэст нь шударга ба эрх тэгш шийдэхэд нь оролдлого гаргадаг байна. Арбитрын ийм шийдвэрийг ихэнх тохиолдолд шүүхийн журмаар сахиулан хэрэгжүүлэх боломжгүй байдаг тул маргаан шийдвэрлэх өөр хувилбар нь, хэрэв талууд шийдэл олохын тулд үнэхээр үүрэг амлалт авч, хэлэлцэн тохиролцоод гарсан үр дүнг хүлээн зөвшөөрнө гэсэн үед л хэрэгжих боломжтой байдаг.</p> <p>Маргаан шийдвэрлэх (dispute settlement) гэснийг үзнэ үү.</p>
47	Alternative specific tariff	<p>Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоох тарифын хувилбар. Тарифын хувь хэмжээг нэг бол тухайн барааны үнийн дүнгээс тодорхой хувиар (ad valorem), эсхүл барааны нэгжид мөнгөн дүнгээр (specific) гэсэн 2 хувилбараар илэрхийлж гаалийн тарифын жагсаалтад заах ба хил дээр энэ хоёр хэлбэрээс гаалийн өндөр татвартайг нь сонгоно.</p> <p>Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоох тариф (specific tariff) үзнэ үү.</p>
48	Amicus brief	<p>Шүүхийн найз мөн “amicus curiae” гэж нэрлэдэг. Тухайн хэрэгт холбогдолгүй хөндлөнгийн тал, хамгийн шилдэг шийдвэрээ гаргахад нь шүүгчдэд дэмжлэг болно гэж үзсэнээр, шүүгчдэд үзэл бодлоосоо хуваалцдаг. ДХБ-ын гишүүдийн дунд Давж заалдах шатны байгууллага нь “Шүүхийн найз”-ын товч мэдээллийг хүлээн зөвшөөрч болох эсэх талаар хэлэлцүүлэг маргаан өрнөсний улмаас энд оруулж ирдэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
49	Analogue country	<p>Үнийн харьцуулалт хийх улс. Үүнийг демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ашигладаг. Өөрөөр хэлбэл, тухайн демпингтэй барааны гарал үүслийн орноос олж авсан үнийн мэдээлэл нь хэрэгцээтэй үр дүнтэй мэдээлэл болж чадахгүй байна гэж үзвэл демпингийн эсрэг үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын зүгээс үнийн харьцуулалт хийх зорилгоор сонгосон улс.</p> <p>Демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) үзнэ үү.</p>
50	Analytical Index	<p>Дүн шинжилгээний индекс. ДХБ-ын Хууль зүйн хэлтсийн бэлдсэн, Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ийг тайлбарлаж, хэрэглэх тухай хоёр боть зааварчилгаа.</p> <p>ТХЕХ-ийн Үндсэн эрх зүйн актууд (GATT Basic Instruments) болон Сонгосон баримт бичгийг (Selected Documents) үзнэ үү.</p>
51	Andean Community	<p>Андын хамтын нийгэмлэг. 1969 оны 5 сарын 26-ны Картагений хэлэлцээрийн дагуу Андын гэрээ буюу заримдаа Андын бүлэг хэмээн нэрлэгддэг, Латин Америкийн Чөлөөт худалдааны бүсийн (LA FTA - Latin American Free Trade Area) дэд бүлэг болгон байгуулсан байна. Уг хэлэлцээр нь өөрийн гишүүн орнуудынхаа аж үйлдвэрийн салбар болон гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг уялдуулан зохицуулах зорилготой. Өнөөгийн гишүүд бол Боливи, Колумб, Эквадор, Перу, Венесуэл. Чили нь 1969-1976 онд гишүүн байжээ. 1992 оны 1-р сарын 1-нд Андын чөлөөт худалдааны бүс байгуулагдсан бөгөөд үүний дараа 1995 оны 1-р сарын 1-ний өдөр нэгдсэн гадаад тарифыг батлав. 1997 оны 1-р сарын 1-нд уг зохион байгуулалт нь Андын хамтын нийгэмлэг болж хувирав. Үүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Лима хотод байрладаг.</p>
52	Andean Pact	<p>Андын гэрээ. Андын хамтын нийгэмлэг (Andean Community) үзнэ үү.</p>
53	Andean Trade Preference Act	<p>Худалдааны давуу эрхийн тухай Андын бичиг баримт (Акт)</p>
54	Andriessen Assurance	<p>Андриессэний баталгаа. Энэ нь Европын Эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЭЗН) болон Австрали улс хоёрын хооронд 1985 онд хэлэлцэж тохиролцсон зохицуулалт ба Азийн зарим улс орнуудын үхрийн махны зах зээлийг улсын татааснаас ангид байлгадаг. Франс Андриессэн нь ЕЭЗН-ийн Хөдөө аж ахуйн Комиссар байв.</p>
55	Annecy Tariff Conference	<p>Аннеси дах бага хурал. Олон талт худалдааны найман удаагийн үе шатны хэлэлцээний хоёр дах үе шат. Энэ бага хурал нь Францын Аннеси хотод 1949 оны 4-р сараас 8-р сар хүртэл зохион байгуулагдсан.</p> <p>Тарифын тухай хурлыг (Tariff Conference) үзнэ үү.</p>
56	Anti-circumvention	<p>Хуулиас гадуур тойрч гарахын эсрэг арга хэмжээ (Тойрч гарах). Энэхүү нэр томьёог бусад талбарт хэрэглэж болох ч, юуны өмнө демпингийн эсрэг татвараас экспортлогч орнууд тойрч гарах үйлдлээс сэргийлэхийн тулд засгийн газрын зүгээс авч буй арга хэмжээнүүдийг хамруулдаг. Заримдаа компаниуд демпингийн эсрэг татвар төлөхөөс хэд хэдэн арга замаар зайлсхийхийг хичээдэг, ялангуяа импортлогч улсад,</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>эсхүл гуравдагч улсад эд ангиуд болон барааны бүрэлдэхүүн хэсгүүдийг угсарч, үйлдвэрлэх, эсхүл аж үйлдвэрлэл болон экспортынхоо эх үүсвэрийг гуравдагч улсууд руу шилжүүлэх замаар зайлсхийдэг. ДХБ-д ашигладаг нэр томьёо нь холбогдох улсуудын хууль ёсны тогтсон журмын дагуу шийдвэрлэдэг залилангийн хэргийг хэлээгүй болно. Хөдөө аж ахуйн хэлэлцээрт хуулиас гадуур тойрч гарахын эсрэг арга хэмжээний заалт байдаг.</p> <p>Демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), морин тойруулга мэт нөлөө (carousel effect), демпинг (dumping), боолтын түлхүүр үйл ажиллагаа (screwdriver operations) үзнэ үү.</p>
57	Anti-competitive practices	<p>Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа. Үүнийг гол төлөв бизнесийг хязгаарласан үйл ажиллагаа, эсхүл бизнесийн шударга бус үйл ажиллагаа гэдэг.</p> <p>Монополын эсрэг (antitrust), картель (cartel), өрсөлдөөний тухай хууль (competition law), Үйл ажиллагааны дэг ба худалдаа (conduct and trade), өрсөлдөөний бодлого (competition policy) үзнэ үү.</p>
58	Anti-dumping Agreement	<p>Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр. 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6 дугаар Зүйлийг хэрэгжүүлэх ДХБ-ын хэлэлцээр.</p> <p>Демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) үзнэ үү.</p>
59	Anti-dumping measures	<p>Демпингийн эсрэг арга хэмжээ. Экспортлогч бараа бүтээгдэхүүнээ дотоодын зах зээл дээр худалддаг үнээсээ ("normal value-хэвийн өртөг/үнэ") доогуур үнээр гадаад зах зээлд худалдаалах үйл ажиллагааг демпинг гэдэг. Энэхүү хямд үнийн өрсөлдөөнөөс үүдэн импортлогчийн дотоодын үйлдвэрлэлд хохирол учрах, эсхүл учирч болзошгүй учраас демпингийн эсрэг арга хэмжээ авахыг ДХБ-ын хэлэлцээрээр зөвшөөрсөн байдаг.</p> <p>Дотоодын үйлдвэрлэгчид хянан магадалгаа явуулах хүсэлтийг Засгийн газрын эрх бүхий байгууллагад хүргүүлсний дагуу хяналт шалгалт хийж тухайн бараа нь экспортлогч орны ижил төрлийн бараанаас доогуур үнээр худалдаалагдаж, дотоодын ижил төрлийн үйлдвэрлэгчдэд материаллаг хохирол учирсан, эсхүл учруулах аюул бий болсон гэдгийг тогтоосон тохиолдолд л ийм бараанд демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх буюу демпингийн эсрэг татварыг демпингийн зөрүүгээр хил дээр ногдуулах боломж үүснэ.</p> <p>Гишүүн орнууд энэ арга хэмжээнийхээ талаар ДХБ-ын демпингийн эсрэг арга хэмжээний хороонд мэдээлж байх хэрэгтэй. Демпингийн эсрэг арга хэмжээг үндэслэлгүй авахыг хориглодог.</p> <p>ДХБ-ын дүрмийн дагуу ялгаатай үнээс гадна, импортлож буй улсынх нь яг ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрт материаллаг хохирол учруулсан тохиолдолд л демпингийн эсрэг арга хэмжээг авч болно. Үүнийг шалтгаант холбоо гэдэг.</p>

1994 оны ТХЕХ-ийн 6-р Зүйлийг (Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр) хэрэгжүүлэх тухай ДХБ-ын хэлэлцээр нь демпингийн эсрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нарийн тодорхойлсон, ил тод журмыг зааж өгсөн байдаг. Ялгаатай тогтоосон гэх үнийг хэмжих ба учруулсан гэж үзэж буй хохирлыг тодорхойлох маш өндөр түвшинд боловсруулсан зарим аргачлалуудыг боловсруулсан байдаг. Хэрэв тухайн экспортлогч компанийн зүгээс импортлогч улсад нийлүүлсэн барааны үнэ нь эх оронд нь тогтсон байдаг хэвийн үнээс доогуур байвал, демпингийн эсрэг арга хэмжээг үүсгэж болно. Хэвийн үнэ нь үйлдвэрлэлийн хатуу тогтсон болон хувьсах зардлууд, мөн үйлдвэрлэл болон худалдаатай холбогдож байдаг бусад олон төрлийн зардлуудаас бүрддэг. Хэрэв уг барааны хувьд дотооддоо маш цөөн хэмжээгээр борлогддог бол хэвийн үнийг тооцоолохдоо гуравдагч зах зээлд хамгийн дөхүү харьцуулж болохуйц үнэ, эсхүл экспортлогч компанийн тооцоолсон үйлдвэрлэлийн зардал болон бусад зардлуудаа багтаасан боломжийн үнийн дүнг (ашиг орлоготой нь хамт) харьцуулан тооцно. Хэрэв үүнд ямар нэгэн экспортын үнэ байхгүй, эсхүл худалдаа нь хоорондоо хамааралтай талуудын дунд хийгдсэн учраас уг үнийг нь авч үзэхэд найдваргүй гэж үзвэл, эсхүл бие даасан худалдан авагчид ногдуулах байсан гэж үзсэний үндсэн дээр, эсхүл өөр бусад зарим боломжийн үндэслэлээр уг экспортын үнийг тооцоолон гаргаж болно. ҮХЕХ болон Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн аль аль нь материаллаг хохирлыг тодорхойлоогүй байдаг боловч Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр нь материаллаг хохирол учирсан эсэхийг нягталж үнэлэхдээ харгалзан үзэх хэд хэдэн хүчин зүйлсийг дүрслэн харуулсан жагсаалтыг агуулсан байдаг. Яг бүрэн төгс гэж үздэггүй боловч уг жагсаалтад борлуулалт, ашиг, үйлдвэрлэлийн гарц, зах зээлд эзлэх хувь хэмжээ, бүтээмж, хөрөнгө оруулалтын өгөөж, эсхүл нөөц чадлын ашиглалтын бодит болон боломжит бууралт; дотоодын үнэд нөлөөлсөн хүчин зүйлс; демпингийн үнийн зөрүүний цар хүрээ; мөнгөн урсгал, бараа материал, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, өсөлт, хөрөнгө босгох чадвар эсвэл хөрөнгө оруулалт зэрэгт бодитоор бөгөөд сөргөөр нөлөөлсөн байх магадлал зэргийг хамруулсан байдаг.

Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Safeguards), Үнийн харьцуулалт хийх улс (analogue country), өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр буух тухай [хуулийн] заалт (boomerang clause), өрсөлдөөний бодлого ба демпингийн эсрэг арга хэмжээ (competition policy and anti-dumping measures), Де-минимис буюу үлэмж бага хэмжээний демпингийн зөрүү (de minimis dumping margins), гаалийн татвар бага байлгах зарчим (lesser duty principle), түрэмгийгээр үнэ тогтоохыг (predatory pricing) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
60	Antitrust laws	<p>Монополын эсрэг хуулиуд. Мөн өрсөлдөөний тухай хууль гэж хэлдэг. Эдгээр нь өрсөлдөөний бодлогыг бүрдүүлж байдаг олон тооны дүрэм, журмууд ба дотоодын зах зээл дэх зах зээлийн эрх мэдлийг буруугаар ашиглахгүй байх замаар компаниудад өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг. Гэвч ялангуяа АНУ-д монополын эсрэг хуулиуд нь өөрийн улсын нутаг дэвсгэрээс гаднах цар хүрээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Antitrust” буюу монополын эсрэг хэмээх энэ нэр томьёо нь 1880-аад болон 1890-ээд онд Америкийн Нэгдсэн Улсад үүссэн ойлголтоос үүдэлтэй бөгөөд зарим аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд хоорондоо харилцан холбоотой томоохон хэмжээний итгэлцэл буюу монопол зохион байгуулалтад орж ажиллахдаа үнийн механизмыг нурааж байсан байна. 1890 онд батлагдсан Шерманы хууль (The Sherman Act) нь АНУ-ын Монополын эсрэг хуулийн тулганы чулуу, билэг тэмдэг болсон хэвээр байна. 1994 онд Төлөөлөгчдийн танхимын хорооны тайланд тэмдэглэснээр бол “юуны өмнө, монополын эсрэг байх үзэл нь Америкчуудын хувьд онцгойлон дээдэлдэг олон ургалч үзэл, худалдааны эрх чөлөө, зах зээлд нэвтрэх боломж, магадгүй хамгийн чухал нь - сонголт хийх эрх чөлөөнд гүн гүнзгий суурилсан байдаг. Монополын эсрэг хуулийг зөрчсөн гэдэг нь нотлогдсон гэм буруутай этгээдүүдэд оногдуулах ял шийтгэл нь АНУ-д нэлээд ноцтой байх хандлагатай байдаг, учир нь шүүхийн зүгээс гэмт хэрэгтнүүдэд гурав дахин их хохирол учруулах чадамжтай байдаг.</p> <p>Картель (cartel), Клейтоны хууль (Clayton Act), дотоодын хуульд эс захирагдсан, нутаг дэвсгэрийн гадна (extraterritoriality), болон Веб-Померины хуулийг (Webb-Pomerene Act) үзнэ үү.</p>
61	ANZCERTA	<p>Австрали, Шинэ Зеландын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээр (ANZCERTA) буюу гол төлөв CER хэмээн нэрлэдэг. Энэ нь 1983 оны 1 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон чөлөөт худалдааны гэрээ. Үүнийг түүнээс хойш хэд хэдэн удаа нягтлаад, шинэчилжээ. Түнш орнуудын хооронд хийгдэж буй бараа бүтээгдэхүүний худалдаа нь тарифаас чөлөөлөгдөх бөгөөд үүнд тоо хэмжээний хязгаарлалтууд гэж байхгүй. Түнш орнууд бие биеийнхээ эсрэг демпингийн эсрэг арга хэмжээ авахгүй ба харин өрсөлдөөний тухай хуулиуддаа найдахаар тохиролцсон байдаг. Татаасны хохирлыг саармагжуулан тэнцэтгэж, импортод татвар ногдуулах нөхцөл одоо ч байсаар л байгаа. Засгийн газрын худалдан авалтын хувьд, талууд бие биедээ бусад үндэсний нөхцөлийг харилцан тохиролцоно. Австрали болон Шинэ Зеланд улсууд хүнс, хүнсний бүтээгдэхүүний стандарт, хүнс, хүнсний бүтээгдэхүүнд хяналт шинжилгээ хийх арга хэмжээнүүд, хорио цээрийн зохицуулалтууд, гаалийн дүрэм журам, бизнесийн хуулиуд зэрэг стандартуудаа уялдуулах чиглэлээр ажиллаж байна. 1998 онд Үйлчилгээний худалдааны ANZCERTA-гийн Протоколоор дамжуулан, чөлөөт худалдааны хэлэлцээрийн цар хүрээнд үйлчилгээг оруулсан байна.</p> <p>Транс-Тассманы Харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалт (Trans-Tasman Mutual Recognition Arrangement) гэдгийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
62	APEC (Asia Pacific Economic Cooperation)	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК). 1989 онд байгуулагдсан. АПЕК-ийн үндсэн зорилтууд нь (а) уг бүс нутагт эдийн засгийн өсөлт болон хөгжлийг тогтворжуулна, (б) бүс нутгийн худалдааны эвслийн байгуулал гэхээсээ илүү олон талт нээлттэй худалдааны системийг бэхжүүлэх, (в) аюулгүй байдлын асуудал гэхээс илүү эдийн засгийн асуудалд төвлөрөх, (г) бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө, технологийн урсгалыг дэмжсэнээрээ бүтээлч харилцан хамаарлыг хөхиүлэн дэмжих зорилготой. 1997 онд баталсан гишүүнчлэлийн шалгуур нь: (а) элсэх өргөдөл гаргаж буй улс нь Ази-Номхон Далайн бүс нутагт байрладаг байна, (б) АПЕК-ийн одоогоор байгаа гишүүн улс орнуудтай бодитой, өргөн хүрээний эдийн засгийн холбоотой байна; нэн ялангуяа хүсэлт гаргасан тухайн орны олон улсынх нь худалдаанд АПЕК-ийн гишүүн орнуудтай хийдэг худалдааны эзлэх хувь хэмжээний үнийн дүн нь харьцангуй өндөр байна, (в) тус улс нь гадагшаа чиглэсэн, зах зээлийн чиг баримжаатай эдийн засгийн бодлоготой байна, (г) Өргөдөл гаргаад амжилттай элссэн улсад, АПЕК-т элсэж орсон цагаас нь эхлээд, АПЕК-ийн Үйл ажиллагааны хөтөлбөрт хамрагдсан Үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд оролцож эхлэн хэрэгжүүлэхийн тулд Бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргахыг шаардах болно. АПЕК-ийн хөтөлбөрийн гол зорилго нь, 2020 он гэхэд бүх гишүүн орнуудын дунд буй худалдаа ба хөрөнгө оруулалтын бүх саад тотгоруудыг арилгах явдал. Өндөр хөгжсөн орнууд 2010 гэхэд ийнхүү хийсэн байхаар шийдсэн байдаг.</p> <p>Богорын тунхаглал (Bogor Declaration), АПЕК-ийн Манилагийн Үйл ажиллагааны төлөвлөгөө (Manila Action Plan for APEC), нээлттэй бүсчлэлийн онол (open regionalism), Осакагийн Үйл ажиллагааны төлөвлөгөө (Osaka Action Agend), Сэулийн тунхаглал (Seoul Declaration), Шанхайгийн хэлцэл (Shanghai Accord), АПЕК-ээс эхэлсэн зах зээл болон бусад [шинээр элсэх] зах зээлүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх (strengthening the functioning of markets and other entries beginning with APEC) гэснийг үзнэ үү.</p>
63	APEC Business Advisory Council	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Бизнесийн зөвлөх эрх, үүрэг бүхий зөвлөл.</p>
64	APEC Committee on Trade and Investment	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Худалдаа ба хөрөнгө оруулалтын хороо. Уг хороо 1993 онд байгуулагдсан, АПЕК-ийн бүс нутгийн худалдаа ба хөрөнгө оруулалтын урсгалыг, нэн ялангуяа худалдааны бодлого, маргаан шийдвэрлэхэд зуучлах, төрийн зохицуулалтыг халах, жижиг дунд үйлдвэрлэгчид, стандартууд болон стандартад нийцүүлэх, гаалийн дүрэм журмууд, өрсөлдөөний бодлого, гарал үүслийн дүрэм, хөрөнгө оруулалт, тарифын бус арга хэмжээнүүд гэх мэт салбаруудыг либералчлах болон дэмжиж ажиллахад чиглүүлэн үйл ажиллагааны хөтөлбөрөө зохицуулж ажилладаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
65	APEC Economic and Technical Cooperation	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Эдийн засаг ба техникийн хамтын ажиллагаа. АПЕК-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн гурван баганын нэг. Энэ нь АПЕК-ийн зорилгуудыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд, бодлогын нэгдсэн үзэл баримтлалыг боловсруулах, хамтарсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бодлогын яриа хэлэлцээнд оролцох зэргээр ажилладаг ба 1995 оны 11-р сард АПЕК-ийн сайд нарын уулзалтын үеэр байгуулагдсан. Хамтын үйл ажиллагаа нь хүний нөөцийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн шинжлэх ухаан ба технологи, жижиг дунд үйлдвэрлэгчид, эдийн засгийн дэд бүтэц, эрчим хүч, тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоо ба мэдээлэл, худалдаа а хөрөнгө оруулалтын тоон мэдээ өгөгдөл, худалдааг сурталчлан таниулах, далайн нөөц эх үүсвэрийг хамгаалах, загас агнуур, хөдөө аж ахуйн технологийн салбаруудад өрнөдөг.</p> <p>АПЕК-ийн ажлын хэсгүүд (APEC working groups), Богорын Тунхаглал (Bogor Declaration), Осакагийн Үйл ажиллагааны хөтөлбөрийг (Osaka Action Agenda) үзнэ үү.</p>
66	APEC Economic Leaders' Meetings	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) удирдагчдын уулзалт.</p> <p>Богорын тунхаглал (Bogor Declaration) болон Осакагийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг (Osaka Action Agenda) үзнэ үү.</p>
67	APEC Eminent Persons' Group	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Нэр хүндтэй хүмүүсийн бүлэг (EPG). Энэ нь 1992 онд Бангкокд байгуулагдсан. Үүнд эрдэмтэн судлаачид, АПЕК-ийн гишүүн орнуудын бизнес эрхлэгчид зэрэг нэр хүндтэй хувь хүмүүсээс бүрддэг. EPG нь худалдааны либералчлал, маргаан шийдвэрлэхэд зуучлах, байгаль орчны асуудлууд, хөрөнгө оруулалт, стандартууд зэрэг асуудлуудыг хамарсан хоёр жилийн тайланг гаргасан байдаг. Осакад 1995 онд зохион байгуулагдсан АПЕК-ийн Тэргүүлэгч нарын уулзалтын үеэр, өөрийн үүрэг даалгавраа гүйцэтгэж дууслаа гэдгээ тунхагласан. Үүнийг хэрэв шаардлагатай бол, дахин шинэчлэн боловсруулах боломжтой.</p>
68	APEC framework for liberalisation and facilitation	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) либералчлал ба хөнгөвчлөх зорилтуудын бүтэц, хамрах хүрээ. Осакагийн Үйл ажиллагааны хөтөлбөрт тайлбарласанчлан, Богор-ын Тунхаглалд даасан зорилтууддаа хүрэх АПЕК-ийн либералчлал ба хөнгөвчлөх үйл явц. АПЕК-ийн Манилагийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг (Manila Action Plan for APEC) үзнэ үү.</p>
69	APEC individual action plans	<p>Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Гишүүн орон тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд. Богорын тунхаглалын зорилтуудад хүрэхийн тулд АПЕК-ийн гишүүн орнуудын хийх сайн дурын үйл ажиллагаануудыг тайлбарладаг. Осакагийн Үйл ажиллагааны хөтөлбөрийн үеэр эдгээр нь илүү тодорхой хэлбэрээ олсон байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>[Тухайн улсын] бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус улсын санал болгож буй бие даасан үйл ажиллагаануудаас гадна, зохистой гэж үзсэн тохиолдолд, худалдаа ба хөрөнгө оруулалтыг дэмжих либералчлалын хувьд хамтарсан үйл ажиллагаа явуулахыг санал болгосон байдаг. Үүнд 15 гол талбаруудад авч хэрэгжүүлэх алхмуудыг агуулсан байдаг: тариф, тарифын бус арга хэмжээ, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, стандарт ба стандартын тохирлууд, гаалийн дүрэм журмууд, оюуны өмчийн эрх, өрсөлдөөний бодлого, засгийн газрын худалдан авалт, төрийн зохицуулалтыг халах, гарал үүслийн журам, маргаан шийдвэрлэхэд зуучлах, бизнес эрхлэгчдийн хөдөлгөөнт байдал, Уругвайн үе шатны хэлэлцээрийн үр дүнг хэрэгжүүлэх, мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх гэх мэт. Бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд илүү нарийвчилсан богино хугацааны үйл ажиллагаануудыг агуулсан байдаг боловч, тэдгээр нь урт хугацааны бодлого, чиглэлүүдийн хувьд тийм ч тодорхой заагаагүй байдаг. Эдгээрийг тогтмол шинэчилдэг. Дэс дараалан хийгдэх тодорхой нөхцөлүүдийг (rolling specificity) үзнэ үү.</p>
70	Appellate body	<p>Давж заалдах шатны байгууллага. “Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай Харилцан ойлголцох баримт бичиг”-ийн дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байнгын үйл ажиллагаатай хуулийн этгээд нь Хөндлөнгийн хэсгээр хэлэлцүүлэхээр гаргаж өгсөн хэргийн холбогдолтой гомдлуудыг авч хэлэлцэнэ. Ийнхүү давж заалдахаар гаргасан гомдлуудын үндэслэл нь ДХБ-ын хууль, эрх зүйн хүрээнд хязгаарлагдана. Давж заалдах шатны байгууллагын гишүүд нь, хууль зүйн салбарт туршлага хуримтлуулсан гэдгээ харуулж чадсан, олон улсын худалдаа ба ДХБ-ын холбогдох хэлэлцээрүүдийн хувьд эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн хүмүүс байдаг ба тэд ямар нэгэн засгийн газартай холбогдолгүй байдаг. Маргаан шийдвэрлэх (dispute settlement), маргаан шийдвэрлэх байгууллага (dispute settlement body), маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөл (panel), Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг (WTO understanding on dispute settlement) зэргийг үзнэ үү.</p>
71	Appellations of origin	<p>Гарал үүслийн нэршлүүд. Тухайн улс, бүс нутаг эсвэл орон нутгаас үүссэн уг бүтээгдэхүүний гарал, газар зүйн заалтын хэлбэрүүд нь, байгаль, хүний хүчин зүйлсийг хамарсан газар зүйн орчноосоо мөн чанар нь онцгойлон хамаарч байдаг тодорхой чанар эсвэл онцлог шинж чанартай байдаг. Тэдгээр асуудлуудыг ДХБ-ын Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээрт (OЕЭХХАХ) хамруулсан байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
72	Applied tariff rates	<p>Мөрдөж буй (импортод бодитоор ногдуулж буй) тарифын хувь хэмжээ. Тарифын энэхүү хувь хэмжээний дагуу импортын бараанд хил дээр гаалийн татвар ногдуулдаг. Энэ нь ДХБ-ын гишүүн орнуудын тохиролцож үүрэг хүлээсэн (bindings) буюу заавал мөрдөх хувь хэмжээнээс доогуур байж болно.</p> <p>Үүрэг хүлээсэн тариф (bindings), үүрэг хүлээсэн тарифын хязгаар (ceiling bindings), нэрлэсэн тарифын хувь хэмжээ (nominal tariff rates), нэг шатлалтай тариф (single-column tariff), олон шатлалтай тариф (multi-column tariff) үзнэ үү.</p>
73	Arab Maghreb Union	<p>Арабын Магреб Холбоо. Энэ холбоо нь Алжир, Ливи, Мавритан, Морокко, Тунис зэрэг орнуудаас бүрддэг. Улстөр, эдийн засаг, нийгмийн зорилтууд, мөн 2000 он гэхэд Нэгдсэн зах зээлд хүрсэн байх зорилттойгоор 1989 онд байгуулагдсан. Нарийн бичгийн дарга нарын газар нь Рабатад байрладаг. Магреб улс (Maghreb) үзнэ үү.</p>
74	Arbitration	<p>Арбитрын шүүх. Маргааныг хөндлөнгийн шүүхээр шийдвэрлүүлэх бөгөөд энэ нь талуудыг нэгтгэхэд чиглэсэн маргаан зуучлах үйлчилгээнээс илүү албан ёсны, шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанаас арай бага түвшний арга. Арбитрын шүүхэд харилцан тохиролцож буй талууд гол төлөв маш сайн тодорхойлсон шүүх ажиллагааны журам буюу хянан шийдвэрлэх хэм хэмжээг дагаж мөрддөг. Арбитрчийн гаргасан шийдвэр нь тэдний хувьд үүрэг хүлээсэн, заавал биелүүлэх шийдвэр байх болно гэдгийг тэд ихэвчлэн урьдчилан тохиролцсон байдаг. Арбитрын шүүх ажиллагаанууд, хэрэв маргалдаж буй талууд тухайн асуудалд эрх тэгш бөгөөд тодорхой шийдлийг эрэлхийлж байвал ихээхэн ач тустай байж чаддаг.</p> <p>Маргаан шийдвэрлэх (dispute settlement), Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг (WTO understanding on dispute settlement) үзнэ үү.</p>
75	Areeda-Turner test	<p>Арийда-Тиорнерийн шалгалт. “Хуулийн дагуу өрсөлдөхүйц үнэ болон түрэмгий гэж хэлж болохуйц үнэ хоёрыг оновчтой ялган заагласан шугамыг тодорхойлж гаргахын тулд, тухайн компанийн нэрлэсэн үнэ болон түүний зардлын хоорондын харьцааг шалгаж үзэх” аргыг Филип Арийда (Phillip Areeda) болон Доналд Ф Тиорнер (Donald F Turner) нар 1975 онд боловсруулж, санал болгосон байдаг. Арийда болон Тиорнер нарын дүгнэж хэлснээр бол, дундаж ханшийн түвшинд эсвэл түүнээс дээш үнэтэй биш л бол, доогуур үнэ нь (1) богино хугацаат ахиуц зардлууд эсвэл (2) дундаж хувьсагч зардлуудыг боломжтой гэж таамагласан бол үүнийг түрэмгий гэж үзэх ёстой бөгөөд монополист этгээд нь өөрийн үнийг “сурталчлан таниулах зорилготой” эсвэл өрсөлдөгчийнхөө доогуур үнэд л нийцүүлэх гэсийм гэсэн үндэслэлүүдээр уг сонирхлоо хамгаалах боломжгүй. Тэдний хэлж буйгаар, хэдийгээр ахиуц ашигтай холбоотой тоон мэдээлэл өгөгдөл бараг ихэнх тохиолдолд олж авах боломжгүй байдаг боловч, харьцангуй урьдчилан тооцоолох боломжтой дундаж хувьсагч зардлаас доогуур үнэ байгаа бол үүнийг хууль бус гэж дүгнэж үзнэ. Монополын эсрэг (antitrust laws), түрэмгийгээр үнэ тогтоох (predatory pricing) зэргийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
76	Arm's-length pricing	Сунгасан гарын зарчмаар тооцсон бодит үнэлгээ. Энэ нь олон улсад худалдаалагдаж байгаа бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнүүдэд тогтоосон зах зээлийн үнийг гуйвуулсан эсэхийг үнэлэхэд зориулсан зарчим. Уг зарчмын дагуу харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын арилжааны болон санхүүгийн харилцаанд тавигдсан нөхцөлүүд нь бие даасан/хараат бус этгээдүүдийн хоорондын ижил нөхцөл байдалд хийгдэж буй ижил төрлийн ажил гүйлгээнд тавигдсан нөхцөлүүдээс ялгаатай байх ёсгүй гэж үздэг. Сунгасан гарын зарчмаар тооцсон бодит үнэлгээг голдуу бие даасан/хараат этгээдүүд харьцуулж үзэж болохуйц нөхцөл байдлуудын хүрээнд сунгасан гарын зарчмаар харилцаж байхдаа тогтоож болох байсан үнэ гэдэг байдлаар тодорхойлсон байдаг. Уг шалгуурыг хангасан эсэхийг үнэлэх аргачлалууд нь маш нарийн цогц байх магадлалтай. Үнэ шилжүүлэлтийг (transfer pricing) үзнэ үү.
77	Arrangements for Consultations on Restrictive Business Practices	Бизнесийг хязгаарласан үйл ажиллагааны талаарх зөвлөгөөнд зориулсан зохицуулалтууд. 1960 онд баталсан ТХЕХ-ийн механизм нь, бизнесийг хязгаарласан үйл ажиллагаанууд нь тарифыг бууруулж мөн тоо хэмжээний хязгаарлалтуудыг арилгасны үр ашгийг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн байдаг. Уг зохицуулалтад зөвлөснөөр бол, гэрээний талууд, жишээ нь ТХЕХ-ийн гишүүн улс орнуудын хувьд, хэрэв гэрээний аль нэг тал нь ийнхүү хүсэлт гаргавал, зохистой гэж үзсэн үедээ хоёр талт болон олон талт зөвлөгөөнүүдэд оролцох ёстой. Бизнесийг хязгаарласан үйл ажиллагаанууд байна гэж санаа нэгдсэн бол, уг асуудлыг хаягласан талд, үүний хор хөнөөлтэй нөлөөг арилгах талаар арга хэмжээ авахыг үүрэг болгодог байна. Энэхүү механизм нь 1996 он хүртэл зогссон байсан боловч, АНУ нь фото зургийн материалуудтай холбоотой асуудлаар Япон улстай маргаан өрнүүлсэн үеэрээ үүнийг хэрэглэхийг уриалсан байна.
78	Arrangement on Guidelines for Officially Supported Export Credits	Албан ёсоор дэмжигдсэн экспортын зээлд зориулсан зааварчилгаатай холбоотой тохиролцоо. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) хуулиар үүрэг хүлээгээгүй, заавал биелүүлэх шаардлагагүй энэхүү зохицуулалтын арга хэмжээг 1978 онд анх хийж байсан. Энэ нь экспортын зээлийн нарийн дэг журамтай зах зээлийг бүрэлдүүлэх мөн зээлийн нөхцөлийн хувьд арай илүү таатай нөхцөлүүдийг олгосноороо улс орнуудын хооронд өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилготой. Түүнээс хойш үүнийг олон удаа шинэчилсэн байдаг. Уг зохицуулалтын арга хэмжээ нь засгийн газраас шууд сунгасан эсвэл дэмжсэн эсвэл засгийн газрын гаргасан баталгааны дор тэдний өмнөөс гаргасан экспортын зээлд хамаатай. Хэрэв зээл олголт нь хандивлагч орноос авдаг худалдан авалттай холбогдсон байвал, зээл тусламжийн хөтөлбөрүүдийн дор олгосон хөнгөлөлттэй санхүүжилтийг ч хамруулсан байдаг. Холимог зээл (mixed credits), Уяж холбосон буцалтгүй тусламжийг (tied aid) үзнэ үү.
79	Arrangement Regarding Bovine Meat	Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээрийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
80	Article 113 Committee	113-р Зүйлийн хороо. 113-р Зүйлийн хороо байгуулагдахаас өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан хүмүүсийг хэлнэ. Энэ хороо нь уг нэрийг Ромын Олон улсын гэрээний 113-р Зүйлийн дагуу нэрлэсэн байна.
81	Article 133 Committee	133-р Зүйлийн хороо гэж гол төлөв тайлбарладаг. Энэ нь, тарифын нэгдсэн зарчмууд, демпингийн эсрэг арга хэмжээ, худалдааны хэлэлцээрүүд, худалдааг либералчлах асуудал зэрэг дээр тулгуурласан Европын эдийн засгийн нийгэмлэгийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн Ромын олон улсын гэрээний нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбарын 133-р Зүйлийн дагуу нэрлэсэн байна.
82	Article 20 of the WTO Agreement on Agriculture	ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 20-р Зүйл. Үргэлжлэл зүйл.
83	ASEAN	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН). Тус бүс нутагт эдийн засгийн өсөлт болон улс төрийн тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжих үүднээс 1967 онд байгуулагдсан. Үүнд Бруней, Камбож, Индонез, Лаос, Малайз, Мьянмар (Бирм), Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам гэсэн орнуудаас бүрдэнэ. Үүний гол зорилго нь, (а) эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшил, соёлын хөгжлийг хурдасгах, (б) бүс нутгийн энх тайван ба тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжих, (в) эдийн засаг, нийгэм, соёл, техник, шинжлэх ухаан болон захиргааны талбарт хамтын ажиллагаа, харилцан туслалцах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих явдал. АСЕАН-ийн Чөлөөт худалдааны хэлэлцээр (AFTA), АСЕАН-ийн Алсын хараа 2000 (ASEAN Vision 2000) үзнэ үү.
84	ASEAN Free Trade Agreement	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АСЕАН) Чөлөөт худалдааны хэлэлцээр. АСЕАН-ийн Чөлөөт худалдааны хэлэлцээр (AFTA) үзнэ үү.
85	ASEAN Vision 2000	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АСЕАН) Алсын хараа 2000. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг АСЕАН-ы анхны зорилгыг бүрэн биелүүлэхийн тулд 1997 оны 12-р сарын 15-нд баталсан. Эдгээр зорилтуудын олонх нь 2020 он гэхэд АСЕАН-ийн Чөлөөт худалдааны хэлэлцээрийг (ЧХХ-AFTA) бүрэн хэрэгжүүлэх мөн АСЕАН-ийн гишүүн орнуудын хооронд хөрөнгө оруулалтын чөлөөт урсгалыг хангах зэрэг эдийн засгийн агуулгатай байдаг. АСЕАН-ийн Хөрөнгө оруулалтын бүсийг (ASEAN Investment Area) үзнэ үү.
86	Associated foreign direct investment	Гадаадын нэгдсэн шууд хөрөнгө оруулалт. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD-НҮБХХБХ) тодорхойлсноор бол, салбар (охин) компани байгуулах замаар, эсхүл одоогоор байгаа салбар (охин) компаниудаа өргөжүүлэх замаар гадаадын шууд хөрөнгө оруулалт хийх гэж томьёолсон байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
87	Association of Caribbean States	Карибын тэнгисийн орнуудын холбоо. Энэ нь 1995 оны 8-р сард хүчин төгөлдөр болсон ба Латин Америкийн болон Карибын тэнгисийн 25 улс орнуудаас бүрддэг. Тэд Карибын тэнгисийн нийгэмлэг (CARICOM), Колумбия, Коста Рика, Куба, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Эл-Салвадор, Гватимал, Гайт, Гондурас, Мексик, Никарагуа, Суринам, Венесуэл зэрэг орнуудын гишүүнчлэлээс тусдаа бөгөөд зорилго нь дэлхийн дөрөв дэх томоохон худалдааны бүлэг байгуулах явдал.
88	Association of Tin Producing Countries	Цагаан тугалга үйлдвэрлэгч орнуудын холбоо. Энэ нь цалин хөлс сайтай, тэгш шударга өгөөжтэй үр ашгийг цагаан тугалга үйлдвэрлэгчид олгох мөн шударга, тогтвортой үнээр хангалттай хэмжээнд хэрэглэгч нарт хүргэх зорилттойгоор 1983 онд байгуулагдсан. Гишүүд нь: Болив, Конгогийн (Зайр) Бүгд Найрамдах Улс, Индонез, Малайз, Нигер, Тайланд.
89	Asymmetrical trade agreements	Тэгш хэмт бус худалдааны хэлэлцээр. Эдгээр нь хэлэлцээрийн хоёр талуудын үүрэг хариуцлагуудын өөр өөр багц бүхий хоёр талт худалдааны хэлэлцээр. Энэ хүрээнд тарифыг бууруулах, эсхүл тарифын бус арга хэмжээнүүдийг аажмаар халах зэрэгт зориулсан өөр өөр цагийн хуваариуд байж болно. Өөр нэг тохиолдолд, хэлэлцээрийн нэг тал нь нөгөө талынхаа бүтээгдэхүүнүүдийг өөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрх олгохдоо, оронд нь эргээд ижил төрлийн нөхцөл хүсэн хүлээхгүй байж болно. Ийм хэлэлцээрүүдийн жишээ бол Ломын (Lome) конвенц ба SPARTECA зэрэг болно. Карибын Тэнгисийн сав газрын санаачилга, GSP-ийг (Caribbean Basin Initiative, GSP) үзнэ үү.
90	Asymmetrical trade openness	Тэгш хэмт бус худалдааны нээлттэй байдал. Экспортолж буй улс орнуудын зах зээлд нэвтрэх тал дээр бодит эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн тэгш бус байдалд тулгуурласан дэлхийн худалдааны системийн тухай ойлголт. Энэ ойлголт нь ялангуяа 1980-аад онд АНУ-д өсөн нэмэгдэж байсан худалдааны алдагдлын дүн шинжилгээний нэгэн хэсэг болж давамгайлж байсан. Бусад улс орнууд янз бүрийн түвшинд тийм ч нээлттэй биш байсан бөгөөд арилжаа худалдааны практикийг баримталж байсан боловч тэд АНУ-ын нээлттэй зах зээлээс бүгд үр ашиг хүртэж байлаа. Нэг талыг баримталсан түрэмгий харилцааны онол (aggressive unilateralism), чөлөөт ба шударга худалдаа (free and fair trade), 301-р Хэсэг (Section 301), 301-р супер хэсгийг (Super 301) үзнэ үү.
91	At-the-border barriers	Хил дээрх саад тотгорууд. Эдгээр нь импортын тоо хэмжээний хязгаарлалт (квот)-ыг хамруулсан, тарифын болон тарифын бус арга хэмжээнүүдийн үндсэн гол шугамаас бүрддэг. Зарим нь валютын ханшуудыг энэ ангилалд нэмж оруулдаг бол, үүнийг нь худалдааны сайд нарын түвшинд гол төлөв хамгаалдаггүй. Хилийн гадна болдог асуудлууд (behind-the-border issues) гэснийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
92	Audiovisual services	<p>Дуу, дүрс бичлэгийн үйлчилгээ. Кино болон видео хуурцагнуудыг үйлдвэрлэж, түгээж, дэлгэн үзүүлэх үйлчилгээнүүд. Энэ салбарт бодлогын зарим эмзэг асуудлууд огтлолцож байдаг. Үүнд соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанар, оюуны өмчийн эрхийн хамгаалал, худалдааг либералчлах зорилго зэргийг хамруулдаг. Эдгээр мөр зэрэгцэн өрсөлдөх шаардлагууд нь, технологийн огцом өөрчлөлт болон тэдний санал болгож буй дуу, дүрс бичлэгийн үйлчилгээний түгээлтийн шинэ боломжууд зэрэг илүү өргөн хүрээний талбарын эсрэг өөрсдөө нүүр тулан гарч ирэв. Засгийн газрууд заримдаа үндэсний соёлын онцгой шинж чанарыг хадгалж хамгаалах оролдлогынхоо хүрээнд, сонин хэвлэл, радио, телевизийн станцуудад [телевизийн] дэлгэцэд гаргах тал дээр нь квот тогтоох болон хэвтээ чиглэлд тэлэх-эзэмшлийн тал дээр нь хязгаарлалт тавьдаг.</p> <p>Уругвайн үе шатны хэлэлцээр дэх дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд (audiovisual services in the Uruguay Round), өргөн нэвтрүүлгийн удирдамж (broadcasting directive), өргөн нэвтрүүлэг болон худалдааны дотоодын/үндэсний агуулгын тухай журам (local content rules), худалдаа ба соёл (trade and culture) зэргийг үзнэ үү.</p>
93	Audiovisual services in the Uruguay Round	<p>Уругвайн үе шатны хэлэлцээр дэх дуу, дүрс бичлэгийн үйлчилгээ. Уругвайн үе шатны үйлчилгээний хэлэлцээрт гол тоглогчид болох Европын хамтын нийгэмлэг болон АНУ-ын хувьд энэ нь илүү их маргаан хэл ам дагуулсан салбаруудын нэг байлаа. Бусад олон оролцогчдын адил, Европын нийгэмлэг нь энэ талбарт чухал соёлынхоо ашиг сонирхлыг хамгаалах хэрэгтэй гэж үзсэн байдаг. АНУ-ын хувьд энэ салбарын ач холбогдол нь, түүний үзвэр үйлчилгээний салбарын экспортынх нь үнийн дүнгийн талаас илүү хувийг кино, видео хуурцагнууд эзэлж байдаг бодит үнэнд оршиж байв. Тэрээр ихэнх улс орнуудын зах зээлд дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүдээ маш сайн нэвтрүүлж чадсандаа таатай байдаг бөгөөд түүний хувьд зах зээлд нэвтрэх бодит саад тотгорууд нь ерөнхийдөө жинхэнэ асуудал биш мэт боловч, тэрээр үлдсэн саад тотгоруудыг халахыг тууштай эрэлхийлсэн. Гэвч тэрээр, шинэ технологиуд болон шинэ үйлчилгээнүүд илүү арилжааны хэлбэртэй болохын хэрээр, нэвтрэхийг хүссэн зах зээлдээ эрчтэйгээр өргөжин тэлэх боломжийг нь хасах магадлалтай гэж үзсэн учраас, шинэ технологиуд, түгээлтийн механизмууд, түгээлтийн сувгуудад оноосон Европын өргөн нэвтрүүлгийн удирдамжид (European Broadcasting Directive) заасан, үндэсний квотын тогтолцоог үргэлжлүүлэн сунгах шийдвэртэй тулж, эсэргүүцэн маргалдсан байна. АНУ-ын хувьд харьцангуй бага цочирдуулсан зүйл бол, Европын хувьд өөрсдийн үндэсний кино үйлдвэрлэлд татаас олгох зорилгоор, кино театруудад зах зээлд нь нэвтрэх зөвшөөрөл олгохдоо татвар ногдуулдаг туршлага байлаа.</p> <p>Хэдийгээр YXEX (GATS)-ийн зүйл заалтууд нь энэ салбарт мөн хамаарах боловч, хэлэлцээний эцэст эдгээр зөрчилдөөн нь</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд нь, ҮХЕХ-рт ямар нэгэн хавсралтгүй, үйлчилгээний цорын ганц томоохон салбар болох нөхцөл байдалд хүргэсэн байна. Уругвайн үе шатны хэлэлцээрт маш цөөхөн оролцогчид энэ талбарын хувьд сайн үүрэг амлалт өгсөн байдаг. Европын өргөн нэвтрүүлгийн удирдамжид шинэ үйлчилгээнүүд болон шинэ технологиудыг хамруулах асуудал нь 1995 оны 3-р сар хүртэл буюу Европын хамтын нийгэмлэг нь шинэ үйлчилгээнүүдэд зориулсан цар хүрээгээ өргөжүүлэхгүй байхаар шийдэх хүртэл шийдэгдээгүй хэвээр байсан байна.</p> <p>Дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд (audiovisual services) болон Соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанар (cultural identity) зэргийг үзнэ үү.</p>
94	Australian argument for protection	<p>Хамгаалалтын талаарх Австралийн маргаан, мэтгэлцээн. Бригдэний тайлангийн (Brigden Report) дүгнэлтэд дурдсанаар бол, "Австрали улс нь чөлөөт худалдааны дор өнөөгийн хүн амынхаа амьжиргааг илүү өндөр түвшинд хүргэж хөгжүүлэх боломжтой байх байсан гэдэг үзэл бодлын маргааныг одоогоор байгаа баримт нотолгоонууд нь баталж чадахгүй байна" гэсэн байдаг. Цааш нь үргэлжлээд, "яг ижил хүн ам нь яг ижил дундаж орлоготой байх нөхцөлийг хамгаалалтгүйгээр олж авч чадахгүй байх байсан" гэсэн байдаг. Бригдэний тайланг боловсруулсан зохиогчдын хувьд, хамгаалалт хийх нь үндэсний нийт орлогыг нэмэгдүүлэх болно гэж үзээгүй учраас, энэ тайлан нь чөлөөт худалдааны мэтгэлцээнийг дордуулаагүй болно.</p>
95	Australia and the third world	<p>Австрали улс ба гуравдагч ертөнц. Хайрисийн тайланг (Harries Report) үзнэ үү.</p>
96	Autarky	<p>Автократ дээд эрх мэдлийг хязгаарлалтгүйгээр захирагч/ ганцаар захирах ёс. Үйлдвэрлэлийн хувьд улс өөрөө өөрийгөө хангадаг байхыг эрэлхийлсэн, эдийн засаг улс төрийн итгэл үнэмшил. Цэвэр ганцаар захирах ёс гэдэг онолын хувьд боловсруулсан сэтгэлгээ бөгөөд орчин үеийн ертөнцөд ийм нөхцөлд хүрэх боломжгүй. Үүнийг туршиж үзсэн Албани зэрэг улсад, амьжиргааны хэм хэмжээнд ихээхэн зардалтайгаар хийж үзэж байсан. Хойд Солонгос улсад, автократын дүр эсгэсэн бодлого нь зөвхөн нөхөрсөг улс орнуудын ихээхэн хэмжээний тусламж дэмжлэг, сүүлийн үед бусад улс орнуудаас үзүүлэх болсон хүмүүнлэгийн тусламжийн ачаар ч хэрэгжих боломжтой байдаг. Өөрөө өөртөө найдах, өөрөө өөрийгөө хангадаг байх, техно-үндсэрхэг үзэлд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар, хэдий зардал өндөртэй байсан ч гэсэн эх орондоо өөрсдийн хэрэгцээ шаардлагуудынхаа багцыг үйлдвэрлэхийг оролдож байгаа улс орнууд одоо мөн энэ нэр томьёог чөлөөтэй хэрэглэж байна.</p>
97	Automatic import licensing	<p>Шууд олгох импортын тусгай зөвшөөрөл (Импортын шууд лиценз). Импортод шууд лиценз хэрэглэх. Импортын лиценз олгох (import licensing) гэдгийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
98	Automatic termination	Автоматаар дуусгавар болгох. Жаргаж байгаа буюу хуучирч буй хууль зүйн заалтыг (sunset clause) үзнэ үү.
99	Autonomous liberalisation	<p>Автономит, бие даасан либералчлал. Бусад орнуудын хүсэлтгүйгээр, улс орнууд ихэнх тохиолдолд өөрсдийн тарифаа буулгаж, эсхүл зах зээлд нь нэвтрэхэд тавьсан хориг саадуудаа ихэнх тохиолдолд бууруулдаг. Тэд голдуу ингэж хийдэг учир нь өөрсдийн эдийн засагт орж ирэх урсгалын өгөөжийг төсөөлөн харсан байдаг. Олон талт худалдааны хэлэлцээнүүдийн хүрээнд, өөрсдийн бие даан үйлдсэн либералчлалынхаа төлөө итгэл шаардах боломжтой байж болох цар хүрээ нь заримдаа асуудал болж хувирдаг.</p> <p>Хэрэв тийм бол, заримдаа нарийн төвөгтэй томьёоллуудыг ашиглан уг итгэлийг бусдаас төлөх яг тодорхой төлбөрт зориулан ашигладаг. Ийм арга замаар хэлэлцээний итгэлийг ашиглах логик нь тийм ч тодорхой бус байдаг, учир нь худалдааг бие даан либералчилсан үйлдлээс хамгийн их үр ашиг хүртэж буй улс нь, энэ үйлдлийг анхнаас нь үйлдсэн улс байдаг.</p>
100	Auto pact	Автомашинны гэрээ. Канад болон АНУ-ын автомашинны бүтээгдэхүүнүүдийн хэлэлцээрийг (Automotive Products Agreement) үзнэ үү.
101	Average tariff	<p>Дундаж тариф. Улс орнуудын эдийн засгийн салбаруудын гаалийн тарифын хамгаалалтын түвшинг харьцуулан харахад ашигладаг. Энгийн дундаж тариф, жигнэсэн дундаж тарифыг тооцох шаардлагатай байдаг. Импортын хэмжээнээс үл хамааран тарифын хувийн нийлбэрийг барааны нэр төрлийн тоонд хувааж энгийн дундаж тарифыг гаргана, харин жигнэсэн дундаж тарифыг барааны тоо хэмжээ болон үнийн дүнгээс нь тооцдог.</p> <p>Мөрдөж буй тарифын хувь хэмжээ (applied tariff rates), үүрэг хүлээсэн тариф (bindings), Оргил тариф (peak tariffs), жигнэсэн дундаж тарифыг (trade-weighted average tariff) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
102	Backdoor protectionism	<p>Арын хаалганы протекционизм. Энэ нь импортын урсгалд нөлөөлөхийн тулд бүтээгдэхүүнд үндэслэлгүй стандартууд, эсхүл хэт хатуу хорио цээр тавих зэрэг арга хэмжээнүүдийг ашигладаг. Тийм шаардлагуудыг олон нийтийнхээ ашиг сонирхлыг хамгаалах, зарим тохиолдолд өөрсдөө ч гайхширалд хүрдэг хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор ногдуулдаг.</p> <p>Протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онол (protectionism), Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ (sanitary and phytosanitary measures), Худалдаан дах техникийн саад тотгорыг (technical barriers to trade) үзнэ үү.</p>
103	Backloading	<p>Ачааллыг [хэлэлцээрийн сүүлийн үе шатанд] хойшлуулах. Либералчлах үүрэг амлалтууд нь аажмаар үе шаттайгаар нэвтрүүлэхээр тохиролцсон цаг хугацаанд ямарваа үүрэг болгосон зүйлийг хамгийн сүүлийн мөчид унагахгүй байхаар худалдааны хэлэлцээнүүдийн нөхцөлийг бүрдүүлж ажиллах арга туршлага. ДХБ-ын сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийн дагуу зарим өндөр хөгжсөн улс орнуудын зүгээс авсан үүрэг амлалтын хувьд энэ нь үнэн. Түүнийг мөн хэлэлцээр болон тохиролцсон зохицуулалтын дор, заавал биелүүлэх худалдааны либералчлалыг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч болохуйц хамгийн сүүлийн мөч хүртэл хойшлуулахтай холбон авч үзэж болно. Ачааллыг [хэлэлцээрийн эхний үе шатанд] урагшлуулах (frontloading) гэдгийг үзнэ үү.</p>
104	Balance of advantages	<p>Давуу талуудын тэнцвэр. Олон талт худалдааны хэлэлцээнүүдэд заримдаа ашигладаг нэгэн зарчим бөгөөд энэ нь, худалдааны хэлэлцээнүүдийн хүрээнд харилцан буулт хийж, буулт, хөнгөлөлт (concessions) үзүүлсний улмаас үүсэх давуу талуудыг оролцогч талуудын дунд өргөн хүрээнд тэнцвэржүүлэх ёстой гэж үздэг. Уг тэнцвэрт байдлыг гол төлөв, хүсэлт гаргах ба санал болгох арга техникийг ашиглах замаар олж авдаг. Энэ зарчим нь эдийн засгийн онол дээр суурилдаггүй ба тэнцвэрт байдал оршин тогтнож байгаа, эсхүл байхгүй байгаа талаарх зарим гайхалтай үндэслэлүүдийг санал болгосон байдаг байна. Энэ зарчмын туйлын үндэс бол худалдааг либералчилна гэдэг нь либералчилж буй тухайн улсад зардал дагуулдаг гэсэн ташаа таамаглал.</p>
105	Balance of concessions	<p>Буулт, хөнгөлөлтүүдийн (concessions) тэнцвэр. Харилцан буулт хийж, тодорхой хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр концесс/ зөвшөөрөл олгохдоо тэнцвэртэй байх зарчим. ДХБ-ын гишүүд хэлэлцээнүүд хийж байх явцдаа болон юу хайж байгаад юу олж авав гэдгийнхээ харьцангуй үнэ цэнийг дүгнэж цэгнэхдээ гаргадаг шүүмж/үнэлгээ. Тэд гол төлөв, хоёр талууд тэнцүү нөхцөлийг хүртэж байхаар шийдэхийг хичээдэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
106	Balance of payments	<p>Төлбөрийн тэнцэл (BOP). Тухайн улсын нийт худалдаа, эдийн засгийн бусад гүйлгээнүүд, санхүүгийн урсгал зэргийг хамруулсан статистикийн нэгдсэн дүгнэлт. Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл (урсгал дансны гүйлгээнүүд), хөрөнгийн урсгал (хөрөнгийн дансны гүйлгээнүүд), болон олон улсын гүйлгээнүүдийг бүртгэхэд бэрхшээлтэй байвал тэгшитгэх, тэнцвэржүүлэлтийн зүйл зэргээс төлбөрийн тэнцэл бүрддэг. Төлбөрийн тэнцлийн урсгал данс болон хөрөнгийн дансны бүрэлдэхүүн хэсгүүд тус бүр нь нэг бол илүүдэлтэй, эсхүл алдагдалтай байж болох боловч, Төлбөрийн тэнцэл нь өөрөө заавал тэнцэтгэсэн тэнцэл байх ёстой. Урсгал тэнцэл буюу урсгал данс нь Төлбөрийн тэнцлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тодорхой цаг хугацаанд харьяалагдах бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний худалдаа мөн орлого ба шаардлагагүй гүйлгээнүүдийг (жишээлбэл, гадаадын буцалтгүй тусламжийн төлбөрүүд, ажилчдын мөнгөн шилжүүлгүүд гэх мэт) гаргаж харуулдаг. Хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалтууд болон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгөтэй холбоотой олон улсын хэлэлцээрүүдийн улмаас үүссэн валютын орж ирж буй болон гарч буй урсгалыг бүртгэн тэмдэглэдэг.</p>
107	Balance-of-payments consultations	<p>Төлбөрийн тэнцэлтэй холбогдсон арга хэмжээний талаарх зөвлөгөөн (Уругвай). ТХЕХ-ийн 12-р Зүйлтэй уялдуулан төлбөрийн тэнцлийн хязгаарлалтууд ногдуулсан ДХБ-ийн гишүүн улс орнууд, тэдний төлбөрийн тэнцэлд тулгарч буй бэрхшээлүүдийн мөн чанар, тэдний авч хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийн хувилбар, мөн тэдний зүгээс бусад гишүүн улс орнуудад ногдуулсан импортын хязгаарлалтуудын нөлөөг үнэлж дүгнэхэд чиглэсэн байнгын тогтмол зөвлөлдөөн зохион байгуулах хэрэгтэй байдаг. Эдгээрийг бүрэн хэмжээний зөвлөлдөөн гэдэг бөгөөд тийм арга хэмжээ авч буй орнуудад нарийвчилсан тайлан гаргаж байх үүрэг хариуцлагыг зааж өгдөг. Эдгээр зөвлөлдөөнийг харилцан тохиролцсон журмын дагуу зохион байгуулахдаа, Олон улсын валютын санг хамруулан оролцуулдаг. Зарим тохиолдолд хөгжиж буй улс орнууд мөн, 18-р Зүйлийн В хэсгийн (XVIII:В - Эдийн засгийн хөгжилд үзүүлэх засгийн газрын тусламж дэмжлэг) дагуу арга хэмжээ авах сонголт нь байдаг. Энэхүү Зүйлийн дагуу зөвлөлдөөн зохион байгуулах нь тийм төвөгтэй биш бөгөөд шаардагдах баримт бичгүүд нь харин ч ярвигтай биш байдаг. Эдгээрийг хялбаршуулсан зөвлөлдөөн гэдэг. ДХБ-ын аль ч гишүүн ийм зөвлөлдөөнд оролцож болно.</p>
108	Balance of trade	<p>Худалдааны тэнцэл. Орчин үеийн тогтсон хэрэглээнд үүнийг эдийн засаг дах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт болон импортын хоорондын тэнцэл гэж үздэг. Гэвч засгийн газруудын арилжаа худалдааны сонирхлынх нь гүнд шингэсэн байдаг, тохиолдлын оролдлогоор эсвэл хараахан томьёолж мэдэгдээгүй урт хугацааны зорилгынхоо хүрээнд, импортын үнийн дүн нь экспортын үнийн дүнгээс нь давахгүй байх нөхцөлийг хангаж ажиллах явдал байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Гол төлөв санаа зовоодог асуудал бол үйлчилгээний худалдаанаас хамаагүй илүү их хэмжээтэй бараа бүтээгдэхүүний худалдаа байх явдал. Худалдаагаа тэнцвэржүүлэхийн тулд импортын хязгаарлалтууд хэрэглэсэн улс орнуудын хувьд, тэд зөвхөн худалдааныхаа нийт хэмжээг бууруулж, тэгснээрээ нийгмийн хангамжийг бууруулж байж л голдуу амжилт олсон байдаг. Тухайн улс нь экспортоосоо илүү их хэмжээний импорт хийж байгаа эсэх нь, түүний эдийн засгийн хөгжлийн түвшин болон түүний эдийн засгийн бүтэц тогтолцоо зэргийг хамарсан олон хүчин зүйлээс хамаардаг. Бараа бүтээгдэхүүний тэнцвэртэй худалдаа гэдэг нь өөрөө амжилттай эдийн засгийн бодлогын үзүүлэлт биш. Эдийн засгийн дүн шинжилгээний түүх хэмээх бүтээлдээ Шумпетерийн (Schumpeter) тэмдэглэснээр бол, "тааламжгүй" тэнцэл гэдэг нь баялаг нэмэгдэж буй шинж тэмдэг байж магадгүй ч, мөн энэ нь ядуурлын үйл явц ч байж болно; 'тааламжтай' гэдэг нь хөгжил цэцэглэлт болон ажил эрхлэлтийн утгыг илэрхийлж байж болох боловч, мөн үүний яг урвуулсан хувилбар байж болно."</p> <p>Гуйлгачин хөршийн бодлогууд (beggar-thy-neighbour policies), Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism), худалдааны алдагдал (trade deficit) болон худалдааны илүүдлийг (trade surplus) үзнэ үү.</p>
109	Bangkok Agreement	<p>Бангкокийн хэлэлцээр. НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын (UN-ESCAP) Хөгжиж буй улс орнуудын худалдааны хэлэлцээний Анхны хэлэлцээр. Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын хөгжиж буй улс орнуудын дунд харилцан ашигтай худалдааны арга хэмжээг хэрэгжүүлэх замаар, худалдааг өргөжүүлэхэд чиглэгдсэн. Үүнийг 1975 оны 7 сарын 31-нд үзэглэсэн. Гишүүн улс орнуудад Бангладеш, Энэтхэг, Лаос, Бүгд Найрамдах Солонгос улс, Шри Ланка зэрэг орнууд багтдаг. Одоо Ази Номхон Далайн худалдаан хэлэлцээр нэртэй болсон.</p>
110	Bargaining tariff	<p>Хэлцэл хийх, тохиролцооны тариф. АНУ-ын 1934 оны Харилцан хоёр талын тэгш худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийг баталсны дараа бусад улс орнуудын тарифыг тохиролцон буулгахад энэ тарифыг ашиглаж болох болсноос хойш, ердийн/ орчин үеийн нийтлэг хэлээр ярихад тохируулсан нэршил. Тухайн үед хүчин төгөлдөр байсан тарифыг Смүүт-Хаулей (Smoot-Hawley) тариф гэдэг байсан бөгөөд конгрессын батлах нэмэлт өөрчлөлт оруулахаас бусад бүх тохиолдолд өөрчлөх боломжгүй байв. Хуучирсан тарифыг авч үлдэхдээ бусад улсын зүгээс яг адилхан хэмжээгээр тарифаа бууруулахад ашиглаж болох магадлалтай гэсэн итгэлтэйгээр ажилладаг арга туршлагын талаар илүү нийтлэг ашиглах болсон нэр томьёо.</p> <p>Автономит, бие даасан тариф (autonomous tariff), уламжлалт тогтсон тариф (conventional tariff), олон шатлалтай тариф (multi-column tariff), нэг шатлалтай тариф (single-column tariff) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
111	Barter trade	<p>Бартерын худалдаа буюу барааг бараагаар солих худалдаа. Яг адилхан үнийн дүнтэй байхаар тооцоолсон бодит бараа бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээг харилцан солилцох үйл явц. Гэрээний талууд тус бүрийн оруулсан хувь нэмрийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор гуравдагч орны валютаар илэрхийлэн үнэлж болно, гэвч бартерын худалдааны үндсэн гол шинж чанар бол мөнгөн шилжүүлэг байдаггүй.</p> <p>Нөхөн төлөх худалдаа (compensation trade), Угтвар худалдаа (countertrade) үзнэ үү.</p>
112	Basel Convention	<p>Базелийн конвенц. Аюултай хог хаягдлыг хил дамнуулан шилжүүлэх хөдөлгөөн ба тэдгээрийг хаях устгах хяналтын тухай Базелийн конвенц. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн (UNEP) ивээл дор 1989 оны 3 сарын 22-нд баталсан бөгөөд 1992 оны 5 сарын 5-нд хүчин төгөлдөр болсон. Аюултай хог хаягдлыг олон улсад дамжуулан шилжүүлэх хөдөлгөөнийг бууруулах, хянах, эдгээр хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй замаар хаях нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Эдгээрийн худалдаатай холбогдолтой хоёр зүйл заалтад зааснаар бол, (а) гэрээний талууд аюултай хог хаягдлын импортыг хориглох эрхтэй, ба (б) гэрээний гишүүн бус улс орнуудаас аюултай хог хаягдлыг импортлох болон тэдэн рүү экспортлохгүй байж болно. 1995 оны 9-р сард уг Конвенцэд элссэн орнууд өндөр хөгжсөн орнуудаас хөгжиж буй орнууд руу дахин боловсруулах зориулалтаар аюултай хог хаягдлыг шилжүүлэх явдлыг хориглох асуудлыг нэмэлт өөрчлөлтөөр оруулахаар шийдвэрлэсэн байна. Гэвч зарим өндөр хөгжсөн орнууд тус оны дараа, уг Конвенц нь өндөр хөгжсөн болон хөгжиж буй улс орнуудын хооронд байгаль орчинд ээлтэй худалдаа эрхлэх боломжийг үргэлжлүүлэн олгосоор байх болно гэж итгэдэг. Худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment) үзнэ үү.</p>
113	Base period	<p>Суурь хугацаа. Бүхий л тарифын буулт болон үүрэг амлалтуудын суурь хугацааг тохирч байхаар Уругвайн үе шатны хөдөө аж ахуйн хэлэлцээрийн үеэр зөвшилцсөн байна. Зах зээлд нэвтрэх асуудал болон дотоодын дэмжлэгийн талаарх үүрэг амлалтуудын хувьд суурь хугацааг 1986-88 он гэж авсан байна. Экспортын татаасны тухай үүрэг амлалтуудын хувьд энэ хугацааг 1986-90 он гэж авчээ.</p> <p>Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийг (Agreement on Agriculture) үзнэ үү.</p>
114	Base rate	<p>Суурь хувь хэмжээ. Тарифын хэлэлцээнүүдийн үед ирээдүйд хийгдэх тарифын бууруулалтад зориулж эхлэх цэгийг нь тогтоох буюу тарифын түвшнийг тайлбарлахад энэхүү нэр томьёог хэрэглэдэг. Тарифын түвшин гэдэг нь тодорхой огноонд хүчин төгөлдөр байх түвшин. Улс орнууд тарифыг бууруулах хэлцэл хийхдээ ДХБ-ын өмнө үүрэг хүлээсэн тариф (bound tariff), эсхүл одоо мөрдөж буй (applied tariff) буюу хил дээр ногдуулсан тарифын хувь хэмжээг суурь болгож хэрэглэх үү гэдэг дээр зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй болдог.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тухайлбал, МУ- Япон улсын хооронд байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт тарифын суурь хувь хэмжээг тухайн үед мөрдөж байсан хувь хэмжээгээр авсан.
115	Basic Instruments and Selected Documents	Үндсэн эрх зүйн актууд болон сонгосон баримт бичгүүд (Үндсэн эх сурвалж болон сонгосон баримт бичиг (ТХЕХ-ийн хэвлэсэн) -Уругвай)). ТХЕХ-ийн Үндсэн эрх зүйн актууд болон сонгосон баримт бичгүүдийг (GATT Basic Instruments and Selected Documents) үзнэ үү.
116	Basic telecommunication services	Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээ. Үүнд дуут утсан харилцаа, телекс, факс, тоон мэдээ өгөгдөл дамжуулалт зэрэг багтана. Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээний тухай хэлэлцээр (Agreement on Basic Telecommunications Services), Үндсэн цахилгаан холбооны бүлэг (Group on Basic Telecommunications), Олон улсын цахилгаан холбооны байгууллага (International Telecommunication Union), Үндсэн цахилгаан харилцаа холбоо болон нэмүү өртөг шингэсэн цахилгаан харилцаа холбооны үйлчилгээний талаарх Хэлэлцээний бүлэг (Negotiating Group on Basic Telecommunications and value-added telecommunications services) зэргийг үзнэ үү.
117	Basket tariff quota	Тоо хэмжээний хязгаарлалттай тариф бүхий барааны сагс. Олон улсад өөр хоорондоо холбоотой өргөн хүрээнд худалдаалагддаг бүтээгдэхүүнүүдийг хамруулж тоо хэмжээний хязгаарлалттай тариф тогтоох хувилбар. Хэрэв Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн (Harmonised Commodity Description and Coding System - HS) дагуу дөрвөн оронтой тооны (зүйлийн) түвшинд тоон хязгаарлалттай тариф хэрэглэж байгаа бол, эмзэг бүтээгдэхүүнүүдийн хувьд энэхүү дөрвөн оронго зургаа (мөрийн) болон түүнээс дээш орны (үндэсний) түвшинд задаргаа хийх замаар энэ төрлийн (сагс дах) бүтээгдэхүүнд нэмэлт хамгаалалт олгох боломж байдаг.
118	Baumgartner proposals	Баумгартнерын санал. 1961 онд тухайн үеийн Францын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан сайд, М Баумгартнерийн зүгээс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дэлхийн худалдааг зохицуулахад зориулж ТХЕХ-ийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн багц санал. Уг саналын гол мөн чанар нь үйлдвэрлэсэн илүүдэл бүтээгдэхүүнээ АНУ-ын Энхийн төлөөх хүнсний хөтөлбөрийг хавсаргасан Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын загварыг олон улсын зах зээлд үргэлжлүүлэн сунгах санал байлаа. Энэхүү төлөвлөгөөний өртөг зардал нь импортлогч улс орнуудад тулгарах байлаа. Үнэлгээ тогтоох механизмын гол бүрэлдэхүүн хэсэг нь “энгийн үнэ” байсан бөгөөд энэ нь нээлттэй зах зээлд тухайн үед байсан үнийн түвшингээс хамаагүй дээгүүр тогтоож болохоор байсан байна. Хөдөө аж ахуй ба ТХЕХ (GATT) ба (PL 480) гэснийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
119	Beggar-thy-neighbour policies	<p>Гуйлгачин хөршийн бодлогууд. Дотоодын эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, жишээлбэл, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг зорилготойгоор авч хэрэгжүүлсэн экспортын татааснууд, импортын тоо хэмжээний хязгаарлалт, тариф гэх мэт худалдаа, эсхүл эдийн засгийн арга хэмжээнүүд нь бусад улс орнуудад зардал болдог. Ийм бодлого хэрэгжүүлсний улмаас, хариуд нь бусад улс орнууд мөн ижил арга хэмжээ авахад хүргэж болох юм. Гуйлгачин хөршийн бодлогууд нь 1930-аад оны Их хямралыг улам гүнзгийрүүлж, хугацааг нь уртасгахад гол хүчин зүйл болж байсан гэж үздэг.</p> <p>Худалдааны тэнцэл (balance of trade), Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Барааны худалдааны Меркантилизмын онол (mercantilism), Смүүт-Хаулей тарифыг (Smoot-Hawley tariff) үзнэ үү.</p>
120	Behaviour	<p>Ажиллах горим (зан төлөв). Монополын эсрэг хууль, өрсөлдөөний тухай хуулиудыг удирдан хэрэгжүүлэхэд хэрэглэдэг нэр томьёо. Энэ нь удирдан зохион байгуулах гэсэнтэй үндсэндээ нэг утга агуулгатай бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд харьяалагдаж болох, компани аж ахуйн нэгжүүдийн үйлдлүүдийг тайлбарладаг.</p>
121	Behind-the-border issues	<p>Хилийн гадна болдог асуудлууд. Үндсэндээ дотоодын эдийн засагт чиглүүлэн засгийн газруудын соёрхон баталсан бодлого, арга хэмжээнүүд боловч, эдгээр нь худалдааны бодлогод нөлөөлөл үзүүлж байдаг. Үүнд дотоодын татааснууд, өрсөлдөөний бодлого, стандарт хэм хэмжээнүүд, хөдөлмөрийн нөхцөлүүд гэх мэт олон зүйлийг хамарсан байдаг.</p> <p>Хил дээрх саад тотгоруудыг (at-the- border barriers) үзнэ үү.</p>
122	Beirut Agreement	<p>Бейрутын хэлэлцээр. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын шинж чанар бүхий Дуу, дүрс бичлэгийн материалуудыг олон улсын эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжих хэлэлцээр. Үүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын (UNESCO) ивээл дор 1948 онд баталсан. Уг хэлэлцээрт зааснаар талууд үүгээр тодорхойлсон материалуудад импортын татвар ногдуулахгүй, эсхүл импортод нь тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй.</p>
123	Benefit	<p>[Татаасны] үр ашиг. ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу тухайн татаас үнэхээр байсан эсэхийг тогтооход шаардлагатай шалгуур хэмжүүр. Уг хэлэлцээрт татаас гэж авч үзэхүйц, засгийн газрын зүгээс үзүүлсэн зургаан төрлийн арга хэмжээнүүдийг тайлбарласан байдаг. Хэрэв үүгээр дамжуулан үр ашиг хүртсэн байвал, уг арга хэмжээг татаас гэж үзэх болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
124	Benefits of trade	Худалдааны үр ашиг. Өөр өөр үнийн тогтолцоотой хоёр улс Автарк (autarky) бодлогыг баримталж ажиллахын оронд, өөр хоорондоо худалдаа наймаа хийвэл эдийн засгийн илүү их өгөөж хүртэнэ гэж баталдаг. Харьцангуй давуу талын онол нь мөн олон улсын худалдаанд тодорхой бараа үйлдвэрлэхэд нарийн мэргэшсэнээр үр ашиг хүртэнэ гэж үздэг. Худалдаа нь үйлдвэрлэлийн зориулалттай бараа бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, түүхий эд материалын хүртээмжийг буй болгодог. Энэ нь шинэ техник, үзэл санаа, ур чадваруудыг худалдаа арилжаа болон хамтын ажиллагаагаар түгээн дамжуулснаар, технологи дамжуулахад хүргэдэг байна. Компани, аж ахуйн нэгжүүд нь өөрсдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн байдлаар, тухайн улсад үйлдвэрлэл эрхлэхийг эрэлхийлэхийн сацуу, худалдаа нь капитал/хөрөнгө шилжүүлэхийг хөхиүлэн дэмждэг. Худалдаа нь мөн монополчлолын бодлогын эсрэг болон өрсөлдөөний орчинг буй болгодог гэх мэт нэмэлт үр ашиг авчирдаг ч байнга таньж чаддаггүй байна.
125	Benelux	Бенелукс. Бенелукс хэмээх гаалийн холбоо нь 1948 онд Бельги, Голланд, Люксембург улсуудын хооронд байгуулагдсан. Эдгээр гурван улсын эдийн засгийн холбоонд нэгдэх төлөвлөгөөнүүдийг, 1958 оны 1-р сарын 1-нд тэдний үүсгэн байгуулалцсан Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгт гишүүнчлэлтэй болсноор орлох болсон байдаг.
126	Benign mercantilism	Зөөлөн/нөхөрсөг байдлаар Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол. Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) үзнэ үү.
127	Berne Convention	Бернийн конвенц. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц нь утга зохиол, урлагийн бүтээл зохиогчдын эрхийг хамгаалдаг. Үүнийг 1886 онд байгуулсан бөгөөд 1971 оноос хойш хэд хэдэн удаа өөрчлөгдсөн. Хамгийн сүүлд хянан засварласан хувилбаруудын үндсэн зорилго нь бүх гишүүн улс орнуудад жигд хамгаалалттай болгоход уг конвенцыг чиглүүлэх явдал байлаа. Үүнийг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) удирдаж байдаг. Бернийн конвенцын 1971 оны нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбар нь Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрт ашиглагдах стандартуудын нэг. Оюуны өмчийг (intellectual property) үзнэ үү.
128	Bicycle theory	Унадаг дугуйн онол. Хэрэв олон талт худалдааны систем нь либерал хэвээр үлдье гэж байвал, либералчлалын дараалсан хэлэлцээний үе шатууд болон хэлэлцээрүүдээр дамжуулан, урагш ахих ёстой гэсэн санал, мэдэгдэл. Хэрэв либералчлах хөдөлгөөнүүдийн хооронд урт завсарлагууд байгаад байвал хамгаалалтын (протекционист) үзэл бодлыг зөвшөөрч, улмаар уг үйл ажиллагаанууд нь нийтлэг болж ирвэл уг систем нь яг дугуй шиг өнхрөн унах болно. Протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онолыг (protectionism) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
129	Bilateral air services agreements	<p>Агаарын тээврийн үйлчилгээний хоёр талын хэлэлцээр. Чикагогийн Конвенцын 6-р Зүйлийн дагуу, засгийн газрууд хоорондоо агаарын тээврийн хэлэлцээрийг байгуулдаг. Тэд заримдаа, агаарын тээвэрлэгчдийн нэрс, хуваарьт нислэгүүдийн тоо, нөгөө улс нь өөрийн орон луугаа илгээж болох зорчигчдын тооны дээд хэмжээ гэх мэт олон асуудлуудыг маш нарийн тодорхойлон гаргадаг.</p> <p>Тэд мөн ашиглагдаж болох нисэх онгоцны буудлуудын жагсаалтыг гаргадаг байна. Агаарын орон зайн эрх чөлөө болон нээлттэй агаарын орон зайг (freedoms of the air and open skies) үзнэ үү.</p>
130	Bilateral investment treaties	<p>Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрүүд (BITs). Энэ нэрийг, нэн ялангуяа АНУ өөрийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, хамгаалах хэлэлцээрүүддээ зориулж өгсөн нэршил. АНУ-ын загвар болсон уг хэлэлцээрт, үндэсний нэн тааламжтай нөхцөл болон үндэсний нөхцөлийн аль тохиромжтойг нь хэрэглэхтэй холбоотой эрх үүргүүд; ерөнхийдөө шударга, эрх тэгш харилцаа; хөрөнгө оруулалт оруулж, боловсруулан хөгжүүлж, удирдаж, зөвлөх мөн аль улсын иргэний харьяалалтайгаас үл хамааран, менежерийн өндөр албан тушаалын боловсон хүчинд оролцох шугамаар гэрээний нөгөө тал болох улсын нутаг дэвсгэрт нэвтрэх эрхийг гадаадын хуулийн этгээдэд олгох; гүйцэтгэлийн шаардлагуудыг ногдуулахгүй байх үүрэг хүлээх; нэхэмжлэл гаргах, эрхээ хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг бий болгох; эрх зүйн зохицуулалтын ил тод байдал; өмч хөрөнгийг албадан хураах тохиолдолд баримтлах журам зарчмууд; хөрөнгийн санг шилжүүлэх эрх чөлөө зэрэг асуудлыг агуулж байдаг.</p>
131	Bilateral restraint agreement	<p>Хоёр талын хязгаарлалтын тохиролцоо. Сайн дурын хязгаарлалтын тохиролцоог (voluntary restraint arrangement) үзнэ үү.</p>
132	Bilateral trade agreement	<p>Хоёр талт худалдааны хэлэлцээр. Хоёр улсын хоорондын худалдааг удирдан явуулах нөхцөлүүдийг зааж өгсөн, хоёр улсын хооронд хийгдсэн хэлэлцээр. Хэрэв хоёр тал ДХБ-ын гишүүн бөгөөд үл ялгаварлах нөхцөл, зах зээлд нэвтрэх боломж, бусад үр ашгийг хүртэж байдаг бол, хоёр талт хэлэлцээр байгуулах гол нэмэлт шалтгаан нь магадгүй хоёр талын худалдааг хөхиүлэн дэмжих хөтөлбөр ба худалдааг дэмжих арга хэмжээнүүд байж болох юм. Хэрэв нэг тал нь ДХБ-ын гишүүн биш бол, уг хэлэлцээр нь гол төлөв үндэсний нэн тааламжтай нөхцөл болон үндэсний нөхцөл, оюуны өмчийн эрхийг хамгаалах, зөвлөлдөөн, маргаан шийдвэрлэлт, мөн худалдааны жигд урсгал болон маргааныг түргэн шийдвэрлэх нөхцөлийг хангахад шаардлагатай бусад зарчмууд болон механизмуудыг олгох болно. Худалдааны хоёр талт хэлэлцээрүүд нь гол төлөв Худалдааны хамтарсан хороо эсвэл Холимог хороо гэх мэт сайд нарын түвшинд эсвэл ахлах албан тушаалтнуудын түвшинд, худалдааны хөгжлийн үйл явцыг үе үе хянан дүгнэх нөхцөлийг агуулсан байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
133	Binding commitments	<p>Үүрэг болгосон, заавал биелүүлэх үүрэг амлалтууд (уялдсан үүрэг амлалтууд - Уругвай). Энэ нь үйлчилгээний салбарын хүрээнд зах зээлд нэвтрэх нөхцөлүүдэд, тус улсын зүгээс ДХБ-д өргөн барьсан үйлчилгээний салбарт заавал биелүүлэх үүрэг амлалтуудын жагсаалтад нь зааснаас илүү их хязгаарлалт, хориг тавихгүй гэж хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага. Заавал биелүүлэх үүрэг амлалтуудыг ДХБ-ын дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх бөгөөд зөвхөн нөлөөлөлд нь өртсөн худалдааны түнш орнуудтайгаа хэлэлцээ хийх замаар л уг амлалтуудыг зөрчиж болно. Заавал биелүүлэх үүрэг амлалтаа зөрчиж буй улсын хувьд, бусад худалдааны түнш улсууддаа үйлчилгээний өөр салбаруудад үүрэг амлалт авах хэлбэрээр, нөхөн төлбөр олгохоо санал болгож болно.</p>
134	Binding	<p>Үүрэг болгосон, заавал биелүүлэх. Тодорхой бүтээгдэхүүнүүд дээр ногдуулах тарифын хувь хэмжээг ТХЕХ-ийн хэлэлцээнүүдийн үеэр тохиролцож, гишүүн улсын тарифын буултын жагсаалттай уялдуулсан тарифын хувь хэмжээний түвшингээс илүү дээш нэмэгдүүлэхгүй гэж хуулиар хүлээсэн үүрэг амлалт. Тарифын үүрэг амлалтыг ДХБ-аар дамжуулан хэрэгжүүлдэг. Тэдний зорилго нь тарифын дээд хязгаарыг тогтоох замаар худалдаа арилжааны илүү тодорхой байдлыг буй болгох явдал бөгөөд нөлөөлөлд нь өртсөн худалдааны түнш орнууддаа нөхөн төлбөр олгох санал тавилгүйгээр үүнийг зөрчиж болохгүй. Эдгээр тарифын дээд хязгаар бүхий хувь хэмжээнүүд нь үргэлж хил дээр ногдуулсан гаалийн тарифын хувьд хэмжээнүүдээс өндөр байдаг.</p>
135	Biochemical prospecting	<p>Биохимийн хайгуул, судалгааны ажил. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Худалдаа Хөгжлийн Бага Хурал Био-худалдаа санаачилгыг (UNCTAD BIOTRADE initiative) үзнэ үү.</p>
136	Blair House Accord	<p>Блэйрийн Танхимын гэрээ хэлцээ. Уругвайн үе шатны хөдөө аж ахуйн талаарх яриа хэлэлцээний үр дүн бүхий баримт бичгийн төсөл дээр гурван өөрчлөлт оруулахаар АНУ болон Европын хамтын нийгэмлэг хоёр 1992 оны 11 сарын 20-нд хэлэлцээрт хүрч чадсан. Эхлээд улсаас татаас олгосон экспортын тоо хэмжээг хасахдаа 24%-аас 21% хүртэл бууруулах болно. Хоёрдугаарт, засгийн газраас үйлдвэрлэгч нарт шууд төлж дотоодод үзүүлсэн зарим татаасыг, [татаасыг] бууруулах үүрэг амлалтаас хасах болно. Гуравдугаарт, бууруулж буй татаастай холбоотой гомдол нэхэмжлэлийн эсрэг дархлааг олгож байсан Энхийн тохиролцооны нэмэлт зүйлийг сунгасан байна. Яриа хэлэлцээний үе шатны төгсгөлийн дараа, эдгээр өөрчлөлтүүд нь хөдөө аж ахуйн салбарын худалдааг засаглах зарчим болж хэвээр үлдсэн боловч, үүнийг хэрэгжүүлэхэд илүү уян хатан хандах боломжийг тэд оролцогч талуудад олгожээ. Блэйрийн Танхимын гэрээ хэлцээ нь олон талт яриа хэлэлцээг дахин эхлүүлэх боломжийг олгосон боловч, энэ нь хоёр талуудын хооронд зах зээлд нэвтрэх тал дээр суурь ялгаатай асуудлууд байсныг шийдэж чадаагүй байсан нь тодорхой болмогц,</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>энэхүү гэрээ хэлцээг анх тааламжтай хүлээж авч байсан байдал нь замхран алга болов. Уг гэрээ хэлцээг 1993 оны 12 сард шинэчлэн найруулсан бөгөөд энэ нь Уругвайн үе шатны хөдөө аж ахуйн яриа хэлэлцээний үр дүн гарахад замд нь тээг болоод байсан сүүлчийн саад бэрхшээлийг арилгасан байдаг.</p> <p>Хөдөө аж ахуйн хэлэлцээр (Agreement on Agriculture), Хөдөө аж ахуй ба ТХЕХ (agriculture and the GATT), Хөдөө аж ахуйн салбарын зах зээлд нэвтрэх (market access for agriculture) зэргийг үзнэ үү.</p>
137	Block exemptions	<p>Хэсэгчилсэн чөлөөлөлт. Энэхүү нэр томьёог, Европын хамтын нийгэмлэг өөрийн худалдааны хөнгөлөлтийн нөхцөл бүхий зохицуулалтуудын зүйл заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхээс зарим эмзэг салбаруудыг хасах арга туршлагыг тайлбарлахад ашигладаг. Үүнд ихэнх тохиолдолд, хөдөө аж ахуйн болон сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүнүүдийг хасаж таардаг. Холбогдох хууль тогтоомжуудаас тодорхой салбарууд эсвэл арга туршлагыг хасахын тулд өрсөлдөөний бодлогыг удирдан явуулахад уг хэсэгчилсэн чөлөөлөлтийг ашиглаж болох юм.</p> <p>[ЕХ-нд] Нэгдэх тухай гэрээнүүд (Association Agreements) болон Европын хэлэлцээрийг (Europe Agreements) үзнэ үү.</p>
138	Blocking statutes	<p>Хориглолт тогтоосон эрх зүйн акт. Бусад улс орнууд өөрийн нутаг дэвсгэрээс гадна монополын эсрэг хуулийг/дангаар ноёрхлын эсрэг практикийг хэрэглэх оролдлогын эсрэг тэмцэхэд чиглэсэн үндэсний хууль тогтоомжийг хэлнэ. Тийм хууль тогтоомж гэдэг нь ерөнхийдөө, гадаад улсын зүгээс эхлүүлсэн монополын эсрэг мөрдөн шалгалтууд явуулахад хамтран ажиллах тал дээр тухайн холбогдох улсын харьяат иргэдийг оролцуулахыг хориглодог. Дотоодын хуульд эс захирагдсан, нутаг дэвсгэрийн гадна (extraterritoriality) гэдгийг үзнэ үү.</p>
139	Blue box	<p>Хөх ангилалд хамаарах татаас (хөх хайрцаг). Уругвайн үе шатны хэлэлцээрт ашигладаг энэ нэр томьёо нь хөдөө аж ахуйн нэгэн төрлийн татаасыг хэлдэг байна. Хөх хайрцагт үйлдвэрлэлийг хязгаарлах хөтөлбөрүүдийн дагуу үйлдвэрлэгчдэд шууд олгож байгаа төлбөрүүдийг хамруулдаг (хэрэв га талбай болон малын тоо толгойд тулгуурласан төлбөртэй холбогдсон бол). Эдгээр нь ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн дагуу бууруулах үүрэг амлалтад хамаарахгүй. АНУ-ын фермерүүдийн дутагдлыг нөхөх төлбөрүүд болон Европын хамтын нийгэмлэгийн зүгээс Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын дор олгодог нөхөн төлбөрүүд зэрэг нь энэхүү ангилалд ордог. Ногоон ангилалд хамаарах татаасыг (green box) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
140	Bogor Declaration	<p>Богорын тунхаглал. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) удирдагчид Индонези улсын Богор хотод 1994 оны 11 сарын 15-нд энэхүү тунхаглалыг гаргасан бөгөөд тэд АПЕК-ийн гишүүдийн дунд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг хамруулсан чөлөөт худалдааг буй болгохоор тохиролцсон байна. Өндөр хөгжсөн улсуудын гишүүд 2010 онд энэ зорилтдоо хүрэх бол, хөгжиж буй улсууд 2020 онд хүрнэ. Удирдагчид, дэлхийн чөлөөт худалдааг хөгжүүлэх хүчин чармайлтыг доройтуулах дотогшоо чиглэсэн [эдийн засгийн] талбарыг буй болгохыг хүчтэй эсэргүүцэж байгаагаа цохон тэмдэглэсэн байна. Удирдагчид мөн ДХБ/ТХЕХ-ийн зүйл заалтуудтай нийцүүлэн, АПЕК-ийн худалдаа ба хөрөнгө оруулалтын либералчлалаас мөн үр ашиг хүртэх нөхцөлийг хангахын тулд, АПЕК-ийн гишүүн бус хөгжиж буй улс орнуудтай хийх худалдаандаа онцгой анхаарал хандуулах болно гэсэн байна. АПЕК (АРЕС) болон нээлттэй бүсчлэлийн онолыг (open regionalism) үзнэ үү.</p>
141	Boomerang effect	<p>Бумеранг үр нөлөө буюу өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр буудаг үр нөлөө. Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлогууд нь эргээд өөрт нь эсрэг үр дүн өгөх магадлалтай. Худалдааны бодлого нь ерөнхийдөө шүүн таслах эрх мэдэл хэрэгждэг өөр нутаг дэвсгэрийн экспортлогчид болон тэдний бүтээгдэхүүнүүдийг авч үзэхдээ, дотоодын үйлдвэрлэгчид болон тэдний бүтээгдэхүүнүүдэд нь олгодог нөхцөлтэй ижил тэгш байдлаар хандсанаар, өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр буудаг бумеранг үр нөлөөнөөс зайлсхийхийг хичээдэг. Үнэндээ бумеранг үр нөлөө нь үндэсний нөхцөлтэй хамааралгүй хууль тогтоомжуудын дор бий болох илүү магадлалтай байдаг. Гуйлгачин хөршийн бодлогыг (beggar-thy-neighbour policies) үзнэ үү.</p>
142	Bootlegging	<p>Дуу, дүрс бичлэгийг шаглах. Хожим телевизороор эсвэл бусад арилжааны ашиг олох зорилгоор концертын тоглолтыг хууль бусаар бичлэг хийж авах. Тийм бичлэгүүд гол төлөв хямдхан бөгөөд чанар нь муу байж болно. Мөн зохиогчийн эрх (copyright), оюуны өмч (intellectual property), зохиогчийн эрхийг зөрчих, хууль бусаар ашиглахыг (piracy) үзнэ үү.</p>
143	Border measures	<p>Хилийн арга хэмжээ. Мөн тарифын болон тарифын бус арга хэмжээнүүдийг үзнэ үү.</p>
144	Border tax adjustments	<p>Хилийн татварын зохицуулалт. Хэрэв дотоодын хэрэглээнд зориулагдсан байсан тухайн нэг зүйл нь экспортлогдож байгаа бол, тухайн зүйлд ногдуулсан татварыг буцаан олгох, нэмэлт олгох, шууд бус татвар ногдуулах (жишээ нь, гэнэтийн ашгийн татвар) эсвэл тухайн зүйлтэй холбоотой үүссэн татваруудыг хураахгүй байх зэрэг зохицуулалтууд. Иймэрхүү зохицуулалтуудыг заримдаа гаалийн татварын буцаан олголт эсвэл чөлөөлөлт гэж нэрлэдэг. Зохицуулалтуудыг хийхдээ мөн, ижил төстэй дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг шууд бус татваруудтай (жишээ нь, борлуулалтын татвар) ижил хувь хэмжээгээр, импортлогдсон [ижил] зүйлд татвар ногдуулах хэлбэртэй ч байж болно. Ийм зохицуулалтууд нь ТХЕХ-ийн дагуу авч үзвэл хууль бус биш. Мөн экспортын урамшууллыг (export incentives) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
145	Border trade	Хилийн худалдаа. Мөн хилийн худалдаа, арилжааг (frontier traffic) үзнэ үү.
146	Bound tariff rates	<p>Үүрэг хүлээсэн тарифын хувь хэмжээ. Аливаа улс ДХБ-д элсэхдээ гаалийн тарифын дээд хувь хэмжээг тохиролцож, түүнээс нэмэгдүүлэхгүй байхаар үүрэг хүлээдэг. Гаалийн тарифын дээд хязгаарыг тогтоосон л бол, нөлөөнд нь өртсөн талд нөхөн олговор олголгүйгээр уг тарифыг өөрчилж болохгүй.</p> <p>Үүрэг хүлээсэн тариф (bindings) үзнэ үү.</p>
147	Bounty	<p>Засгийн газрын урамшуулал буюу татаас. Дотоодын үйлдвэрлэгчдэд тодорхой зорилгоор олгох боломжтой улсын татаас. Үүний зорилго нь аж үйлдвэрлэлийн барааны дотоодын үнэ болон импортоор орж ирсэн үнэ хоёрын хоорондын зөрүүг тэгшитгэх (жишээ нь, усан хөлөг онгоцны үйлдвэрлэл гэх мэт), эсвэл үйлдвэрлэлийн үйл явцад тусгай заасан орцыг (жишээ нь, хөдөө аж ахуйн салбарт зориулсан суперфосфатыг) ашиглахад чиглэгдсэн байж болно. Үйл ажиллагааны энэ чиглэлийг батлах гэж байгаа бол олонх нь тарифаас илүүтэй, аж үйлдвэрийн салбараа дэмжиж, хамгаалах арга хэрэгсэл байдлаар уг татаасыг хэрэглэхийг илүүд үздэг. Үүний учир нь, төлсөн төлбөр болон улмаар бусад аж үйлдвэрлэлийн салбарууд болон хэрэглэгчдэд үүсэж буй зардал нь маш илэрхий болдог. Тэгэхээр төсвийн дарамтууд нь энэ татааснуудыг хяналтад байлгадаг байх магадлалтай. Өөр нэг тайлбараар бол, энэ татаасыг илүү сайн нарийвчлалтайгаар онилж, татварын ерөнхий системээр дамжуулан татвар ногдуулахаас бусад хэлбэрээр энэ татаас нь аж үйлдвэрлэлийн бусад салбаруудын үйлдвэрлэлийн орцод ногдуулсан татвар болчихгүй байж болно гэж үздэг. Мөн хамгаалалт (protection) болон татаасыг (subsidies) үзнэ үү.</p>
148	Boycott	<p>Хориг арга хэмжээ. Тухайн нэг улс эсвэл аж ахуйн нэгжид ханган нийлүүлэлт хийхээс татгалзах, түүнээс импортлох эсвэл тэднээс худалдан авах, эсвэл өөр ямар нэгэн хэлбэрээр түүнтэй харьцахаас татгалзах явдал. Энэ нь зарим тохиолдолд өрсөлдөөний арга туршлага эсвэл бизнесийг хязгаарласан арга туршлагыг буй болгодог байж болох юм.</p>
149	Bracketed language	<p>Хашилтад хийсэн найруулга. Тухайн найруулга нь маргаантай байснаас болж эсвэл хэлэлцээний баримт бичгийн текстийн өөр нэгэн хэсэгт нь хэлэлцээрт хүрч чадахаас хамаарч үүнийг батлах боломжтой зэрэг нөхцөл байдлаас шалтгаалаад, хэлэлцээний баримт бичгийн текстийн нэг хэсгийг нь хашилтад хийдэг.</p>
150	Brandt Report	<p>Брендт тайлан. 1980 онд Олон улсын хөгжлийн асуудлуудын талаарх Бие даасан комиссын зүгээс Умард-Өмнөд: Тэсэж үлдэх хөтөлбөр гэсэн гарчгийн дор хэвлүүлсэн тайлан. Энэхүү комисс нь 1977 онд ХБНГУ-ын Канцлер асан Ноён Вилли Брандтын удирдлагын дор байгуулагдсан байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Уг тайланд гүн боловсруулах үйл явц, бараа бүтээгдэхүүний зар сурталчилгаа болон борлуулалт, түгээлт, нөхөн олговрын санхүүжилтийн зохицуулалт, бараа бүтээгдэхүүний олон улсын хэлэлцээрүүдийг эцэслэх зэрэг асуудлуудад хөгжиж буй улс орнууд илүү их оролцох болно гэдгийг харсан байна. Энэхүү тайлангаар дамжуулан мөн, аж үйлдвэржсэн орнууд протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулсан хамгаалалтаа буцааж татах, эерэг тохируулалт бүхий хөтөлбөрүүд (бүтцийн өөрчлөлтүүд), Хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) дүрэм журмыг хялбаршуулах, шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэхийн тулд шударга хөдөлмөрийн стандартууд, худалдааны либералчлалыг хөхиүлэн дэмжихийг сурталчлан таниулсан байдаг. Тайланг чанартай боловсруулсан байдал, цаг үеэ олсон байдал, уг хорооны бүтэц тогтолцоо зэрэг нь уг тайлангийн дэвшүүлсэн санаа нь өргөн олныг хамарч, олон нийтийн дунд хэлэлцүүлэг болж өрнөсөн байна. Уг тайланд санал болгосон үйл ажиллагааны саналууд нь тухайн үедээ зохион байгуулагдаж байсан бүх чухал хурал семинаруудын хөтөлбөрт тусгалаа олсон байсан боловч, тэдний өмнө тулгарч байсан бэрхшээлүүд нь амжилттай шийдлийг замхруулсан. 1983 онд Брендт хороо нь эхний тайланд нь дэвшүүлсэн асуудлуудыг шийдэх тал дээр хангалтгүй хариу үзүүлж байна гэж үзсэн тул, Нийтлэг хямрал: Умард-Өмнөд: Дэлхийн [эдийн засгийг] сэргээх хамтын ажиллагаа хэмээх тайланг нийтлүүлсэн байна. Комиссыг албан ёсоор 1983 оны 2-р сард татан буулгасан. Мөн Канкуны Дээд түвшний уулзалт (Cancun Summit) болон Умард-Өмнөд яриа хэлэлцээг (North-South dialogue) үзнэ үү.</p>
151	Bretton Woods agreements	<p>Бреттон Вудсийн хэлэлцээр. 1994 онд АНУ-ын Нью Хаймпшир мужийн Бреттон Вудс тосгонд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Валют ба санхүүгийн бага хурал зохион байгуулагдсаны үр дүнд, Дэлхийн банк (Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк - IBRD) болон Олон улсын валютын сангийн (International Monetary Fund - IMF) дүрмийг баталсан байна. Тэрээр мөн тусдаа зохион байгуулсан яриа хэлэлцээний үеэр Олон улсын худалдааны байгууллага (ITO) байгуулахыг санал болгосон байдаг боловч, уг санал нь эцсийн дүндээ арай бага амбиц бүхий ТХЕХ-ийн дүрд хувирсан үр дүн болсон байдаг. Дээрх гурван байгууллагуудыг заримдаа Бреттон Вудсийн институциуд гэж нэрлэх нь бий. Мөн Гаванагийн дүрэм (Havana Charter), ОУСББ (IBRD), ОУВС (IMF), ОУХБ (ITO) зэргийг үзнэ үү.</p>
152	Bribery in international transactions	<p>Олон улсын хэлцлүүд дэх хээл хахууль. Олон улсын бизнесийн хэлцлүүд дэх Гадаадын төрийн албан тушаалтнуудын авлига, хээл хахуультай тэмцэх тухай конвенц (Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions), Хууль бус төлбөрийн тухай олон улсын хэлэлцээрийн төсөл (Draft International Agreement on Illicit Payments) болон худалдаа ба хууль бус төлбөрийг (trade and illicit payments) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
153	Broadband services	Өргөн зурвасын үйлчилгээ. Энэ нь зураг дүрс, видео, дуу, текст болон тоон мэдээ өгөгдлийг тус тусад нь эсвэл нийтэд нь ашигладаг харилцаа холбооны үйлчилгээнүүд. Өргөн зурвас нь ерөнхийдөө өндөр хурдтайгаар мэдээллийг дамжуулж харилцан холбох чадавхтай байдаг утгыг илэрхийлж байдаг. Мөн Дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүдийг (audiovisual services) үзнэ үү.
154	Broader competition policy	Өрсөлдөөний илүү өргөн хүрээний бодлого. Мөн өрсөлдөөний бодлого (competition policy) болон өрсөлдөөний өргөн уужим бодлогыг (wider competition policy) үзнэ үү.
155	Brussels Declaration	Брюсселийн тунхаглал. 2001 оны 5 сарын 14-20-нд Брюссельд зохион байгуулагдсан НҮБ-ын Нэн-буурай хөгжилтэй орнуудын тухай Гуравдугаар бага хурлын үр дүнд гарсан мэдэгдэл. Үүнд олон асуудлуудыг хөндсөний дотор, гишүүд ДХБ-ын Дохагийн үе шатны Сайд нарын бага хурлыг ашиглан "худалдааны хөгжлийн хэмжигдэхүүнд ахиц дэвшил гаргах болно" хэмээн тохиролцсон байна. Үүнд, нэн буурай хөгжилтэй улсууд өндөр хөгжилтэй улсууд руу ямар нэгэн татваргүй болон тоо хэмжээний хязгаарлалтгүй (квотгүй) нэвтрүүлэх зорилгод чиглэж ажиллах замаар, нэн буурай хөгжилтэй улсуудад (LDCs) зориулан зах зээлд хөнгөлөлттэй нэвтрэх боломжийг нь сайжруулах нэгэн зорилго байв. Уг бага хурлаар нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан үйл ажиллагааг баталсан байна. Мөн зэвсгээс бусад бүх зүйлийг (everything but arms) үзнэ үү.
156	Brussels Definition of Value	Үнэ цэний тухай Брюсселийн тодорхойлолт (BDV). Брюссельд байрладаг одоо Дэлхийн гаалийн байгууллага, харин тухайн үеийн Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн ивээл дор, төлбөл зохих гаалийн татваруудыг үнэлж тооцоолох зорилгоор бараа бүтээгдэхүүнийг хил дээр үнэлж, үнэ цэнийг нь тогтоох стандарт хэм хэмжээ. Импорт үүсэж байгаа цаг хугацаа, орон зайд, импортолж буй улсын нээлттэй зах зээлд бараа бүтээгдэхүүний борлуулалтын үнийг зааж өгдөг. Тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь, үнийн утгын нэрлэсэн стандарттай харилцан уялдаж байгаа эсэх тал дээр шийдвэр гаргахад зориулж, энэ нь хэд хэдэн зүйлийг авч үзсэн болно. Үнэ цэний тухай Брюсселийн тодорхойлолтыг одоо ДХБ-ын 1994 оны ТХЕХ-ийн [гаалийн үнэлгээний] 7-р Зүйлийг (Article VII) хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт зааж өгсөн аргачлалууд орлож байна. Мөн гаалийн үнэлгээг (customs valuation) үзнэ үү.
157	Brussels Tariff Nomenclature	Брюсселийн тарифын жагсаалт. Энэ нь үндэсний тарифыг бүтэцжүүлэх зорилгоор гаргасан бүтээгдэхүүний ангилал. Брюссельд байрладаг одоо Дэлхийн гаалийн байгууллага, харин тухайн үеийн Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл үүнийг боловсруулсан байдаг. Энэ нэр томьёоны жагсаалтыг 1988 оны 1 сарын 1-нээс эхлэн Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем орлох болсон (Harmonised Commodity Description and Coding System).

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
158	Budapest Treaty on the International Recognition of the Deposit of Microorganisms for the Purposes of Patent Procedure	<p>Патент олгох зорилгоор микро организмуудыг хадгалах олон улсад хүлээн зөвшөөрөх тухай Будапештийн гэрээ. Уг гэрээг 1977 оны 4-р сарын 28-нд эцэслэн гаргасан. Зохион бүтээлд нь микро организмыг (бичил биетэн) агуулсан эсвэл олон нийтэд хүртээмжтэй микро организмыг ашигласан өргөдөл гаргагчид зориулж патент олгох журмыг хялбарчлах зорилготой. Олон өсөн нэмэгдэж буй улс орнуудад патент олгох журам нь тухайн зохион бүтээлийн талаар нь зөвхөн бичгээр тайлбар бөглөж өгөхийг шаардахаас гадна, тусгай төрөлжсөн байгууллагад уг микро организмын дээжийг хадгалсан нөөцлөл байхыг шаарддаг болсон байна. Ийм ажиллагааг хэд хэдэн улс орнуудад дахин давтан хийх шаардлагатай тохиолдолд нэлээд нарийн төвөгтэй бөгөөд зардал өндөртэй байдаг. Энэхүү гэрээний талууд ямар нэгэн олон улсын [микро организмын] хадгаламжийн эрх бүхий байгууллагад, уг байгууллага нь хаана байрлаж байгаагаас үл хамааран, үүнд нэг л хадгаламжтай байх нь хангалттай гэж тохиролцсон байна.</p>
159	Buffer stocks	<p>Нөөц түүхий эд бүтээгдэхүүн. Түүхий эдийн үнэд нөлөөлж, тогтворжуулах зорилгоор, олон улсын түүхий эд, материалын зарим хэлэлцээрүүдийн дагуу байгуулагдсан механизм. Үнэ нь тодорхойлсон байсан үнийн бүлгээс даваад нэмэгдсэн тохиолдолд нөөц түүхий эд, материалыг борлуулдаг ба харин үнэ нь үнийн бүлгээс доош буухад уг бараа бүтээгдэхүүнийг нөөцлөн цуглуулж эхэлдэг тул зах зээлийн өнөөгийн ханшийн тусгал болж байдаг. Үнийн хэлбэлзлүүд нь богино хугацаатай үед, мөн өндөрт хүрсэн үнэ нь буурч байсан үнийг боломжийн хугацаанд нөхөн тэнцэтгэж байсан бол, нөөц бараа үүргээ гүйцэтгэж чадаж байна гэсэн үг. Хэлэлцээрт хамруулсан үнийн хамрах хүрээг гол төлөв тогтолцоонд оруулсан байдаг учраас, үнэ хамгийн доод бүлэг түвшинд хүрвэл нөөц түүхий эд, материалын менежер худалдан авалтууд хийх ёстой ба уг үйлдэл нь тийнхүү худалдан авах хөрөнгө үлдсэн гэж үзсэнийг харуулдаг. Дараа нь менежерийн худалдан авалт хийх магадлалтай үнийн бүлгийг ажиглаж байгаад, арилжааны төлөв байдал, боломжтой нөөц хөрөнгө, одоогоор байгаа нөөц барааны хэмжээ зэрэг дээр тулгуурлаад тухайн шийдвэрийг гаргадаг. Үнийн түвшин илүү өндөр байх үед менежер зарж магадгүй бөгөөд уг шийдвэр нь мөн л олон хүрээнд авч үзэх асуудлуудаас хамаарах болно. Түүхий эд, материалын үнийн дүн, гэрээнд тусгагдсан хамгийн өндөр үнийн бүлэгт орж ирсэн л бол, тэднийг түүхий эд, материал байна гэж үзээд менежер нь зарах ёстой. Нөөц түүхий эд, материал нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг. Түүхий эдийн хамгийн дээд хэмжээ болон үүнийг санхүүжүүлэх арга зэрэг нь гол төлөв маргаантай байдаг. Ийм механизмыг эсэргүүцэгч нар, нийт зах зээлийн хэмжээтэй харьцуулахад, хүчтэй санхүүгийн тогтмол эх үүсвэртэй томоохон хэмжээний түүхий эд, материалын үйл ажиллагаа нь, жижиг нэгнүүдийг бодвол зах зээлийн хэлбэлзэлтэй хамаагүй илүү амархан зохицож ажиллах боломжтой байдаг гэж үздэг. Мөн ийм үйл ажиллагаа явуулахад маш их өртөг зардалтай байх болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Гэвч, уг үйл ажиллагааны цар хүрээ нь [зах зээлийн үнийн] тохиргоонуудыг илүү хялбар болгож байгаа эсэх нь бүрэн тодорхой биш байна. Практик амьдрал дээр нөөц түүхий эд, материалын зохицуулалтын амжилт нь түр зуурын шинжтэй байдаг, учир нь ихэвчлэн тэд зах зээлийн урт хугацааны хөдөлгөөнүүдтэй зохицож ажиллахад хангалттай хэмжээнд уян хатан байж чаддаггүй. Хэрэг дээрээ тэд, бүтцийн өөрчлөлтийн тохиргоонуудтай харшилж, үймүүлж байж болох юм. Урт хугацаанд үнэ доогуур байгаа үед, үйлдвэрлэгчид тухайн цаг үед үйлдвэрлэлээ хязгаарлахыг нь дэмжихгүй бол, үүний улмаас тодорхой асуудлууд үүсдэг. Үргэлжлүүлэн худалдаж авсаар байх үүрэг хариуцлага нь магадгүй, нөөц түүхий эд, материалыг бизнесээс нь гаргаж болох юм. Нөөц түүхий эд, материалыг худалдаж авах болон зарах үйлдлийг өдөөж байдаг үнийн бүлгүүдийн зөрүү нь хэрэв хэт их өргөн хүрээтэй байвал, зах зээлд хөндлөнгөөс нөлөөлөх арга хэрэгсэл болгож байгаа уг түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрийн үр нөлөө нь маш их багасах юм. Нөөц түүхий эд, материалын зорилгынх нь хүрээнд хэрэгжсэн бүхэл бүтэн түүний түүхэн тэмдэглэлийг нь харвал үргэлж урам хугалсан төрхтэй байж ирсэн байдаг. Олон улсын валютын сан (IMF) гишүүдийн оруулсан шимтгэлийн санхүүжилтийг олон улсын батлагдсан Нөөц түүхий эд, материалд зориулахыг дэмжих үүднээс Нөөц түүхий эд, материалыг санхүүжүүлэх зээлийн хэрэгслийг байгуулж ажилласан боловч, үүнийг 1984 оноос хойш ашиглаагүй байна. Мөн түүхий эд, материалын бодлого (commodity policy), Түүхий эд, материалын нийтийн/хамтын сан (Common Fund for Commodities) болон Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөрийг (Integrated Programme for Commodities) үзнэ үү.</p>
160	Building-block approach	<p>Бүтцийн элементийн арга барил. Чөлөөт худалдааны талбарт дүн шинжилгээ хийхэд ашиглагддаг нэр томьёо. Эхлээд эдгээр нь бүрэлдэхүүн хэсэг байж болох ч, эцсийн дүндээ чөлөөт худалдааны хэлэлцээрийг бүрдүүлж өгч байдаг. Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа гэх мэт зарим хялбархан элемент бүрэлдэхүүн хэсгүүдийг эхлээд итгэлцэл бэхжүүлэх арга хэмжээ байдлаар барьж авч шийдсэн байж болно. Эдийн засгийн илүү хэцүү нөхцөлүүд нь хожим нь гарч ирэх болно. Хоёрдугаарт, зарим хүмүүс чөлөөт худалдааны талбарууд нь олон талт худалдааны системийн бүтцийн элемент буюу барилгын блок гэж хардаг. Байнга өсөн томорч байгаа [эдийн засгийн] талбаруудын хооронд буй худалдааны хориг саадуудыг буулгахад чиглүүлж, эдгээр бие даасан талбаруудыг эцэст нь нийлүүлж болно. Одоогийн байдлаар энэ талаарх баримт нотолгоо нь тодорхой үр дүнд хүрээгүй байна. Мөн эргэлзээтэй элементүүдийг (stumbling blocks) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
161	Built-in Agenda	Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөр (BIA). Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр хэлэлцсэн эрх зүйн актад агуулагдсан нөхцөлүүдийн улмаас үүссэн, ДХБ-ын өргөн хүрээний үйл ажиллагааны хөтөлбөр. Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөрийн зарим хэсэгт Уругвайн үе шатны хэлэлцээрийн үеэр [зөвшилцөлд хүрэх] боломжгүй байсан бодит баримтыг тусгасан байдаг. Эдгээр тохиолдлуудад, Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөр нь шинэ хэлэлцээнүүд эхлүүлэх эрх мэдэлтэй, эрх үүрэгтэй байдаг. 2000 онд эхэлсэн хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын өнөөгийн яриа хэлэлцээнүүдэд зориулсан эрх үүргийг, Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөр өөртөө агуулж байдаг. Тэгэхээр Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөр бол өмнөх үе шатны хэлэлцээнүүдийн шинж чанар болж байсан, хийгдэхээр үлдсэн ажил үйлсээс ялгаатай.
162	Burden-sharing	Ачаалал хуваалцах. Худалдааны шинэ арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг, түүний нөлөөнд өртөж буй орнуудын бүлэг аль болох хамгийн өргөн хүрээнд хуваалцах ёстой гэсэн санал. Худалдааны либералчлалыг зардал гэж эндүү ташаа хардаг зарим нэг нь энэ нэр томьёог ашигладаг. Ачаалал хуваалцана гэдэг нь бусдаас бараг адил тэнцүү түвшний үйлдлийг шаарддаг харилцан адил байх гэдэгтэй ижил утга биш юм, гэвч уг утгатай нь ойрхон дөхсөн зарим тохиолдлууд бол байсан. Мөн давуу талын тэнцвэрийг (balance of advantages) үзнэ үү.
163	Butter mountain	Цэцгийн тосон уул. Уг нэрийг Европын хамтын нийгэмлэгийн Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын улмаас үүссэн сүү сүүн бүтээгдэхүүний илүүдэлд зориулж, ярианы нийтлэг маягт оруулан өгсөн байна.
164	Buy American Act	Америкийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах тухай хууль. Энэ хуулийг АНУ 1993 онд баталснаараа, (а) зөвхөн АНУ-д үйлдвэрлэгдсэн болон аж үйлдвэрлэлийн процессоор ороогүй зүйлс, бараа материал болон ханган нийлүүлэлтийг олон нийтийн хэрэглээнд зориулан худалдан авах, (б) улсын шинж чанартай барилга байгууламжийг барих тохиолдолд болон олон нийтийн үйл ажиллагаанд зөвхөн АНУ-д үйлдвэрлэсэн зүйлс, бараа материал, ханган нийлүүлэлтийг барилгын явцын бүхий л үе шатанд ашиглах нөхцөлийг хангах явдал байв. Уг хууль нь АНУ-ын нутаг дэвсгэрээс гадна ашиглагдаж байгаа бараа бүтээгдэхүүнүүд ба Панамын сувгийн бүсэд ашиглахад зориулан худалдаж авсан эсвэл дотоодод үйлдвэрлэгдээгүй бүтээгдэхүүнүүдэд хамаарахгүй. Үүнд, хэрэв Америкийн материалуудыг ашиглавал олон нийтийн ашиг сонирхлын үүднээс өөр эрэлт хэрэгцээ ба их эсвэл үнийн хувьд үндэслэл муутай байх зэрэг нөхцөлийг хамруулсан, бусад хэд хэдэн онцгой тохиолдлууд байдаг. Америкийн олон мужууд өөрсдийн гэсэн Америкийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах тухай хуультай байдаг. Мөн дотоодын/орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах бодлогыг (buy-local policies) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
165	Buy-local policies	<p>Дотоодын/орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах бодлого. Энэ бол зарим улсуудад засгийн газрын худалдан авалтын журмын дагуу, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоодын худалдан авалтад давуу тал олгох нэг арга. Ийм бодлого нь гол төлөв, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд илүү таатай нөхцөл үзүүлсэн тарифын хөнгөлөлтийн зөрүүгээр илэрхийлэгддэг боловч заримдаа хэрэв бусад бүх зүйлс эн тэнцүү байвал, тэдгээр нь дотоодын худалдан авалт хийх шийдвэрт хязгаарлагдаж болно. Тухайн үедээ орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах тухай бодлогыг дотоодын аж үйлдвэрийн салбарын хөгжлийг хөхиүлэн дэмжихэд ашиглаж байлаа. Засгийн газрын худалдан авалтаас өөр бусад талбарт хэрэглэж байгаа ижил төстэй бодлого нь, үндэсний нөхцөлийн үүрэг амлалттай зөрчилдөх болно.</p>
166	Byrd Amendment	<p>Бердийн нэмэлт өөрчлөлт. Демпинг болон татаасны хохирлыг нөхөн төлөх тухай хуулийг АНУ-ын Конгресс 2000 оны 10 сард баталсан байна. Хөдөө аж ахуйд зориулсан төсвийн зарцуулалтын хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал болгосон Сенатор Роберт Бердийн (D-VW) нэрээр нэрлэжээ. Уг хууль нь демпингийн эсрэг үүсгэсэн хэрэг болон татаасны хохирлыг саармагжуулах, импортод татвар ногдуулсан зэрэг хэргүүдээс орж ирсэн орлогыг, уг хэргүүдийг анх эхлүүлсэн АНУ-ын компаниудад төлөх нөхцөлийг хангахыг эрэлхийлдэг. Ийм төлбөрүүдийг хүлээн авсан компани, аж ахуйн нэгжүүд үүнийгээ үйлдвэрээ шинэчлэн сайжруулах болон тэтгэврийн зардлууддаа зориулан ашиглаж болно.</p>

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
167	Cabotage	<p>Каботаж буюу Дотоодын далайн боомтууд болон нисэх онгоцны буудлуудын хооронд далайн тээврийн болон агаарын тээврийн үйлчилгээ эрхлэх эрх. Ихэнх улс орнуудад, дотоодын [хуулийн этгээдийн] эзэмшилтэй, дотоодод бүртгэлтэй далайн усан онгоц эсвэл нисэх онгоцнуудад ийм үйлчилгээ үзүүлэх эрхийг хадгалж үлдээсэн байдаг. Тэдний экипажийн гишүүдийг дотоодын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлүүдийн дагуу ажилд авсан байх ёстой байдаг. АНУ-д каботаж үйлчилгээ үзүүлж байгаа далайн усан онгоцыг дотоодын усан онгоцны үйлдвэрүүдэд барьж угсарсан байх ёстой байдаг. Мөн Агаарын орон зайн эрх чөлөө болон Жонсын тухай хуулийг (freedoms of the air and Jones Act) үзнэ үү.</p>
168	Cairns Group	<p>Кэрнс Групп. Аргентин, Австрали, Боливи, Бразил, Канад, Чили, Колумби, Коста Рика, Гватемала, Индонез, Малайз, Парагвай, Филиппин, Шинэ Зеланд, Өмнөд Африк, Тайланд, Уругвай зэрэг орнуудаас бүрдсэн хөдөө аж ахуйн шударга худалдааны бүлэг. Үүнийг 1986 онд Австралийн Кэрнсд зохион байгуулагдсан Сайд нарын бага хурлын үеэр, хожим Уругвайн үе шатны хэлэлцээ болж өргөжсөн байдаг, хөдөө аж ахуйг хамруулах асуудлыг хөхиүлэн дэмжихийн төлөө байгуулсан байдаг. Мөн Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээ (Agreement on Agriculture), хөдөө аж ахуй (agriculture), ТХЕХ-ийг (GATT) үзнэ үү.</p>
169	Calvo doctrine	<p>Калво номлол, онол. Уг номлол нь Латин Америкийн хууль эрх зүйн тогтолцоонд өргөн дэлгэрсэн байдаг. Үүнд зааснаар бол, гадаадын харьяат иргэн, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчид нь [хөрөнгөө оруулж байршуулсан] уг орнуудын харьяат иргэдэд олгогдсон байдгаас илүү их хэмжээний хамгаалалтыг өөрсдийн засгийн газруудаас нь хүсэх эрх байхгүй. Өөрөөр хэлбэл, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж илүү давуу нөхцөлийг олгох ямар нэгэн санал зөвлөмжийг энэ нь няцаадаг гэсэн үг. Хүчин төгөлдөр байгаа уг номлол нь түүнийг даган мөрдөж байгаа улс орнуудыг, хөрөнгө оруулалтыг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээр байгуулахаас урьдчилан сэргийлдэг ба тийм учраас энэ нь хөрөнгө оруулалтын урсгалуудад шууд нөлөөлөл үзүүлж байдаг байна. Үүнийг анх 1868 онд томьёолон тунхагласан Аргентинийн хуульч, дипломатч Доктор. Карлос Калвогийн нэрээр нэрлэсэн ажээ.</p>
170	Canada-United States Free Trade Agreement	<p>Канад-АНУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээр. Уг хэлэлцээрийг CUSFTA эсвэл CUSTA гэх мэтээр олон янзаар товчилсон байх нь бий. 1988 оны 1 сарын 2-нд гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрт зааснаар, 1998 оны 1 сарын 1-нд хоёр улсын хоорондох бүх тарифуудыг аажмаар халсан байна. Канад улсын зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг нягтлан шалгах босго дүнг 5 сая ам.доллараас 50 сая ам.доллар болгож нэмэгдүүлсэн боловч, хөрөнгө оруулалтад ногдуулах зарим хязгаарлалтуудыг хэвээр үлдээсэн байдаг. Уг гэрээнд үйлчилгээний салбарыг хамруулсан боловч, энэхүү асуудалтай холбогдолтой нөхцөлүүд нь, бараа бүтээгдэхүүнд олгосон нөхцөлүүдтэй харьцуулахад харьцангуй бага либерал байдаг. Энэ хэлэлцээрийн нөхцөлүүдийн ихээхэн хувийг одоо Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр (NAFTA) орлож байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
171	Cancun Summit	Канкуны дээд хэмжээний уулзалт. 1981 онд Мексикийн нэгдсэн улсын Канкун хотод төр засгийн 22 тэргүүнүүдийн уулзалт зохион байгуулагдсан. Үүний зорилго нь Хойд-Өмнөдийн зогсонги байдалд ороод байсан яриа хэлэлцээг дахин эхлүүлэх арга замыг олох явдал байлаа. Энэ нь 1980 онд нийтлэгдсэн Брендтийн анхны тайлангийн үр дүнд бий болсон таатай уур амьсгалд зохион байгуулагдсан байдаг. Уулзалт хэдийгээр илэрхий харилцан санал нэгдсэн үр дүнтэйгээр төгссөн боловч, өөрсдийнх нь мэдэгдэж байсан зорилтдоо хүрч чадаагүй байсан байжээ. Умард-Өмнөд хэмээдэг бусад бүх санаачилгуудтай ижилхэн, аливаа санал болгосон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хамгийн шилдэг аргатай холбоотойгоор, гол гол оролцогчдын өрсөлдөхүйц үзэл санаануудыг даван гарах чадваргүй байв.
172	Caribbean Basin Initiative	Карибын тэнгисийн сав газрын орнуудын санаачилга (CBI). Карибын тэнгисийн сав газрын орнуудын хөгжлийг хөхиүлэн дэмжих, 1983 оны Карибын тэнгисийн сав газрын эдийн засгийг нөхөн сэргээх хуулийн дагуу, 1984 оны 1 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон АНУ-ын 12-жилийн төлөвлөгөө. Үүнийг одоо дахин арван жилээр сунгасан. CBI нь Карибын тэнгисийн сав газраас нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, зарим арьс ширэн бүтээгдэхүүн болон газрын тосны бүтээгдэхүүнээс бусад бүх бүтээгдэхүүнүүдийг тарифгүй нэвтрүүлэх нөхцөлийг сунгасан. Элсэн чихрийн импорт нь квотын системд хамаарах боловч, Карибын тэнгисийн сав газрын элсэн чихэр бол АНУ-руу тарифгүй ордог. Мөн Дэвшлийн төлөөх эвсэл (Alliance for Progress) болон Америкийн санаачилгын төлөөх аж ахуйн нэгжийг (Enterprise for the Americas Initiative) үзнэ үү.
173	Caribbean Common Market	Карибын тэнгисийн орнуудын нэгдсэн зах зээл. Карибын тэнгисийн Чөлөөт худалдааны холбоог (CARIFTA) орлуулж, 1973 онд байгуулсан байдаг. Одоогийн байдлаар энэ нь нэгдсэн гадаад тарифтай гаалийн холбоо байдлаар ажиллаж байна. Үүнийг Антигуа ба Барбуда, Багамын арал, Барбадос, Белиз, Доминика, Гренада, Гайана, Ямайка, Монтсеррат, Санта Кристофер ба Невис, Санта Люсия, Сент Винсент ба Гренадин, Суринам, Тринидад, Тобаго зэрэг орнууд бүрдүүлж байдаг. Британийн Виржиний арлууд ба Турк буюу Лал, Кайкосын арлууд нь гишүүнчлэлтэй байдаг. Гишүүн улс орнууд, агаарын тээврийн үйлчилгээний хувьд дотоодын чөлөөт зах зээлтэй байхаар тохиролцсон байдаг. Үүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Жоржтаун (Georgetown) болон Гайанад (Guyana) байрладаг.
174	Caribbean Community	Карибын тэнгисийн орнуудын хамтын нийгэмлэг (CARICOM). Энэ нь Бахамагаас бусад Карибын тэнгисийн нэгдсэн зах зээлийн бүх гишүүдээс бүрддэг.
175	Caribbean Free Trade Association	Карибын тэнгисийн орнуудын Чөлөөт худалдааны холбоо. Мөн Карибын тэнгисийн орнуудын нэгдсэн зах зээлийг (Caribbean Common Market) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
176	Carousel effect	Морин тойруулга мэт нөлөө. Демпингийн эсрэг эсвэл хамгаалалтын арга хэмжээний нөлөөллүүдээс зайлсхийх зарим оролдлогуудыг тайлбарлахад энэ нэр томьёог ашигладаг. Зарим мэдээллийн эх сурвалжийн мэдээлж байгаагаар бол, тэдгээр үйлдвэрлэгчид болон экспортлогчид хариу арга хэмжээнээс зайлсхийхийн тулд, эдгээр хариу арга хэмжээнд хамаатай бүтээгдэхүүний нүүр царайг тодорхой цаг хугацааны дараа өөрчлөх болно гэдэг.
177	Carousel legislation	Морин тойруулгын хууль тогтоомж. АНУ-ын 2000 оны 5 сарын 18-нд баталсан Худалдаа ба хөгжлийн тухай хуулийн 407-р хэсэгт, АНУ-ын худалдааны түнш орнуудыг, ДХБ-д маргаан шийдвэрлэх асуудлын хүрээнд тэдний эсрэг гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмждэг. Ийм тохиолдлуудад ДХБ-ын дүрэм журам нь буулт, хөнгөлөлтүүд болон бусад үүрэг амлалтуудыг хэрхэн хэрэгжүүлэхийг нарийн тодорхойлсон байдаг ч гэсэн, ийнхүү хэрэгжүүлэхийг түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг. Ийм зорилгоор бүтээгдэхүүнүүдийн жагсаалтыг бэлдэж, боловсруулдаг. АНУ-ын хувьд өөр арга барилтай. Морин тойруулгын хууль тогтоомж нь эхний түдгэлзүүлэлтийг хэрэглэснээс хойш 120 хоногийн дараа, түүнээс хойш 180 хоног бүрд, уг бүтээгдэхүүнүүдийн жагсаалтыг заавал, нэг талын [шийдвэрээр] дахин хянахыг шаарддаг. Худалдааных нь олон түнш орнууд энэ хууль нь маргаан шийдвэрлэх тал дээр ДХБ-ын ойлголтын зорилго, үзэл санаанаас давсан ойлголт байна гэж үздэг.
178	Carry forward	Урьдчилан ашиглах. Дараагийн ирэх жилд оногдсон байсан нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүн болон хувцасны экспортын квотын тодорхой хэсгийг нь тухайн жилд ашиглах. Мөн Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээр (Agreement on Textiles and Clothing) болон уян хатан механизмыг (flexibility mechanism) үзнэ үү.
179	Carryover	Нөхөн ашиглах. Өнгөрсөн жилд ашиглагдаагүй нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүн болон хувцасны экспортын квотыг тухайн жилд ашиглах. Мөн Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээр (Agreement on Textiles and Clothing) болон уян хатан механизмыг (flexibility mechanism) үзнэ үү.
180	Cartagena Agreement	Картагенагийн хэлэлцээр. Андын дэд бүс нутгийн интеграцлалын хэлэлцээр. Мөн Андын хамтын нийгэмлэгийг (Andean Community) үзнэ үү.
181	Cartel	Картель. Холбогдох компани, аж ахуйн нэгжид харилцан ашигтай үр дүнд хүрэхийн тулд хоорондоо албан эсвэл албан бусаар байгуулсан хэлцэл боловч, энэ нь гэрээний бусад талуудад хортой нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, энэ хэлцлийн талуудын хооронд илүү бага өрсөлдөөн байж, үнийн хувьд өрсөлдөхгүй байх тохиролцоо, үйлдвэрлэх нийт гарцад хязгаарлалт тавих, зах зээлийг хуваах зохицуулалт гэх мэт зүйлс байж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Ийм үйл ажиллагаанууд нь ямар цар хүрээнд хууль ёсны байх вэ гэдэг нь тухайн улсын өрсөлдөөний бодлогоос хамаарна. Картелийн зохицуулалтууд нь хэдхэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааг давамгайлж байх үед л хамгийн сайн хэрэгжих хандлагатай байдаг. Уг хэлцлийг өргөн утгаар нь төрийн болон хувийн хэвшлийн гэж ангилдаг. Төрийн картель гэдэг нь засгийн газар илүү өргөн хүрээний бодлогын учир шалтгааны үүднээс дүрэм журмуудыг бүрдүүлж, удирдаж байдаг.</p>
182	Carve-out	<p>Үүнд дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн экспортын картелийг хүлээн зөвшөөрөх асуудал багтаж байж болно. Үүний нэг жишээ бол АНУ-ын Вебб-Померин хууль (Webb-Pomerene Act). Онцгойлон гадаадын зах зээлүүд рүү чиглэсэн цэвэр экспортын картель нь өрсөлдөөний хуулиудыг ашигласнаар, ихээхэн эрх чөлөөг эдэлдэг байна. Экспортын холимог картелиуд нь, дотоодын болон гадаадын зах зээлүүдийн аль алинд нь нөлөөлөл үзүүлдэг. Импортын картель гэж харин маш ховор байдаг бөгөөд олон тохиолдолд үүнийг байгуулж, үйл ажиллагаагаа явуулахыг нь өрсөлдөөнийг зохицуулдаг эрх бүхий байгууллагууд зөвшөөрдөггүй байна. Төрийн картелиудыг магадгүй бүтцийн өөрчлөлтийн зохицуулалтыг хөхиүлэн дэмжих үүднээс мөн зөвшөөрдөг байж болох юм. Олон тохиолдлуудад хувийн хэвшлийн картелиуд эсвэл аж ахуйн нэгжүүдийн хоорондын зохицуулалтууд нь нууцлалын элементүүдийг агуулж байдаг, ялангуяа тэдгээр нь хуулийн эсрэг байвал эсвэл тэдгээр үйл ажиллагааны улмаас эцсийн хэрэглэгчид очих үнэ өсөхөд хүрвэл. Мөн Монополын эсрэг хуулиуд (antitrust laws), учир шалтгааны дүрэм (rule of reason), худалдаа ба өрсөлдөөний бодлогыг (trade and competition policy) үзнэ үү. Хэлэлцээний зарим хэсгийг нь түр орхих шийдвэр. Хэлэлцээнд оролцож байгаа талууд тухайн цаг үедээ багц арга хэмжээнүүдийг эсвэл эдийн засгийн хувьд тодорхойлсон үйл ажиллагаануудыг, худалдааны шинэ эсвэл санал болгож буй дүрэм журмуудаас чөлөөлж хасахаар тохиролцоонд хүрэхийг хэлнэ. Жишээ нь хоёр талт хэлэлцээрийн нисэх хүчний эрхүүдээс болон санхүүгийн үйлчилгээнд хамаарах зохистой зохицуулалтаас Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS-YXEX) дүрэм журмыг хассан байдаг.</p>
183	Cascading tariffs	<p>Дэс дараалсан тохиргоотой тариф. Заримдаа энэхүү нэр томьёог өсөн нэмэгдэх тарифын бүтцийг тайлбарлахын тулд хэрэглэдэг байна. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ордог түүхий эдэд бага тариф тогтоогоод, харин боловсруулалтын түвшин нэмэгдэх тусам ногдуулах тарифын хэмжээг нэмдэг туршлагыг хэлдэг байна. Үүний гол зорилго нь, дотооддоо аль болох их хэмжээний нэмүү өртөг шингээх явдал.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
184	Causality	Шалтгаант холбоо. Дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах аюул бий болсон нь хянан магадалж буй барааны импортын өсөлттэй “шалтгаант холбоо” байгаа гэдгийг баримт, нотолгоонд тулгуурлан тогтоосон нөхцөлд хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх боломжтой болно. Хамгаалалтын арга хэмжээ авч байгаа ДХБ-ын гишүүн улсууд нь ТХЕХ-ийн дагуу авсан либералчлалын үүрэг амлалтын улмаас хэт ихээр нэмэгдсэн импорт нь ноцтой хохирол учруулсан болохыг нотлон харуулах чадавхтай байх ёстой. Үүнтэй адил демпингийн эсрэг арга хэмжээ авч байгаа гишүүн улсууд бусад өөр шалтгаанаас бус зөвхөн демпингийн уршгаар аж үйлдвэрүүд нь хохирол амсаад байна гэдгийг харуулах ёстой байдаг.
185	Ceiling bindings	Үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаар. Ихэнх тохиолдолд бүх тарифын, эсхүл ихэнх тарифын дээд хязгаарыг тохиролцож, энэ түвшингээс дээш нэмэгдүүлэхгүй байхаар ДХБ-ын өмнө үүрэг хүлээж, амлалт авах тухай ойлголт. Тарифын үүрэг, амлалтуудыг гол төлөв яриа хэлэлцээний үр дүн гэж үздэг. Тарифын үүрэг амлалт авч буй улсууд нь эдгээр дээд хязгаарыг нь тогтоосон тарифын түвшингээ нэмэгдүүлэхгүй гэсэн хууль ёсны үүрэг хариуцлага хүлээдэг. Үүрэг хүлээсэн тариф (bindings), оргил тариф (peak tariffs) үзнэ үү.
186	Central African Customs and Economic Union	Төв Африкийн гааль, эдийн засгийн холбоо. Үүнийг ихэнх тохиолдолд UDEAC (Union douaniere et economique de l'Afrique centrale) хэмээн товчилж нэрлэдэг ба нэгдсэн зах зээлд шилжих эцсийн зорилготойгоор 1964 онд байгуулсан. Үүний гишүүн орнууд нь, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах улс, Чад, Конго, Экваторын Гвиней, Габон зэрэг улсууд байдаг. UDEAC-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Төв Африкийн Бүгд Найрмадах Улсын Бангуй хотод байрладаг.
187	Central American Common Market	Төв Америкийн нэгдсэн зах зээл (CACM). Анхны бүс нутгийн хөгжлийн онолын хөнгөлөлттэй худалдааны зохицуулалтуудын нэг. Үүнийг байгуулж байсан Эдийн засгийн интеграцчлалын ерөнхий гэрээ нь 1961 оны 6 сарын 4-нд хүчин төгөлдөр болсон. Түүний гишүүд нь Коста Рика, Сальвадор, Гватемала, Гондурас, Никарагуа зэрэг улсууд байдаг. Төв Америкийн нэгдсэн зах зээлийг хөхиүлэн дэмжих үүргийг, SIECA хэмээх байгууллагыг байгуулах замаар дахин сэргээж байна.
188	Central European Free Trade Agreement	Төв Европын чөлөөт худалдааны хэлэлцээр (CEFTA). Бүгд Найрамдах Чех, Унгар, Польш, Румын, Словак, Словени зэрэг улсуудыг холбосон цогц бүтэц тогтолцоо бүхий хэлэлцээрүүдэд зориулсан, эмхэтгэл нэр томьёо (omnibus). Хэлэлцээрийн анхны талууд (Бүгд Найрамдах Чех, Унгар, Польш, Словак улсууд) 1992 оны 12 сарын 21-нд гарын үсэг зурсан бөгөөд уг Хэлэлцээр 1993 оны 3 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. Үүний дараа бүрэн либералчилсан байх зорилтот огноог доод тал нь хоёр удаа ярьж, хэлэлцэн тохиролцсон байна. Словени улс 1995 оны 1 сарын 1-нд, харин Румын улс 1997 оны 7 сарын 1-нд нэгдсэн байна. Үүнийг анх байгуулагч гишүүн орнуудын дунд аж үйлдвэрлэлийн салбарын ихэнх тарифыг 1997 оны 1 сарын 1-н гэхэд халсан байсан боловч, зарим бараа бүтээгдэхүүнийг хамруулсан хэд хэдэн эмзэг салбаруудын хувьд зорилтот огноо нь 2001 он байлаа.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
189	CEPAL	Латин Америкийн эдийн засгийн хороо (ECLA, Испани товчилсон үг нь CEPAL). Мөн Латин Америк ба Карибын тэнгисийн эдийн засгийн хороог (Economic Commission for Latin America and the Caribbean) үзнэ үү.
190	CEPT (Common Effective Preferential Tariff)	Нийтлэг үр дүнтэй, хөнгөлөлттэй тариф. АСЕАН дотроо хийгдэх тарифын хувь хэмжээг, эхний 15 жилийн дотор (одоо 10 жил болсон) 0-5% байхаар буулгах зорилтыг биелүүлэхийн тулд АСЕАН-ийн Чөлөөт худалдааны хэлэлцээрийн (AFTA) дор энэхүү механизмыг бий байдаг. Бүтээгдэхүүний ангиллаас хамаараад уг тарифын бууруулалтыг шуурхай хэрэгжүүлэх хөтөлбөрийн дор (2000 онд зорилтдоо хүрсэн байх) эсвэл энгийн хурдаар хэрэгжүүлэх хөтөлбөрийн дор (2003 онд зорилтдоо хүрсэн байх) хийх. Мөн эмзэг бүтээгдэхүүний жагсаалт болон түр хугацаанд хасах жагсаалтыг (sensitive list and temporary exclusion list) үзнэ үү.
191	CER ([Australia New Zealand] Closer Economic Relations)	[Австрали болон Шинэ Зеланд улсын хоорондын] Эдийн засгийн илүү ойр дөт харилцаа. Мөн Австрали ба Шинэ Зеландын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээр (ANZCERTA), буюу гол төлөв CER хэмээн нэрлэдэг хэлэлцээрийг үзнэ үү.
192	CER-AFTA	АСЕАН-ий ЧХХ-ийн гишүүд (Бруней, Бирм, Индонез, Лао, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам) болон Эдийн засгийн илүү ойр дөт харилцааны (CER - Австрали, Шинэ Зеланд) хооронд байгуулсан хамтын ажиллагаа ба худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийг үзнэ үү.
193	Certificate of origin	Гарал үүслийн гэрчилгээ. Импортлолсон бүтээгдэхүүний гарал үүслийн орныг баталгаажуулсан бичиг баримт бөгөөд гарал үүслийн шалгуурын нэг. Гарал үүслийн гэрчилгээтэй байх шаардлагыг олон улсын худалдаанд саад тотгор байдлаар ашиглаж бас болдог. 1953 оноос ТХЕХ-ийн гишүүд эдгээр гэрчилгээг зайлшгүй салгаж авч үзэх боломжгүй нөхцөлд л зөвхөн ашиглана гэдэг тал дээр тохиролцсон байдаг.
194	Chaebol enterprises	Чаебаль аж ахуйн нэгж. Энэ бол дайны дараахан үүссэн Өмнөд Солонгосын олон салбарыг хамарсан аж үйлдвэрийн конгломерат. Эдгээр нь нэг гэр бүлийн эзэмшилтэй ба тэдний хяналт нь бүх хоёрдогч болон гуравдагч үеийнх нь эзэмшилд төвлөрч чадсанаараа онцлог шинж чанартай байдаг. Тэд нэн ялангуяа аж үйлдвэрийн болон барилгын салбарт давамгайлж чадсан байдаг. Чаебаль аж ахуйн нэгжийн эдийн засгийн нийт гарц нь 1970-аад оноос хойш буурч байгаа нь харагддаг боловч, тэд эдийн засгийн чухал тоглогч хэвээр байсаар байна.
195	Change in tariff heading	БТКУС-ийн зүйлийн түвшний өөрчлөлт. Энэ нь гарал үүслийн дүрмийн хэрэглээнд ашигладаг зарчим. Б улсаас гарал үүсэлтэй материалаар А улсад бараа үйлдвэрлэснээр БТКУС-ийн зүйлийн (4 орны) түвшинд өөрчлөлт орж, шинэ бүтээгдэхүүн бий болсон байвал үүнийг А улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүн гэж авч үздэг. Үлэмж хэмжээний өөрчлөлт (substantial transformation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
196	Charter for an International Trade Organisation	Олон улсын худалдааны байгууллагын дүрэм. Мөн Гаванагийн дүрмийг (Havana Charter) үзнэ үү.
197	Charter of Economic Rights and Duties of States	<p>Улс орнуудын эдийн засгийн эрх, үүргийн дүрэм. Энэ нь улс орнуудын эдийн засгийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн боловч, үнэндээ олон улсын эдийн засгийн системд хөгжиж буй улс орнуудын эрхэнд нь халдсанаар доогуур статустай болсон гэж үздэг нөхцөл байдалд өөрчлөлт оруулахыг хөхиүлэн дэмжих зорилгоор (1972 онд) НҮБ-ын Худалдаа хөгжлийн III бага хурлын үеэр эхлүүлсэн санаачилга. Үр дүнд нь гарсан дүрмийг анхандаа үзэглэгч орнуудын хувьд хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг болгож, улмаар олон улсын хууль эрх зүйн нэгэн хэсэг болгох зорилготой байсан ба 1974 оны 12 сарын 12-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 3281-р (XXIX) шийдвэр болж батлагдсан байдаг. Уг дүрэм нь 4 бүлэгт ангилагдсан 34 зүйлтэй. 1-р Бүлэг нь улс орнуудын дундах олон улсын эдийн засгийн харилцааны үндсэн суурь зарчмыг засаглах ёстой 15 зарчмуудыг зааж өгсөн байдаг. Гуравдугаар бүлэг дотроо хоёр хэсэгтэй бөгөөд энэ нь улс орнууд бие биетэйгээ гэх мэт олон улсын хамтын нийгэмлэгт хандах улс орнуудын нийтлэг үүрэг хариуцлагуудыг нарийвчлан заасан байдаг. 29-р зүйлд, үндэсний шүүн таслах эрх мэдэл хэрэгждэг харьяа нутаг дэвсгэрийн хүрээнээс гаднах, далайн суурь дэвсгэр ба далайн ёроол болон тэрхүү талбайн нөөц бол хүн төрөлхтний нийтлэг өв юм гэж үздэг. 30-р зүйлд өнөөгийн болон ирээдүйн хойч үеийн хүрээлэн буй орчныг хамгаалах, хэвийн байдалд нь хадгалах, сайжруулах нь бүх улсын үүрэг хариуцлага гэдгийг зааж өгдөг. Дөрөвдүгээр бүлэгт, олон улсын хамтын нийгэмлэгийн хөгжил цэцэглэлт нь бүхэлдээ түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн хөгжил цэцэглэлтээс шууд хамаардаг юм байна гэсэн ажиглалтыг дөрвөн зүйлд багтаасан байдлаар эцсийн заалтуудыг оруулсан болно. Өндөр хөгжилтэй орнуудын дийлэнх нь нэг бол саналаа өгөхөөс түдгэлзсэн эсвэл эсрэг санал өгсөн байдаг. Энэхүү дүрмийг дэмжихээс татгалзсан орнууд нь, олон улсын хууль тогтоомжид хүлээсэн үүрэг амлалт эсвэл олон улсын эрх зүйн хамаарлын талаарх лавлагааг агуулаагүй байна гэж санаа зовж байжээ. Өөрөөр хэлбэл, Дүрэм нь гарын үсэг зурсан улсуудад олон эрхийг олгосон боловч, эдгээр нь бусад улсуудын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хувьд тэнцвэртэй биш байв. Дүрмийн эрх зүйн байдлын талаар нэлээд их маргаан өрнөсөн боловч, ямар ч тохиолдолд олон улсын асуудал болж аажмаар замрах болов. Хэдийгээр Дүрэм нь олон улсын эдийн засгийн харилцаанд төлөвлөсөн өөрчлөлтийг авчирч чадаагүй ч, үүнтэй холбоотой маргаан нь хөгжиж буй орнуудын санаа зовнилыг ирээдүйд илүү анхаарч байх нөхцөлийг бүрдүүлсэн гэж зарим нь үзэж байна. Түүнчлэн Дэлхийн түвшний хэлэлцээ (Global Negotiations), Олон улсын эдийн засгийн шинэ дэглэм (New International Economic Order), Умард-Өмнөдийн яриа хэлэлцээг (North-South dialogue) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
198	Cherry-picking	Интоор түүх. Хэлэлцээнд оролцож буй тухайн талд хамгийн бага хэмжээний бэрхшээл учруулах магадлалтай үүрэг хариуцлагууд эсвэл хэлэлцээний сонголтууд бүхий цэсээс сонголт хийх оролдлого. Бусдын сонор сэрэмж нь үүнээс үргэлж урьдчилан сэргийлдэг.
199	Chicago Convention	Чикагогийн конвенц. Олон улсын агаарын тээврийн аюулгүйн дэг журамтай үйлчилгээний тогтолцоог хөхиүлэн дэмжих зорилготойгоор 1944 онд Олон улсын иргэний агаарын тээврийн конвенцыг баталсан байна. Уг конвенцын нөхцөлүүд нь дэлхийн агаарын тээврийн системийн үндсэн онцлог шинж чанар, агаарын тээврийн хоёр талын эрхийг олгох аргачлалуудыг засагладаг. Конвенцыг Монтреаль хотод байршилтай Иргэний нисэхийн олон улсын байгууллага (ICAO) удирдаж байдаг. Мөн агаарын тээврийн үйлчилгээний хоёр талын хэлэлцээр (bilateral air services agreements), агаарын орон зайн эрх чөлөө (freedoms of the air), агаарын нээлттэй орон зайн тухай хэлэлцээрийг (open-skies agreements) үзнэ үү.
200	Chicken War	Тахианы махны дайн. Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний эхлэлийг тавьсан гэх АНУ болон Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хооронд үүссэн худалдааны хурцадмал байдлын үеийг хэлдэг. Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын дагуу хувьсах татвар хураамжуудыг сунгаж үүнийг эхлүүлсэн нь улмаар Германы импортын татвар хураамжуудыг гурав дахин нэмэгдүүлсэн байдаг. Энэ нь АНУ-ын Герман улс руу хийж байсан тахиа шувууны махны экспорт шууд эрс буурахад хүргэсэн ба энэ цаг мөч хүртэл АНУ-ын экспортлогчид маш их амжилттай ажиллаж байсан. Нөхөн олговор хүссэн нэхэмжлэл болон түүний эсрэг нэхэмжлэл дагалдан гарах болов. ТХЕХ-ийн дүрмийн дагуу 1963 оны 11-р сард байгуулагдсан маргаан шийдвэрлэх мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүн нь шийдэл гаргах үндэслэлийг гаргаж өгсөн. Хоёр талууд хоёулаа 26 сая ам.долларын үнэ бүхий тахиа шувууны махны худалдаа өртсөн болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Дараа нь АНУ тооцоогоо барагдуулахын тулд нэмэлт импортын татварууд ногдуулсан нь гол төлөв Францын коньяк, Герман ачааны машин, Голландын декстрин, цардуулд нөлөөлснөөр, АНУ-ын хариу арга хэмжээг илүү өргөн хүрээнд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн гишүүдийн дунд мэдрэгдэхүйц байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Кеннедигийн үе шатны хэлэлцээний үлдсэн ажилд уг тахианы махны дайны үзүүлсэн үр нөлөөг, ялангуяа үүний дараа бусад хэд хэдэн хүнд хэцүү үе шатууд дагалдан гарсан байдаг тул, шүүмжлэхэд хэцүү юм. Гэвч Хөдөө аж ахуйн нийтлэг бодлого нь эхлээд Европыг бие дааж өөрөө өөрийнхөө хэрэгцээг хангахад, дараа нь олон бүтээгдэхүүнүүдийн экспортыг татаасаар дэмжих болсон нь, үр ашигтай экспортлогч нарт тулгараад байгаа олон улсын хөдөө аж ахуйн худалдааны улам бүр хурцдаж буй асуудлыг тодруулан зааж өгсөн. Мөн анжисны хошууны дайныг (Ploughshares War) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
201	Chief supplier provision	Тэргүүн ханган нийлүүлэгч. АНУ-ын Харилцан адил байх худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийн гол онцлог чанар. Үүнд тавьдаг болзол нь тухайн бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч биш л бол, ямар ч улсад тарифын хөнгөлөлт үзүүлэхгүй байх болно. Энэхүү заалт нь үндэсний нэн тааламжтай нөхцөлийн журмын дагуу худалдааны гэрээ байгуулсан бусад түнш улсуудад зориулж өмнө нь тарифаа бууруулсны дараа, харилцан адил байх нөхцөл бүхий худалдааны гэрээг хараахан байгуулчихгүй байгаа улсуудтай наймаалцах АНУ-ын эрх мэдлийг хадгалж авч үлдэх зорилготой нөхцөл байсан. Тэргүүн ханган нийлүүлэгчийн нөхцөлийг ТХЕХ-т үндсэн ханган нийлүүлэгчийн эрх хэлбэрээр шилжүүлсэн байна.
202	Child labour	Хүүхдийн хөдөлмөр. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) 138-р Конвенцод элсэн орж байгаа улс орнуудын хувьд хөдөлмөр эрхлэлтийн хамгийн доод нас 15 наснаас доошгүй байх ёстой гэдгийг зааж өгсөн байдаг. Энэ нөхцөлийг зарим хөнгөн ажлын хувьд 13 нас болгож харин хөгжиж буй орнуудын хувьд 12 нас хүртэл бууруулж болох бөгөөд ингэхдээ хөдөлмөр эрхлэлт нь хүүхдийн боловсролд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 138-р Конвенц нь насны доод хэмжээг аажмаар өсгөх зорилготой бөгөөд ОУХБ-ын 146-р зөвлөмжид хөдөлмөр эрхлэлтийн хамгийн доод нас нь 16 нас байх ёстой гэж зөвлөдөг. Мөн хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээнүүдийг (core labour standards) үзнэ үү.
203	Chinese Economic Area	Хятадын эдийн засгийн бүс. Энэ нэр томьёо нь заримдаа БНХАУ, Хонконг, Тайвань зэрэг нутгийг хамарсан бүсийг тэмдэглэхэд хэрэглэгддэг.
204	Chinese Taipei	Хятадын Тайвань. АПЕК болон ДХБ-д нэрлэгдсэн Тайванийн албан ёсны нэр.
205	CIPEC (Conseil intergouvernemental des pays exportateurs du cuivre (Intergovernmental Council of Copper Exporting Countries))	Зэс экспортлогч улсуудын засгийн газар хоорондын зөвлөл. Энэ зөвлөлийг гишүүн улс орнуудынхаа дунд судалгаа шинжилгээний ажлыг уялдуулан зохицуулах болон статистик тоон мэдээ зэрэг мэдээллээ харилцан солилцох зорилгоор 1967 онд байгуулсан байдаг. Бүрэн гишүүд нь Чили, Ардчилсан Бүгд Найрамдах Конго улс (Заир), Индонез, Перу, Замби, Австрали, Папуа Шинэ Гвиней нь Югославын адил гишүүн улсууд.
206	Circumvention	Хуулийг гадуур тойрч гарах замаар зөрчих. (тойрч гарах - Уругвай) Демпингийн эсрэг арга хэмжээг тойрч гарах гэсэн оролдлогыг илэрхийлдэг боловч мөн гарал үүслийн дүрэм зэргээс арга заль хэрэглэн зайлах үйлдлийг хэлдэг. Үүнд: тухайн бүтээгдэхүүний гарал үүслийг нь нуун, зүсийг нь хувиргах, зарим тохиолдолд уг хэлэлцээрийн шаардлагад нийцэх хангалттай хэмжээний нотолгоо гаргаж өгөх. Эдгээр нь заримдаа боолтын түлхүүр (отвёртка/халив) үйл ажиллагааны ангилалд багтах нь бий. Мөн Хуулиас гадуур тойрч гарахын эсрэг арга хэмжээ (anti-circumvention) гэснийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
207	CITES (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora)	<p>Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES). Үүнийг 1973 онд Байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооны (IUCN) ивээл дор байгуулсан байдаг. Уг конвенц нь 1975 оны 7 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. IUCN нь НҮБ-ын нэг хэсэг нь биш боловч үүнтэй маш ойр дөт холбогдсон байдаг. Энэ конвенц нь зэрлэг амьтан, ургамлын олон улсын худалдааг уялдуулан зохицуулж байдаг. Үүнд ховордсон төрөл зүйлийг гурван ангилалд хуваадаг: (i) худалдааны нөлөөнд өртөөд буй эсвэл өртөж болох, устах аюулд өртөөд буй, (ii) устах аюулд өртөөгүй ч гэсэн тэдгээрийн худалдааг чангатган журамлан зохицуулахгүй бол тийм болж болох, (iii) улсаас хамгаалалтад авсан төрөл зүйлүүдийг жагсаагаад, үүний төлөө бусад улсуудын хамтын ажиллагааг эрэлхийлэх юм. Конвенцын дагуу худалдаалж болно гэсэн хэсэгт нь, зөвшөөрлийн системээр дамжуулж үүнийг хийдэг. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment) гэдгийг үзнэ үү.</p>
208	Civil aircraft code	<p>Иргэний агаарын тээврийн онгоцны тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хууль. Мөн Иргэний агаарын тээврийн онгоц худалдаалах тухай хэлэлцээрийг (Agreement on Trade in Civil Aircraft) үзнэ үү.</p>
209	Clawback provisions	<p>Улсын тэтгэлгийг нэмэгдүүлэхэд гарсан зардлыг, татвар нэмэгдүүлэх замаар нөхөх нөхцөлүүд. Энэ нь монополын эсрэг хуулийн дор, дотоодын хуульд эс захирагдсан, нутаг дэвсгэрийн гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, бодит хохирлын хэмжээнээс илүү давсан үнийн дүнг нөхөхийн тулд, учруулсан хохирлыг үндэсний шүүхийн тогтолцоогоор дамжуулан, гурван удаа нөхөн төлөх тушаал авч байгаа талын чадварыг хэлдэг. Хэрэв хохирлын дүнг гурван удаа нөхөн төлөх тушаал авсан тал нь сөрөх нэхэмжлэл гаргаад амжилттай байж чадвал, хохирлын хэмжээг гурав нугалсан төлбөрийг хүлээн авч байгаа тал нь хэт их гэж тооцсон дүнг буцаагаад төлөх үүрэг хүлээх болно. Хохирлыг нөхөн төлүүлнэ гэдэг нь, хэрэв нөхөн төлбөр хүлээн авч байгаа тухайн компани нь, улсын тэтгэлгийг нэмэгдүүлэхэд гарсан зардлыг, татвар нэмэгдүүлэх замаар нөхөхтэй холбоотой шүүх ажиллагаа явуулж байгаа тухайн улсад анхнаасаа өмч хөрөнгөтэй байсан тохиолдолд л зөвхөн боломжтой байдаг.</p> <p>Мөн Дотоодын хуульд эс захирагдсан, нутаг дэвсгэрийн гадна (extraterritoriality) гэснийг үзнэ үү.</p>
210	Cobden-Chevalier Treaty	<p>Кобден-Чевалиерийн гэрээ. Энэ нь 1860 онд Англи болон Франц улсын хооронд байгуулсан арилжааны гэрээ ба үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) хэдэн арван жилийн хугацаанд Европын хэмжээнд нийтлэг ашиглахад хүргэсэн байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
211	COCOM (Co-ordinating Committee for Multilateral Export Controls)	<p>Экспортын олон талт хяналтыг зохицуулах хороо (COCOM). Энэхүү хорооны оршин тогтнох үндэслэл нь 1951 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн зүгээс, коммунист улсууд руу чиглэсэн “зэвсэг, зэвсэглэл, дайн багаж хэрэгсэл, атомын энергийн материал, газрын тос, дайны хэрэгсэл үйлдвэрлэхэд шаардлагатай зүйлсийн” ачаа тээвэрт хориг тавих зөвлөмжид тулгуурласан байдаг. 1958 онд хориглосон зүйлсийн жагсаалтыг стратегийн бараа бүтээгдэхүүнүүдийн хүрээнд чанд хатуу баримтлахаар бууруулсан байдаг бөгөөд хориглосон зүйлсийн жагсаалтад хожим нь хэд хэдэн өөрчлөлтүүд орсон байдаг. Экспортын олон талт хяналтыг зохицуулах хорооны гишүүдийг Исланд, Япон орнуудаас бусад НАТО-гийн (NATO - Умард Атлантын Гэрээний Байгууллага) гишүүн улс орнууд бүрдүүлдэг. 1996 оны 11 сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон Ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологийн экспортын хяналтын талаарх Вассенаарын хэлэлцээр (Wassenaar Arrangement on Export Controls for Conventional Arms and Dual-Use Goods and Technologies) гарч ирснээр COCOM-ын хэлэлцээрийг хүчингүй болгосон байна.</p>
212	Code-conditioned most-favoured-nation treatment	<p>Төрөлжүүлэн нэгтгэсэн хуулийн нөхцөлтэй Үндэсний нэн тааламжтай нөхцөл. Энэ нь нэгэн ижил ТХЕХ-ийн төрөлжүүлэн нэгтгэсэн хууль эсвэл ДХБ-ын хэлэлцээрийн гишүүн улс орнуудад л үндэсний нэн тааламжтай нөхцөлийг сунгаж олгосон байх хэрэгтэй гэдэг нөхцөл байдлыг тайлбарладаг. Үүний нэг жишээ бол Засгийн газрын худалдан авалтын тухай ДХБ-ын хэлэлцээр. Мөн нөхцөл тавьдаг үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (conditional most-favoured-nation treatment) үзнэ үү.</p>
213	Code of Good Practice for the Preparation, Adoption and Application of Standards	<p>Стандартуудыг бэлтгэх, батлах, хэрэгжүүлэхэд зориулсан зохистой дадлын хэм хэмжээ. Энэ нь ДХБ-ын Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 3-р хавсралтад агуулагдсан байдаг. Төв засгийн газрын стандартжуулалд хариуцсан хуулийн этгээд нь үүний нөхцөлүүдийг баримталж ажиллах ёстой боловч энэ нь орон нутгийн захиргааны байгууллагууд болон төрийн бус статустай хуулийн этгээдүүдэд ч мөн хэрэгжүүлэхэд нь нээлттэй байдаг. Уг хэм хэмжээ буюу төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн акт нь, стандартуудыг үл ялгаварласан, ил тод байдлаар бэлтгэж, удирдан чиглүүлэх зорилготой 14 бодит зүйл заалтуудыг агуулсан байдаг. Мөн тохирлын үнэлгээ (conformity assessment), Цахилгаан техникийн олон улсын комисс (Олон улсын цахилгаан холбооны комисс - Уругвай) (International Electrotechnical Commission), Олон улсын стандартчиллын байгууллагыг (International Organisation for Standardisation) үзнэ үү.</p>
214	Code on Commercial Counterfeiting	<p>Арилжааны чанартайгаар хуурамчаар дуурайлган үйлдэх, хууль бусаар хуулбарлах тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хууль. Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр АНУ-ын санал болгосон эрх зүйн акт. Тухайн үед үүний хэрэгжилт болон хүсүүштэй зүйл эсэх талаар ямар ч нэгдсэн зөвшилцөл байгаагүй, гэхдээ Уругвайн үе шатны хэлэлцээгээр Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээрийг (TRIPs) буй болгосон байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
215	Codex Alimentarius	Хүнсний дүрэм/Кодекс Алиментариус. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага анх олон улсын хүнсний стандарт хэм хэмжээнүүдийг санаачилж, бэлтгэж, нийтлүүлж, шинэчлэн засварлаж байхдаа хамтран зохион байгуулж байсан хөтөлбөр. Эдгээр стандартуудын үр дүнд гарсан уялдаа холбоо нь, олон улсын хүнсний худалдааг өргөжүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Уг хөтөлбөрийг 1962 онд байгуулсан Кодекс Алиментариусын эрх зүйн хороо удирдан чиглүүлж байдаг.
216	Co-existence and diversity	Хамтран оршин тогтнох болон олон янз байдал. Хөдөө аж ахуйн салбарын талаарх ДХБ-ын яриа хэлэлцээнүүдэд Японы яриа хэлэлцээний байр суурийн үндсэн зарчмын утгыг илэрхийлж байна. Үүнд уламжлалт хөдөө аж ахуйн нийгэм болон орон нутгийн ард иргэдийн гүйцэтгэх үүрэг нь хүнс болон аж үйлдвэрлэлийн салбарын түүхийн эд материалыг ханган нийлүүлэгчийн хувьд, хөдөө аж ахуйн салбарын гүйцэтгэх үүрэг функцтэй хамт зэрэгцэн оршин тогтнох боломжтой байх ёстой гэсэн үг. Энэ утгын илэрхийлэл нь, олон янз байдал үргэлжилж байх нөхцөлийг хангахын тулд зарим улс орнуудын эдийн засгийн хувьд хөдөө аж ахуйн салбарыг хамгаалах онолын дагуу арга хэмжээ авч байх шаардлагатай болохыг зааж байх шиг байдаг. Мөн Үргэлжлүүлэх тухай заалт (continuation clause), олон талын үр өгөөж бүхий байдал (multifunctionality), худалдааны бус зорилтуудыг (non-trade objectives) үзнэ үү.
217	Collective action	Хамтын үйл ажиллагаа. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) хэрэглэдэг нэр томьёо буюу зөвхөн хамтын үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих боломжтой, худалдааг либералчлах эсвэл худалдааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тайлбарлаж байдаг. Үүнд чанарын баталгаажуулалт болон стандартууд, гаалийн хамтын ажиллагаа зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг хамруулсан байдаг. Мөн либералчлалын нэгдсэн арга хэмжээг (concerted liberalisation action) үзнэ үү.
218	Colorado Group	Колорадогийн бүлэг. ДХБ-д идэвхтэй байдаг бүлэг буюу үндсэн гол гишүүд нь Австрали, Канад, Чили, Европын хамтын нийгэмлэг, Хонконг-Хятад, Израиль, Япон, Шинэ Зеланд, Сингапур, Швейцарь, АНУ. Уг бүлэг нь худалдааг хөнгөвчлөх олон талт зарчмуудыг хөгжүүлэхийг эрэлхийлдэг.
219	Comecon	Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (COMECON) ба өөрөөр СМЕА, СЕМА, САМЕ, СМЕА гэж нэрлэдэг. Энэ нь 1949 оноос 1991 он хүртэл хуучин Зөвлөлт Холбоот Улсын удирдлага дор ажиллаж байсан эдийн засгийн байгууллага бөгөөд үүнд Польш, Зүүн Герман, Чехословак, Унгар, Румын, Болгар, Югослав зэрэг зүүн болон төв Европын орнууд болон дэлхийн бусад хэд хэдэн социалист улсуудаас бүрддэг байв.
220	COMESA (Common Market for Eastern and Southern Africa)	Зүүн болон Өмнөд Африкын нэгдсэн зах зээлийг (Common Market for Eastern and Southern Africa) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
221	Commerce	Арилжаа, худалдааны үйл ажиллагаа. Энэ нь ихэвчлэн дотоодын зах зээлийнхээ хүрээнд, бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээнүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, түгээлттэй холбоотой үйл ажиллагаануудыг илэрхийлдэг. Мөн худалдаа (trade) гэдгийг үзнэ үү.
222	Commercial defence mechanisms	Арилжаа, худалдааг хамгаалах механизм. Мөн болзошгүй хамгаалалтыг (contingent protection) үзнэ үү.
223	Commercial policy	Арилжаа, худалдааны бодлого. Энэ нэр томьёо одоо хэрэгцээнээс гарч байгаа ба нийтлэг хэрэглээнд худалдааны бодлого (trade policy) гэж орлох болсон бөгөөд энэ нэр томьёотой хэрэг дээрээ хэдэн арван жил хамт оршиж ирсэн байдаг. Энэ нэр томьёонд худалдааны урсгалд нөлөөлдөг засгийн газрын эрх зүйн актууд, бодлогууд, практик үйл ажиллагаануудыг хамруулдаг. Орчин үеийн хэлбэрээ олсон худалдааны бодлого нь мөн үйлчилгээний салбарууд, оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлууд гэх мэт худалдааны шинэ асуудлуудыг хамарснаараа илүү олон асуудлуудыг хамруулсан. ТХЕХ-ийн төслийг боловсруулж байсан зохиогчид арилжаа худалдааны бодлогыг ТХЕХ-ийн 2-р Бүлэгт хамарсан сэдвүүд болох үндэсний нөхцөл, демпингийн эсрэг болон татаасыг саармагжуулан импортод ногдуулах татвар, гаалийн үнэлгээ, импорт болон экспортын хураамжууд болон ёс журмууд, гарал үүслийн тэмдэг, тоо хэмжээний хязгаарлалтууд, татааснууд, улсын худалдааны аж ахуйн нэгжүүд, хамгаалалтын арга хэрэгслүүд, зөвлөлдөөн, маргаан шийдвэрлэх зэрэг асуудлууд гэж үзэж байсан. Жишээлбэл, Маастрихтын гэрээний 7-р Гарчигт “нийтлэг арилжаа, худалдааны бодлого” гэсэн хэллэгийг Ромын гэрээнээс авч үлдсэн байдаг нь 113-р Зүйлд (нэмэлт өөрчлөлт оруулсан гэрээний 133-р зүйл) үүнийг тодорхойлсноор бол “энэ нь ялангуяа тарифын хувь хэмжээнд хийх өөрчлөлтүүд, тариф болон худалдааны хэлэлцээрүүдийг байгуулахдаа жигд ижил зарчмуудыг баримтлах, либералчлалын арга хэмжээ, демпинг эсвэл татаас тохиолдсон үед авч хэрэгжүүлэх гэх мэт, экспортын бодлого болон худалдааг хамгаалах бодлогын арга хэмжээнүүдэд нэгэн жигд амжилтад хүрч чадах зэрэгт тулгуурлана” гэсэн байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Мөн 113-р Зүйл Хороо ба Худалдаа, арилжааны нийтлэг бодлогыг (Article 113 Committee and Common Commercial Policy) үзнэ үү.
224	Commercial presence	Арилжааны төлөөлөл/төлөөлөгчийн газар. ДХБ-ын Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (YХЕХ - GATS)-т тусгагдсан үйлчилгээ нийлүүлэх 4 хэлбэрийн 3 дах нь. ДХБ-ын аль нэг гишүүн орны хуулийн этгээд бусад гишүүн орны нутаг дэвсгэрт өөрийн төлөөлөгчөөр дамжуулан арилжааны үйлчилгээ үзүүлэх хэлбэр. Жишээлбэл, БНСУ-ын “А” эмнэлэг Монгол улсад 100 хувийн хөрөнгө оруулалтаар өөрийн салбар эмнэлгийг байгуулж арилжааны нөхцөлөөр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэх мэт. Үйлчилгээ нийлүүлэх хэлбэр (modes of services delivery), Төлөөлөгчийн газар байгуулах эрх ба байгуулахгүй эрх (right of establishment and right of non-establishment) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
225	Commercial treaty	Арилжаа, худалдааны олон улсын гэрээ. Мөн хоёр талын худалдааны хэлэлцээрийг (bilateral trade agreement) үзнэ үү.
226	Commission on Enterprise, Business Facilitation and Development	Аж ахуйн нэгж, бизнесийг дэмжиж, хөгжлийн асуудал эрхэлсэн хороо. Уг хороо нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн 9-р бага хурлын үеэр (UNCTAD) байгуулагдсан. Түүнд олгогдсон эрх, үүргийн хүрээнд, аж ахуйн нэгжийн хөгжлийн асуудалтай холбогдолтой сургалтын үйл ажиллагаа болон бодлоготой холбоотой асуудлаар хөгжиж буй улс орнуудад дэмжлэг үзүүлэх, Худалдааны үр ашгийн талаарх хөтөлбөрийг бүрэн дүүрэн ашиглахыг хөхиүлэн дэмжих, Дэлхийн мэдээллийн дэд бүтцийн бодит практик үр дагаврыг үнэлэх дүгнэх, хөгжлийн амжилттай арга туршлагуудыг судалж нягтлах, 1990-ээд онуудад Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт үнэлгээ хийх зэрэг асуудлыг хамардаг. Хороо нь жилд нэг удаа уулздаг. Мөн НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлыг (UNCTAD) үзнэ үү.
227	Commission on Investment, Technology and Related Financial Issues	Хөрөнгө оруулалт, технологи, холбогдох санхүүгийн асуудал эрхэлсэн хороо. Уг хороо нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн 9-р бага хурлын үеэр (UNCTAD) байгуулагдсан. Түүнд олгогдсон эрх, үүргийн хүрээнд хөгжиж буй улс орнуудын хувьд, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж ашиглах, хөгжлийн тодорхой хамаарал бүхий өрсөлдөөний хуультай холбоотой асуудлуудыг нягтлан шалгах, шинжлэх ухаан, технологи, инновацын бодлогуудыг дүн шинжлэх ажлыг зохион байгуулах, мөн технологийн хөгжилд техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон улсын худалдаа ба хөрөнгө оруулалтад идэвхтэй оролцохтой холбоотой тодорхой хөгжлийн сорилтуудыг нягтлан шалгах чадварыг нь сайжруулахад чиглэсэн асуудлуудыг хамардаг. Хороо нь жилд нэг удаа уулздаг. Мөн НҮБ-ын Худалдаа, хөгжлийн 9-р бага хурлыг (UNCTAD) үзнэ үү.
228	Commission on Science and Technology for Development	Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн комисс. Энэ нь НҮБ-ын Эдийн засгийн ба нийгмийн зөвлөлийн (ECOSOC) салбар байгууллага боловч НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) гардан үйлчилдэг. Үүнд, жижиг хэмжээний эдийн засгийн үйл ажиллагаанд зориулсан технологи, шинжлэх ухаан технологи ба хүсийн тэгш байдлын илэрхийлэл, шинжлэх ухаан ба технологи ба байгаль орчин, хөгжиж буй улс орнуудын аж үйлдвэржилтэд технологиудын хувь нэмэр оруулах, мэдээллийн технологиуд болон тэдний шинжлэх ухаан ба технологид оруулах хувь нэмэр зэрэг асуудлыг хамарсан хөгжлийн хүчирхэг алсын хараа бүхий хөгжлийн хөтөлбөр байдаг. Хороо хоёр жил бүр уулздаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
229	Commission on Trade in Goods and Services, and Commodities	<p>Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүхий эд материалын худалдааны хороо. Энэ нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн 9-р бага хурлын үеэр (UNCTAD) байгуулагдсан. Түүнд олгогдсон өргөн хүрээний эрх, үүргийн хүрээнд хөгжиж буй улс орнуудад дэмжлэг үзүүлэхдээ, тэднийг Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнгүүдээс үр ашиг хүртэх, үүнд зохицож ажиллах боломж олгох, улс орнуудыг ДХБ-д элсэж ороход дэмжлэг үзүүлэх, худалдааны хувьд амжилт гаргахад нь саад болж байгаа зүйлсийг олж тогтоох, худалдааны давуу эрхтэй холбогдож буй асуудлуудад дүн шинжилгээ хийх, хөгжиж буй улсуудыг үйлчилгээний салбарт нөөц чадавхаа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, худалдаа ба байгаль орчны асуудлуудтай холбоотой ажиллах, түүхий эд материалаас хамааралтай улсуудын тодорхой хамаарлын асуудлыг тусгаж ажилладаг байна. Хороо жил бүр уулздаг. Мөн НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлыг (UNCTAD) үзнэ үү.</p>
230	Commission on Transnational Corporations	<p>Үндэстэн дамнасан корпорацуудын асуудал эрхэлсэн комисс. Өмнө нь НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийн (ECOSOC) салбар байгууллага байсан боловч, одоо НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) Хөрөнгө оруулалт, технологи, холбогдох санхүүгийн асуудлын хороотой нэгдсэн байна.</p>
231	Committee on Regional Trade Agreements	<p>Бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн хороо. Мөн бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийг (regional trade agreements) үзнэ үү.</p>
232	Committee on Rules of Origin	<p>Гарал үүслийн дүрмийн хороо. Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээрийг үзнэ үү.</p>
233	Committee on Trade and Development	<p>Худалдаа ба хөгжлийн хороо. ДХБ-ын 1964 оны 11 сарын 26-нд анх байгуулагдсан хороо. Энэ нь хөгжиж буй улс орнуудын асуудалтай холбоотой ажилладаг ба урт хугацаанд үүний гол үүргүүдийн нэг нь ТХЕХ-ийн 4-р Зүйл болон Зөвшөөрөгдөх заалтыг (Enabling Clause) удирдах явдал байсан. Мөн хөгжиж буй орнууд болон ТХЕХ-ийг (developing countries and the GATT) үзнэ үү.</p>
234	Committee on Trade and Environment	<p>Худалдаа ба хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн хороо. Риогийн Хүрээлэн буй орчин ба хөгжлийн бага хурлын тунхаглал болон 21-р зууны Хөтөлбөрийн хариуд энэхүү ДХБ-ын хороо байгуулагдсан. Үүний гол гүйцэтгэх ажил нь тогтвортой хөгжлийг дэмжиж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, оюуны өмчийн эрхтэй холбоотой олон талт худалдааны системийн дэг журамд байж болохуйц өөрчлөлт гаргах зөвлөмжүүдийг боловсруулж гаргахын тулд, худалдааны арга хэмжээ болон хүрээлэн буй орчны арга хэмжээ хоёрын хоорондын харилцан хамаарлыг олж тодорхойлох явдал. Уг Хорооны ажил үүргийн удирдамжаас үзвэл, зөвлөмж болгож буй аливаа өөрчлөлтүүд нь олон талт худалдааны системийн нээлттэй, эрх тэгш, үл ялгаварласан мөн чанартай нийцсэн байх ёстой. Мөн хүрээлэн буй орчны олон талт хэлэлцээрүүдийг (multilateral environment agreements) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
235	Commitment	<p>Үүрэг амлалт. ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд гишүүн орнууд тодорхой хууль ёсны үүрэг амлалт авдаг. Жишээлбэл, тарифын хувь хэмжээг тохиролцсон түвшингээс дээш нэмэгдүүлэхгүй гэсэн үүрэг амлалт (tariff bindings), үйлчилгээний салбарт авсан үүрэг амлалтуудын жагсаалтад заасан заалтууд гэх мэт. Иймэрхүү үүрэг амлалтууд нь гол төлөв хоёр ба түүнээс дээш гэрээний талуудын дундаас үүсдэг бөгөөд дараа нь уг гэрээтэй холбоотой бүх талуудад үл ялгаварлах замаар хүртээмжтэй болгодог байна. Эдгээр нь үндэсний нэн тааламжтай нөхцөл болон үндэсний нөхцөл зэрэг ерөнхий дүрмүүдээс ялгаатай.</p>
236	Commodity	<p>Бараа/түүхий эд, материал. Арилжаалагдан солилцож буй аливаа зүйлс, гэхдээ ихэнх тохиолдолд түүхий эд материалтай холбоотойгоор уг нэршлийг хэрэглэдэг. Жишээ нь, улаан буудай, тугалга, зэс, манган, кофе, цай, резин. Мөн Нөөц түүхий эд бүтээгдэхүүн (buffer stocks), түүхий эд, материалын бодлого (commodity policy), түүхий эд, материалын худалдааны нөхцөл (commodity terms of trade), түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрийг (international commodity agreements) үзнэ үү.</p>
237	Commodity cartels	<p>Түүхий эд, материалын картель. Нээлттэй зах зээлд авч ирэх байсан түүхий эд, материалын үнээс дээгүүр үнэ тогтоохын тулд улсын болон хувийн хэвшлийн салбарын картелиуд бий болдог байна. Үүнийг хэрэгжүүлэх механизм нь зах зээлийн бодит түвшнээс үнийг дээгүүр байлгахын тулд, экспортын квот ногдуулах болон үгсэн хуйвалдах арга. Тийм картелиуд нь зөвхөн бүх гол чухал үйлдвэрлэгчдийг хамруулж чадсан тохиолдолд мөн орлуулах боломжтой өөр түүхий эд материал байдаггүй бол амжилттай хэрэгжих боломжтой. ОПЕК буюу Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага (ОПЕК) нь олон арван жилийн хугацаанд амжилттай картель байсаар ирсэн, гэвч газрын тосны үнийг өндөр байлгаж чаддаг түүний чадавх нь зах зээлд өндөр өртөгтэй үйлдвэрлэгчид орж ирэхэд хүргэсэн байна. Өмнөд Африкт байрладаг олон улсын очир алмаз эрдэнийн картель нь олон жилийн турш ашигтай ажиллаж ирсэн байдаг боловч, [Тэднээс] өөр хувилбар бүхий зах зээлүүдэд борлуулалт хийдэг очир алмаз эрдэнэ олборлон үйлдвэрлэгч нар тэдэнд ихээхэн сорилт авчрах болсон. Мөн түүхий эд материалын бодлого (commodity policy), түүхий эд материалын олон улсын хэлэлцээрүүд (international commodity agreements), байгалийн нөөцийн дипломат үйл ажлыг (resources diplomacy) үзнэ үү.</p>
238	Commodity Credit Corporation	<p>Түүхий эд, материалын зээлийн корпорац (CCC). АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны дотор ажилладаг засгийн газрын корпорац нь хөдөө аж ахуйн фермийн үнэ болон орлогыг дэмжсэн дэмжлэгүүдтэй холбоотой бүх хэлцлүүдээ хариуцаж ажилладаг. Түүхий эд, материалын зээлийн корпорацын чиг үүргүүдэд, зээлийн хүүгийн хувь хэмжээгээр дамжуулан зах зээлийн үнэд дэмжлэг үзүүлэх нөхцөл, улсын үнэт цаас, [фермерүүдийн] дутагдлыг нөхөх төлбөрүүд, хүнсний тусламжийн хөтөлбөрүүдийн менежмент зохион байгуулалт, Экспортыг сайжруулах хөтөлбөр (EEP) болон Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын урамшууллын хөтөлбөрийн (DEIP) менежмент багтдаг. Мөн Ахиц дэвшлийн хөтөлбөр (Progress program) болон PL 400-г үзнэ үү.</p>

239 Commodity policy

Түүхий эд, материалын бодлого. Энэ нь олон улсын түүхий эд, материалын худалдаанд нөлөө үзүүлж байгаа засгийн газрын үйл ажиллагаатай харьцаж ажиллах, худалдааны бодлогын нэг хэсэг. Үүний үндсэн зорилтууд нь, үйлдвэрлэгчдэд найдвартай, шударга, ашиг орлого сайтай цалин хөлс өгөх, хэрэглэгчдэд найдвартай, өрсөлдөхүйц ханган нийлүүлэлтийг олгох явдал. Эдгээр зорилтуудын алиныг нь ч объектив байдлаар тодорхойлох аргагүй. Нийлүүлэлт ба эрэлтийн хэлбэлзэл, үйлчлүүлэгчдийн үнийн өөрчлөлт, экспортын орлогын хэлбэлзэл зэргийн улмаас түүхий эд, зарим хүмүүс бараа материалыг үргэлж л тусгай арга хэмжээ авах шаардлагатай зүйл гэж ангилж авч үзсээр ирсэн байна. Ийм ойлголтод хүргэсэн олон шалтгааны нэг нь, зарим түүхий эд, материалын хувьд нийлүүлэлт болон эрэлтийн хүрээнд гарсан харьцангуй багахан хэмжээний өөрчлөлт нь ихээхэн хэмжээний үнийн хэлбэлзэлд хүргэдэг явдал. Өөр бусад тохиолдлуудад, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд, хүн амын ихээхэн хувийн амьжиргаа нь уг зах зээлд болж байгаа өөрчлөлтүүдэд их бага хэмжээгээр өртдөг байна. Иймэрхүү санаа зовоосон асуудалд засгийн газар соргог хандаж, [сөрөг үр дагаврыг] бууруулах арга замыг эрэлхийлэх хандлагатай байдаг. Олон улсын түүхий эд, материалын орчин үеийн бодлого нь, чөлөөт зах зээлийн зарчмыг гол төлөв илүүд үзсэн Гаванагийн дүрмийн (Havana Charter) төслийг боловсруулж эхлэх үед эхэлсэн. Дүрмийн төсөлд, зах зээлийн ердийн хүчин нь үйлдвэрлэл ба хэрэглээний хоорондын зохицуулалтыг хурдан шийдвэрлэх чадваргүй, болох гэж байгаа эсвэл болохоор хүлээгдэж байгаа анхдагч түүхий эдийн бараатай холбоотой ажилгүйдэл өргөн байгаа тохиолдолд л, Засгийн газар хоорондын хяналтын гэрээ гэж нэрлэгддэг үнэ, худалдааны хяналт бүхий олон улсын түүхий эд, материалын гэрээг (ICAs) байгуулахыг зөвшөөрсөн байдаг. Гэвч гэрээний төслийг боловсруулах явцад, чөлөөт зах зээлийн зарчим нь жишээ нь, зарим хүмүүсийн хувьд шаардлагатай гэж үзсэн засгийн газрын төлөвлөлтийг зөвшөөрснөөрөө олон талаараа харилцан буулт хийхэд хүрсэн байна. Хөгжиж байгаа улс орнуудад дотоодын аж үйлдвэрлэлээ хамгаалахын тулд импортын хязгаарлалт хийхийг нь зөвшөөрсөн байдаг. Эцсийн дүндээ Хаванагийн дүрэм хүчин төгөлдөр болж чадаагүй байна. 1947 онд НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөл (ECOSOC) нь бараа бүтээгдэхүүний зохицуулалтын талаар тохиролцох хэлэлцүүлэг зохион байгуулахыг уриалсан зөвлөмж гаргах, түүхий эдийн судалгааны бүлгүүдийг хуралдуулах эрх үүрэг бүхий, Олон улсын түүхий эд, материалын зохицуулалтын уялдан зохицуулах түр хороог (ICC-ICA) байгуулсан. Нийлүүлэлтийн найдвартай хүртээмжтэй байдлыг эрэлхийлсэн байгалийн нөөцөөр хомс улс орнууд, 1970-аад оны үеийн түүхий эдийн дипломат байдлын богино настай асуудлаар дамжуулан, UNCTAD болон түүний зорилгод шууд бус байдлаар туслалцаа үзүүлсэн бөгөөд энэ замаар түүхий эдийн хувьд хомс улсууд, ханган нийлүүлэгчдийн найдвартай хүртээмжтэй байдлыг эрэлхийлж байжээ. Наяад оны дунд үеэс эхлэн олон улсын түүхий эдийн худалдаатай холбоотой асуудлуудын илүү нухацтай үнэлэлт дүгнэлт гарсан нь, үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн аль алиных нь үзэл бодлын үүднээс, зах зээлийн өргөн цар хүрээтэй хөндлөнгийн оролцооны ашгийн талаар маш их эргэлзэхэд хүргэсэн байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		1990-ээд оны дунд үеэс, бид зах зээлд бараа бүтээгдэхүүнийг илүү сонирхол татахуйц болгох зорилгоор, ил тод байдлын механизмыг сурталчлах, судалгаа, боловсруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх олон улсын хамтын ажиллагааг хязгаарласан чөлөөт зах зээлийн зарчмууд руу үндсэндээ буцаж оров. Мөн нөхөн олговрын санхүүжилтийн зохицуулалтыг (compensatory financing arrangements) үзнэ үү.
240	Commodity terms of trade	Түүхий эд, материалын худалдааны нөхцөл. Үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүний үнийг түүхий эд, материалын үнэтэй харьцуулсан харьцааг харуулсан индекс. Тухайн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төлбөрийг төлөхийн тулд цөөн тооны бараа бүтээгдэхүүнийг борлуулах шаардлагатай бол түүхий эд, материалын худалдааны нөхцөл сайжирсан. Харин илүү их түүхий эд, материалууд борлуулагдах шаардлагатай болох үед тэдгээр нь улам муудна. Мөн худалдааны нөхцөлийг (terms of trade) үзнэ үү.
241	Common Agricultural Policy	Хөдөө аж ахуйн нэгдсэн бодлого (CAP). Европын хамтын нийгэмлэгийн ажиллуулдаг, хөдөө аж ахуйн салбарт үнийн дэмжлэг үзүүлэх ба тэтгэлэг олгох систем. CAP-ыг санхүүжүүлдэг механизм бол Европын хөдөө аж ахуйн зааварчилгаа ба Батлан даалтын сан. CAP-ын албан ёсоор мэдэгдсэн зорилго бол, хөдөө аж ахуйн тогтвортой зах зээлийн нөхцөл байдлыг хөхиүлэн дэмжих, фермерүүдэд амьжиргааны шударга стандартыг бүрдүүлэх, эцсийн хэрэглэгчдэд боломжийн үнийг, хөдөө аж ахуйн гарцыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах явдал. Үүнд нийгмийн болон эдийн засгийн бодлогуудыг хутгаж холих оролдлого хийж байсны улмаас үүний хэрэгжилт нь үргэлж хүндрэлтэй тулгарч байсан. CAP нь ургац нэмэгдүүлж, олон фермерүүдэд орох орлогыг нэмэгдүүлснээрээ маш их амжилттай ажилласан байдаг боловч, ХАА-н гарц нэмэгдэж, өндөр өртгөөр үйлдвэрлэх болж, ихээхэн хэмжээний экспортын татаасны тусламжтайгаар л экспортлох боломжтой нөхцөл байдлыг үүсгэсэн учраас, дэлхийн зах зээлд өргөн хүрээг хамарсан эмх замбараагүй байдлыг бий болгосон байна. Жижиг фермерүүдийг нэгтгэж, нягтруулахад уг хандлагыг эргүүлэн чиглүүлэх тал дээр маш бага зүйл хийсэн байдаг. Мөн CAP нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС) хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн хэрэглээний үнийг хэт өндөр болгоход хүргэсэн бөгөөд тэндхийн төсвийн алдагдалд хүргэхэд хувь нэмэр болсон байдаг. Мөн 2000 оны Хөтөлбөрийг (Agenda 2000) үзнэ үү.
242	Common Commercial Policy	Худалдаа, арилжааны нэгдсэн бодлого. Ромын гэрээний 113-р Зүйлийн дагуу, Европын хамтын нийгэмлэгийн гишүүн орнууд нь Европын Комиссоороо дамжуулан, тарифын нэгдсэн бодлого, худалдааны хэлэлцээрүүд, хамгаалалтын арга хэрэгслүүд, демпингийн эсрэг арга хэмжээ зэргийг удирдан явуулж байдаг. Гишүүн улс орнууд нь дан ганцаараа [ЕСС-гийн] нэгдсэн гадаад тарифыг өөрчлөх эсвэл бусад улсуудтай худалдааны гэрээ хэлэлцээрт орох эрх байхгүй. Үүнд 133-р Зүйлийн Хороо гэх мэт маш өндөр түвшинд боловсорсон дотоодынх нь зөвлөлдөх механизмууд байдаг ба үүний дагуу гишүүн орнууд худалдаа, арилжааны нэгдсэн бодлогод өөрчлөлт оруулах саналуудаа гаргаж тавьж болдог байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
243	Common customs tariff	Гаалийн нэгдсэн тариф. Нэгдсэн гадаад тариф (common external tariff) үзнэ үү.
244	Common external tariff	Нэгдсэн гадаад тариф. Гаалийн холбооны гишүүн орнууд өөр хоорондоо хийх худалдааны саад хоригийг арилгаж, гуравдагч оронтой хийх худалдааны бодлогоо нэгтгэдэг. Өөрөө хэлбэл, гаалийн холбооны гишүүн орнууд гуравдагч оронтой хийх худалдаанд нэгдсэн гадаад тариф ашигладаг. ДХБ-ын дүрмийн дагуу Гаалийн холбооны гишүүн орнуудын нэгдсэн гадаад тариф нь хамгаалалтын түвшинг нийтэд нь нэмэгдүүлэхэд ашиглагдсан байж болохгүй. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн хувьд нэгдсэн гадаад тариф гэж байдаггүй.
245	Common Fund for Commodities	Түүхий эд, материалын нэгдсэн /хамтын сан. Энэ санг гол төлөв Нэгдсэн сан гэж нэрлэдэг. Үүнийг анх 1976 онд НҮБ-ын худалдаа, хөгжлийн 4-р бага хурлын (UNCTAD) үеэр Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөрт зориулсан санхүүжилтийн механизм байдлаар анх санал болгосон байдаг. Үүний бүтэц тогтолцооны талаарх хэлэлцээг 1980 онд эцэслэсэн байдаг. Энэ нь 1989 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд одоо 105 гишүүн улстай. Нэгдсэн санд гурван гол чиг үүрэг бий. Эхний чиг үүрэг нь, Нөөц хувьцааны анхны дансны үйл ажиллагаа болон олон улсын хэмжээнд зохицуулж байдаг үндэсний хувьцаагаар дамжуулан санхүүжилт хийхийг дэмжихэд чиглэсэн байдаг. Энэхүү чиг үүрэг нь хараахан идэвхтэй болж амжаагүй байгаа. Хоёрдугаар чиг үүрэг нь, түүхий эд материалын салбарын судалгаа, хөгжүүлэлт, бүтээмжийг сайжруулах ажил, хэрэглээг хөхиүлэн дэмжих Хоёрдугаар дансаар дамжуулан санхүүжилт хийхэд чиглэсэн байдаг. Гуравдугаар чиг үүрэг нь, түүхий эд, материалын талбарт бараа нөөцлөх болон тэдгээрийг санхүүжүүлэхээс бусад үйлдэл буюу уялдаа зохицуулалт болон зөвлөх үйлчилгээг хөхиүлэн дэмжих явдал байдаг. Түүхий эд, материалын олон улсын хуулийн этгээдүүдийн олж тодорхойлсон төслүүдэд уг санхүүжилтийг олгох боломжтой. Нийтлэг сангаас дэмжлэг авсан төслүүд нь тухайн улсын онцлогт тохирсон гэхээс илүү гол төлөв түүхий эд, материалыг тойрон хүрээлсэн шинж чанартай байдаг. Үүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Амстердамд байршилтай. Мөн Түүхий эд, материалын бодлого (commodity policy), Түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрүүд (international commodity agreements), НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлыг (UNCTAD) үзнэ үү.
246	Common market	Нэгдсэн зах зээл. Зарим нэгнүүдийн үзэж байгаагаар бол үүнийг гаалийн холбооны илүү боловсронгуй болсон хэлбэр гэж үздэг бөгөөд үүнд гишүүн орнуудын хооронд бараа бүтээгдэхүүний чөлөөт урсгалаас гадна мөн хөдөлмөр, хөрөнгө, үйлчилгээ нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр чөлөөтэй урсаж байж болно. Мөн дөрвөн эрх чөлөөний горимыг (four freedoms) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
247	Commonwealth of Independent States	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл. Үүнийг Зөвлөлт холбоот улсыг бүрдүүлж байсан олон бүгд найрамдах улсуудтай хамтран 1991 онд байгуулсан байна. Арван нэг үүсгэн байгуулагч нь Армени, Азербайжан, Беларусь, Казахстан, Киргизстан, Молдав, Орос, Тажикстан, Туркменистан, Украин, Узбекистан байв. Гүрж улс 1993 онд элссэн. Тусгаар тогтносон шинэ улсуудыг (Newly Independent States) мөн үзнэ үү.
248	Commonwealth preferences	Хамтын нөхөрлөлийн хөнгөлөлтүүд (гаалийн хөнгөлөлтэй татварууд). Эзэнт гүрний хөнгөлөлтүүдийн тухай нэршил ялангуяа дайны дараах он жилүүдээс хойш хэрэглэгдэх болсон байдаг боловч, дайн хоорондын жилүүдэд үүнийг аль хэдийнээ ашиглаж байжээ. Мөн эзэнт гүрний давуу байдлын/хөнгөлөлтийн зохицуулалтыг (imperial preferences arrangements) үзнэ үү.
249	Community Charter of Fundamental Social Rights for Workers	Ажилчдын нийгмийн суурь эрхүүдийн тухай Хамтын нийгэмлэгийн дүрэм. Мөн нийгмийн дүрмийг (Social Charter) үзнэ үү.
250	Community interest clause	Олон нийтийн ашиг сонирхлын тухай [хуулийн] заалт. Энэ заалт нь Европын хамтын нийгэмлэгийн 1979 онд гаргасан зохицуулалтын нэг хэсэг. Уг заалт нь тухайн асуудалд Олон нийтийн ашиг сонирхол байгаа эсэхээс хамааран, демпингийн эсрэг эсвэл татаасны эсрэг нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties) ногдуулах зохицуулалтын нэг хэсэг. Чухал зүйл нь гэвэл, "олон нийтийн ашиг сонирхол" нь импортын бүтээгдэхүүнийг хэрэглэгчид, гүн боловсруулагчид, дотоодын өрсөлдөөнт зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргийг хамруулан авч үздэг явдал. Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) болон татаасны эсрэг нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties) үзнэ үү.
251	Community rights	Нийтийн/хамтын эрх. Уг нэр томьёо нь нийгмийн бүлэг, нутгийн ард иргэд нь уламжлалт мэдлэгийг (traditional knowledge) хөгжүүлэх, эсхүл өмчлөх эрхийн асуудлыг тайлбарладаг. Уламжлалт мэдлэгийн хувьд оюуны өмчийн хамгаалалтын шинэ хэлбэр шаардлагатай гэж үздэг.
252	Comparability	Харьцуулагдахуйц байх. Тодорхой зохицуулалтуудын утгыг тэмдэглэж байсан АПЕК-ийн хэлэлцүүлгийн үеэр ашигласан нэр томьёо бөгөөд үүнд, Богорын тунхаглалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн АПЕК-ийн салангид тусдаа хувь нэмрүүдийн хоорондын өргөн хүрээний ижил тэнцүү шинж чанартай байх нөхцөлийг хангаж ажилласан байдаг.
253	Comparative advantage	Харьцангуй давуу тал. 1817 онд Дэвид Рикардогийн анх дэвшүүлсэн онол бөгөөд аливаа улс харьцангуй үр ашигтай үйлдвэрлэх боломжтой бараа бүтээгдэхүүнээ экспортлох магадлал өндөр гэдгийг тайлбарласан. Харьцангуй үр ашгийн хэмжүүр нь өөр өөр улс орны ижил төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг биш харин тухайн улс бүрийн өөр өөр бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг харьцуулж үздэг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Тухайн улсын харьцангуй давуу тал нь дэлхийн зах зээлд татаасаар дэмжиж гаргаагүй экспортод нь тусгалаа олсон байдаг. Харьцангуй давуу тал нь хөдөлгөөнгүй байх нь ховор. Улс орнууд харьцангуй давуу талыг жишээлбэл, ажиллах хүчээрээ дамжуулан ур чадвар олж авахад хөрөнгө оруулах замаар бий болгох боломжтой. Тиймээс динамик харьцангуй давуу тал гэсэн ойлголт байдаг.</p> <p>Мөн үнэмлэхүй давуу тал (absolute advantage), өрсөлдөх чадвартай давуу тал (competitive advantage), худалдаанаас ашиг олох онол (gains-from-trade theory), Хеккер-Охлиний теорем (Heckscher-Ohlin theorem), Калейдоскоп маягийн харьцангуй давуу тал (kaleidoscopic comparative advantage) ба Столпер-Самуэлсон теоремуудыг (Stolper-Samuelson theorem) үзнэ үү.</p>
254	Compensation	<p>Нөхөн олговор (хохирлыг барагдуулах). ДХБ-ын аливаа гишүүн үйлчилгээний салбарт үүрэг хүлээж амласан амлалтаа зөрчих, эсхүл үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаараас давсан тарифыг бараа бүтээгдэхүүнд ногдуулсан тохиолдолд ДХБ-ын гишүүнд олгох боломжтой хохирлыг арилгах арга хэмжээ. Уг арга хэмжээг авсан гишүүн улс нь хохирол амссан гишүүн улсдаа ямар нэгэн байдлаар нөхөн олговор олгох ёстой. Тухайлбал, ихэнх тохиолдолд өөр нэг бүтээгдэхүүнд нь тарифын хөнгөлөлт үзүүлэх, эсхүл өөр нэгэн үйлчилгээний салбарын үйл ажиллагаатай холбоотой үүрэг амлалт авч таардаг.</p> <p>Үүрэг болгосон, заавал биелүүлэх үүрэг амлалтууд (binding commitments), үүрэг хүлээсэн тариф (bindings), хамгаалалтын арга хэмжээ (safeguards) үзнэ үү.</p>
255	Compensation trade	<p>Нөхөн төлөх худалдаа. Гадаадын аж ахуйн нэгжид ханган нийлүүлсэн түүхий эдийн, эсхүл үйлчилгээ үзүүлснийхээ төлбөрийг тухайн аж ахуйн нэгжийнхээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэлбэрээр хүлээн авахаар тохиролцсон худалдааны хэлцэл. Худалдан авагч аж ахуйн нэгжийн давуу тал нь: үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг импортлоход гадаад валют шаардлагагүй болдог, үйл ажиллагаагаа жигдэртэл нь ямар нэгэн эргэн төлөлт хийх шаардлагагүй, мөн зарим бүтээгдэхүүндээ борлуулах бэлэн зах зээлтэй болчихдог.</p> <p>Гэхдээ энэ нь зөвхөн хязгаарлагдмал зах зээлтэй байсан тохиолдолд заримдаа өөрөө өөрийнхөө бүтээгдэхүүнтэй өрсөлдөж, ханган нийлүүлэгчдэд хямдруулсан үнээр өгөх шаардлагатай болох нь бий.</p> <p>Бартерын худалдаа (barter trade), Угтвар худалдаа (countertrade) үзнэ үү.</p>
256	Compensatory financing arrangements	<p>Нөхөн төлбөрийн санхүүжилтийн зохицуулалт. Түүхий эдийн экспортоос ихээхэн хамааралтай хөгжиж буй орнууд түүхий эдийн экспортын орлогын хомсдол, экспортын орлогын хэлбэлзлийн үр нөлөөг багасгах зорилгоор боловсруулсан засгийн газар хоорондын схем.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Гол зохицуулалт болох ОУВС-ийн нөхөн төлбөрийн ба болзошгүй зардлын санхүүжилтийн хэрэгслийг (IMF Compensatory and Contingency Financing Facility) олж авах нь, ихэнхдээ бүтцийн өөрчлөлтийг дэмжиж, төлбөрийн балансыг сайжруулахад чиглэсэн олон нөхцөл байдлаас шалтгаална. Ломе Конвенцын дагуу Африкийн, Карибын тэнгисийн, Номхон далайн бүсийн улс орнуудын хувьд (ACP states) ашиглах боломжтой байдаг STABEX (ACP-ын бүсийн улс орнуудын экспортын орлогыг тогтворжуулах зорилготой Европын Комиссын нөхөн олговрын санхүүжилтийн схем) ба SYSMIN (Уул уурхайн бүтээгдэхүүнүүдээс олох экспортын орлогыг тогтворжуулах систем) схемүүд нь болзол багатай боловч, төлбөр хүлээн авах орнууд нь юуны өмнө Европын Комисстой хамт Харилцан үүрэг хариуцлага хүлээх бүтэц, хамрах хүрээг (Framework of Mutual Obligations) байгуулах ёстой байдаг. Мөн Түүхий эд, материалын нийтийн/хамтын сан (Common Fund for Commodities) үзнэ үү.</p>
257	Competition	<p>Өрсөлдөөн. Энэ нь зах зээлийн орчинд аж ахуйн нэгжүүд хэрхэн ажиллах арга зам болон бусад ханган нийлүүлэгчид, эцсийн хэрэглэгчдийн үйл ажиллагаанд тэд хэрхэн хариу үзүүлж хандах тухай ойлголт. Өрсөлдөөний суурь утгыг зааж байгаа үзэл санаа нь, нийлүүлэлт болон эрэлт нь наанадаж богино хугацаандаа хязгаарлагдмал зүйл бөгөөд аж ахуйн нэгжүүд нь боломжтой нөөц баялгуудаас өөрсдийн хувь хэмжээг олж авах, зах зээлд нийцэж ажиллах тал дээр хүчин чармайлт гаргаж ажиллах ёстой гэсэн санаа. Тохиромжтой нөхцөлд бол аж ахуйн нэгжүүдийн хоорондын өрсөлдөөн нь үнэ болон инновацыг буй болгох чадвар, мөн зах зээлд гарч буй өөрчлөлтөд хариу үзүүлж ажиллах чадварт тулгуурлах болно. Өөрөөр хэлбэл, үнэ болон зах зээлийн системийн үйл ажиллагаанд ямар нэгэн саад тотгор учруулахгүй болно. Бодит эдийн засагт хүний шинийг бүтээх чадвар, зарим аж үйлдвэрийн салбарт нэвтрэх өндөр саад тотгор, томоохон хэмжээний үйл ажиллагаанаас олж авах үр ашигт байдал болон бусад хүчин зүйлүүд нийлээд, төгс өрсөлдөөнийг янз бүрийн арга замаар сулруулдаг. Энэ нь эдийн засгийн түрээсийг зарим компаниудад нийцүүлэн зохицуулах боловч энэ нөхцөл байдлаас хэрэглэгчид ашиг хүртэх боломжийг олгохдоо, тэдний зүгээс ямар нэгэн үүрэг хүлээхгүй юм. Олон улс оронд засгийн газрууд үүнийг хүлээн зөвшөөрч, улмаар тэд монополын эсрэг эсрэг хуулиуд болон өрсөлдөөний тухай бодлогоороо дамжуулан өрсөлдөөнийг хамгаалахыг эрэлхийлдэг байна. Ихэнх эдийн засгууд олон улсын шинж чанартай болж байгаа ба үүнд худалдааны бодлогыг хэрэгжүүлэх засгийн газрын арга барил нь, жишээ нь, гадаадын аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн бараа бүтээгдэхүүнүүдийг өөрийн зах зээл дээрээ ямар цар хүрээнд өрсөлдөхийг нь зөвшөөрөх талаар үнэлэлт дүгнэлт өгөх болсон, тэгснээрээ энэ нь зах зээл дээр нь давамгайлж буй өрсөлдөөний түвшинг тогтооход чухал ач холбогдолтой байж болох юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
258	Competition law	<p>Өрсөлдөөний тухай хууль. Гол төлөв монополын эсрэг хууль гэдэг нэрээрээ илүү танигдсан. Хууль дүрэм журмуудын багц бөгөөд нэг талаараа байгалийн нөөц баялгийг илүү үр дүнтэй хуваарилах замаар, үндэсний эдийн засагт өрсөлдөхүйц орчныг тэтгэж дэмжихийн тулд боловсруулсан байдаг. Ихэнх улс орнуудын өрсөлдөөний тухай хууль нь аж ахуйн нэгжүүдийн үндсэн дөрвөн бүлгийн зан үйл, ажил хэрэгтэй тулж ажилладаг: (a) хэвтээ тэнхлэг дагуу зохицуулалт (үнийг тогтоож мөн хянахын тулд гол төлөв аж ахуйн нэгжүүдийн хооронд тохиролцсон зохицуулалтууд), (b) босоо тэнхлэгийн зохицуулалт (үүнд онцгой арилжаа, [анхны үнийг] дахин худалдаалах үнийг тогтоох, үйл ажиллагааны газарзүйн хязгаарлалт, холбоотой хэлцэл), (c) зах зээлийн эрх мэдлийг монополууд болон томоохон аж ахуй нэгжүүд буруугаар ашиглах, (d) зах зээлийн нийт өрсөлдөөний нөхцөлийг дордуулахгүй байлгахын тулд аж ахуйн нэгжүүдийн нэгтгэл, худалдан авалтыг (mergers and acquisitions) хянах зэрэг болно. Хөндлөн болон босоо тэнхлэгийн хүрээнд хийж буй хязгаарлалтын үйл ажиллагаа болон үүнтэй холбоотой хууль сахиулахыг ёс зүйн зан үйлийн бодлогууд гэж нэрлэх нь бий. Компани, аж ахуйн нэгжүүдийн нэгдэх асуудалтай холбоотой ажиллаж буй нэгнүүдийг бүтэц тогтолцооны бодлого гэж нэрлэх нь бий. Эдгээр асуудлыг хамарсан дүрмийг заримдаа өрсөлдөөний явцуу бодлого гэж тодорхойлдог. Дөрвөн хувьсагч нь өрсөлдөөний тухай хуулийн харьцангуй хүч чадал, сул байдалд нөлөөлдөг. Үүнд: (a) төрийн хуулийн этгээд болон төрийн эзэмшлийн аж ахуйн нэгжүүд эсвэл хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зүгээс үйлдэж буй, төрөөс дэмжсэн эсвэл төрөөс хориглосон үйл ажиллагаанд нь [уг хуулийг] хэрэглэж байгаа цар хүрээ, (b) бизнесийн тодорхой практик арга ажиллагаа, зохицуулалтыг засаглах үндсэн дүрмүүд, (c) салбарын хамрах цар хүрээ, (d) хууль сахиулах</p>
259	Competition policy	<p>Өрсөлдөөний бодлого. Энэ нь өрсөлдөөнийг сурталчлан таниулах, хамгаалах засгийн газрын хандлага, арга замыг илүү өргөн хүрээнд тайлбарласан болно. Энэ нь ижил төстэй зорилгод хүрэх өрсөлдөөний тухай холбогдох хууль, бодлогуудаас бүрдэнэ. 1980-аад оноос хойш “өрсөлдөөний бодлого” хэмээх нэр томьёо нь үйлдвэржилтийг түшиглэсэн эдийн засагтай орнуудад өргөн цар хүрээтэй өргөжиж эхэлсэн бөгөөд одоо өрсөлдөөний өргөн хүрээг хамарсан бодлого гэж нэрлэгддэг, арилжааны бус салбаруудыг өрсөлдөөнд нээж өгснөөр үүссэн нийгмийн хангамжийг сайжруулах нөлөөлөлтэй мөн холбоотой байж магадгүй юм. Үүнд нэгэн цагт анхнаасаа хүн бүрийн мэдэх монопол байсан хий, хэрэглээний ус, цахилгаан зэрэг ахуйн хэрэглээнүүд орсон байна. Өрсөлдөөний бодлогыг ихэвчлэн хэрэглэгчийн ашиг сонирхлыг сурталчлан таниулах бодлого гэж хардаг бөгөөд ялангуяа худалдааны хохирлыг арилгах тохиолдолд үргэлж үйлдвэрлэгч талын эрх ашигт нийцүүлэх хандлагатай байдаг худалдааны бодлоготой харьцуулж үзсэн байдаг. Мөн Монополын эсрэг хуулийг (antitrust laws) болон өрсөлдөөний хууль (competition law) үзнэ үү.</p>

Өрсөлдөөний бодлого болон демпингийн эсрэг арга хэмжээ. Энэ нь худалдааны нэгэн шинэ асуудал болоод байгаа, худалдаа болон өрсөлдөөнтэй холбоотой олон талт худалдааны дүрэм журмуудыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзэж байгаа асуудлуудын нэг. Демпингийн эсрэг хууль, өрсөлдөөн эсвэл монополын эсрэг хуулиудыг засгийн газар нэгэн зэрэг хэрэгжүүлэх засаглалын хооронд үндсэн зөрчил үүсдэг гэсэн ойлголт бүхий байр суурь байдаг. Худалдааны бодлого нь, үнийн өсөлтийг бий болгосноор нэмэлт ашиг олох боломжийг олгодог демпингийн эсрэг арга хэмжээнүүдээр дамжуулан, дотоодын үйлдвэрлэгчдэд ашиг тусаа өгөх болно гэсэн таамаглал дээр зарим талаараа суурилсан болно. Демпингийн эсрэг татвар ногдуулалтаас зайлсхийхийн тулд, үнэ тогтоох үйл ажиллагаа явуулдаг экспортлогчид ийм арга замаар мөн эдийн засгийн түрээс (нөөц эх үүсвэрийг {жишээ нь, газар, капитал, хөдөлмөр} одоо цагт ашигласны ачаар олж авсан нэмэлт орлого ашиг) олж авах боломжтой. Ийм өрсөлдөөний үйлдэл нь худалдааны бодлогын хүрээнд хууль ёсны боловч өрсөлдөөний бодлогын хүрээнд хууль бус гэж маргаж байгаа юм. Өөр нэг зөрчил нь, демпингийн эсрэг хууль нь дотоодын үйлдвэрлэгчид болон бараа бүтээгдэхүүн борлуулагчдыг хамгаалах зорилготой, харин өрсөлдөөний тухай хууль нь хэрэглэгч, импортлогчдыг хамгаалах зорилготой гэсэн үндсэн зарчмаас үүдэлтэй гэж үзэж байна. Энэ нь үнэндээ демпингийн эсрэг хууль нь юунд хүрэх вэ гэж асуухад хүргэдэг. Демпингтэй тэмцэх анхны хуулиудын зарим нь түрэмгийгээр үнэ тогтоох (predatory pricing) үйлдлүүдтэй тулж ажиллах зорилготой байсан ба өрсөлдөөний тухай олон хуулиуд нь өрсөлдөөний эсрэг үйлдлийг хориглосон байдаг. Гэвч өнөөгийн демпингийн эсрэг хуулиудад ийм сэдэл байхаа больсон. Тэднийг шударга худалдааг сурталчлах хэрэгсэл гэж үздэг бөгөөд ихэвчлэн түвшин тогтоох тоглоомын талбар гэсэн утгаар үздэг. Иймээс тэдний зорилго нь өрсөлдөөний тухай хуулиас эрс өөр. Энэ нь шийдвэрлэх шаардлагатай зөрчил хэвээр байна. Демпингийн эсрэг арга хэмжээ авснаар өөрсдийгөө сул талтай болсон гэж үздэг улс орнууд болон аж үйлдвэрийн салбарууд, тийм арга хэмжээнүүдийг хариу арга хэмжээ авах үндэслэл болсон (actionable) өрсөлдөөний тухай хуулиар орлуулснаараа, үр ашиг хүртэх боломжтой гэж үзэх хандлагатай байдаг. Энэ нь ANZCERTA-ийн хүрээнд Австрали, Шинэ Зеланд улсуудын хооронд, Европын хамтын нийгэмлэгийн гишүүд болон Европын эдийн засгийн бүсийн хооронд хийгдэж байдаг худалдаанд аль хэдийнээ тохиолдоод байгаа. Гэвч эдгээр нь онцгой тохиолдлууд бөгөөд үндэслэлийг нь олон жилийн турш маш хянамгайгаар бодож бэлдсэн. Энэхүү зорилгод хүрэхийн тулд өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэх болон тэдгээрийг зохих ёсоор хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай гэдэг тал дээр шинжээчид өргөн хүрээнд санал нэгдэж байна. Худалдааны салбарын өргөн хүрээний оролцогчдын хувьд үүсээд буй асуудал бол өрсөлдөөний олон төрөл болон хууль сахиулахын маш олон тогтолцоонууд байгаагаар зогсохгүй, мөн дээр нь нэмээд олон хөгжиж буй улс орнуудын хувьд өрсөлдөөний ямар ч тогтолцоо байхгүй эсвэл сайн хөгжөөгүй өрсөлдөөний тогтолцоотой байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
261	Competitive advantage	<p>Өрсөлдөх чадварын давуу тал. Майкл Портерын Улс орнуудын өрсөлдөх чадварын давуу талын онол болон бусад зохиогчдын аж үйлдвэрийн хөгжлийн талаарх онол (contentious theory). Онолын гарал үүсэл нь эдийн засагч Альфред Маршалл (1842-1924) руу эргэж хандах болдог. Аж ахуйн нэгж эсвэл салбарын амжилтыг харьцангуй стандартчилагдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртгийн давуу тал эсвэл ялгаатай бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэхтэй холбоотой бүтээгдэхүүнд түшиглэсэн давуу тал дээр суурилдаг гэж заасан байдаг. Өрсөлдөөний давуу тал бүхий компаниуд ихэвчлэн газарзүйн хувьд төвлөрсөн байдаг бөгөөд энэ нь холбогдох ур чадвар бүхий боловсон хүчнийг хөгжүүлэхэд тусалдаг. Энэхүү онолын шүүмжлэгчид, дэвшилтэт орнуудын өндөр технологийн фирмүүдэд онцгой ач холбогдол өгснөөрөө, харьцуулсан зардлын ач холбогдлыг үнэгүйдүүлж чадсанаараа, өндөр технологийн аж үйлдвэрийн салбаруудынхаа анхан шатны хөгжлийг хөгжүүлэх зорилгоор боловсруулсан, улсын төсвийн зарцуулалт болон хамгаалалтын бодлогодоо хууль ёсны байдлыг олгож байгааг харуулж байна гэж мэдэгдсэн байдаг. Мөн харьцангуй давуу тал (comparative advantage) болон худалдааны стратегийн онолыг (strategic trade theory) үзнэ үү.</p>
262	Competitive-need limitation	<p>Өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалт. Энэ нь АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий системтэй холбоотой ойлголт. Хэрэв тухайн хуанлийн жилд АНУ-аас ашиг хүртэгч улсаас импортолсон бүтээгдэхүүний импорт нь АНУ-ын тухайн бүтээгдэхүүний импортынх 50%-иас илүү хувийг эзэлж байгаа бол уг экспортлогч улсын хувьд тухайн бүтээгдэхүүн дээрээ үр ашиг хүртэж байх эрх нь цуцлагддаг байна. Үүнтэй ижлээр, тухайн улсын хувьд АНУ-руу экспортолдог тухайн бүтээгдэхүүний хувь хэмжээ нь тодорхой заасан үнийн дүнгээс давахын цагт, хүртэх үр ашиг нь мөн цуцлагдах болно. Тодорхойлсон утга жилээс жилд өөрчлөгдөж байдаг. Өрсөлдөх чадварын хэрэгцээний хязгаарлалтыг тодорхой нөхцөлд, ялангуяа хэрэв экспортлогч орон АНУ-ын бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнд боломжийн түвшинд нэвтрэх эрх олговол эсвэл уг орон АНУ-ын өмчилдөг оюуны өмчийн эрхүүдийг зохистой түвшинд хамгаалах санал тавьсан тохиолдолд, татгалзуулж болдог. Олон нэн буурай хөгжилтэй орнууд автоматаар үүрэг амлалтаас чөлөөлөгдөх (waivers) боломжийг эдэлж байдаг. Мөн Хөнгөлөлтийг аажмаар дуусгавар болгох (graduation) үзнэ үү.</p>
263	Competitiveness	<p>Өрсөлдөх чадвар. Бусад аж ахуйн нэгж, салбар эсвэл улс орнуудтай харьцуулахад, тухайн аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн салбар, улс орны хувьд эдийн засгийн үр ашгаа хадгалж эзэмших чадвар. Засгийн газрууд заримдаа экспортыг зорилго болгох, татаас олгох, хамгаалалтын эсвэл бусад арга хэрэгслийг ашиглан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг хичээдэг. Үүнийг зөвхөн эдийн засгийн бусад үлдсэн хэсгүүдийнх нь зардлаар хийх боломжтой бөгөөд тийм арга туршлагын урт хугацааны үр нөлөө нь эдийн засгийн нийт өрсөлдөх чадварыг бууруулахад хүргэдэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
264	Competitive neutrality	Төвийг сахисан өрсөлдөхүйц байдал. Энэхүү үзэл баримтлал нь хувийн хэвшлийн салбарын компани, аж ахуйн нэгжүүд болон үнийн хувьд төрийн зохицуулалтыг нь халсан төрийн монопол аж ахуйн нэгжүүдийн хоорондын өрсөлдөөний мөн чанарыг судлах, удирдахтай холбоотой үзэл баримтлал. Өрсөлдөөнийг төвийг сахих шаардлага нь, зах зээлд нэвтрэхэд тулгарч буй саад тотгорыг арилгаж, засгийн газрын монополийг эцэс болгон дуусгах нь, тухайн салбарт жинхэнэ өрсөлдөөнийг бий болгоход хангалтгүй байж болох юм. Ийм нөхцөлд давуу тал нь өмнө нь засгийн газрын монопол эсвэл түүний нэг хэсэг байсан аж ахуйн нэгжид байсаар байх болно. Уг хохирлыг нөхөх арга нь ихэвчлэн өрсөлдөөнийг дэмждэг зохицуулалтын зарим нэгэн хэлбэр. Мөн үнийн хувьд төрийн зохицуулалтыг халах (deregulation) болон төрийн зохицуулалтыг дахин нэвтрүүлэх (re-regulation) үзнэ үү.
265	Composition of trade	Худалдааны бүтэц, бүрэлдэхүүн. Энэ нь голдуу, тухайн улсаас ямар төрлийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг импортлож бас экспортолдог болохыг харуулдаг, тухайн улсын худалдааг бүтээгдэхүүний ангиллын дагуу гаргадаг статистик дүн шинжилгээ.
266	Compound tariff	Хосолсон тариф. Барааны үнийн дүнгээс хувиар (ad valorem) болон барааны нэгжид мөнгөн илэрхийллээр (specific) тооцох тарифыг хослуулан хэрэглэх тарифын хэлбэр. Жишээ нь компакт диск бүрд нэг долларын (specific) гаалийн татвар авахаас гадна, нэмээд үнийн дүнгээс 10%-ийн (ad valorem) татвар ногдуулсан байж болно.
267	Compulsory licensing	Лицензийг албадан олгох/албадан лиценз. Энэ нь, холбогдох оюуны өмчийг агуулсан бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг гадаад улсын компаниуд, эсвэл заримдаа тухайн улсын засгийн газарт эдгээр оюуны өмчийн эрхүүдийг ашиглуулах эрхийг уг оюуны өмчийн эрхийг эзэмшигчээс шаардах практик арга туршлага. Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийн 31-р Зүйлд үүнийг хийж болох хамрах хүрээг тусгасан байдаг. Хамгийн чухал нь, лиценз буюу зөвшөөрлийг албадан олгох үйл ажиллагааг зөвхөн, хэрэв оюуны өмчийг боломжийн арилжааны нөхцөлөөр ашиглах эрхийг олж авах хүчин чармайлт нь амжилтгүй болсон нөхцөлд л хэрэгжүүлж болно. Мөн технологийн албадан дамжуулалтыг (forced technology transfer) үзнэ үү.
268	Computed value	Тооцоолсон/Тооцооны үнэ. Ямар нэгэн найдвартай үнийн мэдээлэл байхгүй бол Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 7-р Зүйлийг (Гаалийн үнэлгээний хэлэлцээр) хэрэгжүүлэх ДХБ-ын хэлэлцээрийн дагуу зөвшөөрсөн, гаалийн үнэлгээний аргачлалуудын нэг хэсэг. Тооцоолсон үнийн утга нь, (a) материалын өртөг буюу тэдгээрийг боловсруулах үнэ, (b) ашиг болон ердийн зардлуудын хэвийн хэмжээ, (c) зардал эсвэл тээвэр, боомт ашиглалт, хураамж, даатгалууд зэрэг бүх шаардлагатай зардлуудын үнийн дүнгийн нийлбэр дүнгээс бүрддэг.
269	Concealed dumping	Нуугдмал демпинг. Мөн нууц демпингийг (hidden dumping) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
270	Concerted liberalisation action	Либералчлалын нэгдсэн арга хэмжээ. Заримдаа нэг талыг баримталсан нэгдсэн зарчим гэж нэрлэдэг. Богорын тунхаглалд заасны дагуу 2010/2020 он хүртэл чөлөөт, нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалтын зорилтыг биелүүлэхэд АПЕК-ийн орнуудын ашигладаг үндсэн арга. Харин ДХБ-ын либералчлал нь гарсан хүсэлт саналд үндэслэсэн байдаг бол, АПЕК-ийн гишүүдийн хувьд, худалдаа, хөрөнгө оруулалтыг харьцуулж үзэх ажиглалтын замаар, худалдаа ба хөрөнгө оруулалтын хооронд бараг тэнцүү ахиц гарч байх нөхцөлд тулгуурлан, иж бүрэн цогц зарчимд нь заасны дагуу бүх салбар нь либералчлалд хамрагдсан үед л, тэд худалдаа ба хөрөнгө оруулалтаа либералчлах болно гэсэн зарчмаар явагддаг байна. Мөн АПЕК, АПЕК-ийн бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтын ажиллагааны арга хэмжээ, Осакагийн үйл ажиллагааны хөтөлбөрийг үзнэ үү.
271	Concerted unilateralism	Нэгдсэн байдлаар нэг талыг баримталсан харилцааны онол. Мөн тохиролцсон либералчлалын үйл ажиллагааг үзнэ үү.
272	Concession	Буулт, хөнгөлөлт. ДХБ-д ашигладаг нэр томьёо. Өөрөөр хэлбэл, ДХБ-ын гишүүн улс хүсэлт тавьсны дагуу, тарифын хувь хэмжээг бууруулах эсвэл үйлчилгээний худалдаанд учирч буй саад тотгорыг арилгах тухай асуудал. Хамгийн энгийн утгаар бол, гишүүдийн тохиролцсон түвшингээс дээш нэмэгдүүлэхгүй гэсэн үүрэг амлалт хүлээх буюу энэ нь тарифын дээд хязгаарыг тогтоосон зүйлсийг л (binding of a tariff item) хамарна. Зарим тайлбарлагчид энэ нэр томьёог, тарифын түвшинг бууруулснаар улс орнууд золиос хийж байгаа бөгөөд худалдааг либералчлах нь эдийн засагт ихээхэн зардал учруулах болно гэсэн хуурамч сэтгэгдлийг арилгах амлалтаар солих хэрэгтэй гэж зөвлөсөн байна. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATS) үүрэг амлалтуудыг аль хэдийнээ хамруулчихсан байдаг. Мөн хүсэлт ба санал болгох (requests and offers), үйлчилгээний салбарт авсан үүрэг амлалтын жагсаалт (schedules of commitments on services), [тарифын] хөнгөлөлт, буултын жагсаалтыг (schedules of concessions) үзнэ үү.
273	Conditional most-favoured-nation treatment	Нөхцөл заасан үндэсний нэн тааламжтай нөхцөл. Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) олгох нь түүнийг хүлээн авч байгаа улсын хувьд биелүүлэх зарим нөхцөлүүдээс хамаарна. Жишээлбэл, ДХБ-ын Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр байлаа гэхэд, засгийн газрын худалдан авалтуудад олгох Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг зөвхөн уг хэлэлцээрт орсон бусад гишүүн улсуудад л сунгах боломжтой. Тэгэхээр хэлэлцээрт орно гэдэг нь тийм нөхцөлүүдийг “хүлээн зөвшөөрөх ёстой” болж магадгүй гэсэн үг. Зарим тохиолдлуудад, тухайн улс нь хэрэв худалдаатай холбогдолгүй зарим нөхцөлүүдийг биелүүлсэн тохиолдолд л нөгөө гишүүн улсдаа Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг олгохоор шийдвэр гаргадаг байна. Яг ийм нөхцөл байдал АНУ-ын Конгресс 1974 оны Худалдааны тухай хуульд Жексон-Ваникийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж баталсан үед үүссэн байдаг ба үүнд либерал цагаачлалын бодлого явуулж байгаа улсуудад л Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг олгохоор хязгаарласан байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүнийг ЗСБНХУ-ын эсрэг ашигласан бөгөөд АНУ нь Хятад улс дах хүний эрхийн асуудалтай холбогдуулан ашигласан байдаг. Мэдээж хэрэг, АНУ нь тухайн үед хараахан ДХБ-ын гишүүн болоогүй байсан Хятад улсад Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) олгох ямар ч хууль ёсны үүрэг хариуцлага хүлээгээгүй байна.</p>
274	Conditional national treatment	<p>Нөхцөл заасан үндэсний нөхцөл. Гадаадын хуулийн этгээдийн өмчилдөг аж ахуйн нэгжүүд, ялангуяа тэдний худалдаа ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ялгаварлан гадуурхаж хандах нөхцөл. Жишээ нь, дотоодын хуулийн этгээдийн өмчлөлтэй аж ахуйн нэгжид хэрэглэгддэггүй гүйцэтгэлийн шаардлагууд, харилцан адил ашигтай байх нөхцөлүүд эсвэл дотоодын агуулгатай байх шаардлагуудыг даган мөрдөх хэрэгтэй болдог. Мөн үндэсний нөхцөлийг (national treatment) үзнэ үү.</p>
275	Conditional offers	<p>Нөхцөл заасан санал. Худалдааны хэлэлцээний үеэр гаргаж тавьсан саналууд нь бусад оролцогчид мөн ижил хэмжээний үнэ цэнэ бүхий санал тавих байх гэсэн хүлээлт, эсхүл өөрийнх нь тавьж байгаа санал хэлэлцээний ширээн дээр аль хэдийнээ гарган тавьсан саналуудтай таарна гэж үзсэнээс болсон байдаг. Яриа хэлэлцээ ерөнхийдөө шийдэлд хүртэл, энэхүү нөхцөл заасан саналуудыг буцаан татаж эсвэл өөрчилж болно.</p>
276	Conformity assessment	<p>Тохирлын үнэлгээ. Үүнд дээж авах журам, сорил ба хяналт шинжилгээ; тохирлыг нотолж баталгаажуулах; бүртгэл, итгэмжлэх, зөвшөөрөл олгох зэрэг асуудлууд багтдаг. ДХБ-ын Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээрт Стандартуудыг бэлтгэх, батлах, хэрэглэхтэй холбоотой Зохистой дадлын төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн актыг зааж өгсөн байдаг ба үүнийг төрийн болон төрийн бус байгууллагууд техникийн зохицуулалт хийх, ашиглахад хэрэглэх ёстой байдаг. Үүнд, бүтээгдэхүүнүүд улсын стандартад нийцсэн эсэх байдлыг тогтоох журам нь, ялангуяа дотоодын болон харьцуулж болохуйц импортын бүтээгдэхүүнүүд оролцсон тохиолдолд, шударга ба тэгш байхыг шаарддаг. Мөн Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission), Олон улсын стандартчиллын байгууллага (International Organisation for Standardisation) зэргийг үзнэ үү.</p>
277	Consensus	<p>Зөвшилцөл, тохиролцоо, нэгдмэл санал. ДХБ-ын хүрээнд шийдвэр гаргах ердийн арга. Албан ёсны санал хураах заалт байдаг боловч ийм санал нь ховор байдаг, эсхүл зөвшилцөлд аль хэдийнээ хүрсэн тохиолдолд л санал авдаг. Зөвшилцөлд тулгуурлаж гарсан шийдвэр нь дүрэм журмыг өөр өөрөөр ойлгосноос үүсэх маргааныг багасгадаг. Зөвшилцлийг эрэлхийлэх нь хэлэлцээний хугацааг нэмэгдүүлж, хөлд чирэгдэгсдийн улмаас хоцроож, саатал үүсгэж болзошгүй. Мөн цуваанд дагалдан яваа [гишүүний] асуудал (convoу problem) болон ДХБ-ын түвшинд шийдвэр гаргах (decision-making in the WTO) асуудлыг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
278	Constructed value	<p>Тооцоолж гаргасан өртөг/тооцооны өртөг. Экспортлогч улс дах уг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг тооцоолох зорилгоор, ихэвчлэн Демпингийн эсрэг арга хэмжээний хэлэлцээр буюу Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6-р Зүйлийг хэрэгжүүлэх тухай ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд хэрэглэх боломжтой байдаг арга хэрэгсэл. Энэхүү арга хэрэгслийг зөвхөн экспортын үнэ огт байхгүй, эсхүл сунгасан гарын зарчмаар тооцсон бодит үнэ (arm's-length pricing)-тэй холбоотой эргэлзээ байгаа учраас найдваргүй үнэ гэж үзсэн тохиолдолд л ашиглах боломжтой. Үүнийг зах зээлийн эдийн засагт байнга хэрэглэдэггүй.</p> <p>Үнийн харьцуулалт хийх улс (analogue country), демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), хэвийн үнийг (normal value) үзнэ үү.</p>
279	Consular formalities	<p>Консулын ёс журам. Зарим улсад бараа бүтээгдэхүүн экспортолж буй аж ахуйн нэгжүүд нь, нэхэмжлэх, гарал үүслийн гэрчилгээ, тээвэрлэлтийн манифест болон бусад баримт бичгийг импортлогч орны консулын төлөөлөгчийн зөвшөөрөлтэйгөөр авах шаардлага. Ачуулсан барааны үнийн дүнтэй ихэнхдээ холбоотой байдаг хураамжийг төлсөн нөхцөлд уг нотолгоог гаргаж өгдөг байна. Хураамжийн бүтэц, хүнд суртлын улмаас хойшлуулах асуудал, горим журам зэрэг нь олон улсын худалдааны харилцаанд олон удаа тохиолдох болсон залхмаар хүчин зүйл болсон байна. Үүнээс гадна, худалдааны биет хэмжээ өргөжиж байгаа нь энэхүү журмыг боломжгүй болгосон. Ихэнх улс орнууд одоо консулын албан журмыг цуцалж, бусад оронд энэ нь хуучирсан байдал болж хувирчээ. Мөн ачилтын өмнөх хяналт шалгалтыг (preshipment inspection) үзнэ үү.</p>
280	Consultation	<p>Зөвлөгөөн. ДХБ-ын маргаан шийдвэрлэх журмын эхний үе шат ба асуудлыг хамтын ажиллагааны зарчмаар шийдвэрлэх, заримдаа сайн дурын үйлчилгээ үзүүлэх (good offices) эсвэл ашиг сонирхолгүй талын дундын зуучлалаар шийдвэрлэхэд чиглэгддэг. Талууд хоорондын зөвлөгөөний хувьд факт/үйл баримтыг олж тогтоох үндсэн шинж чанар нь ихэвчлэн зөвшилцсөн шийдэлд хүргэдэг. Хэрэв зөвлөгөөн нь хүсэлт гарснаас хойш жаран хоногийн дотор маргааныг шийдвэрлэж чадахгүй бол, гомдол гаргагч тал маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг байгуулах хүсэлт гаргаж болно. Талууд зөвлөлдөх уулзалтаар маргааныг шийдвэрлэж чадахгүй гэж дүгнэвэл маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэгт урьдчилаад очиж болно. Тийм учраас тийм зөвлөлдөх уулзалт хүссэн хүсэлтийг хүлээж авсан ДХБ-ын гишүүд тэдэнтэй нухацтай хандах ёстой бөгөөд илүү урт хугацаанд амьсгаа авах шалтаг болгон ашиглаж болохгүй. Мөн Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг (WTO understanding on dispute settlement) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
281	Consultative Group of Eighteen	Зөвлөлдөх арван найм хүний бүлэг (CG-18). Энэ нь өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудыг өргөн хүрээнд төлөөлж, арван найман хүний бүрэлдэхүүнтэйгээр 1975 оны 7-р сарын 11-ний өдөр байгуулагдсан ТХЕХ-ийн албан бус механизм. Эхэндээ үүнийг гишүүдийн нэг нь даргалж байсан боловч 1979 онд ТХЕХ-ийн Ерөнхий захирал хамаарах болсон. Зөвлөлдөх арван наймын бүлэг нь олонд танигдахдаа ихэвчлэн, ТХЕХ-ийн гишүүнчлэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор, хүндрэл учруулж болзошгүй худалдааны асуудлыг эрт үед нь хэлэлцүүлэх замаар үүргээ гүйцэтгэж байсан. Үүнд шийдвэр гаргах үүрэг хариуцлага байдаггүй байв. Гишүүнчлэл нь үе үе ээлжлэн өөрчлөгдөх ёстой байсан боловч практик амьдрал дээр, эхний ээлжийн хуудсыг зөвшөөрсний дараа ямар нэгэн хөдөлгөөн бараг байдаггүй байв. Үүний оронд, уулзалтад ээлж дараалан орохыг хүлээн зөвшөөрсөн заншил үүссэн. CG-18 нь Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр эзэн нь олдохгүй тодорхой бус байдалд орсон байдаг. Энэ нь өөрчлөгдөөгүй боловч ДХБ-д ижил төстэй байгууллагатай болох хүсэлт гарсаар байна. ДХБ-ын сүүлийн үеийн Үл үзэгдэх зөвлөлдөх механизмын (Invisibles Group for a more recent consultative mechanism) талаар үзнэ үү.
282	Consumer subsidy equivalent	Эцсийн хэрэглэгчид олгосон татаастай дүйцэхүйц хэмжээ. Үүнийг CSE хэмээн товчилдог ба хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөрүүдийг халсны улмаас үүдэх үр нөлөөг нөхөхийн тулд эцсийн хэрэглэгчдэд төлөх ёстой хэмжээ хэмээн тодорхойлдог. Энэ нь эцсийн хэрэглэгчдийн хүлээн авсан шилжүүлгийн нийт үнийн дүнг, тухайн бүтээгдэхүүнд зориулж хэрэглэгчийн зарцуулсан нийт зарлагатай харьцуулсан харьцааг хувиар илэрхийлсэн хэмжээ. Эцсийн хэрэглэгч цэвэр тусламж авах үед, CSE-үүд нь эерэг дүнтэй байдаг. Хэрэв тэр дүн нь сөрөг байвал эцсийн хэрэглэгчид татвар ногдуулдаг. Үйлдвэрлэгчид олгосон татаасны тэнцлийг (producer subsidy equivalent) мөн үзнэ үү.
283	Contact points	Харилцаж, лавлагаа авах нэгж. Мөн лавлагаа авах нэгжийг (enquiry points) үзнэ үү.
284	Contestability of markets	Зах зээлийн өрсөлдөх чадвар. Мөн Зах зээлийн олон улсад өрсөлдөх чадварыг үзнэ үү.
285	Contingent protection	Болзошгүй хамгаалалт. ДХБ-ийн хэлэлцээрийн дагуу хууль ёсны бөгөөд дотоодын аж үйлдвэрлэлд хохирол учруулж буй демпинг, татаас, импортын хэт их хэмжээний урсгалын нөлөөллийг арилгах зорилгоор эхлүүлж болох арилжааны хамгаалалтын арга механизм. Ийм механизм нь демпингийн эсрэг арга хэмжээ, татаасны хохирлыг саармагжуулан тэгшитгэх татвар, хамгаалалтын арга хэмжээг агуулдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
286	Continuation clause	<p>Үргэлжлүүлэх тухай заалт. Хөдөө аж ахуйн талаарх ДХБ-ын хэлэлцээрийн 20-р Зүйлд тусгасан уг зүйл заалт нь хөдөө аж ахуйн талаар олон талт хэлэлцээрийг, тохиролцсон хэрэгжүүлэлтийн хугацааг дуусахаас нэг жилийн өмнө, буюу 2000 оны 1-р сарын 1-нд эхлүүлэхийг уриалав. Үргэлжлүүлэх зүйл заалтын урт хугацааны зорилго бол дэмжлэг болон хамгаалалтын арга хэмжээг эрс багасгах явдал. Хэлэлцээрийг дахин үргэлжлүүлэхдээ (a) дэмжлэг болон хамгаалалтыг бууруулах амлалтыг тухайн цаг үе хүртэл хэрэгжүүлэх хүртэлх өмнөх туршлага, (b) хөдөө аж ахуйн дэлхийн худалдааны хүрээнд дэмжлэг болон хамгаалалтыг бууруулах амлалт авсны үр нөлөө, худалдааны бус холбогдох асуудлууд, хөгжиж буй улс орнуудад олгох тусгай ба ялгавартай нөхцөл, (c) шударга, зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн худалдааны тогтолцоог бий болгох зорилт, (d) урт хугацааны зорилтоо хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад зорилтууд. Мөн ДХБ-ын салшгүй хэсэг болсон хэлэлцэх асуудлыг (WTO built-in agenda) мөн үзнэ үү.</p>
287	Continued Dumping and Subsidy Offset Act of 2000	<p>Демпинг болон татаасны хохирлыг үргэлжлүүлэн барагдуулах тухай 2000 оны хууль. Мөн Бирдийн нэмэлт өөрчлөлтийг (Byrd Amendment) үзнэ үү.</p>
288	Contraband	<p>Контрабанд (хууль бусаар хил давуулах наймаа). Энэ нь дайны үед дайсны цэргийн үйл ажиллагаанд туслахад ашиглагдах боломжтой, төвийг сахисан гэх ачааг хэлдэг. Контрабандад хамаарах дүрэм журам нь үргэлж уян хатан байсан бөгөөд тухайн газар дээр нь тайлбарлах ёстой болдог боловч зарчмын хувьд, энхийн цагийн түүхий эд, бараа материал гэж үзэх саатуулагдсан бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхийг зөвшөөрөх боловч, дайны материалыг зогсоож болно. Контрабандын талаарх дүрэм журмыг боловсруулах болон удирдах нь үргэлж хүндрэлтэй байсан, учир нь олон бараа бүтээгдэхүүн болон түүхий эд материал нь нэг бол иргэний эсвэл цэрэг армийн зориулалттай бараа бүтээгдэхүүн байж болдог. Түгээмэл хэл ярианд контрабанд гэж үргэлж хэрэглэгддэг боловч, хууль бус наймаа эсвэл хууль бус бараа гэдэг нь илүү зохистой нэр томьёо. Мөн давхар хэрэглээтэй экспортын [бараа бүтээгдэхүүнийг] (dual-use exports) үзнэ үү.</p>
289	Contracting party	<p>Хэлэлцэн тохиролцогч тал (Уругвай). 1947 оны ТХЕХ-ийн гишүүдэд зориулсан албан ёсны нэр томьёо. Хэлэлцэн тохиролцогч талууд шийдвэр гаргахаар хамтарч ажиллах үед, ТХЕХ-ийн баримт бичгүүдэд үүнийг том үсгээр тэмдэглэсэн байна (ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОГЧ ТАЛУУД). ТХЕХ-ийг хэлэлцэн тохиролцогч талууд нь одоо ДХБ-ын гишүүд болжээ.</p>
290	Conventional tariff	<p>Уламжлалт тогтсон тариф. Олон улсын конвенц, эсхүл хэлэлцээрүүдийн дагуу хийгдсэн, хэлэлцээний үр дүн болсон тариф. Мөн Тарифын дээд ба доод түвшинг (maximum-minimum tariff) үзнэ үү.</p>
291	Convention of Stockholm	<p>Стокгольмын конвенц. Мөн Европын чөлөөт худалдааны холбоог (EFTA) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
292	Convention on Biological Diversity	Биологийн олон янз байдлын тухай конвенц. Энэ нь 1992 оны 6-р сарын 5-нд байгуулагдсан ба 1993 оны 12-р сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Үүний зорилтууд нь биологийн олон янз байдлыг хамгаалахаас гадна, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтвортойгоор ашиглаж, генетикийн нөөц сангийн хэрэглээнээс үүдэх үр ашгийг тэгш хүртэх асуудал. Үүнд генетикийн нөөц сангийн зохих түвшний хүртээмж мөн холбогдох технологиудыг шилжүүлэхтэй холбоотой зүйл заалтуудыг агуулсан байдаг. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
293	Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions	Олон улсын бизнесийн хэлцлүүд дэх Гадаадын төрийн албан хаагчдын авлига, хээл хахуультай тэмцэх тухай конвенц. Энэ нь 1999 оны 2-р сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Үүнд ЭЗХАХБ-ын бүх 29 улс, түүнчлэн Аргентин, Бразил, Болгар, Чили, Словак улсууд гарын үсэг зурсан. Энэхүү конвенц нь бизнесийн хэлцлийг баталгаажуулахын тулд гадаадын төрийн албан тушаалтанд хээл хахууль санал болгох, амлах эсвэл хээл хахууль өгөхийг гэмт хэрэгт тооцдог. Үүнээс тусдаа, ЭЗХАХБ-ын гишүүд хээл хахуулийн төлбөрийн татварын хасалтыг эцэслэхээр тохиролцсон. Мөн Хууль бус төлбөрийн тухай олон улсын хэлэлцээрийн төсөл (Draft International Agreement on Illicit Payments) болон худалдаа ба хууль бус төлбөрийг (trade and illicit payments) үзнэ үү.
294	Convention on International Civil Aviation	Олон улсын иргэний агаарын тээврийн конвенц. Мөн Чикагогийн конвенцыг (Chicago Convention) үзнэ үү.
295	Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц. Мөн CITES-ийг үзнэ үү.
296	Convention on the Law of the Sea	Далайн тухай хуулийн конвенц. Мөн НҮБ-ын Далайн тухай хуулийн конвенцыг (United Nations Convention on the Law of the Sea) үзнэ үү.
297	Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property	Соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөлийг нь шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц. Уг конвенцыг НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 1970 онд баталсан. Талууд археологи, түүхийн өмнөх үе, түүх, уран зохиол, урлаг, шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой соёлын дурсгалт зүйлсийн төрлүүд, шашин болон төрөөс шашин сүм хийдийг тусгаарлах үзлийн талаар тодорхойлдог. Тэд соёлын дурсгалт зүйлсийн хууль бус импорт, экспорт, өмчлөлийг нь шилжүүлэх явдлыг эсэргүүцэхээр шийдлээ. Соёлын дурсгалт зүйлсийн хууль бус экспортыг гэрчилгээжүүлэх тогтолцооны дагуу хийдэг.
298	Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States	Улс болон бусад улсын харьяат иргэн хоёрын хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц. Мөн Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICSID)-ыг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
299	Copyright	<p>Зохиогчийн эрх. Утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотойгоор үүсэх зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг эдлэх хувь хүн, хуулийн этгээдийн онцгой эрх. Зохиогчийн эрхийг хамгаалахад ямар нэг шалгуур хэрэглэхгүй, анх туурвисан огнооноос эрхийн хамгаалалт хийгдэнэ. Энэ нь жинхэнэ эх бүтээлээр тодорхой зүйлийг хийх онцгой эрх бөгөөд, үүнд дахин хуулбарлах, хэвлэн нийтлүүлэх, бүтээлийг олон нийтэд сурталчлах, түүнийг дасан зохицуулах арга хэмжээ авах зэрэг эрхүүд багтдаг. Зохиогчийн эрх нь уран сэтгэмж санааг өөрийг нь хамгаалдаггүй, харин зөвхөн уран сэтгэмж санааны жинхэнэ анхны илэрхийллийг нь хамгаалдаг. Утга зохиолын, драмын, хөгжмийн, урлагийн бүтээлүүдэд энэ нь ерөнхийдөө зохиолчийн амьдралын бүхий л туршид, дээр нь нэмээд тавин жил үргэлжилдэг. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), Бернийн конвенц (Berne Convention), Шударга хэрэглээний номлол (fair-use doctrine), оюуны өмчийн эрх (intellectual property rights), Зэрэгцээ эрх буюу хөршийн эрх (neighbouring rights), Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцыг (Universal Copyright Convention) үзнэ үү.</p>
300	Copyright Treaty	<p>Зохиогчийн эрхийн тухай олон улсын гэрээ. 1996 оны 12-р сарын 20-ны өдөр Дэлхийн оюуны өмчийн байгууллагын (WIPO) ивээл дор байгуулсан эрх зүйн акт. Уг хэлэлцээр нь жишээлбэл, компьютерын программ хангамжууд ба тоон мэдээлэл өгөгдлийн баазуудад (гэхдээ уг баазуудыг үйлдвэрлэхэд зориулсан материалд нь бус) зохиогчийн эрхийн хамгаалалт олгох зэрэг асуудлыг тусгах талаар Бернийн конвенцод шинэчлэлт оруулж өгсөн байдаг. Үүнд мөн зохиогчдын ашигладаг технологийн үр дүнтэй арга хэмжээнүүдийг залилан тойрч гарах оролдлогын эсрэг түрээслэх эрх, хууль ёсны хамгаалалтын асуудлуудыг хамруулсан байдаг. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), параллель буюу зэрэгцүүлэн импортлох (parallel importation) зэргийг үзнэ үү.</p>
301	Core labour standards	<p>Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ/стандарт. Энэ нь худалдаа, хөдөлмөрийн стандартыг олон улсын худалдааг сурталчлан дэмжих чиглэлээр ажилладаг байгууллагуудын ажлын хөтөлбөрт оруулах ёстой эсэх талаарх хэлэлцүүлэгтэй холбоотой үзэл баримтлал. Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагын (OECD) 1995 онд боловсруулж гаргасан хөдөлмөрийн хэм хэмжээ стандартуудын судалгаанд зөвлөснөөр бол, хөдөлмөрийн хэм хэмжээ стандартуудад дараах зүйлсийг хамруулах ёстой. Үүнд (a) эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх, (b) хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрийг устгах, (c) боолчлолын хэлбэрээр хүчээр ажиллуулах болон албадан ажиллуулахыг хориглох, (d) хөдөлмөр эрхлэлтэд, өөрөөр хэлбэл бүх ажилчдад ижил</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>тэгш хандах, харьцах эрх гэх мэтээр үл ялгаварлан хандах зэрэг асуудлуудыг хамарч байна. Тэд бүгдээрээ хүний эрхийн үндсэн хэм хэмжээ стандарт гэж тооцогддог боловч тэдгээрийг ийм байдлаар бүлэглэн авч үзсэн олон улсын нэг ч эрх зүйн акт байдаггүй. Хөдөлмөрийн хэм хэмжээ стандартуудыг Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), НҮБ-ын конвенцууд, зөвлөмжүүдэд тусгасан байдаг. Америкийн Нэгдсэн Улсын Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хууль, үзэл санаанд туссан байдаг зөвшөөрөгдөхүйц хөдөлмөрийн нөхцөлд ажиллах эрхийг (ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгийн доод хэм хэмжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, долоо хоногт ажиллах хамгийн их цаг гэх мэтийг) үндсэн стандарт гэж зарим нь үздэг байна. Мөн ядуугийн тэтгэмжээр амьдрагчдын хөдөлмөрийн тухай мэтгэлцээн (pauper-labour argument), ёроол руу уралдах тухай мэтгэлцээн (race-to-the-bottom argument), нийгмийн шинж чанартай заалт (social clause), нийгмийн чанартай демпинг (social damping), нийгмийн шинж чанартай шошгожуулалт (social labelling), нийгмийн шинж чанартай татаас (social subsidies), Ялгавартай цалингийн тухай мэтгэлцээн (wage-differential argument) зэргийг үзнэ үү.</p>
302	Core-periphery thesis	<p>Үндсэн гол хэсэг болон зах хязгаарын хэсгийн тухай магадлал. Энэ нь 1950-иад он ба 1980-аад онуудын үеэс цэцэглэж эхэлсэн, олон улсын эдийн засгийн харилцааны тухай онол. Энэхүү онолоор олон улсын эдийн засгийн систем нь эдийн засгийн хувьд өндөр хөгжсөн үндсэн гол хэсэг (өндөр хөгжсөн улс орнууд) болон харьцангуй бага хөгжсөн зах хязгаарын хэсгээс (хөгжиж буй улс орнуудаас) бүрдэх хэрэгтэй гэсэн нөхцөл тавьдаг. Мөн энэхүү онолоор бол, зах хязгаар хэсэг нь өөрсдийн бүтээгдэхүүнүүдийг ялангуяа түүхий эдийг борлуулах зах зээлийн хувьд болон шинжлэх ухаан техникийн мэдлэг, үйлдвэрлэлийн нууцын хувьд үндсэн гол хэсгээс хамааралтай байдаг гэж таамагладаг. Уг онол нь динамик хөдөлгөөнтэй гэж үздэг тул урт хугацаандаа захын хязгаар хэсэг нь шинэ үндсэн гол хэсгүүдийг өөрөө бүрдүүлж болох юм гэж үздэг. Гилпинийн (Gilpin 1987) тэмдэглэснээр бол, зах хязгаар хэсгээс илүү гэж үзэх үндсэн гол хэсгийн анхны давуу тал гэдэг нь түүний техникийн болон зохион байгуулалтын давуу байдал гэж харагддаг боловч, урт хугацаандаа түүний өрсөлдөх чадвар нь хорогдон буурдаг байна. Энэхүү үйл явц нь харьцангуй илүү өрсөлдөхүйц болсон зах хязгаар хэсэгт шинэ боломжуудыг буй болгодог байна. Тэрээр мөн уг онол нь 19-р зууны эхээр анх гарч ирэхдээ, гол хэсэг нь зах хязгаарыг хөгжүүлэх ёстой байсан гэж тэмдэглэсэн байдаг. Түүний хожуу үеийн хувилбаруудад үндсэн гол хэсэг нь зах хязгаарын хэсгийн хөгжил дэвшлийн тоормос юм гэж үзсэн байдаг. Мөн Хараат байдлын онол (dependence theory) болон Хойд-Өмнөд яриа хэлэлцээг (North-South dialogue) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
303	Corn laws	<p>Эрдэнэ шишийн тухай хууль. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах үүднээс 12-р зуунд Англид анх батлагдаж байсан багц хууль. Эдгээр хуулиудыг 1846 онд хүчингүй болгосон байдаг. 1849 онд тэдгээр хуулийг үүнтэй эн дүйцэхүйц протекционист буюу хамгаалалтын үзэл баримтлал бүхий Навигацын хуультай хамтад нь хүчингүй болгосон нь, ирэх тавь орчим жилийн хугацаанд Англи улсын худалдааны бодлогын шинж чанарыг тодорхойлох болсон либерал буюу чөлөөт тогтолцооны эхлэл ба чөлөөт худалдаачдын ялалтыг тэмдэглэсэн байдаг. Үүгээрээ мөн эдийн засгийн “шинжлэх ухааныг” бодлого боловсруулах арга хэрэгсэл болгон эцсийн байдлаар хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Мөн Кобден-Чевалиерийн хэлэлцээрийг (Cobden-Chevalier Treaty) үзнэ үү.</p>
304	Council for Mutual Economic Assistance	<p>Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл. Үүнийг гол төлөв КОМЕКОН (COMECON) гэдэг ба 1949 онд Болгар, Чехословак, Унгар, Польш, Румын, ЗХУ зэрэг улсууд гишүүд нь болж анх байгуулсан байдаг. Сүүлд нь Куба, Ардчилсан Германы Бүгд Найрамдах Улс, Монгол, Вьетнам зэрэг улсууд нэгдэв. Албани улс нь 1949-1961 онд гишүүн байсан. Югослав улс нь түнш холбоотон бүхий гишүүн байсан ба үүнд хэд хэдэн ажиглагч улсууд байв. КОМЕКОН-ийн зорилго нь гишүүн улсуудын эдийн засгийн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийг дэмжих, эдийн засаг техникийн хөгжил дэвшлийг хурдасгах, хөгжил багатай аж үйлдвэрийн салбар бүхий улс орнуудын аж үйлдвэржилтийн түвшинг дээшлүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийн зогсолтгүй өсөлт, гишүүн улс бүрийн ард иргэдийн нийгмийн хангамжийг огцом сайжруулж ажиллах явдал байв. КОМЕКОН-ыг 1991 оны 2-р сард татан буулгасан байна. Мөн шилжилтийн үеийн эдийн засаг бүхий улс орнуудыг (economies in transition) үзнэ үү.</p>
305	Council for Trade in Goods	<p>Бараа бүтээгдэхүүний худалдааны асуудал эрхэлсэн зөвлөл. ДХБ-ыг байгуулах Марракешийн хэлэлцээрийн Хавсралт 1-д багтсан бараа бүтээгдэхүүнийг зохицуулдаг, ДХБ-ын олон талт 13 хэлэлцээрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж байдаг хуулийн этгээд. Эдгээрээс хамгийн чухал нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ ба GATT). ДХБ-ын бүх гишүүд автоматаар энэхүү Зөвлөлийн гишүүн болсон байдаг.</p>
306	Council for Trade in Services	<p>Үйлчилгээний худалдааны асуудал эрхэлсэн зөвлөл. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийг (ҮХЕХ ба GATS) удирдаж байдаг хуулийн этгээд. ДХБ-ын бүх гишүүд автоматаар энэхүү Зөвлөлийн гишүүн болсон байдаг.</p>
307	Council for TRIPS	<p>Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудал эрхэлсэн зөвлөл. Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээрийг (ОӨЭХХАХ ба TRIPS) удирдаж байдаг хуулийн этгээд. Уг зөвлөлийн гол үүрэг бол уг хэлэлцээрийн үйл ажиллагаанд болон гишүүд үүнийг хэрхэн баримталж байгаад хяналт тавьж ажиллах явдал. ДХБ-ын бүх гишүүд автоматаар энэхүү Зөвлөлийн гишүүн болсон байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
308	Council of Europe	Европын зөвлөл. Уг байгууллага 1949 онд байгуулагдсан ба гишүүн улс орнууддаа ардчилал, хүний эрх, эрх зүйг дээдлэх ёсыг бэхжүүлэх зорилготой, дөч гаруй гишүүнтэй. Нарийн бичгийн дарга нарын газар нь Страсбург хотод байрладаг. Мөн хоорондоо нягт хамтран ажилладаг боловч байгууллагын хувьд түүнээс ялгаатай Европын Холбооны Зөвлөлийг (Council of the European Union) үзнэ үү.
309	Council of the European Union	Европын холбооны зөвлөл. Европын холбооны [тухайн үеийн] бүх арван таван гишүүн орны сайд нарын төлөөллөөс бүрдэж байсан, гол төлөв Сайд нарын зөвлөл хэмээн нэрлэдэг шийдвэр гаргах түвшний байгууллага. Зөвлөлийн ерөнхийлөгчийн албан тушаалын хувьд гишүүн улс орнуудын дунд зургаан сар тутамд ээлжилдэг байна. Уулзалтууд байнга явагддаг бөгөөд оролцооны хувьд тухайн хэлэлцэх сэдвүүдээс хамаарна. Гадаад харилцааны сайд нар Ерөнхий харилцааны зөвлөлийн хүрээнд хуралддаг. Бараг бүх шийдвэрийг шаардлага хангасан олонхын саналаар гаргадаг. Энэ нь, хэрэв тухайн гаргаж буй саналыг батлуулах гэж байгаа бол, байж болохуйц нийт 87 саналын 67-гоос доошгүй санал нь уг саналын төлөө өгөгдсөн байх ёстой гэсэн үг юм. Герман, Франц, Итали, Их Британи тус бүр арван санал, Испани найм, Бельги, Грек, Нидерланд, Португаль тус бүр тав, Австри, Швед тус бүр дөрөв, Ирланд, Дани, Финлянд гурван тус бүр, Люксембург хоёр санал тус тус өгчээ. Мөн Европын комиссыг (European Commission) үзнэ үү.
310	Counterfeiting	Хуурамчаар дуурайлган үйлдэх, хууль бусаар хуулбарлах. Хуурамч барааны тэмдэгтэй бараа буюу олон нийтэд танигдсан үйлдвэрлэгчийн барааны тэмдгийг өөр дуурайлган хийсэн бараанд хууль бусаар хэрэглэж, барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчих үйлдэл. Мөн Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээр (TRIPS), оюуны өмч (intellectual property) болон оюуны өмчийн эрхийн зөрчлийн (intellectual property rights infringements) талаар үзнэ үү.
311	Countertrade	Угтвар худалдаа. Бараа, эсхүл үйлчилгээг өөр бараа, эсхүл үйлчилгээгээр солилцох худалдааны үйл ажиллагаа буюу энэ үед хатуу валют шаардлагагүй байдаг. Олон улсын худалдааны энэ хэлбэр нь валютын нөөц дутагдалтай, эсхүл зээлийн боломж тааруу хөгжиж буй орнуудад гол төлөв тархсан. Бараа солилцоо/barter trade/, Угтан худалдан авах/counterpurchase or parallel barter/, Нөхөн төлөх худалдаа/compensation trade or buyback/, Оффсет худалдаа/offset trade/, Свич худалдаа/switch trading/ гэх мэт төрөлтэй. Бараа солилцоо (barter trade), Нөхөн төлөх худалдааг (compensation trade) үзнэ үү.
312	Countervailing duties	Татаасны эсрэг нөхөн тэгшитгэх/саармагжуулах татвар. Экспортлогч улс дах үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчид Засгийн газраас нь олгосон татаасны хөнгөлөлтийн улмаас импортлогч талд үүссэн хохирлыг нөхөн тэгшитгэх зорилгоор татаас авсан тухайн барааны импортод ногдуулдаг нэмэлт татвар. ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт (WTO Agreement on Subsidies and Countervailing Measures) уг татварыг ногдуулах журмыг тусгасан.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Татаасны хохирлыг саармагжуулах нэмэлт татварыг тодорхой хязгаарлагдмал нөхцөлд ашиглаж болно. Мөн засгийн газрын гэхээс илүү хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд чиглэгдсэн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) болон де-минимис буюу дотооддоо үзүүлж болох дэмжлэгийн хамгийн доод хэмжээ бүхий татаасыг (de minimis subsidies) үзнэ үү.
313	Country-hopping	Улс орон дамнан аялах. Демпингийн эсрэг арга хэмжээнд одоогоор өртөөд байгаа импортлогч нь демпингтэй бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн эх үүсвэрээ, хянан магадалгаа хийгдээгүй байгаа улс эсвэл компани руу өөрчлөн шилжүүлдэг арга туршлагынх нь албан бус нэршил. Мөн морин тойруулга мэт нөлөө (carousel effect), хуулиас гадуур тойрч гарах (circumvention), Тасралтгүй хийгдэж буй демпингийн тухай заалтыг (Persistent Dumping Clause) үзнэ үү.
314	Country of origin	Гарал үүслийн орон. Гарал үүслийн дүрэм (rules of origin), гарал үүслийн хөнгөлөлттэй дүрмийг (preferential rules of origin) үзнэ үү.
315	Cradle-to-grave assessment	Өлгийнөөс булш хүртэлх үнэлэлт дүгнэлт. Мөн насжилтын мөчлөгийн үнэлэлт дүгнэлтийг (life cycle assessment) үзнэ үү.
316	Crisis cartel	Хямралын картель (cartel). Үүнийг мөн онцгой байдлын картель, оновчтой картель, эдийн засгийн уналтын картел болон иймэрхүү ижил төстэй нэрээр нэрлэдэг. Зарим монополын эсрэг хууль буюу өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хүрээнд үүссэн хэвийн бус нөхцөлд хэрэгжих боломжтой аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны хэлбэр. Үүнийг ашиглах нөхцөлд, аж үйлдвэрийн салбарын байнгын бөгөөд хүчтэй уналт, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн үр ашгийг нэмэгдүүлэх амлалт, өөр бусад арга замаар сайжруулалт хийх боломжгүй гэсэн ойлголт зэрэг хүчин зүйлүүдийг хамрах хандлагатай байдаг. Мөн картель (cartel) болон бүтэлгүйтэж буй-аж ахуйн нэгжийн номлолыг (failing-firm doctrine) үзнэ үү.
317	Critical mass	Шийдвэрлэх тооны олон нийт. Ийм хэмжээнд хүртэл ажиллах нь худалдааны хэлэлцээ хийж байгаа талын мөрөөдөл байдаг. Хэлэлцээний хүрээнд тавьсан тухайн саналын дэмжлэг нь маш хүчтэй болох тэр үед, бусад хүмүүсийнх нь хайхрамжгүй байдал, эсэргүүцэл зэрэг нь хэдийнээ хамаагүй болдог байна.
318	Cross-border alliances	Хил дамнасан холбоо. Мөн бизнесийн стратегийн түвшний холбоог (strategic business alliances) үзнэ үү.
319	Cross-border investment	Хил дамнасан хөрөнгө оруулалт. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (foreign direct investment) үзнэ үү.
320	Cross-border trade	Хил дамнасан худалдаа. Гаалийн нэг нутаг дэвсгэрээс нөгөө нутаг дэвсгэр лүү шилжиж буй бараа бүтээгдэхүүний хөдөлгөөн. ДХБ-ын гишүүд хоорондын худалдаа тус байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ээр зохицуулагддаг. Мөн зарим тохиолдолд хоёр тал болон бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн зохицуулагддаг болно. Хилийн худалдааг (border trade) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
321	Cross-border trade in services	<p>Хил дамнасан үйлчилгээний худалдаа. ДХБ-ын Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (YXEX-GATS)-т тусгагдсан үйлчилгээний худалдааны 4 хэлбэрийн 1 дэх нь. Үйлчилгээ нийлүүлэгч болон үйлчилгээг худалдан авагч хоёр тал биечлэн уулзах шаардлагагүй, аль аль нь өөр өөрийн оронд байх ба ихэнх тохиолдолд цахим хэлбэрээр арилжаа хийдэг. Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр (NAFTA)-т үүнийг илүү өргөн хүрээнд томьёолж дараах зүйлийг тусгасан байдаг: үйлчилгээг худалдах, худалдан авах, түгээлтийн тогтолцоонд нэвтрэх, гэрээний нөгөө талын үйлчилгээ үзүүлэгчийн бие төлөөлөл/төлөөлөгчийн газар, үйлчилгээний худалдаа эрхлэхэд шаардлагатай тохиолдолд бонд гаргах нөхцөл гэх мэт.</p> <p>Арилжааны төлөөлөл (commercial presence), үйлчилгээ нийлүүлэх хэлбэр (modes of services delivery), үйлчилгээний худалдаа (trade in services) үзнэ үү.</p>
322	Cross-compensation	<p>Солбисон нөхөн олговрын арга хэмжээ. Худалдааны маргааныг зохицуулах хүрээнд тус байгууллагад элсэхдээ авсан үүрэг, амлалтаа зөрчсөн нь тогтоогдсон ДХБ-ын гишүүн орон зөрчсөн арга хэмжээ, туршлагаа цуцлахгүйгээр бусад салбар, бүтээгдэхүүнээр эрх нь зөрчигдсэн гишүүнд хөнгөлөлт үзүүлэх аргаар нөхөн олговор санал болгох үйл явцыг хэлнэ. Гишүүний үүрэг, амлалтыг царцаахыг үзнэ үү.</p>
323	Cross-retaliation	<p>Солбисон хариу арга хэмжээ. ДХБ-ын нэг гэрээнд тусгагдсан асуудлаар эрх нь зөрчигдсэн гишүүн орон тус байгууллагын өөр нэг гэрээний хүрээнд гэрээ зөрчсөн гишүүн орны эсрэг хариу арга хэмжээ авахыг хэлнэ. ДХБ-ын Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм болон журмын тухай харилцан ойлгох баримт бичгээр үүнийг зөвшөөрдөг.</p>
324	Crow-bar theory of trade policy	<p>“Кроу-бар” худалдааны бодлогын онол. Худалдааны хориг арга хэмжээ авахаар заналхийлэх аргаар гадаад зах зээлд өөрийн экспортод шударга бусаар ногдуулж буй гэж үзэж байгаа худалдааны саад тотгор, бодлогыг тулган өөрчлүүлэх бодлогыг хэлнэ.</p> <p>Мөн түрэмгийгээр харилцан адил байхыг (aggressive reciprocity) үзнэ үү.</p>
325	Cumulative assessment of dumping	<p>Демпингийн нэгтгэсэн хянан шалгах үйл ажиллагаа. Ижил төрлийн бүтээгдэхүүнээр нэг бус улсаас демпинг хийж буй эсэхийг хянан шалгах үйл ажиллагааг хэлнэ. ДХБ-ын дүрмийн дагуу зөвхөн дараах нөхцөлүүдэд л ийм хянан шалгах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг. Үүнд: (a) демпингийн ялгавар нь орон тус бүрээр үл тооцох хувь (de minimis)-иас илүү, импортын хэмжээ нь үл тоох хэмжээнд биш байх тохиолдолд, (b) дотоодын болон импортын бүтээгдэхүүн хоорондын өрсөлдөөний нөхцөлийг харгалзан хянан шалгах үйл ажиллагаа явуулах нь зохистой гэж үзсэн тохиолдолд. Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) болон демпингийн үл тооцох хувь (de minimis), ялихгүй импортын хэмжээ зэргийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
326	Cumulative rules of origin	<p>Нийлмэл гарал үүслийн дүрэм. Импортлогч талын бүтээгдэхүүний гарал үүслийн дүрэмд зааснаар бүтээгдэхүүний орц, үйлдвэрлэлийн шат дамжлагыг хоёр бөгөөд түүнээс дээш оронд хийхийг зөвшөөрдөг бүтээгдэхүүний гарал үүслийн дүрмийн тогтолцоо. Хөгжингүй орнууд өөрийн Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP) дэглэмийн хүрээнд үйлдвэрлэлийн хүчин чадал хангалтгүй учраас хөнгөлөлтийн ерөнхий системийн гарал үүслийн дүрмийг хангах чадамжгүй хөгжиж буй орнуудад хэрэглэж өөрийн зах зээлд нэвтрэх боломжоор хангадаг.</p> <p>Үлэмж хэмжээний өөрчлөлт (substantial transformation) үзнэ үү.</p>
327	Cumulative subsidies	<p>Татаасны нэгтгэсэн үр нөлөөний үнэлгээ. ДХБ-ын "Татаас болон саармагжуулах арга хэмжээний хэлэлцээр"-т нэг бус орноос нэгэн зэрэг импортлож буй бүтээгдэхүүнд саармагжуулах татвар тавихаар хянан шалгалт хийж буй тохиолдолд холбогдох захиргааны байгууллагууд Татаасны нэгтгэсэн үр нөлөөний үнэлгээг хийж болохоор тусгагдсан. Энэхүү үнэлгээг зөвхөн дараах шалгуурыг хангасан нөхцөлд хийх боломжтой. Үүнд: (a) Татаасны хэмжээ нь Татаасны үл тооцох хувиас дээш байх, (b) импортын зах зээл дээрх өрсөлдөөний нөхцөлийг харгалзан хянан шалгах үйл ажиллагаа явуулах нь зохистой гэж үзсэн тохиолдолд зэрэг болно.</p>
328	Current access tariff quotas	<p>Импортын суурь төвшинг үндэслэн ногдуулах тариф дээр суурилсан тоо хэмжээний хязгаарлалт. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд ногдуулж буй тарифын бус арга хэмжээг тарифын хэлбэрт хөрвүүлэх аргаар зах зээлд нэвтрэх боломжоор хангахыг хэлнэ. ДХБ-ын Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр уг томьёоллыг боловсруулсан. Томьёоллын дагуу зах зээл нээх эсэхийг тухайн бүтээгдэхүүний суурь хугацаан дах импортын хувь хэмжээг хэрэглээний түвшинтэй харьцуулах замаар шийдвэрлэдэг. Суурь хугацааг 1986-88 он, мөн эдгээр онуудад дотоодын хэрэглээний 5%-иас доошгүй хувийг импорт төлөөлсөн тохиолдолд байгаа худалдаанд ногдуулах тариф дээр суурилсан квотыг хэрэглэх юм. Хөдөө аж ахуйн хэлэлцээр (Agreement on Agriculture), зах зээлд нэвтрэх боломжтой хамгийн бага тарифын квотыг (minimum access tariff quotas) үзнэ үү.</p>
329	Current account	Урсгал тэнцэл. Төлбөрийн тэнцлийг (balance of payments) үзнэ үү.
330	Current domestic value	<p>Дотоодын зах зээлийн үнэ. Энэ нь гаалийн татварыг тооцох зорилгоор импортлож буй бараа бүтээгдэхүүний үнэлгээг хийх аргачлал юм. Импортлогдож буй бүтээгдэхүүний зах зээлээс ижил төрлийн бүтээгдэхүүн дотоодын зах зээлийн шударга өрсөлдөөнт орчин нөхцөлд борлуулагдсан үнийн дүнтэй гаалийн татварын үнэлгээг хийхдээ харьцуулах аргачлал юм. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (ТХЕХ) VII зүйлийг хэрэгжүүлэх тухай ДХБ-ын хэлэлцээрт заасан дүрэм журам нь энэхүү аргачлалыг орлох болсон. Гаалийн үнэлгээг (customs valuation) үзнэ үү.</p>
331	Customs Convention on Temporary Admission	Түр хугацаагаар нэвтрүүлэх тухай гаалийн конвенц. Истанбулын конвенцийг (Istanbul Convention) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
332	Customs Cooperation Council	Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл. Дэлхийн гаалийн байгууллагыг (World Customs Organisation) үзнэ үү.
333	Customs duties	Гаалийн татвар. Хилээр гарч буй болон орж ирж буй бараанд гаалийн тарифын жагсаалтад заасан хувь хэмжээний дагуу хил дээр ногдуулдаг татвар. Эдгээр татварыг тухайн улсын үндэсний тарифын жагсаалтад тусгасан байдаг ба гол төлөв барааны үнийн дүнгээс хувиар (ad valorem), барааны нэгжид мөнгөн илэрхийллээр (specific) тооцсон хэлбэртэй байдаг. Энэ 2 хэлбэрийг хослуулан хэрэглэдэг тариф (compound tariff), олон шатлалт тариф (multi-column tariff), нэг шатлалт тариф (single-column tariff) үзнэ үү.
334	Customs territory	Гаалийн нутаг дэвсгэр. ДХБ-ын дүрмийн дагуу бусад нутаг дэвсгэртэй хийх худалдаа арилжааг зохицуулдаг өөрийн гэсэн тарифын болон бусад худалдааны эрх зүйн зохицуулалттай аливаа нутаг дэвсгэрийг хэлнэ. Товчоор хэлбэл, хэлэлцэн тохиролцогч талын гаалийн хууль тогтоомж үйлчлэх нутаг дэвсгэр (шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралт, 2-р бүлэг). Гаалийн нутаг дэвсгэр нь заавал тусгаар тогтносон улс байх албагүй. Гаалийн холбоог (customs union) үзнэ үү.
335	Customs union	Гаалийн холбоо. Хоёр ба түүнээс дээш бие даасан эдийн засагтай улс, эсхүл гаалийн нутаг дэвсгэрүүд өөр хоорондын худалдааны бүх тариф болон бусад саад тотгорыг үлэмж хэмжээгээр халсан бүсийг гаалийн холбоо гэнэ. Уг холбооны гишүүд нь гуравдагч орнуудын хувьд нэгдсэн гадаад тарифыг мөрддөг. Нэгдсэн зах зээл (common market) болон чөлөөт худалдааны бүсийг (free-trade area) үзнэ үү.
336	Customs valuation	Гаалийн үнэлгээ. Гаалийн татварыг үнэн зөв бодитоор тогтоох зорилгоор импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 7-р заалтыг [гаалийн үнэлгээ] хэрэгжүүлэх тухай ДХБ-ын хэлэлцээрт гаалийн үнэлгээний үндсэн зарчмуудыг тогтоож, үнэлгээний үндсэн 6 аргыг заасан байдаг. Үүнд: Хэлцлийн үнийн арга; Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга; Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга; Импортлогч оронд борлуулсан үнэд үндэслэх ялгавар үнийн арга; Барааг үйлдвэрлэхэд гарсан түүхий эдийн болон үйлдвэрлэлийн зардал, ашиг зэрэгт үндэслэх нийлбэр үнийн арга; Уялдуулан хэрэглэх арга зэрэг болно. Дээрх аргуудыг эхнээс нь дараалуулж хэрэглэх ёстой.
337	Customs valuation agreement	Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээр. Мөн 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 7-р Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Agreement on Implementation of Article VII of the General Agreement on Tariffs and Trade 1994) болон гаалийн үнэлгээг (customs valuation) үзнэ үү.
338	Cyclical dumping	Түр зуурын демпинг. Эрэлт буурсны улмаас илүүдэл үүсэж, түүнийгээ хямд үнээр тур хугацаанд худалдаалах (dumping) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
339	Data protection in trade in services	<p>Үйлчилгээний худалдаан дах цахим өгөгдлийг хамгаалах. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (YXEX)-т дуу дүрс бичлэг болон тоон мэдээлэл, өгөгдлийн нууцлалыг хангах талаар хэд хэдэн заалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал, хэлэлцээрийн III bis заалтаар мэдээллийг ил тод болгох шаардлага нь хууль хэрэгжүүлэхэд саад болох, эсхүл нийтийн ашиг сонирхлыг зөрчих, эсхүл улсын, эсхүл хувийн арилжааны хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болох нууц мэдээлэл гаргаж өгөхийг Гишүүнээс шаардахгүй байхаар тусгагдсан. Мөн 9-р зүйл (Ажил хэргийн практик)-ээр шударга өрсөлдөөнийг сааруулсан үйл ажиллагааны талаарх нийтэд нээлттэй нууц бус мэдээллийг өгөх замаар хамтран ажиллах, нууц мэдээлэл гаргаж өгсөн тохиолдолд мэдээллийг хүлээн авч буй тал нь мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээх талаар тусгагдсан. Түүнчлэн 14-р зүйл (Эс хэрэглэх нийтлэг тохиолдол)-д хувь хүний хувийн нууцыг хамгаалах үүднээс, хувийн амьдрал, дансны тухай мэдээлэл, бүртгэл зэргийг хэлэлцээрийн дагуу хүлээгдэж буй үүрэг, хариуцлагыг түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг болно.</p>
340	Decision in Favour of Least-Developed Countries	<p>Нэн буурай хөгжилтэй орнуудыг дэмжих зорилгоор баталсан шийдвэр. Нэн буурай хөгжилтэй орнууд (least-developed countries) үзнэ үү.</p>
341	Decision-making in the WTO	<p>ДХБ-ын шийдвэр гаргах зарчим. ДХБ-ын гишүүд шийдвэр гаргахдаа нийтийн зөшилцлийн зарчмыг баримталдаг. Зөвшилцөлд хүрэх боломжгүй байх тохиолдолд санал хураах эрх зүйн боломж нээлттэй. Шийдвэр гаргахад шаардлагатай олонхийн талаарх ойлголт нь тухайн асуудлаасаа шалтгаалан өөр өөр байдаг. "Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүд"-ийг эс тооцвол ДХБ-ын Сайд нарын бага хурал, Ерөнхий зөвлөлөөс, мөн хөнгөлөлт (waiver) авах асуудлаар шийдвэр батлахад нийт гишүүдийн дөрвөний гурваас доошгүй нь уг шийдвэрийг дэмжсэн байх шаардлагатай. Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ), Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (YXEX), Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээр (TRIPS)-ийн үндэсний нэн тааламжтай нөхцөлтэй холбоотой холбогдох заалтуудад оруулах нэмэлт өөрчлөлтийг зөвхөн нийтийн зөвшилцлийн зарчмыг баримталдаг. "Европын хамтын нийгэмлэг" нь гишүүн улсуудынхаа тоотой тэнцэх тооны санал өгөх эрхтэй. "Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүд"-ийн хувьд эдгээр хэлэлцээрүүдэд тусгагдсан шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтынхаа хүрээнд шийдвэр гаргадаг. ДХБ-ын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт (amendments to WTO agreements) үзнэ үү.</p>
342	Declaration giving effect to the provisions of Article XVI:4	<p>ТХЕХ-ийн XVI зүйлийн 4 дэх заалтыг хүчин төгөлдөр болгох тухай Тунхаглал. Уг тунхаглалд ТХЕХ-ийн хөгжингүй гишүүд нэгдэж улмаар 1960 онд баталсан ба тунхаглалаар гишүүд экспортын бүтээгдэхүүнийг дотоодын зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүний үнийг харьцуулсан үнээс бага үнээр борлуулахад хүргэдэг бүтээгдэхүүний экспортыг шууд болон шууд бус хэлбэрээр татаас олгохыг 1958 оны 1 сарын 1-нээс эхлэн зогсоохоор зөвшөөрсөн. Анхдагч түүхий эд энэхүү тунхаглалд хамааралгүй болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
343	Declaration on the Contribution of the World Trade Organization to Achieving Greater Coherence in Global Economic Policymaking	Глобал эдийн засгийн бодлого боловсруулалтын уялдаа холбоог сайжруулахад ДХБ-ын гүйцэтгэх үүргийн тухай тунхаглал. Тунхаглал нь Уругвайн үе шатны хэлэлцээг 1994 оны 4-р сард албан ёсоор дууссан болохыг баталсан Марракешийн Сайд нарын бага хурлын үр дүнгийн нэг юм. Тунхаглалд: Уругвайн үе шатны нааштай дүн нь илүү уялдуулсан болон бие биеэ харилцан нөхсөн олон улсын эдийн засгийн бодлого явуулах үйл ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулсан. Гарал үүсэл нь худалдаатай холбоогүй хүндрэлийг зөвхөн худалдааны хүрээнд арга хэмжээ авснаар арилгаж болохгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Мөн глобал эдийн засгийн бодлого боловсруулахад илүү зохицолдох явдалд хүрэх зорилгоор Бреттон-Вудийн (ОУВС, ДБ-ны ОУСБХБ) байгууллагуудтай тийм хамтын ажиллагааг авч хэрэгжүүлэх хэлбэрийг ярилцахыг ДХБ-ын Ерөнхий захиралд даалгасан байдаг.
344	Declaration on the Establishment of a New International Economic Order	Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам тогтоох тухай тунхаглал. Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам (New International Economic Order) үзнэ үү.
345	Decompilation	Статистик тоон мэдээллийг задлан гаргах. Үйл ажиллагаа явагдаж буй цаад үндсэн санаа, зарчмуудыг олж мэдэх зорилгоор, компьютер програм хангамжийг судлах эсвэл дүн шинжилгээ хийх. Үүнд ихэвчлэн тухайн програм хангамжид ихээхэн хэмжээгээр дахин шинээр бүтээх эсвэл дахин хуулбарлан бүтээх хэрэг ч гардаг. Зохиогчийн эрхийн хуулийн хүрээнд үүний эрх зүйн байдлын талаар үндэсний шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нар өөр өөр байр суурьтай байдаг бөгөөд энэ практик туршлага нь маргаан дагуулж байдаг. АНУ-ын шүүх нь “шударга хэрэглээ” гэдэг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаалалтгүй санаа, үзэл баримтлалыг нь ил болгох үүднээс, програм хангамжийн статистик тоон мэдээллийг задлан шинжлэх үйлдлийг агуулсан урвуу инженерчлэлийг зөвшөөрдөг бол, Авсралид тийнхүү статистик тоон мэдээллийг задлан шинжлэх нь зохиогчийн эрх эзэмшигчийн дахин хуулбарлан бүтээх эрхийг зөрчиж байна гэж үзэж болно. Мөн Шударга хэрэглээний номлолыг (fair-use doctrine) үзнэ үү.
346	Decoupage	Дидуааж. Энэ нь Кеннедигийн үе шатанд химийн бодисын гаалийн тарифыг бууруулах хэлэлцээний үеэр гарсан процедурын асуудал. Энэ нь хэлэлцээ хийх эрх бүхий АНУ-ын гаргасан концессууд/тарифын хөнгөлөлт, буултыг (1962 оны Худалдааг өргөжүүлэх тухай хууль), Конгрессын нэмэлт зөвшөөрөл шаардагддаг концессууд/хөнгөлөлт, буултаас нь салгах шаардлагаас үүдэж гарсан байдаг. Сүүлийн бүлэг нь гаалийн татвар төлөх зорилгоор хил дээрх зарим химийн бодисыг үнэлэх арга болох Америкийн Борлуулалтын үнийн тогтолцоог цуцлах саналыг тойрон хүрээлэгчид байв.
347	Deep amber	Гүн улбар шар. Ноцтой ялгаварлан гадуурхал гэснийг (serious prejudice) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
348	Deep integration	<p>Гүн хамтын ажиллагаа/интеграцчилал. Хоёр ба түүнээс дээш улс орнуудын үндэсний засгийн газрын бодлогыг уялдуулсан нэгтгэх, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх үйл явц. Үүнд өрсөлдөөний бодлого, техникийн стандарт хэм хэмжээнүүд, татаас, мөнгөний болон төсвийн бодлогууд, санхүүгийн байгууллагуудын эрх зүйн зохицуулалтууд болон удирдлага хяналт, байгаль орчны асуудал, засгийн газрын бараа, үйлчилгээний худалдан авалт гээд олон зүйлс багтдаг. Европын Хамтын нийгэмлэг нь хамгийн сүүлд Нэгдсэн зах зээлийг (Single Market) байгуулж, “Маастрихийн хэлэлцээр”-ээс (Treaty of Maastricht) үүдэлтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар энэхүү үйл явц руу хамгийн хол явсан. Мөн “Австрали ба Шинэ Зеландын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээр” (ANZCERTA), “Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр” (NAFTA) зэргийг дурдаж болно. Хөнгөлөлттэй худалдааны бүсээс эхлээд Чөлөөт худалдааны хэлэлцээр, Гаалийн холбоог (эдгээрийг гүехэн интеграц гэж үзжээ) энд оруулж болох боловч, түүний гишүүн тус бүр нь бусад бүх бодлогынхоо хүрээнд бүрэн чөлөөтэй хэвээр үлдсэн байдаг. Зарим шинжээчид ТХЕХ-ийг энэ ангилалд багтаж байгаа гэж үздэг. Мөн Европын хамтын нийгэмлэг буюу Европын Холбооны нэгдсэн зах зээл (European Community Single Market), сөрөг нэгтгэл/ интеграцчилал (negative integration), эерэг нэгтгэл/интеграцчилал (positive integration) үзнэ үү.</p>
349	De facto discrimination	<p>Де-факто ялгаварлан гадуурхалт. ДХБ-ын Давж заалдах шатны байгууллага 1996 оны гадил жимсний маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийн тайланд анх ашигласан нэр томьёо. Давж заалдах шатны байгууллага нь де-факто (de facto) ялгаварлан гадуурхалтыг “де-юре” (de jure) эсвэл албан ёсны ялгаварлан гадуурхалттай сөргүүлэн харьцуулж харуулдаг. Үүний утга нь хууль тогтоомжийн шаардлага гэхээсээ илүү практик дээр суурилсан “далдуур ялгаварлан гадуурхах” гэсэн утгатай ойролцоо. Мөн “гадил жимсний хэрэг”-ийг (banana cases) үзнэ үү. De-facto (Де-факто) гэдэг нь бодит байдал дээр, хэрэг дээрээ гэсэн латин үг бөгөөд олон улсын эрх зүйд улс ба засгийн газрыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх нэгэн хэлбэр бөгөөд тэгэхдээ эцэслэгдсэн хүлээн зөвшөөрөлт бус гэсэн утгыг эл нэр томьёо илэрхийлнэ. Ийм хүлээн зөвшөөрөлт нь голчлон түр зуурын шинжтэй, дараа нь де-юре (de-jure)-д шилжих үе шат болдог.</p>
350	De facto GATT membership	<p>ТХЕХ-ийн де-факто гишүүнчлэл. Хуучин колонийн эзэмшилд байсан орнууд тусгаар тогтнонгуут хэрэв худалдааныхаа тогтолцоог ТХЕХ-тэй уялдуулан удирдан зохион байгуулна хэмээн зөвшөөрсөн л бол ТХЕХ-т де-факто гишүүд болж оролцох юм. Зөвхөн тэднийг колончилж байсан орнууд нь ТХЕХ-ийн гишүүд байсан тохиолдолд л тийнхүү хийх боломжтой. Де-факто гишүүнчлэл нь ДХБ-ын хувьд боломжгүй.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
351	Deficiency payments	<p>Алдагдлын зөрүүний төлбөр. Европын хамтын нийгэмлэгийн Хөдөө аж ахуйн нэгдсэн бодлого, АНУ-ын хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд төрөөс малчид тариаланчид хүртэх ёстой гэж үздэг үнэ болон зах зээлийн бодит үнэ хоёрын хоорондын зөрүүг ийнхүү томьёолсон байдаг. Энэ зөрүүг татвар ногдуулах замаар эсвэл олон хэрэглэгчээс өндөр үнээр авах замаар, улсын татаасаар хангаж өгдөг. Мөн хөх ангилалд хамаарах татаас (blue box), ногоон ангилалд хамаарах татаасыг (green box) үзнэ үү.</p>
352	Definitive anti-dumping duties	<p>Демпингийн эсрэг тодорхой татварууд. Демпингийн эсрэг арга хэмжээ авахад шаардлагатай бүх хянан магадалгааг хийж дууссаны дараа ногдуулах болсон демпингийн эсрэг тодорхой татварууд. Уг демпинг нь үргэлжлэх, эсхүл дахин гарч ирнэ гэдгийг өмнө нь эхлүүлсэн судалгаагаар тодорхойлоогүй л бол түүнийг таван жилийн дараа дуусгах хэрэгтэй болно. Мөн "демпингийн эсрэг арга хэмжээ" (anti-dumping measures), демпингийн эсрэг нөхцөл заасан татваруудыг (provisional anti-dumping duties) үзнэ үү.</p>
353	Degressivity	<p>Бууруулалт. Ерөнхийдөө цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хамгаалалтыг бууруулах ёстой гэсэн зарчим. Энэ нь ялангуяа засгийн газрын хувьд бүтцийн өөрчлөлтийн бодлогыг санаачлах ёстой байдаг хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтын асуудалд тулгарч байсан асуудал бөгөөд энэ нь өндөр хамгаалалтад байсан салбаруудыг хамгаалалт багатай болгожээ. Ихэнхдээ тэд импортын хязгаарлалтуудыг нэгэн ижил төвшинд байлгахыг илүүд үзсэн байна.</p>
354	Deindustrialisation	<p>Аж үйлдвэржилтгүй болох. Олон хүмүүс үүнийг даяарчлалтай холбоотой сөрөг хөгжил гэж үздэг үзэгдэл. Үүнийг ерөнхийдөө өндөр хөгжсөн болон аж үйлдвэржсэн эдийн засагтай орнуудад боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын ажил эрхлэлтийн эзлэх хувь хэмжээний урт хугацааны уналт гэж тодорхойлсон байдаг. Аж үйлдвэржилтгүй болоход хамгийн чухал хүчин зүйл бол боловсруулах үйлдвэрлэл дэх бүтээмж нь үйлчилгээнийхээс илүү хурдан өсөх системчилсэн хандлага бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хоорондын худалдаа үүнд маш бага үүрэг гүйцэтгэсэн гэж тэд хэлдэг байна. Олон улс орнуудын хувьд, хүлээн зөвшөөрөгдсөн аж үйлдвэржилтгүй болох байдал нь "худалдааны бодлого" боловсруулалтыг жолоодож буй чухал хүчин зүйлүүдийн нэг бөгөөд ихэнх тохиолдолд улс орнууд "эмзэг салбаруудаа" "хамгаалалтанд" авах замаар үүний урсгалыг сөрж гарахыг хичээдэг. Мөн нутагшуулахгүй байх (delocalisation), бүтцийн өөрчлөлтийн зохицуулалтыг (structural adjustment) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
355	DEIP	<p>Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын урамшууллын хөтөлбөр (DEIP). Америкийн Нэгдсэн Улсын татаас олгох хөтөлбөрийг анх 1985 оны Фермийн тухай хуулиар зөвшөөрсөн бөгөөд үүний дагуу “Түүхий эдийн зээлийн корпорац” нь АНУ-ын сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлогчдод бусад татаас өгдөг орнуудтай, гол төлөв “Европын хамтын нийгэмлэг”-тэй өрсөлдөхөд нь туслах зорилгоор татаас олгодог. Зөвшөөрөгдсөн борлуулалт гэдэг нь экспортын арилжааны борлуулалтыг орлуулна гэхээсээ илүү түүний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилготой. Гэвч бодит амьдрал дээр энэ хөтөлбөр нь Европын татааснуудыг зогсоох хүрээнд хязгаарлагдаагүй байсан байна. Мөн уг хөтөлбөрийг өргөжүүлсэн 1996 оны “АНУ-ын Хөдөө аж ахуйг сайжруулж, шинэчлэх тухай холбооны хууль”-ийг (United States Federal Agriculture Improvement and Reform (FAIR) Act) үзнэ үү.</p>
356	De jure discrimination	<p>Де-юре (de jure) ялгаварлал. Албан ёсоор хууль тогтоомж, журамд тусгасан худалдааны түншүүдийн ялгаварлан гадуурхалт.</p>
357	Delocalisation	<p>Нутагшуулахгүй байх. “Худалдаа, хөдөлмөрийн стандарт”-ын талаарх хэлэлцээний өмгөөлөгчдийн хэрэглэдэг нэр томьёо. Энэ утгаараа тухайн компани нь үйлдвэрлэлийн байгууламжаа өндөр өртөгтэй газраас хямд өртөгтэй улс руу нүүлгэх шийдвэр гаргаж магадгүй, учир нь ингэснээр ажилчдынхаа нийгмийн нөхцөлийг дэмжих зардлаа хэмнэх болно гэж үздэг гэсэн үг. Энэхүү шаардлага нь бодит байдал дээр бараг үндэслэгдээгүй байна. Дэвшилтэт, уян хатан үйлдвэрлэлийн систем рүү шилжиж, чанар, найдвартай байдлыг хангах хэрэгцээ нэмэгдэж байгаатай уялдаатайгаар, дэд бүтэц, боловсролын стандарт, ур чадварын түвшин зэрэг хүчин зүйлүүдэд илүү их ач холбогдол өгөх болсон байна. Дараа нь цалингийн түвшин маш бага ач холбогдолтой байдаг. Мөн аж үйлдвэржилтгүй болох (deindustrialisation), даяарчлал (globalisation), ёроол руу уралдах тухай мэтгэлцээн (race-to-the-bottom argument), “ажилчдын эрх”-ийг (workers rights) үзнэ үү.</p>
358	De minimis dumping margins	<p>Де-минимис буюу өчүүхэн бага хэмжээний демпингийн зөрүү. Энэхүү нэр томьёог демпингийн эсрэг арга хэмжээ авах эсэх дээр шийдвэр гаргахад хэрэглэдэг. Хэрвээ демпингийн зөрүү нь тухайн барааны гарал үүслийн орны экспортын үнээс үлэмж бага буюу 2%-иас доош хэмжээтэй, эсхүл демпингтэй гэгдэж буй бүтээгдэхүүн нь энэ төрлийн бүтээгдэхүүний нийт импортод үлэмж бага хэмжээтэй буюу 3%-аас ихгүй байх тохиолдолд импортлогч улс демпингийн эсрэг арга хэмжээ авахгүй.</p>
359	De minimis imports	<p>Де-минимис буюу өчүүхэн бага хэмжээний импорт. “Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудал”-ын тухай ДХБ-ын хэлэлцээрт хэрэглэдэг нэр томьёо бөгөөд уг гэрээний заалтууд нь хувийн хэрэглээний тээш, эсхүл өчүүхэн бага хэмжээгээр илгээгдсэн арилжааны бус бараа бүхий илгээмжид хамаарахгүй.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
360	De minimis safeguards rule	<p>Де-минимис буюу өчүүхэн бага импортод хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх дүрэм. Энэхүү нэр томьёог хамгаалалтын арга хэмжээ авах эсэх дээр шийдвэр гаргахад хэрэглэдэг.</p> <p>Хэрэв импортлогч орны тухайн барааны нийт импортод аль нэг хөгжиж буй гишүүн орны импорт 3-аас дээшгүй хувь эзэлдэг, ингэхдээ тухайн барааны нийт импортод импорт нь 3-аас дээшгүй хувь эзэлдэг хөгжиж буй гишүүн орнууд нь нийлбэр дүнгээрээ 9-өөс дээшгүй хувийг эзэлж байвал хөгжиж буй гишүүн орноос гаралтай тухайн барааны хувьд хамгаалалтын арга хэмжээ үл хэрэглэнэ. Мөн Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Safeguards), хамгаалалтын арга хэмжээ ба сонгогдохуйц байдал (safeguards and selectivity) үзнэ үү.</p>
361	De minimis subsidies	<p>Де-минимис буюу өчүүхэн бага хэмжээний татаас. ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрээр энэ татаасыг 1% -иас доош хэмжээтэй гэж тодорхойлдог ба ийм тохиолдолд хянан магадалгааг/мөрдөн шалгалтыг нэн даруй зогсоодог. Харин хөгжиж буй улс орнуудын хувьд энэ хэмжээг 2%-иар тогтоодог. Энэхүү заалтыг мөн дараах нөхцөлүүдэд хэрэглэнэ. Үүнд: Хөгжиж буй орнуудын татаасны дэмжлэгтэй бүтээгдэхүүний импортын хэмжээ нь ижил төрлийн бүтээгдэхүүний импортын 4%-иас ихгүй бол, мөн импортынх нь 4%-иас ихгүй хэмжээнд тухайн ижил төрлийн бүтээгдэхүүнийг татаасны дэмжлэгтэйгээр импортлосон хэмжээ нь уг мөрдөн шалгалт явуулж буй улсын яг ижил бүтээгдэхүүний нийт импортод нь эзлэх хэмжээ 9% хувиас даваагүй байх тохиолдолд.</p>
362	Denial of benefits	<p>Үр ашиг хүртээхээс татгалзах. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (YXEX) гишүүн орнууд хэрэв тухайн үйлчилгээ нь YXEX-ийн гишүүн улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлгүй, эсхүл уг үйлчилгээг үзүүлж буй компани нь YXEX-ийн гишүүн улсын харьяат иргэн биш байсан гэдгийг нотлон харуулж чадвал, өөр нэгэн гишүүн улсад уг Хэлэлцээрийн үр ашиг хүртээхээс татгалзаж болно. Мөн "үл хэрэглэх тухай" хуулийн заалтыг (non-application) үзнэ үү.</p>
363	Dependence theory	<p>Хараат байдлын онол. Хөгжиж буй орнууд эдийн засгийн, нийгэм, улс төрийн хувьд хөгжингүй орнуудын эрх барьж буй хүчний бүлгүүд, ялангуяа "үндэстэн дамнасан корпорациуд"-аас хараат байна гэж үздэг, 1960-1970-аад оны үед ихэд шинэ загвар болж байсан онол. Одоо бол энэ нь хөгжил болон хөгжил буурай байхын учир шалтгааны талаар хангалттай хэмжээнд тооцоолсон тайлбар болж өгч чадахгүй гэж үздэг болсон тул хөгжиж буй улс орнуудад бодлогын сонголтууд нь байгаа юм. Мөн "Үндсэн гол хэсэг болон зах хязгаарын хэсгийн тухай магадлал"-ыг (core-periphery thesis) үзнэ үү.</p>
364	De-regulation	<p>Төрийн зохицуулалтыг халах. Энэ нь өрсөлдөөнийг дэмжиж, улмаар бараа үйлчилгээг хүргэх үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн, аж үйлдвэрлэлийн салбарууд эсвэл ажил мэргэжлүүдийг зохицуулж байдаг зохицуулалтын бүтэц тогтолцоог засгийн газруудын зүгээс татан буулгах үйл явц. Мөн хувьчлал (privatisation), төрийн зохицуулалтыг дахин нэвтрүүлэх (re-regulation), өрсөлдөөний өргөн хүрээний бодлогыг (wider competition policy) үзнэ үү.</p>

Хөгжиж буй улс орнууд болон Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT-TXEX). 1947 онд TXEX-ийн текстийг хэлэлцэн тохиролцож байх үед, хөгжлийн өөр өөр үе шатанд байгаа улс орнуудад энэ нь бүхэлдээ эн тэнцүү хэрэглэгдэх ёстой гэсэн төсөөлөл өндөр хөгжсөн орнуудын дунд байсан. Үүний зэрэгцээ, хөгжиж буй улс орнууд бусад улс орнуудтай заавал бүрэн хэмжээнд “худалдааг либералчлахад харилцан адил байх” ёсгүй бөгөөд тэд өндөр хөгжсөн улс орнуудын зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх ёстой гэж үзэж байсан үзэл хүчтэй байсан байна. Эцэст нь, эдийн засаг нь хөгжиж буй улс орнууд, ялангуяа амьжиргааны зөвхөн доогуур түвшинг хангаж чадах мөн хөгжлийн эрт үе шатандаа байгаа улс орнуудын дэвшилтэт хөгжлийг дэмжих үүднээс, хуулийн 18-р Зүйлд (Article XVIII) нэг нөхцөлийг оруулсан байна. Тухайн Зүйлийг тайлбарласан тэмдэглэлд нэмж тэмдэглэснээр бол “амьжиргааны доогуур түвшин” гэсэн үг хэллэгийг анхдагч түүхий эдийн барааг сайн экспортлож болох зах зээлээс үүдсэн байж болохуйц эдийн засгийн түр зуурын таатай нөхцөлүүд биш, харин эдийн засгийн хэвийн нөхцөл байдал гэсэн утгыг илэрхийлэхэд хэрэглэх юм. “Эдийн засгийн хөгжлийн эрт үе шатанд байгаа” гэсэн үг хэллэг нь эдийн засгийн хөгжлийн эхний үе шатандаа байгаа улс орнуудад л зөвхөн хэрэглэгдэх бус мөн анхдагч түүхий эдийн барааны үйлдвэрлэлээс хэт хараат байдлыг залруулахын тулд аж үйлдвэржүүлэлтийн үйл явцдаа байгаа улс орнуудад мөн хэрэглэгдэх юм. 18-р Зүйл нь хөгжиж буй улс орнуудад хөгжлийн анхны үе шатандаа яваа аж үйлдвэрлэлийн салбараа хөхиүлэн дэмжих үүднээс тарифын тогтолцоогоо дэмжиж ажиллах мөн “төлбөрийн тэнцлийн” зорилгоор “тоон хязгаарлалтуудыг” хэрэглэхийг зөвшөөрдөг. Хуулийн энэхүү Зүйлийн хүрээнд хэрэглэдэг шалгуур үзүүлэлт нь харьцангуй уян хатан учраас үүнийг удирдлага болгон ажиллахад үргэлж хэцүү байсаар ирсэн байдаг. Нэгдүгээрт, уг Зүйл нь улс орнууд хэзээ өөрсдийг нь эдийн засаг нь хөгжиж буй орнууд гэж тооцогдохыг мэддэг байх ёстой гэж үздэг бөгөөд энэ нь тэдний хувьд өндөр хөгжсөн эдийн засаг бүхий орон гэсэн статус руу шилжих механизмыг агуулаагүй болно. Хоёрдугаарт, хөгжлийн эхний үе шатандаа яваа аж үйлдвэрлэлийн салбаруудаа хөгжүүлэхтэй холбоотой заалтууд нь практик амьдрал дээр нэлээд төвөгтэй байж болно. Гуравдугаарт, төлбөрийн тэнцлийн заалтуудын дагуу “импортын хязгаарлалтууд”-тай холбоотой шалгуур үзүүлэлтүүд нь бүхэлдээ сайн тодорхойлогдож чадаагүй байдаг. [Дараах нөхцөлүүдэд тавих] Хязгаарлалт нь шаардагдах хэмжээнээс илүү хүнд байж болохгүй (a) валютын нөөц ноцтой буурах аюулаас урьдчилан анхааруулах эсвэл зогсоох, (b) хангалттай хэмжээний валютын нөөцгүй гишүүн орны хувьд валютын нөөцийнхөө өсөлтийг зохистой түвшинд хүргэх, зэрэг болно. “Солонгосын үхрийн мах”-ны хэргээс үзэхэд төлбөрийн тэнцлийн зорилгоор хийсэн хязгаарлалтыг бодитоор шаардлагатай байх нөхцөлөөс илүү урт удаан хугацаанд барих оролдлого байсаар байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Бодит амьдрал дээр, 18-р Зүйл нь хөгжиж буй орнуудын хувьд тэдний хүсэн хүлээж байсан шиг хэрэгцээтэй байсан гэж үзсэнгүй. Өндөр хөгжсөн улс орнууд ч мөн үүнийг тийм ч гавьяатай зүйл гэж авч үзээгүй. Зарим хүмүүсийн үзэж байгаагаар бол, хуулийн уг Зүйлийн үндсэн бэрхшээл бол “импортыг орлох” онол, гадагшаа чиглэсэн, экспортын чиг баримжаатай эдийн засагтай орнуудын баримталж буй бодлогын эсрэг үзэл дээр суурилсан гэдэг байна. Эдийн засагчдын хэлж байгаагаар, импортыг орлох бодлогод шаардлагатай капитал бараа бүтээгдэхүүнүүдийг импортлох нь экспортын орлогоосоо хангалттай хэмжээнд тэнцвэржүүлэлт хийлгүйгээр, ямар ч эргэлзээгүйгээр гадаад валютын нөөцийн хомсдолд хүргэх болно гэдэг. ТХЕХ-ийн зүйл заалтуудыг өөрчлөхөд хэцүү бөгөөд 1995 оны “ТХЕХ-ийг хянаж үзэх хурлаар” энэ нөхцөл байдлыг бүхэлд нь хөндөлгүй хэвээр нь орхисон юм. Үнэндээ “Кеннедигийн Яриа хэлэлцээний үе шат” эхлэх хүртэл, хөгжиж буй орнууд бүхэлдээ ТХЕХ-ийн томоохон хэлэлцээнүүдэд багахан үүрэгтэй оролцож ирсэн байдаг. Тэд “Токиогийн үе шатны хэлэлцээний” үеэр “тусгай болон ялгавартай нөхцөлийг” илүү баттай болгож өгсөн “Зөвшөөрөгдөх заалт (Enabling clause)”-ыг батлуулах замаар хүрсэн амжилтаа түшиг тулгуур олж авч чадсан байна. Үүнийг мөн Хөнгөлөлтийн ерөнхий системд (GSP) зориулж, үүрэг амлалтаас байнга чөлөөлөгдөх нөхцөлийг олгож өгсөн гэж үздэг. Гэвч эдгээр хоёр амжилтуудын аль нь ч хөгжиж буй улс орнуудыг олон талт худалдааны системд бүрэн хэмжээнд оролцоход чиглэсэн ахиц гаргахад хүргэж чадаагүй юм. Мөн Хөнгөлөлтийг аажмаар дуусгавар болгох (graduation), Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын тухай мэтгэлцээн (infant-industry argument) үзнэ үү.</p>
366	Development Assistance Committee	<p>Хөгжлийн тусламжийн хороо (DAC). Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) хүрээнд байгуулагдсан уг хуулийн этгээд нь гишүүн улс орнуудынхаа хоёр талт болон олон талт “хөгжлийн тусламж”-тай холбоотой асуудлуудыг авч үзэх хэлэлцүүлгийн нэг хэлбэр.</p>
367	Differential and More Favourable Treatment, Reciprocity and Fuller Participation of Developing Countries	<p>Хөгжиж буй орнуудын хувьд ялгавартайгаар, илүү ээлтэй нөхцөлөөр, харилцан адил байж, бүрэн хэмжээнд оролцох оролцоо.</p> <p>Мөн Зөвшөөрөгдөх заалтыг (Enabling clause) үзнэ үү.</p>
368	Diffuse reciprocity	<p>Сарнилын хувьд харилцан адил байх. Ашгийн (үнэ ба өртгийн зөрүү ашиг) хувьд харилцан адил байх (reciprocity at the margin) гэснийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
369	Dillon Round	Диллоны үе шатны яриа хэлэлцээ. “Худалдааны олон талт яриа хэлэлцээ”-ний тав дах яриа хэлэлцээ 1960-61 онд Женев хотноо зохион байгуулагдсан. Энэ нэрийг тухайн үеийн АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч байсан Дуглас С Диллон-ы нэрээр нэрлэжээ. Диллоны үе шатны яриа хэлэлцээний ихэнх нь “Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг” болон түүний “нэгдсэн гадаад тариф”-ыг байгуулснаас үүдэлтэй тарифын хэлэлцээтэй холбоотой байсан боловч мөн үүнд илүү олон тооны тарифын ерөнхий хэлэлцээнүүд явагдсан байна. “Үе шат бүхий яриа хэлэлцээ” гэсэн нэр томьёолол ашигласан хэдий ч энэ нь үнэндээ хуучин хэв загвар бүхий тарифын хэлэлцээний хурлуудын сүүлчийнх нь байсан. 1947 онд “Женевт болсон тарифын бага хурал”-ын үеэр хийгдсэн байдаг 45,000 орчим тарифын хөнгөлөлт, буулттай харьцуулахад ойролцоогоор 4,400 тарифын хөнгөлөлт, буултыг харилцан солилцсон байна.
370	Direction of trade	Худалдааны чиглэл. Тухайн улсын худалдааны түншүүдийг багцлан тодорхойлсон нэр томьёо, бөгөөд ганц, эсхүл бүлэг улстай хийх худалдаа нь хэр чухал болохыг тайлбарласан болно. Ийм мэдээллийг агуулсан статистикийн үндсэн гол ажил бол ОУВС-гаас жил бүр нийтлүүлдэг Худалдааны статистикийн чиглэл хэмээх ном.
371	Dirty Dozen	Хэдэн арван халтар. Арван хоёр гишүүнтэй байхдаа, бодвол Америкийн кино театрын нэрээр нэрлэсэн энэхүү өндөр хөгжилтэй/хөгжингүй орнуудын бүлэг нь Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр анх байгуулагдсан байна. Одоо үүний үндсэн гол оролцогчид нь Австрали, Канад, Европын хамтын нийгэмлэг, Унгар, Исланд, Япон, Норвеги, Шинэ Зеланд, Швейцарь, АНУ зэрэг улсууд юм.
372	Dirty quotification	Бохир эшлэл. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний худалдаа эрхлэхэд тоо хэмжээний хязгаарлалттай тарифыг тогтоох, захиран зохицуулахад хэт их хянамгай болгоомжтой ханддаг.
373	Disguised trade barriers	Зүсийг нь хувиргасан худалдааны саад тотгорууд. Худалдаатай холбогдолгүй зорилгодоо хүрэхийн тулд засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гэхдээ энэ нь импортод шууд нөлөөлж болох юм. Заримдаа ийнхүү ашигладаг арга хэмжээнүүдийн дунд хэрэглэгчийг хамгаалах хууль, бүтээгдэхүүний стандарт, хорио цээрийн дүрмүүд багтдаг. Мөн Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг (sanitary and phytosanitary measures), Хадгалах хугацааны хязгаарлалт буюу дэлгүүрийн лангуунд байршуулж болох нийт хугацааны хязгаарлалтууд (shelf-life restrictions), Худалдаан дах техникийн саад тотгор (technical barriers to trade) үзнэ үү.
374	Dispersed tariff rates	Тарифын тараан байршуулсан хувь хэмжээ. Бага болон өндөр тарифын зөрүү ихтэй гаалийн тарифын жагсаалт. Ийм тарифын жагсаалтад ижил хувь хэмжээтэй тариф харьцангуй бага байдаг. Мөн жигд-тэгш тарифын тогтолцоо (flat-tariff structures) болон Оргил тариф (peak tariffs) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
375	Dispute settlement	Маргаан шийдвэрлэх. Худалдааны дүрмийг тайлбарлах, эсхүл засгийн газруудын нэгнийх нь үйлдсэн үйлдэлтэй холбоотойгоор, тэдний хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх асуудал. Маргааныг, талуудыг харилцан буулт хийлгэх замаар, заримдаа дундын зуучлагчдаар дамжуулан шийдвэрлэдэг. Бусад тохиолдолд маргаан шийдвэрлэх нь илэрхий маргаантай эсвэл дүрэмд суурилсан шинж чанарыг олж авах боломжтой. ДХБ-д маргаан шийдвэрлэх асуудал нь зөвшилцөлд хүрээгүйгээс гол төлөв эхэлдэг. Зөвлөлдөх, маргаан шийдвэрлэх үндсэн дүрмийг, бараа бүтээгдэхүүнд зориулсан ТХЕХ-ийн 22, 23-р Зүйлүүд, үйлчилгээнд зориулсан ҮХЕХ-ийн 22, 23-р Зүйлс, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээрийн (TRIPS) 64-р Зүйлд зааж өгсөн байдаг. Мөн Давж заалдах шатны байгууллага (appellate body) болон Маргаан шийдвэрлэх байгууллагыг (Dispute Settlement Body) үзнэ үү.
376	Dispute Settlement Body	Маргаан шийдвэрлэх байгууллага (DSB). ДХБ нь гишүүн орнуудынхаа дунд үүссэн маргааныг шийдвэрлэх зорилгоор зарлан хуралдуулдаг ба үүнийг ДХБ-ын Ерөнхий зөвлөл гэнэ. Маргааныг шийдвэрлэх байгууллага нь маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг, маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн болон давж заалдах шатны байгууллагын тайланг батлах, дүрэм, журам, зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тандалт явуулж байх, хэрэв өгсөн зөвлөмжүүдийг нь үл хайхарч байгаа тохиолдолд хариу арга хэмжээ авах зөвшөөрөл олгох ганц эрх бүхий байгууллага. ДХБ-ын нарийн бичгийн дарга нарын хэлснээр хэрэг нэг жил орчим үргэлжилж, давж заалдах шатны байгууллагад очвол арван таван сар болдог. Мөн маргаан шийдвэрлэх (dispute settlement), маргаан шийдвэрлэх тухай ДХБ-ын Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг (WTO understanding on dispute settlement) үзнэ үү.
377	Distortion	Гуйвуулах/гажуудуулах. Чөлөөт зах зээлийн нөхцөлд хэрэв тухайн бүтээгдэхүүн худалдаалагдаж байх байсан үнээс нь тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийг нэг бол дээш, эсхүл доош хэлбэлзүүлсэн арга хэмжээ, бодлого, арга туршлага.
378	Diversionary dumping	Хуурмаг демпинг. Тухайн бүтээгдэхүүнийг демпинг үнээр дундын улс руу экспортлоод дараа нь тэндээсээ тэднийг жинхэнэ зорьсон улс руугаа экспортлох. Хуурмаг демпингийн зорилго нь, демпингийн эсрэг арга хэмжээг өөрөөсөө холдуулж, түүнээс сэрэмжлэхийн тулд дундын улсын үнийн тогтолцооны давуу талыг ашиглах явдал байж болох юм. Мөн хуулиас гадуур тойрч гарах (circumvention), демпинг (damping) үзнэ үү.
379	Doha ministerial conference	Доха дах Сайд нарын бага хурал. ДХБ-ын сайд нарын бага хурал 2001 оны 11-р сарын 9-ээс 13-ны хооронд Катарын Доха хотод болсон.
380	Domestically prohibited goods	Дотоодын зах зээлд хориглосон бараа бүтээгдэхүүн. Мөн Дотоодод хориглосон бараа бүтээгдэхүүний экспортыг (export of domestically prohibited goods) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
381	Domestic content requirements	<p>Дотоодын орц/түүхий эд худалдан авах шаардлага. Энэ нь аливаа үйлдвэрлэл явуулахдаа дотоодын орц, түүхий эдийг ашиглах гэсэн шаардлага. Зарим улс орнууд тухайн барааны үнийн тодорхой хувь нь заавал дотоодын түүхий эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүн байна гэж хуульчилсан байдаг. Тухайлбал, Мексик улс дотоодын машины үйлдвэрлэлээ хөгжүүлэх зорилгоор тус улсад үйлдвэрлэгдэж буй суудлын автомашины нийт үнийн дүнгийн 36-аас доошгүй хувь нь дотоодод үйлдвэрлэсэн сэлбэг, хэрэгсэл байх ёстойг хуульчилсан. Эдгээр шаардлага нь дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэх, ажлын байр бий болгох зорилготой байдаг ч гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудад нэлээд саад тоггор учруулдаг. Тиймээс энэ талаар ДХБ-ын “худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр”-т тодорхой заалтуудыг оруулсан.</p> <p>Дотоодын агуулгын шаардлага (Local content requirements) үзнэ үү.</p>
382	Domestic exports	<p>Дотоодын экспорт. Экспортын бараа бүтээгдэхүүн нь нэг бол дотоодод тарьж ургуулсан, эсхүл боловсруулан үйлдвэрлэсэн, эсхүл тэднийг дотооддоо томоохон өөрчлөлтөд оруулсан учраас тэднийг бүхэлдээ, эсхүл ихэнхдээ дотоодын гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүн гэдэг. Мөн буцаан-экспортлох (re-exports) гэснийг үзнэ үү.</p>
383	Domestic International Sales Corporation	<p>Дотоодын олон улсын борлуулалтын корпораци (DISC). Гол төлөв DISC хэмээн нэршдэг энэхүү корпорацийн бүтэц тогтолцоог АНУ-д 1984 он хүртэл ашигласан байдаг. Энэхүү бүтэц тогтолцооны олгодог үндсэн ашиг нь, хувьцаа эзэмшигч нартаа [орлогыг] тарааж өгөх хүртэлх хугацаанд, экспортын ашгаас үүссэн орлогод ногдуулах холбооны засгийн газрын татваруудын төлбөрийг ялгаатайгаар төлөхийг зөвшөөрсөн байдаг явдал. DISC нь гол төлөв бараа бүтээгдэхүүний худалдааг хамарч байдаг. Үйлчилгээний хувьд тэдгээр нь их бага хэмжээгээр барилгын салбарт хязгаарлагдсан байдаг. 1973 онд ган болдын экспортод олгосон гэж сэжиглэсэн татаасыг DISC нар эдэлсэн гэх асуудлаар, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг ТХЕХ-ийн хүрээнд маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг эхлүүлсэн байдаг. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг АНУ-ын эсрэг [шийдвэр] гаргаж, тэр нь дараа нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгт байдаг тодорхой төрлийн татварын горимд хариу арга хэмжээ авч эхэлсэн. Уг маргааныг эцэст нь 1982 онд дуусгавар болгосон байдаг. 1984 онд DISC-ийн хууль тогтоомжийг ТХЕХ-ийн дүрэм журмыг илүү хангах үүднээс Гадаад борлуулалтын корпорациудын хөтөлбөр гэгчээр сольсон боловч үнэхээр ингэж хийгдсэн гэдэг тал дээр бүгд санал нийлдэггүй.</p>
384	Domestic support	<p>Дотоодын дэмжлэг. Энэ нь дэмжлэг туслалцаа эсвэл улсын татаасны нэг хэлбэр. Мөн Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр (Agreement on Agriculture), Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Subsidies and Countervailing Duties) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
385	Dominant supplier provision	<p>Давамгай ханган нийлүүлэгчийн нөхцөл. Энэ нь АНУ ба Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хувьд нийлээд дэлхийн зах зээлийн 80% эсвэл түүнээс дээш хувийг эзэлж байдаг аливаа ангиллын бүтээгдэхүүний тарифыг тэг хүртэл бууруулахыг зөвшөөрсөн, Америкийн Нэгдсэн Улсын 1962 оны Худалдааг тэлж өргөжүүлэх тухай хуульд заасан байдаг заалт. Мөн тэг-байвал-тэг болгож тарифыг бууруулахыг (zero-for-zero tariff reductions) үзнэ үү.</p>
386	Double ecart formula	<p>Давхар ялгаатай томьёо. Энэ нь Кеннедигийн үе шатны хэлэлцээний үеэр Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС) зүгээс санал болгосон шугаман тарифын хэлэлцээнд зориулж гаргасан томьёо. Энэ нь ялангуяа ЕЕС, Япон, Их Британи, АНУ зэрэг гол оролцогчид болох улсуудын тарифын хувь хэмжээний томоохон зөрүү, ялгааг тодорхойлоход тулгуурласан. Энэ томьёоны дагуу, харьцуулж буй тарифуудын хоорондын харьцаа нь 2:1-ээс их байгаа бол тарифын хувь хэмжээг харьцуулшгүй ялгаатай гэж үзнэ. Үүнийг зөвхөн, хэрэв ялгаа нь хамгийн багадаа 10%-ийн оноогоор үнэлэгдэх үнийн дүнгээс хувиар тогтоох тарифын хэмжээтэй байсан тохиолдолд л хэрэглэх байсан.</p> <p>Барааны үнийн дүнгээс хувиар тооцох тариф (ad valorem tariffs), үнийн хэмжээнд албан ёсны хязгаар тогтоох бодлого (ecretement), тарифын хэлэлцээ (tariff negotiations), гучарвын томьёог (thirty-ten formula) үзнэ үү.</p>
387	Double pricing	<p>Давхар үнэ тогтоох. Энэ нь дотоодын түүхий эд боловсруулагчид болон үйлдвэрлэгчид түүхий эдийг экспортын зах зээлд борлуулснаас хямд үнээр худалдан авах боломжийг баталгаажуулах практик туршлага. Энэхүү зорилтыг экспортын квот, экспортын тариф болон ижил төстэй зорилготой бусад арга хэмжээнүүдийн тусламжтайгаар хэрэгжүүлж болно.</p>
388	Double-zero reductions	<p>Давхар тэг болгож бууруулах. Мөн тэг-байвал-тэг болгож тарифыг бууруулахыг (zero-for-zero tariff reductions) үзнэ үү.</p>
389	Downstream dumping	<p>Нэмүү өртгийн сүлжээний адагт демпинг хийх. Бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг эх орондоо үйлдвэрлэгч компанид бүтэн үнээс нь арай бага үнээр борлуулах практик туршлагад өгсөн нэршил. Дараа нь энэхүү үйлдвэрлэгч нь тухайн бүрэлдэхүүн хэсгийг өөрчлөн хувиргаж эсвэл үүнийг өөр бүтээгдэхүүнд нэгтгэн уялдуулснаараа экспортын зах зээл дээр үнийн давуу талыг олж авдаг.</p> <p>Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), демпинг (dumping) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
390	Draft International Agreement on Illicit Payments	Хууль бус төлбөрийн тухай олон улсын хэлэлцээрийн төсөл. 1979 онд НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийн (ECOSOC) ивээл дор боловсруулан гаргасан эрх зүйн акт боловч НҮБ-ын Ерөнхий зөвлөл үүнийг хүлээн зөвшөөрөөгүй. Энэ нь үндэсний хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шийдэх байсан. Үүнд (a) олон улсын арилжаа наймааны хэлэлцээтэй холбогдолтойгоор аливаа төрийн албан хаагчид түүний үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор хээл хахууль өгөх, (b) мөн ижил ийм зорилгоор аливаа төрийн албан хаагч хээл хахууль авах хүсэлт гаргах. Үүнд элсэж орсон гишүүн улс бүрээс энэ нь эрүүгийн зохих шийтгэл олгох тогтолцоог бий болгохыг шаардах байлаа. Мөн Олон улсын бизнесийн хэлцлүүд дэх Гадаадын төрийн албан хаагчдын авлига, хээл хахуультай тэмцэх тухай конвенц (Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions), Худалдаа ба хууль бус төлбөрийг (trade and illicit payments) үзнэ үү.
391	Draft International Antitrust Code	Олон улсын монополийн эсрэг хуулийн эмхэтгэлийн төсөл. Үүнийг арван хоёр эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Олон улсын монополийн эсрэг хуулийн эмхэтгэлийн ажлын хэсгээс 1993 онд гаргасан. Ажлын хэсгийн арга барилыг зохицуулсан дөрвөн зарчим бий: (a) олон улсын өрсөлдөөний асуудлыг шийдвэрлэхэд үндэсний хууль тогтоомжийг ашиглах, (b) үндэсний нөхцөл нь гэрээний тал тус бүрд нийцэж байх ёстой, (c) үндэсний монополийн эсрэг дүрмийн хамгийн бага, наад захын стандартыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой, (d) Монополийн эсрэг олон улсын эрх бүхий байгууллага байгуулах ёстой. Ажлын хэсэг мөн ДХБ-ын хүрээнд олон талт хэлэлцээр болж орох Хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж санал болгосон байна. Хуулийн төсөл нь засгийн газар хоорондын ямар нэгэн хэлэлцүүлэгт зориулж хангалттай хэмжээний олон улсын дэмжлэгийг хараахан татаж чадаагүй байна. Мөн Монополийн эсрэг (antitrust laws), өрсөлдөөний бодлого (competition policy), худалдаа ба өрсөлдөөнийг (trade and competition) үзнэ үү.
392	Draft International Code of Conduct on the Transfer of Technology	Технологи шилжүүлэх тухай олон улсын ёс зүйн дүрэм, хэм хэмжээний төсөл (эрх зүйн акт, эрх зүйн хэм хэмжээ). Энэхүү эрх зүйн актыг НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) хэлэлцээний хүрээнд 1976-1985 оны хооронд хэлэлцэж байжээ. Төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн актын төслийн зорилго нь технологи дамжуулах асуудалд оролцож буй талуудын үйл ажиллагаанд зориулсан ерөнхий ба тэгш хүртээмжтэй байх стандарт хэм хэмжээг тогтоох явдал байв. Уг хэлэлцээг түдгэлзүүлэх үед ихээхэн ялгаатай байдал хэвээр үлдсэн байдаг. Одоогоор хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх төлөвлөгөө байхгүй байна.
393	Drawback	Буцаан олголт. Тухайн бараа бүтээгдэхүүнийг импортлоод дараа нь боловсруулсан хэлбэрээр эсвэл өөр бусад бүтээгдэхүүнд уялдуулж нэгтгэснийх нь дараа буцаан-экспортлож байгаа бол тухайн бараанд ногдуулсан гаалийн, борлуулалтын, онцгой албан татваруудыг буцаан олгох практик туршлага. Мөн хилийн татварын зохицуулалтыг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
394	Dual pricing	Хоёрдмол үнэ тогтоох. Дотоод уу эсвэл экспортын зах зээлд борлуулагдаж байна уу гэдгээс хамаараад улс орнууд тухайн бүтээгдэхүүндээ өөр өөр үнэ тогтоох практик туршлага байдаг. Үүнийг мөн хоёрдмол үнэ тогтоох гэдэг.
395	Dual purpose exports	Хоёрдмол хэрэглээний зориулалттай экспорт. Иргэний болон цэргийн зориулалтаар ашиглахад тохиромжтой бараа, үйлчилгээ, технологийн худалдаа. Илт иргэний массыг хамарсан зах зээлд тодорхой бүтээгдэхүүнийг, тухайлбал сүүлийн үеийн дэвшилтэт хувь хүний хэрэглээний компьютер зэрэг бүтээгдэхүүнийг цэргийн зориулалтаар ашиглах боломжтой эсэх асуудлын цар хүрээнд санал зөрөлдөөн гарч болзошгүй юм. Тухайн үеийн чухал стратегийн балансын талаарх ойлголтоос их зүйл хамаардаг. Мөн Экспортын олон талт хяналтыг зохицуулах хороо (COCOM), стратегийн экспорт (strategic exports), Ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологийн экспортын хяналтын талаарх Вассенаарын хэлэлцээрийг (Wassenaar Arrangement on Export Controls for Conventional Arms and Dual-Use Goods and Technologies) үзнэ үү.
396	Dual-use products	Хос хэрэглээний зориулалттай бүтээгдэхүүнүүд. Нэг болон түүнээс дээш тооны зорилгоор хэрэглэгдэж болох бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ. Үүний гол санааг харуулж болох нэг жишээ гэвэл, хэлэлцээний үе шатнаас авхуулаад Мэдээллийн технологийн хэлэлцээрт хүрсэн тохиолдол бий. Зарим хүмүүсийн хэлдгээр тодорхой нэг төрлийн цавууг зөвхөн компьютерын эх хавтанг үйлдвэрлэхэд л ашигласан гэдэг боловч, бусад хүмүүсийн ярьж байгаагаар цавуу гэдэг бол химийн бодис, тийм учраас мэдээллийн технологийн бүтээгдэхүүн биш юм гэдэг. Тэгэхээр хос хэрэглээтэй бүтээгдэхүүний тухай асуудал нь гол төлөв салбарын хүрээг хамарсан худалдааны яриа хэлэлцээний үеэр, жишээ нь Ази Номхон Далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас хөхиүлэн дэмждэг Салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх яриа хэлэлцээний үеэр гарч ирдэг байна.
397	Dumping	Демпинг. Энэ нь тухайн компани/аж ахуйн нэгж нь дотоодын зах зээлд борлуулдаг ердийн үнээс доогуур үнээр бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд борлуулдаг практик туршлагыг хэлдэг. Демпингийн эсрэг татвар болон Татаасны эсрэг нөхөн тэгшитгэх татварын асуудлыг тусгасан ТХЕХ-ийн 6-р Зүйл нь үнэндээ демпингийн үйл ажиллагааг хориглодоггүй. Энэхүү зүйлд ёс төдий заасан зүйл гэвэл, хэрэв демпинг нь өөр нэгэн гишүүн орны нутаг дэвсгэр дээр барьж байгуулагдсан аж үйлдвэрт нь материаллаг хохирол учруулж байвал эсвэл учруулах аюултай байгаа бол эсвэл дотоодын аж үйлдвэр байгуулах үйл ажиллагааг сааруулсан бол ТХЕХ-ийн талууд уг демпингийг буруутгана гэдгээ хүлээн зөвшөөрнө гэсэн байдаг. Хэрэв импортлогч орноос гаргасан лавлагаа хүсэлт нь демпинг хийгдсэн бөгөөд аж үйлдвэрт нь материаллаг хохирол учруулсан болохыг харуулж байгаа бол, засгийн газрууд демпингийн эсрэг арга хэмжээ авч болно.

Харьцуулах үндэслэл нь ихэвчлэн, экспортлогч улс дах үйлдвэрийн өмнөх үнэ болон бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрээс гарсны дараа нь үүсэж бий болсон тээврийн зардал болон бусад зардлыг хассан байдлаар авч үзэх, худалдааны хэлцлийн үнэ буюу импортлогч улсын хил дээрх үнэ хоёр юм. Гэсэн хэдий ч зарим нь дотоодын зах зээлийн үнээс доогуур үнээр хийсэн борлуулалтыг зардлаас доогуур үнээр хийсэн борлуулалттай адилтгаж үздэг байна. Энэ тайлбар нь хатуухан хэлэхэд буруу. Демпингийг татаасны төлбөрийн ачаар үр ашиг хүртсэн импортын бүтээгдэхүүнтэй андуурч төөрөгдөх тохиолдол ч байдаг. Худалдааны бодлогын зорилгоор, демпингийг ялгаварлан гадуурхсан үнийн зохицуулалт хийхийн зарим давуу талыг олж харсан бие даасан хувьцаат компаниудын үйл ажиллагаа гэж үздэг бөгөөд тэд үүнийгээ өөрсдийн эх үүсвэрээс санхүүжүүлдэг байна. Нөгөө талаар татаас гэдэг нь засгийн газрын зүгээс үйлдвэрүүдэд шууд болон шууд бус замаар төлдөг төлбөр гэж үздэг. Импортлогч зах зээлийн хувьд, татаасны дэмжлэгтэй болон демпинг хийсэн бүтээгдэхүүний нөлөөлөл нь мэдээж хэрэг адилхан байж болно. Тайлбарлагчид, демпингийн талаарх илт энгийн агуулга нь түүнийг практик амьдрал дээрх хэрэглээний талаар олон тооны маргаанд хүргэсэн гэж онцлох зуршилтай байдаг. Дээрх хоёр үнийг энгийн хэлбэрээр харьцуулах бараг боломжгүй байдаг, учир нь компанийн үнэ тогтоох болон нягтлан бодох бүртгэлийн механизм нь маш бүрхэг байдаг учраас түүний зардлын тогтолцооны талаар ямар нэгэн утга учиртай ойлголт авах боломжийг хязгаарлаж байдаг. Нөгөө талаар экспортолсон бүтээгдэхүүн нь дотоодын зах зээл дээр огт зарагддаггүй эсвэл зөвхөн багахан хэмжээгээр борлуулагддаг учраас харьцуулалт хийх боломжгүй байдаг.

Ямар ч тохиолдолд, худалдааны бодлогын цөөн хэдэн сэдвийг тойрсон оновчтой дүн шинжилгээ байх байтал, үүнийг сэтгэл хөдлөлөөр дүүрэн хүрээлж байх нь бий. Энэ сэдвээр бичсэн судалгааны ажлууд маш их тоогоор байна. Урт удаан хугацаанд демпингийг худалдааны асуудал гэж үзэж ирсэн байдаг боловч энэ нь зөвхөн Дэлхийн I дайны дараа, ялангуяа 1930-аад оны Их хямралын үеэр л томоохон худалдааны бодлогын асуудал болон хувирсан байдаг. Гаванагийн дүрмийг батлахаар хийгдэж байсан хэлэлцээний үеэр оролцогчид демпингийн дөрвөн том ангиллыг тодорхойлсон байна, үүнд: (a) эцсийн дүндээ ТХЕХ-ийн 6-р Зүйлд биеллээ олсон үнийн демпинг гэж байна, (b) үйлчилгээний демпинг гэж бий, үүнд ачаа тээврийн үйлчилгээний нөхцөлд демпинг хийгдэж байдаг учраас тухайн бүтээгдэхүүний хувьд үнийн давуу тал бий болж ирдэг, (c) валютын ханшийн демпинг, өрсөлдөх чадвартай болохын тулд валютын ханшийг залилан өөрчлөх үйлдэлд тулгуурладаг, (d) нийгмийн чанартай демпинг, шоронгийн хоригдлуудын хийсэн эсвэл муу нөхцөлд, бага цалингаар, хүнд нөхцөлд үйлдвэрлэж гаргасан бага үнэтэй бүтээгдэхүүний импортын улмаас үүсдэг байна. Мөн Хуулиас гадуур тойрч гарахын эсрэг арга хэмжээ (anti-circumvention), Хуулиас гадуур тойрч гарах (circumvention), Де-минимис буюу үлэмж бага хэмжээний демпингийн зөрүү (de minimis dumping margins), Тасралтгүй хийгдэж буй демпингийн тухай заалтыг (Persistent Dumping Clause) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
398	Dutiable goods	Татвар ногдуулах бараа бүтээгдэхүүн. Гаалийн нутаг дэвсгэрт орох, гарахад гаалийн татвар ногдуулдаг бараа, бүтээгдэхүүн.
399	Duty	[Үүрэг ногдуулсан] татвар. Энэ нь засгийн газрын зүгээс бүрэн эрх мэдлийнхээ хүрээнд үйлдвэрлэл, арилжааны гүйлгээнүүд, бага давтамжтай байдаг ч өмчийн эзэмшил зэрэгт ногдуулж байдаг хураамж, татвар эсвэл гаалийн хураамж. Ногдуулсан татварын хэмжээ нь гол төлөв арилжааны хэлцлийн үнийн дүнтэй холбогдолтой байдаг. Импорт болон экспортын тарифын дагуу ногдуулдаг гаалийн татварууд нь тийм төлбөрийн үүргүүдийн дэд хэсэг нь. Эдгээрийг хил дээр ногдуулдаг. ДХБ-ын шаардлагуудын нэг бол, хилээр хууль ёсны дагуу орж ирсэн л бол уг импортын бүтээгдэхүүний эсрэг ялгаварлан гадуурхах замаар татварыг ашиглах ёсгүй гэж заадаг. Нэгэн цагт байсан үүрэг ногдуулсан татвар (duty) болон татвар (tax) хоёрын ямарваа утга зүйн хувьд тодорхой байсан ялгаа нь одоо өдөр тутмын хэрэглээнд нэлээд бүдгэрч ирсэн байна. Эдийн засагчдын хувьд, энэ хоёрын үзүүлж буй нөлөөлөл нь ижил боловч хуульч болон татварын эрх бүхий албаныхны хувьд ялгаа нь чухал үр дагавартай байж болох юм. Мөн ЛернеФс-ийн тэгш хэмийн онолыг (LerneFs symmetry theory) үзнэ үү.
400	Duty drawback	Гаалийн татварын буцаан олголт. Мөн хилийн татварын зохицуулалтуудыг (border tax adjustment) үзнэ үү.
401	Dynamic comparative advantage	Динамик харьцангуй давуу тал. Мөн харьцангуй давуу талыг (comparative advantage) үзнэ үү.
402	Dynamic non-member market economy	Гишүүн бус орны динамик зах зээлийн эдийн засаг (DNME). Эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн бус орнуудын эдийн засгийн утгыг илэрхийлэхэд ЭЗХАХБ -ын хэрэглэдэг нэр томьёо. ЭЗХАХБ нь Хонконг, Малайз, Сингапур, Тайвань, Тайланд улстай албан ёсны яриа хэлэлцээ хийсэн боловч мөн Хятад, Энэтхэг, Индонези, Латин Америкийн гол орнуудтай мөн харилцаа холбоо тогтоосон байжээ.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
403	EAEC	<p>Зүүн Азийн Эдийн засгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зөвлөлдөх бүлэг. 1990-ээд оны эхээр Малайз улсаас санал болгосон зөвлөлдөх бүлэг бөгөөд хэрэг хэрэгжвэл энэ нь Зүүн Азийн улс орнуудаас бүрдэх байсан. Мөн АСЕАН+3: Хятад, Япон, Бүгд Найрамдах Солонгос улсыг (ASEAN+3: the ASEAN countries plus China, Japan and the Republic of Korea) үзнэ үү.</p>
404	Early harvest	<p>Эрт ургац. Хэлэлцэж тохиролцсон үр дүнгийн хувьд түншүүдийн хооронд байгуулах хэлэлцээрт ерөнхийдөө хэрэглэдэг нэршил бөгөөд үүнд өөрсдийнх нь тогтоосон зорилтуудыг анх товлож байснаас нь эрт эсвэл хэлцлүүдийнх нь албан ёсны дүгнэлт гарахыг хүлээлгүйгээр аль нэгэн түвшинд дэвшүүлэн тавьж эсвэл хэрэгжүүлдэг байна.</p>
405	Early Voluntary Sectoral Liberalisation	<p>Салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх (EVSL). АПЕК-ийн худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах ажлын хөтөлбөрийн нэг хэсэг. Үүнийг анх 1996 оны 11-р сард Филиппинийн Субик хотод болсон АПЕК-ийн Эдийн засгийн удирдагчдын 9-р уулзалтын үеэр санаачилсан. Энэхүү уулзалтын үед АПЕК-ийн бие даасан гишүүн улсын эдийн засагт болон бүс нутгийн хэмжээнд эерэг нөлөө үзүүлж болох сайн дурын эрт үеийн либералчлал хийж болох салбаруудыг олж тодорхойлохыг худалдааны сайд нарт үүрэг болгов. Үүнд зориулж анх 41 салбарыг санал болгосон ба үүнээс цаашдын арга хэмжээ авах 15-ыг нь 1997 оны 11-р сард Ванкувер хотод болсон АПЕК-ийн сайд нарын уулзалтаар баталсан байна. Тэгээд үүнээс 1999 онд хэрэгжүүлэх 9 салбарыг нь сонгосон ба үүнд: байгаль орчны бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээ, эрчим хүчний салбар, загас ба загасан бүтээгдэхүүн, тоглоом, ойн гаралтай бүтээгдэхүүн, үнэт чулуу ба үнэт эдлэл, эмнэлгийн хэрэгсэл ба багаж төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, харилцаа холбооны салбарын хувьд харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалтууд багтсан байдаг. Нэмэлт бэлтгэл ажлыг үлдсэн 6 салбаруудад хийжээ: байгаль орчны бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээ, байгалийн болон синтетик резин, бордоо, автомашин, тослог ургамлын үр ба уг үрээр хийсэн бүтээгдэхүүн, иргэний нисэхийн онгоц зэрэг болно. Либералчлалын цар хүрээ нь тарифын болон тарифын бус хэмжигдэхүүнээс гадна худалдааг хөнгөвчлөх, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны элементүүдийг багтаасан байдаг. Зарим орнууд бүх 9 салбарыг либералчлах үүрэг амлалт авах шаардлагагүй гэж үзсэн учраас, EVSL нь АПЕК-ийн хувьд нэлээд хэрүүл маргаан үүсгэдэг хэсэг нь болсон байна. Эдгээр орнууд сайн дурын зарчим дээр тулгуурлан өөрсдийн байр сууриа хамгаалсан байна. 1998 оны 11-р сард АПЕК-ийн сайд нар уг санаачилгыг тарифын хурдасгасан либералчлал гэж нэртэй хэлбэр лүү шилжүүлж, үүнийгээ цаашдын ажилдаа зориулан ДХБ-д хүргүүлсэн байна. Мөн Гишүүн орон тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг (individual action plans) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
406	East African Cooperation	<p>Зүүн Африкийн хамтын ажиллагаа (ЕАС). Дорно ба Өмнөд Африкийн нэгдсэн зах зээл дэх энэхүү механизм нь 1996 онд байгуулагдсан. Энэ нь худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын илүү хурдацтай хэмнэлийг хөхиүлэн дэмжихийг зорьдог боловч үүний илүү урт хугацааны зорилтууд нь гаалийн холбоо болон Зүүн Африкийн холбоог байгуулах явдал байлаа. Эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн чиглэл бол төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах, худалдаа, аж үйлдвэр, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, хөдөө аж ахуй, мал аж ахуй, байгаль орчин, байгалийн нөөц, аялал жуулчлал, зэрлэг ан амьтныг хамгаалах зэрэг асуудал юм. Түүнчлэн улс төрийн асуудал, цагаачлал, хууль, шударга ёс, аюулгүй байдлын чиглэлээр хамтын ажиллагаа өрнөж байна. Зүүн Африкийн хамтын ажиллагаа нь мөн хувийн хэвшлийнхний сонирхлыг хөхиүлэн дэмжихийг мөн зорьж байна. ЕАС-ийг бүрдүүлдэг гурван түнш бол Кени, Танзани, Уганда юм.</p>
407	East Caribbean Common Market	<p>Зүүн Карибын тэнгисийн орнуудын нэгдсэн зах зээл. Зүүн Карибын орнуудын байгууллагыг (Organisation of Eastern Caribbean States) үзнэ үү.</p>
408	East-South trade	<p>Дорно (зүүн) ба Өмнөд бүсийн худалдаа. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл буюу COMECON-ийн гишүүн орнууд болон хөгжиж буй орнуудын хоорондын худалдааг тайлбарласан байдаг. Энэ нэр томьёо одоо энэ утгаараа хэрэглэгдэхээ больсон байна.</p>
409	East-West trade	<p>Дорно (зүүн) ба Өрнө (баруун) бүсийн худалдаа. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) болон Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл буюу COMECON-ийн гишүүн орнуудын хооронд хийгдэж буй худалдааг тайлбарлаж байдаг. Энэ нь COMECON-ийн гишүүн орнуудын валютын хөрвөх боломжгүй байдал болон технологи дамжуулалтаас ихэнхдээ үүдэлтэй онцгой асуудлыг үүсгэсэн байдаг. Одоо энэ нэр томьёо нь анхны утгаараа хэрэглэгдэхээ больсон боловч зарим нь Зүүн ба Баруун Европын хооронд худалдаа хийхдээ ашигласаар байгаа ажээ.</p>
410	ECAFE	<p>Ази болон Алс Зүүн бүсийн Эдийн засгийн хороо (Economic Commission for Asia and the Far East). Мөн НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссыг (UN-ESCAP) үзнэ үү.</p>
411	ECDC	<p>Хөгжиж буй орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа. Хамтын үйл ажиллагаагаар дамжуулан, хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийг ахиулахад гол төлөв чиглэж ажилладаг механизм юм. Мөн Худалдаа ба хөгжлийн хороо (Committee on Trade and Development), Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн системийг (Global System of Trade Preferences - GSTP) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
412	Eclectic theory of international investment	Олон улсын хөрөнгө оруулалтын эклектик (хутгамал үзэлтний) онол. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын онол нь өмчлөл, байршил, шингээн тогтоож авахын давуу талуудыг тодорхойлох хэлбэрээр хөрөнгө оруулалтын шийдвэр гардаг, мөн эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэг нь харилцан үйлчлэлцэж байдаг гэж үздэг. Юуны өмнө, шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагчдад хөрөнгийг хянах боломжийг олгодог. Хоёрдугаарт, энэ нь компанийн зорилготой хамгийн сайн нийцсэн үйлдвэрлэлийн байгууламжийн байршлыг сонгох боломжийг хөрөнгө оруулагчдад олгосон байна. Гуравдугаарт, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагч компанид одоогоор байгаа өөрийн оюуны өмчийн капиталыг хамгийн шалгарсан аргаар ашиглах боломжийг олгодог байна.
413	Eco-dumping	Эко шинж чанартай демпинг. Байгаль орчны стандартад нийцэхгүй нөхцөл дор үйлдвэрлэсэн экспортод зориулсан бараа бүтээгдэхүүний тухай ярихад хэрэглэгддэг нэр томьёо. Гэхдээ худалдааны бодлого боловсруулахад зохих байр суурь эзэлж чаддаггүй. Илүү хатуу нөхцөл мөрдөгдөж байдаг экспортын зах зээлд үйлдвэрлэгч нарт зардлын давуу талыг олгохын тулд, зарим хүрээнийхний хувьд авч үздэг практик туршлага. Байгаль орчны эрх зүйн зохицуулалттай уялдуулж болох үйлдвэрлэлийн зардал гэдэг нь үйлдвэрлэлийн бусад зардлууд гэхээс илүү нийт зардлын хувьд маш жижиг хүчин зүйл болж хувирсан байна.
414	Eco-duties	Эко шинж чанартай татвар. Байгаль орчны стандартын шаардлага хангаагүй үйлдвэрлэлийн хямд өртөгтэй, шударга бус өрсөлдөөний давуу талыг олсон импортын бүтээгдэхүүнд ногдуулахаар санал болгосон татвар. Үүнийг протекционист буюу хамгаалалтын үзлийг баримтлагчийн арга хэрэгсэл болгож буруу ашиглах ихээхэн боломжтой, маргаантай асуудал гэж үздэг. Мөн эко шинж чанартай демпинг (eco-dumping), худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
415	Eco-labelling	Эко шинж чанартай шошгожуулалт. Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжиж, бусад бүтээгдэхүүнээс илүүтэйгээр эдгээр бүтээгдэхүүнийг худалдан авч буй хэрэглэгчдийг хөхиүлэн дэмжих зорилгоор боловсруулж гаргасан, зах зээлийн сайн дурын механизм. Энд худалдааны бодлогын хувьд санаа зовоосон асуудал нь зөвхөн импортлогч орны байгаль орчныг эрхэмлэх байдлыг тусгасан, импортын эсрэг ялгаварлан гадуурхдаг, аж үйлдвэрлэлтэй холбоотой шалгуурыг тэд агуулж болох явдал. Мөн Эко шинж чанартай татварууд (eco-duties), генетикийн шинж чанартай шошгожуулалт (genetic labelling), нийгмийн шинж чанартай шошгожуулалт (social labelling), худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
416	Economic and Social Commission for the Asia-Pacific	НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс. ESCAP-ийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
417	Economic and Social Commission for Western Asia	Баруун Азийн Эдийн засаг, нийгмийн хороо (ESCWA). Анх 1973 онд Баруун Азийн Эдийн засгийн хороо гэж нэртэйгээр байгуулагдсан ба үүнд өнөөгийн нэрийг нь 1985 онд өгсөн байдаг. Энэ нь НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн хороонуудын нэг. Энэ нь өөрийн гишүүн улс орнуудын эдийн засгийн сайн сайхныг болон тэдгээрийн өөр хоорондын эдийн засгийн харилцааг сайжруулахыг эрмэлздэг. Нарийн бичгийн дарга нарын газар нь Амманд байрладаг.
418	Economic Commission for Africa	Африкийн Эдийн засгийн хороо (ECA). НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн хороонуудын нэг. 1958 онд байгуулагдсан. Африкийн улс орнуудад эдийн засгийн дэвшлийг сурталчлан таниулах зорилготой. Нарийн бичгийн дарга нарын газар нь Аддис-Абба-д байрладаг.
419	Economic Commission for Europe	Европын эдийн засгийн хороо. НҮБ-ын Европын эдийн засгийн хороо (UN-ECE). НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн хороодын нэг. Энэ нь 1947 онд байгуулагдсан. Энэ нь ялангуяа олон улсын худалдаа болон ерөнхийдөө худалдааг хөнгөвчлөхөд нөлөөлөх стандарт хэм хэмжээний талаар маш ашигтай ажлуудыг хийсэн. Нарийн бичгийн дарга нарын газар нь Женев хотод байрладаг.
420	Economic Commission for Latin America and the Caribbean	Латин Америк ба Карибын тэнгисийн эдийн засгийн хороо (ECLAC). НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн хороодын нэг. Үүнийг 1948 онд Латин Америкийн Эдийн засгийн хороо (ECLA) гэж нэртэйгээр байгуулагдаж байсан ба 1985 онд өнөөгийнхөө нэртэй болсон. Энэ нь Латин Америкийн орнуудын эдийн засгийн ахиц дэвшлийг хөхиүлэн дэмжих зорилготой. Нарийн бичгийн дарга нарын газар нь Рио-де-Жанейро хотод байрладаг.
421	Economic-complementarity agreements	Эдийн засгийн хувьд харилцан бие биеэ нөхсөн хэлэлцээрүүд. Хэсэгчилсэн хамрах хүрээ бүхий худалдааны хэлэлцээрүүдийн өөр нэгэн нэр бөгөөд салбарын чөлөөт худалдааны талбаруудын талаар Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дор хөгжиж буй орнууд заримдаа хэлцдэг байна.
422	Economic Cooperation Area of Black Sea Countries	Хар Тэнгисийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (ECABS). Энэ нь 1992 онд байгуулагдсан бөгөөд үүнд Армени, Азербайжан, Болгар, Грек, Румын, Орос, Турк, Украин орно.
423	Economic Cooperation Organisation	Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ECO). Өөрийн гишүүн улс орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих үүднээс 1985 онд анх байгуулагдаж байсан ба тухайн үед Иран, Пакистан, Турк зэрэг орнууд гишүүн байсан байна. 1992 оноос хойших ECO-гийн гишүүн орнууд нь Афганистан, Азербайжан, Иран, Казахстан, Киргизстан, Пакистан, Тажикистан, Турк, Туркменистан, Узбекистан юм. Худалдаа ба гааль, зам тээвэр ба харилцаа холбоо, мөнгө ба санхүү нь түүний ажлын хөтөлбөрийн гол хэсгийг бүрдүүлж байдаг. Нарийн бичгийн дарга нарын газар нь Тегеранд байрладаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
424	Economic impact criterion	<p>Эдийн засгийн нөлөөллийн шалгуур. Дотоодод авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь үндэсний нөхцөлийг гажуудуулж байгаа эсэхийг үнэлж дүгнэх зорилгоор, ТХЕХ-т хэрэглэхийг заримдаа зөвлөдөг шалгалт. Энэхүү шалгуурын дор, үндэсний нөхцөлийн үүрэг амлалтыг зөрчсөн гэсэн нотлох баримтыг худалдааны өөрчлөгдөж байгаа урсгалаас олох шаардлагатай болно. Энэ нь практик туршлагын хувьд олон бэрхшээлийг дагуулж болзошгүй юм, учир нь аливаа өгөгдсөн цаг мөчид тодорхой нэг төрлийн бүтээгдэхүүнийг нэг улс яагаад импортлосон талаар хэд хэдэн учир шалтгаан байсан байж болох юм. ТХЕХ-ийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөл нь (GATT dispute settlement panels) өрсөлдөөний боломжийн эрх тэгш байдал байгаа эсэхийг үнэлэх шалгалтын төлөөх энэхүү шалгуурыг ашиглахаас татгалзсан байна.</p>
425	Economic integration	<p>Эдийн засгийн хамтын ажиллагаа/интеграцчилал. Энэхүү үйл явцаар дамжуулан улс орнууд олон улсын үйл ажиллагаанд хамтран ажилладаг байна. Өөртөө засах засаглалтай орнуудаас бусад бүх улс орнууд үүнд оролцож байгаа боловч, уг нэр томьёо нь, өөрсдийн үйл ажиллагааг бусад орнуудтай гэхээс илүү өөр хоорондоо илүү хурдан уялдуулахаар тунхагласан орнуудын бүлгүүдэд зориулагдсан байдаг. Зах зээлээр удирдуулсан интеграцчилал (засгийн газрын албан ёсны оролцоогүйгээр аяндаа интеграцчилагдах) ба бодлогоор удирдуулсан интеграци (засгийн газар хоорондын албан ёсны бүтэц, тогтолцоонд үр нөлөө үзүүлэхэд суурилсан интеграци)-ийг хооронд нь ялгаж үзэх нь түгээмэл байдаг. Өөр нэг ялгаа нь гүехэн ба гүн гүнзгий интеграциуд. Гүехэн интеграци нь жишээлбэл, эдийн засгийн бодлогоо боловсруулахад гишүүн тус бүр бие даасан байдлаа хадгалсан, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулахтай холбоотой. Гүн гүнзгий интеграци нь нэгдсэн зах зээлд байдаг бодит тохиолдлуудтай адил, өрсөлдөөний тухай хууль, мөнгөний болон санхүүгийн бодлогууд, стандартууд, бусад эрх зүйн зохицуулалт гэх мэт асуудлуудыг уялдуулах эсвэл хамтын ажиллагааны утгыг илэрхийлж байдаг.</p>
426	Economic integration agreements	<p>Эдийн засгийн хамтын ажиллагааны/интеграцчиллын хэлэлцээр. Энэ нь үйлчилгээний салбар дах чөлөөт худалдааны зохицуулалтыг хамрах үүднээс Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) 5-р Зүйлд хэрэглэдэг нэр томьёо. Үйлчилгээний салбар дах чөлөөт худалдаа нь импортлогч оронд худалдааны бие төлөөлөл/төлөөлөгчийн газар байгуулах боломж болон үйлчилгээний хэрэглэгч болон үйлдвэрлэгчдийн чөлөөт хөдөлгөөнийг шаарддаг учраас энэхүү нэр томьёог сонгосон байна. Бараа бүтээгдэхүүний чөлөөт худалдааны нөхцөлийн дагуу буй болж болох эдийн засгийн интеграцитай харьцуулахад, үүнд эдийн засгийн илүү их интеграцийг хамардаг гэж үздэг байна. Эдийн засгийн интеграцийн хэлэлцээрүүд нь ихээхэн хэмжээний салбарын хүрээг хамарсан байх ёстой бөгөөд өөрийн гишүүд хооронд бүхий л төрлийн ялгаварлан гадуурхалтыг ихээхэн хэмжээгээр бууруулах эсвэл бүрмөсөн арилгах ёстой гэж үздэг. Мөн чөлөөт худалдааны бүс (free-trade areas), үйлчилгээний худалдааг (trade in services) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
427	Economic international commodity agreements	Эдийн эдийн засгийн хувьд ашигтай олон улсын түүхий эд, материалын хэлэлцээр. Эдгээр нь, зах зээлд нэвтрүүлэх бараа түүхий эдийн хэмжээг, нарийн төвөгтэй арга заль хэрэглэдэг нөөц түүхий эд, материал (buffer stocks), экспортын квот, бусад арга хэмжээг ашиглах замаар үнэд нөлөөлөхийг эрэлхийлдэг, олон улсын түүхий эдийн тухай хэлэлцээр. Мөн Захиргааны зохицуулалттай олон улсын түүхий эд, материалын хэлэлцээрийг (administrative international commodity agreements) үзнэ үү.
428	Economic nationalism	Эдийн засгийн үндсэрхэг үзэл. Мөн гуйлгачин хөршийн бодлогууд (beggar-thy-neighbour policies), Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism), нийлбэр нь тэг буюу ямар нэгэн эцсийн ялагч үгүй үндсэрхэг үзэл (zero-sum nationalism)-ийг үзнэ үү.
429	Economic needs test	Эдийн засгийн эрэлт хэрэгцээг нотлох шалгалт. Гадаадын, заримдаа дотоодын зах зээл, фирмүүдэд нэвтрэх нь эдийн засгийн үндэслэлээр батлагдах эсэхийг шийдэхийн тулд, засгийн газар, аж үйлдвэр эсвэл мэргэжлийн холбоодын зүгээс хянаж, хэрэгжүүлж байдаг механизм. Ийм механизмууд нь ихэвчлэн тунгалаг байдаггүй. Тэдгээр нь мөн асуудалд өөрсдийн үзэмжээр хандаж, протекционист нөлөөтэй ч байж байж болох юм. Заримдаа эдийн засгийн эрэлт хэрэгцээг нотлохдоо хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор шалгалт хийдэг боловч тэдгээр хэрэглэгчдээс зах зээл дээрх нэмэлт өрсөлдөөн бий болохыг харахыг хүсэж байгаа эсэхийг ихэнх тохиолдолд асуудаггүй. ТХЕХ-ийн 16-р Зүйлд зах зээлд нэвтрэх хүртээмжийн дүрмийг тодорхойлсон байдаг нь, эдийн засгийн эрэлт хэрэгцээг нотлох шалгалт нь хуульд харш гэж заасан байдаг байна.
430	Economic sanctions	Эдийн засгийн хориг арга хэмжээ. Засгийн газруудын зүгээс гадаад бодлогынхоо зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд заримдаа эдийн засгийн болон арилжааны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг байна. Эдгээр арга хэмжээнд худалдааны хориг, хөрөнгө оруулалтын хязгаарлалтууд эсвэл хориг, аяллын хязгаарлалтууд зэрэг зүйлс багтдаг. Эдгээр арга хэмжээнүүдийг НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс хамгийн нийтлэг авч хэрэгжүүлсэн байдаг. Удаан хугацааны туршид тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээндээ Хуфбауэр ба түүний нөхөд дүгнэхдээ, хориг арга хэмжээ нь “хэзээ ч ажиллахгүй” гэж хэлэх нь худлаа юм гэжээ (“Эдийн засгийн хориг арга хэмжээг дахин авч үзсэн нь: Түүх ба өнөө цаг үеийн бодлого”). Харин үүний оронд тэд хориг саадыг авч үзэхдээ, зорилтот орнуудын хувьд эсэргүүцэхээр шийдсэн байсан тэрхүү арга хэмжээг авахыг албадахаас хамааралтай байдаг гадаад худалдааны бодлогын зорилгодоо хүрэхийн хувьд бол хязгаарлагдмал ашиг тустай байдаг гэжээ. Гэсэн хэдий ч, жижиг зорилтот орнууд болон харьцангуй даруухан бодлогын зорилгуудын хувьд тэдний үзэж буйгаар бол хориг арга хэмжээ нь зан үйлийн хувьд өөрчлөлт авчирсан ажээ. Мөн Аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх нөхцөл (security exceptions) болон хариу арга хэмжээг (retaliation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
431	Economic unity theory	Эдийн засгийн нэгдлийн онол. Энэ нь Европын хамтын нийгэмлэгийн өрсөлдөөний бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг. Энэ нь Хамтын нийгэмлэгийн хуулийн дагуу тухайн Хамтын нийгэмлэгийн хүрээнд байрлаж буй компанийн охин компанийн эсрэг монополын эсрэг арга хэмжээ авах зорилгоор, тэдгээр хоёр компанийг эдийн засгийн нэг нэгдэл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, толгой компанийг өөрийг нь оролцсон гэж үзнэ.
432	Economies in transition	Шилжилтийн үеийн эдийн засагтай орнууд. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжих өөрчлөлт хийгдэж буй эдийн засагтай орнуудыг хэлнэ. Заримдаа үүнийг эдийн засаг дах төрийн зохицуулалтаа ихээхэн хэмжээгээр халж эхэлсэн хөгжиж буй улс орнуудад зориулан хэрэглэдэг. Мөн шилжилтийн үе шатандаа буй түншүүдийг (Partners in Transition) үзнэ үү.
433	Eco-packaging	Эко-сав баглаа боодол. Энэ нь хүрээлэн буй орчинд хамгийн бага нөлөө үзүүлдэг сав баглаа боодлын материалыг ашиглах асуудал бөгөөд үүнд тэдгээрийн үйлдвэрлэл нь нэг бол байгаль орчинд ээлтэй, эсвэл тэдгээрийг амархан дахин ашиглах боломжтой эсвэл дахин боловсруулж ашиглах боломжтой байдаг. Зарим төрлийн стандарт бус эко сав баглаа боодлын нөхцөлийг дагаж мөрдөхийг шахаж шаардах нь зарим тохиолдолд хамгаалалтын буюу протекционист нөлөө үзүүлэхэд хүргэж болно. Мөн худалдаа ба байгаль орчныг үзнэ үү.
434	Eco-protectionism	Эко-протекционизм буюу Экологийг хамгаалах үзэл баримтлал бүхий гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онол. Байгаль орчны болон хөдөлмөрийн харьцангуй өндөр стандартууд нь дотоодын компаниудыг далдуур илүүд үзэж байдаг гэсэн хэтийн төлөвтэй холбоотой хамгаалалтын арга хэмжээ. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment), хөдөлмөрийн стандартыг (labour standards) үзнэ үү.
435	ECOSOC	НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөл (ECOSOC). Энэ зөвлөл нь ямар нэгэн дүрэм журам боловсруулж гаргах үүрэггүй. Үүний жил бүр зохион байгуулагддаг ДХБ, ОУСБХБ, ОУВС зэрэг байгууллагуудын дарга нарыг хамруулдаг өндөр түвшний хурлууд нь улс орнуудын хооронд эдийн засгийн бодлогын уялдаа холбоог хөхиүлэн дэмжихэд тус дэмтэй гэж үздэг. Мөн НҮБ-ЭЗБНЗ болон ТХЕХ (ECOSOC-GATT), Хууль бус төлбөрийн тухай олон улсын хэлэлцээрийн төслийг (Draft International Agreement on Illicit Payments) үзнэ үү.
436	ECOSOC and GATT	НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөл (ECOSOC) болон Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр. НҮБ-ын дүрмээр ECOSOC-т олон улсын эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд олон үүрэг хариуцлага, түүний дотор түүний бүрэн эрхэд хамаарах асуудлаар олон улсын бага хурлыг хуралдуулах боломж олгосон. Дайны дараах жилүүдэд олон талт худалдааны хэлэлцээрүүдийг хөхиүлэн дэмжиж байсан гол эрх мэдэл бүхий байгууллага болох Нэгдсэн Үндэстний Байгууллага нь, ECOSOC-ийг хожим НҮБ-ын Худалдаа ба хөдөлмөр эрхлэлтийн бага хурал гэж нэрлэдэг болсон бага

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>хурлыг хуралдуулах ёстой хэмээн санал болгосон байдаг. Гэвч АНУ нь олон улсын худалдааны байгууллага байгуулах зорилт болон тарифын олон хэлэлцээ хийх гэдэг хоёр асуудлууд хоорондоо ялгаатай болохыг гаргаж тавьсан байдаг. Учир нь 1934 оны Харилцан хоёр талын тэгш худалдааны хэлэлцээрт нь нэмэлт өөрчлөлт орж шинэчлэн найруулагдсаны дагуу олж авсан тарифын хэлэлцээр байгуулахад хэлэлцээ хийх чиг үүргийнх нь хүрээнд уг асуудал урган гарч ирсэн бөгөөд үүнд олон улсын худалдааг удирдан зохион байгуулах ямар нэгэн байнгын байгууллага байгуулах талаар заагаагүй байжээ. ECOSOC нь бага хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоолыг баталсны дараа хэлэлцээрт тууштайгаар оролцох ямар нэгэн нэмэлт үүрэг олгоогүй байна. Тиймээс ТХЕХ нь анх байгуулагдсан цагаасаа л НҮБ-ын тогтолцооноос бараг хараат бус бие даасан байж ирсэн байдаг. Энэхүү зарчмыг ДХБ-д шилжүүлэн нэвтрүүлсэн байдаг. Мөн АНУ-ын Харилцан хоёр талын тэгш худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийг (United States Reciprocal Trade Agreements Program) үзнэ үү.</p>
437	Eco-standards	<p>Эко-стандарт. Энэ нь байгаль орчинд учруулах хохирлыг бууруулах, арилгах зорилгоор тогтоосон бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, хэрэглээний стандартууд. Мөн Худалдаан дах техникийн саад тотгор (technical barriers to trade), худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.</p>
438	ECOWAS	<p>Баруун Африкийн улсуудын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ECOWAS). Анх 1975 онд байгуулагдсан. Энэ нь Баруун Африкийн Эдийн засгийн хамтын нийгэмлэгийн гишүүд (Бенин, Буркина Фасо, Кот д'Ивуар, Мали, Мавритани, Нигер, Сенегал), Мано голын холбооны гишүүд (Гвиней, Либериа, Сьерра-Леоне), Кейп Верде, Гамбия, Гана, Гвиней-Бисау, Нигери, Того зэрэг улс орнууд багтдаг. ECOWAS нь худалдааны либералчлалын зорилгоо биелүүлэхэд зөвхөн хэсэгчлэн амжилттай ажилласан. Энэ нь 1993 онд боловсруулагдаагүй бүх бүтээгдэхүүний чөлөөт худалдаа, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг эрчимтэйгээр либералчлах хөтөлбөрөөр дамжуулан дахин эхлүүлсэн.</p>
439	Ecretement	<p>Үнийн хэмжээнд албан ёсны хязгаар тогтоох бодлого. Энэ нь Кеннедигийн үе шатны хэлэлцээрийн эхэн үед (1963-67) Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгээс (ЕСС) зорилтот хэмжээгээр бууруулах замаар тарифыг уялдуулан зохицуулах талаар гаргасан санал. Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгээс үүсэж гарсан уг саналд авч үзсэнээр бол өөрсдийнх нь тариф нь ихэвчлэн 10% -аас 20% хооронд хэлбэлздэг байсан бол АНУ-ын тариф олон тохиолдолд 30%-иас 50% хооронд хэлбэлздэг, зарим нь 100% хүртэл хэмжээтэй байсан байна. Тийм учраас ЕСС тарифын хувь хэмжээг тал хувиар бууруулах асуудлын хүрээнд, аж үйлдвэрлэлийн түвшинд гүн боловсруулсан бүтээгдэхүүнд 10%, хагас боловсруулсан бүтээгдэхүүнд 5%, түүхий эдэд 0% тариф ногдуулах зорилтот түвшинд хүргэж бууруулахыг санал болгосон байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
440	EC-92 program	ЕК-92 буюу Европын хамтын нийгэмлэгийн 92 хөтөлбөр. Мөн Европын хамтын нийгэмлэг буюу Европын Холбооны нэгдсэн зах зээлийг (European Community Single Market) үзнэ үү.
441	EEC minimum import prices	<p>Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС) импортын хамгийн бага үнэ. 1978 онд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС) эсрэг АНУ-ын гаргасан нарийн төвөгтэй хэрэг юм. Үүнийг цэгцлэхэд хоёр жил шаардлагатай байв. АНУ дараах гурван нэхэмжлэлийг гаргажээ: (а) ЕСС-гийн хувьд баримталдаг өтгөрүүлсэн улаан лоольд оноосон импортын үнийн хамгийн доод хэмжээг заасан систем нь ТХЕХ-ийн үүрэг, амлалтуудтай нийцэхгүй байна, (b) үүнтэй мөн ижил төстэй ЕСС-гийн хувьд баримталдаг тусгай зөвшөөрөл/лиценз олгох болон батлан даалтын системүүд нь ТХЕХ-ийн үүрэг, амлалтуудтай нийцэхгүй байна, (c) ЕСС-гийн хувьд баримталдаг импортын үнийн хамгийн доод хэмжээ, тусгай зөвшөөрөл/лиценз олгох, батлан даалтын барьцаа зэрэг нь АНУ-ийн хувьд хуримтлагдах үр ашгийг дордуулж байна гэж үзсэн байна. Энэхүү гомдол нь ЕСС-гээс өтгөрүүлсэн улаан лоолийн импортын хамгийн доод үнийг тогтоох хэд хэдэн журам баталж гаргасны дараа гарсан байдаг. Эдгээр нь импортлогчдыг импортын гэрчилгээ авах, тодорхой өдрүүдэд бүтээгдэхүүнийг импортлох баталгаа гаргах үүднээс банканд түр хугацаагаар барьцаа байрлуулахыг шаарддаг байна. Хэрэв заасан хугацаанд ямар нэгэн импорт хийгээгүй бол импортын баталгааны барьцаагаа алдана. Өтгөрүүлсэн улаан лоолийн хувьд бас нэгэн баталгаа шаарддаг байсан нь, импортолж буй бүтээгдэхүүний үнэ нь дотоодын хамгийн доод үнэтэй наад зах нь тэнцүү байх нөхцөлийг хангах зорилготой байв. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг эхлээд импортын гэрчилгээ болон холбогдох баталгаажуулалтын системийг нь авч үзсэн. Энэхүү импортын гэрчилгээ олгох систем нь ТХЕХ-ийн бусад гишүүн улс орнуудын хэрэглэдэг ижил төстэй системүүдээс ялгаатай биш бөгөөд энэ нь автоматаар импортын тусгай зөвшөөрөл олгох журамтай нийцэж байгаа нь тогтоогджээ. Автоматаар тусгай зөвшөөрөл/лиценз олгох асуудал нь 11-р Зүйлд ороогүй тул импортын гэрчилгээ ба баталгаажуулалтын систем нь хуулийн энэхүү зүйлд заасан ЕСС-ийн үүрэг амлалттай нийцээгүй зүйл биш байна гэж үзэн байна. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн дараа нь уг системийн утга ач холбогдлыг хуулийн 8-р Зүйлийн хүрээнд (импортлох ба экспортлохтой холбогдсон хураамж, албан ёсны хэлбэрүүдийг) авч үзсэн байна. 8-р Зүйлд заасны дагуу хураамж болон төлбөрийн хэмжээ нь үзүүлсэн үйлчилгээний зардалтай ойролцоо хэмжээний өртөг зардлын хэмжээнд хязгаарлагдаж байсан эсэхийг судалж үзэв: (a) Энэ нь үнэхээр тийм асуудал байжээ гэдгийг Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг илрүүлсэн байна. Тэрээр импортын барьцааг хурааж авах асуудал нь ямар ч импорт хийгдээгүй үед л зөвхөн хэрэглэж байсан тул энэхүү заалтад хамрагдахгүй юм байна гэж үзсэн байна. Мөн импортын гэрчилгээ авах асуудал нь тийм ч хэцүү шаардлага биш юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тэрээр мөн хамгаалалтын арга хэмжээний хариуд гэрчилгээ олгохоо зогсоож чадах ЕСС-ийн бололцоо нь хуулийн 8-р Зүйлд заасан үүрэг амлалттай зөрчилдсөн зүйл биш байна гэж дүгнэсэн байна. Эцэст нь импортлогч эсвэл экспортлогч улсын засгийн газар баталгааны барьцаа өгөх хэрэгтэй болсон байсан эсэхээс үл хамааран, байж болохуйц гуравдагч улсын ханган нийлүүлэгчдийн бүх импортуудад зориулж баталгаа гаргах шаардлагатай байсан бол хуулийн 1:1 (Үндэсний нэн тааламжтай ерөнхий нөхцөл)-ийн ялгаварлан гадуурхсан нөхцөл байхгүй байна гэж Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг дүгнэсэн байна. Мөн хувьсах татвар хураамжийг (variable levies) үзнэ үү.
442	Effective market access	Зах зээлд үр дүнтэй нэвтрэх. Улсын татаас болон сайн дурын хязгаарлалтын зохицуулалт гэх мэт тарифын болон тарифын бус арга хэмжээнүүд дээр нэмээд, заавал импортын эсрэг хамгаалалт хийх зорилгоор боловсруулж гаргаагүй дотоодын эрх зүйн зохицуулалтын бодлого байхгүй байсан гэж тодорхойлдог боловч, энэ нь өрсөлдөөн эсвэл ил тод байдлыг хязгаарлаж байдаг тийм нөлөөлөл болон бүтэц тогтолцооны хүрээний бусад саад тотгоруудыг үзүүлж байдаг байна.
443	Effective market presence	Зах зээлд үр дүнтэй байрших. Хөрөнгө оруулалтаар дамжуулан гадаадын фирмүүдийн зах зээл дээр өрсөлдөх чадвар, өөрөөр хэлбэл бусад оронд өөрийн төлөөлөгчийн газар байгуулж эрх эдлэх замаар өрсөлдөх чадвартай болно гэсэн үг. Мөн худалдаа ба хөрөнгө оруулалтыг (trade and investment) үзнэ үү.
444	Effective rate of assistance	Үр дүнтэй тусламжийн хувь хэмжээ (ERA). Үүнийг заримдаа үр дүнтэй хамгаалалт ч гэж нэрлэх нь бий. Энэ нь аж үйлдвэрлэлийн салбарт дотоодын улсын татаасны ямар ч дэмжлэг байхгүй гэх таамаг нөхцөл байдал болон бодитоор улсын татаасны дэмжлэг авч байгаа нөхцөл байдал хоёрын хоорондын ялгааг тодорхой болгох ерөнхий бүтэц. Үр дүнтэй тусламжийн (ERA) үзэл баримтлал нь, тариф болон тарифын бус арга хэмжээ зэргийг хамруулдаг, хилээр орж гарч буй худалдааны урсгалыг бодитоор хязгаарлахгүйгээр худалдааны урсгалд нөлөөлж болох, улсын татаас эсвэл худалдан авалтын давуу эрх зэрэг засгийн газрын хөндлөнгийн оролцоог хэмжих чадвартай байдаг тул энэ нь маш хэрэгцээтэй байдаг. Ийм аргаар, тухайн улсын дотоодод үзүүлсэн улсын татаасны дэмжлэгийн улмаас эцсийн хэрэглэгчдэд учирч буй нэмэлт зардлыг мөн харуулж чаддаг. Үр дүнтэй тусламж нь, ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд хууль ёсны эсвэл хууль бус гэж үзэж болох арга хэмжээнүүдийн хооронд ялгаж салгаж үздэггүй. Уругвайн үе шатны хэлэлцээрийн үеэр Австрали улс Үр дүнтэй тусламжийн хувь хэмжээний ерөнхий бүтцийг худалдааг чөлөөлөх/либералчлах хэлэлцээрт ашиглах нь зүйтэй гэж санал болгосон боловч энэ нь өргөн цар хүрээнд дэмжлэг аваагүй байна. Мөн хамгаалалтын нэрлэсэн хувь хэмжээ (nominal rate of protection) болон өсөн нэмэгдэх тарифын бүтцийг (tariff escalation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
445	Effective rate of protection	Хамгаалалтын үр дүнтэй түвшин. Мөн дэмжлэгийн үр дүнтэй хувь хэмжээг (effective rate of assistance) үзнэ үү.
446	Efficiency-seeking investment	Үр ашиг эрэлхийлсэн хөрөнгө оруулалт. Бусад зах зээлд хамгийн өрсөлдөхүйц байдлаар ханган нийлүүлэлт хийх зорилгоор хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтад зориулсан нэр томьёо юм. Мөн зах зээлийг эрэлхийлсэн нэр томьёог (market-seeking investment) үзнэ үү.
447	EFTA	Европын чөлөөт худалдааны холбоо (EFTA). 1960 оны 5-р сарын 3-нд Стокгольмын конвенцын дагуу хүчин төгөлдөр болсон. Үүсгэн байгуулагч нь Австри, Дани, Норвеги, Португал, Швед, Швейцарь, Их Британи байв. Исланд 1970 онд элссэн. Финланд улс 1986 онд хамтарсан гишүүнээр элссэний дараа 1986 онд үндсэн гишүүн нь болсон. Дани, Их Британи нар 1972 оны 12-р сарын 31-нд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгт элссэнээр үүнийг орхин явсан байдаг. Тэдгээрийг дагаад мөн 1985 онд Португал, 1995 оны 1-р сарын 1-нд Австри, Финланд, Швед улсууд гарч явсан байна. EFTA нь одоо Исланд, Лихтенштейн, Норвеги, Швейцарь улсуудаас бүрддэг. EFTA нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгээс илүүтэй үргэлж эдийн засгийн интеграцчилалд илүү хүсэл эрмэлзэлтэй байсаар ирсэн. Гэсэн хэдий ч энэ нь бизнесийн үйл ажиллагааг болон гишүүн орнуудын аж ахуйн нэгж байгуулах эрхийг хязгаарласан зүйл заалтуудыг агуулсан байдаг байна. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь ихэнх тохиолдолд конвенцын заалтуудаас чөлөөлөгдсөн байдаг. Мөн Европын эдийн засгийн бүсийг (European Economic Area) үзнэ үү.
448	Electronic commerce	Цахим худалдаа арилжаа. Энэ нь интернэт болон дэлхий дахиныг хамарсан цахим сүлжээгээр дамжуулан хийгдэж буй худалдааг ийнхүү нэрлэх нь элбэг болжээ. Гэвч тун саяхан хүртэл гагцхүү гааль, хорио цээрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүд хооронд эсвэл аж ахуйн нэгжүүдийн хооронд бүтэцчилэгдсэн, стандартчилагдсан мэдээллийг дамжуулах чиглэлийн үйл ажиллагааг хамарсан цахим тоон мэдээлэл өгөгдлийг харилцан солилцох хэлбэрийг гол төлөв нэрлэж байлаа. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээж хэрэг олон арван жилийн турш бие биетэйгээ электрон/цахим худалдаа хийж байсан. Мөн Дэлхийн худалдааны цэгийн сүлжээг (Global Trade Point Network) үзнэ үү.
449	Embodied services	Бодит бүтээгдэхүүн болсон үйлчилгээ. Энэ нь уян диск эсвэл CD-ROMs буюу тоон пянз хэлбэрээр борлуулсан компьютерын программ хангамжийн оюуны өмчийн бүрэлдэхүүн хэсэг гэх мэт бодит бүтээгдэхүүн болж бүрэлдсэн үйлчилгээ. Зарим шинжээчдийн үзэж байгаагаар хэрэв бодит бүтээгдэхүүн болсон үйлчилгээг үйлчилгээний худалдааны статистикт хамруулсан бол дэлхийн худалдааны статистикт эзэлж буй тооцоолж гаргасан үйлчилгээний хувь хэмжээ бараг хоёр дахин нэмэгдэх байсан гэдэг. Энэхүү таамаглал нь үнэн байж болох ч үүнийг батлан харуулахын тулд маш их нэмэлт тайлангууд гаргасан нарийн төвөгтэй ажлын хүрээнд л гаргаж харж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Бодит бүтээгдэхүүн болсон үйлчилгээг тусад нь тайлагнана гэдэг нь, жишээлбэл, төмрийн хүдрийн экспорт гэдэг нь наад зах нь бараа бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг болон үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэх ба үүнд жишээ нь тээвэрлэлт, зар сурталчилгаа, борлуулалт, удирдлага зохион байгуулалтын ажил үйлчилгээ хамрагдах болно. Мэдээжийн хэрэг, үйлдвэрлэл эрхэлж буй компанийн хувьд өөрийн бүтээгдэхүүнийхээ үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь ямар үнэ цэнтэй болох талаар мэдэж байх хэрэгтэй боловч тэрээр бүтээгдэхүүнүүдээ эдгээр үйлчилгээнээс тусад нь борлуулж чадахгүй юм. Тиймээс үйлчлүүлэгчээс ганц нэгжид ногдох үнийн төлбөрийг л авна. Мөн үйлчилгээний худалдааны статистикийг (trade in services statistics) үзнэ үү.</p>
450	Emergency protection	<p>Онцгой байдлын хамгаалалт. Мөн Зугтаах заалт буюу гэрээний хариуцлагаас чөлөөлсөн заалтыг (escape clause) үзнэ үү.</p>
451	Emerging Market Economies	<p>Хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнууд. Эдийн засаг дах төрийн зохицуулалтыг бас халж байгаа, илүү өндөр түвшинд хүрч буй хөгжиж буй орнуудад зориулж, ЭЗХАХБ-д (OECD) ашигладаг нэр томьёо.</p>
452	Emerging Market Economy Forum	<p>Хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын хэлэлцүүлэг. Энэ нь 1995 онд ЭЗХАХБ-аас байгуулсан механизм. Үүний зорилго нь шинээр хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай холбоотой асуудлыг ЭЗХАХБ-ын (OECD) зарчим, зорилго, дүрмийн үүднээс авч үзэхэд оршино.</p>
453	Enabling Clause	<p>Зөвшөөрөгдөх заалт. Токиогийн үе шатны хэлэлцээрийн үр дүнгийн нэг бол Ялгавартай, илүү тааламжтай нөхцөл, Харилцан адил нөхцөл, Хөгжиж буй орнуудын илүү бүрэн дүүрэн оролцооны тухайд санал нэгдсэн хэлэлцээр байлаа. Энэ нь ДХБ-ын хөгжингүй улс орнууд бусад гишүүн улс орнуудад адилхан нөхцөл олголгүйгээр, хөгжиж буй улс орнуудад нааштай хандах арга хэмжээ авах боломжийг олгодог. Үүнд хамруулсан гол арга хэмжээнүүдэд, Хөнгөлөлтийн ерөнхий систем, ТХЕХ-т хамруулдаг тарифын бус арга хэмжээ, хөгжиж буй улс орнуудын хоорондын дэлхийн худалдааны зохицуулалтууд, нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай нөхцөл зэрэг болно. Зөвшөөрөгдөх заалт нь хөгжиж буй улс орнуудыг дэлхийн худалдааны системд илүү идэвхтэй оролцохыг дэмжих зорилготой байсан боловч энэ нь зорилгодоо хүрсэн эсэх талаар эргэлзэх талууд байдаг. Мөн хөгжиж буй улс орнууд (developing countries), ТХЕХ (GATT), Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн систем (GSTP - Global System of Trade Preferences), ТХЕХ-ийн 4-р Бүлэг (Part IV of the GATT), бус нутгийн худалдааны зохицуулалт (regional trade arrangement), тусгай болон ялгавартай нөхцөлийг (special and differential treatment) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
454	Energy Charter Treaty	<p>Эрчим хүчний дүрмийн олон улсын хэлэлцээр. Үүнийг Европын эрчим хүчний дүрмийн тухай чуулга уулзалтын Төгсгөлийн эрх зүйн баримт бичиг болгож 1994 оны 12-р сард үзэглэсэн байдаг. Үүний гишүүнчлэлд нь ЭЗХАХБ-ын ихэнх улсууд, Төв ба Зүүн Европын орнууд, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнууд багтдаг. Хэлэлцээрийн зорилго нь “дутуугаа нөхөж, харилцан бие биедээ ашигтай байх нөхцөлд тулгуурлан, эрчим хүчний салбарт урт хугацаанд хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих зорилгоор эрх зүйн бүтэц, хамрах хүрээг” буй болгох явдал юм. Энэ нь эрчим хүчтэй холбогдолтой худалдаа, хөрөнгө оруулалт болон бусад асуудлыг өргөн хүрээнд хамардаг. 3-р Зүйлд зааснаар бол, худалдаа арилжааны нөхцөлийн дагуу олон улсын зах зээлд нэвтрэхийг хөхиүлэн дэмжих, эрчим хүчний материал болон эрчим хүчний бүтээгдэхүүний нээлттэй бөгөөд өрсөлдөөнт зах зээлийг хөгжүүлэхийг ерөнхийд нь гишүүд дэмжсэн байдаг.</p>
455	Enforcement	<p>[Хуулийг] сахиулах. Мөн зөвлөгөөн (consultations), солбицсон хариу арга хэмжээ (cross-retaliation), хариу арга хэмжээг (retaliation) үзнэ үү.</p>
456	Enquiry points	<p>Лавлагаа авах нэгж/Мэдээллийн төв - Уругвай). ДХБ-ын зарим хэлэлцээрийн дагуу гишүүн улс орнуудыг худалдааны асуудал хариуцсан захиргааны байгууллагууд дээрээ мэдээллийн төвүүдийг байгуулахыг шаарддаг бөгөөд бусад гишүүн орнууд гэрээнд хамрагдсан салбарын талаар мэдээлэл авах боломжтой байдаг. Заримдаа тэдгээрийг холбоо барих албан хаагчид гэж нэрлэх нь бий. Мэдээлэл солилцох ажиллагаа засгийн газрын түвшинд явагдаж байдаг. Эдгээр гэрээний жишээ бол Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (GATS), Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (the Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (Agreement on Technical Barriers to Trade). GATS нь мөн хөгжингүй орнуудыг холбоо тогтоох албан хаагчид томилохыг шаарддаг бөгөөд хөгжиж буй орнуудын хувийн хэвшлийн салбарын аж ахуйн нэгжүүд худалдааны боломжийн талаар мэдээлэл олж авах боломжтой болдог.</p>
457	Enterprise for the Americas Initiative	<p>Америкийн санаачилгын төлөөх аж ахуйн нэгж. Ерөнхийлөгч Буш нь Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын эдийн засгийг бэхжүүлэх зорилгоор 1990 оны 6-р сард АНУ-ын уг хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Санаачилгын гол бүрэлдэхүүн хэсэг нь худалдаа, хөрөнгө оруулалт, өр төлбөрийг бууруулах хөтөлбөрүүд. Америкийн чөлөөт худалдааны бүс (ФТАА) нь энэхүү санаачилгаас гарал үүсэлтэй байв. Мөн Хөгжлийн төлөөх эвсэл (Alliance for Progress), Худалдааны давуу эрхийн тухай Андын бичиг баримт (Andean Trade Preference Act), Карибын тэнгисийн сав газрын санаачилгыг (Caribbean Basin Initiative - CBI) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
458	Entrepot trade	<p>Шилжүүлэн ачих боомт/хотын худалдаа. Жишээлбэл, Хятад улсын зарим бүтээгдэхүүнийг Хонг-Конгоор дамжуулан экспортлох тохиолдол гардаг шиг, бараа бүтээгдэхүүнийг нэг улсын боомтоор дамжуулан нөгөө улсад дахин экспортлох зорилгоор ачилт тээвэрлэлт хийдэг байна. Ачилтын худалдааны хэлбэрээр орж гарч буй бараанд тариф ногдуулдаггүй. Бараа бүтээгдэхүүн эхлээд улс хоорондын завсрын улс руу орж, дараа нь эцсийн зорилтот улс руу буцаан экспортлогдох замаар, жинхэнэ гарал үүслийн улсыг нь харуулалгүйгээр уг бараа бүтээгдэхүүнийг бүртгэх боломжтой байдаг тул, хоёр талт худалдааны статистикт зөрүүтэй мэдээлэл гарч болзошгүй. Гарал үүслийн дүрмийг (rules of origin) үзнэ үү.</p>
459	Environmental dumping	<p>Байгаль орчны демпинг. Мөн Эко шинж чанартай демпинг (eco-dumping), Эко шинж чанартай татварууд (eco-duties) үзнэ үү.</p>
460	Environmental rules under the WTO	<p>ДХБ-ын Байгаль орчны дүрэм. ДХБ-д байгаль орчинтой холбоотой асуудлаар сайн боловсруулсан дүрмийн тогтолцоо байдаггүй. Үүний үндсэн зарчим нь, хэрэв шаардлагатай бол, засгийн газрууд үндэсний нөхцөл дээрээ тулгуурлан өөрсдийн нутаг дэвсгэр дээрээ өөрсдийн байгаль орчны стандартыг бие даан хэрэгжүүлэх эрх чөлөөтэй гэж заасан байдаг. ТХЕХ-ийн 20-р Зүйлд (Эс хэрэглэх нийтлэг тохиолдол /General Exceptions), уг хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтуудаасаа шаардлагатай хэмжээгээр харьцангуй явцуу хүрээнд тодорхойлсон нөхцөл байдалд түдгэлзэхийг зөвшөөрсөн байдаг. Хүн, амьтан, ургамлын амьдрал, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах эсвэл хэрэгжүүлэхийн тулд хуулийн 20-р Зүйл (b) заалтыг ашиглаж болно. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн 14-р Зүйлд ижил төстэй үг хэллэгийг бас олж болно. ТХЕХ-ийн 20-р Зүйлийг ТХЕХ-т харшлах бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад ашиглаж болно. 20-р Зүйл нь дотоодын үйлдвэрлэл, хэрэглээнд хязгаарлалттайгаар уялдуулан, үр дүнтэй арга хэмжээ авч байгаа тохиолдолд, байгалийн шавхагдах нөөцийг хадгалж, хамгаалахтай холбогдсон арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх боломжийг олгодог. Май загас (herring) болон хулд загас (salmon), туна загас (tuna) (Канад, АНУ, 1982 он) мөн туна загас (Мексик, АНУ, 1991 он) мөн эдгээр сэдвүүдээр нийтлэгдсэн материалыг тайлбарлахдаа ТХЕХ-ийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүний зүгээс гаргасан санал бодолд нөлөөлөх үүднээс гаргаж тавьсан өөрчилсөн бензиний асуудлыг үзэж болно. Superfund-ийн хэрэг мөн байгаль орчныг хамгаалах асуудлыг хөндсөн байсан боловч энэ тохиолдолд гарсан маргаанууд нь үндэсний нөхцөлд төвлөрсөн байлаа. Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор худалдааны арга хэмжээ ба байгаль орчны арга хэмжээ хоорондын уялдаа холбоог тодорхойлох зорилгоор Худалдаа, байгаль орчны хороо байгуулагдсан. Хоекман ба Костечки (1995) нар дэмжигчдийнхээ санал болгосны дагуу энэ асуудлыг ДХБ-ын хэлэлцээрт оруулах дөрвөн үндсэн шалтгааныг дэвшүүлжээ.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Нэгдүгээрт, нэг улсын үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний үйл ажиллагаа нь бусад улсын байгаль орчинд хортой нөлөө үзүүлж болзошгүй. Хоёрдугаарт, байгаль орчны чиглэлээр ажилладаг зарим бүлэглэлүүд, бохирдол тархаах боломжтой байдаг тул худалдаа гэдэг нь өөрөө байгаль орчинд муу нөлөөтэй гэсэн үзлийг хэлэлцүүлэхээр дэвшүүлжээ. Гуравдугаарт, байгаль орчны хэмжүүр, бодлого нь худалдааны хувьд муу нөлөө үзүүлдэг, учир нь байгаль орчны илүү өндөр стандартыг баримталдаг улс орнуудыг бодвол байгаль орчны доогуур стандарттай улс орнуудад илүү өрсөлдөх боломжийг олгодог байж болзошгүй гэж зарим нь үздэг байна. Дөрөвдүгээрт, байгаль орчны бодлого нь туна загасны хэргүүдэд харуулсан шиг худалдааг ямар ч шаардлагагүйгээр хязгаарлаж байж болзошгүй юм. Мөн эко-шошгожуулалт (eco-labelling), Эс хэрэглэх нийтлэг тохиолдол (general exceptions), ёроол руу уралдах тухай мэтгэлцээн (race-to-the-bottom argument), Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг (sanitary and phyto-sanitary measures) үзнэ үү.</p>
461	Equality of competitive opportunity	<p>Өрсөлдөөний боломжийн тэгш байдал. Энэ нь ТХЕХ-ийн 3- Зүйлд заасан үндэсний нөхцөлийн дагуу авах үүрэг амлалтын үндсэн зарчим. Энэ нь импортын бүтээгдэхүүнийг дотоодын бүтээгдэхүүнтэй үр дүнтэй өрсөлдөх боломжийг олгохын тулд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох ёстой.</p> <p>Энэ нь импортын болон дотоодын бүтээгдэхүүний зохицуулалт нь ижил байдаг гэсэн үг, гэхдээ тэгш боломжийг хангах цорын ганц арга зам юм гэж үзэж байгаа бол импортын хувьд албан ёсны өөр өөр дүрмүүд ч байж болно. Мөн Төвийг сахисан өрсөлдөхүйц байдал (competitive neutrality), Эдийн засгийн нөлөөллийн шалгуур (economic impact criterion), далдуур ялгаварлан гадуурхахыг (implicit discrimination) үзнэ үү.</p>
462	Equitable competition	<p>Тэгш өрсөлдөөн. Энэ нь компаниуд илүү ижил тэгш нөхцөлөөр өрсөлдөх бүтцийг бий болгохын тулд үйлдвэрлэлийн өртөгт нөлөөлж байдаг хөдөлмөр, байгаль орчны болон бусад стандартыг тодорхой хэмжээгээр олон улсын хэмжээнд уялдуулах ёстой гэсэн төсөөллийг үндэслэсэн үзэл баримтлал. Энэхүү үзэл баримтлалын суурь онол нь, хангалтгүй түвшний стандартыг зөвшөөрсөөр байдаг улс орнуудын хувьд өөрсдийн компаниудад өртгийн хувьд давуу талыг олгож байдаг нь тэдний олон улсад өрсөлдөх чадварыг нь дээшлүүлдэг явдал. Мөн шударга өрсөлдөөн (fair competition), нийгмийн шинж чанартай заалт (social clause), худалдаа ба хөдөлмөрийн стандарт хэм хэмжээ (trade and labour standards), худалдаа ба байгаль орчныг (trade and the environment) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
463	Equitable share of the market	<p>Зах зээлийн шударга хувь хэмжээ. Энэ нь анхдагч түүхий эдийн бараанд олгож болох татаасны тухай хөндсөн ТХЕХ-ийн 16:3-р Зүйлд (Татаас) агуулсан ойлгоход бэрх бүдэг ойлголт. Үүний утгыг ямар нэгэн тоон утгаар тодорхойлж гаргаагүй байдаг. Тийнхүү хийх нь бэрхшээлтэй гэдэг нь нотлогдсон байдаг, учир нь анхдагч түүхий эдийн барааны дэлхий нийтийн эрэлт хэрэгцээг хамгийн үр дүнтэйгээр, эдийн засгийн хэмнэлттэй байдлаар ханган нийлүүлэх хүсэл тэмүүллийн талаар наад тал нь 1955 оноос хойш ТХЕХ-ийн гишүүн улс орнуудын дунд байсан ойлголттой холбоотой байсан ба уг ойлголт нь тухайн үеийг төлөөлөх цаг хугацаанд тухайн авч үзэж буй бүтээгдэхүүний дэлхийн худалдаанд экспортлогч улсын эзлэх хувь хэмжээтэй холбоотой аливаа онцгой хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой байдаг. 1958 онд Францын улаан буудай, улаан буудайн гурилын хэргийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг нь “шударга хувь хэмжээ” гэсэн ойлголтын талаар ашигтай ажиглалт хийсэн байдаг боловч, эдгээрийг дараагийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнээ/хөндлөнгийн хэсэгт цаашид боловсруулж, боловсронгуй болгоогүй байна. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6, 16, 23-р Зүйлийг тайлбарлах, хэрэглэх тухай Токиогийн үе шатны хэлэлцээрийн 9-р зүйлд (Татаасны тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хууль гэж нэрлэдэг) шинэ зах зээлтэй холбогдуулан тэмдэглэхэд тухайн шинэ зах зээл байрлаж буй бүс нутаг руу тухайн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх уламжлалт хэв загвар нь “дэлхийн экспортын худалдаанаас хүртэх шударга хувь хэмжээг” тодорхойлох асуудлыг харгалзан үзэх ёстой. ТХЕХ-ийн 13-р Зүйл нь (Тоон хязгаарлалтын үл ялгаварлах удирдлага) зах зээлийн шударга хувь хэмжээний зарчмыг хангахыг эрмэлздэг. Тоон хязгаарлалтад өртсөн бүтээгдэхүүний худалдааг хуваарилахдаа тоон хязгаарлалт байхгүй нөхцөлд экспортлогч улс орнуудын олж авч болох хувь хэмжээтэй аль болох ойртуулахыг шаарддаг бөгөөд энэ нь үүнийг хэрхэн хийх арга замыг зааж өгсөн байдаг.</p>
464	Equivalent measure of support	<p>Дэмжлэг үзүүлэхтэй дүйцэхүйц арга хэмжээ (EMS). Энэ бол ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрт хэрэглэгддэг нэр томьёо. Энэ нь хөдөө аж ахуй, газар тариаланд мөнгөн хэлбэрээр үзүүлэх дэмжлэгийн жил бүрийн түвшинг тайлбарлаж байгаа бөгөөд дэмжлэг үзүүлсэн нийт арга хэмжээний дүнг (aggregate measure of support) тодорхойлоход ашигладаг аргачлалтай уялдуулан тооцоолон бодож болохгүй.</p>
465	Erga omnes	<p>Эргоумнэйс - Хуульд үндэслэсэн эрх. Латинаар “бүгдийн эсрэг” эсвэл “бүгдтэй холбогдуулан” гэсэн утгатай. Үүнийг заримдаа худалдааны хэлэлцээрт жишээ нь, “хэрэв гэрээний нэг тал эргоумнэйс буюу хуульд үндэслэсэн эрх бүхий тарифаа бууруулбал...” гэх зэргээр ашигласан байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
466	ESCAP	<p>НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (UN-ESCAP). НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн комиссуудын нэг. Энэ нь 1947 онд Ази ба Алс Дорнодын Эдийн засгийн комисс (ECAFE) нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1974 онд өнөөгийн нэрээ олж авсан байна. Энэ нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, байгаль орчин, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, тээвэр, харилцаа холбоо, статистик, нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй хөгжиж буй болон арлын жижиг орнуудын асуудлаар томоохон ажлын хөтөлбөрүүдтэй. ESCAP-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Бангкок байрладаг. Мөн Бангкокийн хэлэлцээрийг (Bangkok Agreement) үзнэ үү.</p>
467	Escape clause	<p>Зугтаах заалт буюу гэрээний хариуцлагаас чөлөөлсөн заалт. Импорт нь ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа дотоодын үйлдвэрлэгч нарт аюул учруулж эсвэл ноцтой хохирол учруулахаар байгаа нөхцөлд, гэрээний талыг үүрэг амлалтаа түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг, худалдааны хэлэлцээрүүдэд ихэнхдээ багтаасан байдаг заалт. ТХЕХ-ийн 19-р дүгээр зүйлд ДХБ-ын гишүүн орнуудын ашигладаг бараа бүтээгдэхүүний худалдаанд зориулсан зугтах тухай заалтыг агуулсан байдаг. Хэрэв урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүссэн эсвэл маш их хэмжээгээр нэмэгдсэн тоо хэмжээгээр ямарваа бүтээгдэхүүний импорт нь дотоодын үйлдвэрлэгч нарт хохирол учруулсан эсвэл учруулах магадлалтай байгаа тохиолдолд, энэ нь гишүүн улс орныг зах зээлээ либералчилж чөлөөлөх үүрэг амлалтаа түдгэлзүүлж эсвэл өөрчлөхийг зөвшөөрдөг. Энэхүү заалтын хэрэглээг илүү нарийвчилсан дүрмийг агуулсан Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр нь хуулийн уг Зүйлийг нөхөж гүйцээж өгсөн байдаг. Үүнтэй төстэй заалтыг GATS буюу Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт хэлэлцээ хийж оруулахаар байгаа бөгөөд 10-р Зүйлд үүнийг тийнхүү хийх бүрэн эрхийг тусгасан. Хамгаалалтын заалтуудыг хэлэлцээрт зориулан тусгах хоёр гол, холбогдох хоёр шалтгааныг ихэвчлэн гаргаж тавьдаг. Нэгдүгээрт [эдийн засгаа] либералчлах/чөлөөлөх үүрэг амлалт авсан улс орнуудын хувьд хэрэв тэдний дотоодын аж үйлдвэрт нь илэрхий хохирол учруулж буй импортын хэт их өсөлтийг санаандгүй буй болгочихсон байвал тэд уг амлалтаасаа ухрах боломжтой байдаг тул тэднийг илүү их либералчлахыг хөхиүлэн дэмждэг. Хоёрдугаарт, тэд урт хугацааны тогтвортой байдлыг дэмжих замаар олон талт худалдааны системийн уян хатан чанарыг нэмэгдүүлдэг. ТХЕХ-т зугтаах заалтыг оруулах шууд учир шалтгаан нь АНУ-ын төрийн захиргааны 1947 оны 2-р сарын 9832 тоот тушаал байсан бөгөөд энэ нь Америкийн худалдааны хэлэлцээ хийх этгээдүүд нь цаашдын худалдааны хэлэлцээрт 1942 оны 12-р сард байгуулсан АНУ-Мексикийн худалдааны хэлэлцээрт тусгагдсантай адил зугтаах заалтыг заавал оруулах шаардлагатай болжээ. Мөн хамгаалалтын арга хэрэгсэл болон 201-р Хэсгийг (Section 201) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
468	Essential products	Нэн чухал бараа бүтээгдэхүүн. ДХБ-ын гишүүн улсууд тодорхой нөхцөл байдалд төлбөрийн тэнцлийг хадгалахын тулд ТХЕХ-ийн 12-р Зүйлийн дагуу импортод хязгаарлалт тавьж болно. Хөгжиж буй улс орны гишүүд 18-р Зүйлийг мөн ашиглаж болно. Ингэснээр тэд бусад бараа бүтээгдэхүүнээс илүү чухал гэж үзсэн бүтээгдэхүүний импортод тэргүүлэх ач холбогдол өгч болно. Уругвайн үе шатны хэлэлцээрт хийсэн ТХЕХ-ийн төлбөрийн тэнцлийн тухай ойлголтод "нэн чухал бараа бүтээгдэхүүн"-ийг үндсэн хэрэглээний хэрэгцээг хангасан эсвэл капитал хөрөнгө эсвэл үйлдвэрлэлийн бусад орц болдог гэх мэтийн төлбөрийн тэнцлийн байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулдаг бүтээгдэхүүн гэж тодорхойлсон байдаг.
469	Euro-Mediterranean Economic Area	Европ болон Газрын дундад тэнгисийн эдийн засгийн бүс (EMEA). 1995 оны 11-р сард Барселонад болсон хурлын үеэр санал болгосон чөлөөт худалдааны бүсэд Европын Холбооны арван таван гишүүн улс, Газар дундад тэнгисийн эрэг дагуух арван улсыг (Алжир, Кипр, Египет, Израиль, Иордан, Ливан, Мальта, Марокко, Палестин, Сири, Тунис, Турк) хамруулах юм. EMEA нь 2010 он гэхэд хүчин төгөлдөр болно. Мөн Газар дундын тэнгисийн орнуудын хэлэлцээрийг (Mediterranean Agreements) үзнэ үү.
470	European Coal and Steel Community	Европын нүүрс ба гангийн хамтын нийгэмлэг (ECSC). Энэ нь 1951 онд Парисын олон улсын хэлэлцээрээр байгуулагдсан. Энэ нь гишүүн орнуудын дунд нүүрс, гангийн нэгдсэн зах зээлийг бий болгосон. Гишүүн улс орнууд үндэстнээс дээгүүр Өндөр эрх мэдэл бүхий шинээр байгуулагдсан уг байгууллагад энэ чиглэлийн бүрэн эрх мэдлээ итгэмжлэн төлөөлүүлсэн байдаг. ECSC-ийн амжилттай ажилласан байдал нь, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийг үүсгэн буй болгосон Ромын олон улсын хэлэлцээрийг хэлэлцэж эхлүүлэхэд хүргэсэн хүчин зүйлүүдийн нэг нь байв. 1965 онд Европын хамтын нийгэмлэгийн Нэгдсэн зөвлөл байгуулах тухай хэлэлцээр (Нэгтгэх хэлэлцээр) нь, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн комисстой Өндөр эрх мэдэл бүхий байгууллагыг нэгтгэсэн байна. Европын нүүрс ба гангийн хамтын нийгэмлэгийг байгуулах уг олон улсын хэлэлцээр нь 2001 онд дуусгавар болсон ба Европын Холбооны шинэ эрх зүйн актууд түүнийг бүхэлд нь хүчингүй болгож, орыг нь эзлэх болсон байна. Мөн Европын хамтын нийгэмлэгийг (European Communities) үзнэ үү.
471	European Commission	Европын Комисс. Энэ нь улс төрийн эрх мэдэл бүхий Европын Холбооны байгууллагуудын нэг. Комисс нь Европын Холбооны хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байдаг янз бүрийн гэрээ, хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөх нөхцөлийг хадгалан хамгаалж байх үүрэгтэй. Энэ бол бодлого, хууль эрх зүйн саналыг албан ёсны санаачлагч, Европын холбооны бодлогыг хэрэгжүүлэгч. Одоогийн байдлаар тус бүр нь дөрвөн жилийн хугацаатай томилогддог 20 комиссар буюу тусгай эрх бүхий төлөөлөгчид ажиллаж байгаа бөгөөд тэд тодорхой сэдэв бүхий талбаруудыг хариуцан ажилладаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Тэдгээрийг ерөнхий чадамжийн үндсэн дээр сонгосон байдаг тул тэдний бие даасан байдал нь эргэлзээтэй байх ёсгүй. Гишүүн улс бүр нэг комиссарын эрхтэй, гэхдээ Франц, Герман, Итали, Испани, Их Британид тус бүр хоёр эрх байна. Захиргааны хувьд Европын Комисс нь 20 гаруй Ерөнхий газрууд (DG) буюу яамнуудад хуваагддаг боловч тэд бүгдээрээ идэвхтэй байдаггүй. DG-1 гэдэг нь ДХБ-д хэлэлцээ хийх зэрэг эдийн засгийн гадаад харилцааны асуудлыг хариуцаж ажилладаг бол, DG-4 нь өрсөлдөөний асуудал, DG-6 нь хөдөө аж ахуйн асуудал гэх мэт. Ромын олон улсын хэлэлцээрийн 228-р Зүйл болон бусад зарим Зүйлийн дагуу гадаад руу чиглэсэн хэлэлцээрүүдийн хувьд Европын Комисс хэлэлцээ хийх бөгөөд Европын Холбооны Зөвлөл (Сайд нарын зөвлөл) түүнийг нь эцэслэн батална. Өргөн утгаараа Сайд нарын зөвлөл нь хэлэлцээ хийх ерөнхий удирдамжийг гаргаж өгдөг ба Европын комисс үүнийг нь яг бодит хэлэлцээний үед дагаж мөрддөг. Тэгэхээр бие даасан гишүүн улс бүр худалдааны хэлэлцээ хийх өөрсдийн бүрэн эрхээ Европын Комисст тавиад өгчихсөн байдаг байна.</p>
472	European Communities	<p>Европын хамтын нийгэмлэгүүд. Энэ нь, Европын хамтын нийгэмлэгийн ганц Комисс ба бусад байгууллагын түвшний олон өөрчлөлтүүдийг бий болгосон Нэгдэх тухай олон улсын хэлэлцээрийг (Merger Treaty Establishing a Single Council of the European Communities) 1965 онд батлах үед бий болсон нэр томьёо. Европын Комисс нь Европын атомын эрчим хүчний нийгэмлэг, Европын Нүүрс ба гангийн хамтын нийгэмлэг (Европын Холбоо), Европын Эдийн засгийн хамтын нийгэмлэгийг удирддаг тусдаа байгууллагуудыг нэгтгэсэн. Эдгээр хамтын нийгэмлэгүүд нь тусдаа хуулийн этгээдүүд байдлаар оршсоор байна. Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн 11-р Зүйлд Европын хамтын нийгэмлэгийг ДХБ-ын гишүүн гэж ойлгож, тайлбарласан байдаг. Учир нь тухайн үед, Европын хамтын нийгэмлэг нь Европын нүүрс ба гангийн хамтын нийгэмлэг (ECSC) болон Атомын эрчим хүчний хамтын нийгэмлэгийн цар хүрээнд хамаарах асуудлаар эрх мэдэл бий эсэх талаар эргэлзээ байсантай холбоотой юм. Эдгээр эргэлзээ эцэстээ үндэслэлгүй болохыг нотолсон. Мөн Европын комиссыг (European Commission) үзнэ үү.</p>
473	European Community	<p>Европын хамтын нийгэмлэг, ЕХ. Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС буюу нэгдсэн зах зээл) дараагийн үе залгамжлагч болж, Маастрихтын олон улсын хэлэлцээрийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд. Ихэнхдээ товчилсон хэлбэр нь бол ЕС гэдэг. “Европын хамтын нийгэмлэг” гэсэн нэр томьёог Маастрихтын гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө ЕЕС буюу Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг гэсэн утгатай ашигладаг байсан, гэхдээ бусад зохиогчид үүнийг Европын хамтын нийгэмлэгүүд (European Communities) гэсэн утгаар илэрхийлдэг байсан.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
474	European Community Single Market	<p>Европын хамтын нийгэмлэг буюу Европын Холбооны нэгдсэн зах зээл. Үүнийг Ромын олон улсын хэлэлцээрт оруулсан нэмэлт өөрчлөлт болох Европын нэгдсэн хуулиар дамжуулан 1987 онд эхлүүлж 1992 онд хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь Европын хамтын нийгэмлэгийн тухайн үеийн арван хоёр гишүүний хооронд үлдсэн биет (гаалийн), техникийн (стандарт, лицензийн) болон төсвийн саад бэрхшээлийг арилгахад хүргэсэн. Энэ нь нэг гишүүн улсад үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ нь хэрэв хүсвэл бусад гишүүн улсын [зах зээлд] чөлөөтэй саадгүй нэвтэрч болно гэсэн ганцхан утга биш бөгөөд энэ нь мөн түүний нэг гишүүн улс нь хууль ёсоор импортолсон л бол тэдгээр гадаадын бараа, бүтээгдэхүүн нь дараа нь бас бусад аль ч гишүүн улсын [зах зээл] рүү шилжүүлэгдэж болно гэсэн үг юм. Тухайн үед, үүнийг үүсгэн байгуулж байх үед хүртэл, энэ нь нэгдсэн зах зээлийг байгуулахад хүргэж чадахгүй бөгөөд цаашид шинэчлэл хийлгүйгээр Европын хамтын нийгэмлэг нь 12 үндэстний зах зээлээс бүрдсэн цуглуулга хэвээр үлдэх болно гэж үзэж байсан үзэл байдаг байсан. Ийм зах зээлийг бий болгоход шаардагдах хүчин чармайлтыг дутуу үнэлэхэд амархан байдаг боловч 1985 онд Европын Комиссын гаргасан Цагаан баримт бичигт Нэгдсэн зах зээлд хүрэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн 282 удирдамжийн (directives) төслийг оруулсан байгаагаас энэхүү дүр зургийг олж харж болно. Мөн Европын хамтын нийгэмлэгийн хууль тогтоомж (European Community legislation), дөрвөн эрх чөлөөний горимыг (four freedoms) үзнэ үү.</p>
475	European Economic Area	<p>Европын эдийн засгийн бүс (EEA). Үүнийг Европын хамтын нийгэмлэгийн 15 гишүүн улс, Европын чөлөөт худалдааны холбооны (EFTA) дөрвөн гишүүний хоёр улс (Исланд, Норвеги) бүрдүүлж байдаг бөгөөд энэ нь тэдгээр улсуудын хооронд нэгдсэн зах зээлийг бүрдүүлсэн байдаг. Европын чөлөөт худалдааны холбооны (EFTA) 4-дэх гишүүн болох Швейцарь улс нь 1992 оны 12-р сард Европын эдийн засгийн бүсэд (EEA) элсэхгүй байхаар шийджээ. Дараа нь Лихтенштейнийг Швейцарь улстай хамт гаалийн холбоо байгуулсан байдаг тул энэ бүсээс татан гаргахад хүргэжээ. Европын эдийн засгийн бүс буюу EEA нь 1994 оны 1-р сарын 1-нд байгуулагдсан. Европын чөлөөт худалдааны холбооны (EFTA) гишүүн улсуудын хувьд энэ нь, тусдаа бие даасан EFTA болон Европын хамтын нийгэмлэгт (EC) бүрэн гишүүн нь болж тэднийг элсэж орох хоёрын хоорондох завсрын алхам юм. Бодит практик амьдрал дээр бол Европын хамтын нийгэмлэгийн гишүүн бус улсууд Европын Холбооны бүх багц хууль, хууль тогтоомжуудыг (acquis communautaire) хүлээн зөвшөөрсөн байсан боловч тэдний хувьд хөдөө аж ахуйн болон загас агнуурын нийтлэг бодлогууд нь тэдэнд хамаарахгүй тул эдгээрийн зөвхөн тал хувийг нь ашиглаж байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
476	European Economic Community	Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС). Энэ нь 1957 оны 3-р сарын 25-нд үзэглэсэн Ромын олон улсын хэлэлцээрийн дагуу байгуулагдсан бөгөөд 1958 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү олон улсын хэлэлцээр нь "Европын ард түмнүүдийн хооронд улам бүр ойртсон нэгдлийн үндэс суурийг тавих" зорилготой байв. Үүний гол зорилтуудын нэг хэсэг нь, гишүүн улс орнуудын хоорондох тарифын болон тарифын бус саад тотгоруудыг арилгах, хүн хүч, үйлчилгээ, хөрөнгө чөлөөтөө урсаж хөдөлгөөнд байх нөхцөлд хүргэх нэгдсэн зах зээлийг бий болгох явдал байв. Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС) нь Хөдөө аж ахуйн нийтлэг бодлого, Худалдаа арилжааны нийтлэг бодлого, Тээврийн нийтлэг бодлого зэрэг хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг байна. Мөн өргөжүүлэлд (enlargement), Европын хамтын нийгэмлэг (European Community), Европын Холбоо (European Union), дөрвөн эрх чөлөөний горимыг (four freedoms) үзнэ үү.
477	European Free Trade Association	Европын чөлөөт худалдааны холбоо (EFTA). Мөн EFTA-г үзнэ үү.
478	European Patent Convention	Европын патентын конвенц. 1973 оны 10-р сарын 5-ны өдөр байгуулагдсан Европын патент олгох тухай конвенц нь гишүүн улс орнуудад патент олгох эрх зүйн нийтлэг тогтолцоог бий болгосон байдаг. Европын эдгээр патентууд нь гишүүн орнуудаас олгосон үндэсний патентуудад үр нөлөөтэй байдаг.
479	European Union-Mercosur Cooperation Agreement	Европын холбоо ба Меркосурын хамтын ажиллагааны хэлэлцээр. Энэ нь Мадрид хотод 1995 оны 12-р сарын 15-нд батлагдсан. Энэ нь түншүүдийн хоёр бүлгийн цаашдын хамтын ажиллагааны үйл явцыг тодорхойлж гаргасан байдаг. Үүнд хамруулах талбаруудын хувьд эдийн засаг, худалдаа арилжаа, аж үйлдвэр, гааль, статистик, оюуны өмч, хөрөнгө оруулалт, эрчим хүч, тээвэр, шинжлэх ухаан, технологи, харилцаа холбоо, мэдээллийн технологи, байгаль орчин, боловсрол, соёл урлаг, хар тамхины наймаа зэрэг орно. Эдгээр ажлыг сайд нарын түвшинд Хамтын ажиллагааны зөвлөлөөр дамжуулан хийх болно. Энэхүү хамтын ажиллагааны хэлэлцээр нь магадгүй 2005 он гэхэд хоёр бүлгийн хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад ч хүргэж болох юм. Мөн Меркосурыг (Mercosur) үзнэ үү.
480	Everything but arms	Зэвсгээс бусад бүх зүйлс. Нэн буурай хөгжилтэй орнуудаас гарал үүсэлтэй, зэвсгээс бусад бүх бараа бүтээгдэхүүнийг татваргүйгээр болон тоо хэмжээний хязгаарлалтгүйгээр зах зээлд нь нэвтрэх боломжийг олгосон Европын Холбооны санаачилга. Энэхүү арга хэмжээ нь элсэн чихэр, цагаан будаа, гадил жимсийг зах зээлд нэвтрүүлэхээс бусад бүх тохиолдолд 2001 оны 3 сарын 5-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон байна. Эдгээр бүтээгдэхүүнүүдийн хувьд 2009 он гэхэд зах зээлд нь чөлөөтэй нэвтрэх хүртэлх цаг хугацаанд шилжилтийн үеийг даван туулна.
481	EVSL	Салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
482	Exchange controls	Валютын хяналт. Оршин суугчдын хувьд хүртэж болох гадаад валютын нөөцийн цар хүрээнд засгийн газрын зүгээс нөхцөл тавьж эсвэл хязгаарлалт хийдэг. ДХБ-ын гишүүн орнууд ОУВС-ийн Холбооны дүрмийн холбогдох Зүйлийн дагуу валютын хяналтыг ашиглаж болох боловч тэд үүнийгээ ашиглахдаа ТХЕХ-ийн санаа зорилгыг алдагдуулалгүйгээр ашиглаж болно. Үйлчилгээний худалдааны хувьд тэдний зүгээс тодорхой үүрэг амлалт авсан байсан олон улсын шилжүүлэг болон урсгал гүйлгээний төлбөр тооцоон дээр хязгаарлалт тавьж болохгүй. Энэ хоёрын аль ч тохиолдолд, валютын хяналт нь хатуу тогтоосон нөхцөлийн дор төлбөрийн тэнцлийг хадгалан хамгаалах боломжтой байж болно. Мөн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон арга хэмжээний талаарх зөвлөгөөн (balance-of-payments consultations), худалдаа ба гадаад валютыг (trade and foreign exchange) үзнэ үү.
483	Exchange dumping	Валютын демпинг. Өнгөрсөн хугацаанд зарим нь үүнийг демпингийн нэг ангилал гэж авч үзэхийг зөвлөсөн байдаг. Энэ нь валютын ханшийг хуурамчаар үйлдэх замаар экспортлогчдодоо тухайн импортын зах зээлд давуу эрх олгох замаар ийм нөхцөл байдал үүсдэг гэж үзсэн байна. Гаванагийн дүрмийн хэлэлцээ хийх үеэр валютын демпинг гэж нэрлэсэн уг асуудлын талаар авч хэлэлцсэн боловч ийм арга туршлагатай хэрхэн харьцах талаар ямар нэгэн дүрэм журам тогтоож гаргаагүй байна. Худалдаа ба гадаад валютын асуудлаар хэлэлцээ хийх талаар зарим нь уриалж байгаа нь валютын демпингийн зарим хэлбэрүүд байсаар байна гэсэн байр суурин дээр үндэслэн гарч байгаа нь харагддаг.
484	Exchange of concessions	Буулт, хөнгөлөлтүүдийг харилцан солилцох. Олон талт худалдааны хэлэлцээний үед гарсан хүсэлт, саналуудын үр дүнд улмаар, хоёр тал тохиролцон үр дүнд хүрэх тохиолдол байдаг. Концесс нь явцуу утгаараа бол хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэгтэй боловч илүү өргөн хүрээнд үүнийг мөн тарифыг бууруулахад ашигладаг.
485	Exhaustion doctrine	Патентийн эрх эсвэл барааны тэмдгийн эзэмшлээс үүссэн эрх шавхагдах. Хэрэв зохиогчийн эрх эдэлж буй ном, компакт диск эсвэл бусад өөр бүтээл хууль ёсоор эдийн засгийн эргэлтэд орсон бол зохиогчийн эрхийг эзэмшигч нь цаашид тэдгээр бүтээлийн түгээлтэд хяналт тавих эрхгүй болно гэсэн номлол. Мөн параллель буюу зэрэгцүүлэн импортлохыг (parallel importation) үзнэ үү.
486	Excise duty	Онцгой албан татвар (акцизын хураамж). Заримдаа бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авах, худалдан борлуулах, ашиглахад засгийн газраас энэ татварыг ногдуулдаг. Үүний ердийн нэг жишээ бол архи, согтууруулах ундааг нэрэх болон борлуулахад ногдуулдаг татвар. Үндэсний нөхцөлийн тухай ДХБ-ын дүрмийн дагуу гадаадын болон дотоодын бүтээгдэхүүнүүдэд ижил хэмжээний онцгой албан татвар ногдуулах ёстой байдаг.
487	Exclusive Economic Zone	Эдийн засгийн онцгой бүс. Мөн НҮБ-ын тэнгисийн хуулийн конвенцыг (United Nations Convention on the Law of the Sea) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
488	Exclusive import rights	Импортын онцгой эрх. Энэ нь патент, зохиогчийн эрх болон оюуны өмчийн бусад эрхийг эзэмшигчдэд мөн ижил төрлийн оюуны өмчийн эрхийг агуулсан бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэн импортлох үйл ажиллагааг зогсоох боломжийг олгох практик туршлага. Зарим улс орнууд улсын худалдааны үйл ажиллагаанд зориулан тодорхой төрлийн бүтээгдэхүүнийг импортлох онцгой эрхийг олгодог. Мөн худалдааны эрхийг (trading rights) үзнэ үү.
489	Exclusive marketing rights	Маркетинг, борлуулалтын онцгой эрх (EMRs). Энэ нь эм зүйн бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүний патентын хамгаалалттай холбоотой Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудлын тухай хэлэлцээрт ашигладаг ойлголт. Уг гэрээний заалтуудыг хүчин төгөлдөр болгохын тулд тодорхой шилжилтийн зохицуулалтыг ашигласан тохиолдолд EMR-ийг таван жилийн хугацаанд ашиглах боломжтой.
490	Explicit harmonisation	Нарийн тодорхой уялдуулан зохицуулалт. Энэ нь урьдчилан тодорхойлсон ба хуулиар үүрэг хүлээж заавал биелүүлэх хоёр талт, бүс нутгийн, дэлхий дахины нэгэн жигд стандарт хэм хэмжээг тогтоохын тулд засгийн газруудын хооронд буй болсон хамтын ажиллагааны нэг хэлбэр. Энэ нь олон улсын бүтэц хамрах хүрээнд эсвэл олон улсын байгууллагуудын хүрээнд шийдвэр гаргахад чиглэсэн стандарт хэм хэмжээг боловсруулахын тулд үндэсний бүрэн бие даасан байдлаас зарим талаар холдоход хүргэдэг байна. Мөн уялдуулан зохицуулалт (harmonisation), тэг ашигтайгаар уялдуулсан зохицуулалтыг (zero-margin harmonisation) үзнэ үү.
491	Export	Экспорт. Энэ нь нэг улсын оршин суугчид нөгөө улсын оршин суугчдад ихэвчлэн гадаад валютаар худалдаж борлуулсан бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ. Мөн бартер (barter), Угтвар худалдаа (countertrade) үзнэ үү.
492	Export cartel	Экспортын картель. Мөн картелийг (cartel) үзнэ үү.
493	Export controls	Экспортын хяналт. Экспортын урсгалыг хянах зорилгоор экспортлогч орнуудаас тогтоосон арга хэмжээ. Тэдгээрийн хувьд ийнхүү хяналт тавих болсон олон шалтгаан байдгийн дотор дараах шалтгаанууд багтах боловч энэ нь эцэслэн гаргасан бүх жагсаалт нь биш. Үүнд: НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээг дагаж мөрдөх, сайн дураар хязгаарласан зохицуулалтыг дагаж мөрдөх, түүхий эдийн олон улсын зохицуулалтын дагуу экспортын квотыг баримтлах, стратегийн экспортын менежмент, хоёрдмол зорилготой экспортын асуудлыг хөндсөн дүрэм журмыг удирдан зохицуулах, дотоодын үйлдвэрлэл эсвэл хэрэглээнд зориулж зарим түүхий эд материал болон бусад зүйлсийг хадгалан нөөцлөх бодлого зэрэг ордог. Мөн саарал бүсийн арга хэмжээ (grey-area measures), Ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологийн экспортын хяналтын Вассенаарын хэлэлцээрийг (Wassenaar Arrangement on Export Controls for Conventional Arms and Dual-Use Goods and Technologies) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
494	Export credits	<p>Экспортын зээл. Бараа, үйлчилгээг импортлогч/худалдан авагчийн төлбөрөө төлөх хугацааг нь сунгаж өгч байгаа хэлбэр. ЭЗХАХБ-ын (OECD) гишүүн улс орнууд Албан ёсны дэмжлэг хүлээсэн экспортын зээлийн Удирдамжийн талаарх зохицуулалтын дагуу засгийн газрын дэмжлэгтэйгээр олгож буй экспортын зээлийг удирдан зохицуулж байдаг. Өнөө үед нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн практик арга туршлага бол зээлийн эргэн төлөлтийн хугацааны хувьд, богино хугацаанд бол хоёр жилээс доош хугацаанд, дунд хугацаанд бол хоёроос таван жилд, урт хугацаанд бол таваас дээш жилд гэж тооцдог. Олон экспортлогч орнууд экспортын зээлийг удирдан зохион байгуулах, дэмжих, баталгаа гаргах механизмтай байдаг, ялангуяа цахилгаан станцууд эсвэл боомтын байгууламж гэх мэт томоохон гэрээ байгуулагдсан тохиолдолд зээлийн хөнгөлөлттэй нөхцөл нь тендерийн өрсөлдөх чадварыг сайжруулахад ихээхэн нөлөөлдөг. ДХБ-ын “Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт” хэрэв экспортын зээл нь арилжааны үнээс бага хэмжээгээр тогтоогдсон байвал экспортын зээлийг хориглоно гэж заасан байдаг. OECD-ийн зохицуулалтын дагуу OECD-ийн гишүүн орнуудаас гаргасан экспортын зээлийг энэхүү хориглоос чөлөөлсөн болно.</p>
495	Export culture	<p>Экспортын соёл. Өрсөлдөх чадвартай экспорт нь үндэсний эдийн засгийн сайн сайханд хувь нэмэр оруулдаг учраас олон улсын зах зээлд оролцох нь эн тэргүүний чухал ач холбогдолтой асуудал юм гэсэн ойлголт хувь хүмүүс, компани аж ахуйн нэгжүүд, засгийн газруудад байдаг байна. Экспортын соёлыг сурталчлах, тогтвортой байлгах нь экспортод учруулж буй дотоодын бүтцийн түвшний саад тотгорыг арилгах, бусад улс орнуудын зах зээлд нэвтрэх тал дээр үл ялгаварласан нөхцөлийг хангаж ажиллахыг шаарддаг.</p>
496	Export earnings guarantee schemes	<p>Экспортын ашиг орлогын баталгааны схем. Энэ нь түүхий эд үйлдвэрлэгчид эсвэл түүхий эдийн экспортын орлогоос ихээхэн хамааралтай улс орнуудыг орлогын хэмжээ нь огцом буурах нөхцөлд бүхлээрээ өртчихгүй байх нөхцөлийг хангахад ихэвчлэн чиглэсэн механизмууд байдаг. Эдгээр механизмуудыг мөн нөхөн олговрын санхүүжилтийн зохицуулалт гэж нэрлэсэн байдаг. Ийм механизмын алдартай жишээ бол Ломе-гийн конвенцын дагуу Европын хамтын нийгэмлэгийн удирдан зохицуулж байдаг STABEX ба SYSMIN юм. ОУВС-ийн нөхөн төлбөрийн ба болзошгүй зардлын санхүүжилтийн хэрэгсэл (IMF Compensatory and Contingency Financing Facility) гэдэг бол цар хүрээний хувьд илүү өргөн хүрээний механизм юм.</p>
497	Export incentives	<p>Экспортын урамшуулал. Энэ нь дотоодын компаниудын экспортыг өргөжүүлэхэд чиглэсэн засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ. Ийм арга хэмжээнд шууд үзүүлэх татаас, шагнал, экспортын бүтээгдэхүүнд угсарч, уялдуулж оруулах бүрэлдэхүүн хэсгүүдэд нь зориулж импортын тарифыг бууруулах, татварын хөнгөлөлтүүд гэх мэт зүйлсийг оруулж болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Татаас болон Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр нь бүтээгдэхүүний экспорттой холбоотой татаасыг хамарсан, экспортын зарим төрлийн урамшууллыг хууль бус болгодог байна. Мөн Засгийн газрын урамшуулал буюу татаас (bounty), экспортын татаасыг (export subsidies) үзнэ үү.
498	Export inflation insurance schemes	Экспортын инфляцийн даатгалын схем. Эдгээр нь ялангуяа 1970-аад оны өндөр инфляцтай орчинд засгийн газруудын зүгээс хэрэгжүүлсэн схемүүд байлаа. Эдгээрийг экспортын хэлэлцээрүүдийн өртгөөс улбаатай мөнгөний инфляцын нөлөөллийг багасгах эсвэл арилгах зорилготойгоор боловсруулсан байв. Ийм схемийг баримталдаггүй улс орнууд тэднээс ашиг олж буй экспортлогчдод өрсөлдөөний давуу талыг олгосон гэж мэдэгдэж байсан, учир нь тэд инфляцын зардлыг дангаараа үүрэх шаардлагагүй болно гэсэн итгэл үнэмшилтэй байсан тул эдгээр экспортлогчид олон улсын зах зээл дээр илүү түрэмгий үнийг санал болгож чадна. Ийм схем нь татаасыг бий болгосон эсэхийг шалгаж үзэхээр 1978 онд ТХЕХ-ийн хүрээнд байгуулсан маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн дүгнэж үзсэнээр бол хэрвээ даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь “урт хугацааны үйл ажиллагааны зардал болон алдагдлыг нөхөхөд илт хангалтгүй байсан” бол энэ үнэхээр үнэн байх болно гэж үзсэн байна. Инцляци багатай өнөөгийн орчинд ч байсаар байх магадлалтай ийм шинж чанартай, ашиглагдахгүй байгаа аливаа схемийн хувьд, “урт хугацааны” хэмээх энэ утгыг тодорхойлох шаардлага байсаар байна гэж мөн цохон тэмдэглэсэн байна.
499	Exporting unemployment	Ажилгүйдлийг экспортлох. Хэрэв импортын урсгалыг ямар нэгэн байдлаар таслан зогсоох юм бол дотоодын эдийн засгийн үйл ажиллагааг өсгөж, улмаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж болно гэсэн бүрхэг санаа. Өөрөөр хэлбэл, энэ санааг дэмжигчид ажилгүйдлийн дарамтыг бусад улс руу шилжүүлж, импортыг мухардуулж, буланд шахах замаар дотооддоо ажлын байрыг хамгаалах, нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байгаа юм. Ерөнхийдөө ийм практик туршлагын хувьд импортыг орлох гэсэн илүү хүлээн зөвшөөрөгдөхүйц нэр томьёог ашигладаг. Ийм бодлого нь богино хугацаанд хэрэгжих боломжтой боловч эцэст нь дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар буурснаас үүдэх зардлаас шалтгаална. Импортыг орлох бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах хүчин зүйл бол импортын олон бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн үйл явцад орж байдаг явдал юм. Тэдний үнийг өсгөх нь дотоодын үйлдвэрлэгчдийн зардлыг нэмэгдүүлдэг. Өсөн нэмэгдэж буй зардал нь худалдан авагчдад таагүй нөлөө үзүүлдэг тул энэ нь эдийн засгийн идэвхжил муудахад хүргэж болзошгүй юм. Тиймээс ажилгүйдлийг экспортлох хэмээх санааны зорилго нь ажилгүйдэл нэмэгдэхэд хүргэж болзошгүй юм. Мөн гуйлгачин хөршийн бодлогууд (beggar-thy-neighbour policies), дотоодын/үндэсний агуулгын тухай журам (local content rules), оновчтой тарифын маргааныг (optimal-tariff argument) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
500	Export of domestically prohibited goods	<p>Дотоодын зах зээлд хориглосон бараа бүтээгдэхүүний экспорт. Эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс дотоодын зах зээлд борлуулахыг зөвшөөрдөггүй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зарим улс орнуудад зөвшөөрсөн байдаг байна. Практик амьдрал дээр ийм жишээг олоход хэцүү байдгийг эхэнд нь тэмдэглэж хэлэх ёстой. Импортлогч орнууд тэдгээр үйлдвэрлэгч нарт өөрсдийн зах зээлээ нээх зөвшөөрлийг ямар цар хүрээнд олгох ёстой вэ гэдэг тал дээр өөр өөр байр суурь байдаг. Хэрэв тухайн улс ийм бүтээгдэхүүнийг дотоодынхоо зах зээлд нэвтрүүлэх талаар ёс суртахууны хувьд эргэлзээгүй хүчтэй байна гэж үзвэл мөн тэдгээр бүтээгдэхүүнийг экспортлохыг хориглох тал дээр баттай итгэл үнэмшилтэй байх ёстой гэж зарим хүмүүс хэлдэг. Бусад хүмүүс импортлогч орнууд ийм бүтээгдэхүүнийг хүлээн авах ямар нэгэн үүрэг хүлээгээгүй гэж хэлдэг. Ийм барааны экспортод улс орнууд оролцох эрхтэй гэж маргадаг тэдгээр нэгнүүдийн хувьд энэхүү маргаан нь тийнхүү цэвэр хамгаалалтын арга хэмжээ болж хувирдаг боловч олон тохиолдолд бодит байдал тийм ч хялбархан бус байдаг. Энэхүү хүнд хэцүү асуудал нь ТХЕХ-ийн ажлын хөтөлбөрт 1982 оноос хойш гарч ирсэн байдаг. ДХБ одоо үүнийг даван туулж байгаа бөгөөд шийдэл нь шууд бэлэн болчихоогүй л байна.</p>
501	Export of jobs	<p>Ажлын байрыг экспортлох. Заримдаа үйлдвэрчний эвлэлүүд болон эмзэг салбарт ажилладаг боловсруулах үйлдвэрлэгчид импортын бүтээгдэхүүн гэдэг нь ажлын байрыг экспортлох гэсэн утгатай байдаг гэсэн ташаа ойлголттой байдаг, учир нь гадаадад хийгдсэн аливаа нэг захиалга гэдэг нь гадаад улсад одоо хэн нэгэн ажилтай болж байна гэсэн үг гэж үздэг. Ихэнх тохиолдолд санал болгодог арга бол импортыг орлуулах зорилгоор илүү өндөр тарифыг санал болгодог. Гэсэн хэдий ч ийм бодлого нь нийт эдийн засагт илүү их зардал гарахад хүргэдэг тул улмаар илүү их ажилгүйдэлд хүргэсэн, илүү өрсөлдөөн багатай болгодог байна. Мөн ажилгүйдлийг экспортлох (exporting unemployment) гэдгийг үзнэ үү.</p>
502	Export participation rate	<p>Экспортын оролцооны түвшин. Энэ нь ихэвчлэн тухайн эдийн засаг дах тухайн өгөгдсөн салбарт ажиллаж буй хэчнээн компаниуд бараа, үйлчилгээг экспортолсон эсвэл экспортлох оролдлого хийдэг болохыг харуулсан хэмжилт. Экспортын оролцооны түвшин гэдэг нь тухайн улс нь экспортын соёлыг ямар цар хүрээнд эзэмшсэнийг үнэлэх хэрэгцээтэй арга хэрэгсэл.</p>
503	Export performance requirements	<p>Экспортын гүйцэтгэлийн шаардлага. Энэ нь тухайн улсын экспортыг өргөжүүлэх зорилготойгоор, өөрийн нутаг дэвсгэртээ гадаадын хөрөнгө оруулалт хийх эрх олгож байгаа тус улсын зүгээс тавьдаг нөхцөл. Хамгийн энгийнээр тайлбарлахад, гадаадын хөрөнгө оруулалттай байгуулагдсан аж ахуйн нэгж нь үйлдвэрлэлийнхээ гарц бүтээгдэхүүний үнийн дүн эсвэл тоо хэмжээгээр илэрхийлсэн тодорхой хувийг нь экспортлох ёстой. Бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн хувьд тэд өөрсдийн импортыг экспорттой тэнцвэржүүлэх хэрэгтэй болж магадгүй. Худалдаатай холбогдолтой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу экспортын гүйцэтгэлийн ихэнх шаардлагуудыг үе шаттайгаар халах хэрэгтэй байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
504	Export pessimism	Экспортын гутранги байдал. Энэхүү үзэл нь 1950-иад онд Латин Америкийн бүс нутгийн хөгжиж буй орнуудын хувьд баримталж байсан импортыг орлох бодлогын хөгжил цэцэглэлтийн үед түгээмэл байсан. Энэ нь тэдний экспортын өчүүхэн хэмжээ эдийн засгийн хөгжлийг ахиулж чадахгүй, олон улсын интеграцилал нь тухайн эдийн засгийн хувьд хүрч чадсан ямар ч өрсөлдөх чадварыг сааруулна гэсэн таамаглал дээр үндэслэсэн байв. Импортыг орлох нь цорын ганц бодитой бодлого байсан гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Мөн хараат байдлын онол (dependence theory) үзнэ үү.
505	Export propensity	Экспортын таатай байдал. Энэ нь бусад зах зээлд экспортолж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь. Мөн экспортын оролцооны түвшинг (Export participation rate) үзнэ үү.
506	Export processing zones	Экспортын бараа бүтээгдэхүүнийг боловсруулах бүс. Мөн чөлөөт худалдааны бүсийг (free-trade zone) үзнэ үү.
507	Export quotas	<p>Экспортын тоо хэмжээний хязгаарлалт/квот. Энэ нь экспортлогч улсын хувьд тодорхой бүтээгдэхүүний нийт үнэ, эсхүл тоо хэмжээнд ногдуулж буй хязгаарлалтууд, эсхүл дээд тааз хэмжээ. Эдгээр нь дотоодын үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг эдгээр бүтээгдэхүүний түр зуурын хомсдолоос хамгаалах, эсхүл нийлүүлэлтийг багасгаснаар тодорхой бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийг сайжруулах зорилготой. Өмнө дурдсан боломжуудын зөвхөн сүүлийнх нь боломжтой, үүнд нэг улс эсвэл хэсэг бүлэг улс тухайн бүтээгдэхүүний хувьд давамгайл экспортлогчид байгаа тохиолдолд энэ нь боломжтой. Эдийн засгийн заалт бүхий Түүхий эдийн олон улсын хэлэлцээр нь үнэ тогтворжуулах зорилгодоо экспортын квот, заримдаа хязгаарлалтын нөөц түүхий эд, материалтайгаа хавсруулан хэрэглэх замаар хүрч чаддаг байна.</p> <p>ТХЕХ-ийн 20(h)-р Зүйл нь (Эс хэрэглэх нийтлэг тохиолдол), 1947 оны НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийн (ECOSOC) зарчимтай нийцэж буй, түүхий эдийн аливаа олон улсын хэлэлцээрийн дагуу тэдний хүлээн зөвшөөрсөн үүрэг амлалтыг нь дэмжсэн арга хэмжээг батлан хэрэгжүүлэхийг гишүүн улс орнууддаа тусгайлан зөвшөөрсөн байдаг. Үүнийг Гаванагийн дүрмийн 6-р бүлэгт мөн тусгасан байдаг. ТХЕХ-ийн 20-р Зүйл нь мөн “засгийн газрын тогтворжуулалтын хөтөлбөрийн нэг хэсэг нь болсон, тухайн материалын үнийг дэлхийн дундаж үнээс доогуур тогтоон барьж байсан хугацаанд дотоодын боловсруулах үйлдвэрлэгч нарт тийм материалын нэн чухал хэрэгцээтэй тоо хэмжээг хангаж ажиллахын тулд шаардлагатай байгаа уг дотоодын материалын экспортод хязгаарлалт тавьж” ажиллахыг гишүүн улс орнууддаа зөвшөөрсөн байдаг боловч, тийм хязгаарлалтыг тухайн түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх эсвэл уг түүхий эдэд илүү их хамгаалалт олгох зорилгоор ашиглаж болохгүй. Хэзээ нэгэн цагт экспортын квотын эсрэг нотлох баримтад ашиглаж болох шалтгаануудын хувьд дараах нөхцөлүүдийг дурдсан байна: (а) хямд өртөгтэй үйлдвэрлэгчид болон зах зээлд шинээр орж буй оролцогчдын эсрэг ялгаварлах хандах хандлага,</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>(b) хомсдолыг арилгах чадваргүй байдал, (c) тэд үйлдвэрлэгчдийн дунд хамгаалагдсан үнийн түвшингийн үндэслэлгүй хүсэн хүлээлтийг үүсгэж болзошгүй, (d) хэрэг дээрээ тэд үр ашиг илүү багатай үйлдвэрлэгчдэд хамгийн бага үнийн баталгаа олгосноор зах зээлд илүү багыг нийлүүлэх байсан зорилгынхоо эсрэг үйлчлээд эхэлчихэж магадгүй юм, (e) зохиомлоор буй болгосон өндөр үнэ нь эцсийн хэрэглэгчдийг тухайн бараа бүтээгдэхүүний хэрэгцээг бууруулан орлуулагч, синтетик эсвэл шинэ технологийг ашиглахыг хөхиүлэн дэмжих, (f) зах зээлд бий болсон бүтцийн өөрчлөлт нь, жишээлбэл, эцсийн хэрэглэгчдийн эрхэмлэх сонголтод өөрчлөлт авчрах эсвэл үйлдвэрлэгчдэд түшиглэсэн шинэ технологиуд нэвтрэх зэрэг өөрчлөлтүүд нь квотын тал дээр хэлэлцээ хийх, квотыг цагдан хянахад ерөнхийдөө хүндрэлтэй болох, (g) экспортын квоттой хэлэлцээрт бүх томоохон үйлдвэрлэгч нарыг гишүүнээр элсүүлэх нь үргэлж хүндрэлтэй байсан бол, (h) бага зэргээр хэтрүүлсэн ханган нийлүүлэлтийн үед ч гэсэн багахан хэмжээний нэмэлт экспорт хийгдэж байсан нь пропорциональ бус нөлөө үзүүлж байж болно. Зарим нь Түүхий эдийн уялдуулан нэгтгэсэн хөтөлбөр нь түүний гишүүнчлэлийн нийтийн шинж чанараас болж үүсч болох эдгээр ихэнх хүндрэлүүдийн эсрэг хамгаалалт болж өгч чадна гэж мэтгэлцдэг боловч, уг уялдуулан нэгтгэсэн хөтөлбөрийг хэлэлцэж байсан 1976 оноос хойших түүхий эдийн хэлэлцээний түүхээс харахад энэ нь энэхүү нэхэмжлэл шаардлагыг хангалттай хэмжээнд дэмждэггүй байна. Мөн түүхий эд, материалын бодлогыг (commodity policy) үзнэ үү.</p>
508	Export restitution	<p>Нөхөн төлбөр олгох замаар экспортыг сэргээн босгох. Хөдөө аж ахуйн нэгдсэн бодлогын дагуу экспортын татаасыг худалдаачдад олгосноор тэдэнд дотоодын өндөр үнэ болон дэлхийн зах зээлийн доогуур үнийн зөрүүг арилгах боломжтой байдаг байна.</p>
509	Export restraint arrangement	<p>Экспортын хязгаарлалтын зохицуулалт. Мөн сайн дурын хоригийн зохицуулалтыг үзнэ үү.</p>
510	Export subsidies	<p>Экспортын татаас. Засгийн газрын зүгээс дотоодын үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчдод хэрэв тэд бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээгээ экспортолдог бол олгодог төлбөр, эсхүл санхүүгийн бусад арга хэрэгсэл. Эдгээр нь "Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр"-ийн тайлбарын дагуу бол хууль бус гэж үздэг байна. Мөн экспортын урамшууллыг (export incentive) үзнэ үү.</p>
511	Export targeting	<p>Экспортын замыг/зах зээлийг тодорхойлох. Экспортлогч улсын хувьд ялангуяа өөрийн бүтээгдэхүүний хувьд ирээдүйтэй гэж үзсэн зах зээлүүдийг сонгох арга туршлага. Шударга бус худалдааны арга барилыг ашиглах үед импортлогч орнуудын үйлдвэрлэгчдийн нүдээр харвал уг практик туршлага нь буруушаамаар зүйл болж хувирдаг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Иймээс тэд 301-р хэсгийн дагуу үүнийхээ үндэслэлийг гаргаж өгч магадгүй. Экспортын замын зургийг тодорхойлохыг эсэргүүцэгч нар ихэвчлэн импортын замыг тодорхойлох эсвэл бусдад сайн дураар импортыг өргөжүүлэх хөтөлбөрийг тулгах зэрэг аргын талаар мөн адилхан эргэлзээ байдаггүй нь сонирхолтой юм.
512	Export tariffs	Экспортын тариф. Үндэсний гаалийн нутаг дэвсгэрээс гарч байгаа үед нь уг бараа бүтээгдэхүүн, эсхүл түүхий эд материалд ногдуулдаг татвар хураамж. Экспортын тарифыг ногдуулах шалтгаануудад, орлогыг нэмэгдүүлэх, улс орон дотроо түүхий эдийг улам гүн боловсруулах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих хүсэл, дотоодын аж үйлдвэрлэлд хомс бөгөөд хэрэгцээтэй гэж үзсэн бараа түүхий эдийг дотоодын үйлдвэрлэлд аль болох их хэмжээгээр нөөцлөх бодлого баримтлах зэрэг асуудлууд ордог. Мөн давхар үнэ тогтоох (double pricing), Лернерфийн тэгш хэмийн теорем (Lernerfs symmetry theorem), ханган нийлүүлэлт багатай бүтээгдэхүүнийг (short-supply products) үзнэ үү.
513	External trade	Гадаад худалдаа. Энэ нь нэгдүгээрт, ерөнхийдөө “foreign trade” гэдэгтэй ижил утгатай. Хоёрдугаарт, худалдааны хөнгөлөлттэй нөхцөлтэй гишүүн улсын гишүүн бус улстай хийсэн гадаад худалдааг хэлж бас болдог. Харин худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийн зохицуулалттай түнш орнуудын хооронд хийгдэж байгаа худалдааг дотоод худалдаа (internal trade) гэж нэрлэдэг.
514	Extraterritoriality	Дотоодын хуульд эс захирагдсан/нутаг дэвсгэрийн гадна. Аливаа улс өөрийн улсын хилийн гадна шүүн таслах ажиллагаа эсвэл дотоодынхоо хуулийг хэрэгжүүлэх гэсэн оролдлого. Энэ нь шүүх эрх мэдлийн харьяалах өөр нутаг дэвсгэрт амьдарч эсвэл үйл ажиллагаа явуулж буй тухайн нэг улсын харьяат иргэдэд эсвэл тус улсын харьяат иргэний удирдаж байдаг аж ахуйн нэгжид, дотоодынхоо хууль тогтоомжийг зориудаар эсвэл далд хэлбэрээр хэрэглэж байгаа үйлдлийг хэлнэ. Дотоодын хуульд эс захирагдсан, нутаг дэвсгэрийн гадна байгаа тохиолдолд Эс хэрэглэх нийтлэг тохиолдлыг (general exceptions) хэрэглэх асуудлын талаарх ТХЕХ-ийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн зүгээс авч үзсэн туна загасны хэрийг (tuna case, Mexico-United States, 1991) үзнэ үү. Мөн итгэлцлийн эсрэг буюу Монополийн эсрэг(antitrust laws), Д’Аматогийн хууль тогтоомж (D’Amato legislation), Нөлөөллийн тухай номлол (effects doctrine), Хелмс-Биортоны хууль тогтоомжийг (Helms-Burton legislation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
515	Factor proportion theory	Хүчин зүйлүүдийн тэнцвэрт харьцааны онол. Мөн Хекшир Олин-ийн теоромийг (Heckscher-Ohlin theorem) үзнэ үү.
516	Failing-firm doctrine	Дампуурч буй компанийн номлол. Энэ нь АНУ болон бусад монополын эсрэг хуулиудын дагуу гарсан номлол. Хэрэв зарим нөхцөл хангагдсан бол, өөр тохиолдолд бол хууль бус байж болох тийм нэгдэх үйл ажиллагааг (mergers) зөвшөөрдөг. Үүнд ихэвчлэн, (a) бизнесийн үйл ажиллагааны ихээхэн доголдсон байж болох нөхцөл, (b) ямар нэгэн бусад боломжийн худалдан авагчид багатай, (c) тухайн компанийг амжилттайгаар дахин зохион байгуулах боломж хомс байх зэрэг нөхцөлүүд орно. Мөн Хямралын үеийн картелийг (crisis cartel) үзнэ үү.
517	Fair and equitable treatment	Шударга, адил тэгш нөхцөл. Засгийн газрын импортын худалдан авалттай холбогдуулан улсын худалдаа арилжаа эрхлэх талаар ТХЕХ-ийн 17-р Зүйлд (Худалдаа эрхлэгч улсын аж ахуйн нэгжүүд) заасан үүрэг. Энэхүү үүрэг нь, Үндэсний нэн тааламжтай нөхцөлийнх (MNF) шиг адилхан хүчтэй биш боловч анхандаа үл ялгаварлах нөхцөлийг байж болох хамгийн дээд хэмжээнд нь олгох зорилготой байв.
518	Fair competition	Шударга өрсөлдөөн. Энэ нь олон талт худалдааны тогтолцооны үл ялгаварлах журмын хүрээнд л олон улсын худалдааг удирдан явуулах ёстой гэсэн санал худалдааны бодлогод гарч ирсэн байна. Заримдаа үүнийг Бүх оролцогчдод шударга өрсөлдөөний эрх тэгш талбарыг бий болгох, шударга худалдаа эрхлэх (level playing field) гэж нэрлэдэг. Худалдаан дах шударга өрсөлдөөний нэг бүрэлдэхүүн хэсэг бол өрсөлдөөнийг тодорхой хязгаар дотор байлгах явдал. Ингэж чадаагүй тохиолдолд демпингийн эсрэг арга хэмжээ, татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэглэж болох юм. Өрсөлдөөний бодлогын хувьд шударга өрсөлдөөн гэдэг нь ихэвчлэн өрсөлдөөнийг дэмжсэн хууль тогтоомжуудад нийцүүлэн бизнес эрхлэхийг хэлдэг. Мөн шударга тэгш өрсөлдөөн (equitable competition), шударга худалдааг (fair trade) үзнэ үү.
519	Fair labour standards	Хөдөлмөрийн шударга хэм хэмжээ (стандарт). Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ (стандартууд) (core labour standards), нийгмийн шинж чанартай заалтыг (social clause) үзнэ үү.
520	Fair trade	Шударга худалдаа. Энэ нь хэд хэдэн утгатай. Энэ нь уг тогтолцоонд оролцогчид эрх, үүргийг тэнцвэржүүлж, дагаж мөрдөж байдаг худалдааны тогтолцоо байж болно. Зарим тохиолдолд энэ нь татаас, эсхүл татаасаас хамааралгүйгээр худалдаа хийх гэсэн утгатай байж болно. 1980-аад оны үед шударга худалдааг зарим хүмүүс хоёр талын худалдааны тэнцвэрт байдалд хүчээр хүрэх гэх мэтээр удирдан зохицуулсан худалдаатай илүү төстэй зүйл гэж тодорхойлсон байдаг. Өрсөлдөөний бодлогод, тухайн улсын өрсөлдөөний хууль тогтоомжид тайлбарласны дагуу өрсөлдөөний-эсрэг зан үйлгүйгээр арилжааны үйл ажиллагааг явуулахыг шударга худалдаа гэж заасан байдаг. Тухайн агуулга нь ихэвчлэн зорьсон утгыг нь тодорхой илэрхийлж байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
521	Fair-use doctrine	Шударга хэрэглээний номлол. Зохиогчийн эрхийг зөрчсөн гэсэн нэхэмжлэл гарахад хүргэлгүйгээр, ялангуяа эрдэм шинжилгээний ажлын зорилгоор бол эшлэлийг иш татах замаар зохиогчийн эрхийн дор хийгдэж байгаа ажлыг хязгаарлагдмал хүрээнд татаж авч болно гэсэн санал. Тухайн тохиолдолд уг хэрэглээг шударга хэрэглээ гэж үзэх эсэх нь тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаарна. Мөн оюуны өмчийн эрх (intellectual property rights), оюуны өмчийн эрхийг зөрчлийг (intellectual property right infringements) үзнэ үү.
522	Farmers' rights	Фермерүүдийн эрх. Эдгээр эрх нь Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын (FAO) боловсруулсан үзэл баримтлал. Энэ нь ялангуяа ургамлын аймгийн анхны гарал үүслийн төвүүдэд байгаа, ургамлын генетик нөөцүүдийг хамгаалж, сайжруулж, бусдад хүртээмжтэй болгоход өнгөрсөн, одоо, ирээдүй цагт фермерүүдийн оруулж буй хувь нэмрээс үүдэж бий болсон эрх хэмээн нэрлэдэг байна. FAO-гийн хэлж байгаагаар бол фермерүүдийн эрх гэдэг нь жишээлбэл оюуны өмчийн эрх гэдэг шиг ямар нэгэн тодорхой сорт, ургамлын төрөл зүйл, эсвэл тодорхой тариаланчдад хамаардаггүй. Фермерүүдийн эрхийн гол зорилго бол фермерүүд болон фермийн аж ахуй эрхлэгчдийг ургамлын генетик нөөцийг өсгөж үржүүлж, хадгалан хамгаалж, ашиглаж, сайжруулахыг нь хөхиүлэн дэмжих зорилготой. Тиймээс фермерүүдийн эрх нь фермерүүдийн урт удаан хугацааны туршид сайжруулах чиглэлээр хийсэн ажлынх нь төлөө, оюуны өмчөөр дамжуулан хийсэн хамгаалалтаас үр ашиг хүртэх боломжгүй байж магадгүй байгаа тул фермерүүдэд нөхөн олговор олгох нэг арга гэж үзэж байна. Мөн уламжлалт мэдлэгийг (traditional knowledge) үзнэ үү.
523	Favourable-balance-of-trade objective	Худалдааны таатай тэнцэлд хүрэх зорилт. Мөн Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) үзнэ үү.
524	Fetish of industrialisation	Үйлдвэржилтийн шүтээн. Клайр Вилкоккс нь ДХБ-ын дүрэмд ашигласан энэхүү үг хэллэгийг, түүний нэрлэснээр бол, хөгжил буурай орнуудыг амьдралынхаа түвшинг сайжруулахыг шаардсан шаардлага болон тэд эдийн засгаа зөвхөн эрчимтэй аж үйлдвэржүүлж байж л ингэж сайжруулж чадна гэсэн оновчтой бус итгэл үнэмшлийг тайлбарлахдаа ашигласан ажээ. Үүнд бараг үргэлж л гадаад худалдааны хязгаарлалтууд дагалдаж байдаг юм хэмээн тэрээр тэмдэглэсэн байна. Мөн Хөгжиж буй улс орнууд болон ТХЕХ (Developing countries and GATT), импортыг орлуулах (import substitution), Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын мэтгэлцээн (infant-industry argument) үзнэ үү.
525	Fifth protocol to the General Agreement on Trade in Services	Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн 5 дугаар протокол. 1996, 1997 онуудад хийгдсэн хэлэлцээнүүдийн дараа санхүүгийн үйлчилгээний худалдаа хийх үүрэг хүлээх тухай протокол 1999 оны 3-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болжээ.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
526	Final goods and services	<p>Эцсийн гүн боловсруулалт хийгдсэн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ. Энэ нь эцсийн хэрэглэгчид худалдан авсан бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ. Эдгээрийг цаашдын үйлдвэрлэлийн процесст ашигладаггүй. Эдгээр нь завсрын үе шатны бараа, үйлчилгээнээс ялгагдана. Энэхүү ялгаа нь хэн худалдаж авахаас бүхэлдээ хамаарч байдаг. Гэртээ хэрэглэх цайны сав нь эцсийн бүтээгдэхүүн боловч өглөөний цай өгөх зорилгоор зочид буудлуудаас худалдаж авсан цайны аяга бол эцсийн үйлчилгээ үзүүлэхэд маш сайхан таарсан завсрын бүтээгдэхүүн болж байна.</p>
527	Financial services	<p>Санхүүгийн үйлчилгээ. Энэ бол банк, ерөнхий даатгал, амьдралын даатгал, сангийн менежмент, эдгээр үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны худалдаа, зөвлөх үйлчилгээ. Мөн Санхүүгийн үйлчилгээний тухай харилцан ойлголцох баримт бичиг [ойлголт] (Understanding on Financial Services), АНУ ба Японы санхүүгийн үйлчилгээний хэлэлцээрийг (United States- Japan financial services agreement) үзнэ үү.</p>
528	FIRA panel	<p>Гадаадын хөрөнгө оруулалтыг хянан дүгнэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах агентлагийн (FIRA) асуудлаар байгуулагдсан Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөл. Энэ бүрэлдэхүүн нь 1973 онд батлагдсан Канад улсын Гадаадын хөрөнгө оруулалтыг хянан дүгнэх тухай хуулийн (FIRA) талаар АНУ-ын гаргасан гомдлыг нягтлан үзэхийн тулд ТХЕХ-ийн дагуу 1982 онд байгуулагдсан байна. Энэхүү хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь импортын бүтээгдэхүүнээс илүү Канадын бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад давуу эрх олгох мөн экспортын гүйцэтгэлийн зарим шаардлагыг хангах зэрэг нөхцөлийг шаарддаг Канадын засгийн газартай хэлэлцээр байгуулах шаардлагатай болдог байсан байна. Бараа худалдан авах ажил нь ихэнх тохиолдолд Канад улсад үнэ, чанар, хүргэлт болон бусад хүчин зүйлүүдээс хамаарч олох боломжтой, олох харьцангуй боломжтой, өрсөлдөж байж олж авах боломжтой бараа бүтээгдэхүүнүүдээс хамаардаг байв. Хэлэлцээрүүдийн алийг нь ч шүүхийн системээр дамжуулан хэрэгжүүлж байгаагүй байна. Хоёр тал хоёулаа FIRA нь өөрөө бол асуудал биш, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг оруулах, өргөжүүлэх асуудлыг зохицуулах Канадын эрх нь ч өөрөө асуудал биш гэдэгтэй санал нэгдэв. Дотоодын бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад импортын бүтээгдэхүүнд илт арай доогуур хандсан байдлаар, Канад улсаас гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүнийг импортын бараа бүтээгдэхүүнээс илүүд үзэх байдлаар заавал худалдаж авах ёстой гэсэн нөхцөл нь ТХЕХ-ийн 111:4-р Зүйлтэй (National Treatment буюу Үндэсний нөхцөл) нийцэхгүй байна хэмээн Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг олж тогтоосон байна. Уг үүрэг албан бус байх үед ч мөн үүнийг ашигласан байсан байна, жишээ нь, олох боломжтой байгаа бараа бүтээгдэхүүний нөхцөлөөс хамаарч байгаа учраас энэ нь дотоодын бүтээгдэхүүнд илүү давуу эрх олгож байсан байна гэдгийг олж тогтоосон.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүнд 111: 4-р Зүйлд заасан цорын ганц зорилго нь дотоодын болон импортын бараа бүтээгдэхүүнд ижил тэгш нөхцөлөөр хандах ёстой гэж үзсэн байна. Түүнчлэн Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг нь Канад улсын ханган нийлүүлэгчдээс худалдан авах үүрэг хүлээх нь 111: 4-р Зүйлтэй мөн адилхан нийцэхгүй байгааг олж тогтоосон байна. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг, FIRA-гийнхаа хүрээнд дотоодын болон гадаадын бүтээгдэхүүнд ижил тэгш хандах байдлаар FIRA-г шинэчилж өөрчлөх боломжтой байж болох юм хэмээн зөвлөсөн байна.</p>
529	First Agreement on Trade Negotiation Among Developing Countries	Хөгжиж буй орнуудын дунд худалдааны хэлэлцээ хийх тухай анхны хэлэлцээр. Мөн Бангкокийн гэрээг үзнэ үү.
530	First-difference negotiations	Анхдагч ялгаатай байдалтай холбогдолтой хэлэлцээ. Бараа, үйлчилгээний худалдаа эрхлэхэд ДХБ-ын системд дагаж мөрддөг, хоёр талын хүсэлт болон санал гаргах бас нэг өөр арга техник.
531	First-difference reciprocity	Анхдагч ялгаатай байдалтай холбогдолтой харилцан адил байх зарчим. Мөн Анхдагч ялгаатай байдалтай холбогдолтой хэлэлцээг (First-difference negotiations) үзнэ үү.
532	First-mover advantage	Анх санаачлагч талын давуу тал. Тухайн компанийн хувьд шинэ технологи эсвэл шинэ үйл явцыг ашиглан зах зээлд анхдагч болж чадсан учраас тус компанийн хувьд хүртэх үр ашиг бий болж байдаг.
533	First-order protectionism	Анхдагч дэг журмаар тогтоосон протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах ухаан. Энэ бол сайн дураараа хязгаарлах арга хэмжээний ангилалд багтдаг, өргөн хүрээг хамарсан худалдааг хязгаарлах арга хэмжээ. Энэ нэр томьёо нь аливаа арга хэмжээ нь протекционист байх ёстой гэсэн маргаангүй санаархал дээр үндэслэсэн байдаг. Мөн протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах ухааныг (protectionism) үзнэ үү.
534	First-to-file	Эхлээд бичиг баримт хадгалах архивд оруулах зарчим. Энэ нь патентын эрхийн давуу эрхийг тодорхойлох журам. Ихэнх улс орнууд, АНУ болон Филиппин улсуудыг эс тооцвол, тухайн шинэ зохион бүтээлийг хэзээ хийгдсэнээс үл хамааран, түүнийг анх удаа бүртгүүлсэн хүнд уг шинэ бүтээлийн анхдагч давуу эрхийг олгодог. АНУ болон Филиппин улсууд нь анхдагч давуу эрхийг олгохдоо “Эхлээд шинээр зохион бүтээх” гэсэн зарчмыг баримталдаг. “Эхлээд бичиг баримт хадгалах архивд оруулах” гэсэн зарчмын гол давуу тал нь гэвэл, хэрэв урьтсан гомдол нэхэмжлэлтэй холбоотой маргаан үүсвэл тухайн шинэ бүтээлийн зохион бүтээгчийн хувьд давуу эрхтэй байж болох талаар аливаа шийдвэр гаргахад чиглэсэн тодорхой эхлэлийг тавьж өгдөг байна.
535	First-to-invent	Эхлээд шинээр зохион бүтээх зарчим. Мөн Эхлээд бичиг баримт хадгалах архивд оруулах зарчмыг (first-to-file) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
536	Fixed quota	Тогтмол тоо хэмжээний хязгаарлалт/квот. Тогтоосон хугацаанд хэтрүүлэх боломжгүй, бараа бүтээгдэхүүний импортын хэмжээнд тогтоосон квот. Мөн Тарифын хувь хэмжээтэй квот (tariff rate quota) үзнэ үү.
537	Flat-tariff structure	Жигд тэгш тарифын тогтолцоо. Бүх барааны тарифын түвшин нь жигд, эсхүл бараг тэгш байдаг тариф. Үүний хамгийн тод жишээ бол 1997 онд бүх импортод ногдуулж байсан тарифын хувь хэмжээ нь 11% байсан Чили улсын жишээ. Мөн Тархсан тарифыг (dispersed tariff) үзнэ үү.
538	Flexibility provisions	Уян хатан байдлын заалтууд. Эдгээр нь Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнд хөдөө аж ахуйн экспортын татаасыг бууруулахтай холбоотой. Хэрэв хэлэлцээнүүд хийгдэж байсан 1986-90 оны үндсэн суурь үеэс хойш тухайн улсын экспортын татаас нэмэгдсэн бол, тус улс 1991-92 оныг үндсэн суурь үе болгон ашиглаж болох сонголттой байв. Гэсэн хэдий ч тарифыг бууруулах зорилгодоо хүрэх эцсийн цэг бол хэвээрээ байв. Текстил (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрт (Agreement on Textiles and Clothing) уян хатан байдлын заалтууд багтсан байдаг. Тэд огцом эргэх (нэг бараа бүтээгдэхүүний экспортын квотын зарим хэсгийг өөр бүтээгдэхүүн рүү шилжүүлэх), он дамжуулах (өмнөх жилийн ашиглагдаагүй экспортын квотыг энэ жилд ашиглах), ирээдүйд шилжүүлэх (ирэх жилийн квотын зарим хэсгийг энэ жилд ашиглах) зэргийг зөвшөөрдөг. Текстил (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрт дурдсан уян хатан байдлын заалтууд нь Олон талт ширхэгтийн тухай хэлэлцээрээс гаралтай. Мөн Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийг (Multi-Fibre Agreement) үзнэ үү.
539	Floating initial negotiating rights	Хөрвөж өөрчлөгдөх чадвартай хэлэлцээ хийх анхдагч эрх. Мөн хэлэлцээний анхны эрхийг үзнэ үү.
540	Floor price	Доод хязгаар үнэ. Түүхий эд үйлдвэрлэгчдэд зориулсан баталгаат үнийн түвшин. Энэ нь тухайн барааны дэлхийн зах зээлийн үнээс өндөр эсвэл доогуур байж болно. Түүхий эдийн олон улсын хэлэлцээрт доод үнэ гэдэг нь, нийлүүлэлтийг бууруулахын тулд хязгаарлалтын нөөц түүхий эд, материалыг зохицуулж байдаг менежер ийм үнийн түвшинд худалдаж авах ёстой байж болох бөгөөд энэ нь зах зээлийн үнийг ийм арга замаар хөшүүрэгддэг байна. Мөн Хөдөө аж ахуйн нийтлэг бодлого (Common Agricultural Policy), зээлийн хүү (loan rate), Болзолт үнийн механизмыг (trigger price mechanism) үзнэ үү.
541	Florence Agreement	Флоренцийн хэлэлцээр. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын материалыг импортлох тухай хэлэлцээр. Энэ нь НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын (UNESCO) ивээл дор 1950 онд батлагдсан байдаг. Энэхүү гэрээнд оролцогч талууд ном, хэвлэл, баримт бичиг болон боловсролын, шинжлэх ухааны, соёлын материалуудад импортын татвар ногдуулахгүй гэж үүрэг хүлээсэн байдаг. 1977 онд батлагдсан Гэрээний протокол нь хамрагдах материалын жагсаалтыг боловсронгуй болгосон.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
542	Flying-geese formation	Нисэж буй галуу. Гурвалжин хошуу үүсгэн зэллэн нисэж яваа галуун цуваа шиг бүрэлдэхүүн. Мөн цуваанд дагалдан яваа [гишүүний] асуудлыг үзнэ үү.
543	Food and Agricultural Organisation	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO). Энэ нь 1945 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын нэг болж байгуулагдсан. Үүний үндсэн дүрмийн оршил хэсэгт уг байгууллагын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд: (a) гишүүн орнуудын ард түмний хоол тэжээлийн түвшин, амьдралын түвшинг дээшлүүлэх, (b) хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх нөхцөлийг хангах, (c) хөдөө, орон нутгийн хүн амын нөхцөл байдлыг сайжруулах, (d) ийм арга замуудаар дэлхийн эдийн засаг өргөжиж, хүн төрөлхтнийг өлсгөлөнгөөс чөлөөлөхөд хувь нэмэр оруулах юм. Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) нь түүхий эдийн асуудал, хөдөө аж ахуй, дэлхийн хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан хороодтой. Энэ нь эдэлбэр газар, усны салбарын хөгжил, ургамал, мал аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй зэрэг салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. ХХААБ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран, хоол хүнсэнд тавигдах шаардлагыг уялдуулах, улмаар олон улсын худалдааг дэмжих зорилготой Кодекс алиментариус буюу хүнсний дүрмийн хороог (Codex Alimentarius Commission) удирдан ажилладаг байна. ХХААБ нь Ром хотод байрладаг. Мөн Дэлхийн хүнсний хөтөлбөрийг (World Food Programme) үзнэ үү.
544	Food-importing Group	Хүнс импортлогч орнуудын бүлэг. Энэ нь хүнсний импортоос хамааралтай байдаг хөгжиж буй орнуудын ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор Уругвайн үе шатны хэлэлцээний эхэн үед байгуулагдсан.
545	Food security	Хүнсний аюулгүй байдал. Олон улсын худалдааны хэлэлцэх асуудлын хүрээнд дахин орж ирж эхэлж байгаа нэг зүйл гэвэл жишээлбэл, Марракеш дах ДХБ-ын сайдын шийдвэрээр ДХБ-ын хөдөө аж ахуйн шинэчлэлийн хөтөлбөрийн нэн буурай хөгжилтэй, хүнс импортлогч орнуудад үзүүлж болзошгүй сөрөг үр дагаврыг судлах асуудал. Улс орны төрийн үүрэг хариуцлагын нэг нь иргэд, оршин суугчдаа хүнсээр хангалттай хангаж өгөх явдал. Зарим улс орнууд байгалиасаа өөрөө өөрийгөө хангадаг эсвэл цэвэр экспортлогч нар (импортлогдог дүнгээсээ илүү ихийг экспортлогдог) байдаг бол бусад улс орнууд их бага хэмжээгээр импортоос хамааралтай байдаг байна. Гэсэн хэдий ч бусад нь өндөр тариф, улсын татаас болон бусад тарифын бус арга хэмжээгээр дамжуулан, үйлдвэрлэгчдийг гаднын өрсөлдөөнөөс хамгаалсан дотоодын хөтөлбөрөөрөө дамжуулан, хүнсний аюулгүй байдлыг хангахыг эрмэлздэг. Ийм хөтөлбөрүүдийн олон улсын нөлөөлөл харилцан адилгүй байдаг. Худалдааны бодлогын асуудал бол, хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрээс үүсэх үүрэг хариуцлагыг дордуулах эсвэл няцаахын тулд бий болсон зүсээ хувиргасан арга хэрэгсэл эсвэл хөдөө аж ахуйн салбарт цаашдын шинэчлэл, хөдөө аж ахуйн худалдааг үргэлжлүүлэн либералчлах шаардлагатай байгааг хориглох явдал биш. Хөдөө аж ахуйн илүү чөлөөт худалдаа нь нэн ялангуяа импортлогч орнуудын үйлдвэрлэгчдийн үнийг дарамтлан бууруулдаг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) улс орнуудаас үзүүлж байдаг татаасны дэмжлэгтэй экспортуудыг нь бууруулах замаар, хөгжиж буй улс орнуудын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нарт дэмжлэг үзүүлэх болно гэсэн агуулгын хүрээнд маш хүчтэй хэрэг гарч байсан. Илүү чөлөөтэй худалдаа нь зах зээлд нэвтрэх боломж улам бүр нэмэгдэж, олон улсын түүхий эдийн үнэ нэмэгдэхэд хүргэх болно. Үүний үр дүнд нь хөгжиж буй орнуудын үйлдвэрлэгчдэд тавигдах нөхцөл сайжрах нь бодитоор үндэсний хүнсний аюулгүй байдлыг сайжруулна. Мөн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (Food and Agricultural Organisation), Дэлхийн хоол хүнсний хөтөлбөрийг (World Food Programme) үзнэ үү.</p>
546	Foot dragger	<p>Хөлд чирэгдэн тушаа бологчид. Энэ бол тухайн нэг шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх эсвэл өөрийнхөө зорилгод нийцүүлэн ашиглахын тулд тухайн нэг хуулийн заалтын хүчин чадлыг сулруулахын тулд зөвшилцлийн зарчмыг ашигладаг, олон талт худалдааны хэлэлцээний нэг тал. Мөн цуваанд дагалдан яваа [гишүүний] асуудлыг (convoy problem) үзнэ үү.</p>
547	Footloose industries	<p>Эрх чөлөөт аж үйлдвэрүүд. Боловсронгүй болгосон бодит дэд бүтэц эсвэл тогтмол хөрөнгө оруулалтаас хамаардаггүй учраас үйлдвэрлэл эрхлэх болон борлуулалт явуулах байршил нь тийм ч чухал биш байдаг аж үйлдвэрүүдэд ашигладаг нэр томьёо. Тэд хямд, илүү сайн ажиллах орчныг хайж, өөр газар харьцангуй хялбархан шилжих боломжтой. Заримдаа гарал үүслийн шинэ дүрмийг хангаж ажиллахын тулд тэд үүнийг хийх хэрэгтэй болдог. Мэдээлэл боловсруулах гэх мэт үйлчилгээний зарим үйл ажиллагааг эрх чөлөөт аж үйлдвэрийн ангилалд орно гэж үздэг. Үйлдвэрлэлийн үйл явцыг олон улс оронд тархаан байршуулж чадах даяаршил нь тийм аж үйлдвэрүүд бий болж гарч ирэхэд тодорхой түлхэц өгнө гэж үздэг. Мөн нутагшуулахгүй байхыг (delocalisation) үзнэ үү.</p>
548	Forced technology transfer	<p>Технологийг албадан дамжуулах. Технологийг шилжүүлэх тухай ямар ч хууль тогтоомж, журам байхгүй байгаа тохиолдолд, хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл авахын тулд үүнийх нь нэг хэсэг болгож, өөрсдийн технологийн зарим хэсгийг тухайн хүлээн авагч улсад шилжүүлэхийг компаниудаас шаарддаг практик туршлага. Мөн лицензийг албадан олгохыг (compulsory licensing) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
549	Foreign direct investment	<p>Гадаадын шууд хөрөнгө оруулалт. ОУВС-аас “хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад өөр эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид удаан хугацааны ашиг сонирхлоо бүрдүүлж авахын тулд хийгдсэн шууд хөрөнгө оруулалт бөгөөд хөрөнгө оруулагчийн зорилго нь тухайн аж ахуйн нэгжийн менежмент удирдлагад дуу хоолойгоо үр нөлөөтэй байлгах зорилготой байдаг” хэмээн тодорхойлжээ. “Урт удаан хугацааны ашиг сонирхол” гэсэн утгын хувьд нэлээд их зүйл бодоход хүргэсэн байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD буюу ЭЗХАХБ) зөвлөснөөр бол 10% ба түүнээс дээш өмчлөл нь энэ шаардлагыг хангаж байх ёстой гэж зөвлөсөн байна. ЭЗХАХБ нь шууд хөрөнгө оруулалтын урсгалыг (i) шууд хөрөнгө оруулагч тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө (share capital) болон цэвэр зээлийн (net loans) цэвэр худалдан авалт хийсэн бол, мөн (ii) шууд хөрөнгө оруулагчийн хувьд дахин хөрөнгө оруулсан орлогоос эзэмших хувьтай байна гэж мөн тодорхойлсон байна. Мөн Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) хувьд хуулиар үүрэг хүлээгээгүй, заавал биелүүлэх шаардлагагүй хөрөнгө оруулалтын зарчмууд (APEC non-binding investment principles), Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ (Foreign Investment Advisory Service), байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгөд тулгуурлагүй хөрөнгө оруулалт (non-equity-based investment), портфель хөрөнгө оруулалт (portfolio investment) болон Гадаадын шууд хөрөнгө оруулалттай харьцах тухай Дэлхийн Банкны удирдамжийг (World Bank Guidelines on the Treatment of Foreign Direct Investment) үзнэ үү.</p>
550	Foreign exports	<p>Гадаадын экспорт. Мөн буцаан экспортлох (re-exports), үүнтэй харьцуулсан дотоодын экспортыг (domestic exports) үзнэ үү.</p>
551	Foreign investment screening	<p>Гадаадын хөрөнгө оруулалтыг нягтлан шалгах. Энэхүү механизмыг, гадаадын шууд хөрөнгө оруулалттай төслүүд нь үндэсний хөгжлийн зорилтууд болон эдийн засгийн эрэлт хэрэгцээний шалгуурыг хангаж, мөн тодорхой салбаруудад эсвэл аж ахуйн нэгж компаниудад буй гадаадын хувь нийлүүлсэн хөрөнгө нь хуулиар заасан хязгаараас хэтрэхгүй байх нөхцөлийг хангах зорилгоор олон улс орнууд эрхлэн явуулдаг байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг нягтлан шалгах нь хөрөнгө оруулалтын саналын шударга байдлыг (bona-fide) хөхиүлэн дэмжих зорилготой. Худалдааны бодлогын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг нягтлан шалгахын ач холбогдол гэвэл зах зээлд үр дүнтэй нэвтрэх тал дээр гадаадын хөрөнгө оруулалт нэн чухал байгаа үед энэ нь худалдаанд саад тотгор учруулах магадлалтай гэж зарим нь үздэг бодит нөхцөл байдлаас үүсэл гаралтай ажээ. Нягтлан шалгах явцын үр дүнд хөрөнгө оруулалтын өргөдлөөс татгалзах, тэгснээрээ зах зээлд нь нэвтрэхийг нь үл зөвшөөрөхөд хүрч болох юм. Мөн Эксон Флорио (Exon-Florio)-гийн нэмэлт өөрчлөлтийг үзнэ үү.</p>
552	Foreign parity	<p>Гадаад валютын ханш/паритет. Мөн Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
553	Foreign sales corporation	Гадаадын борлуулалтын корпорац (FSC). Энэ нь АНУ-ын Дотоодын Орлогын Кодын заалтын дагуу гадаад улсад байгуулагдсан, тэнд ажилладаг корпорацыг хэлдэг байна. Гадаадын борлуулалтын корпорац нь гадаадад олсон орлогынхоо зарим хэсэгтээ АНУ-ын татвараас чөлөөлөгдөх боломжтой. Мөн дотоодын олон улсын борлуулалтын корпорацыг (domestic international sales corporation) үзнэ үү.
554	Formula tariff reductions	Тусгай томьёоллын дагуу тарифыг бууруулах. Мөн шугаман аргачлалын дагуу тарифыг бууруулахыг (linear tariff cuts) үзнэ үү.
555	Fortress effect	Хэрэм цайзын нөлөө. Энэ нь бүс нутгийн интеграцчлалын хэлэлцээр нь гишүүн орнуудынх нь зүгээс гишүүн бус орнуудад илүү хамгаалалтын байр сууринаас хандахад хүргэж болзошгүй гэдгийг сануулж байдаг. Энэ асуудлыг илүү хянамгай нарийвчлан дүн шинжилснээр дээрх нөхцөлүүдийн аль нэгэн шийдвэрт хүрэхүйц нотолгоог гаргаж өгч чадаагүй байна.
556	Fortress Europe	Европын хэрэм цайз. Европын хамтын нийгэмлэгийн Нэгдсэн нэг зах зээл байгуулагдсанаар Хамтын нийгэмлэгийнхийг нэвтэрч ороход улам хэцүү, дотоод руугаа чиглэсэн зах зээл рүү эргүүлчих вий гэсэн айдастай байдгийг нь илэрхийлсэн нэр томьёо. Иймэрхүү айдас байх ёстой эсэхийг батлан тайлбарлаж чадаагүй ажээ.
557	Four freedoms	Дөрвөн эрх чөлөөний горим. Энэ нь бараа, капитал, ажиллах хүч, үйлчилгээний чөлөөтэй хөдөлгөөнийг хэлдэг. Энэхүү илэрхийлэл нь ихэвчлэн I ба III гарчигт бичигдэж эрхийг нь олгосон байдаг Ромын хэлэлцээрийн агуулгын хүрээнд хэрэглэгддэг. Мөн Гүн уялдуулсан нэгтгэл/интеграцчиллыг (deep integration) үзнэ үү.
558	Four pillars of trade liberalisation	Худалдааны либералчлалын дөрвөн багана. Олон талт худалдааны дипломат үйл ажлын үеэр Жерард Курзон нь үүнийг Худалдааны либералчлалын дөрвөн багана хэмээн тайлбарласан бөгөөд үүнд дараах нөхцөлүүд орно: тарифын бус арга хэмжээ гэхээсээ илүү гаалийн тарифт түшиж найдах, тарифыг бууруулахад хүргэх тарифын хэлэлцээнүүд, тарифын хувьд хуулиар үүрэг хүлээж, заавал биелүүлэх нөхцөлийг олгосон дүрэм журмаар дамжуулан тарифын тогтвортой байдлыг буй болгох зэрэг болно.
559	Fourth Protocol to the General Agreement on Trade in Services	Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) 4-р Протокол. Энэ нь цахилгаан харилцаа холбооны үндсэн үйлчилгээнд хүлээх үүргийг хүчин төгөлдөр болгож буй протокол. Энэ нь 1998 оны 2-р сарын 5-нд хүчин төгөлдөр болсон байдаг. Мөн Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээний тухай хэлэлцээрийг (Agreement on Basic Telecommunications Services) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
560	Framework Agreements	<p>Эрх зүйн бүтэц, хамрах хүрээний суурь хэлэлцээрүүд (Framework Agreements). Энэ нь ялангуяа хөгжиж буй орнуудын асуудалтай харьцаж ажиллахтай холбоотой Токиогийн үе шатны хэлэлцээнээс гарсан дөрвөн үр дүнг нэрлэсэн болно. Дөрвөн эрх зүйн акт нь: (i) Зөвшөөрөгдөх заалт (Enabling clause), (ii) Төлбөрийн тэнцлийн зорилгоор авч хэрэгжүүлсэн Худалдааны арга хэмжээний тухай тунхаглал (Declaration on Trade Measures Taken for Balance-of-Payments Purposes), (iii) Хөгжлийн зорилгод чиглэсэн Хамгаалалтын арга хэмжээний талаарх шийдвэр (Decision on Safeguard Action for Development Purposes), (iv) Мэдэгдэл өгөх, зөвлөгөөн, маргаан шийдвэрлэх, хяналт тандалт хийх тухай харилцан ойлголцох баримт бичиг (Understanding Regarding Notification, Consultation, Dispute Settlement and Surveillance). Хөгжиж буй улс орнуудын хувьд худалдааны систем тэдний эрэлт хэрэгцээг хангаж чадаагүй хэмээн үзсэн тэдний болгоомжлолд хариу болгож, бусад олон асуудлын зэрэгцээ “дэлхийн худалдааг явуулах олон улсын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох”-ыг эрэлхийлсэн, Токиогийн тунхаглалын 2-р зүйлээс энэхүү “Эрх зүйн бүтэц, хамрах хүрээний суурь хэлэлцээрүүд” хэмээх нэр томьёог авчээ. Мөн Токиогийн үе шатны хэлэлцээрийг (Tokyo Round agreements) үзнэ үү.</p>
561	Free and fair trade	<p>Чөлөөт ба шударга худалдаа. Хэрэв зөвхөн худалдааны түнш орнууд нь тэдний хүлээн зөвшөөрсөн дүрэм журмын дагуу мөн шударгаар тоглох тохиолдолд, эдийн засгийн хөгжил болон дэлхийн сайн сайхны төлөө чөлөөт худалдаа нь маш чухал зорилт байх болно гэсэн хэтийн төлөвлөгөөнөөс үүдэлтэй, нэн ялангуяа АНУ-ын тариф болон худалдааны бодлогод маш сайн томъёологдож өгсөн байдаг үзэл санаа. Хэрэв тэд шударга бус үйлдлүүдийг дагаж мөрдөж байгаа бол зах зээлд чөлөөтэй нэвтрэхийн ашиг тусыг хүртэх эрхгүй юм. Жишээлбэл, 301-р хэсэг гэж гарч ирэх болсон цаад сэтгэлгээ нь АНУ-ын зах зээлийг хамгаалахад бус харин бусад улс орнууд өөрсдийн зах зээлээ мөн адилхан нээлттэй байлгахад чиглэсэн, сайн баримтжуулж авсан үзэл санаа байдаг.</p>
562	Freedom of transit	<p>Дамжин өнгөрөх эрх чөлөө. ТХЕХ-ийн 5-р зүйлд заасны дагуу ДХБ-ын гишүүн улс орнуудад, бараа бүтээгдэхүүнээ нөгөө нэг гишүүн улсынхаа нутаг дэвсгэр дээгүүр саад бэрхшээлгүйгээр дамжуулан, зорьсон газартаа хүргэх боломжтой байх эрхийг олгосон байдаг. Уг эрхэд энэхүү зорилгоор, далайн хөлөг онгоц болон бусад тээврийн хэрэгслүүдийг ашиглах боломжийг багтаасан байдаг. Гишүүн орнууд нь бусад гишүүн орнуудын бараа бүтээгдэхүүн болон тээврийн хэрэгслийг ялгаварлаж болохгүй бөгөөд дамжин өнгөрч буй бараа, бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулж болохгүй. Гэсэн хэдий ч тэд транзит буюу дамжин өнгөрөх тээвэртэй холбогдолтой гарсан аливаа үйлчилгээний бодит зардал дээрээ үндэслэн, захиргааны зардлыг нөхөн төлүүлэх эрхтэй.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
563	Freedoms of the air	<p>Агаарын орон зайн эрх чөлөө буюу Тухайн улсын агаарын тээврийн компаниудад өөр улсын агаарын орон зайд нэвтрэх, газардах эрх олгосон арилжааны нислэгийн багц эрх. Нисэх хүчний мэргэжилтнүүд агаарын тээврийн байгууллагуудын эрхийг, “агаарын орон зайн эрх чөлөө буюу арилжааны нислэгийн багц эрх чөлөө” хэмээх нэрийн дор найман ангилалд хувааж үздэг, гэхдээ үүний эхний зургаагийнх нь хувьд л “нислэгийн багц эрх чөлөө” хэмээх нэр томьёог нийтлэг хэрэглэдэг байна. Тэдгээр нь: (i) тухайн улсын нутаг дэвсгэр дээгүүр нь нисэх, (ii) тухайн улсад шатахуунаа дахин цэнэглэх эсвэл ижил төстэй зорилгоор газардах эрх, гэхдээ үүнд зорчигчид эсвэл ачаа тээврийг ачиж эсвэл буулгахгүй болно, (iii) өөр нэг улсад зорчигчид эсвэл ачаа тээврийг буулгах эрх, (iv) зорчигчид эсвэл ачаа тээврийг өөр нэг улсаас ачиж аваад, агаарын тээврийн байгууллагын эх оронд нь буулгах эрх, (v) өөрийн улсыг тээврийн зангилаа төв болгон ашиглах замаар гуравдагч улсуудын хооронд зорчигчид эсвэл ачаа тээврийг тээвэрлэх эрх, (vi) 4 болон 5-дугаар эрх чөлөөний хүрээнд олж авсан эрхийг нэгтгэж уялдуулах эрх, (vii) агаарын тээврийн үйлчилгээг бүхэлд нь өөрийн улсын нутаг дэвсгэрээс гадна, гуравдагч улсуудын хооронд үзүүлэх эрх, (viii) тухайн нэг улс дотроо агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх эрх, ихэвчлэн үүнийг каботаж (cabotage) гэж нэрлэдэг. [Каботаж гэдэг нь нэг улсын боомт хооронд хэрэгжүүлдэг ачаа ба зорчигч тээвэрлэлтийн далайн хөлөг онгоцны даяллын төрөл юм.] Нисэх хүчний эдгээр багц эрх чөлөөг ихэвчлэн дотоодын агаарын тээврийн байгууллагуудын өмнөөс засгийн газрууд хоорондоо хэлэлцээ хийдэг. Мөн агаарын тээврийн үйлчилгээний хоёр талт хэлэлцээр (bilateral air services agreement), Чикагогийн конвенц (Chicago Convention), агаарын нээлттэй орон зайн тухай хэлэлцээрийг (open-skies agreements) үзнэ үү.</p>
564	Free imports	<p>Чөлөөтэй импорт. Энэ нь ямар нэгэн гаалийн татваргүйгээр импортлогдох боломжтой бараа бүтээгдэхүүн. Мөн гаалийн ямар нэгэн татваргүй чөлөөтэй импортлогдох бараа бүтээгдэхүүний жагсаалт (free list), тэг үнэлгээг (zero rating) үзнэ үү.</p>
565	Free list	<p>Гаалийн ямар нэгэн татваргүй чөлөөтэй импортлогдох бараа бүтээгдэхүүний жагсаалт. Гаалийн татваргүй чөлөөтэй импортлогдож болох эсвэл лицензийн шаардлагад хамрагдахгүй бараа бүтээгдэхүүний жагсаалт.</p>
566	Free riders	<p>Үнэгүйгээр ашиглагчид буюу ямар нэг эдлэх ёсгүй зүйлийг авсан хувь хүн, аж ахуйн нэгж эсвэл улс орон. Өөрсдийн зүгээс зохих хэмжээний үйлдэл хийгээгүй мөртлөө худалдааны либералчлалаас үр ашиг хүртэгч нарт зориулсан нэр томьёо. Заримдаа үүнийг либералчлалд хүргэх хамтарсан үйл ажиллагаанд оролцохыг хүсэхгүй байгаа боловч ашиг тусыг нь ашиглахыг хүсэж байгаа орнуудад ч хэрэглэгддэг. Худалдааны хэлэлцээний агуулгын хүрээнд ямар нэг эдлэх ёсгүй зүйлийг авсан улс орны утга санаа гэвэл харилцан адил байх зарчимд тулгуурладаг. Эдийн засгийн үүднээс авч үзвэл чөлөөт зорчигчид өөрсдөдөө ч хор хөнөөл учруулж байдаг учир нь тэд худалдааны либералчлалаас хүртэх өөрсдийнхөө ашиг тусыг үгүйсгэж байдаг. Мөн Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
567	Free trade	<p>Чөлөөт худалдаа. Зарчмын хувьд бараа, үйлчилгээ, капитал, хүмүүсийн хилээр чөлөөтэй шилжих хөдөлгөөнийг хэлдэг. Бодит байдал дээр эдгээрийн тус бүрийн чөлөөт шилжилт хөдөлгөөнд бусад улсын үндэсний бодлого болон эрх зүйн зохицуулалтын зорилтууд их бага хэмжээгээр хязгаарлалт болж өгдөг байна. "Чөлөөт худалдаа" гэсэн утга нь өөрөө олон жилийн турш өөрчлөгдөж байв. Ажиглагчдын үзэж байгаагаар бол АНУ-ын тарифгүй чөлөөт худалдаа нь 19-р зууны эхэн үед 20%-иас доош тарифын утгыг илэрхийлж байсан байна. 19-р зууны сүүлчээр чөлөөт худалдаалагчид тарифын түвшинг 40% -иас доогуур байлгахыг сурталчлан таниулдаг байсан бол 20-р зуунд чөлөөт худалдаа 5%-иас бага тарифтай байна гэсэн утгатай болж иржээ. Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АСЕАН) Чөлөөт худалдааны хэлэлцээрийн (AFTA) хувьд чөлөөт худалдаа гэдгийг 0%-иас 5% хооронд хэлбэлздэг тарифын хэмжээ гэж ойлгодог байна. ТХЕХ-ийн 24-р Зүйлд заасны дагуу, «гаалийн холбоо болон чөлөөт худалдааны бүсүүд нь, чөлөөт худалдааны шалгуурыг хангахын тулд талуудын хооронд хийсэн бүх худалдаанд ногдуулсан татварыг болон бусад арилжааг хязгаарласан эрх зүйн зохицуулалтуудыг халах хэрэгтэй байдаг. Мөн эдийн засгийн нэгтгэл/интеграцийн зохицуулалт (economic integration arrangements), дөрвөн эрх чөлөөний горим (four freedoms), чөлөөт ба шударга худалдааг (free and fair trade) үзнэ үү.</p>
568	Free-trade agreement	<p>Чөлөөт худалдааны хэлэлцээр. Энэ нь хоёр ба түүнээс дээш улс орнууд хоорондоо бие биеийнхээ зах зээлд давуу эрхтэйгээр нэвтрэх эрхийг олгодог, чөлөөт худалдаа хэмээн ихэвчлэн нэрлэгддэг, гэрээнд үндэслэсэн зохицуулалтыг хийдэг байна. Практик амьдрал дээр чөлөөт худалдааны хэлэлцээр нь эмзэг бүтээгдэхүүнийг хамруулахын тулд бүх төрлийн үл хамаарах нөхцөлийг зөвшөөрөх хандлагатай байдаг. Зарим тохиолдолд чөлөөт худалдаа нь урт хугацааны зорилгоос өөрцгүй болж эсвэл худалдааны зохицуулалттай либералчлалын нэгэн хэлбэрийг төлөөлөх болсон байна. Ажиглагчдын тэмдэглэснээр бол, сүүлийн үед чөлөөт худалдааны талаар хийсэн олон хэлэлцээр нь хэдэн зуун хуудас давсан баримт бичиг болж байгаа бол жинхэнэ чөлөөт худалдааны хэлэлцээрийн хувьд зөвхөн хэдхэн мөр л шаардагдаж байжээ. Мөн гаалийн холбоо (customs union), чөлөөт худалдааны бүс (free-trade area), бүс нутгийн нэгтгэл/интеграцчиллын зохицуулалт (regional integration arrangement), бүс нутгийн худалдааны зохицуулалтыг (regional trade arrangement) үзнэ үү.</p>
569	Free-trade area	<p>Чөлөөт худалдааны бүс. Энэ нь техник хэллэгээр бол гаалийн нутаг дэвсгэр буюу хоёр ба түүнээс дээш тооны улс орнуудын бүлэг нь тэдгээрийн хоорондын худалдаанд нөлөөлж буй тарифыг мөн бүх эсвэл ихэнх тарифын бус арга хэмжээг халсан байдаг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүнд оролцогч улсууд өөрсдийнхөө тарифыг гадны бараа бүтээгдэхүүнүүдэд ногдуулсан хэвээр байж болно эсвэл нэгдсэн гадаад тарифыг буй болгохоор [хамтран] ажиллаж болно. Хэрэв бүх түншүүд бие бие рүүгээ чиглэсэн тариф болон бусад саад тотгоруудаа халбал, уг чөлөөт худалдааны бүсийг харилцан эрх тэгш адил болсон (reciprocal) гэж үзнэ. SPARTECA болон Ломе-гийн конвенцтой холбоотой тодорхой нөхцөлбайдалтай адилхан, хөгжиж буй орнууд бүхий түншүүд нь хэдийгээр өндөр хөгжсөн улс орнуудын зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй ч гэсэн, яг ижил түвшинд [тарифуудаа] бууруулах нөхцөлөөс чөлөөлөгдсөн тодорхой нөхцөл байдал гэж байдаг. Тэдгээрийг харилцан адил байх шаардлагагүй чөлөөт худалдааны бүс гэж нэрлэдэг. Мөн гаалийн холбоо (customs union), худалдааг буй болгох (trade creation), худалдааг гажуудуулах (trade deviation), худалдааны урсгалыг өөр чиглэл руу хазайлгахыг (trade diversion) үзнэ үү.</p>
570	Free Trade Area of the Americas	Америкийн чөлөөт худалдааны бүс. Мөн ФТАА-ийг үзнэ үү.
571	Free-trade zones	<p>Чөлөөт худалдааны бүсүүд. Эдгээр бүсийг экспортын [зориулалттай] боловсруулалтын бүсүүд гэж нэрлэдэг, ихэвчлэн тээврийн зангилаа төвүүдийн ойролцоо байрладаг ба цаашид гүн боловсруулалт, эцсийн угсралт хийж, дараа нь буцаан экспортлох зориулалт бүхий түүхий эд, үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гаалийн татваргүй импортлохоор засгийн газраас зааж тодорхойлсон бүсүүд байдаг. Ийм бүтээгдэхүүнийг бусад орны зах зээлд экспортлодог. Амжилттай чөлөөт худалдааны бүсүүд нь харьцангуй хямд, зохих чадвартай ажиллах хүчний хангалттай нөөцтэй байх хандлагатай байдаг. Чөлөөт худалдааны бүсийг байгуулж буй улс орнууд ихэвчлэн дотоодын үйлдвэрүүд ба эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь өрсөлдөх чадваргүй байдаг тул энэ нь гадаадын хөрөнгө оруулалтын хүртээмж болон зах зээлд нэвтрэх боломжийг олгох нэг арга зам нь болдог. Ийм бүс нь заримдаа хүлээн авагч орнуудад технологийн дамжуулалт хийхэд хүргэдэг боловч ихэнхдээ энэ нь тэнд үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын зорилго нь биш байдаг.</p>
572	Friends	<p>Найзууд. Энэ нь ДХБ-ын гишүүдээс бүрдсэн, хэлэлцэж буй ямарваа сэдвийн хүрээнд өрнөж буй ахиц дэвшлийг дэмжигч болон сурталчлан таниулагчдын багахан бүлгийн өсөн нэмэгдэж буй чиг хандлага. Тиймээс бид "Тарифын бус арга хэмжээний найзууд", "Үйлчилгээний хэлэлцээний найзууд", тэр ч байтугай "Үйлчилгээний үнэхээр сайн найзууд" гэх мэт байж боломгүй сонин бүлгүүд байдаг.</p> <p>Эдгээр ихэнх бүлгүүдийн халуун дулаан сэтгэлээс гадна үр дүнд хүрэхийн төлөө дэмий хөөцөлдсөн байдал нь ч харагддаг. Ихэнх нь түр зуурын богино настай байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
573	Frontier traffic	Хилийн худалдаа, арилжаа. Энэ нь сайн тогтсон ураг төрлийн холбоо эсвэл урт хугацаанд тогтоосон эдийн засгийн холбоо бүхий маш тодорхой газар зүйн байршлын хүрээнд орон нутгийн оршин суугчдын хил дамнасан худалдааг гол төлөв нэрлэдэг. ТХЕХ-ийн 24-р Зүйлийн дагуу, улс орнууд хилийн худалдаатай холбоотой гаалийнхаа шаардлагатай бүхий л ёс журмыг хэрэглэхгүй байхаар шийдэж болно. Ийм аргаар арилжаалагдсан бараа нь хилийн аль ч талд өргөн хүрээний эдийн засгийн эргэлтэд орохгүй байх гэж үздэг. Хилийн хоёр талын хоёулангаас нь яг ямар зайны [газрыг] хилийн бүсийн хүрээнд байгаа гэж үзэх вэ гэдгийг ТХЕХ бол тусгайлан тогтоож өгөөгүй байдаг боловч, дайны өмнөх олон худалдааны хэлэлцээрүүдийн хувьд хилээс 15 километр тогтоож шийдсэн байдаг байна.
574	Frontloading	Ачааллыг [хэлэлцээрийн эхний үе шатанд] урагшлуулах. Энэ нь гэрээ, хэлэлцээрийн дагуу либералчлах үүрэг амлалт нь харьцааны хувьд хэрэгжилтийн эхний үе шатандаа илүү хүнд байх нөхцөлийг бүрдүүлсэн практик арга туршлага гэж тайлбарладаг. Мөн Ачааллыг [хэлэлцээрийн сүүлийн үе шатанд] хойшлуулахыг (backloading) үзнэ үү.
575	FTAА	Америкийн чөлөөт худалдааны бүс (FTAA). Үүнийг мөн Дэлхийн бөмбөрцгийн баруун хагасын Чөлөөт худалдааны хэлэлцээр гэж нэрлэдэг. 1994 оны 12-р сард Америкийн Майами-гийн дээд хэмжээний уулзалтын үеэр Кубаас бусад бүх Америкийг хамрах зорилт тавьжээ. Зарим талаараа Америкийн чөлөөт худалдааны бүсийг Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн (NAFTA) өргөтгөл гэж үзэж болох боловч энэ хоёр хууль ёсны хувьд нэлээд ялгаатай байх магадлалтай. 2005 он бол хүчин төгөлдөр болох зорилтот өдөр. Хэлэлцээр хийх үндэслэлийг бэлтгэх зорилгоор, зах зээлийн хүртээмж, гаалийн журам, гарал үүслийн дүрэм, хөрөнгө оруулалт, худалдаан дах стандартын болон техникийн саад тогторууд, Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ (sanitary and phytosanitary measures), татаас, демпингийн эсрэг татвар (anti-dumping duty), Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээний/нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties), жижиг эдийн засаг, засгийн газрын худалдан авалт, оюуны өмчийн эрх, үйлчилгээ, өрсөлдөөний бодлого зэрэг сэдвүүдийг хамарсан арван нэгэн ажлын хэсгүүд байгуулагдсан. Хэлэлцээг Чили улсын нийслэл Сантьягод 1998 оны 3-р сард зохион байгуулсан Америкийн дээд түвшний уулзалтаар эхлүүлсэн байдаг. Мөн Америкийн санаачилгын төлөөх аж ахуйн нэгжийг (Enterprise for the Americas Initiative) үзнэ үү.
576	Full balance-of-payments consultations	Төлбөрийн тэнцэлтэй холбогдсон арга хэмжээний талаарх бүрэн зөвлөгөөн. Мөн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон арга хэмжээний талаарх зөвлөгөөнийг (balance-of-payments consultations) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
577	Full preferential trade agreement	Иж бүрэн хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр. Энэ нь худалдааны давуу эрхийн гэрээг тодорхойлсон байдаг ба үүний дагуу гэрээний бүх талууд бүх бүтээгдэхүүн дээр бие биедээ чөлөөт худалдаа хийхийг баталгаажуулдаг байна. Хөнгөлөлттэй худалдааны хэсэгчилсэн хэлэлцээрийг мөн үзнэ үү.
578	Functional trade agreement	Тодорхой чиг үүргийн худалдааны хэлэлцээр. Худалдааны хэлэлцээрийн энэ хэлбэрийг одоо ховор хэрэглэдэг. Худалдааны хэлбэр, арга хэмжээ, үйл явдлын тодорхой нэг хэлбэрийг шийдвэрлэхийг эрмэлздэг. Үүний жишээ гэвэл, засгийн газрын худалдан авалт, худалдааг хязгаарлах, зохицуулах арга хэмжээ авах, мөн Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээний/нөхөн тэгшитгэх татвар ногдуулах зэрэг болно.
579	Functioning of the GATT System	ТХЕХ-ийн тогтолцооны үйл ажиллагаа (FOGS). Энэ нь Уругвайн үе шатны эхэнд байгуулагдсан хэлэлцээний бүлгүүдийн нэг. Үүний хэлэлцээ хийх чиг үүргийг, үндэсний хэмжээний худалдааны бодлогыг хянан нягталж үзэх ТХЕХ-ийн хяналт тандалтыг сайжруулах, институтын хувьд ТХЕХ-ийн шийдвэр гаргах үйл явцыг бүхэлд нь сайжруулах, дэлхийн эдийн засгийн бодлогыг боловсруулахад илүү уялдаа холбоог хангах чиглэлээр ТХЕХ-ийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх үүрэгтэй хэмээн тодорхойлсон байдаг. Үүний нэг ололт бол Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоог (Trade Policy Review Mechanism) бий болгосон явдал.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
580	Gains-from-trade theory	<p>Худалдаанаас ашиг олох онол. Энэ нь, хэрэв үнийн өөр тогтолцоотой хоёр улс өөрөө өөртөө засаглахаас (autarchy) илүүтэйгээр бие биетэйгээ худалдаа хийвэл эдийн засгийн өгөөжөө хамгийн их хэмжээгээр нэмэгдүүлж болохыг харуулсан, олон улсын эдийн засгийн харилцааны онолын нэг хэсэг. Хэрэв тухайн улсууд өөрөө өөрсдийгөө хангах гэж оролдсон үед гарах байсан зардлын дүнгээс илүү доогуур зардлаар аль аль улс нь худалдан авах боломжийг бүрдүүлсэн тийм үр ашиг. Үүний үр дагавар нь үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн байдал. Мөн үнэмлэхүй давуу тал (absolute advantage), харьцангуй давуу тал (comparative advantage), Хеккер-Охлин теорем (Heckscher-Ohlin theorem), хөдөлмөрийн олон улсын хуваарилалт (international division of labour), өөрийн хүчинд тулгуурлах (self-reliance), өөрөө өөрийгөө хангадаг байхыг (self-sufficiency) үзнэ үү.</p>
581	GATS	<p>Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (GATS - YXEX). Энэ бол Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнгийн нэг. Үүнд засгийн газрын эрх мэдлийг хэрэгжүүлэх замаар жишээлбэл, засгийн газрын худалдан авалтын замаар худалдаж авсан, эсхүл нийлүүлсэн, хоёр талын хэлэлцэж тохиролцсон агаарын тээврийн эрхээс бусад бүх үйлчилгээний худалдааг хамардаг. Эрх, үүрэг хоёр түвшинд явагддаг. Нэгдүгээрт, үндэсний нэн тааламжтай нөхцөл, ил тод байдал, дотоод зохицуулалтын шударга байдал, мэргэшлийг хүлээн зөвшөөрөх, эдийн засгийн интеграцчиллын зохицуулалт, монополиуд, бизнесийн арга ажиллагаа, төлбөр тооцоо ба шилжүүлэг, Эс хэрэглэх нийтлэг тохиолдол, аюулгүй байдлын үл хамаарах зүйлс зэрэг бүх үйлчилгээний худалдаа болон дэг журамд хэрэглэгдэх нийтлэг үүрэг хариуцлагууд байдаг. Хоёрдугаарт, YXEX нь зөвхөн хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалттай холбоотой тодорхой үүргийг агуулсан байдаг. Эдгээрт зах зээлд нэвтрэх баталгаа болон үндэсний нөхцөл орно. Засгийн газрын худалдан авалт, онцгой байдлын хамгаалалт, татаас зэрэг сэдвээр хэлэлцээ хийгдэж байгаа. YXEX нь 2000 оноос эхэлсэн үйлчилгээний талаарх хэлэлцээний шинэ үе шатуудыг эхлүүлэх эрх үүрэгтэй. YXEX-ийн гишүүд гурван жилийн турш зах зээлд нэвтрэх боломж, үндэсний нөхцөлийн илүү хатуу чанга [хувилбарыг] нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээсэн, үүрэг амлалтын хуваарийг гаргаж өгөх ёстой. YXEX-ийн талаар холимог байр суурьтай үнэлэлт дүгнэлт гарсан байдаг. Зарим нь үүнийг дэлхийн үйлчилгээний худалдааг илүү урьдчилан таамаглаж болохуйц, илүү эрх чөлөөтэй, илүү ил тод байлгахад чиглэсэн анхны боловч хамгийн чухал алхам гэж хардаг. Бусад нь түүний хоёр түвшин бүхий үүрэг хариуцлагаас үүдэлтэй байдаг түүний үйл ажиллагааны илт нарийн төвөгтэй байдалд нь сэтгэл дундуур байдаг. Хэлэлцэх ёстой үлдсэн асуудлуудын хэмжээ болон заавал биелүүлэх үүрэг амлалтуудын жагсаалтын хувьд нэмж бичих замаар гаргадаг жагсаалтыг ашиглах шийдвэр зэргийн улмаас, нарийвчлан авч үзэж буй байдал болон хамарч буй сэдвүүдийн хувьд эрх зүйн "болхидуу" баримт бичиг гэж Уайнсаймер (Waincymer, 1997) үзсэн байдаг. Тэрээр мөн, дараагийн үе шатны хэлэлцээний явцад гарах ахиц дэвшлээс их зүйл хамаарна хэмээн нэмж хэлсэн байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
582	GATT	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT - ТХЕХ). Энэ нь түр хэлэлцээр байдлаар 1948 оны 1-р сарын 1-нд хүчин төгөлдөр болж, 1995 оны 1-р сарын 1-ний өдрөөс түүний нөхцөл, зүйл, заалтууд нь Дэлхийн худалдааны байгууллагын (WTO) нэгэн хэсэг нь болтлоо тэр хэвээрээ байсан. Үүнд үндэсний нэн тааламжтай нөхцөл (MFN) болон үндэсний нөхцөлийг (NT) хамруулсан бараа бүтээгдэхүүний худалдаа, ил тод байдал, дамжин өнгөрөх эрх чөлөө, демпингийн эсрэг татвар болон Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээний/нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties), гаалийн үнэлгээ, импортын болон экспортын хураамж ба ёс журмууд, гарал үүслийн дүрэм, тоон хязгаарлалт, төлбөрийн балансын нөхцөлүүд, татаас, улсын худалдааны аж ахуйн нэгжүүд, импорттой холбоотой онцгой байдлын арга хэмжээ (safeguards), гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс гэх мэт асуудлуудын хүрээнд олон талт үүрэг хариуцлагуудыг хуульчлан тогтоож өгдөг байна.
583	GATT a la carte	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT - ТХЕХ) цэсийн дагуу (according to the menu). Уругвайн үе шатны хэлэлцээний төгсгөлд ТХЕХ-ийн гишүүн орнууд Токиогийн үе шатны хэлэлцээрийн аль хэсэгт нь элсэж орох ёстойгоо шийдэх нь өргөн хүрээнд давамгайл болж ирж байсан нөхцөл байдлыг зарим тайлбарлагчид тайлбарлахдаа энэхүү ёжтой нэр томьёог ашиглаж байв. Мөн Нэгдсэн үүрэг амлалтыг (single undertaking) үзнэ үү.
584	GATT Basic Instruments and Selected Documents	ТХЕХ-ийн Үндсэн эрх зүйн актууд ба сонгож авсан баримт бичгүүд (BISD). ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газар 1952-1994 оны хооронд жил бүр нийтэлсэн тайланд тайлант хугацаанд батлагдсан шийдвэр, дүгнэлтүүд, тайлангуудыг агуулсан байдаг. BISD гэдэг нь ТХЕХ, холбогдох хэлэлцээрүүд ба төрөлжүүлэн нэгтгэсэн хуулиудын удирдлага болон судалгааны салшгүй нэн чухал зүйл нь. Үүнийг Бүхнийг хамарсан дүн шинжилгээний индекс хэмээх тогтмол хэвлэлээр баяжуулж өгдөг.
585	GATT-consistency of national legislation	ТХЕХ ба үндэсний хууль тогтоомжийн нийцэл. Түр зуурын хугацаанд гишүүнээр элсэж орох тухай протоколын дагуу, 1948 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан үндэсний хууль тогтоомж нь хэдийгээр ТХЕХ-ийн нөхцөл, зүйл заалтуудтай нийцэхгүй байсан ч гэсэн хүчин төгөлдөр хэвээр үлдэхийг зөвшөөрсөн байдаг. Өөрөөр хэлбэл, ийм хууль тогтоомжийн эрх дарх нь хамгаалагдсан буюу шинэ хуулийг хэрэгжүүлэх нөхцөлөөс чөлөөлөгдсөн гэсэн үг. Хэдийгээр тодорхой үл хамаарах нөхцөлүүд, жишээ нь хүрээ хязгаарыг нь хатуу тогтоож өгч [үүрэг амлалтыг нь] цуцлах/чөлөөлөх хэлбэрээр үл хамаарах гэх мэтийн боломж байдаг боловч, энэ өдрөөс хойш батлагдсан хуулиуд нь ТХЕХ-тэй нийцсэн байх ёстой болдог. Үйлдвэрлэлийн заалтын хувьд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн олж тогтоосноор бол хэрэв тэд ТХЕХ-тэй илүү нийцэхээргүй болгохгүй бол эсвэл

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		бусад гишүүн улс орнуудын зохих хүсэн хүлээлтийг цуцлахгүй бол, эрх дарх нь хамгаалагдсан (grandfathered) хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж болох ажээ. Энэ удаа Супер сантай холбоотойгоор Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн гаргасан бас нэг тогтоол шийдвэр гэвэл, ТХЕХ-тэй нийцээгүй, хувийн үзэмжээр арга хэмжээ хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн үндэсний хууль тогтоомжтой байж байгаа байдал нь ТХЕХ-ийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа зөрчсөн үйлдэл болохгүй гэж үзсэн байна.
586	GATT Council of Representatives	ТХЕХ-ийн Төлөөлөгчдийн зөвлөл. Ажлын хөтөлбөрөө өргөжүүлж байгааг харгалзан ТХЕХ-ийг илүү үр дүнтэйгээр удирдахын тулд үүнийг 1960 оны 6 сарын 4-нд байгуулсан байна. Тэр хүртэл арван долоон гишүүнээс бүрдсэн чуулган хоорондын хороо нь гэрээ байгуулагч талуудын жил бүрийн чуулгануудын хооронд үргэлжилсэн байдлыг хангаж ажиллаж байлаа. Зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь гэрээ байгуулагч талуудын жил бүрийн чуулганы хуралдаануудын хооронд яаралтай анхаарал хандуулах асуудлуудыг авч хэлэлцэж мөн хороод, ажлын хэсгүүд, бусад туслах байгууллагуудын ажилд хяналт тавих үүрэгтэй байв. ТХЕХ-ийн бүх гишүүд сард нэг удаа хуралддаг Зөвлөлийн гишүүн автоматаар болсон байдаг. ДХБ-д ТХЕХ-ийн чиг үүргийг бараг л гүйцэтгэж байгаа байгууллага гэвэл Ерөнхий зөвлөл.
587	GATT plus	ТХЕХ дээр нэмэх нь. ТХЕХ-т заасан нөхцөлүүдээс илүү хатуу нөхцөлтэй олон улсын худалдааны сахилгын шийтгэл ногдуулах, эсхүл шийтгэл хүлээх, эсхүл ТХЕХ-ийн дүрмийг бараа бүтээгдэхүүний худалдаанаас бүр давуулан өргөжүүлэх гэсэн утгыг илэрхийлж байдаг. "ТХЕХ дээр нэмэх нь" гэсэн утгын хамгийн амбицтай жишээ бол (1975 онд) АНУ-ын Атлантын Зөвлөлийн гаргасан санал байдаг, үүнд уг саналыг хүлээн авах хүсэлтэй байгаа аж үйлдвэржсэн улс орнуудын хоорондох худалдааны харилцааг явуулахдаа илүү хатуу дүрэм бүхий, ТХЕХ-ийн эрх зүйн бүтэц хамрах хүрээнд худалдааны либералчлалын төрөлжүүлэн нэгтгэсэн хууль байх ёстой гэжээ. Түүнийг дэмжигчид үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (most-favoured-nation) заалтын дагуу ТХЕХ-ийн бүх гишүүн улс орнуудад үр ашиг нь өргөжин хүрэх байсан гэж үзэж байв. Уг төрөлжүүлэн нэгтгэсэн хуулийн үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх хүсэлтэй байгаа шинэ гишүүдэд ч энэ нь нээлтэй байх байсан боловч үүнд тарифын хэлэлцээг зөвхөн уг хуулийн гишүүн улс нь уг хуулийн өөр нэгэн гишүүн улстай хийж эхлүүлэх боломжтой байлаа. Энэхүү санал нь нийт ТЕГ-ын гишүүдэд таалагдсангүй. Мөн үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) үзнэ үү.
588	GATT review session	ТХЕХ-ийн хянан нягтлах хуралдаан. 1954 оны 10-р сараас 1955 оны 3-р сар хүртэл зохион байгуулагдсан ТХЕХ-ийн гэрээлэгч талуудын ес дэх хуралдаан нь ТХЕХ-ийн үйл ажиллагааны бүхий л асуудлыг хянав.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүний үр дүнд хэд хэдэн зүйлд өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээрийн хамгийн гол нь эдийн засгийн хөгжлийн асуудал, хөгжиж буй орнуудын эрх, үүргийн талаарх 18-р дугаар Зүйл байв. Бусад ихэнх өөрчлөлтүүд багахан хүрээний асуудал байсан. Ихэнхдээ нэмэлт, өөрчлөлт оруулах хэлцэл дээр бол тохиролцоонд хүрээгүй байдаг. Энэ нь мөн АНУ хөдөө аж ахуйн салбарт авсан үүрэг амлалтаас татгалзсан/чөлөөлөгдсөн тухай баримт бичгээ олж авсан хурал байлаа. Мөн Хөгжиж буй улс орнууд ба ТХЕХ (developing countries and the GATT), 22-р хэсгийн үүрэг амлалтаас татгалзсан тухай баримт бичгийг (Section 22 waiver) үзнэ үү.</p>
589	GATT-Think	<p>ТХЕХ-ийн талаар тунгаан бодох нь. ТХЕХ-ийн хэлэлцээ хийж буй улс орнуудын зорилтын талаар гурван энгийн дүрэм байдаг гэж Пол Кругман тодорхойлжээ: 1. Экспорт бол сайн, 2. Импорт бол муу, 3. Бусад зүйлс бол тэнцүү, импорт болон экспортын аль алиных нь ижил тэгш өсөлт бол сайн. Тэрээр мөн ТХЕХ-ийн талаар тунгаан бодох нь гэгээрсэн гэж хэлж болох Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) бөгөөд эдийн засгийн хувьд утгагүй зүйл юм гэжээ. Энэ бүхнийг үл харгалзан Кругман дэлхийн худалдааны системийг либералчлахад ТХЕХ нь чухал үүрэг гүйцэтгэсэн юм гэсэн байна.</p>
590	GATT 1947	<p>1947 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ 1947). Энэ нь НҮБ-ын Худалдаа, хөдөлмөр эрхлэлтийн бага хурлын Бэлтгэл ажлын хорооны хоёрдугаар хурлын төгсгөлд 1947 онд батлагдсан бөгөөд дараа нь үүнд засвар, нэмэлт өөрчлөлт оруулж эсвэл өөрчлөн зассан байдаг. 1947 оны ТХЕХ нь 1948 оны 1-р сарын 1-ээс эхлээд Уругвайн үе шатны хэлэлцээг эцэслэж 1994 онд ТХЕХ-ээр солигдох хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байсан. Энэхүү хоёр бичвэрийн хувьд, 1947 оны ТХЕХ нь олон улсын хэлэлцээр байсан бол 1994 оны ТХЕГ нь зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг нь гэдгээрээ хууль зүйн хувьд ялгаатай болно.</p>
591	GATT 1994	<p>1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ 1994). 1947 оны ТХЕХ-ийг хамруулаад мөн үүнийг 1947 онд хүчин төгөлдөр болсноос хойш хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд, хуулийн тайлбарууд, нэмэлтүүд зэргийн цуглуулгын албан ёсны нэршил. Энэ нь ДХБ-ыг байгуулах хэлэлцээрийн зөвхөн нэг хэсэг нь бөгөөд өөрт нь бие даасан хууль эрх зүйн статус байхгүй. Энэ нь 1947 оны ТХЕХ (1947 оны ТХЕХ хэлэлцээр нь өөрөө биш)-д тусгасан заалтууд дээр нэмээд, тарифын хөнгөлөлттэй холбоотой протоколууд болон сертификатууд, гишүүнээр элсэж орсон тухай протоколууд, үүрэг амлалтаас цуцлах/чөлөөлөх тухай шийдвэр болон ТХЕХ-ийн гэрээ байгуулсан талуудын гаргасан бусад шийдвэрүүдээс бүрдэх боловч үүнд дээд үеийн хуулийн заалт (grandfather clause) ордоггүй. Үүнд мөн ТХЕХ-ийн хэд хэдэн зүйлүүдийг тайлбарласан зургаан ширхэг харилцан ойлголцох баримт бичиг болон гишүүн улс орнуудын зүгээс гаргасан тарифын буулт, хөнгөлөлтүүдийг хамруулсан 1994 оны ТХЕХ-ийн Марракешийн протоколыг агуулсан байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		ДХБ-д элсэн орж байгаа орнууд 1994 оны ТХЕХ-т багтсан бүх эрх, үүргийг хүлээн зөвшөөрдөг боловч тэд үүнд тусад нь нэгдэж орох боломжгүй юм. Мөн Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах Марракешийн хэлэлцээр (Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation), Нэгдсэн үүрэг амлалтыг (single undertaking) үзнэ үү.
592	General Agreement on Trade in Services	Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр. Мөн ҮХЕХ-ийг (GATS) үзнэ үү.
593	General Agreement on Tariffs and Trade	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр. Мөн ТХЕХ-ийг (GATT) үзнэ үү.
594	General Council	Ерөнхий зөвлөл. Энэ бол ДХБ-ын бүх гишүүдээс бүрдсэн хуулийн этгээд. Үүнд ДХБ-ын шүүхийн практикийн хүрээнд байгуулагдаж байгаа янз бүрийн хэлэлцээрт хяналт тавих ерөнхий эрх мэдэл байдаг. Энэ нь хоёр жилд нэг удаа явагддаг ДХБ-ын Сайд нарын бага хурлуудын хооронд болон тэдний өмнөөс эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Мөн Маргаан шийдвэрлэх байгууллага (Dispute Settlement Body), Худалдааны бодлогын хянан үзэх тогтолцоог (Trade Policy Review Mechanism) үзнэ үү.
595	General exceptions	Эс хэрэглэх нийтлэг тохиолдол. ҮХЕХ (GATS Article XIV) болон ТХЕХ (GATT Article XX) нь ДХБ-ын гишүүн улс орнуудад эдгээр хэлэлцээрийн заалтуудыг тодорхой заасан нөхцөл байдалд эс хэрэглэх эрхийг олгосон байдаг. Гэхдээ эдгээр заалтуудыг улс орнуудыг хооронд нь ялгаварлан гадуурх эсвэл олон улсын худалдаанд учруулах халхавч хязгаарлалт байдлаар ашиглаж болохгүй. ТХЕХ-ийн дагуу дараах үндэслэлээр шаардлагатай болсон тохиолдолд л энэ эрхээ хэрэгжүүлж болно, үүнд: (a) нийтийн ёс суртахууныг хамгаалах, (b) хүн, мал амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, (c) алт, мөнгөний худалдааг хамрах, (d) ТХЕХ, гаалийн дүрэм, ёс журмыг сахиулах, монополийн хууль, эрх зүйг албадан хэрэгжүүлэх, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хууран мэхлэх аргаас урьдчилан сэргийлэх зэрэгтэй нийцэлтэй хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах, (e) шоронгийн хоригдлын хөдөлмөрөөр бүтсэн бүтээгдэхүүнтэй ажиллах, (f) урлагийн, түүхэн эсвэл археологийн үнэ цэнэ бүхий үндэсний баялгийг хамгаалах, (g) үйлдвэрлэл болон хэрэглээнд тавих дотоодын хязгаарлалттай зөвхөн хослуулах замаар шавхагдах байгалийн нөөцийг хадгалан хамгаалах, (h) олон улсын түүхий эдийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, (i) хатуу тогтоосон нөхцөлийн дор дотоодын түүхий эд/материалын экспортыг хязгаарлах, (j) дотоодын ханган нийлүүлэлт хомс байгаа үед эсвэл ерөнхийдөө бараа бүтээгдэхүүнийг олж авах болон түгээхэд нэн чухал арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг болно. Нийтийн ёс суртахуун, хүн, мал амьтан, ургамлын амьдралтай холбоотой ижил төстэй заалтуудаас гадна, ҮХЕХ нь нийгмийн язгуур эрх ашгийн аль нэгэнд бодитоор болон хангалттай хэмжээнд ноцтой хохирол учруулах аюул заналхийлсэн тохиолдолд сахих нийтийн дэг журмын талаар дурдсан байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>ҮХЕХ-ийн дүрэм журам, дан болон давхар татварын хэлэлцээрүүдийн дагуу [татварын орлогыг] хураах зэрэг нөхцөлүүдтэй нийцэмжгүй бус хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эс хэрэглэж бас болдог. Туна загасны хэргийн хувьд (Мексик-АНУ, 1991 он), маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн дурдсанаар бол, ТХЕХ-ийн эс хэрэглэх тухай ерөнхий зүйлсийн тухай заалт нь ТХЕХ-ийн бусад заалтуудын дагуу үүсдэг үүргээс хязгаарлагдмал хүрээнд ба тодорхой нөхцөлтэйгөөр эс хэрэглэх ёстой байсан ба мөн энэ нь үүрэг хариуцлагыг тогтооход эерэг дүрэм болж чадаагүй байна. Хуулийн уг Зүйлийг үргэлж нарийн тайлбарлаж ирсэн байдаг ба үүнийг дуудан эхлүүлж байгаа тал нь уг арга хэмжээг авах болсон үндэслэлээ гаргах хэрэгтэй болдог байв. 20-р Зүйлийг хамарсан бусад маргаан гэвэл туна загасны хэрэг (Канад-АНУ, 1982 он), өөрчлөн боловсруулсан бензин, май загас, хулд буюу яргай загасны хэргүүд ордог. Мөн Аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх нөхцөлийг (security exceptions) үзнэ үү.</p>
596	General tariff	<p>Ердийн тариф. Өнөө үед энэ нэр томьёог ихэнхдээ Үндэсний нэн тааламжтай нөхцөлийн тарифын оронд хэрэглэж байгаа ба тухайн гишүүн улсын худалдааны багц түншүүдийн хувьд хамаардаг байна. 1948 онд ТХЕХ хүчин төгөлдөр болохтой зэрэгцээд ердийн үндэсний нэн тааламжтай нөхцөл гарч ирэхээс өмнө, энэ нь ямар нэгэн төрлийн хөнгөлөлттэй нөхцөл авч чадаагүй улс орнуудад ашигладаг тарифтай ихэвчлэн хамаатуулан ойлгож байлаа. Зарим тохиолдолд улс орнууд Ердийн тариф ба Үндэсний нэн тааламжтай нөхцөлийн тарифыг хооронд нь ялгаж салгадаг хэвээр байгаа бөгөөд Ердийн тарифын хүрээний тарифын хувь хэмжээ нь гол төлөв өндөр байдаг. Мөн худалдааны ердийн харилцааг (normal trade relations) үзнэ үү.</p>
597	General trade	<p>Ердийн худалдаа. Энэ нь Ердийн тарифын үнээр арилжаалагдсан бараа бүтээгдэхүүн. Орчин үеийн хэрэглээнд энэ нь ихэвчлэн үндэсний нэн тааламжтай нөхцөлийг хүртэж чадсан бараа бүтээгдэхүүн гэсэн утгыг илэрхийлдэг байна.</p>
598	Generic springboarding	<p>Патентгүйгээр гулгах арга. Патентын хамгаалалтад байсаар байгаа зүйлийг патентгүй бүтээгдэхүүн мэтээр арилжааны зориулалттай үйлдвэрлэлд оруулж мөн борлуулалт хийхээр бэлтгэж эхэлсэн аж ахуйн нэгжийн хувьд энэ бол маш маргаантай үйл явц. Патентгүйгээр гулгахын зорилго нь патентгүй үйлдвэрлэгчид нь патентын хугацаа дуусмагц зах зээлд аль болох эрт орох боломжийг бүрдүүлэх явдал. Патентгүй эмийг боловсруулан гаргахад хоёроос гурван жил шаардлагатай байдаг эм зүйн бүтээгдэхүүний тохиолдолд, эрх зүйн зохицуулалтын өмнөх шаардлагад нийцэх үүднээс патентгүйгээр гулгах арга нь, патентын хамгаалалтад байсаар байгаа зүйлийг үйлдвэрлэх боломжийг тухайн аж ахуйн нэгжид олгодог байна. Гэхдээ энэ шатанд арилжааны үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй бөгөөд ингэж үйл ажиллагаа явуулсан тохиолдолд, оюуны өмчийн эрхийг зөрчсөн үйлдэл болно. Мөн статистик тоон мэдээллийг задлан гаргах (decompilation), оюуны өмч (intellectual property), урвуу инженерчлэлийг (reverse engineering) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
599	Genetic labelling	<p>Генетикийн шошгожуулалт. Зарим нь генетикийн хувьд хувиргаж өөрчилсөн бүтээгдэхүүн эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн шинж тэмдгийг товч илэрхийлэхийн тулд бүтээгдэхүүнийг шошголох энэхүү системийг санал болгосон байна. Үүнийг дэмжигчдийн үзэж байгаагаар бол ийнхүү үйлдэх нь хэрэглэгчид болон ашиглагчдын ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн байна. Үүнийг эсэргүүцэгчид энэ нь худалдаанд учруулах бас нэг хэрэгцээгүй техник саад тотгор юм, учир нь өртөг зардалтай байдаг тул ихэнх улс орнууд бусад үр тарианаас тусдаа генетикийн хувьд өөрчилж хувиргасан үр тариатай байгаад байдаггүй гэсэн байна. Шаардлагатай тохиолдолд Европын Холбооны гишүүн улс орнуудад байрлалтай аж ахуйн нэгжүүд уг шошгуудыг ашиглах нөхцөлийг баталгаажуулахын тулд 1997 оны 7-р сарын 31-н гэхэд Генетикийн шошгожуулалтын хууль тогтоомжийг батлахыг ЕХ-ны гишүүн улс орнуудаас шаардсан байна. Мөн эко-шошгожуулалт (eco-labelling), нийгмийн шинж чанартай шошгожуулалтыг (social labelling) үзнэ үү.</p>
600	Geneva Convention	<p>Женевийн конвенц. Энэ бол Фонограммыг нь (Авиазүйн галигийн тэмдэг) хууль бусаар хуулбарлагчдын эсрэг фонограм үйлдвэрлэгчдийг хамгаалах тухай конвенц. Энэ нь өөр гишүүн орны фонограм үйлдвэрлэгчийг зөвшөөрөлгүйгээр хуулбар хийхээс хамгаалдаг. Фонограм гэдэг нь дууны бичлэг гэх мэт (дууны бичлэг, компакт диск, аудио хуурцаг гэх мэт) гагцхүү дуу авианы тэмдэглэл гэсэн утгатай. Уг нэр томьёонд дуу хууртай кино, видео хуурцаг ороогүй болно. Тус конвенц одоогоор 52 гишүүнтэй байна.</p>
601	Geneva Tariff Conference, 1947	<p>Женевийн тарифын бага хурал, 1947 он. Энэ нь НҮБ-ын Худалдаа, хөдөлмөр эрхлэлтийн бага хуралд Бэлтгэх ажлын хорооны оролцогчдын хооронд хийсэн тарифын хэлэлцээрүүдээс бүрдсэн. Ойролцоогоор 45,000 орчим тарифын хөнгөлөлт, буултуудыг харилцан солилцов. Энэ нь анх удаа тарифын хэлэлцээрийг олон талт түвшинд хийсэн явдал байв. Хэлэлцээрийг үндсэн нийлүүлэгчийн дүрмийн дагуу удирдан явуулсан. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний хамгийн их хувийг нь ханган нийлүүлж буй улс тарифыг бууруулах хүсэлт гаргасан тохиолдолд л тарифын хөнгөлөлт бууруулалт олгох асуудлыг авч үзэх ёстой байсан. Энэхүү тарифын бага хурал нь олон талт худалдааны хэлэлцээний эхний үе шат болсон байна гэж үздэг. Мөн үндсэн ханган нийлүүлэгчийн эрхийг (principal supplier right) үзнэ үү.</p>
602	Geneva Tariff Conference, 1955-56	<p>Женевийн тарифын бага хурал, 1955-56 он. АНУ-ын зүгээс өөрийн улсын төлөөлөгчдөд хэлэлцээ хийх хязгаарлагдмал эрх олгосон байсан учраас, тарифын олон талт хэлэлцээний багахан хүрээний үе шат болж өнгөрөв. Энэ бол албан ёсны тарифын бага хурлын хамгийн сүүлчийнх байсан ба олон талт худалдааны хэлэлцээний дөрөв дэх үе шат байсан гэж үздэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
603	Geographical indications	Газарзүйн заалт. Энэ нь тухайн бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээ нь тухайн нэг улс, эсхүл газар нутгаас үүсэл гаралтай болохыг илэрхийлэн тодорхойлоход ашигладаг илэрхийлэл, эсхүл тэмдэг. Газарзүйн заалтад тухайн бараа бүтээгдэхүүний тодорхой чанар, нэр хүнд, бусад шинж чанарыг үндсэндээ хамаатуулж болохоор байдаг. Дарс үйлдвэрлэдэг зарим улс орнуудад уламжлалт газарзүйн заалт нь дарсны төрлийг тайлбарлахад ашигладаг өргөн хүрээнд тархсан арга хэрэгсэл болсон байдаг тохиолдолд “хагас-патентгүй” нэршлийг ашиглахыг зөвшөөрдөг боловч энэ нь зөвхөн тухайн шошгон дээр нь тухайн дарсны жинхэнэ газар зүйн заалтыг харуулж байгаа тохиолдолд л зөвшөөрдөг байна. Тийм “хагас-патентгүй” нэршлийн жишээ гэвэл Бургунди (Burgundy), Шери (Sherry), Порт (Port) байна. Зарим нөхдүүдийн үзэж байгаагаар бол ийм арга нь Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийн дагуу авч үзвэл хууль бус гэдэг.
604	Global commons	Даян дэлхийн нийтийн эзэмшил. Энэ нь үндэсний шүүн таслах ажиллагаа, шүүхийн практикаас гадна харьяалагдах далай тэнгис, гадаад сансрын орон зай, Антарктик буюу өмнөд туйл гэх мэт дэлхийн бөмбөрцгийн бусад хэсгүүд юм хэмээн Байгаль орчин, хөгжлийн асуудал эрхэлсэн дэлхийн комиссоос тодорхойлсон байдаг. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
605	Globality	Даяаршлын (даяарчлал) хамгийн эцсийн төлөв. Үүнийг заримдаа Пунта дель Эсте тунхаглалын нэг хэсгийг нь бүрдүүлж байдаг хэлэлцээ хийх үндсэн зарчмын нэгийг дурдан эшлэл болгон ашигладаг байна. Хэлэлцээг эхлүүлэх, удирдан явуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг Нэгдсэн үүрэг амлалтын (single undertaking) нэг хэсэг гэж үзэх ёстой гэсэн зарчим юм. Энэхүү зарчмыг ихэвчлэн “бүх зүйл зөвшилцөлд хүрэх хүртэл юу ч зөвшилцөлд хүрээгүй байдаг” гэсэн хэллэгээр илэрхийлдэг.
606	Global quota	Даян дэлхийн хүрээний тоо хэмжээний хязгаарлалт/квот. Энэ нь тодорхой хугацаанд буюу ихэвчлэн нэг жилийн дотор импортлож, эсхүл экспортлож болох бүтээгдэхүүний нийт тоо хэмжээнд тухайн нэг улсын тавьсан хязгаар юм. Мөн Тоо хэмжээний хязгаарлалттай тариф (tariff quota) үзнэ үү.
607	Global Trade Point Network	Даян дэлхийн худалдааны цэгүүдийн сүлжээ. Үүнийг олон улсын худалдаанд шилжиж буй хөгжиж буй орнууд болон бусад улс орнуудын оролцоог нэмэгдүүлэх, худалдааны хэлцлийн зардлыг бууруулах, худалдаатай холбогдолтой мэдээлэл, дэлхийн сүлжээнд илүү сайн нэвтрэх боломжийг олгох зорилгоор НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) байгуулсан байдаг. Одоо 100 орчим үндэсний худалдааны цэгүүд бий. Тэд хоорондоо цахимаар холбогдсон байна. Тэд худалдааг дэмжих төв байдлаар ажилладаг бөгөөд ёс журмын дагуу хийгдэх бүх бүртгэлийг нэг дэврийн дор хийж болох бөгөөд тэд экспортын боломжийн талаар худалдаа эрхлэгчдэд мэдээлэл өгч байдаг. Мөн худалдааны үр ашгийн хөтөлбөр (Trade Efficiency Programme), цахим худалдаа, арилжааг (electronic commerce) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
608	Government procurement	Засгийн газрын худалдан авалт. Үүнийг мөн төрийн худалдан авалт гэдэг. Үүнд засгийн газар болон засгийн газрын эрх баригчид өөрсдийн хэрэгцээнд зориулан бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хамруулсан байдаг. Засгийн газрын худалдан авалт нь олон улс орнуудын хувьд, ДНБ-ий 10% орчим хувийг эзэлдэг гэсэн тооцоолол байдаг боловч тооцоолол бүр ихээхэн ялгаатай байх нь бий. ТХЕХ болон ҮХЕХ-ийн дүрэм журмыг хэрэгжүүлэх нөхцөлөөс засгийн газрын худалдан авалтыг чөлөөлсөн байдаг. Мөн Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр (Agreement on Government Procurement), засгийн газрын худалдан авалтын ил тод байдлын талаарх Ажлын хэсгийг (Working Group on Transparency in Government Procurement) үзнэ үү.
609	Government trading monopolies	Засгийн газрын худалдаа эрхэлсэн монополууд. Энэ нь ихэвчлэн төрийн өмчит, нэг аж ахуйн нэгжид тодорхой бараа бүтээгдэхүүнийг олон улсад худалдаалах онцгой эрхийг олгосон байдаг. Мөн нэгдмэл ганц аппаратын борлуулалт (single desk), улсын худалдаа эрхлэлтийг (state trading) үзнэ үү.
610	Graduation	Хөнгөлөлтийг аажмаар дуусгавар болгох. Энэ нь Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP - Generalised System of Preferences)-тэй холбоотой ойлголт бөгөөд хөнгөлөлт эдлэгч хөгжиж буй орон, эсхүл тодорхой бараанд олгох хөнгөлөлтийг аажмаар бүр мөсөн болон хэсэгчлэн хасах тогтолцоо. Хасалт хийх гол шалгуур нь хөгжиж буй орны эдийн засгийн хөгжлийн төвшин болон экспорт, импортын хэмжээ. Бүр мөсөн хасалт гэдэг нь эдийн засгийн тодорхой төвшинд хүрсэн орнуудыг хасахыг хэлдэг ба ЕХ, АНУ-ын хөтөлбөрөөс БНСУ, Сингапур зэрэг орнууд хасагджээ. Хэсэгчилсэн хасалт гэдэг нь хөнгөлөлтөөс бүх барааг бус тодорхой барааг хасахыг хэлэх ба бүрэн хасалтын эхний алхам болдог. Хэсэгчилсэн хасалтыг экспорт, импортын төрөлжилт, хөгжлийн түвшингээс хамруулж хийнэ. Жишээлбэл, эхний жил нь хөнгөлөлттэй оруулах хэмжээг 50 хувь багасгаж, 2 дах жил нь хөнгөлөлтөөс бүрэн хасах гэх мэт. Тайваниас импортлодог хуванцар бүтээгдэхүүний хөнгөлөлтийг Япон улс хассан. Японы хувьд бүтээгдэхүүний импорт тодорхой түвшинд хүрсэн тохиолдолд уг барааг хасдаг байна. Мөн Өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалтыг (competitive-need limitation) үзнэ үү.
611	Graduation clause	Аажмаар шилжих тухай заалт. Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) 7-р догол мөрд тэмдэглэснээр бол ТХЕХ-ийн буурай хөгжилтэй гишүүн улс орнууд ТХЕХ-ийн нөхцөлийн дагуу хувь нэмэр оруулах тэдний хүчин чадал нь тэдний эдийн засаг болон худалдааны дэвшилтэт хөгжлийг сайжруулах болно гэж хүсэн хүлээдэг. Үүний дагуу тэд ТХЕХ-ийн эрх, үүргийн бүтэц хамрах хүрээнд илүү бүрэн дүүрэн хэмжээнд оролцох болно гэж тэд найдах болно. Мөн хөгжиж буй улс орнууд ба ТХЕХ (developing countries and the GATT), Хөнгөлөлтийг аажмаар дуусгавар болгох (graduation) үзнэ үү.
612	Grains Trade Convention	Үр тарианы худалдааны конвенц. Мөн Үр тарианы олон улсын хэлэлцээрийг (International Grains Agreement) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
613	Grandfather clause	<p>Дээд үеийн хуулийн заалт. Энэ нь 1947 оны ТХЕХ-ийн анхны гишүүн улс орнуудын баталж гаргасан Түр ашиглах протоколын нөхцөлийг эшлэн тайлбарлаж байгаа бөгөөд үүнд ТХЕХ-ийн 2-р Бүлгийг “одоо байгаа хууль тогтоомжуудтай харшлахгүйгээр бүрэн хэмжээгээр хэрэглэнэ” гэж заажээ. Энэ нь ТХЕХ-ийн зүйл заалтуудыг зөрчсөн үндэсний хууль тогтоомж үргэлжлүүлэн оршин тогтнох боломжийг зөвшөөрсөн эрх зүйн акт байлаа. Гишүүн улс орнууд ТХЕХ-тэй эхлээд тэдний өөрсдийн хууль тогтоомжуудаа нийцүүлнэ гэвэл ТХЕХ-г хүчин төгөлдөр болгох асуудал нь хугацаагүйгээр хойшлох байсан гэсэн байр суурь дээр энэ нь тулгуурласан байна. Энэ нөхцөлийг “Дээд үеийн хуулийн заалт” гэдэг учир нь уг хэлэлцээрийг хожим урагшлуулан огноолох (predating) fait accompli (уг хуулийн нөлөөнд өртөгсөд сонсож мэдэхээс өмнө шийдэгдсэн эсвэл аль дээр болоод өнгөрсөн) хууль тогтоомж хэмээн хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой юм. Дээд үеийн хуулийн заалтыг 1994 оны ТХЕХ-т шилжүүлэн оруулж ирээгүй байдаг. Мөн Үндэсний хууль тогтоомжийн ТХЕХ-тэй нийцэлтэй байдлыг үзнэ үү.</p>
614	Green box	<p>Ногоон ангилалд хамаарах татаас. Энэ нь Уругвайн үе шатны хэлэлцээний хүрээнд тарифыг бууруулах үүрэг амлалтаас чөлөөлөгдсөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд үзүүлэх дотоодын дэмжлэг. Ногоон ангилалд хамаарах татааст худалдаанд гажуудал үүсгэхгүй буюу жишээлбэл, гамшгийн хор уршгийг арилгах, судалгаа шинжилгээ, өвчний хяналт, дэд бүтэц, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүнсний аюулгүй байдал зэрэг олон төрлийн тусламжийн арга хэмжээгээр дамжуулан малчид, тариаланчдад бодит тусламж үзүүлэх үйл ажиллагааг хамардаг. Мөн Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр (Agreement on Agriculture), хөх ангилалд хамаарах татаасыг (blue box) үзнэ үү.</p>
615	Greenhouse gases	<p>Хүлэмжийн хий. Хэт улаан туяаг шингээж мөн ялгаруулдаг агаар мандалд буй (атмосфер) хийд өгсөн бүх зүйлийг хамарсан (omnibus) нэр томьёо. Эдгээр хий нь агаар мандлын эзлэхүүний 1% -иас бага хувийг эзэлдэг. Ийм хий удаан хугацааны туршид бий болсон болохыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотолсон байдаг. Энэ нь цаг уурын сөрөг өөрчлөлтөд хүргэсэн гэх урьдчилсан таамаглал гаргахад хүргэсэн. Хүлэмжийн гол хийнүүд нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), метан (CH₄), азотын исэл (N₂), перфлуокарбон (PFC) юм. Мөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцийг (United Nations Framework Convention on Climate Change) үзнэ үү.</p>
616	Greening the GATT	<p>ТХЕХ-ийг ногооруулах. Энэхүү нэр томьёог заримдаа ДХБ-аас байгаль орчны тодорхой асуудалд илүү хариуцлагатай хандахыг хүсдэг, ТХЕХ-т байгаль орчныг хамгаалах зорилтыг илүү тодорхой тусгасан байх шаардлагатай гэж үздэг хүмүүс ашигладаг.</p>
617	Green labelling	<p>Ногоон шошгожуулалт. Мөн эко-шошгожуулалтыг (eco-labelling) үзнэ үү.</p>
618	Green protectionism	<p>Ногоон протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах ногоон онол.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
619	Grey-area measures	Саарал бүсийн арга хэмжээ. Экспорт болон импортыг ялгаварлах замаар хязгаарлалт хийхийг засгийн газрууд хоорондоо тохиролцсон нь олон талт худалдааны тогтолцоог зохицуулах зарчимд ихэвчлэн харшлах боловч олон талт дүрмийн дагуу илэрхий хууль бус зүйл биш байв. Жишээлбэл, Зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт (Orderly Marketing Arrangements) ба сайн дурын экспортын зохицуулалт (voluntary export arrangements). Одоо эдгээр нь ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу хууль бус. Одоогоор байгаа саарал бүсийн арга хэмжээг 1999 он гэхэд арилгасан байх хэрэгтэй болсон. Энэ арга хэмжээ нь магадгүй засгийн газрын зүгээс далдуур хориглосон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хооронд хийгдсэн картель болон засгийн газрууд хооронд хийгдсэн сайн дурын импортын өргөжүүлэлт байж болох юм.
620	Grey marketing	Саарал маркетинг. Паралель импортын үйл ажиллагааны аргыг илэрхийлсэн Хойд Америкийн ярианы хэллэг. Ийм аргаар импортлогдсон бол "саарал зах зээлийн бүтээгдэхүүн" эсхүл "саарал зах зээлийн импорт" гэж нэрлэдэг.
621	Group of Latin American and Caribbean Countries	Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудын бүлэг. Мөн GRULAC-ийг үзнэ үү.
622	Group of Negotiations on Goods	Бараа бүтээгдэхүүний талаарх хэлэлцээний бүлэг (GNG). Уругвай үе шатны хэлэлцээний эхэнд байгуулагдсан уг бүлэг нь ТХЕХ болон бараа бүтээгдэхүүний худалдаатай холбоотой хэлэлцэж буй бүх асуудлыг, түүнчлэн Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлууд, Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээг хамруулан удирдан зохион байгуулахын тулд байгуулагдсан байна.
623	Group of Negotiations on Services	Үйлчилгээний бүтээгдэхүүний талаарх хэлэлцээний бүлэг (GNS). Уругвайн үе шатны хэлэлцээний эхэнд байгуулагдсан уг бүлэг нь үйлчилгээний худалдаатай холбоотой бүх асуудлуудыг зохицуулахын тулд байгуулагдсан байна.
624	Group of Three	Гурвын бүлэг. Колумби, Мексик, Венесуэл улсын хооронд байгуулагдсан чөлөөт худалдааны хэлэлцээр. Энэ нь 1995 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Мөн Чөлөөт худалдааны бүсийг (free-trade area) үзнэ үү.
625	Group of 77	77-гийн бүлэг (77 гишүүн орнуудын бүлэг (G77)). 1964 онд НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) анхдугаар хурлаар байгуулагдсан ба хөгжиж буй орнуудын сул зохион байгуулалттай бүлэг ба анх 77 гишүүнтэй байсан. Удалгүй маш богино хугацаанд UNCTAD-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг боловсруулан тогтоож өгдөг гол хүчин болсон байна. Одоо 130 гаруй гишүүнтэй болжээ. Одоо байгаа гишүүд нь тухайн нэг улсыг гишүүнчлэлээр элсүүлэх эсэхийг шийдэхийн тулд эдийн засаг, улс төрийн өргөн хүрээний шалгуурыг ашигладаг. G77-ийн хурал даргалагчийн хувьд, Африк, Латин Америк, Азийн орнуудыг төлөөлж буй бүлгүүдийн дунд тогтмол интервалтайгаар ээлжлэн ажиллуулдаг. G77 нь НҮБ-ын системийн бусад хэсэгт бас үйл ажиллагаа явуулдаг. Мөн бүлгийн системийг (group system) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
626	Group on Basic Telecommunications	Үндсэн цахилгаан харилцаа холбооны бүлэг (GBT). Үүнийг Үйлчилгээний худалдааны зөвлөл нь Үндсэн цахилгаан харилцаа холбооны талаарх хэлэлцээний бүлгийн залгамжлагчаар 1996 оны 1-р сарын 15-ны өдөр байгуулсан байдаг. Үүний гол ажил бол үндсэн цахилгаан харилцаа холбооны талаарх зөвлөгөөнүүдийг үргэлжлүүлэх явдал байв. Үндсэн цахилгаан харилцаа холбооны үйлчилгээний тухай хэлэлцээрийг эцэслэн байгуулснаар энэхүү бүлэг нь 1997 оны 2-р сарын 15-ны өдөр дуусгавар болсон.
627	GRULAC (Latin American and Caribbean Group)	Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудын бүлэг. ДХБ-д албан бус үйл ажиллагаа явуулдаг.
628	GSP (Generalized System of Preferences)	Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP). Хөгжиж буй орнуудаас гарал үүсэлтэй импортод хөнгөлөлттэй тариф эдлүүлэх хөгжингүй орнуудын хөтөлбөр. Үүнийг анх 1968 онд НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) 2-р хуралдааны үеэр санал болгосон байдаг. 1971 онд хүчин төгөлдөр болсон. Энэ нь хөгжиж буй улс орнуудын бараа бүтээгдэхүүн өндөр хөгжсөн улс орнуудын зах зээлд нэвтрэхэд тулгардаг тарифын хувь хэмжээнээс хүртэх хөнгөлөлтийн ашгийг хөгжиж буй улс орнуудад олгодог бөгөөд ийм арга замаар тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг зорьдог. Олон талт худалдааны хэлэлцээр, нэг талт үйл ажиллагааны үр дүнд 1971 оноос хойш үүссэн тарифын асар их бууралт, бүтээмжид гарсан өөрчлөлт нь олон хөгжиж буй улс орнуудын хувьд авч үзэж байсан GSP-гийн ач холбогдлыг бууруулсан боловч, хөгжиж буй олон улс орнуудын худалдааны бодлогод нэгэн чухал талбар нь хэвээр болж үлдсэн байна. UNCTAD нь GSP-ийн асуудлыг хэлэлцэх гол хэлэлцүүлэг.
629	GSTP (Global System of Trade Preferences)	Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн систем. Энэ нь НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD)-ын ивээл дор 1989 онд хүчин төгөлдөр болсон ба хөгжиж буй орнуудын хоорондын худалдаанд тарифын хөнгөлөлт (тарифын бусыг мөн оруулах боломжтой) бий болгох замаар тэдний эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийг хангах зорилготой. Нэн буурай орон харилцан хөнгөлөлт эдлүүлэх шаардлагагүй. 77-гийн бүлгийн орнуудад гишүүнчлэл нь нээлттэй бөгөөд одоогоор 44 орон энэ системд оролцож байна. Мөн Хөгжиж буй улс орнууд хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг (Economic Cooperation Among Developing Countries - ECDC) үзнэ үү.
630	Guidelines for Mutual Recognition Agreements or Arrangements in the Accountancy Sector	Нягтлан бодох бүртгэлийн салбар дах харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр, зохицуулалтын удирдамж. ДХБ-аас 1997 оны 5-р сарын 29-ний өдөр батлагдсан заавал үүрэг амлалт авах шаардлагагүй зарчмуудын багц буюу энэ нь мэргэжлийн ур чадварыг харилцан хүлээн зөвшөөрөх талаар засгийн газрууд хоорондоо хэлэлцээ хийхэд хялбар дөхөм болгох зорилготой.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Удирдамжийн А хэсэгт: хэлэлцээг удирдан явуулах болон ҮХЕХ-ийн дагуу засгийн газруудын хүлээсэн холбогдох үүрэг хариуцлагуудыг тусгасан. Б хэсэгт: хэлэлцээрт товлож буй оролцогчид, тохиролцооны зорилго цар хүрээ, дагаж мөрдөх шаардлагатай болох харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлүүд, хэрэгжүүлэх механизм, бусад холбогдох асуудлууд зэрэг хэлэлцээрийн явцад шийдвэрлэх шаардлагатай байж болох янз бүрийн асуудлыг тусгасан.</p> <p>Мөн Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (mutual recognition arrangements), Мэргэжлийн үйлчилгээний талаарх ажлын хэсгийг (Working Party on Professional Services) үзнэ үү.</p>
631	Guiding Principles Concerning Environmental Policies	<p>Байгаль орчны бодлогын талаар баримтлах удирдамж болгосон зарчмууд. Энэ нь 1972 оны 5-р сарын 26-ны өдөр батлагдсан ЭЗХАХБ-ын (OECD) зөвлөмж. Үүнд агуулагддаг дараах таван зарчим нь байгаль орчны бодлогын олон улсын эдийн засаг, худалдааны утгыг нь авч үзэхэд чиглэсэн байдаг. Нэгдүгээрт, бохирдлыг бууруулах, нөөцийг илүү зүй зохистой хуваарилахад чиглэсэн олон нийтийн арга хэмжээний зардлыг “Бохирдуулагч нь төлөх” зарчмаар хангах ёстой. Хоёрдугаарт, хэдийгээр энэ нь гүйцэлдүүлэхэд бэрхшээлтэй байж болох боловч хүрээлэн буй орчны стандартыг уялдуулан нийцүүлэхийг хөхиүлэн дэмжсэн байдаг. Ямар ч тохиолдолд илүү хатуу хэм хэмжээний жишигт хүрэх нь зүйтэй юм. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь тарифын бус саад бэрхшээлийг худалдаанд бий болгохоос зайлсхийх ёстой. Гуравдугаарт, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг улсын гарал үүслээс үл хамааран импортын бүтээгдэхүүнүүдэд ижил тэгш нөхцөлөөр хандах ёстой хэмээн тодорхойлсон үндэсний нөхцөл, үл ялгаварлах зарчмын дагуу хэрэгжүүлэх ёстой. Дөрөвдүгээрт, бүтээгдэхүүний стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах журмыг тогтоосон байх ёстой. Тав дах зарчим бол байгаль орчны бодлогын ялгаа нь ямар нэгэн нөхөн орлуулсан импортын татвар эсвэл экспортын хөнгөлөлтийн хэлбэрт хүргэж болохгүй юм.</p>
632	Gulf Cooperation Council	<p>Персийн Булангийн хамтын ажиллагааны зөвлөл (GCC). Үүний албан ёсны нэр нь Персийн Булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл. Энэ нь 1981 онд байгуулагдсан. Үүнд Саудын Араб, Кувейт, Бахрейн, Катар, Арабын Нэгдсэн Эмират, Оман улсуудаас бүрддэг. Түүний улс төрийн болон эдийн засгийн томоохон зорилтуудын нэг нь эдийн засаг, санхүүгийн салбар, худалдаа, гааль, тээвэр, мэдээлэл, аялал жуулчлалын салбарт ижил төстэй зохицуулалт хийх явдал. 1981 онд GCC-ийн гишүүд үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хамарсан чөлөөт худалдааны бүс байгуулсан боловч үүнд газрын тосны бүтээгдэхүүн ороогүй байдаг. Түүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Эр-Рияд хотод байрладаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
633	G-7	Их Долоо (G-7). Энэ нь АНУ, Япон, Франц, Герман, Канад, Итали, Их Британи улсуудаас бүрддэг. Энэ нь олон улсын эдийн засаг, мөнгөний үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан чиглэлийг тогтоохыг хичээдэг. G-7 гишүүд жил бүр гол төлөв худалдааны бодлогын асуудлаар хэлэлцдэг эдийн засгийн дээд хэмжээний уулзалтад оролцдог. Тэдгээр улс орнуудын эдийн засгийн хэмжээ нь дэлхийн бүх Дотоодын нийт бүтээгдэхүүний бараг тал хувьтай тэнцүү байдаг.
634	G-8	Их Найм (G-8). Энэ нь ОХУ-ыг оролцуулаад Их Долоод (G-7) өгсөн албан бус нэршил.
635	G-15	Их Арван тав (G-15). ДХБ-ын системд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг анх 15 гишүүн улсаас бүрдсэн бүлэг. Энэ нь 1990 онд байгуулагдсан бөгөөд одоо түүний гишүүд нь: Алжир, Аргентин, Бразил, Чили, Колумби, Египет, Энэтхэг, Индонез, Иран, Ямайка, Кени, Малайз, Мексик, Нигери, Перу, Сенегал, Шри-Ланка, Венесуэл, Зимбабве.

--- O ---

636 Haberler Report

Хаберлерийн тайлан. 1957 оны сүүлээр ТХЕХ-ийн гишүүд өнгөрсөн болон өнөөгийн олон улсын худалдааны чиг хандлага, тэдгээрийн үр дагаврыг нягтлан шалгуулахаар шийдсэн болно. Үүний тулд, ялангуяа (а) нэн буурай хөгжилтэй орнуудын худалдаа нь аж үйлдвэржсэн орнуудынх шиг хурдацтай хөгжиж чадаагүйн учир шалтгаан, b) хэт богино хугацаанд гарч буй анхдагч түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, c) хөдөө аж ахуйн салбар дах өргөн хүрээний хамгаалалтын асуудал зэрэг байв. Энэ нь ялангуяа хөгжиж буй орнуудын өмнө тулгамдаж буй асуудлуудыг харгалзан ТХЕХ-ийн хэрэгжилтэд хийсэн анхны тийм хяналт шалгалтын ажил байв. Энэхүү ажлыг хийж гүйцэтгүүлэхээр Харвардын их сургуулийн Готфрид Хаберлерээр ахлуулсан нэр хүнд бүхий эдийн засагчдын бүрэлдэхүүнийг цуглуулсан. 1958 оны 10-р сард "Олон улсын худалдааны чиг хандлага" нэртэй маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөлийн (panel) анхны тайланг гаргасан. Энэхүү тайлан гарсан даруйд Хаберлерийн тайлан (Haberler Report) гэж нэрлэгдэх болсон. Уг тайланд нийт 60 дүгнэлт орсон байна. Эхний арван таван дүгнэлт нь богино хугацаан дах хэлбэлзэл, түүхий эдийн бараа бүтээгдэхүүний урт хугацааны чин хандлага, тухайн үед олон улсын худалдаанд давамгайлж байсан боловсруулах үйлдвэрлэлийн худалдааны хандлагын бодит байдлыг дүгнэсэн. Дараагийн найман дүгнэлт нь олон улсын худалдааны түүхэн чиг хандлага, ирээдүйд импортод тавигдах шаардлага, экспортын төлөв байдлыг тайлбарлахтай холбоотой юм. Гэвч энэхүү тайланд сүүлийн жилүүдэд аж үйлдвэржсэн орнуудаас хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйн салбар дах хамгаалалтын арга хэмжээ нэмэгдэж буй нөхцөл байдлыг урьдчилан дүгнэж чадаагүй боловч, аж үйлдвэржээгүй улс орнуудын хувьд импортыг худалдан авах чадвараа нэмэгдүүлэх худалдааны нөхцөл байдал нь сайжирна гэдэгт найдахгүй байхыг мөн анхааруулсан байна. Дараагийн 33 дүгнэлт хамгийн чухал нь байв. Тодорхой түүхий эдийн зах зээлийг тогтворжуулах асуудлыг уриалсан боловч хэт идэвх санаачилгатай биш байдлаар дүгнэсэн. Түүнчлэн, Хойд Америк болон Баруун Европын улс орнуудаас хөдөө аж ахуйн салбартаа хэрэгжүүлж буй протекционист арга хэмжээгээ бууруулах зохицуулалт хийх асуудлыг тусгажээ. Мөн Европын бодит орлого өсөхийн хэрээр түүхий эд, хүнсний бараа бүтээгдэхүүний худалдаа хазайж гаднын эх үүсвэрээс Европын эх үүсвэр рүү шилжиж буйд санаа зовсон нэгэн таамаглалыг дэвшүүлсэн байна. Сүүлийн дөрвөн дүгнэлтэд, хэдийгээр илтгэлд тусгагдсан асуудал нь үндсэндээ өндөр хөгжилтэй улс орнуудын худалдааны бодлогод нөлөөлөх хэдий ч санал болгож буй өөрчлөлтийн үр дүнд эдгээр улсууд ч мөн адил ашиг хүртэнэ гэдэгтэй шинжээчид санал нэгджээ.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Мэргэжилтнүүд ямар ч тохиолдолд олон улсын худалдаанд баримталж буй өнөөгийн дүрэм журмууд болон конвенцууд нь хөгжиж буй орнуудад харьцангуй тааламжгүй байна гэсэн нь зарим талаараа үндэслэлтэй байна гэж дүгнэв. Хаберлерийн тайлан (Haberler Report) нь 1958 оны 11-р сард батлагдсан Худалдааг өргөжүүлэх хөтөлбөрт зориулан зарим санааг дэвшүүлсэн боловч ТХЕХ-ийн дүрмийг боловсруулахад маш багахан хэмжээнд шууд нөлөөлсөн бөгөөд улмаар энэ нь Диллонийн үе шатны хэлэлцээнд хүргэсэн юм. Үүний гол шалтгаануудын нэг нь 1950-аад оны сүүлчээр ТХЕХ нь дөнгөж 37 гишүүнтэй байснаас 21 нь хөгжингүй орнууд байсантай холбоотой байж болох юм. Гэсэн хэдий ч уг тайлан нь хөгжиж буй орнуудын түүхий эдийн экспортод нөлөөлж буй олон хүчин зүйлүүдийн асуудлыг нотолсон болно. Энэхүү тайланд хөндөгдсөн олон асуудлууд нь НҮБ-ын ХХБХ (UNCTAD)-ын нэгдүгээр бага хурлын (1964) бэлтгэл ажлын үеэр хэлэлцэгдсэн байна. Энэхүү бага хуралд оролцогсад тайланд санал болгосон цар хүрээний хувьд харьцангуй дунд зэргийн, даруухан шийдвэрлэх арга зам, шийдлүүдийг нь олох л байсан. Мөн Түүхий эд, материалын бодлого (commodity policy), хөгжиж буй орнууд болон ТХЕХ (developing countries and the GATT)-ийг үзнэ үү.</p>
637	Hard -core waiver	<p>Хүнд үүрэг амлалтыг цуцлах тухай/үүргээс чөлөөлөх баримт бичиг. Энэ нь төлбөрийн тэнцэлтэй холбоотой байнгын хүндрэл бэрхшээлээс болж хэдэн жилийн турш хэрэглэгдэж байсан тоон хязгаарлалтыг халалгүйгээр, хэвээр нь авч үлдэхийг гишүүдэд зарим тохиолдолд зөвшөөрөх үүднээс ТХЕХ-ийн хүрээнд 1955 онд гаргасан шийдвэр. Үүргээс татгалзаж/чөлөөлөгдөх гишүүд зарим нөхцөлийг хангах ёстой. Жишээлбэл, тоон хязгаарлалтыг гэнэт халах нь дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулах болно гэдгийг гишүүд нотлох ёстой байсан бөгөөд тэд либералчлалын идэвхтэй бодлого явуулах ёстой байв. Мөн Үлдэгдэл тоон хэмжээний хязгаарлалтыг (residual quantitative restrictions) мөн үзнэ үү.</p>
638	Hard law	<p>Хатуу эрх зүй. Энэ нь худалдааны бодлогын хүрээнд гишүүдээс эрх, үүргээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэхийг шаарддаг олон улсын зохицуулалт. ДХБ-ын ТХЕГ (Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр) ба GATS (Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр)-ийн хүрээнд авсан үүрэг амлалт бол хатуу хуулиудын жишээ. Ийм зохицуулалт нь ихэвчлэн хэлэлцээр хэлбэрээр байдаг, эсвэл тэд олон улсын хэлэлцээрийн статустай байдаг. Мөн зөөлөн эрх зүй (soft law)-ийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
639	Harmonisation of standards and qualifications	<p>Стандарт ба чанарын баталгаажуулалтыг уялдуулах. Энэ нь урьд өмнө тус бүр өөр өөрсдийн бие даасан стандарт, чанарын шаардлагыг тавьж байсан хоёр буюу түүнээс дээш улс орнуудын хувьд нэг стандарт эсвэл мэргэшлийн чанарын шаардлагыг батлан мөрдөх болсон байна. Энэхүү зохицуулалтаар цоо шинэ стандартыг бий болгох, зохицуулалтад хамгийн нөлөө бүхий оролцогчийн стандартыг батлан мөрдөх, хамгийн боломжийн үндэслэлтэй стандартыг эсвэл тэдгээрийн холимог стандартыг багтааж болно. Мөн Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (Agreement on Technical Barriers to Trade), нарийн тодорхой уялдуулан зохицуулалт (explicit harmonisation), Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission), Олон улсын стандартчиллын байгууллага болон харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (International Organisation for Standardisation and mutual recognition arrangements) зэргийг үзнэ үү.</p>
640	Harmonised Commodity Description and Coding System	<p>Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем. Үүнийг ихэвчлэн Уялдуулсан систем гэж нэрлэдэг ба Дэлхийн гаалийн байгууллагаас удирдан зохицуулдаг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн олон улсын конвенцид тусгагдсан, олон улсад худалдаалагдаж байгаа барааг ангилал систем. Энэхүү конвенц нь 1988 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Уялдуулсан системийг гаалийн зорилгоор ашигладаг. Түүнчлэн гарал үүслийн дүрмийг хэрэгжүүлэхэд хамааралтай. Уялдуулсан системийн зорилго нь (a) гаалийн зориулалтаар барааны ангиллыг олон улсын хэмжээнд нэг мөр жигдрүүлэх; (b) дэлхийн худалдааны статистик мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, харьцуулах; (c) арилжааны зорилгоор барааг кодлох, тодорхойлох, ангилал олон улсын нийтлэг тогтолцоог бий болгох; (d) технологийн хөгжил, олон улсын худалдааны хэв загвар дах өөрчлөлтийг харгалзан нэр томьёоны жагсаалтыг (nomenclature) шинэчлэх. Энэ нь 96 бүлэг, 1241 зүйл (4 орон буюу headings) ба 5000 гаруй мөр (6 орон буюу sub headings)-тэй. Үндэсний засаг захиргааны болон статистикийн шаардлагыг тусгах зорилгоор үндэсний кодын задаргааг 7,8 дах орноос хийж болно.</p>
641	Harmonised tariff reductions	<p>Тарифыг уялдуулан бууруулах. Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр судлагдсан тарифын түвшинг бууруулах нэг арга. Энэ нь гишүүдийн ижил төрлийн бүтээгдэхүүний тарифыг ойролцоогоор ижил түвшинд хүргэхэд чиглэгдсэн байв. Тарифыг уялдуулах нь 25 жилийн өмнөх шигээ маш хэцүү төвөгтэй асуудал. Учир нь эмзэг бүтээгдэхүүнүүдэд үзүүлэх тарифын өөрчлөлтийн нөлөөллөөс шалтгаалж байна. Мөн шугаман аргачлалын дагуу тарифыг бууруулах (linear tariff cuts), тарифын хэлэлцээг (tariff negotiations) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
642	Havana Charter	<p>Гаванагийн дүрэм. Энэ нь 1948 онд Гавана хотноо батлагдсан Олон улсын худалдааны байгууллага (ОУХБ)-ын дүрмийн эцсийн төсөл. Энэ зүйлийн өргөн цар хүрээг бүлгийн гарчгаас нь харж болно. Үүнд: хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн үйл ажиллагаа, эдийн засгийн хөгжил, сэргээн босголт, хөрөнгө оруулалт, хязгаарласан бизнесийн арга ажиллагаа, засгийн газар хоорондын түүхий эд материалын гэрээ, худалдааны бодлого. Австрали, Либери улсууд энэхүү дүрмийг баталсан анхны хоёр орон байсан боловч Австрали улс нь Англи болон АНУ-ын мөн адил дүрмийг дагаж мөрдөх тохиолдолд гэсэн нөхцөлөөр дүрмийг баталсан. Үнэн хэрэгтэй, хэлэлцээрт оролцогчдын ихэнх нь соёрхон батлах санаачилга гаргахын өмнө АНУ-ыг хүлээж байв. Гавана дүрэм нь нэлээд төвөгтэй шалтгааны улмаас хэзээ ч олон улсын худалдааны эрх зүйн нэг хэсэг болоогүй. Гавана дүрмийг заавал дагаж мөрдөх ёстой зүйл ангиудын багц байх ёстой гэж үзэж байсан боловч үүний агуулгын талаарх ээлжит хэлэлцээний дүнд түүний ихэнх зүйл заалтууд нь аажмаар хамгийн сайн хүчин чармайлт бүхий үүрэг, үүрэгчлэлүүд (best-endeavours obligations) болон өөрчлөгдөж байв. Хөгжиж буй орнууд хөрөнгө оруулалтын нээлттэй дэглэмийг эсэргүүцэв. Эцэст нь энэхүү дүрмийн зорилго нь АНУ-ын дотоод улс төртэй орооцолдож эхэлсэн бөгөөд энэ нь дотоодын тусгаар тогтнолыг сулруулах вий гэсэн болгоомжлолыг бий болгож байв. Иймээс Гүйцэтгэх удирдлагын зүгээс дүрмийг Конгрессээр хэлэлцүүлэхийг хойшлуулж, улмаар 1950 онд дүрмийг Конгрессоор хэлэлцүүлэн батлуулахгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ нь бусад улс орнуудад цаашид дүрмийг соёрхон батлуулахгүй байх дохио болжээ. Худалдаа арилжааны бодлогын талаарх бүлгийн ихэнх хэсэг нь ТХЕХ (Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр)-т тусгалаа олж хадгалагдан үлджээ. Энэ нь 1947 онд тусдаа хэлэлцэгдсэн бөгөөд 1948 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Дараа нь НҮБ-ын ХХБХ (UNCTAD)-д дүрмийн хүрээнд хамрагдсан зарим бүлгүүдээр хэлэлцээ хийх оролдлогууд хийж байсан ч хэлэлцээ хийгчдэд асуудал нарийн төвөгтэй байсаар байв. Мөн Түр мөрдөх протоколыг (Protocol of Provisional Application.) үзнэ үү.</p>
643	Hawley-Smoot tariff	Хаули Смүүт (Smoot-Hawley) тарифыг үзнэ үү
644	Hazard Analysis and Critical Control Points	<p>Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (НАССР). Энэ нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үйлдвэрлэлийг баталгаажуулах систем ба долоон үе шатаас бүрдэнэ: (1) аюулыг шинжлэх, (2) эгзэгтэй цэгийн хяналтыг тодорхойлох, (3) хяналтын цэг тус бүрд эгзэгтэй чухал хязгаар тогтоох, (4) хяналтын цэгүүдийг хянаж шинжлэх, (5) зөрчлийг арилгах тогтолцоог бий болгох, (6) үр дүнтэй бүртгэл хөтлөх, (7) систем зөв ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах журам тогтоох. НАССР нь НАСА-аас АНУ-ын сансрын хөтөлбөрт зориулж анх боловсруулсан хүнсний аюулгүй байдлын шаардлагаас үүдэлтэй байв. Энэ нь ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг удирдан хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
645	Heckscher-Ohlin theorem	<p>Хеккшер-Олиний онол. Энэ нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн (газар, хөдөлмөр, капитал) хамаарлын онол бөгөөд анх Шведийн нэрт эдийн засагчид болох Эли Филип Хекшер 1919 онд боловсруулж, Бертил Готтард Олин 1933 онд олон нийтэд танилцуулсан. Уг онолоор тухайн улс өөрийн сайн хангагдсан үйлдвэрлэлийн хүчин зүйлийг ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж, харин өөрт хомсдолтой байгаа хүчин зүйлсээр үйлдвэрлэгдэх бараа бүтээгдэхүүнийг импортлох нь зүйтэй гэж үздэг. Тэрээр тухайн улсын хувьд үйлдвэрлэлийн ямар нэгэн хүчин зүйлсээр бусад улсуудтай харьцуулахад харьцангуй сайн хангагдсан байх нь, түүний оролцоотой үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг харьцангуй хямд үнэтэй болгоно. Үндсэндээ энэхүү онол нь харьцангуй давуу онолыг дахин тайлбарласан хэрэг.</p> <p>Худалдааны шинэ онол (new trade theory), Столпер-Самуэлсон онол (Stolper-Samuelson theorem)-ыг үзнэ үү.</p>
646	Hidden dumping	<p>Нуугдмал демпинг. Энэ нь тухайн экспортын барааг зах зээлийн хуурмаг үнээр хараат компанид борлуулах үед үүсдэг демпингийн хэлбэр. Дараа нь хоёр дах компани нь импортлогч оронд бараагаа зах зээлийн үнээс доогуур зардаг. Демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures.) мөн үзнэ үү.</p>
647	High-income economies	<p>Өндөр орлоготой улс. ОУСБХБ (IBRD)-аас ангилсан бөгөөд Дэлхийн хөгжлийн тайланд тусгагдсан 52 эдийн засгийг багтаасан бүлэг улс. Эдгээр улсын эдийн засгийн нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО) нь 2000 онд 9266 ам.доллараас дээш байжээ. Үүний 23 нь ЭЗХАХБ-ын (OECD) гишүүн улсууд. Эдгээр орнуудын дундаж орлого ихээхэн өөр байдаг бөгөөд тэд бүгд өөрсдийгөө хөгжингүй эсвэл аж үйлдвэржсэн орон гэж тооцдоггүй. Мөн бага орлоготой улс (low-income economies), бага дунд орлоготой улс (lower-middle-income economies), дээд дунд орлоготой улсыг (upper-middle-income economies) үзнэ үү.</p>
648	Historical preferences	<p>Түүхэнд тэмдэглэгдсэн хөнгөлөлт. ДХБ-ын эрх зүйн бүтэц, хамрах хүрээнд энэ нь 1948 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн ТХЕХ хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийн үр ашигт хамаарах болно. Ийм зохицуулалт нь үндэсний нэн тааламжтай нөхцөлийн зарчимтай зөрчилдөж байгаа хэдий ч үргэлжлүүлэхийг зөвшөөрдөг байсан. Гэвч ТХЕХ-ийн 1-р зүйлд (Үндэсний нэн тааламжтай ерөнхий нөхцөл) заасны дагуу хөнгөлөлттэй нөхцөлийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх боломжгүй. Эзэнт гүрний давуу байдлын/хөнгөлөлтийн зохицуулалт нь түүхэн хөнгөлөлтийн нэг жишээ. Үндэсний нэн тааламжтай нөхцөл бүхий тариф буурахад түүхэн хөнгөлөлтийн хэмжээ мөн хурдацтай буурсан.</p>
649	Horizontal arrangements	<p>Хэвтээ зохицуулалт. Өрсөлдөөний бодлогыг (competition policy) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
650	Horizontal commitments	Хэвтээ үүрэг амлалт. Энэ нь ДХБ-ын гишүүн орнуудын ҮХЕХ-ийн дагуу авсан үүрэг амлалтын жагсаалтын нэг бүрэлдэхүүн хэсэг буюу бүх бүрэлдэхүүн хэсэг нь ДХБ-ын гишүүн орнууд Ерөнхийдөө эдгээр нь хөрөнгө оруулалт, корпорацийн бүтэц бий болгох, газар эзэмших, боловсон хүчний шилжилт хөдөлгөөн гэх мэттэй холбоотой байдаг. Мөн үүрэг амлалтыг (commitment) үзнэ үү.
651	Horizontal foreign direct investment	Хэвтээ хэлбэрийн гадаадын шууд хөрөнгө оруулалт. Энэ нь өөрийн улсын нутаг дэвсгэрт аль хэдийнээ явуулж байдаг үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн гадаадад шууд хөрөнгө оруулалтыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө хэлбэл, хөрөнгө оруулалтыг хэлдэг.аг дэвсгэрт эзэмших, боловсон хүчний шилжилт хөдөлгөөн гэх мэттэй холбоотой байдаг. Мөн үүрэг амлалтыг (commitments Жишээлбэл, А улсад автомашин үйлдвэрлэдэг компани В улсын автомашины үйлдвэрт хөрөнгө оруулалт хийх. Ингэхдээ хөрөнгө оруулагч үйлдвэрлэлийн хэмжээг хангалттай хэмжээнд байлгах том зах зээл дээр байрлах ба гол төлөв дотоодын зах зээлд чиглэсэн байдаг. Тухайн зах зээл рүү экспорт хийх нь өндөр зээл рүү байвал хэвтээ хөрөнгө оруулалт экспортыг орлох учир хэвтээ хөрөнгө оруулалт өсөх магадлалтай. Мөн Тарифыг огцом өсгөсөн хөрөнгө оруулалтыг (tariff-jumping investment.) үзнэ үү.
652	Horizontal keiretsu	Хэвтээ кейрецу. Мөн keiretsu харилцааг (keiretsu relationships) үзнэ үү.
653	Hormone growth promotants	Гормоны өсөлтийг дэмжигч. Энэ нь тэжээл болгон хувиргах үр ашгийг нэмэгдүүлэх замаар амьтны өсөлтийг хурдасгадаг химийн бодисууд. Тэдгээрийг зохистой хэрэглэвэл амьтанд гаж нөлөө үзүүлэхгүйгээр илүү их булчин, бага өөх тос үйлдвэрлэх боломжийг олгодог гэж үүнийг ашиглахыг дэмжлэг хүмүүс үздэг. Гормоны өсөлтийг өдөөгч эмийг хэрэглэх нь АНУ болон үхрийн мах үйлдвэрлэдэг бусад томоохон оронд хууль ёсны байдаг. 1989 онд Европын хамтын нийгэмлэг нь гормоны өсөлтийг дэмжигч бодис ашиглан үйлдвэрлэсэн үхрийн мах, үхрийн махан бүтээгдэхүүн импортлохыг хориглосон. Учир нь түүнийг хэрэглэснээр бүтээгдэхүүнд химийн бодисын үлдэгдэл аюултай түвшинд хүрсэн гэсэн үндэслэл гаргажээ. АНУ-ын үйлдвэрлэгчид өөрсдийн үхрийн махны бүтээгдэхүүнээ аюулгүй гэж мэдэгдэж байгаа бөгөөд Европын хамтын нийгэмлэгийн зүгээс үхрийн махны илүүдлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ийм шийдвэр гаргасан гэж үзжээ. Нэгнийгээ буруутгаж мөн нөгөө нь эсрэг буруутгасан асуудал эцэстээ шийдвэрлэгдэж чадаагүй бөгөөд 1996 онд АНУ маргааныг ДХБ-д гаргаж тавьсан. Австрали, Канад, Шинэ Зеланд улс АНУ-ын үйлдлийг дэмжиж ажиллав. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг 1997 оны дундуур Европын хамтын нийгэмлэгийн эсрэг шийдвэр гаргасан. Мөн Ургамал, мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг (sanitary and phytosanitary measures) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
654	Hub and spokes	<p>Зангилаа төв буюу яг тоононд зангидагдсан унинууд шиг системийн тухай ойлголт ба худалдаа, тээвэр логистикийн төрөл бүрийн шинжилгээнд ашигладаг. Өөрөөр хэлбэл, бусад онгоцны буудлуудаас ирэх, очих нислэгүүдийг зохицуулахад зориулсан төв цэг болж үйлчилж буй томоохон нисэх онгоцны буудалд нислэгийн хөдөлгөөнүүдийг чиглүүлж байхад зориулсан системтэй зүйрлэсэн ойлголт. Үүнийг чөлөөт худалдааны хэлэлцээрийн шинжилгээнд мөн ашигладаг. Тухайлбал, том улс нь хэд хэдэн чөлөөт худалдааны хэлэлцээрийн гишүүн байж болох боловч харин жижиг улсууд зөвхөн эдгээр хэлэлцээрийн аль нэгэнд хамаарч болох юм гэсэн байр суурийг зарим судлаачид илэрхийлдэг. Дараа нь том улс нь хүрдний төв зангилаа (hub) болж, бусад нь худалдааны хоёр талын зохицуулалттайгаар хэлэлцээнд түшиг уни (spoke) болж оролцох болно. Бүх талууд адил тэгш эрхтэйгээр хэлэлцээр хийдэг чөлөөт худалдааны хэлэлцээрийн тохиолдлоос ялгаатай нь hub-and-spoke тогтолцоонд том улсууд гишүүнчлэлийн нөхцөлийг ерөнхийд нь тогтоож өгдөг. Гэсэн хэдий ч зарим нь hub-and-spoke зохицуулалт нь чөлөөт худалдааны илүү томоохон бүсийг бий болгох тулгийн чулууг дэвсэж байна гэж үздэг. Бусад хэсэг нь төвийг бүрдүүлж буй улс орны хувьд худалдааны хөнгөлөлтэй нөхцөлийг бусдад олгох ямар нэгэн урамшуулал болох зүйл байхгүй гэж үздэг. Энэ маргаан шийдэгдээгүй хэвээр байна. 1995 оны Бүсчлэлийн үзэл баримтлалын талаарх ДХБ-ын судалгаа болон Дэлхийн худалдааны тогтолцооны талаарх судалгаанд тэмдэглэсэнээр, hub-and-spoke тогтолцооны хувьд мөн чанар нь үргэлж ижил байдаг гэжээ. Үүнд: бараа, үйлчилгээний (магадгүй капитал, ажиллах хүч) урсгал нь зөвхөн “spoke” тогтолцооны хоорондын урсгалаас hub-and-spoke тогтолцоо нь дотроо илүү чөлөөтэй байдаг гэж үздэг.</p>

---- О ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
655	IBRD	<p>Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (IBRD- ОУСБХБ). Бреттон Вудст 1944 онд болсон НҮБ-ын Мөнгө ба санхүүгийн бага хурлын үеэр байгуулагдсан байгууллагуудын нэг. Үүнийг Дэлхийн банк гэж нэрлэдгээр нь хүмүүс мэддэг. Энэхүү байгууллагын гол үүргүүдийн нэг нь эдийн засгийн хувьд өндөр хөгжөөгүй гишүүн орнуудын хөгжлийг дэмжих явдал. Үүнийг боломжийн нөхцөлийн дагуу хувийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй тохиолдолд төслүүдийн санхүүжилтээр дамжуулан хийдэг. Энэхүү байгууллага нь өөрийн хөрөнгийн ихэнх хувийг олон улсын бондын зах зээлээс босгож авдаг. ОУСБХБ жил бүр дэлхийн хөгжлийн тайланг гаргадаг бөгөөд үүнд ихэвчлэн худалдааны бодлогын хэрэгтэй дүн шинжилгээ багтдаг. Энэхүү байгууллагын нэг хэсэг нь Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын санхүүгийн корпорац мөн Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг зэрэг байна. Мөн Бреттон Вудсын хэлэлцээр (Bretton Woods Agreements), Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ (FI AS), Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICSID), Өндөр орлоготой улс (high-income economies), бага дунд орлоготой улс (lower-middle-income economies), дээд дунд орлоготой улсыг (upper-middle-income economies), Гадаадын шууд хөрөнгө оруулалттай харьцах тухай Дэлхийн Банкны удирдамжийг (World Bank Guidelines on the Treatment of Foreign Direct Investment) үзнэ үү.</p>
656	ICITO (Interim Commission for the International trade Organization)	<p>Олон улсын худалдааны байгууллагын түр хороо. ОУХБ (ITO)-г хүчин төгөлдөр болгох захиргааны зохицуулалтыг бэлтгэх зорилгоор 1948 онд байгуулагдсан. Үүний зэрэгцээ ОУХБТХ нь ТХЕХ-т зориулан нарийн бичгийн дарга нарын албын үйлчилгээ үзүүлэхээр тохиролцов. ОУХБ хүчин төгөлдөр болж байгуулагдаагүй тул ОУХБТХ-ийн оршин тогтнох цорын ганц зорилго нь ТХЕХ-ийн нарийн бичгийн дарга нарын албыг хэрэгжүүлэх зохицуулалт байв. ОУХБТХ нь тэрхүү хугацаанд мөн ижил үйлчилгээг ДХБ-д үзүүлдэг байв.</p>
657	ICSID (International Centre for Settlement of Investment Disputes)	<p>Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв. АНУ-ын Вашингтонд байрлах уг төв нь 1966 оны 10-р сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Улс орнууд болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцын дагуу байгуулагдсан ба маргааныг эвлэрүүлэх, арбитр хийх боломжийг олгодог. Мөн үндсэн зорилгоо хөгжиж буй орнуудад баялгийн урсгал нэмэгдэхэд хүргэх улс орнууд болон гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан итгэлцлийн уур амьсгалыг дэмжих явдал гэж тодорхойлсон. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн сэтгүүлийг нийтэлдэг ба энэ нь гадаадын хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн зохицуулалт, үүнд мөн гадаадын хөрөнгө оруулалтын олон улсын хэлэлцээр зэргийг тайлбарлах, дүн шинжилгээ хийхэд хэрэгтэй эх сурвалж болсон. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (foreign direct investment.) мөн үзнэ үү.</p>
658	IMF (International Monetary Fund)	<p>Олон улсын валютын сан. Бреттон Вудст 1944 онд болсон НҮБ-ын Мөнгө ба санхүүгийн бага хурлын үеэр байгуулагдсан байгууллагуудын нэг. Олон улсын валютын системд дараах байдлаар хяналт тавьдаг</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>(а) олон улсын валютын чиглэлээрх хамтын ажиллагааг дэмжих, (б) олон улсын тэнцвэртэй худалдааг өргөжүүлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх, (в) богино болон дунд хугацааны зээлээр дамжуулан төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад гишүүн орнуудад туслах (г) гадаад валютын тогтвортой байдлыг хангах, гишүүдийнхээ дунд валютын дэг журамтай солилцоог зохицуулах. ТХЕХ-ийн XXV дугаар зүйл нь валютын нөөц, төлбөрийн баланс эсвэл валютын зохицуулалттай холбоотой асуудлаар талууд хоорондоо зөвлөлдөх, зохицуулалт хийхээр заасан байдаг. ТХЕГ-ын гишүүд нэг бол ОУВС-д гишүүнээр элсэх эсвэл гадаад валюттай холбоотой арга хэмжээний улмаас уг хэлэлцээрийн нөхцөлүүд зөрчигдөхгүй байх нөхцөлийг хангах үүднээс ТХЕХ-ийн бусад гишүүдтэй гадаад валютын асуудлаар тусгай тохиролцоо хийх ёстой. ОУВС нь ТХЕХ-ийн XII зүйлд заасны дагуу төлбөрийн тэнцлийн асуудлаар зөвлөлдөөнд оролцдог. ДХБ-тай ОУВС харилцах харилцаа нь ТХЕХ-ийн хүрээнд үүнтэй харьцах харилцааг удирдсан заалтууд дээр суурилдаг. Бреттон Вудсын гэрээг (Bretton Woods Agreements) мөн үзнэ үү.</p>
659	Impairment	Хүчин төгөлдөр бус болох ба хохирол учруулахыг (nullification and impairment) үзнэ үү.
660	Imperial preferences arrangement	<p>Эзэнт гүрний давуу байдал/хөнгөлөлтийн зохицуулалт. Энэ нь 1917 оноос хойш Эзэнт гүрэн/эзэнт хааны бага хурлаар нухацтай хэлэлцэгдэж эхэлсэн бөгөөд 1932 оны Оттавагийн Эзэн хааны бага хурлаар албан ёсоор бий болсон хөнгөлөлтийн нөхцөл. Гэвч Британийн улс төрд эртнээс бий болсон хүчин зүйл байв. Энэхүү хэлэлцээрийн гол онцлог нь тухайн үед Британийн эзэнт гүрнийг бүрдүүлж байсан улсууд нь хоорондоо харилцан худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийг олгодог байв. Их Британи ихэнх тохиолдолд хэлэлцээрийн нэг тал болж оролцсон байдаг. Энэхүү зохицуулалт нь 1941 онд Атлантын хуулийн төслийг боловсруулж байх үед АНУ-ын худалдааны бодлогын гол зорилт болсон бөгөөд Их Британи, АНУ-ын хооронд 1942 онд байгуулсан харилцан туслах гэрээний 7-р зүйлд дахин тусгалаа олсон. Энэхүү зүйл нь “олон улсын худалдаанд ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг арилгах” зорилготой байв. ТХЕХ нь 1948 онд хүчин төгөлдөр болоход хөнгөлөлттэй нөхцөлийн бүх хязгаар/зөрүү ашгийг нэмэгдүүлэхийг хориглосон. ТХЕХ-ийн хүрээнд тарифыг бууруулах хэлэлцээ хийснээр энэхүү хөнгөлөлтийн нөхцөлийн хязгаар/зөрүү ашгийг удалгүй буурах боломжийг хангаж өгсөн. Энэхүү хөнгөлөлттэй нөхцөлийг эдлэх туршлага одоог хүртэл хэвээр байгаа бөгөөд хөнгөлөлтийг эдэлж буй талууд гол төлөв энэхүү зохицуулалтыг хамгаалдаг. Дайн хоорондын жилүүдэд хэрэглэгдэж байсан “Их Британийн хамтын нөхөрлөлийн орнууд” гэсэн нэр томьёог маш их хэрэглэх болсноос үүдэн Эзэн хааны хөнгөлөлттэй нөхцөлийн оронд Хамтын нөхөрлөлийн хөнгөлөлттэй нөхцөлийг илүү өргөн хүрээнд ашиглахад хүргэсэн. Орчин үеийн Хамтын нөхөрлөл нь уг зохицуулалтад ямар нэг үүрэг гүйцэтгээгүй байдаг. Мөн CAN AT A, түүхэнд тэмдэглэгдсэн хөнгөлөлт (historical preferences), худалдааны хөнгөлөлттэй нөхцөл бүхий зохицуулалтыг (preferential trade arrangements) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
661	Implementation doctrine	Худалдааны хэлэлцээний дагуу авсан үүрэг, амлалтаа хэрэгжүүлэх тухай номлол. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн удирдан явуулж буй үйл ажиллагаа нь хэдийгээр өөр улс оронд шийдэгдсэн байж болох ч тухайн нэг улс оронд эсвэл тухайн бүлэг улс орнуудын хувьд хариу арга хэмжээ авах үндэслэл болж болдог талаар, өрсөлдөөний тухай хуульд заасан зарчим. Мөн Монополын эсрэг(antitrust laws), өрсөлдөөний бодлого (competition policy), Нөлөөллийн тухай номлол (effects doctrine) үзнэ үү.
662	Implicit discrimination	Далдуур ялгаварлан гадуурхах. Энэ нь импортын бараа, үйлчилгээнд шууд бусаар эсвэл санамсаргүйгээр ялгавартай нөхцөл байдлыг үүсгэж болохуйц дотоодын болон импортын бараа, үйлчилгээнд хамаарах хууль тогтоомж, ногдуулах татварын болон худалдааны бусад арга хэмжээ. Импортлогч орны хувьд дотооддоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зарим тохиолдолд тэдний өрсөлдөх давуу талыг бууруулахад хүргэж болзошгүй байдаг. Засгийн газруудын хувьд ийм арга хэмжээ нь үндэсний нөхцөлөөс илүүгүй зүйл юм хэмээн харуулахад хялбархан байж болох боловч, тэдгээр арга хэмжээ нь импортын бүтээгдэхүүнийг сулруулах зорилготой боловсруулж гаргасан байж болно. Энэхүү ойлголтын талаар дарсны галлоны үнэлгээг практик жишээ болгосныг(wine gallon assessment for a practical example of this concept) үзнэ үү.
663	Import	Импорт. Энэ нь нэг улсын оршин суугчдын нөгөө нэг улсын оршин суугчдаас худалдан авсан бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ бөгөөд, хариуд нь төлбөр тооцоог гадаад валютаар авахыг хэлнэ. Мөн бартер болон Угтвар худалдаа (barter and countertrade) үзнэ үү.
664	Import cartel	Импортын картель. Картелийг (cartel) үзнэ үү.
665	Import deposit schemes	Импортын депозит/татан төвлөрүүлэх төлбөрийн хуваарь. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүн зах зээлд борлуулагдахаас өмнө, импортын захиалга хийгдэх үед засгийн газрын зүгээс удирдаж байдаг эсвэл засгийн газрын өмнөөс удирдан зохицуулж байдаг, төсөвт мөнгөн хадгаламж төвлөрүүлж буй төлбөрийн механизм юм. Энэхүү схем нь ихэвчлэн импортын лицензийн тогтолцооны нэг хэсэг нь байдаг. Энэ механизмын зорилго нь импортын захиалга бодитоор биелэгдэх эсвэл импортын барааны үнийн дүнгийн доод хэмжээг хангасан байх явдал юм. Мөн ЕЕС-ийн импортын хамгийн бага үнийг (ЕЕС minimum import prices) харна уу.
666	Import discipline hypothesis	Импортын дэг журмын тухай таамаглал. Чөлөөт худалдааны тогтолцоо нь эдийн засгийн хувьд ашигтай түрээс бий болохоос урьдчилан сэргийлэх замаар, дотоодын аж ахуйн нэгж, компаниудын үр ашиг болон хэрэглэгчдийн эрх ашигт мөн эерэг нөлөө үзүүлнэ гэсэн санаа.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
667	Import licensing	Импортын лиценз хэрэглэх (Уругвай). Бараа бүтээгдэхүүн импортлоход тусгай зөвшөөрөл авах тухай. Үүнийг ДХБ-ын Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээрт импортын нөхцөл болгон, холбогдох байгууллагад өргөдөл өгөх эсвэл шаардлагатай бусад баримт бичгийг хүргүүлэхийг шаарддаг, импортын тусгай зөвшөөрлийн дэглэмийн үйл ажиллагаанд зориулсан захиргааны арга хэмжээ гэж тодорхойлсон болно. Импортын зөвшөөрөл авах бүх хүсэлт зөвшөөрөгдсөн тохиолдолд импортын тусгай зөвшөөрөл (automatic) шууд олгогдсон гэж тооцогддог. Мөн импортын депозит/татан төвлөрүүлэх төлбөрийн хуваарийг (import deposit schemes) үзнэ үү.
668	Import market value	Импортын зах зээлийн үнэлгээ. Импортлогч орны дотоодын зах зээл дээр зарагдаж буй ижил төрлийн барааны үнэд үндэслэн гаалийн татвар ногдуулах зорилгоор импортлогдох барааг үнэлэх тогтолцоо. Энэ систем урьд нь нийтлэг байгаагүй бөгөөд ДХБ-ын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VII зүйл [гаалийн үнэлгээ] -д тусгагдсан хэлцлийн үнийн аргачлалд үндэслэн гаргасан. Гаалийн үнэлгээг (customs valuation) мөн үзнэ үү.
669	Import quotas	Импортын барааны тоо хэмжээний хязгаарлалт/квот. Импортын зарим бараа бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээнд нь хязгаарлалт хийх, эсхүл дээд хязгаарыг импортлогч орны зүгээс тавих арга хэмжээ. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдийг хямд үнэтэй импортын бараа бүтээгдэхүүний нөлөөнөөс хамгаалах зорилготой.
670	Import restrictions	Импортын хязгаарлалт. Импортын урсгалыг бууруулахад нөлөөлөх зорилгоор Засгийн газраас авч хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээ. Тухайлбал, гадаад валютын хязгаарлалт, импортын тусгай зөвшөөрөл, импортын тоо хэмжээний хязгаарлалт/квот зэрэг орно. Импортын картелууд мөн ижил үр нөлөөтэй байж болно.
671	Import risk assessment	Импортын эрсдэлийн үнэлгээ. Эрсдэлийн үнэлгээг (risk assessment) үзнэ үү.
672	Import substitution	Импортыг орлох. Бараа, үйлчилгээний дотоодын үйлдвэрлэлийн чадавхийг хөгжүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх, урсгал дансны алдагдлыг бууруулах зорилгоор импортыг багасгаж, түүнийг дотооддоо орлуулан үйлдвэрлэх бодлого. Зарим судлаачид үүнийг ийм арга хэмжээ авч хэрэгжүүлж буй орнуудын хувьд гадаад валютын нөөц нь огтхон ч нэмэгдэхгүй байгаа нь зарим талаараа импортын капитал барааг авах шаардлага байсаар байгааг илтгэнэ. Энэхүү бодлого нь импортын хязгаарлалт эсвэл дотоодын татаасыг хамарсан тохиолдолд дотоодын өртгийг нэмэгдүүлж, тухайн улсын экспортыг хязгаарладаг гэж үздэг.
673	Import surcharge	Импортын нэмэлт хураамж. Энд импортын татвар дээр нэмж хураадаг татвар хураамжууд орно. Зарим тохиолдолд улс орнууд урсгал дансны алдагдлыг багасгах зорилгоор импортын тарифыг нэмдэг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Гэхдээ худалдааны алдагдал нь ихэвчлэн эдийн засгийн бүтцийн тодорхой хэлбэрийг тусгасан худалдааны зогсолтгүй алдагдлын улмаас, эсвэл эдийн засгийн суурь хүндрэлтэй асуудлуудаас шалтгаалж байдаг тул энэхүү зохицуулалтыг ашигласнаар тийм ч их амжилтад хүрдэггүй. Импортын тарифыг нэмэгдүүлэх нь дотоодын үйлдвэрлэгчдийн өртгийг нэмэгдүүлж, тэдний олон улсын стандартын дагуу өрсөлдөх чадварыг бууруулж байдаг. Үүнийг мөрдөж буй тариф болон үүрэг хүлээсэн тарифын дээд хязгаар хоёрын хоорондын зөрүүгээс хэтрээгүй тохиолдолд ДХБ-ын дүрэм журмын дагуу хууль ёсны байна гэж үзнэ. Мөн Тээврийн нэмэгдлийг (primage) үзнэ үү.
674	Import target	Импортын зорилт. Сайн дурын импортын өргөжүүлэлтийг (voluntary import expansion) үзнэ үү.
675	Import tariffs	Импортын тариф. Энэ нь бусад улсаас импортолж буй бараа бүтээгдэхүүнд хил дээр ногдуулах тариф. Олон болон нэг шатлалтай тариф (multi-column tariff and single-column tariff) үзнэ үү.
676	Inclusion list	Хөнгөлөлт эдлэх барааны жагсаалт. АСЕАН-ийн Чөлөөт худалдааны хэлэлцээрийн (AFTA) хүрээнд Нэгдсэн гадаад хөнгөлөлттэй тарифын (CEPT) механизмын нэг хэсэг. Энэ жагсаалтад багтсан бараа АСЕАН-ны орнуудтай худалдаа хийхэд хөнгөлөлттэй тарифыг эдэлнэ. Мөн Эмзэг мэдрэг бараа бүтээгдэхүүнүүдийн жагсаалт (Sensitive List), Түр хасах жагсаалтыг (Temporary Exclusion List) үзнэ үү.
677	Indian Ocean Rim Association for Regional Cooperation	Бүс нутгийн хамтын ажиллагааны Энэтхэг далайн хүрээний ассоциаци (IOR-ARC). 1995 онд байгуулагдсан Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, тогтвортой өсөлт, тэнцвэртэй хөгжлийг дэмжих зорилготой байгууллага. Энэхүү ассоциаци нь арван найман гишүүнтэй (Австрали, Бангладеш, Энэтхэг, Индонез, Иран, Кени, Мадагаскар, Малайз, Маврики, Мозамбик, Оман, Сейшелл, Сингапур, Өмнөд Африк, Шри Ланка, Тайланд, Танзани, Арабын Нэгдсэн Эмират, Йемен). Элсэх шатандаа буй орнууд байгаа. Египт болон Япон нь яриа хэлэлцээний түншүүд.
678	Indicators of market openness	Зах зээлийн нээлттэй байдлын үзүүлэлт. Энэ нь ялангуяа нэг улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд нөгөө улсын зах зэх зээлд шинээр нэвтэрч уг зах зээлд өрсөлдөх цар хүрээг хэмжиж тодорхойлох агуулга. Шинэ зах зээлд нэвтрэх боломж, цар хүрээг тодорхойлох үндсэн гурван шалгуур үзүүлэлт байдаг. Үүнд: Эхнийх нь тарифын саад тотгор, тарифын бус саад тотгор болон тарифтай тэнцэхүйц арга хэмжээний түвшинг тогтооно. Хоёр дах нь чөлөөт худалдааны бодлогын өөрчлөлтийн үр дүнг нь худалдааны урсгал, салбар хоорондын худалдаанд гарсан хэмжээ, өсөлт зэрэг нөлөөллийг нарийвчлан судлах замаар авч үздэг. Үүнийг эдийн засгийн загварчлалын аргаар гүйцэтгэнэ. Гурав дах арга нь тухайн зах зээлд нэвтрэх саад тотгор ба өрсөлдөөний үйл явцын харилцан үйлчлэлийг авч үзнэ. Өөрөөр хэлбэл, тухайн зах зээл нь бүтэц тогтолцооны хувьд өрсөлдөөнд нээлттэй эсэхийг нь харгалзана.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Эхний хоёр аргын хувьд хамгийн оновчтой аргачлал гэдэг тал дээр нэлээд зөвшилцсөн байгаа боловч гуравдугаар ангиллын шалгуур үзүүлэлтээс арай өөр байж болно. Зах зээлийн олон улсад өрсөлдөх чадвар (international contestability of markets), худалдаа ба өрсөлдөх чадварыг (trade and competition) үзнэ үү.
679	Indirect dumping	Шууд бус демпинг. Демпинг гэдэг нь ерөнхийдөө аливаа барааг экспортлогч орны дотоодын зах зээл дээр борлуулдаг үнээс бага үнээр импортлогч/гадаад орны зах зээлд борлуулах гэсэн ойлголт. Энэхүү тодорхойлолтод зөвхөн хоёр улсыг хамруулан ойлгоно, өөрөөр хэлбэл барааг А улсаас Б руу экспортолох. Шууд бус демпингийн хувьд хохирол учруулсан зүйлийг анх А улсаас В улс руу экспортлоод (энэ үед демпинг гэж үзэхгүй) дараа нь В улсаас С улс руу дамжуулан демпинг хийхийг ойлгоно. Мөн демпинг (dumping), демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.
680	Individual action plan	Гишүүн орон тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө. Мөн АРЕС-ийн гишүүн орон тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (APEC individual action plan) үзнэ үү.
681	Industrial property	Аж үйлдвэрийн өмч. Энд шинэ бүтээл, худалдааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, газарзүйн заалт зэрэг оюуны өмчийн объект багтана. Мөн оюуны өмчийг (intellectual property) үзнэ үү.
682	Industrial research	Аж үйлдвэрийн судалгаа. Үүнийг ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт шинэ мэдлэг олж авахад чиглэсэн төлөвлөгөөт судалгаа, хянан шалгалтын үйл ажиллагаа гэж заасан байдаг. Энэхүү мэдлэг нь шинэ бүтээгдэхүүн, боловсруулах үйл явц, үйлчилгээг хөгжүүлэх, эсвэл одоо байгаа бүтээгдэхүүн, боловсруулах үйл явц, үйлчилгээг мэдэгдэхүйц сайжруулахад ашиг тустай байх ёстой. Энэхүү үйлдвэрлэлийн судалгааны ажлын өртгийн 75% хүртэлх хувийг эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаас (non-actionable subsidies) хэлбэрээр олгох дэмжлэгийг хэлэлцээрийн дагуу олгож болно. Гэхдээ энэхүү татаас нь зөвхөн хувь хүний зардал, арга хэрэгсэл, тоног төхөөрөмж, газар болон судалгаатай шууд холбоотой байшин барилга, зөвлөх үйлчилгээ, нэмэлт зардлууд, мөн судалгаа үр дүнд гарсан урсгал зардлуудаар хязгаарлагдсан байвал болно. Мөн өрсөлдөөнөөс өмнөх хөгжлийн үйл ажиллагааг (pre-competitive development activity) үзнэ үү.
683	Industry policy	Аж үйлдвэрийн бодлого. Энэ нэр томьёо нь өргөн утгаараа Засгийн газрын зүгээс дотоодын бүх үйлдвэрлэл, эсвэл аж үйлдвэрийн хөгжилд чиглүүлж баталсан бодлогыг илэрхийлдэг. Тодруулбал, тухайн салбарыг хөгжүүлэх эсвэл бүтцийн өөрчлөлт хийх зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогыг хамарсан байдаг. Энэхүү бодлогыг олон аргаар хэрэгжүүлж болох бөгөөд тэдгээрийн нэг нь хамгаалалтын арга.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Аж үйлдвэрийн салбарын идэвхттэй бодлогыг уриалах нь зарим тохиолдолд зөвхөн арилжаа худалдааг дэмжих, татаасыг чөлөөтэй олгох, Засгийн газрын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэгчдэд давуу эрх олгох, дотоодын/ орон нутгийн шинжтэй шаардлага тавих зэргээс хэтрэхгүй хэмжээнд байх нь бий. Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын мэтгэлцээн (infant- industry argument), ажиллах явцдаа суралцах (learning-by-doing argument), ялагчийг сонгох (picking winners), худалдааны стратегийн онол (strategic trade theory), бүтцийн өөрчлөлтийн зохицуулалт зэргийг (structural adjustment) үзнэ үү.</p>
684	Industry-to-industry understandings	<p>Аж үйлдвэрийн салбар хоорондын харилцан ойлголцол. Энэ нь сайн дураар хязгаарлалт тогтоох зохицуулалтад өгсөн нэр. Засгийн газрын зүгээс шаардлага тавьсан тул, аж үйлдвэрийн салбарууд хоорондоо харилцан ойлгодог байна, гэвч зарим тохиолдолд импортлогч болон экспортлогчдын аль алинд нь гэнэтийн ашиг олох боломжийг олгодог тул, зарим тохиолдолд аж үйлдвэрийн салбарууд энэ саналыг хүлээж авахдаа тун таатай байдаг байна.</p>
685	Inertial policy determinism	<p>Инерцийн бодлогын тодорхойлолт. Энэ нь ашиглагдахаа больсон бодлогыг хэсэг хугацааны дараа эргэн дагаж мөрдөх явдал. Мөн бүтээлч ухаан (inventional wisdom), QWERTY зарчим (QWERTY principle), Алсран одож байгаа бодлыг (vestigial thought) үзээрэй.</p>
686	Infant-industry argument	<p>Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарыг дэмжих тухай ойлголт. Харьцангуй давуу талтай байж болох тухайн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих зорилгоор ихэвчлэн тариф, татаас, дотоодын/орон нутгийн шинжтэй шаардлага тавих, өгөөж гэх мэт хэлбэрийн хамгаалалтын бодлого хэрэгжүүлж, өөрөө бие даан хөгжих боломжийг олгохыг хэлнэ. Үүний үр дүнд тухайн үйлдвэрлэл урт хугацаандаа давуу талаа хөгжүүлэн ямар нэгэн тусгай хамгаалалтын бодлого шаардалгүйгээр хөгжих боломжтой болно гэж үздэг. Хэрэв одоогийн хэрэгжүүлж буй хамгаалалтын арга хэмжээний өртгийг ирээдүйд нөхөн төлнө гэж үзвэл үйлдвэрлэл хөгжсөний дараа дунджаас дээгүүр өгөөж шаардлагатай болно гэж үздэг. Энэ нь өөрөө гол асуудлыг үүсгэдэг. Практик бодит амьдрал дээр цөөн тооны эрт эмзэг үе шатандаа яваа үйлдвэрүүд өөрсдийн хүчээр хөгжилд хүрдэг. Үүний оронд тэд өөрсдийгөө хамгаалах боломжийг эрэлхийлэх хандлагатай байдаг. Мөн хийх явцдаа суралцах мэтгэлцээн (learning-by-doing argument), ялагчийг сонгох (picking winners), худалдааны стратегийн онолыг (strategic trade theory) үзнэ үү.</p>
687	Infant-industry provision	<p>Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрлэлээ дэмжих заалт/ Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих заалт. ТХЕГ-ын XVIII зүйл (Эдийн засгийн хөгжилд засгийн газраас үзүүлэх дэмжлэг) нь тодорхой нөхцөлд хөгжиж буй орнуудад хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах боломжийг олгодог.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>ҮХЕХ нь энэ тухай асуудлаар зохицуулалт агуулаагүй байна. Хөгжиж буй орнууд болон ТХЕХ (developing countries and the GATT), Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын тухай мэтгэлцээн (infant-industry argument) үзнэ үү.</p>
688	<p>Information Technology Agreement</p>	<p>Мэдээллийн технологийн тухай хэлэлцээр. Энэ нь 1996 оны 12-р сард Сингапурт болсон ДХБ-ын Сайд нарын бага хурлын үр дүнд байгуулсан хэлэлцээр. Талууд мэдээллийн технологийн олон төрлийн бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн болон бусад татварыг 1997 оноос эхлэн 2000 он гэхэд ижил тэгш бууруулахыг зөвшөөрч хийсэн хэлэлцээр. Тэд мөн тарифыг тэглэх хэлэлцээг мөн хийсэн. Энэхүү хэлэлцээр нь өргөн цар хүрээтэй гишүүнчлэлтэй бөгөөд компьютер, харилцаа холбооны хэрэгсэл, хагас дамжуулагч, хагас дамжуулагч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, программ хангамж, шинжлэх ухааны арга хэрэгсэл зэрэг дэлхийн мэдээллийн технологийн худалдааны 90% гаруй хувийг хамардаг. Гэхдээ өргөн хэрэглээний цахилгаан бараа хэлэлцээрт хамаарахгүй.</p>
689	<p>Information Technology Agreement II</p>	<p>Мэдээллийн технологийн хэлэлцээр 2. Худалдааны сайдууд 1997 оны 5-р сард ДХБ-ын хэлэлцээний хүрээнд гаргасан санал. Энэхүү санал нь Мэдээллийн технологийн хэлэлцээрт тарифын бус арга хэмжээний тухай, бүтээгдэхүүний хамрах хүрээг өргөжүүлэх, технологи дамжуулах тухай зэрэг заалтууд нэмж оруулах замаар хэлэлцээрийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилготой болно.</p>
690	<p>Initial negotiating right</p>	<p>Хэлэлцээ хийх анхдагч эрх (INR). Үндсэн нийлүүлэгч биш ч гэсэн, ТХЕХ-ийн гишүүн улсын хувьд ТХЕХ-ийн яриа хэлэлцээний үе шатандаа явж байгаа нөгөө нэг гишүүн улсаас тарифын буулт хийхийг хүсэх эрх гэсэн ойлголт. Худалдааны хэлэлцээний үед чухал байгаа нэгэнт болих боловч, хэлэлцээ хийх анхдагч эрх (INR) нь тухайн нэг бараа бүтээгдэхүүний хувьд худалдааны чухал ашиг сонирхол бүхий улс орнуудын хувьд хэлэлцээ хийх чухал арга хэрэгсэл. Оролцогчид тарифыг шугаман аргачлалын дагуу тарифыг бууруулах (linear tariff cuts) хэлэлцээ хийж байгаа тохиолдолд INR-ын асуудал үүсэхгүй, учир нь бүх хэлэлцээнд оролцогчид тухайн тодорхой бүлэг барааны хувьд худалдааны аливаа нэгэн түншийн хувьд ямар ач холбогдолтой байсныг үл харгалзан тарифыг ижил хувиар бууруулахыг зөвшөөрдөг. Гэхдээ хоёр талын хэлэлцээний энэ хүрээнд арга хэрэгслийн боломж үүсэж болно. Тиймээс ТХЕХ-ийн гишүүд анхдагч гэгддэг хөрвөх чадвартай хэлэлцээ хийх анхдагч эрхийг (floating initial negotiating rights) бий болгохыг хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээр нь, өмнө нь шугаман тооцооллын аргаар хасах болж байсан, тариф ногдуулах тодорхой нэг зүйлийн талаар хэлэлцээ хийж байх үед, ханган нийлүүлэгчийн үндсэн эрхтэй гишүүдийн хувьд эдэлдэг хэлэлцээ хийх анхдагч эрх. Ийм хэлэлцээ хийх анхдагч эрхийг "хөвөгч буюу хөрвөх чанартай" гэж нэрлэх бөгөөд тодорхой бодит хэрэг гарч ирэх хүртэл энэ нь таамаглал хэвээрээ байдаг. Мөн Үндсэн ханган нийлүүлэгчийн ашиг сонирхол (principal supplying interest), үндсэн ханган нийлүүлэгчийн дүрмийг (principal supplier rule) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
691	Injury	<p>Хохирол учруулах. Энэ нь бусад орны экспортлогчдын үйлдлээс, жишээлбэл, демпинг, татаас эсхүл импортын хэт их өсөлт зэргээс үүдэн дотоодын үйлдвэрлэлд хохирол учрах буюу сөрөг нөлөө үзүүлэх явдал. Демпинг болон татаасны хувьд дотоодын үйлдвэрлэлд “материаллаг” хохирол үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авч болно. Хамгаалалтын арга хэмжээний хувьд дотоодын үйлдвэрлэлд “ноцтой” хохирол учруулсан, эсхүл учруулах аюултай байдал үүссэн бол хариу арга хэмжээ авч болно. Энэ хоёр тохиолдолд субъектив хяналт шалгалт хийх ёстой бөгөөд ноцтой хохирол нь материаллаг хохирлоос илүү хүнд гэж тооцогддог. ДХБ нь хохирол учирсан эсвэл хохирол учруулах аюултай байдал үүсэх тохиолдолд хохирлыг нягтлан шалгах, хохирлыг арилгах арга хэмжээ авах маш боловсронгуй зохицуулалттай. Нэхмэл, сүлжмэл, оёмол, хувцасны тухай хэлэлцээр нь импортын хэмжээ хэт их өссөний улмаас дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулах, эсхүл ноцтой хохирол учруулах аюултай байдал үүссэн тохиолдолд шилжилтийн хугацааны хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг гишүүдэд зөвшөөрдөг. Хэлэлцээрт “ноцтой хохирол” гэдгийг хэрхэн авч үзэхийг нарийвчлан тодорхойлоогүй боловч үүнийг тодорхойлохын тулд үйлдвэрлэлийн гарц, бүтээмж, бараа материал, зах зээлд эзлэх хувь, ажил эрхлэлт, ашиг, хөрөнгө оруулалт гэх мэт олон зүйлсийг авч үзэх шаардлагатай хэмээн жагсаасан байдаг. Мөн Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Safeguards), Демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.</p>
692	Inland parity	<p>Дотоод паритет. Мөн үндэсний нөхцөлийг (national treatment) үзнэ үү.</p>
693	Inorganic integration	<p>Органик бус нэгтгэл/интеграцчилал. Зарим судлаачид улс орнууд тарифын болон тарифын бус саадыг багасгах, худалдаатай холбогдолтой дотоодын эдийн засгийн бодлогыг уялдуулах зорилгоор улс орнуудын хооронд байгуулсан албан ёсны болон улс төрийн зорилготой худалдааны хэлэлцээрээс үүдэлтэй үйл явц гэж тайлбарладаг. Мөн эдийн засгийн нэгтгэл, интеграцийг (economic integration) үзнэ үү.</p>
694	Input dumping	<p>[Үйлдвэрлэлийн] орцын демпинг. Тухайн бараа бус харин түүнийг хийсэн орц буюу бүрэлдэхүүн хэсгүүд нь демпингтэй байна гэж гомдол гаргах. Хоёрдогч демпинг (secondary dumping) мөн үзнэ үү.</p>
695	In-quota rate	<p>Тоон хязгаарлалт доторх тарифын хувь хэмжээ. Өөрөөр хэлбэл, тухайн тоо хэмжээний хязгаар дотор импортолсон бүтээгдэхүүнд ногдуулдаг тариф.</p>
696	Integrated Framework for Trade-Related Technical Assistance to Least-Developed Countries	<p>Нэн буурай хөгжилтэй улс орнуудад зориулсан худалдаатай холбоотой техник туслалцааны нэгдсэн хөтөлбөр. Энэ нь ДХБ болон бусад олон талт түвшинд ажилладаг таван агентлагуудаас (ОУВС, ОУХТ, ДХБ, НҮБХХБХ болон НҮБХХ зэрэг) нэн буурай хөгжилтэй улс орнуудад зориулсан худалдаатай холбогдолтой үр өгөөжийг сайжруулах зорилгоор 1998 онд баталсан хөтөлбөр.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
697	Integration	Нэгтгэл/интеграцчилал. Гүн интеграци, эдийн засгийн интеграци, органик бус интеграци, зах зээлийн чиг баримжаатай интеграци, органик интеграци, бодлогын удирдлага бүхий интеграцийг үзнэ үү.
698	Intellectual property	Оюуны өмч. Энэхүү ойлголтод ерөнхийдөө патент, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, интеграл цахилгаан шугам бүхий микро схемийн зураг төсөл, зохиогчийн эрх, газарзүйн заалт, худалдааны нууц (нууц мэдээлэл) орно. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагыг (United Nations Educational, Scientific and Cultural Organisation) үзнэ үү.
699	Intellectual property protection	Оюуны өмчийн хамгаалах. Үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрээр дамжуулан оюуны өмчийг өмчлөгчийн эрхийг хамгаалах, ялангуяа зохиогчийн эрх, патент, барааны тэмдэгтэй (trademark) холбоотой эрхийг хамгаалах асуудал орно. Олон улсын тайлбарлагчид улс орны оюуны өмчийг хамгаалах тогтолцооны давуу болон сул талууд нь технологийн чиглэлийн компаниудын өөр улс руу тодорхой төрлийн технологийг дамжуулахад ихээхэн нөлөө үзүүлдэг гэж үзэж байна. Мөн оюуны өмчийн эрхийн зөрчлүүд (intellectual property right infringements), төрөл зүйлийн ховор/хосгүй/давтагдашгүй эрх (sui generis right), технологийн дамжуулалтыг (transfer of technology) үзнэ үү.
700	Intellectual property rights	Оюуны өмчийн эрх. Энэ нь оюуны өмчийг өмчлөх эрх, түүний ашиг тусыг хүртэх тухай юм. Оюуны өмчийн эрх эзэмшигч нь өөрийн эрхийг бусад хүмүүст тохиролцсон нөхөн олговортойгоор/төлбөртэйгөөр шилжүүлж болно. Тухайн оюуны өмчийн эрх авсан зохион бүтээгчид бүтээлийг ашиглах хууль ёсны онцгой эрхийг монопол хэлбэрээр нь олгодог. Энэ нь хүмүүсийг шинэлэг зүйл бүтээхэд шагнал урамшуулал болж, чиглүүлж байдаг. Иймд оюуны өмчийн эрхийн үзэл баримтлал нь тухайлбал, монопол эрх мэдлийг бууруулах замаар чөлөөт зах зээлд учруулах саад тотгорыг арилгахад чиглэсэн өрсөлдөөний бодлогын үзэл санаатай зөрчилдөж болзошгүй юм. Тиймээс оюуны өмчийн тухай хуулийн төслийг боловсруулахад тулгамдаж буй асуудал бол шинийг санаачлагч нь бүтээлч байх хангалттай хэмжээний урамшууллыг хүлээн авах, мөн оюуны өмчийн эрхийн эзэд эдгээр эрхийг урвуулан ашиглахгүй байх явдал. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), Өрсөлдөөний тухай хуулийг (competition laws) үзнэ үү.
701	Intellectual property right infringements	Оюун өмчийн эрхийн зөрчил. Олон нийтэд танигдсан үйлдвэрлэгчийн барааны тэмдгийг өөр дуурайлган хийсэн бараанд хууль бусаар хэрэглэн "хуурамч барааны тэмдэгтэй бараа" (counterfeiting) үйлдвэрлэж, барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчих, мөн оюуны өмчийн эрхээр баталгаажсан бүтээлийг хууль бусаар хувиран олшруулж

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>худалдаалах буюу “хууль бусаар дуурайлгасан бараа” (piracy) үйлдвэрлэж, эрх эзэмшигчдийн эрхийг зөрчих зэргээр хэрэглэгчдийг төөрөгдүүлэх үйлдэл. Түүнчлэн патент авахаар мэдүүлсэн шинэ бүтээлийг зөвшөөрөлгүй үйлдвэрлэх, ашиглах, борлуулах замаар зөрчил гаргасан гэх мэт.</p> <p>Хуурамчаар дуурайлган үйлдэх, хууль бусаар хуулбарлах / Counterfeiting</p>
702	Interested parties	<p>Сонирхогч тал/ашиг сонирхол бүхий талууд. Энэ нь демпингийн эсрэг арга хэмжээ авах хүсэлт гаргах, хяналт шалгалт хийхэд оролцох эрхтэй этгээдүүд. Тэд нарт эрх бүхий байгууллагаас шаардах мэдээллээр хангаж, асуудлыг хянан шийдүүлэхэд хангалттай цаг хугацаагаар хангагдах ёстой бөгөөд тэд эрх ашгаа хамгаалах боломжоор бүрэн хангагдсан байх ёстой. ДХБ-ын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VI заалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт демпингийн эсрэг арга хэмжээ авах журмыг тусгасан бөгөөд сонирхогч талууд гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна, үүнд: (a) демпингийн эсрэг мөрдөн шалгалт явуулахад хүргэсэн тухайн барааг экспортлогч, гадаадын үйлдвэрлэгч эсвэл импортлогч. Мөн тухайн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, экспортлогч, импортлогчдын дийлэнх олонх нь гишүүн нь байдаг худалдааны эсвэл бизнесийн холбоо, (b) экспортлогч гишүүн улсын Засгийн газар, (c) импортлогч гишүүн оронд ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч эсвэл импортлогч гишүүн улсын нутаг дэвсгэр дээр ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дийлэнх нь гишүүн нь байдаг худалдаа, бизнесийн холбоо юм гэжээ. Мөн ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх гэж байгаа гишүүн улс орнуудыг, тухайн бараа бүтээгдэхүүнд ихээхэн ашиг сонирхол бүхий гишүүдтэй хэлэлцээ хийх боломж олгохыг шаарддаг. Гэвч “ихээхэн ашиг сонирхол” гэсэн ойлголтыг хэрхэн тайлбарлах талаар тодорхойлоогүй болно. Мөн демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) харна уу.</p>
703	Interested third parties	<p>Ашиг сонирхол бүхий гуравдагч тал. Энэ нь ДХБ-ийн маргаан шийдвэрлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг механизмын ойлголт. Энэ нь маргаантай асуудалд шууд оролцоо байхгүй гишүүн улс орнуудын ашиг сонирхлыг харгалзан үзэх боломжийг олгосон механизм. Эдгээр гишүүд тухайн маргаантай асуудлаар санал хэлэх эрхтэй боловч ингэхийн тулд уг маргаантай барааны тухайд ихээхэн ашиг сонирхолтой гэдгээ худалдааны тоо баримтаар харуулах шаардлагатай. Маргалдаж буй асуудлыг зөвхөн сонирхох нь өөрөө хангалттай биш юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
704	Interface theory	Интерфейс онол. Энэхүү санал нь 1980-аад оны үед өргөн тархсан бөгөөд олон улсын эдийн засаг, худалдааны харилцаанд эдийн засгийн янз бүрийн тогтолцоо бүхий улс орнууд өөр хоорондоо зөрчилдөлгүйгээр худалдаа хийх боломжийг бүрдүүлэх интерфейс механизм шаардлагатай байж болох юм гэсэн санаа. Хуучин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай улс орнуудын зах зээлийн эдийн засгийн зарчимд шилжсэн нь ийм механизмын хэрэгцээг бууруулсан боловч татаас болон демпингтэй холбоотой тогтолцооны хүндрэлүүд хэвээр байна. Мөн Дорно-Өрнийн худалдааг (East- West trade) үзнэ үү.
705	Interim Agreement on Trade in Financial Services	Санхүүгийн үйлчилгээний худалдааны асуудлаарх завсрын хэлэлцээр. Санхүүгийн үйлчилгээний түр хэлэлцээрийг (financial services interim agreement) үзнэ үү.
706	Intermediate goods and services	Дунд зэргийн боловсруулалт хийгдсэн/завсрын бараа үйлчилгээ. Мөн Эцсийн гүн боловсруулалт хийгдсэн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг (final goods and services) үзнэ үү.
707	Internal market	Дотоод зах зээл. Энэхүү ойлголт нь нэг улсын харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд байгаа зах зээл болон гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс, эсвэл Европын хамтын нийгэмлэг зэрэг нэгдсэн зах зээлээс бүрэлдсэн зах зээлийн аль алинд нь хэрэглэдэг нэр томьёо.
708	Internal taxes	Дотоодын татвар. Энэ нь гаалийн нутаг дэвсгэрийн дотор бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан борлуулахад ногдуулдаг татвар. ТХЕХ-ийн III зүйлд ийм татварыг дотоодын болон импортын бараа бүтээгдэхүүнд ижил хувь хэмжээгээр ногдуулахыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, үндэсний нөхцөлийн суурь зарчим. Хилийн гадна болдог асуудлууд (behind-the-border issues) үзнэ үү.
709	Internal trade	Дотоод худалдаа. Энэ нь ихэвчлэн худалдааны хөнгөлөлттэй нөхцөл бүхий зохицуулалтаар худалдаа хийдэг улс орнууд хоорондын худалдаа. Худалдааны хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдаа хийж буй улс орнуудаас гуравдагч орнуудтай хийсэн худалдааг гадаад худалдаа (external trade) гэж нэрлэдэг. Заримдаа дотоод худалдааг (internal trade) нэг эдийн засгийн дотор хийгдэж буй арилжааны үйл ажиллагаа гэж бас тодорхойлдог ба энэ үед арилжаа гэсэн үгийг ашиглахыг илүүд үздэг байна.
710	International accounting standards	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС). Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хороо (IASB)-оос боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн стандарт. Үүнийг санхүүгийн мэдээллийн харьцуулалтыг сайжруулах, ил тод байдлыг сайжруулах, дагаж мөрдөх/нийцлийн өртгийг бууруулах, үндэстэн дамнасан компаниудын нэгдсэн санхүүгийн тайланг дэмжих зорилгоор боловсруулсан. Эдгээр стандартыг санхүүгийн эх үүсвэрийг илүү үр ашгтай хуваарилах хэрэгсэл гэж үздэг. Нягтлан бодох бүртгэлийн салбар дах харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр, зохицуулалтын удирдамж (Guidelines for Mutual Recognition Agreements or Arrangements in the Accountancy Sector), стандартууд ба чанарын баталгаажуулалтыг уялдуулахыг (harmonisation of standards and qualifications) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
711	International Agreement on Jute and Jute Products	Олс болон олсон даавуун бүтээгдэхүүний олон улсын хэлэлцээр. Энэ нь түүхий эдийн нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд 1984 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү гэрээг 1989 онд дахин хэлэлцэж 1991 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү гэрээ нь 2000 оны 4-р сарын 11-ний өдрийг хүртэл сунгагджээ. Энэхүү хэлэлцээр нь олсон ба олсон даавуун материалаар хийсэн бүтээгдэхүүний зах зээлийг сайжруулах, олон улсын худалдааны ил тод байдал, үйлдвэрлэл, боловсруулалтын техникийг сайжруулах зорилготой. Энэхүү хэлэлцээрийг Дакка хотноо байрладаг Олон улсын олсон ширхгийн байгууллага удирддаг.
712	International Bauxite Association	Баукситын олон улсын холбоо. Уг холбоо нь 1975 онд байгуулагдсан зөвхөн үйлдвэрлэгч гишүүдээс бүрдсэн. Үүний зорилго нь бауксит үйлдвэрлэлийг эмх цэгцтэй, оновчтой хөгжүүлэх, хэрэглэгч орнуудын ашиг сонирхлыг харгалзан боксит болон түүний бүтээгдэхүүнийг ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанаас гишүүн орнуудад шударга, үндэслэлтэй өгөөж өгөх явдал юм. Түүний ажлын алба нь Ямайка улсын Кингстон хотод байрладаг.
713	International Bovine Meat Agreement	Үхрийн махны асуудлаарх олон улсын хэлэлцээр. Энэ нь ДХБ-ын хязгаарлагдмал тооны гишүүдийн оролцоотой хэлэлцээрүүдийн нэг бөгөөд анх Токиогийн үе шатны хэлэлцээний нэгэн хэсэг болгож үхрийн махтай холбоотой зохицуулалтын зорилгоор хийсэн. Хэлэлцээрийн зорилтууд нь (а) үхрийн мах, малын худалдааг өргөжүүлэх, чөлөөлөх, тогтворжуулах, (в) үхрийн мах, малын худалдааны асуудлаарх олон улсын илүү сайн хамтын ажиллагааг өргөжүүлэх, (с) хөгжиж буй орнуудын хүртэх нэмэлт үр ашгийг сайжруулах, (d) үр ашигтай үйлдвэрлэгчдийн уламжлалт байр суурийг харгалзан өрсөлдөөний үндсэн дээр худалдааг цаашид өргөжүүлэх зэрэг болно. 1997 оны сүүлээр хэлэлцээрийг хүчингүй болгох хүртэл үүнийг Олон улсын махны зөвлөл удирдан зохицуулдаг байв.
714	International Bureau of Intellectual Property	Оюуны өмчийн асуудлаарх олон улсын товчоо. Энэ нь Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон түүний Холбоонуудын удирдлагын байгууллагуудыг удирдаж байдаг Нарийн бичгийн дарга нарын газар. Холбоо нь оюуны өмчийн аль нэг конвенцид нэгдэн орсон улсуудаас бүрддэг. Олон улсын товчоо нь патент, барааны тэмдэг, аж үйлдвэрийн загвар, гарал үүслийн нэршлүүд зэрэг олон улсын бүртгэлийн үйлчилгээ эрхэлдэг. Энэ нь Женев хотод байрладаг.
715	International Civil Aviation Organisation	Иргэний нисэхийн олон улсын байгууллага. Мөн Чикагогийн конвенцийг (Chicago Convention) үзнэ үү.
716	International Cocoa Agreement	Какоагийн асуудлаарх олон улсын хэлэлцээр. Анх 17 жил үргэлжилсэн хэлэлцээний дараа 1972 онд байгуулагдаж, 1975, 1980, 1986, 1993 онд дахин хэлэлцээ хийсэн. Энэхүү хэлэлцээрт эдийн засгийн заалтуудыг агуулсан, тухайлбал нөөц түүхий эд, материалын үйл ажиллагаа (гэнэтийн шокоос болгоомжлох, тэрхүү шокийг даван туулахад зориулан илүүдэл хэлбэрээр бэлнээр байлгаж байгаа хөрөнгө) болон үйлдвэрлэгч орнуудын

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>экспортын орлогыг тогтворжуулах, хөгжиж буй орнуудад какаоны цаашдын боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх зэрэг эдийн засгийн агуулгатай заалтууд орсон байсан. Энэхүү гэрээ нь 1994 оны 2-р сард хүчин төгөлдөр болсон бөгөөд 1999 оны 10-р сарын 1-ний өдөр хоёр жилийн хугацаатай сунгагджээ. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь (а) олон улсын какаоны эдийн засаг дах хамтын ажиллагааг хөгжүүлэх, бэхжүүлэх, (в) дэлхийн зах зээл дээрх какао нийлүүлэлт ба эрэлт хоёрын хоорондын тэнцвэрийг хангахад хувь нэмрээ оруулах, (с) какаогийн талаарх статистик, бусад мэдээллийг цуглуулах, түгээх замаар дэлхийн какаоны эдийн засгийн ил тод байдлыг дэмжих зэрэг болно. Какаоны хэлэлцээрт одоо нөөц түүхий эд, материалтай холбоотой заалт гэж байхгүй болсон. 2001 оны 2-р сард дахин хэлэлцэж эхэлсэн шинэ хэлэлцээр нь 1993 оны хэлэлцээрийг орлон залгуулах болсон. Энэхүү хэлэлцээр нь 2003 оны 10-р сарын 1-ээс хүчин төгөлдөр болох буюу соёрхон батлах зарим шаардлагыг хангаж дууссаны дараа хүчин төгөлдөр болно. Энэхүү хэлэлцээрийн удирдлагыг ханган ажилладаг Олон улсын Какаоны байгууллага нь Лондонд байрладаг.</p>
717	International Coffee Agreement	<p>Кофены асуудлаарх олон улсын хэлэлцээр. Энэ нь анх 1962 онд байгуулагдаж, 1968, 1976, 1983 онд дахин хэлэлцсэн бөгөөд 1994 онд таван жилийн хугацаатай дахин хэлэлцээ хийсэн. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд экспортын квот тогтоох замаар үнэ тогтворжуулах зорилго байсан боловч одоо больсон бөгөөд нөөц түүхий эд материалын үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй. Харин одоогийн хэлэлцээрийн зорилго нь: (а) кофены асуудлаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, (в) кофены талаар засгийн газар хоорондын зөвлөлдөх уулзалт, хэлэлцээ зохион байгуулах; (с) мэдээлэл цуглуулах, статистик анализ хийх, түгээх замаар кофены олон улсын худалдааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (d) кофены талаарх техникийн болон эдийн засгийн мэдээллийг цуглуулах, солилцох, (e) кофены талаарх судалгааг дэмжих, (f) кофены хэрэглээг дэмжих, нэмэгдүүлэх явдал юм. Хэлэлцээрийн удирдлагыг Лондонд байрладаг Олон улсын кофены байгууллага хариуцдаг.</p>
718	International commercial dispute resolution	<p>Олон улсын арилжааны маргааныг шийдвэрлэх. Энэ нь янз бүрийн улс орны хувийн хэвшлийн салбар дах талуудын хоорондын маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх тухай юм. Үүнийг хэлэлцээр хийх, зуучлах, эвлэрүүлэх, шинжээчдийн тодорхойлолт, шинжээчдийн үнэлгээ, арбитрын үйл ажиллагаа, эдгээр үйл явцыг хослуулах замаар хийж болно. Сонгосон арга нь талуудын үзэл бодлоос хамаарна. Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICSID)-г бас үзнэ үү.</p>
719	International commodity agreements	<p>Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын хэлэлцээр (ICAs - ТЭАОУХ). Эдгээр нь үйлдвэрлэгч ба хэрэглэгчдийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх замаар дэлхийн түүхий эдийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд юм. Эдгээр нь хоёр төрөлтэй: (а) жишээлбэл статистик тооцоо хийх замаар үйлдвэрлэл, зах зээлийн нөхцөл байдлыг ил тод болгоход чиглэсэн захиргааны шинжтэй хэлэлцээр,</p>

(b) холбогдох бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнэд шууд нөлөөлөхийг эрэлхийлэх эдийн засгийн хэлэлцээр юм. Эдийн засгийн хэлэлцээр байгуулах зорилготой Түүхий эдийн барааны нэгдсэн сан байгуулах тухай НҮБ-ын ХХБХ-ын (UNCTAD) хэлэлцээр нь ICAs -т шаардлагатай гэж үзсэн дөрвөн бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Үүнд: (a) хэлэлцээр болон гэрээ нь Засгийн газар хооронд хийгдэх ёстой, (в) хэлэлцээрээр тухайн барааны хувьд олон улсын хамтын ажиллагааг дэмжих ёстой (c) үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид хамрагдах ёстой бөгөөд (d) тухайн бараа бүтээгдэхүүний дэлхийн худалдааны дийлэнх хэсгийг хамрах ёстой зэрэг болно. Тэдний үйл ажиллагааг нь нягтлан үзэхэд, тодорхой хугацаагаар хэлэлцсэн ихэнх ICAs -ийн үйл ажиллагаа нь ихэвчлэн гурваас зургаан жилийн хугацаанд хэрэгждэг байна. Олон улсын Бокситын гэрээ болон ОПЕК (International Bauxite Agreement and OPEC) зэрэг зарим хэлэлцээр нь зөвхөн үйлдвэрлэгч талуудаас бүрддэг. Эдийн засгийн агуулгатай ICAs нь ихэвчлэн үнэ тогтворжуулах, нөөц түүхий эд, материалыг санхүүжүүлэх, арилжааны бус шинж чанартай бараа нөөцлөхийг болих, зах зээлийн хүртээмжийг сайжруулах, хэрэглээг дэмжихэд чиглэсэн үүрэг амлалт зэрэгт чиглэсэн үүргийг агуулдаг. Түүнчлэн зарим хэлэлцээр нь үйлдвэрлэгч орнуудад боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, хариуд нь үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний мэдээлэл солилцох зохицуулалтыг хийж өгсөн байна. Ихэнх нь зөвлөлдөх ба маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байдаг. 1954 оны элсэн чихэр, цагаан тугалганы хэлэлцээрт “шударга хөдөлмөрийн стандарт” гэсэн заалт орсон бөгөөд тухайн бараа үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхэлдэг хүмүүс шударга цалин хөлс авах, хангалттай хэмжээний нийгмийн баталгаа, хөдөлмөр эрхлэлтийн бусад зохистой нөхцөлүүдээр хангагдах ёстой гэдгийг зааж өгсөн байна. Эдгээр заалтыг удалгүй ашиглахаа больсон боловч хожим нь зарим хэлэлцээр жишээлбэл, Байгалийн резиний асуудлаарх олон улсын хэлэлцээр (International Natural Rubber Agreement) нь гишүүдийнхээ хөдөлмөр, амьжиргааны түвшинг дээшлүүлэх заалтаа хэвээр хадгалсан байна. Түүхий эдийн үнэ нь тогтоосон үнийн хязгаараас хэтрэх тохиолдолд түүхий эд, материалын зохицуулалтыг хийнэ. Үнийн хязгаар зөв тогтоох нь их төвөгтэй байдаг. Хэрэв үнийн доод хязгаар хэт өндөр байвал энэ нь зах зээлийн үнийг сулруулж, нөөц түүхий эдийн барааг худалдан авахад хүргэж болзошгүй үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжих болно. Үнийн доод хязгаар нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байх нөхцөлийг хангах чухал бүрэлдэхүүн хэсэг бол бүх томоохон үйлдвэрлэгч нар уг хэлэлцээрийн гишүүн байх хэрэгцээ байдаг. Үүнийг хэрэгжүүлэхэд заримдаа хэцүү байдаг. 1985 онд Олон улсын цагаан тугалганы гэрээг цуцалснаас хойш барааг нөөцлөх нь моодноос гарсан байна. Ихэнх ICAs -г хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн зорилгоор байгуулагдсан байгууллага удирддаг. Гишүүд нь үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид гэж хуваагдан бүрддэг бөгөөд энэ хоёр ангиллын бүлгийн нийт санал өгөх эрхийн тоо нь тэнцүү байна. Үйлдвэрлэгч орнууд ихэвчлэн ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортолдог бөгөөд хэрэглэгч орнууд мөн экспортолдог байна.

Тиймээс үйлдвэрлэгч ба хэрэглэгчийн тодорхойлолт нь тухайн улс цэвэр экспортлогч эсвэл импортлогч эсэхээс хамаарна. Санал хураалт нь тухайн гишүүн тухайн бараа бүтээгдэхүүний олон улсын худалдаанд эзлэх хувь хэмжээн дээр суурилдаг. ICA нь ихэвчлэн бие даасан байдлаар ажилладаг боловч 1964 онд НҮБ-ын системийн хүрээнд бараа бүтээгдэхүүний асуудлыг хариуцан ажиллах болсон НҮБ-ын ХХБХ (UNCTAD)-ын ивээл дор хэлэлцээ хийх эсвэл дахин хэлэлцээг зохион байгуулдаг болсон. ТХЕХ-ийн хүрээнд хоёр хэлэлцээрийн хүрээнд хэлэлцээ хийгдсэн бөгөөд тэдгээр нь 1997 оны эцэс хүртэл ДХБ-ын хязгаарлагдмал оролцогчидтой хэлэлцээрийн нэг хэсэг байв. Энэхүү хоёр хэлэлцээр нь Олон улсын сүү, сүүн бүтээгдэхүүний хэлэлцээр, Олон улсын үхрийн махны хэлэлцээр юм. Хоёулаа тэдний хяналтад доор байгаа түүхий эд, материалын худалдааг өргөжүүлэх, чөлөөлөх, тогтворжуулах зорилготой байсан. Мөн түүхий эд, материалын бодлого (commodity policy), Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөр (Integrated Programme for Commodities), Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын байгууллагыг (International commodity bodies) үзнэ үү.

720

International commodity bodies

Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын байгууллага (ICBs). Эдгээр нь олон улсын түүхий эдийн хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулдаг мөн барааны судалгаа хийдэг бүлэг байгууллагууд юм. НҮБ-ын ХХБХ-ын (UNCTAD) дэргэд байгуулагдсан Түүхий эдийн нийтлэг сан нь 30 гаруй түүхий эд барааны асуудлыг төлөөлсөн 24 байгууллагыг томилжээ. Эдгээрийг гурван үндсэн бүлэгт ангилна. Эхний бүлэгт Какаотой холбоотой асуудлаарх олон улсын байгууллага, Хөвөнгийн асуудлаарх олон улсын зөвлөх хороо, Олсон ширхэгтийн асуудлаарх олон улсын байгууллага, Олон улсын хар тугалга, цайр судлалын бүлэг, Олон улсын зэс судлалын бүлэг, Олон улсын чидун жимсний тосны зөвлөл, Олон улсын байгалийн резиний байгууллага, Олон улсын никель судлалын бүлэг, Олон улсын резин судлалын бүлэг, Олон улсын элсэн чихрийн байгууллага, Олон улсын халуун орны модны байгууллага, Олон улсын кофены байгууллага, Олон улсын үр тарианы зөвлөл зэрэг багтана. Хоёрдох бүлэгт Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын харьяанд байх байгууллагууд багтана: Банана жимсний Засгийн газар хоорондын бүлэг, Цитрус жимсний Засгийн газар хоорондын бүлэг, Үр тарианы тухай Засгийн газар хоорондын бүлэг, Хатуу шилэн материалын Засгийн газар хоорондын бүлэг, Махны тухай Засгийн газар хоорондын бүлэг, Тос, тосны ургамал, өөх тосны тухай Засгийн газар хоорондын бүлэг, Цагаан будааны тухай засгийн газар хоорондын бүлэг, Цайны асуудлаарх Засгийн газар хоорондын бүлэг, Загасны худалдааны асуудлаарх Засгийн газар хоорондын дэд хороо, Арьс, ширний талаарх Засгийн газар хоорондын дэд бүлэг. Гурав дах бүлэг бол Тангстены талаарх НҮБ-ын ХХБХ-ын хороо бөгөөд эдгээр нь Нийтлэг сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийг ивээн тэтгэнэ. Эдгээр байгууллагуудын удирддаг зарим хэлэлцээрийн талаар (separate entries for some of the agreements administered by these bodies) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
721	International commodity-related environment agreement	Түүхий эдтэй холбогдолтой байгаль орчны тухай олон улсын хэлэлцээр (ICREA). Түүхий эдийн үйлдвэрлэлд байгаль орчны зорилтыг хөхиүлэн дэмжиж, энэ чиглэлээр үйлдвэрлэгчид ба хэрэглэгчдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын ХХБХ-ын санал болгосон Засгийн газар хоорондын сайн дурын нэг арга хэрэгсэл юм. ICREAs нь стандартыг тогтоох асуудалд анхаарлаа хандуулах эсвэл илүү тогтвортой үйлдвэрлэлийн арга барил руу шилжүүлж хөгжүүлэх явдлыг санхүүжүүлэх зорилтыг дэвшүүлдэг. Мөн түүхий эд, материалын бодлого (commodity policy), худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
722	International contestability of markets	Зах зээлийн олон улсад өрсөлдөх чадвар. Энэ нь хууль тогтоомж, засгийн газраас явуулж буй эрх зүйн зохицуулалтууд эсвэл бусад улсуудын экспортлогчдын байр сууринаас бол хувийн хэвшлийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэргээр дамжуулан, гажуудлаас чөлөөтэй байх зах зээлийг үнэлж дүгнэхэд зориулсан гол малгай нэр томьёо. Бүрэн хэмжээнд өрсөлдөхүйц зах зээл гэдэг нь тухайн зах зээлд хүссэн бараа, үйлчилгээг үнэ болон нийлүүлэх чадварын үндсэн дээр аж ахуйн нэгжүүд цэвэр өрсөлдөх боломжтой зах зээл юм. Иймд олон улсад өрсөлдөх чадварыг тариф ба тарифын бус арга хэмжээ, үйлчилгээний импортод нөлөөлөх эрх зүйн зохицуулалтын нөхцөл байдал, хуваарилалтын систем гэх мэт хөрөнгө оруулалт ба өрсөлдөөний дотоод зохицуулалтын хэлбэрээр бүтцийн саад тогтор учруулах, өрсөлдөөний эсрэг хувийн хэвшлээс хэрэгжүүлж буй арга туршлага зэрэг хүчин зүйлүүдээр тодорхойлдог байна. Зах зээлийн нээлттэй байдлын үзүүлэлтүүд (indicators of market openness), худалдаа ба өрсөлдөөнийг (trade and competition) мөн үзнэ үү.
723	International Convention for the Protection of New Varieties of Plants	Ургамлын шинэ сортуудыг хамгаалах тухай олон улсын конвенц. Энэхүү конвенц нь 1961 онд Парист батлагдаж, 1978 онд Женевт шинэчлэгдсэн. Энэхүү конвенц нь шинэ ургамлын сорт үржүүлэгчдэд патент эсвэл тусгай хамгаалалтын эрх олгоно. Үүнийг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДООБ) бус харин Шинэ ургамлын олон төрлийг хамгаалах олон улсын холбоо (UPOV) удирддаг. Мөн оюуны өмчийн эрхийг (intellectual property rights) үзнэ үү.
724	International Convention for the Protection of Performers, Producers of Phonograms and Broadcasting Organisations	Жүжигчин, фонограм үйлдвэрлэгч, өргөн нэвтрүүлгийн байгууллагыг хамгаалах олон улсын конвенц. Мөн Ромын конвенцыг (Rome Convention) үзнэ үү.
725	International Convention on the Harmonised Commodity Description and Coding System	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн олон улсын конвенц. Мөн Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийг (Harmonised Commodity Description and Coding System) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
726	International Convention on the Simplification and Harmonisation of Customs Procedures	Гаалийн журмыг хялбаршуулах, уялдуулах тухай олон улсын конвенц. Мөн Киотогийн конвенцийг (Kyoto Convention) үзнэ үү.
727	International Copper Study Group	Зэс судлалын олон улсын судалгааны бүлэг (ICSG). Энэ нь 1992 онд UNCTAD-ийн ивээл дор байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага бөгөөд дэлхийн худалдааны 80% гаруй хувийг төлөөлдөг үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид багтдаг. ICSG-ийн үндсэн үүрэг нь олон улсын зах зээл дэх зэсийн эдийн засгийн асуудлаар мэдээлэл солилцох, сайжруулсан статистик мэдээллийг цуглуулах, түгээх, үүсэж болзошгүй аливаа асуудлыг авч хэлэлцэх явдал юм. Энэхүү байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар нь Лиссабонд байрладаг. Мөн CIPEC (CIPEC), Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын байгууллагыг (international commodity bodies) үзнэ үү.
728	International Cotton Advisory Committee	Хөвөн даавууны асуудлаарх олон улсын зөвлөх хороо (ICAC). 1939 онд хөвөн үйлдвэрлэгчдийг төлөөлсөн холбоо болон байгуулагдаж, 1945 онд хэрэглэгчдийг мөн төлөөлөх холбоо болж өөрчлөн байгуулагджээ. Энэ нь хөвөн үйлдвэрлэл, худалдааны талаарх статистик мэдээллийг цуглуулж, түгээж, дэлхийн хөвөнгийн эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээг дэмжих зорилготой. Холбооны Нарийн бичгийн дарга нарын газар нь Вашингтонд байдаг. Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын байгууллагыг (international commodity bodies) мөн үзнэ үү.
729	International Court of Justice	Олон улсын шүүх. Олон улсын шүүхийн байгууллага нь НҮБ-ын шүүхийн үндсэн байгууллага. Энэхүү байгууллага үндсэн хоёр чиг үүрэгтэй. Үүнд, улс хоорондын эрх зүйн маргааныг шийдвэрлэх, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болох олон улсын эрх бүхий байгууллага, агентлагуудаас ирүүлсэн эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх явдал юм. Шүүх ажиллагаанд ашиглаж буй хууль тогтоомжийн эх сурвалжуудад олон улсын гэрээ, конвенц, олон улсын гааль, эрх зүйн ерөнхий зарчим, шүүхийн шийдвэр, эрдэм шинжилгээний бүтээлүүд орно. Уг шүүх нь 1946 онд Олон улсын шүүн таслах ажиллагааны байнгын танхимын (Permanent Court of International Justice) залгамжлагч байгууллага болон өөрчлөн байгуулагдсан. Энэхүү байгууллага нь Гаагад байрладаг.
730	International Dairy Agreement	Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр. Энэ нь ДХБ-ын Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр анх удаа Олон улсын сүүн бүтээгдэхүүний хэлэлцээр нэртэй, ДХБ-ын Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрийг байгуулав. Хэлэлцээрийн зорилго нь (а) экспортлогч болон импортлогч орнуудын харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр зах зээлийн зарчмын хүрээнд сүүн бүтээгдэхүүний дэлхийн худалдааг аль болох тогтвортойгоор өргөжүүлэх, улам бүр чөлөөтэй болгох, (б) хөгжиж буй орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах явдал байв. Хэлэлцээрийн хүрээнд шинэ болон хадгалсан сүү, цөцгийн тос, масло, бяслаг, ааруул, казеин зэрэг сүүн бүтээгдэхүүний худалдааг тусгасан болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		1997 оны сүүлээр хэлэлцээрийн хэрэгжилтийг зогсоох хүртэл Олон улсын сүүний зөвлөл хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах удирдлагыг хэрэгжүүлдэг байсан.
731	International Dairy Arrangement	Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын тохиролцоо. Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээрийг (International Dairy Agreement) үзнэ үү.
732	International Dairy Council	Сүүн бүтээгдэхүүний асуудлаарх олон улсын зөвлөл. Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээрийг (International Dairy Agreement) үзнэ үү.
733	International division of labour	Хөдөлмөрийн олон улсын хуваарилалт. Энэ нь илүү их мэргэшсэн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн цар хүрээ, стандартын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцыг зохион байгуулах ойлголт. Зорилго нь компаниудад үнийн механизмаар өрсөлдөх боломжийг олгох явдал юм. Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн гол санаа нь анхнаасаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамгийн хямд өртгөөр, мэргэшсэн бус эсвэл хагас мэргэшсэн ур чадвар бүхий ажиллах хүчийг ашиглан үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хуваасан загварчлал дээр суурилсан байсан боловч одоо бол олон улсын түвшинд үйлдвэрлэгдэн худалдаалагдаж буй олон бараа бүтээгдэхүүний нарийн төвөгтэй байдлаас шалтгаалж энэхүү суурь санааны үндэслэлийг ихээхэн алдагдсан байна. Мөн нутагшуулахгүй байх (delocalisation), Фордын онол (Fordism), даяаршил (globalisation), хөдөлмөрийн олон улсын хуваарилалт (international division of labour), Бүтээгдэхүүний мөчлөгийн онолыг (product cycle theory) үзнэ үү.
734	International economic relations	Эдийн засгийн олон улсын харилцаа. Энэ нь гадаад худалдаанаас гадна хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг олон улсын мөнгө, санхүүгийн хамтын ажиллагаа, үйл ажиллагаанаас шууд хамаарна. Илүү шууд бус байдлаар бол, бараг бүх олон улсын үйл ажиллагаа нь эдийн засгийн үр нөлөө үзүүлэх боломжтой байдаг
735	International Electrotechnical Commission	Цахилгаан техникийн олон улсын комисс (IEC). Цахилгаан, электроник болон холбогдох технологийн салбарт стандарт, тохирлын үнэлгээний чиглэлийн олон улсын хамтын ажиллагааны гол байгууллага юм. Зөвшилцөлд суурилсан, сайн дурын үндсэн дээрх олон улсын стандартыг боловсруулан бэлтгэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг. IEC нь Худалдаан дах техникийн саад тотгорыг зохицуулах хэлэлцээрээр дамжуулан ДХБ-тай уялдаа холбоотой байдаг. Түүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Женев хотод байрладаг. Түүнчлэн Олон улсын стандартчиллын байгууллагыг (International Organisation for Standardisation) үзнэ үү.
736	International Energy Agency	Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA). Энэ нь Газрын тосны анхны шокийн дараа буюу 1974 онд байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага. Энэ нь OECD гишүүн орнуудаас бүрддэг. Үүний гол асуудал бол эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, эрчим хүч хэмнэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох явдал юм. IEA-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Парис хотод байрладаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
737	International Finance Corporation	Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК). Энэ нь хөгжиж буй орнуудад хувийн хэвшлийн салбарын аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох үүрэг бүхий ОУСБХБ (IBRD) (Дэлхийн банк)-ны нэг хэсэг бөгөөд ийм арга замаар тэдгээрийн эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой юм. ОУСК нь өөрийн үйл ажиллагааг Дэлхийн банктай нягт уялдуулж зохицуулдаг боловч үндсэндээ бие даасан агентлаг байдлаар ажилладаг. Олон улсын хөгжлийн нийгэмлэг (International Development Association), Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг (Multilateral Investment Guarantee Agency) үзнэ үү.
738	International financial institutions	Олон улсын санхүүгийн байгууллагууд. Энэ нь ОУВС, ОУСБХБ, Азийн хөгжлийн банк зэрэг Засгийн газар хоорондын байгууллагуудад хэрэглэгддэг нэр томьёо. Эдгээр байгууллагууд нь гишүүн орнуудын эдийн засгийн оновчтой менежментийг дэмжих эсвэл гишүүн орнууддаа тодорхой зорилго бүхий арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд голлон анхаардаг. Хөгжиж буй орнууд эдийн засгийнхаа хөгжилд санхүүгийн туслалцаа авахдаа ихэвчлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авах боломжтой байдаг. Тухайлбал, зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, зах зээл дэх зээлийн хүүгийн хэмжээнээс доогуур хүүтэй зээл авах гэх мэт. Мөн бүтцийн өөрчлөлтийн зохицуулалтыг (structural adjustment) үзнэ үү.
739	International Fund for Agricultural Development	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (IFAD). Энэ нь НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага бөгөөд мэргэшсэн байгууллагуудын нэг. Энэхүү байгууллага нь 1977 онд хөгжиж буй орнуудын хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хөдөө аж ахуйн бүтээн байгуулалтыг хөгжүүлэх төслийг санхүүжүүлэх үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Зээлийнхээ ихэнх хэсгийг бага орлоготой орнуудад, ихэвчлэн маш хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (Food and Agricultural Organisation), Дэлхийн хүнсний хөтөлбөрийг (World Food Programme) үзнэ үү.
740	International Grains Agreement	Үр тарианы олон улсын хэлэлцээр (IGA). Энэ нь олон улсын улаан буудайн асуудлаарх хэлэлцээрийн залгамжлагч нь юм. Энэхүү хэлэлцээр нь 1995 оны 7-р сарын 1-ээс эхлэн гурван жилийн хугацаатай байгуулагдсан бөгөөд хоёр жил тутамд шинэчлэгдэх нөхцөлтэй. IGA нь Үр тарианы худалдааны конвенци, Хүнсний тусламжийн конвенци гэсэн хоёр эрх зүйн актаас бүрдэнэ. Эхний хэлэлцээрийн зорилго нь зах зээлийн ил тод байдлыг хангах замаар улаан буудай, бүхэл ширхэгтэй үр тарианы худалдаанд олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилготой юм. Дараагийн хэлэлцээр нь ихэнх тусламжийг Дэлхийн хүнсний хөтөлбөрөөр дамжуулан хөгжиж буй орнуудад жил бүр тогтоосон хамгийн бага хэмжээний хүнсний тусламжийг хүний хэрэглээнд тохирсон үр тариа хэлбэрээр олгодог. IGA-г Лондон хотод байрладаг Олон улсын үр тарианы зөвлөл удирддаг. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (Food and Agricultural Organisation) болон хүнсний аюулгүй байдлыг (food security) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
741	International Labour Organisation	Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO-ОУХБ). Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 1919 онд Версалын гэрээний нэг хэсэг болон байгуулагдсан. Энэхүү байгууллага нь 1946 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллага болсон. Гол зорилго нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоосон, ажиллах цагийг тогтоосон, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг тодорхойлсон, нийгмийн даатгалын асуудал зэргийг тогтоож өгсөн олон улсын конвенц, зөвлөмжийг батлах замаар ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилготой юм. Энэ нь Женевт байрладаг. Мөн хүүхдийн хөдөлмөр (child labour), Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ (стандартууд) (core labour standards), худалдаа ба хөдөлмөрийн стандартыг (trade and labour standards) үзнэ үү.
742	International Lead and Zinc Study Group	Хар тугалга, цайр судлалын олон улсын бүлэг (ILZSG). Энэ нь 1960 онд Хар тугалга, цайр судлалын хороог залгамжлан байгуулагдсан. Энэ бол хар тугалга, цайрыг үйлдвэрлэх, худалдаалахтай холбоотой асуудлаар үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн дунд зөвлөлдөх уулзалт, статистик мэдээллийг нэгтгэх форум юм. ILZSG нь Лондон хотод байрладаг боловч уулзалтууд нь НҮБ-ын ХХБХ-ын (UNCTAD) ивээл дор явагддаг. Мөн Түүхий эд, материалын асуудлаарх олон улсын байгууллагыг (international commodity bodies) үзнэ үү.
743	International Maritime Organisation	Олон улсын далайн байгууллага (IMO). Олон улсын далайн байгууллага нь НҮБ-ын төрөлжсөн/мэргэшсэн байгууллагуудын нэг. Энэхүү байгууллага нь анх 1959 онд Засгийн газар хоорондын далайн зөвлөлдөх байгууллага нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1982 онд өнөөгийн нэрээр нэрлэгдэх болсон. ОУДБ нь олон улсын далайн тээвэр хөдөлгөөнийг хөнгөвчлөх, далайн аюулгүй байдлын стандарт, хүлээх үүрэг хариуцлага, усан онгоцны бохирдлоос хамгаалах нөхөн төлбөрийн асуудал болон авах арга хэмжээ зэрэг асуудлаар Засгийн газар хоорондын хамтын ажиллагаанд зориулсан уулзалт зохион байгуулдаг. Энэхүү байгууллага нь Лондон хотод байрладаг. Мөн далайн тээврийн үйлчилгээг (maritime transport services) үзнэ үү.
744	International Meat Council	Махны олон улсын зөвлөл. ДХБ-ын Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрийн нэг болох Олон улсын үхрийн махны хэлэлцээрийг 1997 оны эцсээр цуцлах хүртэлх хугацаанд хэлэлцээртэй холбоотой асуудлыг Олон улсын үхрийн махны зөвлөл удирдан зохион байгуулдаг байсан.
745	Internationally recognised labour standards	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн стандарт. Мөн Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээг (стандартууд) (core labour standards) үзнэ үү.
746	International Natural Rubber Agreement	Байгалийн резиний асуудлаарх олон улсын хэлэлцээр. Олон улсын байгалийн резиний асуудлаарх хэлэлцээр нь анх 1979 онд байгуулагдаж 1987 онд шинэчлэгдэж 1999 онд дуусгавар болсон. Үүнийг Куала Лумпурт байрладаг Олон улсын байгалийн резиний асуудлаарх байгууллага удирддаг байсан. Мөн Резин судлалын олон улсын бүлгийг (International Rubber Study Group) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
747	International Nickel Study Group	Никель судлалын олон улсын бүлэг (INSG). Олон улсын никель судалгааны бүлэг нь 1986 онд НҮБ-ын ХХБХ-ын (UNCTAD) ивээл дор байгуулагдсан бөгөөд 1990 оны 5-р сарын 23-нд хүчин төгөлдөр болсон. Энэ нь никелийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, ялангуяа никелийн зах зээлийн статистик, бусад мэдээллийг сайжруулах замаар нийтлэг ашиг сонирхолд нийцсэн болон санаа зовоосон асуудлыг хэлэлцэх форумыг зохион байгуулдаг. Дэлхийн никелийн үйлдвэрлэлийн 80% орчим хувийг INSG-ийн гишүүд эзэлдэг. Түүний ажлын алба Гаагад байрладаг.
748	International Office of Epizootics	Эпизоотик буюу амин тахлын олон улсын алба. Энэ нь 1924 онд байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага юм. Энэхүү байгууллагын гол зорилго нь (а) дэлхий даяар мал, амьтдын өвчний гаралт, явц, тэдгээр өвчнийг хянах арга замын талаар засгийн газруудад мэдээлэх, (б) мал, амьтдын өвчний тандалт судалгаа, хяналтад чиглэсэн судалгааны ажлыг уялдуулан зохион байгуулах, (в) гишүүн орнуудын дунд мал, амьтан болон мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдаа хийх эрх зүйн зохицуулалтуудыг уялдуулан нийцүүлэх явдал юм. Энэ нь Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээний асуудлаарх хэлэлцээрийг удирдан хэрэгжүүлэхэд ДХБ-ын гишүүдтэй нягт хамтран ажилладаг.
749	International Olive Oil Agreement	Чидун жимсний тосны олон улсын хэлэлцээр. Чидун жимс буюу оливын тосны олон улсын хэлэлцээр нь анх 1956 онд байгуулагдаж, 1963, 1979, 1986 онд дахин хэлэлцэгдэж 1994 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн таван жилийн хугацаатай шинэчлэгдэв. Энэхүү хэлэлцээрийн үйл ажиллагаа нь урт хугацааны зах зээлийг хөгжүүлэх, судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих, хэрэглээг өргөжүүлэх, шударга бус өрсөлдөөний үйл ажиллагааг зогсоох, хангамжийн найдвартай байдлыг хангах зорилготой. Үүнд нөөц түүхий эд, материалын механизм байхгүй болно. Гишүүнчлэл нь ихэнхдээ Европын хамтын нийгэмлэг ба гол төлөв Газар дундын тэнгисийн арав орчим орноос бүрддэг. Энэхүү хэлэлцээрийг Мадрид хотод байрладаг Олон улсын чидун жимсний тосны зөвлөл удирдан зохион байгуулдаг.
750	International Organisation for Standardisation	Олон улсын стандартчиллын байгууллага (ISO). Энэхүү Олон улсын стандартчиллын байгууллага нь олон улсын бараа, үйлчилгээний худалдааг хөнгөвчлөх зорилгоор стандартчилал болон үүнтэй холбогдох үйл ажиллагааг хөгжүүлэхээр, 1947 онд байгуулагдсан үндэсний стандартын байгууллагуудын дэлхийн хэмжээний нэгдсэн дээвэр холбоо юм. Улс болгоныг зөвхөн нэг байгууллага төлөөлдөг. ОУСБ нь оюуны, шинжлэх ухаан, технологи, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэ нь ДХБ-тай, ялангуяа стандартыг худалдаанд учруулах өнгөлөн далдалсан саад тотгор болгож ашиглахгүй байх нөхцөлийг хангах зорилготой Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээртэй холбоотой юм. Мөн Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission), ISO 9000, ISO 14000 зэргийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
751	International Plant Protection Convention	Ургамал хамгааллын олон улсын конвенц. Ургамал хамгааллын олон улсын конвенц нь 1952 оны 4-р сарын 3-нд хүчин төгөлдөр болсон. Конвенцийг Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага удирдаж байдаг. Конвенцийн зорилго нь ургамал, ургамлын гаралтай хортон шавжийн тархалт, халдвараас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хяналтыг сайжруулах арга хэмжээг дэмжих олон улсын нийтлэг, үр дүнтэй арга хэмжээ авах явдал юм. ДХБ-ын Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээний тухай хэлэлцээрийн стандарт шаардлагыг хангах зорилгоор 1997 онд Конвенцид хэсэгчлэн нэмэлт өөрчлөлт оруулсан.
752	International political economy	Олон улсын улс төрийн эдийн засаг. Олон улсын улс төрийн эдийн засаг нь орчин үеийн олон улсын нийгэм дэх улс төр ба эдийн засгийн салбар хоорондын харилцаатай холбоотой асуудлын талаарх эрдэм шинжилгээний нэг салбар гэж тодорхойлсон болно. Худалдааны бодлого бол энэ харилцааны нэг тал юм.
753	International Program for the Elimination of Child Labour	Хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоох олон улсын хөтөлбөр (IPEC). Хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоох хөтөлбөрийг 1992 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гишүүн орнуудад хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсооход нь туслах зорилгоор санаачилсан. IPEC-ийн хүрээний үйл ажиллагаанд үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, засгийн газар, төрийн бус байгууллагууд, ажилчид, ажил олгогчдод үзүүлэх сурталчилгааны төсөл, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх хөтөлбөрүүд орно. Одоо хорин хэдэн улс IPEC-т оролцож байна. Хүүхдийн хөдөлмөр (child labour), Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ (стандартууд) (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), худалдаа ба хөдөлмөрийн стандартыг (trade and labour standards) мөн үзнэ үү.
754	International Rubber Study Group	Резин судлалын олон улсын бүлэг (IRSG). Олон улсын резин судлалын групп нь 1944 онд үйлдвэрлэгч, хэрэглэгч орнуудаас бүрдэн байгуулагдсан байгууллага. Энэхүү байгууллагын зорилго нь байгалийн болон синтетик резиний үйлдвэрлэл, хэрэглээ, худалдаатай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах явдал юм. Түүнчлэн өргөн хүрээний статистик мэдээллийг нийтэлдэг. Түүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Лондон хотод байрладаг.
755	International Sugar Agreement	Элсэн чихрийн асуудлаарх олон улсын хэлэлцээр. 1860-аад оны анхны элсэн чихрийн асуудлаарх хэлэлцээр юм. 1931 онд үйлдвэрлэгчдийн холбоодын хооронд шинэ хэлэлцээр байгуулж, түүний заалтуудыг дараа нь тэдний Засгийн газрууд баталсан. Үүний зэрэгцээ Гаагад Байнгын нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь нь илүүдэл барааг экспортын квот тогтоох замаар бууруулах зорилготой байсан боловч гишүүн бус үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн тул хэлэлцээр нь амжилтгүй болсон. Хоёрдох хэлэлцээрийг 1937 онд байгуулсан бөгөөд энэ нь хэрэглэгчид, үйлдвэрлэгчдийн төлөөллийг багтаасан.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Дайны дараа анхны Элсэн чихрийн асуудлаарх хэлэлцээрийг 1954 онд байгуулсан бөгөөд 1958, 1968, 1973, 1977, 1984 онд дахин хэлэлцэн зөвшилцсөн. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд 1977 он хүртэл нөөц түүхий эд, материалын арга хэмжээг хэрэгжүүлсэн. 1980-аад оны эхээр элсэн чихрийн үнэ огцом унав. Учир нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг нь импортлогч улсаас цэвэр экспортлогч улс болсон тул экспортод хэрэглэх заалтуудыг хүлээн зөвшөөрөөгүй байна. 1984 оны хэлэлцээр нь эдийн засгийн заалт агуулаагүй боловч энэ төрлийн шинэ гэрээ хэлэлцээр хийх зорилтыг өөртөө тавьсан. Энэхүү хэлэлцээрийг залгамжлах захиргааны хэлэлцээр нь 1993 онд таван жилийн хугацаатай байгуулагдсан бөгөөд дахин сунгах боломжийг хязгаарлаагүй. Захиргааны байгууллага болох Олон улсын элсэн чихрийн байгууллага нь одоо Лондон хотод байрладаг.</p>
756	<p>International Tea Agreement</p>	<p>Цайны олон улсын хэлэлцээр. Энэ нь анх 1933 онд зөвхөн үйлдвэрлэгчдийн гишүүнчлэлтэй хүчин төгөлдөр болсон. Энэ хэлэлцээрт Энэтхэг, Цейлон, Жава бүгд гишүүн орнууд байсан тул урт хугацаандаа буурч байсан үнийг амжилттай тогтворжуулж чадсан гэдгээрээ итгэл хүлээсэн байдаг. Эдгээр гурван гишүүн улс нь тухайн үед дэлхийн цай үйлдвэрлэлийн 96% хувийг дангаар эзэлж байсан. Цай бол Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөрт багтсан түүхий эдийн нэг боловч, цайны шинэ гэрээ хэлэлцээр хийх хүчин чармайлт үр дүнд хүрээгүй. Хэлэлцээ үр дүнд хүрээгүйн гол шалтгаануудын нэг нь яриа хэлэлцээ хийж буй орнууд Зүүн Африкийн шинээр гарч ирж буй үйлдвэрлэгчдийн саналын шаардлагад нийцэхүйц томьёоллыг олж чадаагүй явдал юм. Хэрэв экспортод эзлэх түүхэн хувь хэмжээг экспортын квот хуваарилахад ашигласан тохиолдолд, тэд өөрсдийнх хувьд таатай нөхцөл бүрдэхгүй юм байна гэж үзжээ.</p>
757	<p>International Telecommunication Union</p>	<p>Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU-ОУХХХ). Энэхүү холбоо 1865 онд байгуулагдаж, 1947 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын нэг болгон өөрчлөн байгуулагдсан. Холбооны үүрэг нь: а) бүх төрлийн цахилгаан харилцаа холбооны зохистой ашиглалтыг сайжруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хангах, өргөжүүлэх; (в) цахилгаан харилцаа холбооны үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор техникийн байгууламжийг хөгжүүлэх, тэдгээрийн хамгийн үр ашигтай ажиллагааг дэмжих; тэдгээрийн ашигт чанарыг нэмэгдүүлэх, тэдгээрийг аль болох олон нийтэд хүртээмжтэй болгохыг дэмжих, с) эдгээр зорилгын хүрээнд гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах зэрэг болно. ITU-гийн Нарийн бичгийн дарга нарын газар Женев хотод байрладаг. Мөн Үндсэн цахилгаан харилцаа холбооны асуудлаарх хэлэлцээрийг (Agreement on Basic Telecommunications) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
758	International Clothing and Textiles Bureau	<p>Бэлэн хувцас ба текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэлийн олон улсын товчоо. Энэхүү товчоо нь Женев хотод байрладаг. Товчооны зорилго нь гишүүдийнхээ үйлдвэрлэсэн хувцас, нэхмэл эдлэлийг экспортлоход тулгарч буй хүндрэлүүд, ялангуяа худалдаанд хэрэгжүүлж буй ялгавартай, протекционист арга хэмжээг бууруулах, эдгээр бүтээгдэхүүний худалдаанд ТХЕХ-ийн зарчмыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага юм. Гишүүд нь Аргентин, Бангладеш, Бразил, Хятад, Колумби, Коста Рика, Сальвадор, Египет, Хонконг, Энэтхэг, Индонез, Ямайка, Макао, Мальдив, Мексик, Пакистан, Перу, БНСУ, Шри Ланка, Тайланд, Турк, Уругвай зэрэг улсууд байна.</p>
759	International Tin Agreement	<p>Цагаан тугалганы олон улсын хэлэлцээр. Олон улсын цагаан тугалганы хэлэлцээр нь анх 1931 онд байгуулагдаж 1934 онд шинэчлэгдсэн. Эдгээр эхэн үеийн хэлэлцээрүүд нь хэрэглэгчдийн төлөөллийг хангадаггүй байв. Үүний 1937 онд байгуулагдсан гурав дах хэлэлцээрийн хүрээнд хоёр том хэрэглэгч улсыг хуралд оролцохыг урьсан юм. Энэхүү хэлэлцээрт хэрэглэгчдийн оролцоог хангах зорилгоор 1954 онд дахин хэлэлцсэн, дараа нь 1961, 1966, 1971, 1975, мөн 1980 онд таван жилийн хугацаанд хэлэлцэн тохиролцсон. Гэрээний бүх хувилбаруудад нөөц түүхий эд, материалын заалт оруулж, экспортын квотын системийг хэрэгжүүлсэн. Энэ нь эцэстээ 1985 онд уг гэрээг цуцлах шалтгаануудын нэг болсон юм. Лондонгийн металлын бирж дээрх нөөц түүхий эд, материалын менежерийн хийж байсан форвард буюу ирээдүйд шилжүүлэн худалдах/худалдан авах худалдааны хэлцлүүд нь шинээр үүсэж буй хөрөнгийн хомсдолд нөлөөлж байсан юм. Өөр нэг шалтгаан нь зарим томоохон үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид гишүүн биш байсан тул уг хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх хуулиар хүлээсэн үүрэггүй байв. Гэсэн хэдий ч хэлэлцээрийг цуцлах шалтгаануудын талаар санал нэгдэхгүй байгаа юм. Цагаан тугалга судлалын олон улсын гуурыг (International Tin Study Group.) мөн үзнэ үү.</p>
760	International Tin Study Group	<p>Цагаан тугалга судлалын олон улсын групп. Энэ нь 1989 онд НҮБ-ын Цагаан тугалганы асуудлаарх бага хурлын үр дүнд байгуулагдсан боловч дэндүү цөөн тооны оролцогчид хүлээн зөвшөөрсөн тул үйл ажиллагаагаа явуулаагүй байна. Тус бүлгийн зорилго нь цагаан тугалганы асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, статистик мэдээлэл сайжруулах, үйлдвэрлэл, худалдааны талаар мэдээлэл солилцох явдал юм. Цагаан тугалганы олон улсын хэлэлцээрийг (International Tin Agreement) мөн үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
761	International Trade Centre UNCTAD/WTO	Олон улсын худалдааны төв (ИТС-ОУХТ) Энэ нь НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурал ба Дэлхийн худалдааны байгууллага хоёрын дундаас төрсөн агентлаг юм. Олон улсын худалдааны төв нь худалдааг дэмжих чиглэлээр хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор НҮБ-ын тогтолцооны хүрээнд 1964 онд байгуулагдсан. ОУХТ-ийн ажлын хөтөлбөрт бүтээгдэхүүн, зах зээлийн хөгжил, худалдааг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, худалдааны мэдээлэл, хүний нөөцийн хөгжил, олон улсын худалдан авалт, хангамжийн менежмент, худалдааг дэмжих хэрэгцээ зэрэг асуудлыг хамардаг. Тус төв нь Женев хотод байрладаг. Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг (trade facilitation) бас үзнэ үү.
762	International Trade Commission	Олон улсын худалдааны хороо. АНУ-ын засгийн газрын агентлаг бөгөөд бусад улс орнуудаас АНУ-ын экспортод ногдуулж буй тарифын болон тарифын бус арга хэмжээний үр нөлөөг тайлагнах үүрэгтэй. Анх 1916 онд АНУ-ын тарифын комисс гэж нэртэй байгуулагдсан. Энэхүү комиссын эрх үүрэгт демпингийн үйл ажиллагааг тодорхойлох, бусад орнуудаас экспортлогч нартаа олгож буй экспортын татаасны болон хамгаалалтын арга хэмжээний нөлөөллийг судлах асуудал тусгагдсан болно. Түүнчлэн хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний импорт нь хөдөө аж ахуйн салбарын үнийг дэмжих хөтөлбөрт саад болж байгаа эсэх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөдөг. Олон улсын худалдааны Комисс нь худалдааны бодлого боловсруулан гаргадаггүй боловч түүний судалгааны үр дүн нь АНУ-ын худалдааны бодлогыг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг .
763	International trade law	Олон улсын худалдааны эрх зүй. Эдгээр нь олон улсын худалдаа хэрхэн явуулахад нөлөөлж байдаг олон талт, бүс нутгийн болон хоёр талын худалдааны хэлэлцээрүүд мөн олон улсын бусад хэлэлцээрүүдийн иж бүрдэл юм. ДХБ-ын гишүүн олон орнуудын хувьд хувьд ТХЕХ, ҮХЕХ болон ДХБ-ын бусад хэлэлцээрүүд нь мөн ДХБ-ын гишүүн бусад орнуудтай хийх худалдааны харилцааны хамгийн чухал хэрэгсэл нь юм. Бусад үлдсэн улс орны хувьд, хоёр талын хэлэлцээр болон бусад эрх зүйн актууд нь олон улсын худалдааны холбогдох хууль тогтоомжийг нь бүрдүүлж байдаг. Олон улсын худалдааны эрх зүйн өөр нэг чиг урсгал нь хувийн компаниудын үйл ажиллагаатай холбоотой юм. Олон улсын хувийн эрх зүй (private international law), Олон улсын нийтийн эрх зүй (public international law), болон UNCITRAL-г үзнэ үү.
764	International Trade Organisation	Олон улсын худалдааны байгууллага. ОУХБ-ыг үзнэ үү.
765	International trade writ large	Олон улсын худалдааны талаарх ойлгомжтой, тодорхой байдал. Энэ нь Эрнест Пригийн хувьд олон улсын бараа, үйлчилгээний солилцоо болон үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг тайлбарлахад ашигласан нэр томьёо. Олон хүмүүс одоо бол энэхүү хандлагыг импорт, экспортын худалдааг ажиглахаас илүү ач холбогдолтой ерөнхий арга барил гэж үздэг. Мөн дөрвөн эрх чөлөөний горимыг (four freedoms) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
766	International Tropical Timber Agreement	<p>Халуун орны модны асуудлаарх олон улсын хэлэлцээр. 1983 онд Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөрийн ивээл дор хоёр жилийн хугацаатай хэлэлцээг хийсэн бөгөөд 1994 онд дахин хэлэлцэж дөрвөн жилийн хугацаатай хоёр удаа гурван жилээр сунгах боломжтойгоор байгуулсан. Энэхүү хэлэлцээр нь эдийн засгийн тухай заалт агуулаагүй болно. Хэлэлцээрийн гол зорилго нь дэлхийн мод, модон эдлэлийн эдийн засгийн бүх холбогдох асуудлаар гишүүд улс орнууд зөвлөлдөх, олон улсын хамтын ажиллагаа, бодлого боловсруулах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Худалдаатай холбоотой бусад зорилтууд бол (а) мод, модон эдлэлийн худалдаанд ялгавартай зарчим хэрэглэхгүй байхыг дэмжихийн тулд зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулах, (в) 2000 он гэхэд тогтвортой экспортын стратегийг боловсруулж гаргах гишүүдийн чадавхыг сайжруулах (с) тогтвортой эх үүсвэрээс халуун орны мод бэлтгэх олон улсын худалдааг өргөжүүлэх, төрөлжүүлэх (d) зах зээлийн мэдлэг, мэдээллийг сайжруулах, (e) үйлдвэрлэгч гишүүн орнуудын боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих (f) маркетинг болон түгээлтийг дэмжих (g) олон улсын модны зах зээлийн талаарх мэдээлэл хуваалцахыг дэмжих зэрэг болно. Олон улсын Халуун орны модны байгууллага нь Якохамад байрладаг захиргааны байгууллага юм. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.</p>
767	International Vine and Wine Office	<p>Усан үзмийн мод ба дарсны олон улсын алба. Мөн Office international de la vigne et du vin-ийг үзнэ үү.</p>
768	International Wheat Agreement	<p>Улаан буудайн олон улсын хэлэлцээр. Олон улсын улаан буудайн хэлэлцээрийн эцсийн хувилбар нь хоёр эрх зүйн актаас бүрдэв: (а) Статистик мэдээлэл цуглуулах, түгээх хөтөлбөр бүхий зөвлөлдөх форум болох 1986 оны Улаан буудайн худалдааны конвенц б) мөн тухайд үед байгуулсан Хүнсний тусламжийн конвенц. Энэ нь 1995 оны 7-р сарын 1-ний өдөр Олон улсын үр тарианы хэлэлцээрийн дагуу Үр тарианы худалдааны конвенц болон батлагдсан. Хэлэлцээрийн оролцогч талууд бүгд Лондонд байрладаг Олон улсын үр тарианы зөвлөл болон өөрчлөгдсөн Олон улсын улаан буудайн зөвлөлийн гишүүд байв.</p>
769	Intervention price	<p>Хөндлөнгөөс оролцсон интервенцийн үнэ. Энэ нь Европын хамтын нийгэмлэг Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогынхоо хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, материалыг тодорхой үнээр худалдаж авдаг механизм. Гарц нь эрэлтээс өндөр байсан ч тариаланчдын одоогийн орлогын түвшинг дэмжих зорилгоор интервенцийн үнийн механизмыг ашигладаг. Доод хязгаар үнийг (floor price) мөн үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
770	Intra-firm trade	<p>Нэг компанийн нэгжүүд хооронд хийх худалдаа. Энэ нэг компанийн нэгжүүдийн хооронд явагддаг олон улсын худалдаа. Энэ төрлийн худалдааны дийлэнх хувь нь үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүд буюу компанийн нэгжүүдийнх нь хооронд явагддаг байна. Компанийн доторх нэгж хоорондын худалдааны тоо хэмжээ ялгаатай боловч судалгаагаар нийт худалдааны гуравны нэг орчим хувийг эзэлж магадгүй гэж гарчээ. Зарим тайлбарлагчид компанийн нэгж хоорондын худалдаа арилжаа нь үнийн хувьд ялгаа байсан ч гэсэн нээлттэй зах зээлээс худалдан авалт хийхдээ өөрийн нэгжээс худалдаж авдаг гэсэн таамаглал дээр үндэслэн, үүнийг зохицуулалттай худалдааны нэг хэлбэр гэж авч үздэг. Энэхүү саналын талаарх санал бодол нь хуваагдмал хэвээр байна. Мөн даяаршлыг (globalisation) мөн үзнэ үү.</p>
771	Intra-industry trade	<p>Салбар хоорондын худалдаа. Өөрөөр хэлбэл, тухайн аж үйлдвэрлэлийн салбар дотроо хийх худалдаа. Энэ нь үндсэндээ ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд нэгэн зэрэг хийж буй экспорт эсвэл импорт. Жишээлбэл, нэг улсын автомашины үйлдвэрлэлийн салбар нь автомашины сэлбэг хэрэгслийг импортолж эсвэл экспортлож болно. Нэг аж үйлдвэрлэлийн салбар дотроо хийх худалдааг 1970-аад оноос хойш эдийн засагчид эрчимтэй хэлэлцэж ирсэн бөгөөд зарим нь үүнийг олон улсын худалдаан дах онцгой тохиолдол гэж үздэг. Гэхдээ олон улсын худалдааны урсгалын хувьд нэг аж үйлдвэрлэлийн салбар дотроо хийх худалдааны ач холбогдлын талаар санал зөрдөггүй байна. Даяаршлыг (globalisation) мөн үзнэ үү.</p>
772	Invention	<p>Шинэ бүтээл. Энэ нь Оюуны өмчийн үндсэн салбар болох аж үйлдвэрийн өмчид хамаарах ба хувирч болох ямар нэгэн шинэ зүйлийг бүтээн бий болгох тухай ойлголт. Шинэ бүтээл гэдэг нь байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдэл. Уг шинэ бүтээлд патентын хамгаалалт авч үр ашиг хүртэхийн тулд 3 үндсэн шалгуурыг хангах ёстой. Үүнд: 1) шинэ байх (урьд өмнө хаа нэг газар тайлбарлаагүй эсвэл ашиглагдаагүй байх), 2) шинэ бүтээлийн түвшин агуулсан байх (тодорхой бус, бусад бүтээлээс ялгагдах шинжтэй), 3) үйлдвэрлэлд ашиглах боломжтой байх ёстой.</p>
773	Investment	<p>Хөрөнгө оруулалт. Бизнесийн байгууллага, компани, аж ахуйн нэгжид эзэмших хувь. Саув болон Фалконер нар (Saue and Falconer, 1995) олон улсын хөрөнгө оруулагчид, бизнесүүдийн даяаршсан орчинд явуулж буй үйл ажиллагаа нь улам бүр төвөгтэй болж байгаагийн улмаас хөрөнгө оруулалтын тодорхойлолт олон жилийн турш улам өргөжин өөрчлөгдөж байгааг тэмдэглэжээ.</p>

1961 оны ЭЗХАХБ-ийн (OECD) Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг чөлөөлөх тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хуулиар бол, шууд хөрөнгө оруулалт гэдэг тухайлбал, түүний удирдлагад үр дүнтэй нөлөө үзүүлэх боломж олгох хөрөнгө оруулалт зэрэг аж ахуйн нэгжтэй удаан хугацааны эдийн засгийн харилцаа тогтоох зорилгоор дараах аргуудаар хийсэн хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон. Үүнд: (1) бүрэн эзэмшилт аж ахуйн нэгж, охин компани эсвэл салбар компанийг байгуулах эсвэл өргөжүүлэх, одоо байгаа аж ахуйн нэгжийн бүрэн өмчлөлийг бүхэлд нь эзэмших (2) шинээр байгуулагдсан болон одоо байгаа аж ахуйн нэгжид оролцох, (3) тав ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл олгох. 1994 оны 12-р сард байгуулсан Эрчим хүчний дүрмийн тухай олон улсын гэрээнд хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчийн шууд болон шууд бус байдлаар өмчилдөг эсвэл хянаж байдаг аливаа төрлийн хөрөнгө гэж тодорхойлдог. Үүнд: (а) биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, өмч хөрөнгө, түрээс, ипотекийн барьцаат зээл, эд хөрөнгө барьцаалан зээл авах эрх (liens), барьцаа хөрөнгө зэрэг аливаа өмчийн эрх, (b) компани, бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж, эсвэл компанийн өмчлөх эрхийг гэрчилсэн хувьцаа (shares), компанийн капиталд оролцох эрхийг худалдан авагчдад олгодог хувь оролцооны үнэт цаас (stocks), компани, аж ахуйн нэгжийн эздийн өмч буюу хувь нийлүүлсэн хөрөнгөд оролцох зэрэг бусад хэлбэр (c) эдийн засгийн үнэ цэнэ бүхий хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний дагуу мөнгө нэхэмжилж, гүйцэтгэлийг шаардах, (d) оюуны өмч, (e) хөрөнгө оруулалтын өгөөж, (e) хууль тогтоомж, гэрээнд заасан аливаа эрх эсхүл эрчим хүчний салбарт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд хууль тогтоомжийн дагуу олгосон, хуульд заасан аливаа лиценз, зөвшөөрөл, гэрээ зэрэг болно. 1994 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон НАФТА (NAFTA) нь хөрөнгө оруулалтыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: (a) аж ахуйн нэгж, (b) аж ахуйн нэгжийн хувьцаатай адилтгах үнэт цаас (equity security), (c) аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулагчтай холбоотой байдаг аж ахуйн нэгжийн өрийн үнэт цаас/бичиг, мөн өрийн үнэт цаас/бичгийн анхдагч өр төлөх хугацаа дор хаяж гурван жил байх, (d) хөрөнгө оруулагчтай холбоотой тухайн байгууллага, аж ахуйн нэгжид олгох зээл, мөн зээлийн төлбөр хийх анхдагч хугацаа дор хаяж гурван жил байх тохиолдолд (e) аж ахуйн нэгж дэх ашиг сонирхол нь орлого, ашгаа хуваах эрхийг олгосон байх, (f) үйл ажиллагаа нь дуусгавар болж байгаа (dissolution) тохиолдолд аж ахуйн нэгжийн актив хөрөнгийг хуваах эрхийг өмчлөгчид нь олгосон, тухайн аж ахуйн нэгж дэх ашиг сонирхол (g) хүсэн хүлээлтийн дагуу олж авсан, эсвэл эдийн засгийн үр ашиг эсвэл бизнесийн зорилгоор ашигласан үл хөдлөх хөрөнгө эсвэл бусад эд хөрөнгө, биет буюу биет бус хөрөнгө, (h) НАФТА-ийн (NAFTA) гишүүн орны нутаг дэвсгэрт байгаа капитал хөрөнгийн болон бусад эх үүсвэрийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтын дагуу үүссэн ашиг сонирхол зэрэг болно. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (foreign direct investment) мөн үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
774	Investment promotion and protection agreements	Хөрөнгө оруулалтыг дэмжиж, харилцан хамгаалах тухай хэлэлцээр. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа, хөгжлийн асуудалд зориулагдсан хөрөнгийн урсгалыг дэмжихэд чиглэсэн олон улсуудын хооронд хоёр талт түвшинд байгуулсан хэлэлцээр. Ийм хэлэлцээрүүд нь ихэвчлэн үндэсний нэн тааламжтай нөхцөлийн бүрдүүлж, хувь хүн/бие бүрэлдэхүүнийг нэвтрүүлэх, өмчийг нь албадан авах, улсын өмчлөлд авах, хөрөнгө шилжүүлэх, талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх гэх мэт нөхцөлүүдийг агуулсан байдаг. Мөн Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрүүд (bilateral investment treaties), Хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагуудын дэлхийн ассоциацийг (World Association of Investment Promotion Agencies) үзнэ үү.
775	Investment-related trade measures	Хөрөнгө оруулалттай холбоотой худалдааны арга хэмжээ. Энэ нь улсынхаа эдийн засагт гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн Засгийн газрын арга хэмжээ. Зарим тохиолдолд эдгээр компаниудад зах зээлийг эзлэх боломжийг олгох зорилгоор өндөр тариф тогтоосон Засгийн газрын арга хэмжээг багтаадаг. Мөн Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Investment Measures), тарифыг огцом өсгөсөн хөрөнгө оруулалтыг (tariff-jumping investment) үзнэ үү.
776	Investment services directive	Хөрөнгө оруулалтын үйлчилгээний удирдамж (ISD). Энэ нь үнэт цаасны салбарт үйлчилгээ эрхлэх болон бие төлөөлөгч/төлөөлөгчийн газраа байгуулах эрх чөлөөг сайжруулахад чиглэсэн Европын хамтын нийгэмлэгийн удирдамж. Энэ нь 1996 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү удирдамжийн нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтын компаниуд өөрийн гишүүн улсдаа уг зөвшөөрлийг авсны үндсэн дээр Европын хамтын нийгэмлэгийн аль ч нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Өөрийн улсаас зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг өөр бусад улсад бие төлөөлөгч/төлөөлөгчийн газраа байгуулах эсвэл хил дамнасан худалдаа хийх замаар хийж болно. Үүнд ямар нэгэн нэмэлт зөвшөөрөл, эхлэлтийн, хуримтлалын хөрөнгө эсвэл түүнтэй адилтгах нөлөө бүхий бусад арга хэмжээ авахыг шаарддаггүй. Мөн санхүүгийн үйлчилгээг (financial services) үзнэ үү.
777	Investment substitution	Хөрөнгө оруулалтыг орлуулах. ТХЕХ-ээр хязгаарласан арга хэмжээг өөр бусад арга хэмжээгээр орлуулах, заримдаа дотоодын бодлого хэрэгжүүлэх замаар илүү саад тогтор үзүүлэх тухай нэр томьёог.
778	Invisible hand	Үл үзэгдэх гар. Адам Смит нь аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулах сэдлийн талаар туурвисан “Үндэстнүүдийн баялаг” хэмээх бүтээлдээ авч үзэхдээ хэрэглэсэн нэр томьёо. Тэрээр худалдаачин, эсхүл хөрөнгө оруулагч нь “дотоодын үйлдвэрлэлийг түүний бүтээгдэхүүн нь хамгийн их үнэ цэнтэй байхаар чиглүүлэхдээ үүнийг зөвхөн өөрийнхөө ашиг сонирхлын үүднээс хийж байгаа гэж үздэг. Ийнхүү хийж байхад үл үзэгдэгч гар төдий эцсийн зорилго биш байж болох төгсгөлийг дэмжиж байдаг гэжээ”.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
779	Invisibles Group	Үл үзэгдэх бүлэг. Энэ нь гол төлөв Женев хотноо жилд хэд хэдэн удаа уулздаг ДХБ-ын гишүүн орнуудын төв нийслэл хотод ажиллаж буй ахлах албан тушаалтнуудын албан бус бүлэг. Энэ бүлэг нь ДХБ-ын ажлын хөтөлбөрт нийтлэг анхаарал татаж буй томоохон асуудлуудыг судлахтай холбоотой. Энэ нь шийдвэр гаргах бүрэн эрхгүй. Мөн Арван найман хүний зөвлөлдөх бүлгийг (Consultative Group of Eighteen) үзнэ үү.
780	Invisible tariffs	Үл үзэгдэх тариф. Энэ нь хуучин үг хэллэг ба одоо худалдаанд хязгаарлалт болж буй гаалийн үнэлгээний журам, хохирлыг арилгах худалдааны арга хэмжээ зэрэгт өргөн ашигладаг тарифын бус арга хэмжээ.
781	Invisibles trade	Үл үзэгдэх худалдаа. Мөн үйлчилгээний худалдааг (trade in services) үзнэ үү.
782	IOSCO (International Organization of Securities Commissions)	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага. Монреаль хотод байрладаг ба зорилго нь (а) шударга, үр ашигтай, тогтвортой зах зээлийг дэмжихийн тулд өндөр стандарт бүхий хууль журмыг дэмжихэд хамтран ажиллах (в) дотоодын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор туршлага судлах, мэдээлэл солилцох, (с) стандарт тогтоох болон олон улсын үнэт цаасны гүйлгээнд үр дүнтэй хяналт тавих, (d) стандартыг чанд мөрдөх, хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар зах зээлийн бүрэн бүтэн байдлыг дэмжихэд харилцан туслалцаа үзүүлэх. 130 гаруй гишүүнтэй.
783	ISO 9000	ИСО/ОУС 9000. Олон улсын стандартчиллын байгууллагаас боловсруулсан чанарын системийн цуврал багц стандартууд (ISO) буюу компаниуд үйл ажиллагаагаа журмын дагуу хийж байгаа эсэхийг үнэлэх стандарт. Эдгээр стандартыг бүтээгдэхүүний стандарттай андуурч болохгүй. Чанарын системийн стандартууд нь компаниудын зүгээс үйлчлүүлэгчдийнхээ шаардлагыг тогтмол хангах арга хэрэгслийг олж тогтоох боломжийг олгодог.
784	ISO 14000	ИСО/ОУС 14000. Олон улсын стандартчиллын байгууллагаас бэлтгэсэн зургаан чиглэлийг хамарсан байгаль орчны менежментийн цуврал стандартууд. Үүнд; байгаль орчны менежментийн тогтолцоо, байгаль орчны менежментийн аудит; байгаль орчны шошгожуулалт; байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ; насжилтын мөчлөгийн үнэлгээ; нэр томьёо, тодорхойлолтууд багтана. Ихэнх стандартууд нь компаниуд болон бусад байгууллагуудад байгаль орчны талаарх асуудлуудыг бизнесийн үйл ажиллагаандаа уялдуулан хэрэгжүүлэхэд нь туслах байгаль орчны арга хэрэгсэл болон тогтолцооны талаарх зааварчилгааны баримт бичиг. Байгаль орчны менежментийн тогтолцооны зөвхөн ISO 14001 гэдэг стандарт л гэрчилгээжүүлэх, бүртгүүлэх зорилго бүхий техникийн нөхцөлүүдийг агуулна. Мөн Худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) мөн үзнэ үү.
785	Istanbul Convention	Истамбулын конвенци. Истамбулын конвенц нь 1993 оны 11-р сарын 27-нд хүчин төгөлдөр болсон Түр хугацаагаар нэвтрүүлэх тухай гаалийн конвенц. Энэхүү конвенц нь бараа бүтээгдэхүүнийг өөр улс эсвэл гаалийн холбоонд түр хугацаагаар нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Үүний хэрэгжилтийг Дэлхийн гаалийн байгууллага хангаж ажиллана.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
786	Item-by-item tariff negotiations	Зүйл тус бүрээр тарифын хэлцэл хийх арга. Энэхүү арга нь тарифыг томьёоны дагуу бууруулах, шугаман тооцооллын аргаар тарифыг бууруулах эсвэл салбарын хүрээний худалдааны хэлэлцээнээс илүү их цаг хугацаа шаарддаг. Гэвч үр дүнд хүрэх хамгийн боломжтой арга, ялангуяа эмзэг барааны асуудлаар хэлэлцэж байгаа тохиолдолд.
787	ITO (International Trade Organization)	Олон улсын худалдааны байгууллага. ОУХБ байгуулах саналыг 1944 оны Бреттон Вудсын чуулганаас анх гаргасан. ОУХБ нь эдийн засгийн өргөн хүрээний асуудлуудыг хамрах зорилготой байсан бөгөөд үүнд хөрөнгө оруулалт, бизнесийг хязгаарласан үйл ажиллагаа, бараа түүхий эдийн зохицуулалт, олон улсын худалдааны дүрэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотой худалдааны асуудлууд багтсан болно. Эдгээр бүх асуудлууд нь 1947, 1948 онд Гавана хотод болсон эрчимтэй хэлэлцээний сэдэв байлаа. Эцэст нь олон төрлийн буулт хийсэн боловч хэлэлцээрийн гол талуудын сонирхлыг бүрэн хангаж чадаагүй. Өнөөдөр ТХЕХ хэмээх болсон тарифын дүрэм журам болон тарифын талаар хүлээсэн үүрэг амлалтын багц л зөвхөн талуудын хүсэн хүлээж байсан асуудлуудын дундаас нэг үр дүн болж биеллээ олсон байдаг. Хэлэлцээний үр дүнд ТХЕХ байгуулсан. ТХЕХ нь хөндөгдөж байсан арилжааны бодлогын бүлэгт үндэслэсэн, гэхдээ хэлэлцээг зэрэгцээ давхар замаар хийсэн байна. ОУХБ-ыг байгуулж чадаагүй. Мөн Бреттон Вудсын хэлэлцээр (Bretton Woods agreements), Гаванагийн дүрэм (Havana Charter), Худалдааны хамтын ажиллагааны байгууллага (Organisation for Trade Cooperation), Дэлхийн худалдааны байгууллагыг (WTO) үзнэ үү.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
788	Joint action	Хамтарсан арга хэмжээ. Энэ нь хэлэлцээрийн заалтыг зохицуулах, эсвэл зорилгоо цаашид хэрэгжүүлэх зорилгоор ТХЕХ-ийн бүх талуудын (гишүүд) хэрэгжүүлсэн арга хэмжээ. Хамтарсан арга хэмжээ авах шаардлагатай байсан, жишээлбэл, үүрэг амлалтыг цуцлах/ чөлөөлөх боломжийг олгоход. ТХЕХ-ийн албан ёсны баримт бичигт “хэлэлцээрийн талууд” гэсэн үгс нь талуудын хамтарч авсан арга хэмжээ гэж зааж байгаа тул том үсгээр бичигдсэн байдаг.
789	Joint Group on Trade and Competition	Худалдаа ба өрсөлдөөний талаарх хамтарсан бүлэг. Худалдаа болон өрсөлдөөний бодлогын хоорондын уялдаа холбоог хангах, өрсөлдөөний зарчмуудыг олон улсын худалдааны системд илүү нягт уялдуулах хувилбаруудыг авч үзэх зорилгоор 1996 онд ЭЗХАХБ -аас (OECD) байгуулагдсан байгууллага. Мөн худалдаа ба өрсөлдөөнийг (trade and competition) үзнэ үү.
790	Joint Trade Committee	Худалдааны хамтарсан хороо. Энэ нь хоёр талын худалдааны урсгал, тэдгээрээс үүссэн асуудлуудыг нягтлан үзэхээр тогтмол хийдэг уулзалтыг хоёр талт худалдааны хэлэлцээрийн дагуу хийдэг механизм. Уулзалтууд сайд, албан тушаалтнуудын түвшинд болох бөгөөд байршил нь оролцож буй хоёр орны хооронд ээлжлэн явагддаг. Мөн холимог хороог (mixed commission) мөн үзнэ үү.
791	Joint venture	Хамтарсан үйлдвэр/аж ахуйн нэгж. Тодорхой үйл ажиллагаа явуулах зорилготой хоёр ба түүнээс дээш аж ахуйн нэгж эсвэл хувь этгээд хоорондын хамтын ажиллагааны нэгдэл. Тухайн хамтарсан үйлдвэр нь хамтарсан төслөө хэрэгжүүлж дуусгаад татан буугдаж болно, тухайлбал, гүүр барих, судалгаа, хөгжлийн төсөл хэрэгжүүлэх гэх мэт. Үйлдвэрлэлийн байгууламжийн хувьд ихэвчлэн урьд өмнө тохиролцсон удирдамжийн дагуу тодорхой хугацааны дараа хамтарсан үйлдвэрийг татан буулгах тохиролцоо байж болно. Хамтарсан аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэр байгуулах үндсэн шалтгаан нь санхүүгийн, техникийн болон оюуны нөөцийг нэгтгэх, эрсдэлийг хуваалцах эсвэл шинэ зах зээлд нэвтрэх хөгжүүлэх зэрэг байж болно. Заримдаа, дотоодын болон орон нутгийн компанитай хамтарсан үйлдвэр байгуулах нь шинэ зах зээлд нэвтрэх цорын ганц бодит арга зам байж болох юм. Мөн АСЕАН-ы Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны схем (ASEAN Industrial Cooperation Scheme), оюуны өмчийг хамгаалах (intellectual property protection), технологийг дамжуулахыг (transfer of technology) үзнэ үү.
792	Juridical person	Хууль зүйн; хууль ёсны; эрх зүйн субъект бүхий этгээд. ҮХЕХ-т ашигласан нэр томьёо. Энэ үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан корпорац, итгэлцэл, түншлэл, хамтарсан аж ахуйн нэгж, байгууллага; хамтарсан үйлдвэр, ганц өмчлөгч, холбоо гэх мэт хуулийн этгээд.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
793	Kaleidoscopic comparative advantage	Калейдоскоп маягийн харьцангуй давуу тал. Энэ нь олон улс орны харьцангуй давуу тал нь болсон салбарын нэгэн зэрэг эмзэг болсон нөхцөл байдлыг тайлбарлахад ашигласан Жагдиш Бхагватын санал болгосон нэр томьёо. Өөрөөр хэлбэл харьцангуй давуу тал нь калейдоскоп юм. Ийм нөхцөлд дотоод орчин дах бага зэргийн өөрчлөлтүүд нь өрсөлдөх чадвараа хадгалахыг эрмэлзэж байгаа улс орнууд дах салбаруудыг өөрчлөхөд хүргэж болзошгүй юм. Энэ нь эрх чөлөөт аж үйлдвэрүүд эсвэл боолтын түлхүүр (отвёртка/халив) үйл ажиллагаанд (screwdriver operations) хүргэж болзошгүй юм. Мөн даяаршил (globalization), нутагшуулахгүй байхыг (delocalisation) мөн үзнэ үү.
794	Keiretsu relationships	Кейрецу харилцаа. Японы түгээлтийн нарийн төвөгтэй систем ба үйлдвэрлэлийн конгломератын зохицуулалт нь зах зээлд шинээр орж буй бизнест үнийн хувьд өрсөлдөхөд бэрхшээл учруулдаг. Түүхээс үзэхэд keiretsu харилцаа нь компани нийлүүлэлт, захиалгын тасралтгүй эрэлт дээр суурилсан байдаг. Өнөөдөр keiretsu-ийн харилцааг АНУ-ын экспортлогчид ялангуяа тарифын бус арга хэмжээ эсвэл бизнесийг хязгаарласан практик арга ажиллагаа гэж үздэг. Японы тоймчид тэдний хүчин чадлыг хэтрүүлэн үзсэн, мөн уг харилцаа нь ерөнхийдөө үнийн дохиог үгүйсгэх чадваргүй гэж маргах хандлагатай байдаг. Зарим нь хэвтээ keiretsus (хэд хэдэн салбар дах компани хоорондын зохицуулалт) ба босоо keiretsus (нэг ижил салбар дах үйлдвэрлэл, түгээлтийн өөр өөр үе шатанд байгаа компани хоорондын зохицуулалт)-ыг ялгаж салгаж авч үздэг. Зах зээлийн чиг баримжаатай тодорхой салбарын хэлэлцүүлэг (Market-Oriented Specific Sector talks), Бүтцийн саад тотгорыг арилгах санаачилга зэргийг (Structural Impediments Initiative) мөн үзнэ үү.
795	Kennedy Round	Кеннедигийн яриа хэлэлцээний үе шат. Энэ нь 1963-1967 оны хооронд явагдсан ТХЕХ-ийн олон талт худалдааны хэлэлцээрийн зургаа дах удаагийн хэлэлцээ. 1962 оны Худалдааг өргөжүүлэх тухай хуулийг баталснаар АНУ-ын худалдааны хөтөлбөрийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлсэн гэдэг утгаараа Ерөнхийлөгч Жон Ф Кеннедигийн нэрээр нэрлэжээ. Энэхүү хуулиар Ерөнхийлөгчид хэлэлцээ хийх өргөн хүрээний эрх мэдлийг олгосон. (Энэхүү асуудлаарх товч тайлбарыг АНУ-ын худалдааны гэрээний хууль тогтоомжоос үзнэ үү). Диллоны үе шатанд бараа тус бүрээр тарифын хэлэлцээ хийсэн бөгөөд энэ үеэр Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС- ЕЭЗХН), Европын чөлөөт худалдааны холбоо (ЕФТА) зэргийг байгуулж байсан, түүнчлэн Европын хувьд олон улсын худалдаанд томоохон байр суурь эзлэх болж буйтай холбоотой шинээр бий болж буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд илүү цогц арга барил шаардлагатай болох нь хэлэлцээ дуусахаас өмнө тодорхой болсон байсан. Японы эдийн засгийн өндөр өсөлт нь хожим экспортлогч болоход нь гол үүрэг гүйцэтгэхийг ёрлож байсан боловч Кеннедийн үе шатны голлон тоглогч нь АНУ болон ЕЭЗХН хоорондын харилцаа байв.

Үнэндээ, Кеннеди үе шат нь эцсийн дүндээ Атлантын Далайг дамнасан эдийн засгийн хамтын нийгэмлэг, түншлэлийн эхлэл болно гэсэн Америкийн нөлөө бүхий үзэл бодол байсан бөгөөд Европын орнуудад ч энэ үзэл байсан. Гэвч Европын нэгдэх үйл явц явагдаж байсан нь өөрийн гэсэн асуудал бий болгож байсан тул, тухайн үед Кеннедигийн үе шатны хэлэлцээ нь ЕЭЗХН-ийн хувьд хоёрдогч асуудал нь болж байв. Үүний нэг жишээ бол тус хэлэлцээ эхлэхээс ч өмнө Их Британы Нэгдсэн Вант Улс ЕЭЗХН-т гишүүнээр элсэх асуудалд 1963 оны 1-р сард Франц хориг тавьсан байдаг. Өөр нэг зүйл бол Люксембургт болсон 1965 оны дотоодын хямрал байв. Шинэ яриа хэлэлцээний бэлтгэл ажил Тахианы дайны асуудлаас болоод нэн даруй суларсан нь, аажмаар [ЕХ-ны] Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын хүрээнд ногдуулж эхэл гэж байсан нөлөө үзүүлэхүйц хувьсагч татвар хураамжийн эхний шинж тэмдэг байлаа. Хэлэлцээнд оролцсон зарим оролцогчид 1964 онд товлогдсон НҮБ-ын ХХБХ-ыг хуралдуулах нь үйл ажиллагаанд нь улам хүндрэл учруулж болзошгүй гэж санаа зовж байсан боловч үүний бодит хэлэлцээрт үзүүлэх нөлөө нь маш бага байсан. 1963 оны 5-р сард сайдууд энэ удаагийн хэлэлцээний хүрээнд гурван зорилт дээр тохиролцов. Үүнд: (а) өөрсдийн эдийн засгийн хөгжлийн улам дэмжих арга хэрэгсэл болгож, хөгжиж буй орнуудын эдийн засгийн худалдааг өргөжүүлэх арга хэмжээ авах, (в) тарифын саад болон худалдааны бусад саад тотгорыг бууруулах, халах болон (с) хөдөө аж ахуй болон бусад анхдагч түүхий эдийн барааны зах зээлд нэвтрэх арга хэмжээ. Тарифын хэлэлцээ хийх ажлын зорилго нь шугаман тооцооллын зарчмаар тарифыг 50% бууруулж, үүрэгт үл хамаарах хамгийн цөөн тооны зүйлийг (exceptions) тусгах явдал байв. Худалдааны тарифыг жигд бууруулсны улмаас АНУ-ын тарифын хэмжээний хол зөрүүтэй хэмжээнд (бага болон өндөр тарифын зөрүү нэлээд их) үзүүлэх худалдааны үр нөлөөний хувьд, ЕЭЗХН-ийн илүү төвлөрсөн шинж чанартай тарифын хэмжээтэй харьцуулахад бага байсан. ЕЭЗХН-ийн тарифууд нь АНУ-ын тарифын доод хагас хэмжээнд байх хандлагатай байсан. Үүний дагуу ЕЭЗХН нь тарифын оргил болон хамгийн доод хэмжээнүүдийг, үнийн хэмжээнд албан ёсны хязгаар тогтоох бодлого (ecretement) болон давхар ялгаатай томьёо (double esart) буюу 30:10-ийн томьёог ашиглан, уялдуулан жигдрүүлэх талаар санал дэвшүүлэв мэтгэлцэж байв. Хэлэлцээ эхэлмэгц энэхүү ажлын хэсгийн таамаглал үгүй болсон. Түүхий эд болон бусад анхан шатны түүхий эдийн экспорт давамгайлж байсан онцгой бүтэц бүхий улс орнууд (Австрали, Канад, Шинэ Зеланд, Өмнөд Африк) тариф бууруулах хэлэлцээг бүхэлд нь "бараа тус бүр"-ийг хэлэлцэх аргаар шийджээ. Эцэст нь, нэхмэл эдлэл, химийн бодис, ган болон бусад эмзэг бүтээгдэхүүнээс бусад барааны тарифыг дунджаар 35% хувиар бууруулсан үр дүн гарсан; үүнээс гадна хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний үнийн тарифыг 15% -аас 18% хүртэл бууруулсан байна. Мөн химийн бодисын асуудлаар хийсэн хэлэлцээ нь Америкийн борлуулалтын үнийг (ASP) цуцлах тухай түр тохиролцоонд хүргэсэн. Мөн дамппингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
796	Kyoto Convention	<p>Киотогийн конвенц. Энэ нь Гаалийн журмыг хялбаршуулах, уялдуулах тухай олон улсын конвенц. 1974 онд хүчин төгөлдөр болсон. Энэ нь гаалийн удирдлагын тодорхой чиглэл бүрд холбоотой журам тус бүрийг хавсаргасан олон хавсралтуудтай. Гишүүд өөрсдөө эдгээрийн алийг нь дагаж мөрдөхөө шийддэг. Бүх хавсралтууд хүчин төгөлдөр болоогүй байна. Энэхүү конвенцид бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох дүрмийг мөн оруулсан болно. Конвенцийн хэрэгжилтийг Дэлхийн гаалийн байгууллага удирдан ажиллана. Конвенцийг 1999 онд худалдаа, тээвэр, захиргааны арга техникийн хөгжлийг харгалзан үзэж шинэчилсэн.</p> <p>Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (Harmonised Commodity Description and Coding System), Станбулын конвенц (Istanbul Convention), гарал үүслийн дүрмийг (rules of origin) үзнэ үү.</p>

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
797	Labelling	Шошгожуулалт. Мөн эко-шошго (eco-labelling), генетикийн шинж чанартай шошгожуулалт (genetic labelling), гарал үүслийн тэмдэг (marks of origin), нийгмийн шинж чанартай шошгыг (social labelling) үзнэ үү.
798	LAFTA (Latin-American Free Trade Association)	Латин Америкийн чөлөөт худалдааны холбоо. Энэ нь 1960 оны 2-р сард Монтевидеогийн олон улсын гэрээгээр байгуулагдсан засгийн газар хоорондын энэхүү байгууллага нь Латин Америкийн нэгдсэн зах зээлийг бий болгох үндэс суурь болох чөлөөт худалдааны бүсийг аажмаар байгуулахаар төлөвлөжээ. 1980 он гэхэд гишүүн улс орнуудын худалдааны дөнгөж 14% нь л Латин Америкийн чөлөөт худалдааны холбоонд хамрагдаж байжээ. LAFTA-аас тодорхой үр дүнд хүрэх боломжгүй гэж үзсэний дараа тэр ондоо ALADI (Латин Америкийн нэгтгэл/интеграцчиллын холбоо) байгуулагдсан.
799	Laissez-faire policies	Лиси фээг (Laissez-faire) бодлого. Зах зээлийн хувьд хамгийн сайн үр дүнд хүрэх боломжийг олгох Засгийн газрын хамгийн бага оролцоонд суурилсан эдийн засгийн бодлого. Мөн Латин Америкийн интеграцийн холбоог (ALADI) үзнэ үү.
800	Law of constant protection	Байнгын хамгаалалтын тухай эрх зүй. Жагдиш Бхагватын санал болгосон энэхүү нэр томьёо нь хэрэв протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онолыг ямар нэгэн хэлбэрээр зогсоох юм бол энэ нь өөр бусад хэлбэрээр хаа нэгтэй гарч ирнэ гэсэн үг.
801	Lay-out designs of integrated circuits	Интеграл цахилгаан шугам бүхий микро схемийн зураг төсөл. Энэ нь Худалдаатай холбогдолтой оюуны өмчийн эрхийн асуудлаарх хэлэлцээрийн (TRIPS) дагуу хамгаалагдсан оюуны өмчийн нэг хэлбэр юм. Хамгаалалтыг ихэвчлэн ховор/хоггүй/давтагдашгүй (sui generis) эрхийн тусламжтайгаар хийдэг бөгөөд энэ тохиолдолд нэгдсэн схемийн зураглалыг (эсвэл топографийг) ашиглах аргыг ашигладаг. Энэ нь ийм загварыг зөвшөөрөлгүй хуулбарлах, түгээн тараахыг хориглодог. Урвуу инженерчлэлийг олон улсын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрдөг.
802	Learning-by-doing argument	Ажиллах явцдаа суралцах. Энэ нь хөгжлийн эхний үе шатандаа яваа эмзэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх (infant-industry) нэг хувилбар. Хэрэв Засгийн газраас хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлснээр тухайн салбарын өрсөлдөх чадвар нь сайжирна гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. Мөн Импортын орлуулалтыг (import substitution) үзнэ үү.
803	Least developed countries	Нэн буурай хөгжилтэй улсууд. Үүнийг LDC эсвэл ялангуяа хуучин материалд LLDC гэж товчилсон байдаг. Хөгжиж буй 49 орныг дараах үзүүлэлтүүд дээр үндэслэн НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлөөс (ECOSOC-НҮБЭЗНЗ) нэн буурай хөгжилтэй улсууд гэж бүлэг болгосон, үүнд: Нэг хүнд ногдох ҮНБ, төрөх үеийн дундаж наслалт, нэг хүнд ногдох илчлэгийн хангамж, анхан шатны болон дунд боловсролын хамрагдалтын харьцаа, насанд хүрэгчдийн бичиг үсгийн түвшин, ДНБ дэх үйлдвэрлэлийн эзлэх хувь, үйлдвэрлэлд эзлэх хөдөлмөр

эрхлэлт, нэг хүнд ногдох цахилгаан хэрэглээ, тэдгээрийн экспортын төвлөрлийн харьцаа зэрэг юм. Эдгээр үзүүлэлтүүд болон нэн буурай хөгжилтэй гэж тогтоосон орнуудын жагсаалтыг НҮБЭЗНЗ гурван жил тутамд хянаж байдаг. Энэ жагсаалтад одоогоор Афганистан, Ангола, Бангладеш, Бенин, Бутан, Буркина Фасо, Бурунди, Камбож, Кейп Верде, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Комор, Ардчилсан Конго, Джибути, Экваторын Гвиней, Эритрея, Этиоп, Гамбия, Гвиней, Гвиней-Бисау, Гаити, Кирибати, Лаос Ардчилсан Ардчилсан Бүгд Найрамдах Улс, Лесото, Либериа, Мадагаскар, Малави, Мальдив, Мали, Мавритани, Мозамбик, Мьянмар, Непал, Нигер, Руанда, Самоа, Сан-Томе ба Принсипи, Сенегал, Сьерра-Леоне, Соломон Арлууд, Сомали, Судан, Того, Тувалу, Уганда, Танзани, Вануату, Йемен, Замби багтана. ДХБ-ын зарим заалтууд нь нэн буурай хөгжилтэй улсуудын онцгой бэрхшээл, эрэлт хэрэгцээг хэд хэдэн аргаар хүлээн зөвшөөрдөг. Нэгдүгээрт, эдгээр улсуудад ТХЕХ-ийн IV хэсэг ба Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дагуу нэн буурай хөгжилтэй орнууд нь харилцан адил байх нөхцөлийг мөрдөлгүйгээр, өөрсдийнхөө ашиг сонирхолд нийцүүлэн арга хэмжээ авах боломжийг олгоно. Нэмж дурдахад, 1994 оны 4-р сард Марракеш хотод болсон Сайд нарын бага хурлын үеэр гаргасан шийдвэрийн дагуу, өөрсдийн бие даасан хөгжлийн түвшин, санхүү, худалдааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үүрэг амлалт авч, хөнгөлөлт эдлэх боломжийг олгодог. Мөн энэхүү шийдвэр нь нэн буурай хөгжилтэй улс орнуудын сонирхсон тарифын болон тарифын бус арга хэмжээг хурдан хугацаанд хэрэгжүүлэх, ХЕС-д хамрагдах нөхцөлийг сайжруулахыг эрэлхийлсэн. Тэдэнд худалдаагаа өргөжүүлэх боломж олгохын тулд техникийн туслалцаа авах боломжоор хангана. ДХБ-ын хэд хэдэн хэлэлцээр нь нэн буурай хөгжилтэй орны асуудлаарх заалтуудыг агуулдаг. Жишээлбэл, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлаарх хэлэлцээр нь нэн буурай хөгжилтэй орнуудад хэлэлцээрийн нөхцөлүүдийг хэрэгжүүлэхэд 10 жилийн нэмэлт хугацаа олгосон байдаг. ҮХЕХ нь гишүүн орнуудын зүгээс нэн буурай хөгжилтэй орнуудыг дэлхийн үйлчилгээний худалдаанд илүү идэвхтэй оролцох боломжийг олгох арга хэмжээ авахыг шаарддаг. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (НҮБХХБХ) нь жил бүр нэн буурай хөгжилтэй тулгарч буй хөгжлийн гол асуудлууд, тэдгээрийн богино хугацааны төлөв байдал, өсөлтийн төлөв байдлын талаарх тайланг гаргадаг. Мөн зэвсгээс бусад бүх зүйл (everything but arms), хүнсний аюулгүй байдал (food security), нэн буурай хөгжилтэй орнуудын худалдаатай холбоотой асуудлаар техникийн туслалцааны нэгдсэн хөтөлбөрийг (Integrated Framework for Trade-Related Technical Assistance to Least-Developed Countries) үзнэ үү.

Нэн буурай хөгжилтэй орны тайлан. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас (НҮБХХБХ) жил бүр гаргадаг. Мөн Нэн буурай хөгжилтэй орнуудыг (Least developed countries) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
805	Leontief Paradox	Леонтьевийн парадокс хэмээх худалдааны онол. Эдийн засгийн ухаанд Леонтьевийн парадокс гэдэг нь нэг ажилтанд ногдох капиталын хувь өндөр улсын хувьд, экспортын бараа бүтээгдэхүүнийг нь авч үзвэл капитал ихээр шаардсан гэхээсээ илүү хөдөлмөр ихээр шаардсан бүтээгдэхүүний хувь хэмжээ нь өндөр байдаг байна. Мөн худалдааны шинэ онолыг (new trade theory) үзнэ үү
806	Lerner's symmetry theorem	Лернерын тэгш хэмийн теорем. 1936 онд экспортын татвар нь импортын татвартай тэнцүү байх юм гэдгийг нотолсон эдийн засагч Абба Лернерийн нэрээр нэрлэгдсэн.
807	Lesser-duty principle	Бага татвар зарчим. Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх зарчим. Демпинг хийсэн гэж үзсэн бараанд ногдуулах нэмэлт татвар нь, хэрэв бага татвар нь учруулсан хохирлыг арилгахад хангалттай юм бол, демпинг хийсэн гэх барааны маржинаас бага байх ёстой.
808	Less than fair value	Зах зээлийн үнээс бага байх. АНУ-ын демпингтэй тэмцэх хуулийн дагуу тухайн бүтээгдэхүүний экспортын үнэ нь экспортлогчийн дотоод зах зээлийн үнээс харьцангуй бага байх. Хэрэв экспортын үнэ дотоодын үнээс бага байвал бодит зах зээлийн үнээс доогуур байна гэж үзнэ. Үнийн ялгаа, демпингийн маржин болон материаллаг хохирол нь тогтоогдсон бол дамппингийн эсрэг авах арга хэмжээний үнэлгээний хэсэг байгуулна.
809	Lex posterior	Хууль хэрэглэх дүрэм. (Өмнөх хуулийг хүчингүй болгосон сүүлийн хууль). Хэрэв нэг улс хоорондоо зөрчилтэй заалт бүхий хоёр олон улсын хэлэлцээрт нэгдэн орсон бол сүүлд нэгдэн орсон хэлэлцээрийн заалт илүү хүчинтэй байна.
810	Leutwiler Report	Лютвистерийн тайлан. 1983 оны сүүлээр буюу ТХЕХ-ийн Сайд нарын хуралдаанаас хойш нэг жилийн дараа ТХЕХ-ийн Ерөнхий захирал Швейцарын Үндэсний Банкны ТУЗ-ийн дарга байсан доктор Фриц Лейтвилерээр ахлуулсан бизнес, Засгийн газар, эрдэм шинжилгээний ажилтнууд оролцсон долоон бүлэг бүхий хүмүүсийг цуглуулав. Бүлгийн үүрэг нь олон улсын худалдааны тогтолцооны байдал, түүнд тулгарч буй бэрхшээлийн үндсэн шалтгааныг олж харах, цаашдын үйл ажиллагааны талаар санал гаргах байв. Үүний үр дүнд "Илүү сайхан ирээдүйг бий болгох худалдааны бодлого" гэсэн тайланг 1985 оны 3-р сард гаргасан. Тайлангийн арван таван зөвлөмж нь худалдааны шинэ хэлэлцээ хийхэд түлхэц өгч, түүнийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгов. Эдгээр асуудлын ихэнх нь Уругвайн үе шатны хэлэлцээний үед үр дүнд хүрсэн. Дүгнэж хэлэхэд: (i) улс орнуудын худалдааны бодлого нээлттэй байх (ii) хөдөө аж ахуйн худалдааг илүү тодорхой, шударга журамд үндэслэх (iii) саарал хэсэгт хамаарах арга хэмжээг ТХЕХ-т нийцүүлэх хуваарийг гаргах (iv) нэхмэл эдлэл, хувцасны худалдаа нь ТХЕХ-ийн хүрээнд хийгдэх (v) татаас олгох журмыг илүү үр дүнтэй болгох; (vi) тарифын бус арга хэмжээний талаарх хуулийг сайжруулах,

(vii) чөлөөт худалдааны бүс, гаалийн холбоо байгуулах журмыг нарийвчлан боловсруулж, чангатгах шаардлагатай; (viii) худалдааны бодлого, үйл ажиллагаанд олон улсын хяналт тавих шаардлагатай, (ix) хамгаалалтын арга хэмжээг зөвхөн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх (x) хөгжиж буй орнууд өрсөлдөх чадварын давуу талаа ашиглах, худалдааны тогтолцоо дах оролцоогоо нэмэгдүүлэхэд илүү их анхаарал хандуулах (xi) үйлчилгээний худалдааны асуудлаарх олон талт зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх. (xii) маргаан шийдвэрлэх журам, хөндлөнгийн хэсгийн зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах, (xiii) ТХЕХ-ийн хэлэлцээний шинэ шатыг эхлүүлэх, (xiv) асуудлыг шуурхай шийдвэрлэх хэлэлцээ хийхийг дэмжих зорилгоор сайд нарын түвшний байнгын байгууллагыг байгуулах, (xv) дэлхийн өрийн асуудлыг зохистой шийдвэрлэх, хөгжлийн санхүүжилтийн зохистой урсгал, макро эдийн засгийн бодлогын олон улсын зохицуулалтыг сайжруулах, худалдаа, санхүүгийн бодлогын хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг хүчин чармайлтууд. Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр хангалтгүй анхаарал хандуулсан хоёр зөвлөмжийг (vi ба xv) одоо ДХБ-ийн хүрээнд хэлэлцэж байгаа. Үүнийг зөвхөн ТХЕГ-ын хүрээнд шийдвэрлэх боломжгүй байсан юм. Сайд нарын байнгын байгууллагыг байгуулах шаардлагатай хэвээр байгаа бөгөөд ДХБ-ын Сайд нарын бага хурлыг дор хаяж хоёр жилд нэг удаа хийхээр тохиролцсон.

811 Level playing field

Бүх оролцогчдод шударга өрсөлдөөний эрх тэгш талбарыг бий болгох, шударга худалдаа эрхлэх. A level playing field гэдэг нь нэгэн ижил багц дүрмийг бүх оролцогчид дагаж мөрдөн шударга худалдаа эрхлэх нөхцөлийг илэрхийлэн дүрслэхэд хэрэглэгддэг нэр томьёо. Энэ нэр томьёоны асуудлаар янз бүрийн байр суурь байгаа. Зарим нь худалдааны дүрэм, журмууд нь хууль эрх зүйн талаасаа аль нэг талд давуу эрх олгодоггүй гэх боловч, тэдний үзэж байгаагаар бол, ихэнхдээ хазайсан байдалтай байдаг level playing field нь үл танигдах тарифын бус худалдааны саад тотгорыг агуулж байдаг гэж үздэг. Тиймээс тэдний үзэж байгаагаар зарим тоглогчид дүрмээр тоглохыг зөвшөөрвөл байнга асуудалтай тулгарах болно. Иймд худалдааг “шударга” байлгаж, бүх гажуудлыг арилгах ёстой гэж үздэг олон төрлийн хамгаалалтын хэлбэрийг илүүд үзэж ашигладаг хүмүүс, a level playing field гэсэн нэр томьёог маш ихээр ашиглах болсон байна. Хэрэв үүнийг ийнхүү хийх боломжгүй бол, байдал мэдээжийн хэрэг ийм л байсан, импортын эсрэг Засгийн газрын зүгээс хөндлөнгийн арга хэмжээ хэрэгжүүлэхийг зөвтгөнө. Олон улсын тайлбарлагчийн хэлж байгаагаар тухайн нэг улсын эдийн засгийн хувьд a level playing field байх боломжтой, учир нь хүн бүр нэг ижил дүрмийн дагуу ижил түвшинд тоглох боломжтой байдаг. Хэрэв олон тоглогчдын дүрмийг хамруулсан тохиолдолд, түүнийг дагаж мөрдөн хэрэгжүүлэх нь илүү хэцүү байдаг. Одоогоор level playing field-ийн агуулгын хувьд бие даасан олон таамаглалуудаар дүүрэн байдаг бөгөөд тэдгээрийг дүн шинжилгээний арга хэрэгсэл болгон ашиглах боломж маш хязгаарлагдмал юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
812	Life cycle assessment	Насжилтын мөчлөгийн үнэлгээ. Бараа, үйлчилгээ, түүний боловсруулалтын үйл явцын бүхэл бүтэн насжилтынх нь хүрээнд байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг нь тогтоох арга. Үүнд бүтээгдэхүүний эцсийн устгал орно. Насжилтын мөчлөгийн үнэлгээ нь бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд зарцуулагдсан бүх нөөц, түүнчлэн эдгээр бүтээгдэхүүн оршин тогтносноос үүдэлтэй хүрээлэн буй байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамардаг. Заримдаа насжилтын үнэлгээг “өлгийнөөс булш хүртэлх үнэлэлт дүгнэлт” (cradle-to-grave) үнэлгээ гэж нэрлэдэг. Мөн Худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
813	Like-Minded Group of Developing Countries	Ижил байр суурь бүхий хөгжиж буй орнуудын бүлэг. ДХБ-ын хэлэлцээнүүдэд идэвхтэй оролцдог бүлэг. Үүний үндсэн гишүүд нь Куба, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Египет, Гондурас, Энэтхэг, Индонез, Малайз, Пакистан, Уганда, Зимбабве.
814	Like product	Ижил бараа. Энэхүү илэрхийлэл нь ДХБ-ын удирдаж байдаг хэд хэдэн хэлэлцээрт байдаг боловч ихэнх тохиолдолд тодорхойлогдоогүй байдаг байна. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүнд ялгавартай журам тогтоосон эсэхийг шалгаж үзэх стандартуудын нэг. “Ижил бараа” гэсэн утгатай холбоотой маргаантай асуудлуудыг хянахдаа маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг олон улсын хэрэглээ болон хүлээн зөвшөөрөгдсөн гаалийн ангилал гэх мэт шалгууруудыг үзэх хандлагатай байжээ. Гэсэн хэдий ч “ижил” гэсэн нэр томьёог “адилхан” -тай тэнцүүлэх хандлага ажиглагдаж байна. Ижил бараа үйлдвэрлэдэг үйлдвэр материаллаг хохирол амссан тохиолдолд л арга хэмжээ авах боломжтой демингийн эсрэг арга хэмжээ авах тохиолдолд энэхүү арга барилыг албан ёсны болгосон байдаг. ДХБ-ын холбогдох дүрмийн дагуу “ижил бараа” гэсэн нэр томьёо нь авч үзэж буй бараатай бүх талаараа ижил төстэй бүх барааг хэлнэ. Хэрэв ийм бараа байхгүй бол бүх талаараа ижил төстэй биш боловч авч үзэж буй бараатай төстэй шинж чанар бүхий өөр барааг ашиглаж болно. Бразилын хуураагүй кофе (Brazilian unroasted coffee), Германы сардин загасны импортод хэрэглэсэн “ижил бараа” гэх утгатай маргааныг (German imports of sardines for disputes based on the meaning of “like product”) үзнэ үү.
815	Linear country	Шугаман аргачлал бүхий улс. Шугаман аргачлалаар тарифыг хасаж хөнгөлөлт үзүүлэхээр тохиролцсон орнуудад зориулан, Кеннедигийн үе шатны хэлэлцээний үеэр ашигласан нэр томьёо.
816	Linear tariff cuts	Шугаман аргачлалаар тарифыг бууруулах арга. Үүнийг бас томьёоны арга гэж нэрлэдэг. Эдгээр нь барааны бүх ангилалд тарифыг ижил түвшинд буулгах утга бөгөөд хувиар илэрхийлэгдэнэ. Энэ аргыг анх Кеннедийг үе шатны хэлэлцээ (1963-67) -ний үеэр олон талт худалдаанд албан ёсоор танилцуулсан бөгөөд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн зүгээс Диллоны үе шатны үед (1960) гаргаж байсан анхны саналд мөн үүнийг авч үзсэн байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Кеннедийн үе шатны хэлэлцээнээс өмнө энэ аргыг хүлээн аваагүй гол шалтгаан нь үүнийг ашиглах тухайд АНУ-ын хэлэлцээ хийх эрх мэдэл хангалтгүй байсантай холбоотой байв. АНУ Уругвайн үе шатны хэлэлцээнд тарифыг бууруулах энэхүү шугаман аргыг (linear tariff cuts) няцаав. Токиогийн үе шатны тарифын хэлэлцээний үер ашигласан Швейцарын томьёог (Swiss formula which was used in the Tokyo Round tariff negotiations) мөн үзнэ үү.</p>
817	Lisbon Agreement	<p>Лиссабоны хэлцээр. Гарал үүслийн нэршлийг хамгаалах, олон улсын бүртгэлд хамруулах тухай хэлэлцээр 1958 онд Лиссабонд байгуулагдаж, 1967 онд шинэчлэгдсэн. Бүх гишүүн улс орнууд олон улсад бүртгэгдсэн нэршлийг тухайн гарал үүслийнх нь оронд нь хамгаалсан хэвээр байгаа тохиолдолд мөн түүнийг нь хамгаалах ёстой. Гэхдээ гишүүн улс нь бүртгэгдсэн нэршлийн хамгаалалтыг хангаж чадахгүй гэдгээ нэг жилийн дотор мэдэгдсэнээс бусад тохиолдолд юм. Энэ нь гарал үүслийн нэршлийг хамгаалах боломжийг олгодог. Ийм нэршлийг сонирхсон улсын хүсэлтийн дагуу ДООБ (WIPO) бүртгэнэ. Мөн оюуны өмчийг (intellectual property) үзнэ үү.</p>
818	Local content requirements	<p>Дотоодын агуулгын шаардлагууд. Энэ нь дотооддоо үйлдвэрлэх бараа, үйлчилгээнд дотоодод буюу орон нутагт үйлдвэрлэсэн бүрэлдэхүүн хэсгийг угсарч уялдуулан ашиглах шаардлагын хамгийн доод түвшинг тогтоосон Засгийн газрын арга хэмжээ. Дотоодын буюу орон нутагт үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн хамгийн доод түвшин гэдэг агуулгад (local content) жин, хэмжээ, үнэ цэнэ гэх мэтийг ойлгож болно. Эдгээр хөтөлбөрүүдийн зорилго нь дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадваргүй үйлдвэрлэлдээ баталгаатай зах зээл олох, бүс нутгийн хөгжлийг дэмжихэд оршино. Энэхүү шаардлага нь тухайн бүрэлдэхүүн хэсгийг ханган нийлүүлэгчдийг хамгаалахад чиглэгдсэн байдаг тул энэ нь эргээд хэрэглэгчдэд тухайн бараа өндөр өртөгтэй нийлүүлэгдэнэ. Өрсөлдөх чадвар өндөртэй салбарууд зах зээл хайх шаардлагагүй байдаг тул энэхүү зохицуулалтыг хийх шаардлагагүй байдаг нь харагддаг. Гэсэн хэдий ч Засгийн газар тухайн хөтөлбөрийн ирээдүйн үр өгөөж нь эдгээр гарч буй зардлаас илүү жин дарж байдаг гэж үзэж болох юм. ТХЕХ-ийн III-р зүйл: 5 (Дотоодын татвар, зохицуулалтын үндэсний нөхцөл) нь тухайн бүтээгдэхүүнүүдэд тодорхой тогтоосон хэмжээгээр бүтээгдэхүүн боловсруулалтад [дотоодын барааг] хольж ашиглах, боловсруулах эсвэл ашиглахтай холбоотой дотоодын тоон хязгаарлалт тогтоох эсвэл заавал дотоодын бүтээгдэхүүнүүдийг ашиглах зэргийг хориглосон байдаг. Худалдаанд холбогдолтой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Investment Measures), Гадаадын хөрөнгө оруулалтыг хянан дүгнэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах агентлагийн (FIRA) маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөл (FIRA panel) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
819	Local content rules in broadcasting	<p>[Телевиз, радиогийн] Өргөн цацалтын нэвтрүүлгийн хүрээнд тавигдах дотоодын буюу үндэсний агуулгын тухай журам. Иймэрхүү журамд ерөнхийдөө радио, телевизийн нэвтрүүлгийн тодорхой цаг хугацааны хуваарьд тухайн дотоодын буюу орон нутагт үйлдвэрлэсэн материалыг ашиглах хэмжээний доод шаардлагыг зааж өгсөн байдаг. Дотоодын бүтээгдэхүүн гэсэн тодорхойлолтыг тухайн материалын агуулга, уран сайхны бүтээл үйлдвэрлэгч байгууллагын харьяалал, уран бүтээл үйлдвэрлэгч, найруулагч, гол жүжигчид, санхүүжилтийн эх үүсвэр гэх мэт шинж чанар, агуулгын аливаа хослол дээр үндэслэж болно. Мөн дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд (audiovisual services), Уругвайн үе шатны хэлэлцээр дэх дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд (audiovisual services in the Uruguay Round), өргөн нэвтрүүлгийн удирдамж (broadcasting directive), соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанар (cultural identity), худалдаа ба соёлыг (trade and culture) үзнэ үү.</p>
820	Lome Convention	<p>Ломе конвенц. Энэхүү хэлэлцээр нь анх 1975 онд Яундэ (Yaounde) конвенцийн өв залгамжлагчаар байгуулагдсан бөгөөд 1990 онд Африк, Карибын тэнгис, Номхон далайн 71 улсуудын нэг төрлийн холбоо нь одоогоор бол Европын хамтын нийгэмлэг болсон тухайн үеийн Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгтэй 10 жилийн турш (Ломе-IV) дахин хэлэлцсэн (ЕЭЗХН) үндсэн малгай хэлэлцээр. Эвлэлдэн нэгдсэн улс орнуудын бараг бүх бараа бүтээгдэхүүн ЕЭЗХН-т тарифгүйгээр нэвтрэх эрхтэй бөгөөд мөн ихээхэн хэмжээний тусламж авах эрхтэй. Экспортын орлого ноцтой, гэнэтийн уналтад орсон тохиолдолд хөнгөлөлттэй зээл авах замаар экспортын орлогоо баталгаажуулах хоёр ч схемд хамрагдах боломжтой. Эдгээр нь STABEX ба SYSMIN юм. ЕЭЗХН нь Африк, Карибын тэнгис, Номхон далайн орнуудад тарифгүй нэвтрэх эрх олж аваагүй. Ломе конвенцийг 2000 оны 3-р сарын 1-ний өдөр Африк, Карибын тэнгис, Номхон далайн болон Европын Холбооны түншлэлийн хэлэлцээр болгон өөрчилсөн.</p>
821	London Guidelines for the Exchange of Information on Chemicals in International Trade	<p>Олон улсын худалдаанд химийн бүтээгдэхүүний асуудлаар харилцан мэдээлэл солилцох Лондонгийн удирдамж. Энэ нь 1989 оны 5-р сарын 25-нд UNEP (НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр) -ийн ивээл дор баталсан. Энэхүү удирдамж нь шинжлэх ухаан, техник, эдийн засаг, хууль эрх зүйн мэдээлэл солилцох замаар химийн бодисын зохистой менежментийг сайжруулахад чиглэсэн бөгөөд үүнд урьдчилж мэдэгдсэн зөвшилцлийн зарчмыг мөн оруулсан болно. Үүнд олон улсын худалдаанд химийн бодисыг хориглосон эсвэл эрс хязгаарласан тусгай заалтууд байдаг. Худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) мөн үзнэ үү.</p>
822	Long-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textiles	<p>Хөвөн текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэлийн олон улсын худалдаанд хамаарах асуудлаарх урт хугацааны тохиролцоо (LTA). Энэ нь Текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэлийн олон улсын худалдааны талаарх богино хугацааны тохиролцооны залгамжлагчаар 1962 онд таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр болсон Хөвөн текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэл, хувцасны зохицуулалттай худалдаанд зориулан ТХЕХ-т оруулсан тохиролцоо юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Энэхүү зохицуулалтыг Кеннедигийн үе шатны хэлэлцээний хүрээнд дахиад гурван жилээр сунгасан. 1970 онд дахин сунгасны дараа уг зохицуулалтыг 1973 онд Multi-Fibre (Олон ширхэгт) Текстилийн (сүлжмэл, нэхмэл, оёмол) эдлэлийн худалдааны асуудлаарх олон улсын хэлэлцээрээр сольсон. LTA-ийн гишүүнчлэл нь текстиль эдлэл, хувцасны гол чухал импортлогч, экспортлогчдоос бүрдэж байв. Энэ нь импортлогч гишүүн орнуудаас экспортлогч улсуудыг өөрсдийн худалдаагаа хязгаарлахыг хүсэх боломжийг олгов. Импортлогч гишүүд ТХЕХ-ийн XI зүйлд заасан тоон хязгаарлалтыг бүхэлд нь халах заалтыг үл хамааран тоон хязгаарлалт тавих боломжтой болсон. Мөн текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) эдлэл, бэлэн хувцасны худалдааг олон талт худалдааны хэвийн журмын дагуу эргээд хэрэгжүүлэх зорилго бүхий Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийг (Agreement on Textiles and Clothing) үзнэ үү.</p>
823	Low-income economies	<p>Бага орлоготой улс. Энэ нь ОУСБХБ (IBRD)-аас ангилсан байдаг бөгөөд Дэлхийн хөгжлийн тайланд тусгагдсан 63 эдийн засгийн бүлэг юм. 2000 онд эдгээр эдийн засаг бүхий орнуудад нэг хүнд ногдох ҮНО (GNI - үндэсний нийт орлого) 755 ам.доллар ба түүнээс бага байжээ. Энэ бүлэгт нэн буурай хөгжилтэй орнууд, ялангуяа орлогын түвшний доод хэсгийн хувьд багад тооцогдох орнууд багтдаг боловч Хятад, Энэтхэг улсууд нь мөн түүний нэг хэсэг юм. Мөн өндөр орлоготой улс (high-income economies), бага дунд орлоготой улс (lower-middle-income economies) дээд дунд орлоготой улсыг (upper-middle-income economies) үзнэ үү.</p>
824	Lower-middle-income economies	<p>Бага дунд орлоготой улс. Энэ нь ОУСБХБ (IBRD)-аас ангилсан байдаг бөгөөд Дэлхийн хөгжлийн тайланд тусгагдсан 54 орны бүлэг юм. 2000 онд эдгээр улс орнуудын нэг хүнд ногдох ҮНО (үндэсний нийт орлого) 756-2995 ам.долларын хооронд хэлбэлзэж байв. Мөн өндөр орлоготой улс (high-income economies), бага дунд орлоготой улс (lower-middle-income economies) дээд дунд орлоготой улсыг (upper-middle-income economies) үзнэ үү.</p>
825	Luxembourg Compromise	<p>Люксембургийн харилцан буулт. Энэ нь Европын Эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хүрээнд үүссэн хямралын талаар, Кеннедийн үе шатны хэлэлцээний үеэр зургаан сарын турш хэлэлцсэний дараа 1966 оны 1-р сард гарсан тогтоол юм. Энэ нь Франц, Герман хоёр Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогыг хэрхэн санхүүжүүлэх талаар тохиролцож чадаагүйн шууд шалтгаан байсан юм. Гэсэн хэдий ч гол асуудал нь, бүгд санал нэгдэн гардаг шийдвэрээс олонхын саналаар шийдэх хэлбэрт шилжихээр төлөвлөж байсан нь Францын вето эрх мэдлээ ашиглах чадварыг алдагдуулах байсан учраас үүнд тус улс өөрчлөлт хийхийг оролдож байсан гэдэг нь харагддаг юм. Уг буулт нь санал хураалтын асуултын хувьд санал зөрөлдөх, мөн Кеннедийн үе шатны хэлэлцээний үеийн хөдөө аж ахуйн хэлэлцээний агуулгын хүрээнд хөдөө аж ахуйн салбарт үнэ тогтоох явдлыг дахин ярилцана гэсэн харилцан буулт бүхий тохиролцоонд хүрсэн.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
826	Made-to-measure tariffs	Тусгай захиалгаар, тодорхой хэмжээнд тааруулсан тариф. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлийн зардлаа тооцоод дээр нь нэмээд ердийн ашиг олох боломжийг олгох зорилготой, дөнгөж бага зэрэг дээгүүр хэмжээний тариф. Үйлдвэрүүд өөр өөр өртгийн бүтэцтэй байдаг тул, аж үйлдвэр тус бүр мэдээж Тусгай захиалгаар, тодорхой хэмжээнд тааруулсан тарифын дэмжлэг хүртэж байдаг учраас уг тарифын бүтэц нь ярвигтай болоход хүргэдэг байна. Зарим нь үүнийг "Тухайн нөхцөлд тааруулсан тарифууд" (tailor-made tariffs) гэж нэрлэдэг.
827	Madrid Agreement Concerning the International Registration of Marks	Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр. Үүнийг 1891 оны 4-р сарын 14-нд байгуулагдсан бөгөөд 1967 оны 7-р сарын 14-ний өдөр Стокольмд хамгийн сүүлд шинэчлэгдсэн. Энэхүү хэлэлцээрт 1996 оны 4-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Мадридын хэлэлцээрийн протоколын дагуу 1989 онд нэмэлт оруулсан байна. Энэхүү хэлэлцээр болон протокол нь Мадридын холбооны нэг хэсэг юм. Хэлэлцээр ба Протокол нь тусдаа хэлэлцээрүүд бөгөөд нэг гишүүнчлэл нь нөгөөгөөсөө хараат бус байх боломжтой. Хэлэлцээрт заасны дагуу гишүүн орнуудын харьяат иргэд гарал үүслийн улсад бүртгэгдсэн бараа, үйлчилгээнд хамаарах барааны тэмдгийнхээ олон улсын хамгаалалтыг ДОӨБ (WIPO)-ын Оюуны өмчийн олон улсын товчоонд мэдүүлснээр хангуулах боломжтой болно. Товчоонд бүртгүүлснээр тухайн улс тус бүрд тусад нь бүртгүүлэх зардал, цаг хугацааг хэмнэдэг. Протокол нь энэхүү системийг илүү олон улс орнуудад хүлээн зөвшөөрөхөд чиглэгддэг.
828	Madrid Agreement for the Repression of False or Deceptive Indications of Source on Goods	Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх худал ба хуурамч үзүүлэлтүүдийг таслан зогсоох Мадридын хэлэлцээр. Энэ нь Мадрид хотод 1891 оны 4-р сарын 14-нд байгуулагдсан бөгөөд хэд хэдэн удаа шинэчилсэн. Хамгийн сүүлд 1967 онд шинэчилсэн байна. Үүнийг ДОӨБ (WIPO) удирдаж байдаг. Барааны эх үүсвэрийг хуурамчаар эсвэл бусдыг төөрөгдүүлэхээр тусгасан барааг хураах нөхцөл, арга хэлбэрийг хэлэлцээрт тусгасан болно. Энэ нь бараа бүтээгдэхүүний эх үүсвэрийг тавихдаа олон нийтийг төөрөгдүүлэх чанартай илэрхийлэл ашиглахыг хориглодог. Гишүүн улс тус бүр ерөнхий шинж чанараасаа хамааран ямар нэршлийг хэлэлцээрт хамруулахгүй байхаа шийдэж болно. Гарал үүслийн нэршлүүд (appellations of origin), газарзүйн заалт (geographical indications), Лиссабоны гэрээг (Lisbon Agreement) үзнэ үү.
829	Madrid Union	Мадридын холбоо. Олон улсын барааны тэмдгийг бүртгэх тухай Мадридын хэлэлцээр.
830	Maghreb states	Магребын улсууд. Энэ нь 1976 онд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС) -тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, түүний зах зээлд нь нэвтрэх хөнгөлөлттэй бөгөөд харилцан адил байх шаардлагагүй нөхцөл эдлэх болсон Алжир, Марокко, Тунис зэрэг улстай холбоотой. Мөн Араб Магребын холбоог (Arab Maghreb Union) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
831	Mailbox	Шуудангийн хайрцаг. Оюуны өмчийн эрхийн худалдааны холбоотой асуудлаарх хэлэлцээрт заасан шаардлагад хэрэглэдэг энэхүү нэр томьёоны дагуу гишүүд дараах шаардлагыг хангасан байх ёстой. (а) хөдөө аж ахуй, эмийн бүтээгдэхүүнтэй холбоотой патент авах мэдүүлэг гаргах аргатай байх (б) ийм төрлийн бүтээгдэхүүний маркетингийн (худалдааны зар сурталчилгаа) онцгой эрх (EMRs) олгох аргыг тусгах.
832	Malevolent mercantilism	Хорсолтой байдлаар Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Барааны худалдааны онол. Мөн Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) үзнэ үү.
833	Managed liberalism	Зохицуулалттай либерализм. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн одоогоор байгаа гишүүд хоорондын хэлэлцээрийн дагуу зарим салбарыг хэлэлцээрийн үйл ажиллагаанаас чөлөөлөх практикийг тайлбарлахад ашигладаг, үүнийг ялангуяа шинэ гишүүд хэлэлцээрт нэгдэн орох үед ашигладаг. Мөн хэсэгчилсэн чөлөөлөлтийг (block exemptions) үзнэ үү.
834	Managed trade	Зохицуулалттай худалдаа. Энэ нь зарим салбар эсвэл бүтээгдэхүүний худалдаа зах зээлийн эрэлт хэрэгцээний зарчимд тулгуурлахгүй явагддаг олон улсын худалдааны нэг төрөл. Үүнд сайн дураараа хязгаарлалт хийх, зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт, тоон хязгаарлалт болон тарифын бус арга хэмжээ зэрэг орно. Эдгээр тохиолдлуудад зохицуулалттай худалдааны зорилго нь дотоодын үйлдвэрлэлийг ямар нэгэн шалтгаанаар эсвэл зорилгоор хамгаалах явдал юм. Зохицуулалттай худалдааны орчин үеийн хувилбарууд нь ерөнхийдөө зах зээлийг хязгаарлахгүй, харин ихэвчлэн гуравдагч орны экспортлогчдод хохирол учруулахуйц арга хэмжээ хэрэгжүүлэх зэргээр экспортоо тоон зорилттойгоор нэмэгдүүлэхэд оршино. Зарим тайлбарлагчид үндэстэн дамнасан корпорацийн нэгж хооронд хийж буй худалдааг зохицуулалттай худалдаа гэж үздэг. Мөн шударга худалдаа (fair trade), саарал бүсийн арга хэмжээ (grey-area measures), Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр (Multi-Fibre Arrangement), сайн дурын импортын өргөжүүлэлд зэргийг (voluntary import expansion) үзнэ үү.
835	Manila Action Plan for APEC	Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) орнуудын Манилагийн үйл ажиллагааны төлөвлөгөө. Энэ нь 1996 оны 11-р сард Манилад болсон АПЕК-ийн гишүүн орнуудын удирдагчдын уулзалтаар батлагдсан ажлын хөтөлбөр. Энэ нь АПЕК-ийн орнуудын бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтын үйл ажиллагааны төлөвлөгөө, АПЕК-ийн хүрээнд байгуулагдсан янз бүрийн байгууллагуудын бэлтгэсэн ажлын хөтөлбөрүүдийг нэгтгэдэг.
836	Mansholt proposals	Маншолтын санал. Кеннедигийн үе шатны хэлэлцээний үеэр Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн комиссар Сикко Маншолтын нэрээр нэрлэгдсэн хоёр санал байдаг. Эхнийх нь ЕЭЗХН-ийн үр тарианы үнийг тогтоох нийтлэг журмыг тогтоох асуудал байв.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Санал болгож буй зохицуулалтын үр дүнд үр тарианы үнэ ханш нь буурсан гишүүн орнуудад ЕЭЗХ нь шууд нөхөн төлбөр олгох ёстой. Хоёр дах санал нь хэлэлцээний үеэр ЕЭЗХ-ны хөдөө аж ахуйн талаархи саналын тойм. Үндсэндээ гурван жилийн турш montant de soutien (дотоод дэмжлэгийн түвшин) -ийг харилцан адил байх зарчим дээр үндэслэн тогтоохыг санал болгодог. ЕЭЗК эхний санал дээр дотооддоо тохиролцоонд хүрч чадсан боловч яриа хэлэлцээний түншүүд нь хоёр дах саналын хувьд тохиролцоонд хүрч чадаагүй. Түүнчлэн хөдөө аж ахуй ба ТХЕХ-ийг (agriculture and the GATT) үзнэ үү.</p>
837	Manufacturing Clause	<p>Үйлдвэрлэлийн тухай заалт. Энэ нь Европын хамтын нийгэмлэгээс 1983 онд ТХЕХ-ийн (GATT) зөвлөлд гаргасан маргаан. АНУ-ын 1982 оны Нийтийн эрх зүйн хуулийн 601-р хэсэг (Үйлдвэрлэлийн заалт), зарим тохиолдолд, АНУ эсвэл Канадад бүтээснээс бусад тохиолдолд зохиогчийн эрхэд хамаарах драмын бус утга зохиолын бүтээлийг импортлох эсвэл олон нийтэд түгээхийг хориглодог. “Үйлдвэрлэл” гэсэн тодорхойлолтод үсэг өрөлт (typesetting), хэвлэл (printing) ба хавтаслалт (binding) зэрэг орно. Үйлдвэрлэлийн заалтыг анх 1891 онд баталж, хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. 1976 оны нэмэлт өөрчлөлтөд 1982 оны 7-р сарын 1-ээс өмнө хэрэглэгдэх жаргаж байгаа буюу хуучирч буй хууль зүйн заалт орсон. Энэхүү хуулийн хэрэгжих хугацаа дууссан бөгөөд хуулийг 1982 оны 7-р сарын 13-ны өдрөөс эхлэн 1986 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр дахин баталсан. Энэхүү асуудлын гол зорилго нь нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль нь Нэгдэн орох тухай түр протоколын дагуу хийгдсэн эсэхийг хянах байв. Энэхүү Нэгдэн орох тухай түр протокол нь ТХЕХ-ийн гишүүдэд 1947 оны 10-р сарын 30-ны өдрөөс өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан журмаа ТХЕХ-ийн журамд нийцэхгүй ч гэсэн бүрэн дагаж мөрдөх боломжийг олгодог. Үйлдвэрлэлийн заалтын тухай хууль тогтоомжийн өөрчлөлт нь түүнийг “одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомж” гэдгээр хасах шаардлагагүй гэж маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн үзсэн. Гэсэн хэдий ч 1976 оны хуульд дээрх заалтыг оруулсан нь ТХЕХ-т илүү сайн нийцүүлэх бодлогын өөрчлөлт гэж үзэв. Хуулийн хүчин төгөлдөр хугацааг хойшлуулан 1982 онд дахин баталсан хууль нь энэхүү илүү сайн нийцүүлэхэд чиглэсэн өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ болсон тул ТХЕХ-тэй нийцэхгүй байх хэмжээ нэмэгдсэн байна. Үүний дагуу маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг нь Европын хамтын нийгэмлэгийн талд асуудлыг шийдсэн.</p>
838	Marginalisation	<p>Туйлын бага ашиг, үр бүтээмжтэй эдийн засгийн тухай ойлголт. ЮНКТАД (UNCTAD) хоёр түвшинд байдаг нарийн төвөгтэй үзэгдэл гэж үздэг зүйлийг тайлбарлахыг оролдохдоо энэхүү нэр томьёог илүүд үзжээ. Нэгдүгээрт, тухайн нийгэм дэх эмзэг бүлгүүдэд хамаарал бүхий нийгмийн нөхцөл байдал гэж үзэж болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Хоёрдугаарт, энэ нь бүх улс оронд нөлөөлж, эдийн засаг, хөгжлийн хэтийн төлөв байдалд аюул учруулж буй эдийн засгийн үзэгдэл байж болно. Ийм байдалд өртсөн орнууд интеграцын ач холбогдлыг хүртэх нь хэцүү байж магадгүй юм. Marginalisation буюу туйлын бага ашиг, үр бүтээмжтэй эдийн засгийн тухай ойлголт нь даяаршилтай зэрэгцэн явагддаг үйл явц гэж тооцогддог. Зохисгүй эдийн засгийн бодлого нь түүнийг үйл явцыг хурдасгана.</p>
839	Margin of dumping	<p>Демпингийн зөрүү. Энэ нь демпингийн эсрэг авах арга хэмжээний боломжит хэмжээ буюу демпингтэй барааны хэвийн үнэ (normal value) болон экспортын үнэ хоёрын хоорондын зөрүү.</p> <p>Демпингийн зөрүү хэмжээг тогтоох журмыг ДХБ-ын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VI заалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт тусгасан. Эрх бүхий байгууллагаас демпингийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлж, татвар ногдуулахдаа зөвхөн зөрүү хэмжээг арилгах түвшинд байлгах ёстой.</p> <p>Де-минимис буюу үлэмж бага хэмжээний демпингийн зөрүү (De minimis dumping margins), Бага татвар зарчмыг (esser-duty principle) үзнэ үү.</p>
840	Margin of preference	<p>Хөнгөлөлтийн зөрүү/Хөнгөлөлт үзүүлэх зөрүү. Зарим төрлийн чөлөөт худалдааны зохицуулалтын хөнгөлөлтийн системийн хүрээнд тогтоосон төлбөл зохих татвар болон үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (MFN) дагуу төлбөл зохих татвар хоёрын хоорондын ялгаа буюу зөрүү.</p>
841	Marine Mammal Protection Act	<p>Далайн хөхтөн амьтдыг хамгаалах тухай хууль. Мөн Тунагийн хэрэг (Европын эдийн засгийн нийгэмлэг, АНУ, 1994) ((Tuna) (European Economic Community-United States, 1994)), Тунагийн хэрэг (Мексик-АНУ, 1991) (Tuna (Mexico-United States, 1991))-ийг үзнэ үү.</p>
842	Maritime transport services	<p>Далайн тээврийн үйлчилгээ. Олон улсын тээвэр, туслах үйлчилгээ, боомтуудад нэвтрэх, ашиглах хүрээнд ҮХЕХ-ээр хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор 1995 онд Үйлчилгээний Худалдааны Зөвлөлөөс Далайн тээврийн үйлчилгээ (NGMTS)-ийн хэлэлцээний бүлгийг байгуулсан. NGMTS нь хэлэлцээгээ 1996 оны 6-р сарын 30-ны өдөр дуусгахаар төлөвлөж байсан боловч тохиролцсон хугацаанд үр дүнд хүрэх боломжгүй болох нь батлагдсан байна. ҮХЕХ-ийн XIX зүйлд заасны дагуу, үйлчилгээний яриа хэлэлцээний шинэ үе шатны нэг хэсэг болгож, далайн тээврийн үйлчилгээний талаарх хэлэлцээг 2000 онд дахин эхлүүлнэ. Мөн Каботаж буюу Дотоодын далайн боомтууд болон нисэх онгоцны буудлуудын хооронд далайн тээврийн болон агаарын тээврийн үйлчилгээ эрхлэх эрх (cabotage), Жонсийн хууль (Jones Act), дэвшилтэт либералчлалыг (progressive liberalisation) үзнэ үү.</p>

843 Market access

Зах зээлд нэвтрэх. Энэ нь олон улсын худалдааны үндсэн ойлголтуудын нэг бөгөөд тухайн бараа, эсхүл үйлчилгээ нь бусад улсын зах зээлд тэдний дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй нь хэрхэн өрсөлдөх боломжийг тайлбарладаг. ДХБ-ын хэлэлцээрийн дагуу гишүүн орны бараа бүтээгдэхүүн бусад гишүүн орны зах зээлд үл ялгаварлах нөхцөлийн дагуу нэвтрэх болохыг заасан хууль ёсны нэр томьёо. ДХБ-ын хүрээнд зах зээлд нэвтрэх ойлголтыг барааны худалдааны хувьд хил дээрх буюу тарифын болон тарифын бус арга хэмжээ, харин үйлчилгээний худалдааны хувьд зах зээлийн дотоодын зохицуулалтаар илэрхийлдэг. Уламжлал ёсоор олон талт худалдааны бодлого нь зах зээлийн нөхцөлийг урьдчилан таамаглагдахуйц, болж өгвөл илүү чөлөөтэй болгохыг эрэлхийлж ирсэн. Энэ нь тарифыг бууруулах, тэдгээрийг доогуур түвшинг тогтоох “үүрэг амлалт авхуулах” замаар зохицуулдаг. Үүрэг хүлээж заавал биелүүлнэ гэдэг нь хөнгөлөлт, буултын жагсаалтад тодорхой заасан түвшингээс дээгүүр нэмэгдүүлэхгүй гэж гэрээгээр хүлээсэн үүрэг амлалт. Гадаад зах зээлд нэвтрэхэд учирч буй саад тоггорыг арилгах, тухайлбал тарифын бус арга хэмжээ хэлбэрээр хэрэгжүүлж буй арга хэмжээг бууруулах нь илүү төвөгтэй байдаг, учир нь тэдний зарим нь хууль зүйн нарийн тодорхойлолтоос зайлсхийсэн байх магадлалтай байдаг. Иймд Засгийн газар хооронд хэлэлцээ хийх замаар эдгээр арга хэмжээг хууль бус хэмээн зарлан тодорхойлох тогтсон арга байдаг. Үйлчилгээний худалдааны эрчимтэй өсөлт болон даяаршлын үйл явцын улмаас хилийн дотоод зах зээлд нэвтрэх саад бэрхшээлүүд нь анхаарал татах болсон байна. ДХБ-ын хэлэлцээрүүдийн дундаас, ҮХЕХ ийн хүрээнд худалдааг хязгаарлаж буй хууль журмын зохицуулалтын асуудлыг хамгийн гүнзгий хэлэлцсэн байдаг бөгөөд бусад эрх зүйн актууд, жишээ нь Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн хүрээнд мөн дотоодын дүрэм журмын зохицуулалтыг хэлэлцээрээр зохицуулах асуудлыг хөндөж байгаа. Эдгээр дүрмийн талаарх мэдээлэл нь бүрхэг байгаа тул өрсөлдөөний бодлогыг ДХБ-ын тогтолцоонд оруулах асуудал яригдаж байгаа. Өрсөлдөөний хамрах хүрээний хувьд зах зээлд нэвтрэх бодлогыг тухайн зах зээл дээр үр дүнтэй өрсөлдөх чадвар гэж тодорхойлдог. Үүний зорилго нь өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа болон эрх зүйн зохицуулалтыг зохицуулах, арилгахад оршино. Хэрэв боломжтой бол зах зээлд нэвтрэх тухай энэ хоёр ойлголтыг нэгтгэх нь олон улсын зах зээлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хүртээмж нь зах зээлд нэвтрэх асуудалд мөн нөлөөлж болох юм. Зарим тодорхой сэтгэгчдийн хувьд зах зээлд нэвтрэх тухай энэхүү үзэл баримтлал нь хэт явцуу үзэл бөгөөд үүнийг зах зээлд бие төлөөлөл/төлөөлөгчийн газар байгуулах оролцооны хэлбэрийн (market presence) илүү ээлтэй үзэл баримтлалаар солих хэрэгтэй гэж үздэг. Мөн өрсөлдөөний боломжийн тэгш байдал (equality of competitive opportunity), хөдөө аж ахуйн салбарын зах зээлд нэвтрэх (market access for agriculture), үйлчилгээний зах зээлд нэвтрэх (market access for services), үндэсний нөхцөл (national treatment), үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
844	Market access for agriculture	Хөдөө аж ахуйн салбарын зах зээлд нэвтрэх. Энэ нь Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр хөдөө аж ахуйн асуудлаар тохиролцсон тариф, тоо хэмжээний хязгаарлалттай тариф зэргийг хамарсан нэр томьёо. Энэхүү хэлэлцээ нь зах зээлд нэвтрэх, дотоодын дэмжлэг, экспортын татаас гэсэн гурван чухал элементийг багтаасан бөгөөд эдгээр асуудлыг багцаар нь хэлэлцэн хүлээн зөвшөөрөх шаардлагатай байв. Уругвайн үе шатны хэлэлцээ нь худалдааг гажуудуулсан арга хэмжээг өргөжүүлэхийг хязгаарлаж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хувьд зах зээлд нэвтрэх шинэ боломжийг нээж өгчээ.
845	Market access for services	Үйлчилгээний зах зээлд нэвтрэх. ҮХЕХ нь үйлчилгээ болон үйлчилгээний ханган нийлүүлэгчдэд зориулж зах зээлд нээлттэй, үл ялгаварлах зарчмаар нэвтрүүлэх зорилтыг сурталчлан дэмждэг. Энэхүү хэлэлцээр нь зах зээлд нэвтрэх асуудлыг хэрхэн ойлгохыг тодорхойлоогүй боловч XVI зүйлд үйлчилгээний худалдаанд хэрэгжүүлж, батлахыг хориглосон зургаан төрлийн арга хэмжээг жагсаасан болно. Эдгээр нь (i) үйлчилгээг нийлүүлэгчдийн тоог хязгаарлах, (ii) үйлчилгээ үзүүлэх нийт үнийн дүнгийн хязгаарлалт, (iii) үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчдийн нийт тооны хязгаарлалт, (iv) үйлчилгээ үзүүлэхээр ажилд авсан хүнийх нь тоог хязгаарлах (v) аж ахуйн нэгжийн хязгаарлалт эсвэл хамтарсан компанийн шаардлага, (vi) гадаадын өөрийн хөрөнгийн түвшинд тавих хязгаарлалт. Зах зээлд нэвтрэх асуудлыг зохицуулж байдаг эдийн засгийн эрэлт хэрэгцээг судлах шаардлагыг хүчингүй болгох зэрэг багтдаг байна.
846	Market disruption	Зах зээлд учруулсан хохирол. Энэ нь хамгаалалтын арга хэмжээг ногдуулах үндсэн үндэслэлүүдийн нэг. Энэхүү нөхцөл байдал нь импортын урсгал нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэгчдийн бизнес эрхлэх чадварт ноцтой дарамт учруулснаар үүснэ. Хөвөн нэхмэл, даавуун эдлэлийн олон улсын худалдаатай холбоотой Урт хугацааны зохицуулалтын хүрээнд энэ асуудал нь гол ойлголт болон гарч ирсэн бөгөөд нэхмэл, даавуун эдлэлийн импортын урсгал хэд хэдэн худалдааны түнш улсаас маш бага үнээр гэнэт их хэмжээгээр орж ирснээр асуудал үүссэн байдаг. Энэхүү асуудлыг Хөвөн даавуун Зохицуулалт. Энэхүү хэлэлцээрийн албан ёсны нэршил нь сүлжмэл, нэхмэл, оёмол эдлэлийн худалдааны асуудлаарх олон улсын хэлэлцээр рүү (Multi-Fibre) цааш нь уламжилсан байдаг.
847	Market dominance	Зах зээлд давамгайлах. Олон улс орнуудад өрсөлдөөний бодлогын хэрэгцээг бий болгох үндсэн үндэслэл нь юм. Зах зээлийн давамгайлал гэдэг нь нэмүү өртгийн сүлжээний анхан шат болон эцсийн шат дамжлагад ажилладаг бусад компаниудын зан төлөвт нөлөөлөх чадвар. Ихэнх тохиолдолд өрсөлдөөний бодлого нь зах зээлийн ноёрхол байгааг хүлээн зөвшөөрдөг боловч түүний эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг арилгах асуудалд анхаардаг. Мөн Монополын эсрэг(antitrust laws), зах зээлийн хүчин чадлын асуудлыг (market power) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
848	Market economy	Зах зээлийн эдийн засаг. Үнийн механизм нь юуг үйлдвэрлэж, худалдаалахыг тодорхойлдог эдийн засаг, гэхдээ зах зээлийн үнийн механизмыг татаас болон засгийн газрын бусад оролцоо гажуудуулж байдаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг (centrally-planned economies) мөн үзнэ үү.
849	Market-expansion dumping	Зах зээлээ тэлэх демпинг. Зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхийн тулд экспортын үнийг хямд тогтоож, хэрэглэгчийг татах, бүтээгдэхүүнийхээ чанарыг мэдрүүлэх. Мөн Демпинг (dumping) үзнэ үү.
850	Market failure	Зах зээлийн доголдол. Энэ нь бүрэн төгс ажиллаж чадахгүй байгаа зах зээлийн талаарх эдийн засагчдын өгсөн нэр томьёо. Энэ нь зах зээл нурсан гэсэн үг биш. Тухайн зах зээлд оролцогчид мэдээллээр хангалтгүй байх, цөөн тооны худалдан авагч, цөөн тооны худалдагч байх (монопол эсвэл монопол нөхцөл байдал) эсвэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал, ашиг нь зах зээлийн зөвхөн зарим оролцогчдод хамааралтай байх зэрэг нөхцөлд үүсэж болно.
851	Marketing boards	Маркетингийн зөвлөл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд гаргах, экспортлох зорилгоор үйлдвэрлэгч орнуудаас заримдаа хувийн хэвшлийн болон төрийн байгууллагуудыг байгуулдаг. Тэдгээрийн чиг үүрэгт илүү үр ашигтай үйлдвэрлэх, хадгалах, боловсруулах, шинэ хэрэглээг тодорхойлох судалгааны санхүүжилт байж болно. Маркетингийн зөвлөл нь заримдаа экспортын хууль ёсны монопол эрхтэй байдаг. Тэдгээрийн захиргааны зардлыг ихэвчлэн үйлдвэрлэгчдэд ногдуулдаг татвараар санхүүжүүлдэг. Нэг цонхны худалдаа (single-desk selling), улсын арилжаа (state trading) зэргийг үзнэ үү.
852	Market-led integration	Зах зээлийн баримжаатай интеграцчилал. Энэ нь бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулж эсвэл түүний сурталчгааны замаар бий болох бүс нутгийн эдийн засгийн интеграци. Энэхүү интеграци нь нэгдэлд зориулан засгийн газар хоорондын бүтэц, хамрах хүрээний оролцоогүй хэрэгжих магадлалтай юм. Бодлогын баримжаа бүхий интеграцчилал (policy-led integration) мөн үзнэ үү.
853	Market-opening initiatives	Зах зээлийг нээх санаачилга. Ялангуяа АНУ-ын экспортын эсрэг тууштай хэрэгжүүлж буй худалдааны саад тотгорыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлоход АНУ-ын ашигладаг нэр томьёо. Цөөхөн улс оронд ийм санаачилгыг амжилтад хүргэх эдийн засгийн хүч байдаг. Ердийн жишээ гэвэл хоёулаа Японы эсрэг чиглэсэн Зах зээлд суурилсан тухайн салбарын хүрээний 1985 оны яриа хэлэлцээ, 1989 оны Бүтцийн саад бэрхшээлийн санаачилга юм. Зах зээлийг нээх санаачилга нь ихэвчлэн 301-р хэсгийн дагуу хэрэгждэг.
854	Market-Oriented Sector-Specific talks	Зах зээлийн чиг баримжаатай, тухайн салбарын хүрээний яриа хэлцэл. Үүнийг MOSS хэлэлцүүлэг гэдэг. Японы ойн аж ахуйн бараа бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, электроник бараа, харилцаа холбооны хэрэгсэл, авто сэлбэг хэрэгсэл, тээврийн

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>хэрэгслийн барааны зах зээлийг нээх зорилгоор 1985 онд АНУ-аас гаргасан санаачилга. Энэхүү санаачилгын үр дүнд Японы харилцаа холбооны салбарыг зохицуулж буй бодлогыг либералчлах, 1800 орчим бараа бүтээгдэхүүний тарифыг бууруулах зэрэг зарим нэг амжилтад хүрсэн боловч үр дүн нь бүхэлдээ сайнгүй байв. АНУ-ын бараа бүтээгдэхүүнийг Япон улс руу зарим тохиолдлоос бусад тохиолдолд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр чөлөөтэй нэвтрүүлнэ гэсэн Японы тунхаглал нь хангалтгүй байв. Мөн Бүтцийн саад тотгорыг арилгах санаачилга (Structural Impediments Initiative), Эдийн засгийн шинэ түншлэлийн талаарх АНУ-Японы эрх зүйн бүтэц, хамрах хүрээг (United States-Japan Framework for a New Economic Partnership) үзнэ үү.</p>
855	Market power	<p>Зах зээлийн хүчин чадал. Монополын эсрэг хууль тогтоомжийн үндсэн суурь ойлголт. Энэ нь пүүсүүд борлуулалтаа бууруулж хохиролгүйгээр үнээ өсгөх чадвартай байх болно гэсэн үзэл дээр суурилдаг. Монополын эсрэг хууль нь зах зээл дээрх үнийн өрсөлдөөн оршиж байх нөхцөлийг хангахад чиглэгддэг. Мөн Өрсөлдөөний бодлого (competition policy), зах зээлийн ноёрхлыг (market dominance) мөн үзнэ үү.</p>
856	Market presence	<p>Зах зээлд бие төлөөлөл/төлөөлөгчийн газар байгуулах. Амжилтад хүрэхийн тулд компаниуд импортлогч орны зах зээлд нэвтэрнэ гэсэн ойлголтоос илүүтэйгээр тухайн оронд зарим төрлийн үйл ажиллагаагаа эрхлэх бие төлөөлөл/төлөөлөгчийн газраа байгуулах шаардлагатай юм гэсэн ойлголт. Энэ нь компаниуд хөрөнгө оруулах хүсэлтэй бөгөөд тухайн зах зээлд өрсөлдөх хангалттай боломж бий гэсэн ухагдахууныг агуулдаг.</p> <p>Арилжааны төлөөлөл/төлөөлөгчийн газар (commercial presence), Төлөөлөгчийн газар байгуулах эрх (right of establishment) үзнэ үү.</p>
857	Market-seeking investment	<p>Зах зээл эрэлхийлсэн хөрөнгө оруулалт. Нэг буюу хэд хэдэн зах зээлд ханган нийлүүлэлтийн хувьд зонхилох зорилготой хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтад ашигладаг нэр томьёо. Мөн тарифыг огцом өсгөхийг (tariff-jumping) үзнэ үү.</p>
858	Market-sharing arrangements	<p>Зах зээлийг хуваалцах тохиролцоо. Тухайн орон нутгийн үйлдвэрлэл дэх тодорхой салбарын эзлэх хувийг тодорхой түвшнээс доогуур түвшинд хүргэхгүй байхын тулд засгийн газраас дэмжиж, хэрэгжүүлдэг хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрт бараа, үйлчилгээний худалдаа хамрагдаж болно. Үйлчилгээний худалдааны хувьд хоёр чухал жишээ бол агаарын тээврийн үйлчилгээний хоёр талын гэрээ болон Усан онгоцны тээвэрлэлтийн тухай бага хурлын ёс зүйн хэм хэмжээний талаарх НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) конвенц юм (UNCTAD Convention on a Code of Conduct for Liner Conferences). Тодорхойлсон [зах зээлийн] хувь хэмжээ тус бүрийн дунд хүчтэй өрсөлдөөн байж болох юм. Сайн дураараа хязгаарлалт хийх зохицуулалт нь мөн зах зээлийг хуваалцах (market-sharing) хэлбэр юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
859	Market transparency	Зах зээлийн ил тод байдал. Зах зээлд оролцогчид, тухайн зах зээлийн талаар мэдээллийг олж авсны үндсэн дээр тухайн зах зээл хэрхэн өөрчлөгдөх хандлагатай байгааг үнэлэх боломж. Сайн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэлд үйлдвэрлэл, борлуулалт, үнэ, үйлдвэрлэл зэрэг статистик мэдээлэл багтана. Хөрөнгө оруулалтын томоохон саналуудын урьдчилсан мэдүүлгийг авах нь зүйтэй. Олон улсын түүхий эдийн олон хэлэлцээрүүд нь зах зээлийн ил тод байдлыг гол зорилгоо болгосон байдаг. Захиргааны зохицуулалттай олон улсын түүхий эд, материалын хэлэлцээрийг (administrative international commodity agreements) мөн үзнэ үү.
860	Marks of origin	Гарал үүслийн тэмдэг. Энэ нь ихэвчлэн "...-д. үйлдвэрлэсэн." эсвэл "...-ын бүтээгдэхүүн" гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд тухайн барааг үйлдвэрлэсэн улсаас гарал үүсэлтэй болохыг илэрхийлдэг бүтээгдэхүүний тэмдэг. Гарал үүслийн гэрчилгээ (certificate of origin), гарал үүслийн дүрмийг (rules of origin) үзнэ үү.
861	Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр. Заримдаа ДХБ-ын хэлэлцээр гэгддэг энэхүү хэлэлцээрийг 1994 оны 4-р сарын 15-нд Марракешт болсон ДХБ-ын Сайд нарын бага хурлын үеэр баталсан. Энэхүү хэлэлцээрээр Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулсан. Энэхүү хэлэлцээр нь өөрийн эрх зүйн хүрээнд, олон талт болон Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүдийг дөрвөн хавсралтууддаа зааж өгсөн байдаг. Энэхүү хэлэлцээр нь 1995 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Хавсралт 1-д дараах олон талт хэлэлцээрүүд багтсан болно. Үүнд, 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр, Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр, Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээний асуудлаарх хэлэлцээр, ДХБ-ын Текстил (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон оёмол хувцасны тухай хэлэлцээр, Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр, Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын авах арга хэмжээний тухай хэлэлцээр, Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VI заалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VII заалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Гаалийн үнэлгээ), Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр, Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр, Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр . (Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр - Уругвай), Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр. Хавсралт 2 нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрээс бүрдэнэ. Хавсралт 3 нь Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр юм. Хавсралт 4-т Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг, Худалдааны бодлогыг хянан хэлэлцэх механизм, ДХБ-ын Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүдээс бүрдсэн болно.
862	Material injury	Материаллаг хохирол. Мөн Хохирол учруулахыг (injury) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
863	Material transfer agreement	Материал дамжуулах тухай хэлэлцээр. Генетикийн материалыг ханган нийлүүлэгч/хэрэглэгчээс нөгөө нэгэн хэрэглэгч рүү шилжүүлэхээс хамгаалахад ашигладаг хууль эрх зүйн акт. Ийм хэлэлцээрийг худалдааны нууцын тухай хуульд хамаарна гэж үздэг.
864	Maximum-minimum tariff	Тарифын дээд ба доод түвшин. Гаалийн байгууллагаас мөрдөж хэрэгжүүлэх импортын бараа бүтээгдэхүүний зарим хэсэгт болон бүхэлд нь тогтоосон тарифын дээд болон доод хэмжээ бүхий тарифын жагсаалт. Ийм тарифыг ихэвчлэн үндэсний хууль тогтоох байгууллагууд бие даан тогтоодог байсан. Харьцангуй нээлттэй, чөлөөт зах зээл бүхий орнуудад тарифын доод түвшинг тогтоон урамшуулж харин хаалттай зах зээл гэж үзсэн орнуудад өндөр тариф тогтоохыг зорьж байв. Үндэсний нэн тааламжтай ерөнхий нөхцөлийг бий болгосноор, ДХБ-ын гишүүн орнуудын дунд энэ замаар үүнийг ашиглахыг хориглосон боловч, ДХБ-ын гишүүн бус орнуудтай хийх тэдний худалдааны агуулгын хүрээнд бол энэ арга нь хууль ёсны хэвээр байх болно. Мөн уламжлалт тогтсон тариф (conventional tariff), сөрөг харилцан адил байх хамаарлыг (negative reciprocity) үзнэ үү.
865	Measure	Арга хэмжээ. Ерөнхийдөө Засгийн газрын өмнөөс буюу Засгийн газраас хэрэгжүүлдэг аливаа хууль, дүрэм, журам, зохицуулалт, бодлого, практик, арга хэмжээ.
866	Mediterranean Agreements	Газар дундын тэнгисийн орнуудын хэлэлцээр. Эдгээр нь Турк, Кипр, Мальтагаас бусад Европын хамтын нийгэмлэг ба Газар дундын тэнгисийн орнуудын хооронд хийсэн хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр юм. Хамтын нийгэмлэгийн зүгээс тэдгээрийг хуучин болон шинэ үеийн хэлэлцээр хэмээн хуваадаг. 1970-аад онд байгуулагдсан хуучин хэлэлцээрээр түнш улс орнуудад Европын хамтын нийгэмлэгийн зах зээлд хөнгөлөлттэй бөгөөд харилцан адил бус нөхцөлөөр нэвтрэх боломжийг олгодог. Сүүлийнх нь буюу 1990-ээд оны хэлэлцээрээр түншүүдийн хооронд чөлөөт худалдаа хийх боломжийг бүрдүүлжээ. Мөн [ЕХ-нд] Нэгдэх тухай гэрээнүүд (Association Agreements), Евро-Газрын дундад тэнгисийн эдийн засгийн бүс (Euro-Mediterranean Economic Area), Европын хэлэлцээрийг (Europe Agreements) үзнэ үү.
867	Melanesian Spearhead Group Trade Agreement	Меланезянгийн үзүүр хэмээх бүлгийн худалдааны хэлэлцээр. 1999 онд Папуа Шинэ Гвиней, Соломоны Арлууд ба Вануату улсуудын хооронд байгуулсан худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийн хэлэлцээр. Хэлэлцээрт тарифыг бууруулах, худалдааны хязгаарлалтыг арилгах хуваарийг тусгаагүй болно.
868	Mercantilism	Меркантилизмын онол. Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол. 17-р зууны онол бөгөөд одоо ч ашиглагддаг хэвээр байгаа. Олон улсын худалдааны зорилго бол дэлхийн баялгаас хүртэх хувь хэмжээг алт болон мөнгөн зоос/гулдмай хэлбэрээр, харин орчин үед бол валютын хэлбэрээр нэмэгдүүлж, хуримтлуулах ёстой гэж үздэг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Түүний үзэж буйгаар энэ нь үндэсний баялаг, эрх мэдэлд хүрэх арга хэрэгслийг хүчтэй онцолсон шинж чанартай байсан. Ирвиний (1996) тэмдэглэснээр бараг бүх меркантилистууд дараах саналтай санал нэг байв. Үүнд: боловсруулах үйлдвэрлэлийн экспорт ашигтай, харин түүхий эдийн экспорт (гадаадын үйлдвэрлэгчид ашиглахад) хортой байсан; түүхий эдийн импортын хувьд давуу талтай бөгөөд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний импорт эдийн засагт хохирол учруулна. Энэхүү санал нь орчин үеийн бодлого боловсруулагчийн хувьд нэлээд танил сонсогдож болно. Гэвч ихэнх меркантилистууд эдийн засгийн хөгжлийг дэмжих хэрэгсэл болгон худалдааг өргөжүүлэхийг дэмжиж байв. Коатс (1987) нь меркантилист үзэл санааны гурван түвшинг ялгаж тайлбарладаг (а) эдийн засгийн бодлогын эцсийн зорилго, зорилтууд, жишээ нь, улс орны баялаг, эрх мэдэл, аюулгүй байдлыг дэмжих (б) дунд хугацааны зорилго нь, жишээ нь, үнэт металлын хангалттай хэмжээний ханган нийлүүлэлт, тогтвортой ханш, худалдааны ээлтэй тэнцэл, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах гэх мэт. (с) дунд хугацааны зорилгод хүрэх арга хэрэгсэлд, экспортын хөнгөлөлт, бэлэн бараа бүтээгдэхүүний импортод тавигдах татвар, үнэт метал экспортлохыг хориглох гэх мэт. Гилпин (1987) нь меркантилизмыг зохистой меркантилизм (үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн) болон хор хөнөөлтэй меркантилизм (империалист тэлэлт, үндэсний өдөөн хатгалга руу чиглэсэн) гэж ялгаатай тодорхойлсон. Меркантилизмыг баримталдаг хүмүүс дэлхийн баялаг тогтмол байна гэж битүүхэн таамагладаг. Тиймээс тэд худалдааг нэг улс нь нөгөөгийнхөө зардлаар л цэцэглэн хөгжих боломжтой нийлбэр нь тэг бүхий үйл ажиллагаа гэж дүрсэлжээ. Иймд меркантилизм нь эдийн засгийн үндсэрхэг үзлийн нэг хэлбэр юм. Сүүлийн хоёр зуун жил ба түүнээс дээш жилийн хугацаанд дэлхийн худалдаа, баялгийн асар их өсөлт нь худалдаа нь үнэндээ эцсийн нийлбэр нь эерэг дүнтэй үйл ажиллагаа болохыг харуулж байна. Мөн үр дүнтэй мэргэшлийн тусламжтайгаар бүгд цэцэглэн хөгжиж чадна гэдгийг харуулж байна.</p>
869	Merchandise trade	<p>Бараа бүтээгдэхүүний худалдаа. Бодит бараа, өөрөөр хэлбэл түүхий эд, хагас болон бүрэн боловсруулсан үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний импорт, экспорт. Мөн үйлчилгээний худалдааг (trade in services) үзнэ үү.</p>
870	Mercosur (or Mercosul)	<p>Меркосур. Энэ нь Өмнөдийн нэгдсэн зах зээл. Одоогийн байдлаар бараа бүтээгдэхүүний худалдааг хамарч байгаа гаалийн холбоо боловч Mercosur-ийн зорилго нь бүх бараа, үйлчилгээг чөлөөтэй нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн хүчин зүйл болон тарифын бус хязгаарлалтыг хөнгөлөх асуудлыг хамарна. Энэ нь 1991 оны 11-р сарын 29-нд Асунсионы хэлэлцээрээр байгуулагдсан бөгөөд 1994 оны 12-р сарын 17-ны өдөр Оуро Претогийн протоколоор нэмэлт оруулж, үндсэндээ институцийн асуудлыг багтаасан болно. Үүнд Аргентин, Бразил, Парагвай, Уругвай орно. Чили улс нь нэгдэх тухай гэрээг 1996 оны 10-р сарын 1-нд байгуулсан.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Боливи улс 1997 оны 3-р сарын 1-ний өдөр мөн нэгдэх тухай гэрээ байгуулсан. Гишүүнчлэл нь АЛАДИ буюу Латин Америкийн интеграцийн холбооны гишүүдэд нээлттэй. Мөн тухайн нутаг дэвсгэр дэх оюуны өмчийн эрхийн зохицуулалтыг уялдуулж, их дээд сургуулийн зэрэглэлийг харилцан хүлээн зөвшөөрөх төлөвлөгөөтэй байгаа. 1995 оны 12-р сард Меркосурын орнууд гаалийн тарифыг нэгтгэх, худалдааны бодлогыг нэгтгэх үйл ажиллагааны хөтөлбөр болох Mercosur 2000-ийг батлав. Меркосурын нарийн бичгийн дарга нарын газар Монтевидео хотод байрладаг. Меркосул бол Португал хэл дээрх хэлэлцээрийн нэр.
871	Merger Treaty	Нэгтгэх хэлэлцээр. Мөн Европын хамтын нийгэмлэгийг (European Communities) үзнэ үү.
872	MFN exemptions	Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг эс хэрэглэх/чөлөөлөгдөх заалт. ҮХЕХ-ийн дагуу гишүүн орнуудад аль нэг өгөгдсөн салбарт үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) баримтлахгүй байх боломжийг олгосон болно. Энэ нь ихэнх тохиолдолд зах зээл хуваалцах хэлэлцээрийн гишүүнчлэл, хөнгөлөлттэй зохицуулалт эсвэл хамтын ажиллагааны хэлэлцээр гэх мэт өмнө нь байгуулагдсан хэлэлцээрийн үүрэг амлалтаас шалтгаалж байдаг. MFN-ийг хэрэглэхгүй байх/чөлөөлөгдөх нөхцөл нь дээд тал нь 10 жил байдаг бөгөөд 5 жилийн дараа дахин хянах ёстой байдаг. ДХБ-ын олон гишүүд ҮХЕХ хүчин төгөлдөр болоход үндэсний нэн тааламжтай нөхцөлийг дагаж мөрдөхгүй байх/чөлөөлөгдөх заалтыг авч хаясан болно. Гэвч тэр цаг үеэс хойш бусад гишүүн орнууд нэгдэн орох үедээ чөлөөлөгдөх эрхтэй болсон байна. Одоогоор байгаа гишүүн улсуудын хувьд Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс чөлөөлөгдөх шинэ нөхцөлийг хасаж авч болох боловч, үүнийг ДХБ-ын Сайд нарын бага хурлаар ДХБ-ын гишүүн улс орнуудын 75%-ийн саналаар л зөвхөн хийгдэх боломжтой. Мөн Үүрэг амлалтыг цуцлах тухай баримт бичгийг ([ногдуулсан] үүргээс чөлөөлөх - Уругвай) (waiver) үзнэ үү.
873	Millennium Round	Мянганы яриа хэлэлцээний үе шат. 1997 онд Европын Комиссын Тэргүүн дэд ерөнхийлөгч Сэр Леон Бриттан 2000 эсвэл 2001 онд явагдах олон талт худалдааны хэлэлцээг шинэ шатанд гаргахыг санал болгосон. Мөн Сиатл хотод болсон Сайд нарын бага хурлыг (Seattle Ministerial Conference) үзнэ үү.
874	Minilateralism	Минилатерализм буюу цөөн тооны талуудын харилцааны онол. Энэ нь цөөн хэдэн улстай нөхөрлөх замаар худалдааны бодлого явуулахыг илүүд үзнэ гэсэн үг. Минилатерал-ын талаар яг тодорхой тодорхойлолт байдаггүй. Энэ нь хоёр талт харилцаанаас арай илүү харилцаа боловч хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрээс арай бага түвшинд тайлбарлагдана. Дөрвөн талт хэлэлцээ гэхдээ энэ утгад нэлээд сайн таарна. Мөн Бүтээлч минилатерализм (creative minilateralism), хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн тухай онол (plurilateralism) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
875	Minimum access tariff quotas	Зах зээлд нэвтрэх хамгийн доод түвшний тарифын квот. Тарифын бус арга хэмжээг тарифт шилжүүлэх үед хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх хамгийн доод түвшний боломжийг олгох механизм. Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр 1986-88 оныг суурь болгон тухайн үеийн импорт, хэрэглээний харьцаанд үндэслэн тодорхой нэг бүтээгдэхүүний хувьд зах зээлд нэвтрэх боломжийг нээх түвшингийн томьёог гаргасан. Суурь оны хугацаанд тухайн барааны импортын хэмжээ нь хэрэглээний 3%-иас бага байсан орнууд хөдөө аж ахуйн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Уругвайн үе шатны хэлэлцээг хэрэгжүүлэх хугацаанд уг импортын зах зээлд нэвтрэх хэмжээг даруй 3% болгож, улмаар 5%-д хүргэх шаардлагатай байв. Түүнчлэн Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр (Agreement on Agriculture), Зах зээлд урсгал түвшинд нэвтрүүлэх тарифын квот (current access tariff quotas), тарифжуулалтыг (tariffication) үзнэ үү.
876	Minimum labour standards	Хөдөлмөрийн суурь стандарт. Мөн Хөдөлмөрийн үндсэн хэмжээг (стандартууд) (core labour standards) үзнэ үү.
877	Mini-trading area	Худалдааны бичил бүс. Энэ нь зарим судлаачдын хувьд чөлөөт худалдааны бүсийг тодорхойлоход ашигладаг нэр томьёо. Гэвч бусад судлаачдын хувьд энэ нь өсөлтийн гурвалжин юм. Агуулга нь юуг илэрхийлж байгааг тодорхой болгоно.
878	Mirror-image reciprocity	Толины тусгал мэт харилцан адил ашигтай байх нөхцөл. Өөр улсад санал болгосон худалдааны нөхцөлийн үр өгөөж нь ашиг нөгөө улсын зүгээс олгох нөхцөлтэй яг таарах болно гэсэн хүсэн хүлээлт. Мөн харилцан адил байх (reciprocity), ашгийн (үнэ ба өртгийн зөрүү ашиг) хувьд харилцан адил байхыг (reciprocity at the margin) үзнэ үү.
879	Mixed Commission	Холимог комисс. Ихэвчлэн хоёр талын төлөөллөөс бүрдэх, хоёр талын худалдааны хэлэлцээний дагуу байгуулагдсан нэгж. Холимог комиссын үүрэг бол хэлэлцээрийн хэрэгжилтийг үе шаттай хянах явдал. Мөн Худалдааны хамтарсан хороог (Joint Trade Committee) үзнэ үү.
880	Mixed credits	Холимог зээл. Хөгжингүй орнуудын зүгээс хөгжиж буй орнуудад олгож буй зээлийн нөхцөл бөгөөд энэхүү зээлийн зарим хэсгийг нь арилжааны нөхцөлөөр, зарим хэсгийг нь зээлийн хүүгийн татаас хэлбэрээр олгоно. Ийм зээлийн гол зорилго нь хүлээн авагч орны эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах чадвартай төслүүдийг санхүүжүүлэхэд оршино. Эдгээр төслүүдийг бүхэлд нь арилжааны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг гэсэн төсөөлөл байдаг. Мөн Хөгжлийн албан ёсны тусламж (official development assistance), худалдаа ба буцалтгүй тусламжийг (trade and aid) үзнэ үү.
881	Mixed export cartel	Экспортын холимог картель. Мөн картелийг (cartel) үзнэ үү.
882	Mixed tariff	Холимог тариф. Хосолсон тариф (compound tariff) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
883	Mixed trade policies	Худалдааны холимог бодлого. Худалдааны холимог бодлого. Эдийн засгийн зорилтоо хэрэгжүүлэхэд худалдааны холимог бодлогыг хэрэглэх нь ойрын хугацааны өөр өөр зорилттой хамгийн зохистой худалдааны бодлого гэж үздэг боловч эдгээр нь бүгд тухайн улсын экспортыг өргөжүүлэх зорилготой байдаг. Эдгээр нь (а) зах зээлийг нээх арга хэмжээ авах замаар дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах нэг талын бодлого, (б) зах зээлийг нээх санаачилгыг дагалдан бусад улс орны зах зээлд харилцан ашигтай нэвтрэхэд хүчтэй анхаарах, в) болзошгүй хамгаалалтыг ашиглах (демпингийн эсрэг, Татаасны хохирлыг сэргүүлэн тэнцэтгэж, импортод татвар ноогдуулах хамгаалалтын хариу арга хэмжээ, хамгаалалтын арга хэмжээ), заримдаа дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах бусад ил тод бус арга хэмжээ байдаг.
884	Modalities	Хэлцэл хийх арга барил. Худалдааны хэлэлцээ хийх зэрэг ДХБ-ын зохион байгуулалтын арга зам, хэлбэр.
885	Modes of services delivery	<p>Үйлчилгээ нийлүүлэх хэлбэр. ҮХЕХ-ийн талаар хийгдэж байсан Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр оролцогчид үйлчилгээ нийлүүлэх үндсэн 4 хэлбэрийг тохиролцсон. Үүнд:</p> <p>үйлчилгээ нийлүүлэгч болон хэрэглэгч өөр өөрийн нутаг дэвсгэрт байрлах үед утас, интернэт зэргийг ашиглан хийгдэх хил дамнасан үйлчилгээ (cross-border supply). Жишээлбэл, МУ-ын иргэн "Б" Австралид байгаа багшаас цахим хичээл авах.</p> <p>хэрэглэгч нь тухайн үйлчилгээг нийлүүлэгчийн нутаг дэвсгэрт очиж авах буюу хилийн чанд дах хэрэглээ (consumption abroad). Жишээлбэл, МУ-ын иргэн "Б" Австралид очиж их сургуульд суралцах</p> <p>үйлчилгээ нийлүүлэгч хуулийн этгээд нь хэрэглэгчийн нутаг дэвсгэрт өөрийн салбар, төлөөлөгчийн газар зэргийг байгуулах замаар арилжааны үйлчилгээ үзүүлэх (commercial presence). Австралийн их сургууль өөрийн салбарыг МУ-д байгуулснаар иргэн "Б" элсэн суралцах</p> <p>үйлчилгээ нийлүүлэгч хувь этгээд нь хэрэглэгчийн нутаг дэвсгэрт зорчин очиж үйлчилгээ үзүүлэх (movement of natural persons). МУ-ын иргэн "Б" Австрали улсад зорчиж, иргэдэд нь зүү төөнүүрийн эмчилгээ хийх</p> <p>Хил дамнасан үйлчилгээний худалдаа (cross-border trade in services), үйлчилгээ (services), үйлчилгээний худалдаа (trade in services) үзнэ үү.</p>
886	Monetary assessments	Мөнгөн үнэлгээ. АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газраас хэд хэдэн удаа гаргаж тавьж байсан саналыг хэлнэ. Энэхүү санаа нь АНУ-ын нэгдэн орсон чөлөөт худалдааны хэлэлцээрийн дагуу гаргасан маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрдөх зорилгоор, худалдааны хоригийн оронд мөнгөний үнэлгээг ашиглах боломжтой юм гэсэн санаа. Энэхүү систем нь ялагдсан тал торгууль төлөхөд хүргэж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
887	Monopoly	Монопол. Энэ нь бараа, ажил үйлчилгээний ганц ханган нийлүүлэгч эсвэл борлуулагч байх бөгөөд бусад үйлдвэрлэгчдэд ижил үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөггүй хууль тогтоомжоор ихэвчлэн хамгаалагдсан нөхцөл байдал. Мөн хувийн хэвшлийн зах зээл дээр монопол үүсэж болох боловч ирээдүйд зах зээлд шинээр орох хүсэлтэй үйлдвэрлэгчдийн зүгээс ирэх байнгын аюулд өртөх хандлагатай байна. Мөн төрийн зохицуулалтыг халах (deregulation), төрийн зохицуулалтыг дахин нэвтрүүлэхийг (re-regulation) үзнэ үү.
888	Monopsony	Монопсони. Тодорхой бараа, үйлчилгээний нэг худалдан авагчтай байх явдал бөгөөд энэ нь ихэвчлэн хууль тогтоомжоор хамгаалагдсан байна.
889	Montant de soutien	Дотоодын дэмжлэгийн ахиц/зөрүү ашиг (margin of support). Энэ нь Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний үеэр хөдөө аж ахуйн хэлэлцээнд зориулж Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгээс (ЕЭЗХН) санал болгосон элемент. ЕЭЗХН-ээс санал болгосон тодорхойлолтод "тухайн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд олгосон дэмжлэгийн ахиц/зөрүү ашиг нь олон улсын зах зээл дээрх тухайн бүтээгдэхүүний үнэ болон үндэсний үйлдвэрлэгчид бодитоор олгосон урамшуулал хоёрын зөрүүтэй тэнцүү байна" гэжээ. Эванс (1972) нь энэхүү тодорхойлолт нь бусад улсад үзүүлэх дэмжлэгийн механизмд анхаарлаа төвлөрүүлэхэд ЕЭЗХН-ийн хувьд давуу талтай байсан боловч ноцтой дутагдалтай байгааг тэмдэглэжээ. Хамгийн гол асуудал бол хөдөө аж ахуйн голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ нь өөрсдөө дотоодод үзүүлдэг үнийг дэмжлэгийн систем болон татаасны нөлөөнд автсан байдгаас хойш, эдгээр бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөхүйц дэлхийн үнэ гэж байхгүй байсантай холбоотой байдаг.
890	Montreal mid-term review	Мотреалийн дунд хугацааны хяналт. Уругвай үе шатны хэлэлцээрийг (Uruguay Round) үзнэ үү.
891	Montreal Protocol	Монтреалын протокол. Озоны давхаргыг задалдаг химийн бодисын тухай Хүрээлэн буй орчны асуудлаарх олон талт хэлэлцээр нь 1987 онд батлагдсан. Протоколд нэгдээгүй талуудын хяналтгүй үйлдвэрлэл, хэрэглээ нь уг протоколд нэгдэн орсон талуудын тохиролцсон хяналтын үр нөлөөг бий болгоход үзүүлэх нөлөөллийн асуудлыг хөндсөн болно. Үүнд протколд нэгдсэн орноос нэгдээгүй улсын нутаг дэвсгэрт CFC ашигладаг эсвэл үйлдвэрлэж буй үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэлтийг хязгаарлах зорилготой заалтууд орсон байгаа. Эдгээр заалтууд нь ДХБ-ын үндэсний нэн тааламжтай нөхцөлийн зарчимтай зөрчилдөж болзошгүй юм. Хөгжиж буй орнуудын хувьд Протоколын дагуу хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхэд туслах зорилгоор Монртеалын Протоколыг хэрэгжүүлэх Олон талт сангаас санхүүжилт авах хүсэлт гаргаж болно. Түүнчлэн Даян Дэлхийн Байгаль Орчны Санг (Global Environment Facility) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
892	Moral rights	<p>Ёс суртахууны эрх/ зохиогчийн давуу эрх. Бернийн конвенцийн bis-т заасан санаа нь “Зохиогч нь зохиогчийн эдийн засгийн/ эд хөрөнгийн эрхээс үл шалтгаалан, тэр ч атугай энэхүү эрхээ шилжүүлсэн тохиолдолд ч гэсэн, тэрээр бүтээлийнхээ зохиогч мөн болохыг хүлээн зөвшөөрөхийг шаардах эрхтэйгээс гадна уг бүтээлийг гуйвуулах, гажуудуулах буюу өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц бусад аливаа халдлагыг эсэргүүцэх эрхтэй” гэсэн утгатай. Тиймээс зохиогчийн давуу эрхэд тухайн зохиогчийн хувь хүний эрх хамаарна. Харин зохиогчийн эрхэд тухайн бүтээлийн ажил нь хамаарна. Бернийн конвенцид гарын үсэг зурсан бүх улс орнууд зохиогчийн эрхийн ёс суртахууны эрхийг үндэсний хууль тогтоомжоороо хүлээн зөвшөөрсөн байдаггүй. Мөн оюуны өмч (intellectual property), Дэлхийн оюуны өмчийн байгууллагыг (WIPO) үзнэ үү.</p>
893	Moratorium	<p>Мораторий буюу Үйл ажиллагааг түр зогсоох, хойшлуулах. Худалдааны бодлогын хэлэлцээнд энэ нь зогсонги байдалтай ижил утгатай байна. Оролцогчид үнэ тарифаа өсгөхгүй байх эсвэл тэд үүнийг хэлэлцээний гол арга болгох ганцхан зорилгоор ашиглаж, хууль тогтоомждоо өөрчлөлт хийхгүй байх нөхцөлийг хангахын тулд үүнийг ихэвчлэн хэлэлцээ эхлэхээс өмнө ашигладаг.</p>
894	More than an equitable share of the market	<p>Зах зээлийн эрх тэгш хувиас илүү. Мөн Зах зээлийн шударга хувь хэмжээ (equitable share of the market), улаан буудайн гурилын асуудлыг (wheat flour case) үзнэ үү.</p>
895	Most-favoured-nation tariff	<p>Үндэсний нэн тааламжтай нөхцөлийн тариф. Энэ нь ДХБ-ын гишүүн орнууд, худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээр байгуулаагүй байгаа ДХБ-ын бусад гишүүн орнуудын бараа бүтээгдэхүүнд мөрдөж буй тарифыг хэлдэг. ДХБ-ын гишүүн биш тохиолдолд эдгээр тарифыг хэрэглэх нь хоёр талын худалдааны гэрээний шаардлага байж болно. Мөн Ердийн тарифыг (general tariff) үзнэ үү.</p>
896	Most-favoured-nation treatment	<p>Үндэсний нэн тааламжтай нөхцөл (MFN-ҮНТН). Энэ нь тухайн улс нь холбогдох хэлэлцээрийг хамтран байгуулсан худалдааны түншүүдийнхээ тус бүрд нь, тэдний аль нэгэнд нь тодорхой бараа бүтээгдэхүүнд нь олгосон хамгийн шилдэг нөхцөлийг мөн бусдад нь олгох зохицуулалт. Үндэсний нэн тааламжтай нөхцөл нь өөрөө худалдааны өөр нэгэн түншүүддээ таатай нөхцөл үзүүлэх эсвэл илүү сайн хөнгөлөлт үзүүлэх хэлэлцээ хийх үүрэг амлалт биш. Энэ нөхцөлийн үндсэн зарчим нь ялгаваргүй, тэгш нөхцөл олгох явдал бөгөөд зарим хуучин номлолд үүнийг “гадаад паритет буюу гадаад үнийн тэнцвэрт байдал” гэж нэрлэдэг. ҮНТН нь статик шинж чанартай боловч үл ялгаварлах зарчмаар худалдааг либералчлах хүчирхэг хөдөлгүүр. Үндэсний нөхцөлтэй хамтраад үндэсний нэн тааламжтай нөхцөл нь [гадаад] худалдааны үл ялгаварлах зарчмыг бүрдүүлдэг. Үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (ҮНТН) ямар нэгэн хэлбэрээр нэлээд эрт ашиглаж байсан бөгөөд арван зургаадугаар зууны үеэс ашиглаж ирсэн болохыг үзэж болно.</p>

Эдгээр хуучин заалтуудын нийтлэг зүйл нь Утрехийн хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг болсон эрх зүйн акт болох Их Британи ба Испани хооронд 1793 онд байгуулсан Энхтайван ба найрамдлын гэрээнд тусгалаа олсон. Үүнд дурдсанаар бол "хаант улс бүрийн харьяатууд ... Францын улсын эсвэл нэн тааламжтай аливаа бусад гадаад улс орны субъектуудын хувьд байдаг, эзэмшдэг, эрх эдэлж байдаг бүх зүйл дээр ижил тааламжтай нөхцөлийг эдэлж, эсвэл дараа нь хүссэн үедээ эдэлж, эзэмшиж, эрхтэй байх боломжтой байна." гэжээ. Үндэсний нэн тааламжтай нөхцөлийн заалт нь Англи ба Франц хооронд 1860 онд байгуулагдсан Гобден ба Шевалиерийн хэлэлцээрт тусгалаа олсон. Энэ нь энэхүү нөхцөлийн орчин үеийн хэрэглээний эртний хувилбар юм. Юутай ч Үндэсний нэн тааламжтай нөхцөлийн дүрмийг Европын бусад олон худалдааны хэлэлцээрт мөн хуулбарласан болно. Дэлхийн нэгдүгээр дайны өмнөх үед энэхүү ҮНТН нөхцөлийн ашиглалт буурч байсан бол дайны дараах улс төрийн байдлаас шалтгаалж улам буурсан. Дайн дуусах үеэр үндэсний нэн тааламжтай нөхцөлийн ач холбогдлыг эргэн сэргээхийг оролдож байсан боловч нь аль нь ч үр дүнд хүрээгүй. Ерөнхийлөгч Вилсон 1918 оны нэгдүгээр сард хийсэн мэдэгдлийнхээ 14 асуудлын 3-дугаарт тэмдэглэхдээ, эдийн засгийн бүх саад бэрхшээлийг аль болох ихээр арилгах, энх тайвныг хүлээн зөвшөөрч, энэхүү нөхцөлийг эргээд сэргээхийн төлөө нэгдэж буй бүх үндэстнүүдийн хооронд худалдааны тэгш байдлыг бий болгохыг уриалав. Энэ нь үндэсний нэн тааламжтай нөхцөлийг сэргээхийг уриалсантай дүйцэхүйц байсан юм гэж зарим нь үздэг. Энх тайвны бага хурал дээр худалдааны саад тотгорыг авч хэлэлцээгүй боловч энх тайвны хэлэлцээрт Герман болон бусад улс гүрнүүдэд үндэсний нэн тааламжтай нөхцөлийг холбоотон улсуудын худалдаанд гурван жилийн хугацаатай сунгах шаардлага тавьсан. Үндэстнүүдийн Лигийн хэлэлцээрт Лигийн бусад гишүүд хоорондын худалдаанд "тэгш хандах" зарчмыг л зөвхөн зааж өгсөн нь ҮНТН нөхцөлийн заалтаас ихээхэн дутуу болсон. 1927 оны 5-р сард болсон Женевийн Дэлхийн эдийн засгийн бага хурал нь ҮНТН-ийн заалтыг байж болох хамгийн өргөн хүрээнд тайлбарлахыг дэмжиж, худалдааны хэлэлцээрт ашиглах түүний хэрэглээ нь хэвийн хэмжээнд байх ёстой гэж цохон тэмдэглэв. 1933 онд Үндэстнүүдийн Лиг нь ҮНТН-ийн талаар 300 үгтэй загвар бичвэрийг хэвлүүлжээ. Тэр үед эдийн засгийн нөхцөл байдал хэдэн жилийн турш маш хүнд байсан бөгөөд ҮНТН зарчим нь өргөн хүрээний дэмжлэгийг авч чадаагүй. 1941 оны Атлантын дүрмээр үүнийг сэргээж, ТХЕХ-ээр үлгэр жишээ болсон олон талт худалдааны тогтолцооны үндэс суурийг тавьсан юм. ДХБ-д ҮНТН нь аль нэг улсад үзүүлсэн аливаа хөнгөлөлтийг бусад бүх гишүүдэд нэн даруй олгох ёстой гэсэн заавал биелүүлэх үндсэн үүрэг юм. Энэхүү зарчмыг ДХБ-ын удирдаж байдаг бусад хэлэлцээрүүдэд тусгасан болно. Жишээлбэл, ТХЕХ-ийн бүх гишүүн орнууд гаалийн эрх зүйн зохицуулалт, тариф болон бусад татваруудыг удирдан хэрэглэхдээ, бусад аливаа улсад олгодог шигээ тийм тааламжтай нөхцөлийг өөр хоорондоо мөн олгодог. Гэхдээ ҮНТН-ийн үүрэгт үл хамаарах зүйлүүд байдаг. Энд бол зөвхөн зарим чухал зүйлийг дурдав.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Чөлөөт худалдааны бүс буюу гаалийн холбоонд гишүүнээр элсэх нөхцөлийг хангаж буй ДХБ-ын гишүүн орнууд ийм төрлийн худалдааны хөнгөлөлттэй зохицуулалтын гишүүн бус улс орнуудад зэх зээлд нь нэвтрэх мөн ижил төрлийн нөхцөлийг олгох үүрэгтэй биш юм. Хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудын импортын бараанд хөнгөлөлттэй нөхцөлийг олгодог Хөнгөлөлтийн ерөнхий системийг хэрэгжүүлж болно. Мөн зарим гишүүдэд илүү эергээр хандах зорилготой эрх зүйн үндсийг бүрдүүлж өгдөг үүрэг амлалтаас татгалзах/чөлөөлөгдөх хүсэлт гаргах боломж бас бий. Мөн нөхцөл заасан Үндэсний нэн тааламжтай нөхцөл (conditional most-favoured-nation treatment), Жексон-Ваникийн нэмэлт өөрчлөлт (Jackson-Vanik amendment), худалдааны хэвийн харилцааг (normal trade relations) үзнэ үү.</p>
897	Movement of natural persons	<p>Хувь этгээдийн шилжилт хөдөлгөөн. Үйлчилгээ үзүүлэх, нийлүүлэх зорилгоор үйлчилгээ эрхлэгчид өөр улсын харьяалалд түр хугацаагаар нэвтрэхийг ҮХЕХ-ийг хэлэлцэгчид хүлээн зөвшөөрсөн нэршил. Үйлчилгээ нийлүүлэх хэлбэр (Modes of services delivery) үзнэ үү.</p>
898	Multi-column tariff	<p>Олон шатлалтай тариф. Худалдааны түнш орнуудын ижил бараанд ялгаатай буюу өөр өөр шатлалаар тариф тогтоох. Өөрөөр хэлбэл, эхний шатлал нь ердийн буюу үндэсний нэн тааламжтай нөхцөлийг олгоогүй орнуудаас, хоёрдох нь ҮНТН (MFN) олгосон орнуудаас, гуравдах нь хөнгөлөлттэй буюу чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан, эсхүл Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу хөгжиж буй орнуудаас гарал үүсэлтэй бараанд ногдуулах тарифыг харуулдаг. Нэг шатлалт тариф (single-column tariff) үзнэ үү.</p>
899	Multidomestic corporation	<p>Дотоодод дамнасан корпорацууд. Энэ нь улс орнуудад салбар нэгжээ байгуулан өөрийн стратегиа хэрэгжүүлдэг хил дамнасан корпорацийн нэг хэлбэр. Ер нь бол тухайн улсын зах зээлд голчлон ханган нийлүүлэхийн тулд өөр улсад үйл ажиллагаагаа явуулдаг.</p>
900	Multi-Fibre Arrangement	<p>Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр (MFA). Энэхүү хэлэлцээрийн албан ёсны нэршил нь сүлжмэл, нэхмэл, оёмол эдлэлийн худалдааны асуудлаарх олон улсын хэлэлцээр гэдэг. Энэ нь текстиль бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч орнуудын хооронд анх 1973 онд байгуулагдсан хэлэлцээр бөгөөд дараа нь текстиль бүтээгдэхүүний худалдаанд зохицуулалт хийх зорилгоор хэд хэдэн удаа дахин хэлэлцсэн. Энэ нь зах зээлийг хямруулах замаар маш их өрсөлдөөнтэй болж ирж буй хөгжиж буй улсуудын сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжиж хөгжингүй орнуудын энэ салбар дах үйлдвэрлэгчдэд “ноцтой хохирлыг” барьж тогтоохыг эрэлхийлдэг. Энэхүү хэлэлцээр нь зорилтот орнуудад чиглэсэн байсан тул ТХЕХ-ийн үл ялгаварлах заалтыг зөрчсөн. Нөлөөнд нь өртсөн хэрэглэгч улс орнуудын үнийг өсгөхөөс гадна, хэлэлцээрийн үр дүнд хөгжиж буй орнууд өндөр нэмүү өртөг бүхий үйлдвэрлэл эрхлэх болсон нь хөгжингүй орнуудын өрсөлдөх чадварыг улам сулруулж байсан.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Энэхүү хэлэлцээрийг орлуулан ДХБ-ын Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) эдлэл болон бэлэн хувцасны асуудлаарх хэлэлцээр батлагдсан бөгөөд хэлэлцээрийн дагуу энэ салбар дах худалдааны аливаа хязгаарлалтыг 1995 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн 10 жилийн хугацаанд шат дараатай бууруулахаар тусгасан байсан. Мөн Хөвөн даавуун текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэлийн олон улсын худалдаатай холбоотой богино хугацааны зохицуулалт (Short-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textiles), Хөвөн даавуун текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол) эдлэлийн олон улсын худалдаатай холбоотой урт хугацааны зохицуулалтыг (Long-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textiles) үзнэ үү.</p>
901	<p>Multilateral agreement on competition</p>	<p>Өрсөлдөөний тухай олон талт хэлэлцээр. Энэ нь засгийн газар хоорондын ирээдүйд хэлэлцэх асуудлын талаар гаргасан санал боловч одоохондоо хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй байгаа. Зарим нь үүнийг хэтийн зорилгыг хууль сахиулах асуудлаарх өрсөлдөөний асуудал хариуцсан үндэсний эрх бүхий байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд оршино гэж үздэг. Бусад нь нийтлэг эрх, үүргийн шалтгаан болох монополын эсрэг хууль тогтоомжийг олон улсын хэмжээнд удирдахад зориулсан хэлэлцээр гэсэн утгыг илүүд үздэг. Мөн Олон улсын монополын эсрэг хуулийн төсөл (Draft International Antitrust Code), худалдаа ба өрсөлдөөний талаар (trade and competition) мөн үзнэ үү.</p>
902	<p>Multilateral Agreement on Investment</p>	<p>Хөрөнгө оруулалтын тухай олон талт хэлэлцээр (MAI). 1995 оны 6-р сард болсон ЭЗХАХБ (OECD)-ын Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар хөрөнгө оруулалтыг чөлөөлөх тухай хэлэлцээрийг эхлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд хэлэлцээ нь ЭЗХАХБ-ын гишүүн бус улсуудад мөн нээлттэй байхаар шийдсэн. Энэхүү хэлэлцээрт хөрөнгө оруулалтын асуудлаарх дотоодын дүрэм, журмуудыг либералчлах стандартыг агуулж, маргаан шийдвэрлэх үр дүнтэй заалтуудыг тусгана гэж сайд нар найдаж байсан. Энэхүү санаачилгыг нааштай эхлүүлсний дараа бараг бүх салбарт яриа хэлэлцээ хурдан гацаанд орох болов. Хэлэлцүүлэгт оролцогчдыг асуудлаа нууцалж байна мөн гишүүн орнуудын хооронд ямарч саадгүй хөрөнгө оруулалтын урсгалыг бий болгох зорилготой байна хэмээн төрийн бус байгууллагуудын зүгээс тэдний эсрэг маш их эсэргүүцэл үзүүлсэн байна. Хэлэлцээнд оролцогчид хэлэлцээрийн текстийг олон нийтэд нээлттэй болгох тал дээр удаашралтай байсан бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай олон талт хэлэлцээрийн үндсэн заалтууд болон хэлэлцээр хийгчид харилцан буулт хийхийг хичээж байсан хэлэлцээрийн төслийн ойлгомжгүй үг хэллэгээс шалтгаалж, гишүүдийн байр суурийн хороонд эвлэршгүй ялгаа үүссэний улмаас хэлэлцээ зогссон байна. Түүнчлэн, маш цөөхөн гишүүн бус улсууд уг хэлэлцээрт нэгдэх хандлагатай байв. Хэлэлцээрийн хэлэлцэх хугацааг нэг жилээр сунгахаад 1998 он гэхэд зарим улсын засгийн газрууд санал болгож буй хэлэлцээрийн улс төрийн өртөг маш өндөр болж байна гэж үзсэн байв.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Франц улс 1999 оны эхээр хэлэлцээнээс гарсан. Хэдийгээр ЭЗХАХБ-ын зарим гишүүд Францын шийдвэрт харамсаж байсан боловч олон улсууд Франц улсыг бодит байдалтай зоригтойгоор нүүр тулсан юм байна гэдэгт итгэх болсон байна.
903	Multilateral Agricultural Framework	Хөдөө аж ахуйн олон талт эрх зүйн бүтэц, хамрах хүрээ. Токиогийн үе шатны хэлэлцээний төгсгөлийн үе шатанд хөдөө аж ахуйн салбарт хийсэн хэлэлцээний үр дүнг хянах механизмыг бий болгох, хөдөө аж ахуйн худалдаанд тулгарч буй бэрхшээлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл солилцох талбар болгох зорилготой бий болсон санаа юм. Тэр тусмаа энэхүү бүтэц, хамрах хүрээ нь хөдөө аж ахуйн салбарт үргэлжилж буй улс төр, арилжааны сөргөлдөөнийг арилгах болно гэсэн бодолтой байсан. ТХЕХ-ийн ивээл дор Олон улсын хөдөө аж ахуйн зөвлөлдөх зөвлөл байгуулахыг уг санаачилга зорьж байсан. Токиогийн үе шатны хэлэлцээ 1979 оны 4-р сарын 12-нд дуусахад оролцогчид энэ санаачилгын талаар санал нэгдээгүй байсан тул Яриа хэлэлцээний дараах хэлэлцээ үр дүнд хүрээгүй. Түүнчлэн хөдөө аж ахуй ба ТХЕГ-ыг (Agriculture and the GATT) үзнэ үү.
904	Multilateral environment agreements	Хүрээлэн буй орчны олон талт хэлэлцээр. Энэ нь олон талт хэлэлцээр, конвенц, протоколыг олон талт түвшинд тохиролцож, байгаль орчинд учирч буй хохирлыг арилгах, багасгахад чиглэсэн болно. Энэ хүрээнд 180 орчим хэлэлцээ хийгдсэн байна гэдэг. Тэдний дор хаяж арван найм нь худалдааны тодорхой заалтуудыг агуулдаг. Худалдааны бодлоготой холбогдолтой заалт бүхий хэлэлцээрүүдэд тодорхой төрлийн зүйлүүдийн худалдааг хязгаарлах арга хэмжээний тухай заалтыг хамарсан байдаг Базелийн конвенц, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES) болон Монртеалын Протокол орно. Эдгээрийн зарим бусад хэлэлцээрүүдэд худалдааны бодлого боловсруулахад нөлөөлөл үзүүлэхүйц заалтуудыг агуулсан байдаг ба үүнд 21-р зууны хөтөлбөр, Байгаль орчин, хөгжлийн тухай Риогийн тунхаглал, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц зэрэг болно.
905	Multilateral Investment Guarantee Agency	Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлаг (MIGA). Олон талт хөрөнгө оруулалтын батлан даалтын агентлаг нь (ОТХОБДА) 1988 оны 4-р сарын 12-нд ОУСБХБ (IBRD)-ны ивээл дор байгуулагдсан. Энэ байгууллагын зорилго нь хөгжиж буй орнуудад хувийн хэвшлийн шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. ОТХОБДА нь хүлээн авагч улс дах улс төрийн тодорхой эрсдлийн эсрэг хөрөнгө оруулалтын даатгагчийн үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах, шинэ хөрөнгө оруулалт татахад туслах техникийн туслалцаа үзүүлдэг. ОТХОБДА нь Вашингтонд байрладаг. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт (foreign direct investment), Дэлхийн хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын холбоог (World Association of Investment Promotion Agencies) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
906	Multilateralism	Олон талт тогтолцооны онол. Энэ нь хамтын ажиллагаа, тэгш эрх, үүрэг хариуцлага, үл ялгаварлах, олон улсын худалдаанд тухайн улсын эдийн засгийн хэмжээ болон эзлэх хувь хэмжээнээс үл хамааран олон улс орнуудтай адил тэгш эрхтэй оролцох оролцоо зэрэгт тулгуурласан олон улсын худалдааг удирдан явуулах арга хандлага юм. Энэ бол Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд тусгалаа олсон дүрэм, зарчмуудын үндэс юм.
907	Multilateral procurement	Олон талт худалдан авалт. Олон талт байгууллагууд (жишээ нь НҮБ, ОУВС, ДХБ гэх мэт) өөрсдийн хэрэгцээнд зориулан эсвэл тэдгээрийн санхүүжүүлсэн төслүүдэд ашиглах зорилгоор бараа, үйлчилгээ худалдаж авах явдал юм.
908	Multilateral Specialty Steel Agreement	Дээд зэргийн гангийн тухай олон талт хэлэлцээр (MSSA). Энэ нь 1996 оны эхээр Европ, АНУ-ын аж үйлдвэрийн холбоодуудаас дэлхийн дээд зэргийн гангийн худалдаан дах (а) татаас олгохыг хориглох, (б) тариф болон тарифын бус саад тотгорыг арилгах, (в) худалдааг гажуудуулсан, өрсөлдөөний эсрэг практик туршлагыг халах зорилгоор гаргасан санаачлага юм. Түүнчлэн үүгээр илүүдэл үйлдвэрлэлийн хүчин чадлын асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байсан. Энэ нь хэлэлцэх асуудлыг жагсаалтанд одоогоор ороогүй байгаа. Мөн Гангийн талаарх олон талт хэлэлцээрийг (Multilateral Steel Agreement) үзнэ үү.
909	Multilateral Steel Agreement	Гангийн тухай олон талт хэлэлцээр (MCA). Уругвайн үе шатны хэлэлцээний хоёрдугаар хагаст АНУ нь ялангуяа гангийн худалдаатай холбоотой тарифын бууруулалт, тоон хязгаарлалтыг халах, татаас олгох, демпингийн эсрэг арга хэмжээ ногдуулах, Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах арга хэмжээ гэх мэт асуудлуудыг тусгаж, хэлэлцээрийг байгуулахыг санал болгов. Хэлэлцээ Уругвайн үе шатны хэлэлцээнээс тусдаа явагдсан бөгөөд 36 улс оролцов. Хэдийгээр 1992 оны 3-р сард хэлэлцээ зогссон боловч хэлэлцээрийг эргэн харах шаардлагатай байна гэсэн санал үе үе гарч байсан. Дээд зэргийн гангийн тухай олон талт хэлэлцээр (Multilateral Specialty Steel Agreement), салбарын хүрээний худалдааны хэлэлцээрийг (sectoral trade negotiations) мөн үзнэ үү.
910	Multilateral trade agreements	Олон талт худалдааны хэлэлцээрүүд. Энэ нь олон улсын худалдааг үл ялгаварласан, урьдчилан таамаглахуйц, ил тод нөхцөлийн дагуу өргөжүүлж, либералчилах зорилго бүхий харилцан эрх үүргээ тусгасан Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд. Энэхүү үүрэг амлалтуудыг хүлээж авах сэдэл нь, гадаад худалдаагаа удирдан зохицуулах нийтлэг стандарт баримталснаар нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ гэж бүх талууд үздэг. Ерөнхийдөө ийм хэлэлцээрүүд нь жижиг, дунд, том худалдаа, эдийн засаг бүхий улс орнуудыг төлөөлж байдаг олон тооны гишүүдтэй.

Ийм төрлийн хэлэлцээрт гишүүнээр элсэх нь бусад улс орнуудад нээлттэй байдаг боловч элсэх хүсэлтэй улс орнуудын хувьд худалдааны горим нь хэлэлцээрийн зорилгыг баримталж, тэдгээрийн зах зээлд нэвтрэх боломж нь хэлэлцээрт орсон гишүүн орнуудынхтай ерөнхийдөө нийцэх боломжтойг тайлбарлаж харуулах шаардлагатай байдаг. Хэрэв шаардлагатай тохиолдолд эдгээр улс орнууд худалдааны горимдоо өөрчлөлт оруулах ёстой. 1948 онд хүчин төгөлдөр болох үедээ ТХЕХ нь анхны олон талт худалдааны хэлэлцээр байсан бөгөөд өнөөг хүртэл тэргүүлэгч хэвээр байна. Үүнээс өмнө худалдааны хэлэлцээрүүд нь ихэвчлэн хоёр талын, эсвэл хөнгөлөлттэй нөхцөл олгодог, тухайлбал эзэнт гүрний давуу байдлын/хөнгөлөлтийн зохицуулалт гэж байсан. ДХБ-ын хүрээнд “Олон талт худалдааны хэлэлцээр” гэсэн нэр томьёо нь Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн 1, 2, 3-р хавсралтад орсон зохицуулалтууд болон холбогдох хууль эрх зүйн актуудыг илэрхийлдэг. Мөн нэгдэн орох (accession), хоёр талын худалдааны хэлэлцээрүүд (bilateral trade agreements), Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээр (plurilateral trade agreements), Шоронгийн хоригдлын дилемма (олон хүнд сонголтуудаас нэг сонголт хийх мухардмал байдал) (prisoner's dilemma) зэргийг үзнэ үү.

911

Multilateral trade negotiations

Олон талт худалдааны хэлэлцээ (MTN). Мөн хэлэлцээний үе шатууд гэж нэрлэдэг. Эдгээр хэлэлцээний үр дүнд олон улсын худалдааг эмх цэгцтэй, шударга явуулах нөхцөлийг бүрдүүлэх дүрэм журмыг бэхжүүлж, дэлхийн худалдаанд тулгарч буй саад тотгорыг багасгах, харилцан ашигтай тохиролцоонд хүрэхийг зорино. 1947 оноос хойш ТХЕХ-ийн хүрээнд найман удаагийн яриа хэлэлцээ хийгдээд байна. Хэлэлцээ тус бүрт урт хугацааны яриа хэлэлцээнүүдийн хэсгүүдтэй байлаа. Өнөөг хүртэл үргэлжилсэн найман удаагийн хэлэлцээ нь: Женев (1947), Аннеси (1949), Торкуэй (1950), Женев (1955-56), Диллон (1960-61), Кеннеди (1963- 67), Токио (1973-79), Уругвай (1986-94) үе шатны хэлэлцээ гэж нэрлэгддэг. Кеннеди хүртэл хийгдсэн хэлэлцээний агуулга нь зөвхөн тариф бууруулах асуудал байв. Эхний үед хийгдсэн хэлэлцээ нь хэд хэдэн цуврал хоёр талын хэлэлцээнээс бүрдэх бөгөөд хэлэлцээний үр дүнд бусад улс орнууд (MFN) нөхцөлд тулгуурлан хэлэлцээрт нэгдэн орох боломжийг нээсэн. Кеннедигийн үе шатны хэлэлцээнээс эхлэн тарифын бус арга хэмжээ, системийн асуудлууд хэлэлцэх асуудлын жагсаалтад орох болсон. “MTN” товчлолыг Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр түгээмэл хэрэглэдэг байсан бөгөөд ихэвчлэн тэрхүү хэлэлцээнд тусгайлан хамааруулдаг байсан. Мөн Аннесигийн тарифын бага хурал (Annecy Tariff Conference), Диллоны үе шатны хэлэлцээ (Dillon Round), Женевийн тарифын бага хурал 1947 он (Geneva Tariff Conference, 1947), Женевийн тарифын бага хурал, 1955-56 он (Geneva Tariff Conference, 1955-56 он), Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээ (Kennedy Round), Торкуэй тарифын бага хурал (Torquay Tariff Conference), Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээ. (Uruguay Round) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
912	Multilateral Trade Organisation	Олон талт худалдааны байгууллага (МТО). 1990 онд Европын хамтын нийгэмлэгээс Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнг илүү хүчтэй хууль эрх зүйн үндэслэлтэй, нэгдсэн удирдлага бүхий эрх зүйн бүтэц, хамрах хүрээнд оруулахаар санал болгосон. Энэхүү саналыг ТХЕХ-ын гишүүн орнууд ихэнх нь дэмжсэн. Гэсэн хэдий ч, 1993 оны 12-р сард хийсэн албан ёсны хэлэлцээний бараг төгсгөл үеэр АНУ шинэ байгууллагыг Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) гэж нэрлэх нь зүйтэй гэж үзэв. Энэ саналыг батлав.
913	Multilateral trading system	Олон талт худалдааны тогтолцоо. 1947 онд ТХЕХ-ийн хамт үүсэн бий болсон олон худалдаанд үл ялгаварлах зарчим баримтлах олон талт худалдааны тогтолцоо бөгөөд одоо бол ДХБ-ын тогтолцооны хүрээнд илэрхийлэгдэж байдаг.
914	Multinational enterprises	Үндэстэн дамнасан аж ахуйн нэгж. Улс дамнасан корпорацуудыг (transnational corporations) үзнэ үү.
915	Mutual aid agreement	Харилцан туслах буцалтгүй тусламжийн хэлэлцээр. Түрэмгийллийн эсрэг дайнд харилцан туслалцаа үзүүлэх зарчмуудын талаар Их Британи, АНУ-ын хооронд 1942 оны 2-р сарын 23-нд байгуулсан хэлэлцээр. Энэхүү хэлэлцээр нь Атлантын дүрмийн баримт бичигт суурилсан бөгөөд 1947 онд НҮБ-ын Худалдаа, хөдөлмөр эрхлэлтийн бага хурлыг хуралдуулах, 1947 онд ТХЕХ-ийн хэлэлцээг хийх, 1948 оны Гаванагийн дүрмийн хэлэлцээрийг байгуулахад хүргэсэн чухал алхамуудын нэг юм. Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд олон улсын эдийн засгийн харилцааны асуудлыг тусгасан. Хоёр улсын хооронд тохирсон энэхүү хэлэлцээрт "үйлдвэрлэл, ажил эрхлэлт, бараа бүтээгдэхүүний солилцоо, хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн олон улсын болон дотоодын зохистой арга хэмжээ авах, бүх ард түмний эрх чөлөө, сайн сайхан байдлын материаллаг үндэс суурь болох олон улсын худалдаанд баримталж буй бүх хэлбэрийн ялгавартай нөхцөлийг халах, тарифыг бууруулах, худалдааны бусад саад бэрхшээлийг арилгах." зэрэг ижил төстэй бодлого бүхий бусад улс орнууд элсэн орох нь нээлттэй байсан.
916	Mutual recognition arrangements	Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр. Энэ нь хоёр ба түүнээс дээш улс хоорондоо стандарт, мэргэшил, лицензийн шаардлагыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр. Энэхүү хэлэлцээр нь бараа, үйлчилгээ, боловсрол, мэргэжлийн ур чадварыг хамарч болно. Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн үр дүнд зарим техникийн саад тотгорыг арилгах замаар худалдааг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж чадна. Харилцан хүлээн зөвшөөрөхөд талуудаас тохиролцсон хамгийн бага стандартыг дагаж мөрдөхийг шаардаж болох бөгөөд энэ нь шаргуу хэлэлцээ хийхэд хүргэж болзошгүй юм. ТХЕХ-ийн гишүүн орнууд хоорондоо харилцан хүлээн зөвшөөрсөн стандарт, ур чадварын нөхцөлийг бусад орнуудад үндэсний нэн тааламжтай нөхцөлийн дагуу олгох шаардлагагүй юм. Хэрэв гуравдагч орон мөн мэргэшлийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж чадахаа харуулж байвал тийнхүү хийх боломж нь нээлттэй байх ёстой.

1979 онд Европын шүүхийн Касс де Дижоны хэрэг дээр гаргасан шийдвэрийн үндсэн дээр ижил төстэй стандарт гэхээсээ илүү ижил төстэй бүтээгдэхүүний стандартыг харилцан хүлээн зөвшөөрөх Европын хамтын нийгэмлэгийн зарчмыг тогтоожээ. Энэ нь хамтын нийгэмлэгийн хүрээнд стандарт харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг илүү хялбар болгож, маш хэцүү асуудлуудын ангиллаас стандартыг хассан. Мөн Нягтлан бодох бүртгэлийн салбар дах харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр, зохицуулалтын удирдамж (Guidelines for Mutual Recognition Agreements or Arrangements in the Accountancy Sector), Стандарт ба чанарын баталгаажуулалтыг уялдуулах (harmonisation of standards and qualifications), худалдаан дах техникийн саад тотрог (technical barriers to trade), тэг ашигтайгаар уялдуулсан зохицуулалтыг (zero-margin harmonisation) үзнэ үү.

---- О ----

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
917	NAFTA (North American Free Trade Agreement)	<p>Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр (ХАЧХХ -NAFTA). Энэ нь 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Канад, Америкийн Нэгдсэн Улс болон Мексик улсуудаас бүрэлдсэн гишүүдтэй. Энэ нь бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг хамардаг байна. Ихэнх тарифыг арван жилийн хугацаанд аажмаар бууруулсан. Үйлчилгээний нийлүүлэлтийн бүх горимууд хамрагдсан. Үндэсний нөхцөл (national treatment болон үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured nation treatment) нь хөрөнгө оруулалтад хэрэглэгддэг байна. Мөн ХАЧХХ нь өрсөлдөөний бодлого болон оюуны өмчийн нөхцөлүүдтэй. Хөдөө аж ахуйн чиглэлээр гурван тусдаа хэлэлцээр болон Хөдөлмөр ба хүрээлэн буй орчны чиглэлээр дагалдах хэлэлцээрүүд зурагдсан байна. Бүс нутгийн бусад улс орнууд ХАЧХХ-д элсэх боломжтой боловч бусдууд нь Америкийн чөлөөт худалдааны бүсийг (FTAA) явж явж илүү логик шийдэл гэж үздэг байна. Мөн Хөдөлмөрийн хамтын ажиллагааны тухай Хойд Америкийн хэлэлцээрийг (North American Agreement on Labour Cooperation) үзнэ үү.</p>
918	Narrow competition policy	<p>Явцуу өрсөлдөөний бодлого. Энэ нь ихэвчлэн Монополийн эсрэгтогтоомж (antitrust laws) эсвэл бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг (restrictive business practices) хянахад чиглэсэн хууль тогтоомжийн хүрээнд үйлчилдэг өргөн хүрээний практик үйл ажиллагааг авч үздэг. Явцуу өрсөлдөөний бодлогын үндсэн зорилтууд нь босоо болон хөндлөн тэнхлэгийн зохицуулалт, зах зээлийн хүчин чадлыг зүй бусаар ашиглах явдал, (аж ахуйн нэгжлийн) нэгдэх болон худалдан авалтын үйл ажиллагааны үр дүнд гарсан өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хянах явдал юм. Мөн өрсөлдөөний бодлого (competition policy) болон өрсөлдөөний илүү өргөн хүрээний бодлогыг (wider competition policy) үзнэ үү.</p>
919	National champions	<p>Үндэсний аваргууд. Энэ нь зарим улс орнуудын хувьд тодорхой заасан компаниуд нь шинэ технологиуд эсвэл шинэ [технологийн] үйл ажиллагааг үүсгэн байгуулагчаар ажиллаж бусад компаниуд үүнээс суралцах боломжийг олгох үүрэг хүлээж ажилладаг байна. Ихэвчлэн, уг компаниуд нь нэр дэвших үедээ аль хэдийн өөрсдийн салбартаа тэргүүлж, давамгайлсан байр сууриа олсон байдаг байна. Үндэсний аваргууд ихэнх тохиолдолд татварын хөнгөлөлттэй журам (preferential tax treatment) болон бусад дэмжлэг бүхий арга хэмжээнээс ашиг тус хүртдэг байна. Түүнээс гадна зарим өрсөлдөөний тухай хуулиар [хүлээх үүргээс] чөлөөлөгдөж болдог байна. Ийм компаниудын дотоод зах зээлд үзүүлэх нөлөөлөл их байж болох боловч тэдний олон улсын зах зээл дэх үүрэг оролцоо нь нилээд бага байж болно. Үндэсний аварга нь түүнийг дэмжигчдийн зүгээс хүсэн хүлээж буй үр дүнд хүрч чадах эсвэл эсвэл зүгээр л хялбархан хамгаалагдсан, өрсөлдөөнгүй аж ахуйн нэгж болж хувирах эсэхийг тааж хэлэх ямар ч аргагүй юм. Мөн Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын мэтгэлцээн (infant-industry argument), хийх явцдаа суралцах (learning-by-doing argument), ялагчдыг сонгох (picking winners) зэргийг үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
920	National interest	<p>Үндэсний ашиг сонирхол. Энэ нь яг таг тодорхойлогдоогүй ч, олон төрлийн тодорхой шалгуур үзүүлэлтийг тайлбарлахад хэрэглэдэг нэр томьёо бөгөөд үүний гүйцэтгэл нь улс орны сайн сайхны төлөө үндсэн чухал ашиг сонирхол болж тусгагдсан байдаг. Үүнийг ихэвчлэн үндэсний ашиг сонирхлыг өөрсдийн зорилготой эн тэнцүү авч үздэг, тодорхой ашиг сонирхлын эсвэл лобби бүлгүүд (lobby groups) ерөнхий утгаар нь авч хэрэглэдэг. Шууд утгаар нь тайлбарлахад, зөвхөн үндэсний засгийн газрууд л үндсэн хуулиар болон түүнээс урган гарч буй хууль тогтоомжуудын дагуу тэдэнд оноогдсон үүрэг хариуцлагын дагуу, үндэсний ашиг сонирхлыг шүүн тунгаах, түүнтэй холбогдуулан тайлбар зүйл ангийг хэрэглэх эрх мэдэлтэй юм. Парламентын зарим хууль эрх зүйн актуудад үндэсний ашиг сонирхлыг илэрхийлсэн зүйл заалтуудыг агуулсан байдаг бөгөөд зарим тохиолдолд эдгээр эрх зүйн актуудад зааж өгсөн мөрдөх журмуудаас нь ихээхэн зөрсөн үйл ажиллагааны чиглэлийг засгийн газрууд нь батлах эрхийг олгосон байх нь бий. Ялангуяа үндэсний ашиг сонирхлын зүйл заалтуудын эхлэлийг тавьж буй тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг ойлгомжтой, үндэслэлтэйгээр тайлбарлаж гаргаагүй тохиолдолд, иймэрхүү үзэмжээрээ шийдэх эрх мэдлийг (ялгаварлан гадуурхах эрх мэдэл) хэрэгжүүлэх нь хэр зэрэг зохистой болох талаар хүчтэй маргаан дагуулах тохиолдол байдаг. Гэсэн хэдий боловч, засгийн газрын зүгээс зарим салбаруудыг удирдан зохион байгуулахад үндэсний ашиг сонирхолтой холбогдолтой хуулийн зүйл заалтуудын хүрээнд уян хатан байдал шаардлагатай болдог гэдэг тал дээр өргөн хүрээнд хүрсэн тохиролцоо байдаг. Мөн, Эксон-Флориогийн нэмэлт өөрчлөлт (Exon-Florio amendment), гадаадын хөрөнгө оруулалтыг нягтлан шалгах (foreign investment screening), Эс хэрэглэх нийтлэг тохиолдол (general exceptions), учир шалтгааны дүрэм (rule of reason) болон Аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх нөхцөлийг (security exceptions) үзнэ үү.</p>
921	National treatment	<p>Үндэсний нөхцөл. (GATT Article 3, GATS Article 17, TRIPS Article 3). Энэ бол хоёр талт болон олон талт худалдааны олон хэлэлцээрт агуулагдсан зарчим. Энэ нь дотоодын зах зээлд гадаадын бүтээгдэхүүнүүд болон зарим үед бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг дотоодын бүтээгдэхүүн эсвэл тэдгээрийн ханган нийлүүлэгчдээс илүү дорд үзэхгүй байх талаар баталгаа гаргахыг хичээдэг. Хуучны судалгааны ажлууд дээр энэхүү зарчмыг заримдаа "улс орны дотоодын паритет" ("inland parity") гэж нэрлэдэг. Энэ нь маш энгийн төлөвлөгөө боловч, маш олон маргалдааны шалтгаан болдог, учир нь зарим талаар үндэсний нөхцөлийн талаар хатуу тайлбар хийх нь үнэн хэрэгтээ гадаадын ханган нийлүүлэгчдийн хувьд магадгүй сул тал болж мэдэх юм. Ийм магадлалын сонгодог жишээ бол Дарсны галлоны үнэлгээ (Wine gallon assessment). Ийм учраас, хэрэв энэ үндэсний нөхцөл нь гадаадын бүтээгдэхүүнд сул тал болохгүй байх цорын ганц баталгаа болох арга зам юм бол, олон жилийн туршид уг үндэсний нөхцөлийн зарчмыг боловсронгуй болгосон ба улмаар гадаадын бүтээгдэхүүнд өөрөөр эсвэл ёс журмын дагуу илүү сайн нөхцөлөөр хандах боломжийг олгох юм.</p>

Заримдаа улс орнууд өөрсдөд нь тохиромжтой компаниудыг татахын тулд гадаадын хөрөнгө оруулагчдад үндэсний нөхцөлөөс илүү нөхцөлийг зориуд олгодог байна. Бусад тохиолдолд импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүнд чиглэсэн арга хэмжээ болон зөвхөн гадаадын бүтээгдэхүүн рүү чиглэсэн тоон хязгаарлалтын арга хэмжээ хоёрын хооронд ялгахад хэцүү байдаг. Бараа бүтээгдэхүүнд зориулсан үндэсний нөхцөлийн асуудлыг авч хэлэлцдэг Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 3-р зүйл заалтад үндэслэсэн үндсэн зарчим бол өрсөлдөх боломжийн тэгш байдал. Уг зүйл заалтад, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор, импортын эсвэл дотоодын бараа бүтээгдэхүүнд дараах зүйлсийг хэрэглэхгүй байх ёстой талаар ТХЕХ-ийн гишүүд хүлээн зөвшөөрсөн тухай ерөнхий мэдэгдлээр эхэлдэг бөгөөд эдгээр зүйлсийн дотор улс орны дотоодын татвар болон бусад хураамжууд, дотоодын борлуулалтад нөлөөлөх хууль тогтоомж дүрмүүд, тээвэрлэлт болон түгээлт, дотоодын тоон хязгаарлалтын зохицуулалтууд зэрэг багтсан байдаг. Дараа нь дотоодын бараа бүтээгдэхүүнд ногдуулдаг хэмжээнээс илүү хэмжээний дотоодын татвар эсвэл дотоодын бусад хураамжийг импортын бүтээгдэхүүнүүдэд ногдуулах ёсгүй талаар үүнд дурдсан байдаг. Мөн уг заалтад бүх хууль, хууль тогтоомж, дүрэм журам зэргийг импортын болон дотоодын бүтээгдэхүүнүүдэд ижил тэгш байдлаар хэрэглэх ёстой болохыг шаардсан байдаг. Нэмж дурдахад, дотоодын тоон хязгаарлалтуудыг үл ялгаварласан байдлаар хэрэглэх ёстой байдаг. Оюуны өмчийн хувьд, Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) 3-р Зүйл заалтад заасны дагуу, ДХБ-ын гишүүн нь өөрийн иргэдэд нийцүүлж олгосон байдаг таатай нөхцөлөөс багагүй таатай нөхцөлийг бусад гишүүн орны иргэдэд олгох ёстой. Үүнд, Парисын конвенц (Paris Convention), Бернийн конвенц (Berne Convention), Ромын конвенц (Rome Convention) болон Интеграл цахилгаан шугам бүхий микро схемүүдтэй холбоотой Оюуны өмчийн тухай олон улсын гэрээний (Treaty on Intellectual Property in Respect of Integrated Circuits) дагуу урьд өмнө байсан эрхүүдээс хамааран, зарим дурдсан зүйлсийн хувьд хамаарахгүй байх боломжтой. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) 17-р Зүйл заалтад тайлбарласнаар үйлчилгээний хувьд, үндэсний нөхцөл нь гадаадын үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний үйлчилгээнд, дотоодын үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний үзүүлдэг үйлчилгээнд олгодог нөхцөлтэй дүйцэхүйц ижил тэгш нөхцөлийг олгох баталгаа олгох үүрэгтэй байдаг. Ижил тэгш боломжийг олгох шаардлагын улмаас гадаадын ханган нийлүүлэгчдэд олгох нөхцөл нь хэлбэрийн хувьд өөр байж болно. Мөн эдийн засгийн нөлөөллийн шалгуур (economic impact criterion), далдуур ялгаварлан гадуурхах (implicit discrimination), үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured nation treatment), үл ялгаварлахыг (non-discrimination) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
922	National treatment instrument	Үндэсний нөхцөлийн эрх зүйн акт. Энэ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) эрх зүйн акт юм. Энэ нь 1976 онд батлагдсан Олон улсын хөрөнгө оруулалт ба Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдийн тухай Тунхаглал (Declaration on International Investment and Multinational Enterprises) болон 1991 батлагдсан Үндэсний нөхцөлийн тухай гуравдугаар шинэчлэн найруулсан шийдвэрийн (Third Revision Decision on National Treatment) үндэсний нөхцөлийнх нь хэсгүүдээс бүрэлдсэн байдаг. Энэхүү эрх зүйн акт нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлийн стандартыг тогтоосон байдаг бөгөөд тэдгээр нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад буй гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг ялгаварлан гадуурхлыг устгахад тусалдаг. Энэ нь хуулийн дагуу заавал биелүүлэх ёстой үүрэг биш боловч хуулийн дагуу үүрэг болгож журамласан процедурын хэлэлцээрт үндэслэн баталсан байдаг.
923	National Treatment Study	Үндэсний нөхцөлийн тухай судалгаа. 1988 онд батлагдсан Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хуулийн (Omnibus Trade and Competitiveness Act) дагуу АНУ-ын Сангийн Яамнаас нийтэлсэн судалгаа. Энэ нь олон улс орны банк, [хөрөнгөөр баталгаажсан] үнэт цаасны үйлчилгээнд хамаарах эрх зүйн зохицуулалтын ерөнхий бүтэц болон зах зээлийн нөхцөлүүдийн талаарх нарийвчилсан мэдээллийг агуулсан байдаг. Үндэсний нөхцөлийн тухай судалгаа нь санхүүгийн үйлчилгээний худалдаанд хэрэглэх олон улсын дүрмийг судалгаанд зориулсан үндсэн зөвлөмж бүхий лавлагаа баримт бичиг болгож чадсан байдаг. Хамгийн сүүлийн хэвлэл нь 1998 онд нийтлэгдсэн байна. Мөн АНУ-ын Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хууль (United States Omnibus Trade and Competitiveness Act), Гадаадын худалдаанд учирч буй саад тотгорын тухай Үндэсний худалдааны үнэлгээний тайланг (National Trade Estimate Report on Foreign Trade Barriers) үзнэ үү.
924	Natural persons	Хувь хүн буюу хувь этгээд (харьяат иргэн). Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS - YXEX) гишүүн орны иргэд эсвэл байнгын оршин суугчдад хэрэглэдэг нэр томьёо юм. Хэрэв харьяат иргэн нь YXEX-ийн бусад гишүүн орнуудад үйлчилгээ үзүүлдэг бол тэд YXEX-ийн дагуу эрхээ эдэлдэг байна.
925	Natural resource-based products	Байгалийн нөөцөд суурилсан бүтээгдэхүүнүүд. Байгалийн нөөцөд суурилсан бүтээгдэхүүн нь Уругвайн үе шатны хэлэлцээнд тусдаа хэлэлцээний багийн хувьд гол сэдэв болон яригдаж байсан бөгөөд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) орчинд авч үздэг ашигт малтмал, хүдэр, загс, загас агнуурын бүтээгдэхүүн, ойн бүтээгдэхүүн, банз мод болон цаас зэрэг зүйлс орно.
926	Natural trading blocs	Худалдааны хувьд жам ёсоор төвлөрсөн бүлэг орнууд. Энэ нь өөр хоорондоо ойрхон хөрш улс орнууд, тэдний хоорондын тээврийн зардал маш бага байдаг тул бие биетэйгээ худалдаа хийдэг улс орнуудыг тодорхойлохын тулд загварчлал гаргах зорилгоор Паул Кругманы хэрэглэсэн нэр томьёо юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
927	Natural-trading-partners hypothesis	Худалдааны жам ёсны түншүүдийн тухай таамаглал. Ихэнх худалдаагаа өөр хоорондоо аль хэдийнээ хийж буй улс орнуудын хоорондын чөлөөт худалдааны бүсийн хувьд хамгийн их ашиг орлоготой байдаг гэсэн таамаглал юм.
928	Negative comity	Сөрөг нийгэмлэг ба найрсаг ёс. Мөн үүнийг уламжлалт нийгэмлэг ба найрсаг ёс (traditional comity) гэж нэрлэнэ. Энэ нь өрсөлдөөний бодлогыг удирдан зохицуулахад хэрэглэдэг нэр томьёо юм. Энэ нь холбогдох хоёр талт хэлэлцээрийн нөхцөлийн дагуу аливаа улс орон өрсөлдөөний тухай өөрийн хуулийн дагуу үйл ажиллагаа эхлүүлж байгаа тохиолдолд бусад орны ашиг сонирхлыг харгалзан үзэх хэрэгтэй гэсэн утгатай юм. Мөн эерэг нийгэмлэг ба найрсаг ёсыг (positive comity) үзнэ үү.
929	Negative integration	Сөрөг интеграцчилал. Энэ нь шинэ эрх зүйн бүтэц тогтолцоог бий болгохгүйгээр хил дамнан худалдаанд учрах саад бэрхшээлийг арилгах явдал. Мөн эерэг интеграцчиллыг (positive integration) үзнэ үү.
930	Negative listings	Сөрөг жагсаалт/Хасалт хийх журмаар гаргадаг жагсаалт. Үүнийг Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) дагуу авсан зарим үүрэг амлалтын жагсаалтад ашигладаг. Улс орнууд хасалт хийх журмаар жагсаалтыг боловсруулахдаа нэн ялангуяа зах зээлд нэвтрэхэд зарим хязгаарлалт тавих болон үндэсний нөхцөлөөр зохицуулагдах байдлаар бүх үйлчилгээний үйл ажиллагааг жагсаагаагүй л бол, бүх үйлчилгээний үйл ажиллагаануудыг ҮХЕХ-ийн бүх нөхцөл, зүйл заалтуудад хамруулсан байна гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү арга барилын давуу тал нь бүх шинэ үйлчилгээнүүд автоматаар уг дүрэмд хамрагдана. Хөгжингүй орнууд санхүүгийн үйлчилгээний хувьд авах үүрэг амлалтандаа зориулж энэхүү арга барилыг ашигласан байдаг. Австрали ба Шинэ Зеландын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээр (ANZCERTA)-ийн протоколд хасалт хийх журмаар гаргадаг жагсаалтыг сонгосон байна. Мөн эерэг буюу нэмэх зарчмаар гаргадаг жагсаалтыг (positive listings) үзнэ үү.
931	Negative reciprocity	Сөрөг байдлаар харилцан адил байх. Энэхүү нэр томьёоны анхны утга агуулга нь одоо зөвхөн түүхэн ашиг сонирхол болж үлдсэн. Энэ нь 19-р зуун болон 20-р зууны эхэн үед АНУ болон зарим бусад орнуудын хувьд дагаж мөрдөж байсан практик арга туршлагыг тайлбарлаж байгаа бөгөөд тэд үндэслэлгүйгээр өндөр тариф ногдуулж байна гэж үзсэн орнуудын эсрэг өөрсдийн тарифаа өсгөдөг байсан. Гэвч сөрөг байдлаар харилцан адил байхыг голдуу зах зээлийг нээх механизм гэж үздэг байв. Энэхүү практик үйл ажиллагааг дэмжигчид ерөнхийдөө өөрсдийн тарифын өндөр хэмжээнд бага анхаарал тавьдаг мөн тэдний бодлогын үндэслэл нь үргэлж арилжааны шинж чанартай байсан.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
932	Negotiated protectionism	Хэлэлцэн тохиролцсон протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онол. Энэ бол, 1980-аад оны эхээр зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт болон сайн дурын хязгаарлалтын зохицуулалтууд гэх мэт худалдааг хязгаарлах чиглэлээр хэлэлцэн тохиролцсон эрх зүйн актуудыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх болсныг тайлбарлахын тулд зарим үед хэрэглэдэг нэр томьёо.
933	Negotiating coin	Хэлэлцээний зоос. Энэ нь хэлэлцээрийн явцад нэг тал нь өөрийн хүссэн ямар нэгэн зорилгодоо хүрэхийн тулд буулт хийхийг хүсэж байгаа тэр зүйл нь. Заримдаа хэлэлцээний зоос нь зохиомол байдаг боловч энэ нь бие даан хийх либералчлалд зориулсан төлбөр болох зэрэг асуудлын хувьд чухал зүйл болдог байна.
934	Negotiating credits	Хэлэлцээ хийх итгэл. ДХБ-д байдаг энэхүү албан бус практик үйл ажиллагааны хувьд товлогдсон өдрөөс өмнө (ихэвчлэн хэлэлцээг эхлүүлэх үетэй холбоотой огноо байдаг) бусад оролцогчдын зүгээс дангаараа/нэг талыг баримтлан тарифыг бууруулах нөхцөлийг улс орнууд харгалзан үздэг байна. Энэхүү практик үйл ажиллагаа нь оролцогчид бусдаас хамгийн бага хэмжээний саад тотгорын хэлбэрээр хангалттай нөхөн олговор аваагүй тохиолдолд тэд өөрсдийн саад тотгорыг бууруулах шаардлагагүй гэдгийг баталгаажуулах зорилготой. Ийм янзаар, уг практик үйл ажиллагаа нь тохиромжтой үед нь тааруулан улс орнуудын худалдааг либералчлахыг уриалдаг. Хэлэлцээ хийх итгэлийг олгох нь худалдааны либералчлалыг либералчлалж буй улсын зардал болно гэсэн ташаа ойлголт бий.
935	Negotiating rights	Хэлэлцээ хийх эрх. ДХБ-ын зорилгуудын нэг нь худалдааны саад тотгорыг бууруулах болон арилгахад чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулах үйл хэрэг. Үүнийг хэлэлцээгээр дамжуулан хийдэг боловч ийм үйл ажиллагаанд оролцох эрх нь тодорхой дүрэм журамд заасан нөхцөлөөс хамаатай байдаг. Саад тотгорыг бууруулах ажлын дийлэнх хэсгийг олон талт худалдааны хэлэлцээнүүд, үе шатны гэх хэлэлцээрүүд, салбарын хүрээний худалдааны хэлэлцээнүүдээр дамжуулан одоогоор хийгдэж байдаг. ДХБ-ын бүх гишүүд үүнд оролцох эрхтэй. Бусад нөхцөл байдлын хувьд, тэд автоматаар хэлэлцээ хийх эрхгүй байх магадлалтай. [Автоматаар хэлэлцээ хийх эрх байх эсэх нь] зарим нөхцөл байдлууд тэр дундаа үндсэн ханган нийлүүлэгчийн дүрэм (principal supplier rule) болон ихээхэн хэмжээгээр ханган нийлүүлэгчийн дүрэм (substantial supplier rule) багтана. Хэлэлцээ хийх эрх үүсэж болох зарим тохиолдлуудын хувьд тарифын талаар дахин хэлэлцээ (renegotiation of tariffs) хийж эхлэх тохиолдол багтаж болдог. Мөн хэлцээ хийх анхдагч эрхийг (initial negotiating rights) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
936	Neighbouring rights	<p>Зэрэгцээ эрх буюу хөршийн эрх. Энэ нь жүжигчид, фонограмм үйлдвэрлэгчид, өргөн нэвтрүүлэгчдийн онцгой эрх. Иймэрхүү эрхийг зохиогчдын эрхийг хамгаалах уламжлалт чиглэлийн түүхэн талаас нь авч үзвэл “хөрш” гэж тодотгосон байдаг. Зэрэгцээ буюу хөршийн эрх нь үүсмэл субьекттэй (жишээ нь, бичлэгийн компани хөгжмийн зохиол бичиж байна гэх мэт) холбоотой байдаг гэж үздэг ба үүнд шагнал урамшууллыг хүртэх эрхтэй тухайн бүтээлч хүнийг тодорхойлоход харьцангуйилуу бэрх байх магадлалтай. Мөн Бернийн конвенц (Berne Convention), зохиогчийн эрхийг (copyright) үзнэ үү.</p>
937	New commercial policy instrument	<p>Худалдаа, арилжааны бодлогын шинэ эрх зүйн акт (NCPI). Энэ бол 1984 онд Европын хамтын нийгэмлэгийн баталсан дүрэм журам. Энэ нь нутаг дэвсгэртээ оршин суугаа компаниуд [Европын] хамтын нийгэмлэгийн аж үйлдвэрүүдэд хохирол учруулсан гуравдагч улс орнуудын хууль бус арилжааны практик үйл ажиллагааны эсрэг нөхөн төлбөр гаргуулан авах талаар Европын Комисст (European Commission) өргөдөл гаргах боломжийг олгодог байна. Хэрэв холбогдох хууль бус практик үйл ажиллагаа нь олон улсын хууль эсвэл өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм журамтай нийцэхгүй бөгөөд уг практик үйл ажиллагаа нь гуравдагч улстай хамааралтай байсан тохиолдолд л зөвхөн уг арилжааны бодлогын шинэ эрх зүйн актыг хэрэглэхийг уриалж болно. Энэхүү эрх зүйн актыг худалдааны хохирлыг арилгах бусад арга хэмжээ байгаа тохиолдолд ашиглах боломжгүй. Жишээ нь, энэхүү дүрэм журмын дагуу демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) авах боломжгүй болох болно. Уг дүрэм журам нь АНУ-ын хууль тогтоомжийн дагуу гарсан 301-р хэсэг (Section 301) дээр тодорхой хэмжээнд үндэслэн загварчлагдсан гэж харагддаг. Гэвч үүнийг 301-р хэсгээс ялгаж өгч байгаа зүйл нь гэвэл, бусад зах зээлийг нээнэ гэхээс илүүтэйгээр гадаадын зарим практик үйл ажиллагааны эсрэг Европын хамтын нийгэмлэгийг хамгаалах асуудлыг илүү чухалчилдаг. 1984 оны арилжааны бодлогын шинэ эрх зүйн актыг маш ховор хэрэглэсэн байсан. Зарим талаараа, ДХБ-ын эрх зүйн актуудын хүрээнд Европын хамтын нийгэмлэгийн хүлээсэн үүрэг хариуцлагатай нийцүүлэн уялдуулах зорилгоор 1994 онд уг дүрэм журмыг шинэчилсэн. Үүнд гарсан гол өөрчлөлт бол “хууль бус (illicit)” практик арга ажиллагааг “худалдаан дах саад тотгор (obstacles to trade)” гэж солиод мөн үүнд үйлчилгээг хамааруулсан байдаг. Эдгээр өөрчлөлтүүд нь арилжааны бодлогын шинэ эрх зүйн актын шинж чанарыг бүхэлд нь өөрчлөөгүй болно.</p>
938	New industrial policies	<p>Аж үйлдвэрийн шинэ бодлого (NIPs). Энэхүү нэр томьёог заримдаа зорилтот аж үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогод хэрэглэдэг бөгөөд энэ нь дараах хоёр бодлогын хоёулангаас нь өөр юм. Үүнд эхнийх нь, Laissez-faire policy буюу “хүмүүс юу хийхийг хүсэж байна түүнийгээ хийхийг нь зөвшөөрөх” бодлого нь аж үйлдвэрлэлийн хөгжлийг өргөн хүрээг зах зээл өөрөө тодорхойлохыг нь зөвшөөрөх явдал. Нөгөөх нь, аж үйлдвэрүүдэд импортын өрсөлдөөний эсрэг хамгаалалт бий болгох зорилготой энгийн хамгаалалт.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>NIPs-д хадгаламж болон капиталын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх засгийн газрын арга хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн дунд технологийг албадлагын дагуу заавал эсвэл өгсөн удирдлага чиглэлийн дагуу харилцан хуваалцах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор албадан нэгтгэх (forced mergers), харилцан хамт ажилладаг судалгаа болон хөгжлийн байгууламжууд, татаас олгох магадлал гэх мэтийг багтаасан байдаг. Мөн үндэсний аваргыг (national champions) үзнэ үү.</p>
939	<p>New international division of labour</p>	<p>Хөдөлмөрийн олон улсын шинэ хуваарилалт. Энэ нь олон улсын хөдөлмөрийн хуваарилалтын үзэл баримтлалын хувьсал хөгжил бөгөөд үүнд үнийн өрсөлдөөн нь компаниуд бүтээгдэхүүнээ хэрхэн үйлдвэрлэдэг болохыг тодорхойлох цорын ганц эсвэл ноёрхогч шийдвэрлэх хүчин зүйл байхаа нэгэнт больсон. Уг систем нь тодорхой хэмжээнд хэрэглэгчдийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг боловч энэ нь мөн тэдэнд олон хуурмаг сонголтуудыг бий болгож өгч байдаг. Шинжээчдийн үзэж байгаагаар энэхүү системд бусад олон зүйлээс гадна, бүтээгдэхүүний уян хатан байдал, хурдацтай шинэчлэл, олон төрлийн мэргэжлийн чадвартай ажилчид, үйлдвэрлэлийн хуваарийг илүү нягт нэгтгэх болон холбогдох үйлдвэрлэлийн нэгжүүдтэй холбоотой бүтээгдэхүүн боловсруулалт үйлдвэрлэлтэй илүү нягт холбож уялдуулах гэх мэт зүйлс шаардлагатай гэж үздэг. Корпорацууд өөрсдийн өрсөлдөөний шаардлагыг хамгийн дээд зэргээр хангах зорилгоор үйлдвэрлэлийн нэгжүүдээ олон улсад тараан байршуулдаг байна. Мөн Фордын онол (Fordism), даяарчлал (globalisation), Фордын дараах онол (Post-Fordism), бүтээгдэхүүний мөчлөгийн онол (product cycle theory), үндэстэн дамнасан корпорацыг (transnational corporations) үзнэ үү.</p>
940	<p>New International Economic Order</p>	<p>Олон улсын эдийн засгийн шинэ дэглэм (NIEO). 1970-аад оны эхээр олон улсын эдийн засгийн дэг журамд эрс өөрчлөлт бий болгох зорилгоор хөгжиж буй орнуудын эхлүүлсэн кампанит ажил. Энэ нь Дэлхийн 2-р дайн дууссанаас хойш үүссэн эдийн засаг болон технологийн хүрээнд гарсан ахиц дэвшил нь хөгжиж буй орнуудын хүмүүсийн амьдралыг ямар нэгэн утга учиртай арга замаар өргөжүүлэн баяжуулж чадаагүй гэсэн ойлголтод суурилж гарсан байдаг. Ялангуяа түүхий эд, материалын экспортоос хамааралтай хөгжиж буй улс орнуудын хувьд 1970-аад оны эхэн үед хүсэн хүлээлтийн өсөлт хэмээх хувьсал болон түүхий эд, материалын үнийн уналт хоёрын дунд баригдмал байдалтай байгаагаар мэдэрч эхэлсэн байна. Мөн, энэхүү хөнгөлөлттэй боловч тодорхой болзолтой нөхцөлийн дагуу олгогдсон зээлийн тусламжтайгаар хөгжинө гэдэг нь, хөгжиж буй орнуудын өр төлбөрийн ачааллыг зөвхөн нэмэгдүүлж, улмаар тэднийг хөгжингүй орнуудын бодлого болон үйл ажиллагаанаас өршөөл аврал эрсэн байдалд маш ихээр хүргэж байна гэсэн ойлголт бий болж байлаа. 1973 онд болсон ОПЕК-ын Сайд нарын бага хурлаар газрын тосны үнийг дөрөв дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргаснаар, NIEO-ийн эрэлт хэрэгцээнд ихээхэн түлхэц болж өгсөн.</p>

Газрын тос экспортлогч улс орнуудын (ОРЕС-ОПЕК) гишүүн орнуудын ашиг орлогыг нэмэгдүүлэхэд энэхүү бодлогын хувьд үзүүлсэн илэрхий тод амжилт нь, хөгжиж буй улс орны хүсэл эрмэлзлийг урагшлуулахад бусад түүхий эд, материалуудыг бас нийцүүлэн зохицуулж болох юм байна гэсэн үзэл санааг хөхиүлэх болсон байна. ОПЕК-ын шийдвэрийг зөв учир шалтгааны үүднээс хийсэн гэж олон хөгжиж буй орнууд үзэж байлаа. Нөгөө талаар 1973 онд Израиль улстай хийсэн дайны үр дүнд Арабын улс орнууд газрын тосыг улс төрийн зэвсэг болгож ашиглахыг эрэлхийлсэн байдаг. Нөгөөтээгүүр тэд хөгжингүй орнуудад гол төлөв хохирол учруулах замаар өөрсдийн ашиг орлогоо нэмэгдүүлэх арга замыг олж нээсэн хэрэг байлаа. Энэ үндэслэлийн хүрээнд 1974 онд уг НҮБ-ын Олон улсын эдийн засгийн шинэ дэг журмын хөтөлбөрийг баталсан. Энэ нь Ерөнхий Ассамблейн 3201 (S-VI) ба 3202 (S-VI)-р тогтоолуудыг гаргах хэлбэрээр Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам байгуулах тухай тунхаглал болон Олон улсын эдийн засгийн шинэ дэглэмд зориулсан Үйл ажиллагааны хөтөлбөрөөс (Programme of Action on the Establishment of a New International Economic Order) бүрдсэн. Тунхаглалд түүхий эд, хөгжлийн асуудлуудад онцгой анхаарал хандуулж, 1970 оноос хойш хөгжиж буй улс орнуудад ноцтой хор хохирол учруулсан, сүйрлийн хэмжээний хэд хэдэн хямрал дэлхийн эдийн засагт тулгарч байсныг дурдсан байна. Үйл ажиллагааны хөтөлбөр нь ч мөн адил идэвх санаачилгатай байв. Энэ нь худалдаа, хөгжлийн асуудал болон хүнсний хямралтай холбоотой түүхий эд, материал ба анхдагч түүхий эдийн бараа бүтээгдэхүүнүүдийн суурь асуудлуудыг шийдэх гарцыг эрэлхийлсэн байлаа.

Түүнчлэн нөхөн олговрын санхүүжилтийн зохицуулалт, сайжруулсан Хөнгөлөлтийн ерөнхий системийн хувилбар, нөөц бараа бүтээгдэхүүнийг бий болгох зэрэг худалдааны үйл ажиллагааны урт жагсаалтыг санал болгосон. Мөн тээвэр, даатгал болон олон улсын валютын тогтолцоог сайжруулахыг эрмэлзсэн. Эдгээр зүйлсийн олонхыг нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаар (UNCTAD) авч хэлэлцэгдсэн бөгөөд жишээ нь 1976 онд Бараа материалын нийтийн/хамтын сан болон Бараа материалын нэгдсэн хөтөлбөр байгуулах талаар санал дэвшүүлэхэд хүргэсэн байна. NIEO-ын нөхцөл байдлын хувьд хөгжингүй орнуудын зүгээс ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан боловч зарим хөгжингүй орнуудын томоохон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд хэрэв түүхий эд материалын арга хэмжээг авч хэрэгжүүлж чадваас экспортын ашиг өндөр байж болох хэтийн төлөв харагдсан нь тэднийг татаж байлаа. Олон улсын бусад байгууллагууд, жишээ нь Токиогийн үе шатны хэлэлцээтэй зэрэгцэн хэрэгжиж байсан Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр нь мөн хөгжиж буй орнуудын үзэл бодолд онцгой анхаарал хандуулж байсан ч, NIEO нь 1980-аад оны эхэн үеэс эхлэн хөтөлбөр гэдэг утгаараа хэрэгжиж эхэлсэн байдаг. Мөн Улс орнуудын эдийн засгийн эрх, үүргийн дүрэм (Charter of Economic Rights and Duties of States), Умард-Өмнөд яриа хэлэлцээг (North-South dialogue) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
941	Newly industrialising economies	Аж үйлдвэржиж буй шинэ эдийн засгууд. Үүнээс гадна шинээр аж үйлдвэржиж буй улс орнууд гэж нэрлэдэг. Голдуу 1980-аад онд, аж үйлдвэржсэн эдийн засагтай орнуудын олон шинж чанаруудтай ойртож дөхсөн түвшинд эдийн засгийнхаа ихээхэн хэсгийг өөрчлөн байгуулах үе шатандаа яваа хөгжиж буй орнуудын хувьд ашиглагдаж байсан нэр томьёо юм. Ийм эдийн засагтай орнуудын жишээнд Хонг Конг, Мексик, Малайз, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайвань болон Сингапур нар орно.
942	Newly liberalising countries	Либералчилагдаж буй шинэ улс орнууд. Уг томьёо нь, өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжин өөрчлөгдөж буй Тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэгийг (Commonwealth of Independent States) бүрдүүлж байдаг Төв болон Зүүн Европын улс орнууд мөн дээр нь Хятад улсын хувьд хэрэглэдэг нэр томьёо юм. Үүний зэрэгцээ тэдний гадаад худалдааны төвлөрсөн дэглэм нь ч бас либералчлагдаж байна.
943	New protectionism	Шинэ протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах ухаан. 1980-аад онд нийтлэг ашиглагдаж байсан нэр томьёо. Үүнд, өндөр тарифаар илэрч байдаг хамгаалалтын үйл ажиллагаатай харьцуулбал уг томьёо нь тоон хязгаарлалтууд, сайн дурын хязгаарлалтын зохицуулалтууд, зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт зэргийг тайлбарлахад ашигладаг байсан. Мөн саарал бүсийн арга хэмжээ (grey-area measures) үзнэ үү.
944	New trade agenda	Худалдааны шинэ хөтөлбөр. Энэ нь зах зээлд нэвтрэхэд өнөөг хүртэл шийдэл хайж байгаа нөхцөл байдлыг тайлбарлах үүднээс зарим хүмүүсийн ашигладаг нэр томьёо. Энэ өнцгөөс нь харвал, уламжлалт худалдааны тухай хөтөлбөр нь тарифын болон тарифын бус арга хэмжээнээс бүрдэх хилийн арга хэмжээг багасгах хүчин чармайлтын хүрээнд илэрхийлэгдэж байдаг. Нөгөө талаас, худалдааны шинэ хөтөлбөр нь стандарт, ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээнд хэтэрхий их найдах, хувийн хэвшлийн болон төрийн өрсөлдөөний эсрэг арга ажиллагаа зэрэг зах зээлийн дотоод орчны саад тотгор луу илүү чиглэгдсэн байдаг. Зарим талаараа худалдааны шинэ хөтөлбөр нь тодорхой хэмжээгээр худалдааны шинэ асуудлуудтай давхцаж байгаа боловч бусад талаар одоо оршиж буй олон талт худалдааны хэлэлцээрээс илүү тохиромжтой үр дүнд хүрэхийг эрмэлзэж байна. Мөн худалдаан дах техникийн саад тотгорыг (technical barriers to trade) үзнэ үү.
945	New trade issues	Худалдааны шинэ асуудлууд. Энэ нь худалдааны шинэ хэв загварууд, шинэ бүтээгдэхүүн, шинэ технологи эсвэл худалдааны бодлого, нийгмийн бодлого хоёрын уялдаа нэгдэл зэрэг урган гарч ирж буй нөхцөл байдлын улмаас үүсэж буй асуудлууд. "Худалдааны шинэ асуудлууд" гэсэн нэр томьёо нь ихэвчлэн маш энгийнээр илэрхийлбэл, холбогдох асуудлуудыг шийдвэрлэх олон талт худалдааны албан ёсны бүтэц тогтолцоо хараахан тогтоогүй байгаа эсвэл уг асуудлуудыг дөнгөж саяхнаас ДХБ дотроос анхааралдаа авж эхэлсэн байна гэдэг утгыг илэрхийлж байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Одоогийн байдлаар хэлэлцэж буй худалдааны шинэ асуудлуудын хүрээнд худалдаа ба өрсөлдөөн, худалдаа ба хууль бус төлбөр тооцоо, худалдаа ба хөрөнгө оруулалт мөн худалдаа ба хөдөлмөрийн стандарт зэрэг асуудлууд орно. Зарим нь уг жагсаалтад худалдаа ба хүрээлэн буй орчныг нэмсэн байдаг боловч ДХБ-ын Худалдаа ба хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн хороог (Committee on Trade and Environment in the WTO) байгуулах шийдвэр гаргаснаар уг асуудлыг хэрэв шийдвэрлэж чадахгүй юм бол бодитой асуудал гэж олон хүмүүсийг ятган ойлгуулахад нөлөө үзүүлсэн байна. Үе үе худалдаа ба соёл, худалдаа ба гадаад валют, худалдаа ба татварын асуудлуудыг мөн анхаар үзэх талаар санал дэвшүүлдэг байна.</p>
946	New trade order	<p>Худалдааны шинэ дэг журам. Энэхүү нэр томьёо нь нарийн оновчтой утга агуулаагүй ч, орчин үеийн судалгааны бүтээлийн хүрээнд үүнийг Дэлхийн Худалдааны Байгууллага (WTO) байгуулагдсантай холбоотойгоор эхэлсэн дэлхийн худалдааны тогтолцоог голчилж хэлж байна. Хэрэв зарим тодорхой эрх зүйн акт эсвэл дүрэм журмын хувьд тохиролцож чадах юм бол заримынх нь үзэж буйгаар бол худалдааны зохистой тогтолцоо бий болох нөхцөлийг тайлбарлахад ашигладаг байна.</p>
947	New trade theory	<p>Худалдааны шинэ онол. “Леонтьевийн парадокс” (Leontief Paradox)-оос үүсэл гаралтай, олон улсын худалдааны судалгааны дүн шинжилгээний нэгэн арга хандлага. 1953 онд Америкийн эдийн засагч Василий Леонтьев нь орц-гарцын статистикийн дүн шинжилгээндээ капитал хөрөнгө ихтэй орон болох АНУ нь хөрөнгө оруулалт ихийг шаарддаг бүтээгдэхүүнээс илүү хөдөлмөрийн хүч ихээр шаарддаг бүтээгдэхүүнийг амжилттай экспортлодог болохыг олж мэдсэн байна. Энэ нь харьцангуй давуу талын онолыг дахин нотолгоожуулж байдаг Хеккер-Охлиний теоремийн дагуу (Heckscher-Ohlin theorem) түүний тооцоолж байсан хүлээлтээс энэ нь зөрчилдсөн эсрэг утгатай байсан байна. Үүнийг тайлбарлахын тулд эдийн засагчдын гаргасан хүчин чармайлтын үр дүнд улмаар технологи, судалгаа болон хөгжил зэрэг хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан авч үзсэн худалдааны шинэ онолыг бий болгоход хүргэсэн байдаг. Эдгээр хүчин зүйлүүд нь одоо тухайн улсын хувьд урьд өмнө байгаагүй харьцангуй давуу талыг олж авах боломжийг олгосон байна. 1967 онд гарч ирсэн бүтээгдэхүүний мөчлөгийн онол нь дунд хугацааны чухал үр дүн байв. Эцсийн үе шат нь стратегийн худалдааны онол бөгөөд үүний тайлбар нь янз бүр байдаг байна. Уг онолыг мэдээж хэрэг ялагчдыг онилж, өө эрэхээс хамгаалахад ашигласан байдаг. Энэ нь ерөнхийдөө энэхүү онолыг дэмжиж байдаг эдийн засагчдын зорилго гэж харагддаггүй. Мөн Өрсөлдөх чадвартай давуу талыг (competitive advantage) үзнэ үү.</p>

948

New Transatlantic Agenda

Атлантын Далайг дамнасан шинэ хөтөлбөр. Энэ нь 1995 оны 12-р сарын 3-нд Мадрид хотод болсон Европын Холбоо болон АНУ-ын Дээд түвшний уулзалтаар батлагдсан. Энэ нь хоёр талыг олон улсын эдийн засаг, нийгмийн болон улс төрийн өргөн хүрээний асуудлууд дээр хүчээ нэгтгэх боломжийг бий болгосон. Энэхүү шинэ хөтөлбөрт дөрвөн зорилго байдаг ба 3-р зорилго нь дэлхийн худалдааны тогтолцоог бэхжүүлэх ба эдийн засгийн хувьд ойр хамтын ажиллагаанд хүрэхэд чиглэгдсэн болно. Энэ нь дараах асуудлуудад чиглэсэн, үүнд (a) ДХБ нь төлөвлөсний дагуу сайн ажиллаж байх нөхцөлийг хангаж ажиллах мөн худалдааны шинэ асуудлуудын хүрээнд хамтран ажиллах алхмуудад чиглэсэн, (b) хоёр-талт харилцааны хүрээнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тарифуудыг цаашид улам бууруулах эсвэл арилгах мөн Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээний (Uruguay Round) дагуу тарифыг бууруулах үйл ажиллагааг хурдасгах, (c) Атлантын далайг дамнасан шинэ зах зээлийн орчинг (New Transatlantic Marketplace) үүсгэн байгуулах замаар Атлантын далайг дамнасан худалдаан дах [эрх зүйн] зохицуулалт болон бусад саад хоригийг арилгах бодит алхмууд зэрэг болно. Бусад гурван зорилтуудын хувьд: дэлхий даяар энх тайван, хөгжил цэцэглэлт болон ардчиллыг хөхиүлэн дэмжих, дэлхийн хэмжээнд тулгамдаж буй сорилтуудад хариу арга хэмжээ авах, Атлантын далайг дамнасан гүүр барих зэрэг асуудал юм. Мөн Атлантын Далайг дамнасан бизнесийн яриа хэлэлцээг (Transatlantic Business Dialogue) үзнэ үү.

949

New Transatlantic Marketplace

Атлантын Далайг дамнасан шинэ зах зээл. Энэ нь Атлантын Далайг дамнасан шинэ хөтөлбөрийн (New Transatlantic Agenda) зорилтуудын нэг бол үйл ажиллагааны хөтөлбөр бөгөөд үүнд дараах зүйлсийг хамруулсан байдаг: бараа болон үйлчилгээний худалдааг дэмжиж хөнгөвчлөх мөн тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгах талаар хамтарсан судалгаа хийх, хоёр-талын худалдааны асуудлыг шийдвэрлэх замаар итгэл найдварыг бий болгох; стандарт, баталгаажуулалт, эрх зүйн зохицуулалтын асуудлууд; мал эмнэлэг болон ургамлын эрүүл төлөв байдлын тухай асуудлууд; засгийн газрын худалдан авалт; оюуны өмчийн эрх; санхүүгийн үйлчилгээний талаарх хоёр талын яриа хэлэлцээг өргөжүүлэх; гаалийн хамтын ажиллагаа болон харилцан туслалцах тухай хэлэлцээр байгуулах; Мэдээллийн тухай нийгмийн хоёр-талт яриа хэлэлцээг өргөжүүлэх болон мэдээллийн технологи ба цахилгаан холбооны салбарт хамтран ажиллах; өрсөлдөөний асуудлуудтай холбоотой хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх; тоон мэдээлэл өгөгдлийн хамгаалалтын асуудлаар хамтран ажиллах; агаарын болон далайн тээврийн асуудлуудын талаарх хамтын ажиллагааг өргөжүүлэх; эрчим хүчтэй холбоотой асуудлуудын хүрээнд хамтын ажиллагааг эрчимжүүлэх; биотехнологи; аюулгүй байдал ба эрүүл мэнд зэрэг болно. Мөн Атлантын Далайг дамнасан бизнесийн яриа хэлэлцээг (Transatlantic Business Dialogue) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
950	New Zealand Australia Free Trade Agreement	Шинэ Зеланд ба Австрали хоорондын чөлөөт худалдааны хэлэлцээр (NZAFTA). 1966 оноос 1982 оны хооронд Австрали болон Шинэ Зеланд улс хоорондын худалдааны харилцааг зохицуулж байсан худалдааны хэлэлцээр. Энэ нь уг хоёр улсын хоорондын худалдааг их хэмжээгээр чөлөөлж либералчилж өгсөн боловч бүрэн хэмжээний чөлөөт худалдааг байгуулж чадаагүй байна. Энэхүү гэрээ нь 1983 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Австрали болон Шинэ Зеланд улсуудын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээрээр (ANZCERTA) солигдсон байна.
951	NGBT	Үндсэн цахилгаан холбооны хэлэлцээний багийг (Negotiating Group on Basic Telecommunications) үзнэ үү.
952	NGMTS	Далайн тээврийн үйлчилгээний хэлэлцээний баг (NGMTS). Далайн тээврийн үйлчилгээг (maritime transport services) үзнэ үү.
953	Nice Agreement Concerning the International Classification of Goods and Services for the Purposes of the Registration of Marks	Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай [Франц улсын] Ницийн хэлэлцээр. 1957 онд байгуулагдсан бөгөөд сүүлд 1979 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэхүү гэрээг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) удирддаг ба одоогоор 100 гаруй гишүүнтэй. Энэ гэрээг худалдааны тэмдэгтүүдийг үнэлэх болон бүртгэхэд ашигладаг ба үүнд бараа, үйлчилгээний 42 ангиллыг бий болгосон байна.
954	Nominal rate of protection	Хамгаалалтын нэрлэсэн хувь хэмжээ. Энэ нь тухайн бүтээгдэхүүний дотоодын үнэ нь хил дээрх үнээс давсан тохиолдолд, гол төлөв хувиар илэрхийлэн тооцож авч үздэг (өөрөөр хэлбэл аливаа гаалийн татвар ноогдуулахаас өмнө) эдийн засгийн ойлголт. Мөн хамгаалалтын үр дүнтэй түвшин (effective rate of protection) ба үнийн шаантагийг (price wedges) үзнэ үү.
955	Nominal tariff	Нэрлэсэн тариф. Энэ нь тухайн улсын тарифын жагсаалтад заасан/нэрлэсэн тариф. Энэ нь мөрдөж буй тарифын (тухайн бүтээгдэхүүнийг импортлох үед гаалийн байгууллагаас бодитоор ногдуулж буй тариф) хувь хэмжээнээс ялгаатай байж болно. Үүрэг хүлээсэн тариф (bindings) үзнэ үү.
956	Non-actionable subsidies	[Эрх зүйн] хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаас. ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт (WTO Agreement on Subsidies and Countervailing Measures) тодорхойлогдсон татааснуудын төрөл. Үүнд судалдаа ба хөгжилд үзүүлсэн дэмжлэг, сул дорой хөгжилтэй бүс нутгуудад үзүүлэх тусламж, одоогоор оршин буй байгууламжийг хүрээлэн буй орчны шинэ, илүү хүнд шаардлагад нийцүүлэн дасан зохицоход нь үзүүлэх тусламж, дэмжлэг зэрэг зүйлс орно. Уг хэлэлцээрт татаасыг хэрхэн яаж тайлбарлах талаар дэлгэрэнгүй тайлбарласан байна. Хэрэв ДХБ-ын нэг гишүүн нь өөр/эсрэг тохиолдолд эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй байх байсан тухайн татаасыг ноцтой сөрөг үр нөлөө учруулсан гэж үзэж байвал, уг асуудлаар тодорхой шийдэл ба зөвлөгөө хүсэж болно. Уг хэлэлцээр нь хөдөө аж ахуйн татааст хамаарахгүй.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Харин үүнийг Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрт хамааран авч үздэг байна. Мөн Эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаас (actionable subsidies), хориглосон татаас (prohibited subsidies), татаас (subsidies) зэрэг нэр томьёог үзнэ үү.
957	Non-agricultural market access	Хөдөө аж ахуйн бус зах зээлд нэвтрэх. Энэ нь Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрт (Agreement on Agriculture) тусгагдсанаас бусад бүтээгдэхүүний хувьд хийгдэх тарифын хэлэлцээг заадаг. Зөвхөн хөтөлбөрт тусгасан бол хөдөө аж ахуйн салбарын тарифын хэлэлцээг урьдчилан харж болдог боловч харин бусад аль ч салбарт ийм боломж байдаггүй байна. Энэхүү нэр томьёог [АНУ-ын] Сиатл хотод болсон ДХБ-ын Сайд нарын бага хурлын (Seattle WTO Ministerial Conference) бэлтгэл үе шатанд, бүх салбарыг хамарсан тарифын хэлэлцээнүүд хийх бүрэн эрхийг хангаж ажиллах зорилгоор үүсгэн бий болгосон байна.
958	Non-application	Эс хэрэглэгдэх. Энэ нь олон талт худалдааны зарим хэлэлцээрүүдийг тодорхой гишүүн орнуудын дунд мөрдөхгүй байх нөхцөл. Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн 13-р зүйлд заасны дагуу энэхүү хэлэлцээр болон ДХБ-ын удирдаж байдаг бусад хэлэлцээрүүд нь, [ДХБ-ын] хоёр гишүүн улс тухайн үед гишүүнээр элсэж орж байх цаг үед хэрэв аль аль нь тэдгээр хуулиудыг хэрэгжүүлэх тал дээр зөвшөөрөөгүй бол, тэдгээр хоёр гишүүн орнуудын дунд эдгээр хуулиуд үйлчлэхгүй ба эс хэрэглэгдэнэ гэсэн үг. Тиймээс эс хэрэглэгдэнэ гэдэг нь зөвхөн тухайн улс ДХБ-д элсэж байх тэр үед л үйлчлэх буюу хэрэглэгдэх боломжтой. Мөн үр ашиг хүртээхээс татгалзахыг (denial of benefits) үзнэ үү.
959	Non-discrimination	Ялгаварлан гадуурхахгүй байх. Энэ нь олон талт худалдааны бүтэц хамрах хүрээний үндсэн үзэл баримтлал юм. Аливаа улс гадаадын ханган нийлүүлэгч улс орнуудын дунд ялгаварлан гадуурхахгүй байх бөгөөд хэрэв тэдний нутаг дэвсгэрт хууль ёсоор нэвтэрсний дараа тухайн бараа бүтээгдэхүүнд сөргөөр ялгаварлан гадуурхах нөхцөлөөр хандаж болохгүй юм. ДХБ-ын дүрэмд хатуу зааж тодорхойлсон нөхцөлийн дор энэхүү үзэл баримтлалыг мөрдөхгүй байж болох зарим онцгой нөхцөлийг зөвшөөрдөг. Жишээлбэл, чөлөөт худалдааны бүс эсвэл гаалийн холбооны гишүүн орнууд тарифын хувь хэмжээг хэрэглэхдээ гишүүн бус улс орнуудын эсрэг ялгаварлан гадуурхаж болдог. Мөн ДХБ-ын гишүүн орнууд хөгжиж буй орнуудад зориулж хөнгөлөлттэй тарифын тогтолцоог хэрэгжүүлэх боломжтой байдаг. Мөн Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP), үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured-nation treatment) болон үндэсний нөхцөлийг (national treatment) үзнэ үү.
960	Non-dutiable goods	Татвар ногдуулахгүй бараа бүтээгдэхүүн. Энэ нь гаалийн нутаг дэвсгэрт орох болон гарахад татвар ногдуулдаггүй барааг хэлнэ. Мөн Гаалийн ямар нэгэн татваргүй чөлөөтэй импортлогдох бараа бүтээгдэхүүний жагсаалтыг (free list) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
961	Non-equity-based investment	Эздийн өмчийн бус хөрөнгө оруулалт. Үүнд лицензийн гэрээ, менежментийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах зохицуулалт, эрсдэл хуваах гэрээ, олон улсын түвшинд дэд гэрээ байгуулах гэх мэт хэлбэрийн хөрөнгө оруулалтууд орно. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт (foreign direct investment), хөрөнгө оруулалт (investment), портфель хөрөнгө оруулалтыг (portfolio investment) үзнэ үү.
962	Non-market economies	Зах зээлийн бус эдийн засаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг (centrally-planned economy) үзнэ үү.
963	Non-price predation	Үнийн бус түрэмгийлэл. Энэ нь амжилттай яваа өрсөлдөгч нарыг хүчээр бизнесээс нь зайлуулахын тулд буруу хууль тогтоомж гаргуулах мөн тэдэнд их хэмжээний зардал учруулах зэрэг өөр бусад аргыг ашиглаж буй үйлдлийг хэлдэг. Жишээлбэл, хувийн ашиг сонирхлын үүднээс хортойгоор ашиглаж буй шүүхийн маргаан нь өрсөлдөгчдийн хувьд зарим чухал оюуны өмчийн эрхээ хамгаалуулах нөхцөлийг нь хангаж ажиллахын оронд харин тэд үүнийгээ ашиглаж чадахгүй байхад хүргэдэг байна. Мөн түрэмгийгээр үнэ тогтоохыг (predatory pricing) үзнэ үү.
964	Non-reciprocal free-trade area	Харилцан адил байх нөхцөлгүй чөлөөт худалдааны бүс. Чөлөөт худалдааны бүсийг (free-trade area) үзнэ үү.
965	Non-tariff barriers	Тарифын бус саад тотгор. Тарифын бус саад тотгорын арга хэмжээг (non-tariff measures) үзнэ үү.
966	Non-tariff distortions	Тарифын бус арга хэмжээнээс үүссэн гажуудал. Энэ нь тарифын бус арга хэмжээ хэрэглэснээс үүдэн худалдааны урсгалд үзүүлэх сөрөг нөлөөлөл.
967	Non-tariff measures	Тарифын бус арга хэмжээ. Худалдааны урсгалыг хязгаарлахад чиглэсэн тарифаас бусад засгийн газрын арга хэмжээ. Тухайлбал, тоо хэмжээний хязгаарлалт, импортын тусгай зөвшөөрөл, сайн дурын хязгаарлалтын зохицуулалтууд болон хувьсах татвар хураамж гэх мэт орно. Эдгээр арга хэмжээнүүд нь ерөнхийдөө ДХБ-ын дүрэм журамтай одоо зөрчилддөг. Уругвайн үе шатны яриа хэлэлцээнээс гарсан үр дүнгийн нэг нь хөдөө аж ахуйн худалдаанд нөлөөлж буй тарифын бус бүх арга хэмжээг тариф руу хувирган шилжүүлэх үүрэг амлалт. Мөн Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Safeguards) болон тарифын (tariff) талаар үзнэ үү.
968	Non-tradeables	Олон улсын түвшинд арилжаалагдаад байдаггүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ. Олон улсад ер худалдаалагддаггүй эсвэл ховорхон тохиолдолд худалдаалагддаг бараа, үйлчилгээ бөгөөд учир нь эдгээр зүйлс нь хэт элбэг байдаг, маш хямд байдаг, эсвэл арилжаа хийхэд шаардагддаг дэмжлэг үйлчилгээний өртөг нь импортын зах зээл дээрх уг бүтээгдэхүүний үнээс давчих нөхцөл байдалтай холбоотой байдаг. Уг арилжааны хувьд ашигтай бус бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт олон жилийн турш нэлээд өөрчлөгдөх бөгөөд уг жагсаалт улам бага болох магадлалтай. Үүнд хоёр жишээ татахад хангалттай.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Саяхныг хүртэл дотоодод олборлож байдаг арилжааны бус чанартай гэж үзэж байсан элс ба хайрганы хувьд тэдгээрийн олборлолтын үйл ажиллагааг хянан засаглаж байдаг байгаль орчны илүү хатуу арга хэмжээ зэрэг олон шалтгааны улмаас арилжаалагдах чанартай бүтээгдэхүүнүүд болсон байна. Хэдийгээр хилийн ойролцоо амьдардаг хүний хувьд үсээ засуулахаар хил давах нь илүү тохиромжтой байх үе байдаг ч, үс засалт нь одоог хүртэл арилжааны бус чанартай үйлчилгээний жагсаалтад орсон хэвээр байна. Мөн хагас арилжааны чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ (semi-tradeables), арилжааны чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг (tradeables) үзнэ үү.
969	Non-trade concerns	Худалдааны бус асуудлууд. Мөн Олон талын үр өгөөж бүхий байдал (multifunctionality), Худалдааны бодлогод туссан худалдааны бус зорилтуудыг (non-trade objectives in trade policy) үзнэ үү.
970	Non-trade objectives in trade policy	Худалдааны бодлого дах худалдааны бус зорилтууд. Энэ нь илүү чөлөөт, урьдчилан таамаглаж болохуйц, үл ялгаварласан худалдааны уламжлалт зорилгоос өөр бусад зорилгодоо хүрэхийн тулд боловсруулсан худалдааны дүрмийг илэрхийлж байгаа юм. Ийм зорилгын хүрээнд, хүрээлэн буй орчныг хамгаалах, хөдөлмөрийн үндсэн стандарт эсвэл хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ардчиллын үнэ цэнэ болон өргөн утгаараа нийгэм ба улс төрийн үзэл санааг дэмжих зэрэг болно. Зарим нь энэхүү ангилалд өрсөлдөөн болон хөрөнгө оруулалтын асуудлыг тусгасан дүрмийг оруулдаг боловч зарим нь худалдааны бодлого, хөрөнгө оруулалт эсвэл өрсөлдөөний хооронд байдаг байнгын харилцан бие биеэ нөхөх шинж чанарын улмаас энэ тал дээр маргадаг байна. Худалдааны бус зорилтуудын хүчин төгөлдөр байдлын талаарх маргаан мэтгэлцээн нь ихэвчлэн нэлээд ширүүн байдаг. "Миний санаа зовж буй асуудлууд бол хууль ёсны үндэслэлтэй, харин таных бол сэжигтэй бөгөөд хамгаалалтын үзэл баримтлалтай байх магадлалтай" гэсэн үндсэн зарчмууд ажиглагддаг. Мөн олон талын үр өгөөж бүхий байдал (multifunctionality), худалдаа ба өрсөлдөөн (trade and competition), худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment), худалдаа ба хүний эрх (trade and human rights), худалдаа ба хөрөнгө оруулалт (trade and investment) болон худалдаа ба хөдөлмөрийн стандартыг (trade and labour standards) үзнэ үү.
971	Non-violation	Зөрчлийн бус тохиолдол. Олон талт худалдааны хэлэлцээрийн нэг тал нь (жишээлбэл, Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (GATT) эсвэл Үйлчилгээг худалдаалах тухай ерөнхий хэлэлцээр (GATS)) тухайн хэлэлцээрийн хууль эрх зүйн заалтуудын эсрэг үйлдэл хийдэггүй боловч ямар нэгэн байдлаар өөрсдийн үйлдлээрээ дамжуулан гэрээний нөгөө талын эрхийг хүчингүй болгож эсвэл хохироож байдаг нөхцөл байдал.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Зөрчлийн арга хэмжээ нь, харилцан хүлээн зөвшөөрсөн заавал биелүүлэх тарифын үүрэг амлалт эсвэл зөрчлийн бус зарчмаар буй болох боломжтой хохирлыг нөхөн барагдуулах хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг амлалтуудын хүрээнд тогтоосон өрсөлдөөний нөхцөлийг өөрчлөх хэрэг гардаг байна. Өөрөөр хэлбэл, тухайн арга хэмжээний нөлөө нь урьдаас таамаглаагүй гэнэтийн байх ёстой болдог. Зөрчлийн бус тохиолдлын тухайд сүүлийн үеийн жишээ гэвэл, ургамлын тосны үйлдвэрлэгч нарт Европын хамтын нийгэмлэгээс тусламж дэмжлэг үзүүлсэн хэргийн хувьд тохиолдсонтой мөн адил дотоодод үзүүлдэг татаасаар дамжуулан хуулиар хүлээсэн тарифын үүрэг амлалтыг бууруулж сулруулсан явдал юм. ДХБ-ын маргаан шийдвэрлэх зүйл заалтын (WTO dispute settlement provisions) дагуу зөрчлийн бус хэлбэрээр үүссэн хэргүүдийг шийдвэрлэж болно. Саяхан зарим тохиолдлуудын хувьд хөрөнгө оруулалтын бодлого энэ ангилалд багтаж болзошгүй гэсэн гомдол гарсан байна. Мөн Хүчингүй болгосон эсвэл хохирол учруулсан (nullification or impairment), Тослог ургамлын үрийн тухай хэргийг (Oilseeds case) үзнэ үү.</p>
972	Normal trade relations	<p>Худалдааны хэвийн харилцаа. Энэхүү нэр томьёог одоогоор, нэн ялангуяа АНУ болон Хятад улс хоёрын хоорондын худалдааны бүтэц хамрах хүрээний мөн чанарын талаар АНУ-ын жил бүрийн Конгрессын хурлын үеэр мэтгэлцэн хэлэлцэхэд, үндэсний нэн тааламжтай нөхцөлийн оронд ашиглах болсон байна. Мөн, Худалдааны тогтмол хэвийн харилцаа (permanent normal trade relations), худалдааны түр зуурын хэвийн харилцааг (temporary normal trade relations) үзнэ үү.</p>
973	Normal value	<p>Хэвийн үнэ/өртөг. Энэ нь Демпингийн үйл ажиллагаа явагдсан эсэхийг тодорхойлох гол ойлголт. ТХЕХ-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу өөр нэгэн гишүүн улстай арилжаа худалдаа эрхлэхдээ аливаа бүтээгдэхүүний үнийг хэвийн үнээс нь доогуур үнээр нэвтрүүлэхийг буруушаадаг байна. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн (ДХБ-ын Демпингийн эсрэг хэлэлцээр /Anti-dumping Agreement)-ийн 2 дугаар зүйлд “хэвийн үнэ”-ийн гол утга агуулга болон үүнийг тодорхойлох журмыг тодорхой зааж өгсөн байдаг. Ердийн худалдааны явцад экспортолж буй бараа бүтээгдэхүүн нь экспортлогч орны хэрэглээнд зориулан оруулах үед харьцуулж болохуйц бараа бүтээгдэхүүний үнээс доогуур үнээр нэвтэрч байгаа бол тухайн бүтээгдэхүүний хувьд демпинг хийсэн эсвэл хэвийн үнээс доогуур үнээр нэвтрүүлсэн гэж үзнэ. Хэрэв экспортлогч орны дотоодын зах зээл дээр борлуулалт хийгдээгүй эсвэл эдгээр борлуулалтын хувьд зохих харьцуулалт хийх боломжгүй тохиолдолд, экспортын үнийг зохимжтой ба төлөөлж болохуйц гуравдагч орон руу хийгдсэн экспортын үнийг ашиглаж болох юм. Гурав дах арга нь гарал үүслийн улс дах үйлдвэрлэлийн өртөг зардал дээр нэмээд байж болохуйц захиргааны, борлуулалтын, нийтлэг зардал болон ашгийн тооцооны хэмжээг ашиглаж болох юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тухайн бараа бүтээгдэхүүн нь ердийн худалдааны горимын дагуу экспортлогдоогүй байсан эсвэл зөвхөн богино хугацааны худалдаанд зориулагдсан байсан эсэхийг нягтлан үзэх нарийвчилсан дүрмийг ашиглах боломжтой. Хэрэв ямар ч экспортын үнэ байхгүй эсвэл экспортлогч, импортлогч эсвэл гуравдагч этгээдийн хоорондын харилцан холбогдолтой байдлаас шалтгаалан эскпортын үнийг найдваргүй байж магадгүй гэж үзсэн үед, экспортын үнийг бие даасан худалдан авагчид тухайн импортын бүтээгдэхүүнийг худалдаалсан үнэд үндэслэн тодорхойлон гаргаж ирж болно. Экспортын үнэ ба хэвийн хэмжээний үнийн хоорондын харьцуулалтыг зайлшгүй ялгааг нь хүлээн зөвшөөрөхүйц адил төстэй нөхцөл байдлын хүрээнд хийх ёстой. Мөн демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.
974	North	Умард зүг. Хөгжингүй орныг (developed country) үзнэ үү.
975	North American Free Trade Agreement	Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийг (NAFTA) үзнэ үү.
976	North Atlantic Free Trade Area	Хойд Атлантын чөлөөт худалдааны бүс. Энэ нь 1960-аад оны үед, АНУ болон Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хоорондох чөлөөт худалдааны бүс байгуулах тухай тохиолдлын байдлаар гарч ирсэн санал. Хөдөө аж ахуйн худалдааны (agricultural trade) үзэл бодлын хувьд эвлэршгүй ялгаатай байдал, бусад бүх зүйлсээс дээгүүр тавьж үүнийг шийдвэрлэх хэрэгтэй гэсэн үүний маргаан зөрөлдөөн байдлын улмаас хэлэлцээрийн ширээнд хүрч чадаагүй. Мөн Атлантын Далайг дамнасан чөлөөт худалдааны хэлэлцээрийг (TAFTA) үзнэ үү.
977	North East Asia Free-Trade Area	Зүүн Хойд Азийн Чөлөөт худалдааны бүс (ЗХАЧХБ). Анх 1999 онд Японы Ерөнхий сайд Обучигийн санал болгосон бүс нутгийн эдийн засгийн илүү ойр дөт интеграцчлалд зориулсан урт хугацааны төсөл. Үүний ирээдүйн гишүүдийн дунд Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс, Хятад, Хонг-Конг болон бусад орнууд хамрагдах боломжтой юм. Одоогоор хэлэлцээрийн хөтөлбөрийн хуваарь гараагүй байна.
978	North-South: A Programme for Action	Умард-Өмнөд: Үйл ажиллагааны хөтөлбөр. Мөн Брендт тайланг (Brandt Report) үзнэ үү.
979	North-South dialogue	Өндөр хөгжилтэй эсвэл аж үйлдвэржсэн орнууд (Умард) болон хөгжиж буй орнууд (Өмнөд) хооронд ихэвчлэн ёжтой хорсолтой, үр өгөөжгүй явж ирсэн яриа хэлэлцээний үйл явц. Зарим нь үүнийг 1960-аад оны эхэн үеэс эхэлсэн гэж үзэж байна, жишээлбэл, Хөгжлийн төлөөх эвсэл (Alliance for Progress), НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлыг (UNCTAD) байгуулагдахад хүргэсэн алхмууд болон үүнтэй зэрэгцэн байгуулагдсан 77 гишүүдийн бүлэг (Group of 77) зэргийг нэрлэж болно. Бусад нь Умард-Өмнөд яриа хэлэлцээг, 1975 онд Франц улсад зарлан хуралдуулсан ба тодорхой үр дүнд хүрэлгүй 1977 онд дууссан Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны бага хуралтай (Conference on International Economic Cooperation) нэг цаг үед эхэлсэн гэж үздэг.

Уг яриа хэлэлцээний ямар нэгэн байдлын албан ёсны төгсгөл нь 1980 онд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тусгай чуулганаар дуусгавар болсон. Энэ тал дээр санал зөрөлдөөн бага байдаг. Уг Умард-Өмнөдийн яриа хэлэлцээ яг хэдийд эхэлснийг хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран, энэ нь НҮБ болон шинээр тусгаар тогтносон олон тооны хөгжиж буй орнуудаас бүрдсэн НҮБ-ын системийн хүрээний төрөлжсөн байгууллагуудад орж ирсэн юм. Тэдний тооны хэмжээ нь эдгээр байгууллагуудын ажлын хөтөлбөрийг тодорхойлох эсвэл нөлөөлөх боломжийг улам ихээр нэмэгдүүлсэн. Энэ нь хөгжиж буй олон улс орнуудын хувьд, хөгжил цэцэглэл, эдийн засгийн өсөлт болон дэлхийн худалдааны системд оролцох оролцооны талаарх тэдний хууль ёсны үндэслэлтэй санаа зовоосон асуудлуудыг хөгжингүй орнууд нухацтай авч үзэхгүй байгаа талаарх үзэл бодлоо хүчтэй хамгаалж байсан явдал нь, 1970-аад оны эхээр Умардын улс орнуудын зүгээс хүлээн зөвшөөрч, ямар нэгэн үйлдэл хийх хэрэгтэй юм байна гэж үзэхэд хүргэсэн байдаг. 1973 онд ОПЕК-ийн газрын тосны үнийг дөрөв дахин нэмэх шийдвэр гаргасан нь үүнд нэмэлт шалтгаан болж өгсөн. Үүний дараа улс төр болон эдийн засгийн олон төрлийн санаачилга гарч ирсэн боловч ихэнх нь тэсэж үлдээгүй байна. Тойм байдлаар, 1974 онд Олон улсын эдийн засгийн шинэ дэг журмын талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол гарч, үр дүнд нь Умардын орнуудаас Өмнөдийн орнууд рүү их хэмжээний нөөцийг шилжүүлэх шаардлага тавигдсан. Улс орнуудын эдийн засгийн эрх, үүргийн дүрмийг баталсан нь олон улсын эрх зүйн талыг дахин тодорхойлох гэсэн оролдлого байсан бөгөөд энэ нь тухайн онд болсон байдаг. 1975 оны эхээр Ломе-ийн анхны конвенц (Lome Convention) гарсны дараа хөгжиж буй орнуудад давуу талыг бий болгож байсан боловч энэ нь мөн тэд огцом өөрчлөлт хийх хүч чадалгүй байсныг харуулсан байна. Өмнө нь дурдаж байсан чилан, тухайн жилд зохион байгуулагдсан Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурлын үеэр энэ нь улам тодорхой болж ирсэн. Дэлхийн Хэлэлцээний (Global Negotiations) хөтөлбөрийг 1980 онд эхлүүлэх талаар 1977 оноос хойш НҮБ-ын системийн хүрээнд хөдөлгөөн өрнөж байсан байдаг. 1980 онд Брендт тайланг санаачлан гаргаснаар шинэ эхлэлийн итгэл найдвар төрүүлсэн. Гэвч, аль хэдийн хоёр тал хоорондын ялгааг арилган шийдэх боломжгүй болж, тэдний байр суурийг урагшлуулахад ихээхэн ярвигтай болсон байсан тул тус яриа хэлэлцээ нь барагдан дууссан байлаа. Умард-Өмнөд хоёрын хоорондын яриа хэлэлцээг дахин сэргээх талаар үе үе уриалдаг боловч үүнийг хэрхэн хийх талаарх хэлэлцүүлэг нь урьдчилсан яриа хэлэлцээний үеэр байнга л гацаанд ордог байв. Мөн Харисийн тайланг (Harries Report) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
980	Notification	<p>Мэдэгдэл. ДХБ-ын удирдаж байдаг хэлэлцээрийн гишүүн улсуудад ямар нэгэн үр нөлөө үзүүлж болохуйц худалдааны арга хэмжээг баталсан бол ДХБ-ын холбогдох байгууллагад тайлагнах үүрэгтэй байдаг. Мэдэгдэл гаргах нь ил тод байдлыг дэмжиж, хяналт тандалтын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж ажиллаж байдаг. Мэдэгдэл гаргаж өгөх нь тухайн арга хэмжээ нь өөрөө дүрэм журамд нийцэж байгаа талаар шүүгдэх эсэх асуудалтай ямар нэгэн хамаагүй. 1994 оны 4 дүгээр сард Марракеш хотод болсон Мэдэгдэл хүргүүлэх дүрмийн талаарх шийдвэрт (Decision on Notification Procedures) мэдэгдэл гаргах хэмжээний хорин төрлийн арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй жагсаалтыг агуулсан байдаг. Үүнд тарифын тоон хязгаарлалт, бусад тарифын бус арга хэмжээнүүд, худалдаан дах техникийн саад тотгор, хамгаалалтын арга хэмжээ, демпингийн эсрэг арга хэмжээ гэх мэтчилэн зүйлсийг хамарсан байна. Уг жагсаалтыг гаргахад хэлэлцээ хийгчид өргөн хүрээний сүлжээг бий болгосон байдаг бөгөөд зарим цөөхөн арга хэмжээ үндсэндээ үүнээс зайлсхийх боломжтой. ДХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдсэн бүх арга хэмжээний жагсаалтыг хадгалж байдаг бөгөөд гишүүн улс орнуудад хэзээ стандарт мэдэгдэл гаргах шаардлагатай болохыг нь сануулж байдаг байна. Мөн урвуу мэдэгдэл гаргах (reverse notification), хяналт тандалт (surveillance) болон ил тод байдлыг (transparency) үзнэ үү.</p>
981	Not inconsistent with	<p>Нийцэлгүй бус байх. Энэ нь ДХБ-ын маргааныг шийдвэрлэх тухай тайланд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн хувьд түгээмэл ашигладаг үг хэллэг. Энэ нь маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн олж тогтоож чадсан тэр хэмжээнд, тухайн хяналт шалгалт хийлгүүлж буй арга хэмжээ нь ДХБ-ын аливаа дүрэм журамтай харшлаагүй байна гэсэн үг. Үүнтэй уялдаад тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа тал үүнийгээ өөрчлөх шаардлагагүй байдаг. Энэхүү үг хэллэг нь, 1947 оны ТХЕХ нь үнэн хэрэгтээ түр хугацаагаар хүчин төгөлдөр байсантай зарим талаараа холбоотой бий болсон бөгөөд нөгөөтээгүүр маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн хувьд баримтуудыг илрүүлж чадаагүй байх магадлалаас өөрсдийгөө хамгаалах гэсэн хүслээс үүдэлтэй. Мөн Түр мөрдөх протоколыг (Protocol of Provisional Application) үзнэ үү.</p>
982	Not-made-here syndrome	<p>Энд-үйлдвэрлээгүй гэх синдром. Технологийн үндсэрхэг үзлийг (techno-nationalism) үзнэ үү.</p>
983	Not-on-the-whole-higher-or-more-restrictive criterion	<p>Бүх талаараа илүү өндөр эсвэл илүү хязгаарласан шалгуур тавьдаггүй. Тухайн гаалийн холбоо нь ТХЕХ-ийн дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд ашигладаг шалгуур. ТХЕХ-ийн 24-р Заалтад гаалийн холбооны нэгдсэн гадаад тарифын хэмжээ нь тухайн холбоонд элсэж орохоос өмнө гишүүн улсуудынх нь хувьд байсан үндэсний тарифын хэмжээнээс бүхэлдээ их өндөр эсвэл илүү хязгаарлалт тогтоосон байх ёсгүй гэж шаарддаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тухайн шалгуурыг хангаж ажилласан эсэхийг тодруулахад ашиглах аргын тухайд ихээхэн маргаан үүссэн байдаг, ялангуяа дундаж тарифыг ашиглах уу эсвэл худалдааны жигнэсэн дундаж тарифыг ашиглах уу гэдэг асуудалтай холбоотой. Ямар тооцооллыг ашигласнаас хамаараад үр дүн нь илт өөр байж болно. 24-р Зүйлийг тайлбарлах тухай Харилцан ойлголцлын баримт бичигт дүгнэж тэмдэглэсэнээр бол Уругвайн үе шатны хэлэлцээгээр уг асуудлыг тодруулсан байна. Тарифын түвшинг үнэлнэ гэдэг нь жигнэсэн дундаж тарифын хэмжээ болон гаалийн хураасан татварын ерөнхий үнэлгээнд үндэслэсэн байх ёстой гэж заасан.
984	Nuisance tariff	Ашиггүй тариф (Чирэгдэл болсон хэт бага тариф). Энэ нь тарифын орлогыг цуглуулах өртөг нь түүнийг цуглуулсан хэмжээтэй нь тэнцэх, эсхүл түүнээс давсан хэт бага хувь хэмжээтэй, эсхүл тухайн тариф нь ямар нэгэн хамгаалалтын нөлөөгүй болохыг илэрхийлж байна гэсэн үг. Мөн орлогын тарифыг (revenue tariff) үзнэ үү.
985	Nullification or impairment	Хүчингүй болгосон эсвэл хохирол учруулсан (Хүчингүй болгосон эсхүл багасгасан - Уругвай). ДХБ-ын гишүүний авсан үүрэг амлалт ба/эсвэл үйл ажиллагаа хоёрын аль алиныг үл хүндэтгэсэн байдал нь, хэлэлцээрт заасны дагуу бусад гишүүдийн хүртэх үр ашгийг үгүйсгэх үр нөлөөтэй. Хэрэв тухайн асуудлыг зөвлөлдөөнөөр зарчмаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг шийдвэрлэх албан ёсны журмын хүрээнд туслалцаа эрэх нь гишүүдэд нээлттэй байдаг. Дүрмийг зөрчсөнөөр хүчингүй болгох болон үүрэг амлалтын үнэ цэнийг бууруулах явдал гарч болох боловч мөн зөрчил гаргаагүй тохиолдолд ч бас тохиох боломжтой.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
986	OECD (Organisation for Economic Cooperation and Development)	<p>Энэ нь 1961 онд Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын (ОЕЕС) залгамжлагчаар байгуулагдсан. Түүний гишүүд нь дэлхийн гарц бүтээгдэхүүний 70% гаруй хувийг бүрдүүлдэг тул зарим тохиолдолд үүнийг “баян улс орнуудын клуб” (“rich-country club”) гэж нэрлэдэг. Уг байгууллагын зорилтууд нь (а) эдийн засгийн хамгийн тогтвортой өсөлт, хөдөлмөр эрхлэлт, болон гишүүн орнуудын амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал бөгөөд үүний зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг барьж улмаар дэлхийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, (b) эдийн засгийн хөгжлийн явцад гишүүн болон гишүүн бус орнуудын бат бөх эдийн засгийн өргөжүүлэн тэлэхэд хувь нэмэр оруулах, болон (c) олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудад нийцүүлэн, дэлхийн худалдааг олон талт, үл ялгаварласан зарчим дээр тулгуурлан өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм. OECD буюу ЭЗХАХБ нь сүүлийн гучин жилийн хугацаанд, зарим талаар түүний нэгэн гарал үүсэлтэй гишүүнчлэлийнхээ дэмжлэгийг авснаараа, худалдаа болон эдийн засгийн талбарт ихээхэн амжилт олсныг дурдаж болно. Одоогоор Австрали, Австри, Бельги, Канад, Чех, Дани, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Итали, Япон, Солонгос, Люксембург, Мексик, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Польш, Португали, Испани, Швед, Швейцар, Турк, Их Британи болон АНУ гэсэн улс орнуудаас гишүүнчлэл нь бүрэлдэж байна. ЭЗХАХБ-ын хамгийн дээд байгууллага нь жил бүрийн 5 дугаар сард ихэвчлэн болдог Сайд нарын зөвлөлийн хурал (Ministerial Council Meeting) юм. Мөн Албан ёсоор дэмжигдсэн зээлд зориулсан зааварчилгаа бүхий зохицуулалтын арга хэмжээ (Arrangement on Guidelines for Officially Supported Credits); Олон улсын бизнесийн хэлцлүүд дэх Гадаадын төрийн албан тушаалтнуудын авлига, хээл хахуультай тэмцэх тухай конвенц (Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions); Худалдаа, өрсөлдөөний хамтарсан бүлэг (Joint Group on Trade and Competition); Хөрөнгө оруулалтын тухай олон талт хэлэлцээр (Multilateral Agreement on Investment); Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдэд зориулсан ЭЗХАХБ-ын зааварчилгаа (OECD Guidelines for Multinational Enterprises); Худалдаа, өрсөлдөөний талаар ЭЗХАХБ-ын зөвлөмж (OECD Recommendation on Trade and Competition); ЭЗХАХБ-ын хөлөг онгоц үйлдвэрлэх хэлэлцээр (OECD shipbuilding agreement); Шилжилтийн үеийн түншүүд (Partners in Transition); Худалдаа ба хууль бус төлбөр (trade and illicit payment), Гишүүн бус динамик зах зээлийн эдийн засгийг (dynamic non-member market economy) үзнэ үү.</p>
987	Office international de la vigne et du vin	<p>Усан үзэм ба дарсны олон улсын байгууллага (International Organisation of Vine and Wine - OIV). Энэхүү байгууллага нь дарстай холбоотой асуудлаар шинжлэх ухаан, техник, эдийн засаг, хууль эрх зүйн мэдээллийг цуглуулах, түгээх зорилгоор 1924 онд байгуулагдсан. Дарс ургуулж, үйлдвэрлэдэг олон чухал улс орнуудын хувьд өөрсдийн дарс үйлдвэрлэлд зориулан тухайн стандарт хэм хэмжээг батлан хэрэглэдэг тул энэхүү ажил нь олон улсын дарсны худалдаанд ихээхэн ач холбогдолтой юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Үүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Парис хотод байрладаг. Мөн нэршлийн хяналт, тооллого (appellation contrfйie) болон газар зүйн заалтыг (geographical indications) үзнэ үү.
988	Official development assistance	Хөгжлийн албан ёсны тусламж. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Хөгжлийн тусламжийн хорооны тодорхойлсноор бол, тодорхой жагсаалтад багтсан хөгжиж буй орнуудад түүний гишүүн улс орнуудаас олгож буй буцалтгүй тусламж эсвэл зээл юм. Хөгжлийн албан ёсны тусламжийг хүртэх шаардлага хангахын тулд үйл ажиллагаанууд нь дараах хэлбэртэй байна, үүнд (a) хандивлагч орны хувьд албан ёсны салбарт үүрэг болгосон, (b) голдуу эдийн засгийн хөгжил болон нийгмийн хангамжийг дэмжихэд чиглэсэн, (c) санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй байх шаардлагатай. Үүнд техникийн хамтын ажиллагааны үйл ажиллагаа хамрагддаг боловч цэргийн зориулалтын буцаалтгүй тусламж, зээл болон кредит бол шаардлагад тэнцдэггүй байна.
989	Offsets	Нөхөн төлөх, нөхөн олгох. Энэ нь дотоодын агууламжийн шаардлага, технологийн тусгай зөвшөөрөл, хөрөнгө оруулалтын шаардлага, угтвар худалдаа болон эдгээртэй төстэй шаардлагуудыг ашиглан, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх эсвэл худалдааны тэнцлийг сайжруулах зорилгоор ашигладаг арга хэмжээнүүд. Худалдаан холбогдолтой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн (TRIMS) дагуу эдгээр арга хэмжээнүүдийн зарим нь хууль бус. Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр нь өөрсдийн гишүүн орнууддаа иймэрхүү бүх төрлийн хохирлыг нөхөн төлөх, нөхөн олгох шаардлагуудыг хориглодог байна. Хамгаалалтын бүх хэлбэрүүдийн нэгэн адил, хохирлыг нөхөн төлөх, нөхөн олгох нь дотоодын зардлыг нэмэгдүүлж, улмаар тухайн улсын экспортын хүчин чармайлтад хохирол учруулж болзошгүй. Засгийн газрууд хөгжлийн эхний үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх гэдэг байдлаар хохирлыг нөхөн төлөх, нөхөн олгох асуудалд ихэвчлэн татагдаж байдаг байна. Мөн Хөгжлийн эрт эмзэг үе шатандаа яваа аж үйлдвэрийн салбарын мэтгэлцээн (infant-industry argument) үзнэ үү.
990	Oil-exporting countries	Газрын тос экспортлогч орнууд. Алжир, Ангол, Бахрейн, Болив, Бруней, Камерун, Конго, Эквадор, Египет, Габон, Индонез, Иран, Ирак, Кувейт, Ливи, Малайз, Мексик, Нигери, Оман, Катар, Саудын Араб, Тринидад ба Тобаго, Тунис, Арабын Нэгдсэн Эмират болон Венесуэл орнууд энэхүү бүлэгт багтана.
991	OMA	Зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалтыг (Orderly Marketing Arrangement) үзнэ үү.
992	Omnibus Trade and Competitiveness Act	Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хууль. АНУ-ын Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хуулийг (United States Omnibus Trade and Competitiveness Act) үзнэ үү.
993	One-way free-trade area	Нэг талын чөлөөт худалдааны бүс. Тэгш хэмт бус худалдааны хэлэлцээрийг (asymmetrical trade agreement) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
994	OPEC (Organization of Petroleum Exporting Countries)	<p>Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК). Энэ нь 1960 онд Иран, Ирак, Кувейт, Саудын Араб болон Венесуэл орнууд хамтран үүсгэн байгуулагч нь болж байгуулагдсан. Үүний гол зорилго нь үйлдвэрлэлийн болон экспортын бодлогыг уялдуулж, нэгтгэх явдал юм. Хожим нэмж Катар, Индонез, Ливи, Арабын Нэгдсэн Эмират, Алжир, Нигери, Эквадор болон Габон орнууд нэгдсэн. Гишүүнчлэл нь түүхий нефтийг их хэмжээгээр цэвэр экспортлогч улс орнуудад нээлттэй байдаг. ОПЕК-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Вена хотод байрладаг байна.</p>
995	Open Markets 2000	<p>2000 оны Нээлттэй зах зээлүүд. Энэхүү санаачилгыг АНУ нь 1994 оны 7-р сард болсон Их Долоогийн (G-7) уулзалтын үеэр худалдаа ба технологийн бодлогуудыг тодорхой хэмжээнд интеграцчлалд хүргэх байсан мэдээлэл технологи болон цахилгаан холбооны салбарууд дах чөлөөт худалдаанд хүчтэй анхаарал хандуулах замаар эхлүүлсэн байдаг. Уг саналын товч хувилбарыг гүнзгийрүүлэн хэлэлцүүлэхээр G-7 үйл ажиллагааны явцад дэвшүүлэн тавьсан боловч түүнээс хойш маш бага амжилтад хүрсэн байдаг. Мөн Дэлхийн мэдээллийн дэд бүтцийг (Global Information Infrastructure) үзнэ үү.</p>
996	Open regionalism	<p>Нээлттэй бүсчлэлийн онол. Энэ нь аливаа бүсийн түвшний зохион байгуулалт нь бусад оронтой харилцаа холбоогоо бэхжүүлэх хүсэлтэй байх (outward-looking) ёстой бөгөөд тухайн зохицуулалтаас гадна орших улс орнуудтай болон уг зохицуулалтын хүрээнд багтсан улс орнуудынхаа доторх саад тотгорыг бууруулах ёстой болохыг илэрхийлсэн нэр томьёо. Зарим улсын хувьд нээлттэй бүсчлэл гэдэг нь тухайн эрх зүйн зохицуулалтад багтсан гишүүн улс орнуудын хувьд тарифыг бууруулахад үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (most-favoured-nation treatment) бүхэлд нь хэрэглэж ашиглана гэсэн утгатай байдаг. Харин бусад улсуудын хувьд энэ нь, хөнгөлөлттэй худалдааны эрх зүйн зохицуулалтын боломжийг гишүүнчлэлээр хялбархан элсэх боломжтой холбож авч үзэхийг зөвшөөрдөг.</p>
997	Open-season negotiations	<p>Нээлттэй улирлын хэлэлцээ. Энэ нь үүрэг хүлээсэн амлалтуудын хугацаа нь дуусах үед 28 дугаар Зүйл ангид заасны дагуу ТХЕХ-ийн гишүүдэд гурван жил тутамд олддог техникийн тарифын хэлэлцээ хийх боломж. Үүрэг хүлээсэн амлалтуудыг анхнаасаа гурван жилээр хийдэг байна. Ийм хэлэлцээ нь хөнгөлөлтүүдэд өөрчлөлт оруулах эсвэл буцааж авахад хүргэж болзошгүй юм. Үүрэг хүлээсэн амлалтуудыг байнгын тогтмол гэж үзэх болсон тул иймэрхүү хэлэлцээнд найдах нь одоо нийтлэг биш болсон байна. Мөн Тарифын дахин хэлэлцээ хийх (renegotiation of tariffs) тухай үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
998	Open-skies agreements	Агаарын нээлттэй орон зайн тухай хэлэлцээрүүд. Эдгээр нь засгийн газрууд өөр хоорондоо хуваарьт нислэгийн зорчигч болон ачааны нислэгүүдийг өөрсдийн онгоцны буудлууддаа хязгаарлалтгүй нэвтрэх боломжийг олгох хэлэлцээр. Олон улсын агаарын ихэнх нислэгийн чиглэл болон үйлчилгээний давтамжийг агаарын үйлчилгээний хоёр талт хэлэлцээрийн үндсэн дээр одоо хүртэл хуваарилан олгосоор байна. Уг хэлэлцээрүүдэд нь ихэвчлэн санал болгож болохуйц зорчигчдын суудлын тооны дээд хязгаарыг тодорхой зааж өгсөн байдаг ба ашиглаж болохуйц онгоцны буудлыг мөн тодорхойлсон байдаг.
999	Optimal-intervention principle	Хамгийн оновчтой хөндлөнгийн оролцооны зарчим. Эрх зүйн акт ашиглан хамгийн бага хэмжээний хүсээгүй харш нөлөө үзүүлэх замаар бодлогын зорилгодоо хүрэх явдал бөгөөд энэ нь ихэвчлэн бодлогын тодорхой асуудлын шууд эх үүсвэр лүү нь халдах арга байдаг.
1000	Optimal-tariff	Оновчтой тариф. Үндэсний эдийн засгийн сайн сайхан байдлыг хамгийн өндөр түвшинд байлгаж чадах нөхцөлийг хангах тарифын түвшин
1001	Orderly Marketing Arrangement	Зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт (OMA). Энэ нь 1974 оны АНУ-ын Худалдааны тухай хуулийн дагуу зөвшөөрөгдсөн журам. OMA нь зорилтот орнуудаас орж ирэх импортод хязгаарлалт ноогдуулах утгын зөөлрүүлсэн нэр томьёо. Хязгаарлалтыг ихэвчлэн экспортлогч орнууд удирдан зохицуулж байдаг. Зах зээлийн нарийн дэг журамтай зохицуулалт нь сайн дурын хязгаарлалтын тохиролцоо хийх (voluntary restraint arrangements) болон сайн дураар импортыг өргөжүүлэх төлөвлөгөө (voluntary import expansion schemes) гэх зэрэг худалдааг гажуудуулагчдын ангилалд багтдаг байна. Мөн Хамгаалалтын арга хэрэгслийн тухай хэлэлцээрийг (Agreements on Safeguards) үзнэ үү.
1002	Organic integration	Органик интеграцчилал. Ихэвчлэн үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдийн хөтлөн явуулж байдаг хил дамнасан хувийн хөрөнгийн урсгал, бараа ба үйлчилгээ, технологи болон мэдээлэл байдаг байна. Мөн эдийн засгийн нэгтгэл буюу интеграцчиллыг (economic integration) үзнэ үү.
1003	Organisation for European Economic Cooperation	Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ЕЭЗХАБ - ОЕЕС). 1948 онд Маршалын Төлөвлөгөөг (Marshall Plan) удирдан зохион байгуулж байдаг байгууллага болж байгуулагдаад, 1961 онд үүнийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) орлох болсон байна.
1004	Organisation for International Economic Cooperation	Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ОУЭЗХАБ - ОИЕС). Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн өв залгамжлагч байгууллага ба тэдний гол ажил нь худалдаа болон эдийн засгийн асуудлаар гишүүн орнуудад зөвлөгөө өгөх үүрэгтэй боловч одоогийн байдлаар идэвхгүй байгаа байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1005	Organisation for Trade Cooperation	Худалдааны хамтын ажиллагааны байгууллага (ХХАБ). 1955 онд ТХЕХ-ийн ажлын хэсгийн тайлангаар дамжуулан ТХЕХ-г удирдаж байх байнгын механизм болгох санал болгосон. Түүнд олгогдсон эрх, үүрэг нь Олон улсын худалдааны байгууллагын (ITO) хүсэн хүлээж байсан хэлбэрийн хязгаарлагдмал хувилбар байх байлаа. ТХЕХ-ийн бүх гишүүд автоматаар тухайн байгууллагын гишүүн болох байсан. Ажлын хэсгийн тайланд дурдсан нэг сонирхолтой зүйл бол жил бүрийн хурлын дундуур бизнес эрхлэх цорын ганц арга барил болоод байсан Хурлууд завсрын хороонд (Intersessional Committee) томилогдсон улс орнууд, Женев хотод эсвэл ойролцоох нийслэл хотод суурин байх тохиромжтой нэр хүнд бүхий төлөөлөгчдийг болон шаардлагатай эрх бүхий этгээдийг томилж ажиллуулж, ингэснээрээ тэд нарын санал солилцох, хэлэлцүүлэг зэрэгт нь хувь нэмэр оруулж байх талаар авч үзэж болох юм гэжээ. Тайлан дах бас нэг зөвлөмж бол уг байгууллагыг НҮБ-тай тусгай мэргэшсэн агентлагийн хүрээний харилцаанд оруулах ёстой гэж үзэж байсан явдал юм. Худалдааны хамтын ажиллагааны байгууллагыг байгуулах санал нь АНУ-ын Конгрессын зөвшөөрлийг авч чадаагүй бөгөөд энэ төлөвлөгөө нь нуран унасан юм. Мөн ТХЕХ-ийн Төлөөлөгчдийн зөвлөл (GATT Council of Representatives), НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (United Nations specialised agencies) болон Дэлхийн худалдааны байгууллагыг (WTO) үзнэ үү.
1006	Organisation of American States	Америк тив дэх улс орнуудын байгууллага (OAS). 1948 оны Боготагийн дүрмийн (Bogota Charter) дагуу байгуулагдсан ба 1951 онд хүчин төгөлдөр болсон. Америк тивийн 35 тусгаар тогтносон улс орнууд үүнд оролцдог байна. 1962 онд Куба улс гишүүнчлэлээс нь хасагдсан. OAS нь голдуу олон улс төрийн зорилго дундаас, гишүүн орнуудын хооронд үүсэх магадлалтай эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх болон хамтын үйл ажиллагаагаар дамжуулан тэдний эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг хөхиүлэн дэмжихийг зорьдог байна. Үүний нэг хэсэг болох 1994 оны 12 дугаар сард Майами хотод болсон Эдийн засгийн Дээд түвшний уулзалтаар (Miami Economic Summit) Америкийн чөлөөт худалдааны бүсийг байгуулахаар тохиролцсон (FTAA). OAS-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь Вашингтон хотод байрладаг.
1007	Original membership of the WTO	ДХБ-ын Анхдагч гишүүн (Уругвай). Үүнийг, (a) Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийг 1995 оны 1-р сарын 1-ний өдөр хүлээн зөвшөөрсөн, мөн (b) үүний хавсралт болох Олон талт худалдааны хэлэлцээрүүд (Multilateral Trade Agreements), (c) 1994 оны ТХЕХ-ийн хавсралт болох тарифын буулт, хөнгөлөлт болон үүрэг амлалтын жагсаалт (schedules of concessions and commitments) болон Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) тодорхой үүрэг амлалтын жагсаалтыг (schedules of specific commitments) хүлээн зөвшөөрсөн байдаг, 1947 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийг (GATT) хэлэлцэн тохиролцогч талуудын олж авсан [анхдагч гишүүний] статус гэж үздэг. Эдгээр шаардлагуудыг хангасан улс орнуудын хувьд элсэж орох тогтсон журмыг дагах шаардлагагүй байсан боловч анхдагч гишүүдэд ямар нэгэн өөр бусад эрхүүдийг өгдөггүй.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1008	Osaka Action Agenda	<p>Осака дах Үйл ажиллагааны төлөвлөгөө. Энэ нь АПЕК-ийн тэргүүлэгч нарын 1995 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Осака хотод хийсэн уулзалтын үеэр зөвшөөрч тохиролцсон худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлал болон эдийн засгийн хамтын ажиллагаанд зориулсан хөтөлбөр. Энэ бол 1994 оны Богорын тунхаглалын (Bogor Declaration) зорилгуудыг бодит байдалд хөрвүүлэх алхам. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь гурван тулгуураас бүрэлддэг ба үүнд дараах зүйлс орно: (a) худалдаа ба хөрөнгө оруулалтын либералчлал, (b) эдгээрийг хөнгөвчлөх, (c) эдийн засгийн ба техникийн хамтын ажиллагаа. Уг үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь бүс нутагт сайн дурын либералчлал хийх оролдлогын хүрээний хувьсал хөгжлийг хөхиүлэн дэмжих ба түүнд хувирган чиглүүлэх, либералчлал болон дэмжлэг үзүүлэх зорилгуудыг боловсронгуй болгож сайжруулахын төлөөх хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэлхийн түвшний либералчлалд чиглэсэн цаашдын урагшлах замд түлхэц үзүүлэх ба хувь нэмэр оруулах замаар уг үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилгуудыг амжилттайгаар биелүүлнэ. Хөтөлбөрийг чиглүүлж буй зарчмууд нь иж бүрэн өргөн хүрээний; ил тод байдал; тогтуун; ялгаварлан гадуурхахгүй байх; нэгэн зэрэг эхлүүлэх; тасралтгүй үйл явц, ялгавартайгаар гаргах хуваарь; уян хатан байдал; болон хамтын ажиллагаа зэрэг юм. Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийг 1996 оны Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Сайд нарын бага хуралд (APEC ministerial meeting) өргөн барьж танилцуулах шаардлагатай байсан. 1997 оны 1 дүгээр сараас тэдний ерөнхий хэрэгжүүлэлт нь эхэлсэн бөгөөд улмаар жил бүр нягтлан дүгнэх үйл ажиллагаа дагалддаг байна. Мөн харьцуулагдахуйц байх (comparability), АПЕК Гишүүн орон тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (APEC individual action plan) болон АПЕК-ээс эхэлсэн бусад зах зээлд нэвтрэх үйл ажиллагааны (other entries beginning with APEC) тухай үзнэ үү.</p>
1009	Out-of-quota rate	<p>Тоо хэмжээний хязгаарлалтаас гадуурх тарифын хувь хэмжээ. Энэ нь тоо хэмжээний хязгаарлалтай тариф тогтоосон үед тогтоосон тоон хязгаараас илүү гарсан импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулах тарифын хувь хэмжээ. Энэхүү хувь хэмжээ нь тогтоосон тоо хэмжээний хязгаараас давсан хэмжээний импортыг мохоож саад хийх зорилготой. Энэ хувь хэмжээ нь ихэвчлэн тоо хэмжээний хязгаарлалтын хүрээнд багтсан импортод ногдуулдаг тарифын хэмжээтэй харьцуулахад хамаагүй өндөр хэмжээтэй байдаг. Мөн квот доторх тарифыг (in-quota tariff) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1010	Pacific Agreement on Closer Economic Relations	Эдийн засгийн илүү нягт харилцаанд тулгуурласан Номхон Далайн хэлэлцээр (PACER). Энэ нь 2001 оны 8 дугаар сард болсон Номхон далайн арлуудын чуулганаар (PFI) батлагдсан хэлэлцээр бөгөөд уг чуулганы гишүүдийн хоорондох худалдааны харилцааг хөгжүүлэхэд зориулсан бүтэц хамрах хүрээг гаргаж өгсөн. Энэ нь чөлөөт худалдааны хэлэлцээр биш боловч чөлөөт худалдааны бүс байгуулах боломжийг олгодог. Үүний нэг болох, Номхон далайн арлын орнуудын худалдааны хэлэлцээр (Pacific Island Countries Trade Agreement) буюу долоон улс уг PACER-ийг баталсны дараа энэ нь хүчин төгөлдөр болно. Мөн Өмнөд Номхон Далайн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг (SPARTECA) үзнэ үү.
1011	Pacific Free Trade Area	Номхон Далайн чөлөөт худалдааны бүс (PAFTA). Энэ нь 1960-аад оноос хойш бий болсон бүс нутгийн түвшний хөнгөлөлттэй худалдааны зохицуулалтын талаарх ойлголт. Олон жилийн туршид дэвшүүлж байсан олон төрлийн саналуудын ихэнх хувилбарт АНУ эсвэл Япон улс хоёрын аль нэгийг, ихэвчлэн хоёуланг нь аливаа хэтийн эрх зүйн зохицуулалтын төвд тавьсаар ирсэн байдаг. Эдгээр саналуудын нэг нь ч хэлэлцээрийн шатанд хүрч чадаагүй. Зарим хүмүүс АПЕК-ийг байгуулсан учраас PAFTA-ийн шаардлага илүүдэл болсон гэж үзсэн байна. Мөн Номхон далайн худалдаа, хөгжлийн байгууллага (OPTAD), Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөл (PBEC) болон Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурлыг (PECC) үзнэ үү.
1012	Panel	Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн буюу хөндлөнгийн хэсэг (Мэргэжилтний бүрэлдэхүүн). Энэ нь ДХБ-ын дүрэм журмын дагуу үүссэн маргааныг анхааралдаа авч хэлэлцэх зорилгоор, ихэвчлэн гурван нарийн мэргэжилтний бүрэлдэхүүнээс бүрддэг бүлэг. Зарим тохиолдолд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн олж мэдсэн бодит мэдээллүүдийг эсвэл гаргасан шийдвэрийг нь зүйрлэн илэрхийлж ашигладаг байна. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийг ДХБ-ын хүрээнээс гадуур тогтоосон гадны хүчин зүйлс эсвэл дүрэм удирддаггүй. Мөн маргаан шийдвэрлэх (dispute settlement), маргаан шийдвэрлэх байгууллага (dispute settlement body), Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг (WTO understanding on dispute settlement) үзнэ үү.
1013	Pan-European Cumulation Area	Пан-Европыг нэгтгэсэн бүс. Энэ нь нэгээс илүү оролцогч улс орнуудад үйлдвэрлэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн бараа бүтээгдэхүүн байгаа тохиолдолд дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй нэгэн ижил байдлаар харьцах тухай 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр баталсан тогтолцоо. Уг бүс нь Европын хамтын нийгэмлэг, Европын чөлөөт худалдааны бүс, Төв Европын чөлөөт худалдааны бүс, Балтын орнууд болон Болгар зэрэг орнуудаас бүрдсэн. Хэрэв тэдгээрийн 60 хувь ба түүнээс дээш хувийн үнэ цэнэ бүрдэлт нь уг бүс нутгаас үүссэн тохиолдолд үйлдвэрлэгчид тухайн тогтолцооны хүрээний шаардлагыг хангах боловч энэ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд 100 хувь болгон өсгөж болдог байна. Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрмийг (preferential rules of origin) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1014	Parallel importation	<p>Параллель буюу зэрэгцүүлэн импортлох. Энэ нь оюуны өмчийн эрхийг эзэмшигч, эсхүл эзэмшигчийн зөвшөөрөлтэйгөөр оюуны өмчийн агуулга бүхий бүтээгдэхүүнийг хууль ёсны дагуу зах зээлд байршуулж байсан өөр нэгэн улсаас уг оюуны өмчийн агуулга бүхий бүтээгдэхүүнийг импортлох явдал. Ийм импортын бүтээгдэхүүн нь мөн уг эрхийг эзэмшигчийн зөвшөөрөлтэйгөөр үйлдвэрлэж эсвэл түгээсэн мөн ижил төрлийн бүтээгдэхүүнтэй нь дотоодын зах зээлд өрсөлддөг. Тиймээс, тэдгээр бүтээгдэхүүнүүдийг зөвшөөрөгдсөн сувгуудаар, параллель маягаар импортолсон гэж хэлдэг. Параллель импортын бүтээгдэхүүнийг зах зээлд илүү хямдаар нийлүүлж болдог учраас ийнхүү үйлдэх сэдэл үүсдэг байна. Уг сэдвийг нарийвчлан судлах явцад, Ротни (Rothnie 1993 онд) өгүүлэхдээ, шулуухан хэлэхэд нэг ижил хүн аль аль оронд нь оюуны өмчийн эрхийг эзэмших ёстой, гэвч одоо энэхүү нэр томьёо нь өмчлөлийг гэрээгээр хувааж эзэмшсэн нөхцөл байдлуудыг ерөнхийд нь тайлбарладаг болсон. Параллель импорт нь өнөөг хүртэл маргаантай практик туршлага хэвээрээ байгаа бөгөөд түүний хуульчлагдсан байдал нь тухайн орны шүүх эрх мэдэл хэрэгжих эрхтэй уялдан өөр өөр байдаг байна. Энэхүү практик үйл ажиллагаанаас үйлчлүүлэгчид үр ашиг хүртдэг нь илт тодорхой учраас өрсөлдөөнийг зохицуулах эрх бүхий удирдлагууд үүнд ээлтэй хандах хандлагатай байдаг. Хэдий тийм боловч, бусад хүмүүс оюуны өмчийн эрхийн систем нь шинэ санаачилга болон бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор боловсруулсан байдаг тул уг төрлийн импорт нь уг системийг дордуулж байна гэж үздэг байна. ДХБ-ын Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (WTO Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) болон Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ивээл дор (WIPO auspices) 1996 оны 12 дугаар сард батлагдсан Зохиогчийн эрхийн тухай олон улсын гэрээний (Copyright Treaty) аль аль нь, засгийн газруудыг параллель импортыг зөвшөөрөхийг хориглодог байна. Мөн Патентын эрх эсвэл барааны тэмдгийн эзэмшлээс үүссэн эрх шавхагдах (exhaustion doctrine) үзнэ үү.</p>
1015	Para-tariffs	<p>Нэмэлт тариф (пара-тариф). Тарифын оронд, эсхүл түүнтэй зэрэгцүүлэн нэмэлтээр импортод ногдуулдаг төлбөр хураамжийг тайлбарлахдаа хэрэглэдэг нэр томьёо. Энэ нь үйлчилгээ үзүүлсний шимтгэл, импортын нэмэлт татвар, импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулсан бусад шимтгэлүүдээс бүрдэнэ. Энэхүү тарифыг импортын бараанд төдийгүй дотоодын үйлдвэрлэлийн ижил төрлийн бараанд ногдуулна. Хэрэв ногдуулаагүй тохиолдолд үүнийг хууль бус гэж үзэх ба ДХБ-ын үндэсний нөхцөлийг зөрчиж байна гэж үзэж болно.</p>
1016	Pareto optimum (or efficiency)	<p>Паретогийн оновчтой нөхцөл (буюу үр бүтээмжтэй байх). Энэ нь өөр бусад хэн нэгэн хүнийг дордуулахгүйгээр аливаа нэгэн хүнийг дээрдүүлж чадахгүй нөхцөлд нөөц эх үүсвэрийг үр ашигтайгаар хуваарилан ашиглах тухай Вилфредо Паретогийн тодорхойлсон зарчим. Өнөөгийн үе шат болон хамгийн оновчтой нөхцөлийн хоорондох завсрын нөхцөл байдлыг Парето-онцгой төгс (Pareto-superior) гэж нэрлэдэг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1017	Paris Club	Парисын Клуб. Энэ нь голчлон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн орнуудаас бүрдсэн чуулга уулзалт бөгөөд зээлийн эргэн төлөлтөд аливаа бэрхшээл учирсан нөхцөлд зээлдүүлэгч болон зээлдэгч улсуудыг эвлэрүүлэх зорилгоор байгуулагдсан. Энэ нь зээлийн нөхцөлийг бүтцийн хувьд дахин өөрчлөх болон бусад арга механизмуудаар дамжуулан, зээлийг эргэн төлөх чадваргүй болох байдлаас зайлсхийхийг эрмэлздэг байна. Парисын Клубийн хувьд Францын Сангийн яамнаас (French Treasury) олгосон нарийн бичгийн дарга нарын газар үйлчилгээ үзүүлж байдаг байна.
1018	Paris Convention	Парисын конвенц. Парисын Холбоо гэгчийг байгуулсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай конвенц. Энэ нь 1884 онд хүчин төгөлдөр болсноос хойш хэд хэдэн удаа шинэчлэгдэж өөрчлөгдсөн. Хамгийн сүүлд 1967 оны Стокхольм дах Шинэчилсэн хувилбар (Stockholm Revision) байсан. Уг конвенцыг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) удирдаж байдаг. Энэ нь патент, худалдааны тэмдэгтүүд, бүтээгдэхүүний загвар зэрэг аж үйлдвэрийн өмч, түүнчлэн газар зүйн заалтууд, гарал үүслийн нэршил зэргийг хамруулаад өргөн хүрээнд аж үйлдвэрийн өмчийг хамгаалахад хэрэглэгддэг. Конвенцын гол шинж тэмдгүүд бол үндэсний нөхцөл, давамгайлах эрх (хэрэв нэг хүн аливаа нэг гишүүн оронд патент авахаар бүртгүүлсэн тохиолдолд тэр нь нэг жилийн дотор өөр нэг оронд патентаа бүртгүүлэх давуу эрхтэй), болон хамгаалалтын хамааралгүй бие даасан байдал (гишүүн орнуудын иргэдээс гишүүн оронд өргөдөл гаргасан патент нь бусад улсад мөн ижилхэн шинэ бүтээлд зориулан олгогдсон патентаас хамааралгүй байна) зэрэг юм. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) үзнэ үү.
1019	Partial-scope trade agreements	Хэсэгчилсэн-хүрээний худалдааны хэлэлцээр. Салбарын хүрээний чөлөөт худалдааны талбаруудыг нэрлэсэн өөр нэгэн нэр нь бөгөөд зарим үед энэ талаар хөгжиж буй орнууд Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дор хэлэлцээ хийх нь бий.
1020	Partial preferential trade agreement	Хэсэгчилсэн хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр. Зарим салбарын хүрээний худалдаанд хязгаарлагдсан хөнгөлөлттэй нөхцөл бүхий худалдааны хэлэлцээрүүд эсвэл гэрээний зөвхөн зарим орны зүгээс бусад гишүүн орнуудаас ирсэн бараа бүтээгдэхүүнд [зах зээлд нь] чөлөөтэй нэвтрэх боломжийг олгосон тэгш хэмт бус худалдааны хэлэлцээрийн (asymmetrical trade agreement) аль нэгийг нь тайлбарлах үед ашигладаг нэр томьёо. Мөн Иж бүрэн хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийг (full preferential trade agreement) үзнэ үү.
1021	Part IV of the GATT	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 4 дүгээр Бүлэг. Энэ нь Кеннедигийн үе шатны хэлэлцээрээс гарал үүсэлтэй, 1966 оны 6 дугаар сарын 27-нд хүчин төгөлдөр болсон Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) протокол. ТХЕХ-т 36-аас 38 дугаар зүйлүүдийг нэмсэн байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Эдгээр гурван зүйл ангид, хөгжиж буй орнуудын худалдаанд нөлөөлж байгаа тохиолдолд, тарифыг бууруулах болон худалдааны саад тотгорыг арилгах талаар хүрээнд харилцан адил байх зарчмыг баримталж ажиллахыг шаардахгүй гэж хөгжингүй орнууд өргөн хүрээнд санал нэгдэв. Мөн түүнчлэн, хөгжингүй орнуудын авч хэрэгжүүлсэн үйлдлийн улмаас болж хөгжиж буй орнуудын худалдааг хохиролд оруулахгүй байх нөхцөлийг хангахын тулд хөгжингүй орнууд арга хэмжээ авч ажиллах ба тэдний худалдааг дэмжин, өргөжүүлэх талаар хамтран ажиллах болно. Хэдийгээр, эдгээр гурван зүйл нь хөгжингүй орнуудад хууль эрх зүйн цөөхөн хэдэн л нөхцөлийг ногдуулсан байдаг боловч 1965 оноос хойш хөгжиж буй орнуудын хийж чадах юу байж болох эсвэл юу хийх ёстойг шаардаж болох тухай хүсэн хүлээлтийг багасгах замаар, худалдааны тогтолцооны хэлбэрийг нэлээд хэмжээгээр боловсруулсан байна. Мөн Зөвшөөрөгдөх заалт (Enabling clause), Хөгжиж буй орнууд ба ТХЕХ-ийг (developing countries and the GATT) үзнэ үү.</p>
1022	Partners for Progress	<p>Ахиц дэвшлийн төлөөх түнш. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) хүрээнд дотор эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг илүү үр дүнтэйгээр дэмжихийн тулд, харилцан туслалцаа үзүүлэх болон сайн дурын зарчим дээр суурилсан АПЕК-ийн механизм. Энэ нь 1995 оны 11 дүгээр сард АПЕК-ийн Сайд нарын хуралдаанаар байгуулагдсан. Уг механизм нь худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах ба хөнгөвчлөхийг шууд хэлбэрээр дэмжих үйл ажиллагаанд чиглэсэн болно. Мөн Богорын тунхаглал (Bogor Declaration), Осака дах Үйл ажиллагааны хөтөлбөрийг (Osaka Action Agenda) үзнэ үү.</p>
1023	Partnership and Cooperation Agreements	<p>Түншлэл ба хамтын ажиллагааны тухай хэлэлцээр (PCAs). Энэ нь Европын хамтын нийгэмлэг болон Тусгаар тогтносон шинэ улсуудын хооронд байгуулсан хэлэлцээрүүдийг нэгтгэсэн нэр. Талууд, бараа бүтээгдэхүүний худалдаанд үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) бие биедээ санал болгодог. Мөн түүнчлэн, үйлчилгээний худалдаа, үүсгэн байгуулах эрх, оюуны өмчийг хамгаалах болон бусад асуудлыг тусгасан нөхцөлүүд бий. Хамтын нийгэмлэгийн хувьд PCAs-ийг эрх үүргийн талаас нь авч үзвэл, хөнгөлөлттэй нөхцөл олгодоггүй стандарт бүтэцтэй хэлэлцээрүүд болон Европын хэлэлцээр (Europe Agreements) хоёрын хооронд замын хагаст нь явж байгаа гэж үздэг боловч, худалдааны хөнгөлөлттэй нөхцөлд автоматаар хүрчихдэг гэж ойлгож болохгүй.</p>
1024	Partners in Transition	<p>Шилжилтийн үедээ яваа түнш (PITs). Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) зүгээс Польш, Унгар, Чех, Словак зэрэг улс орнуудад зориулсан нөхцөл бөгөөд ихэвчлэн үүнийг PITs гэж товчилсон байдаг. OECD нь PITs-ээр дамжуулан гишүүнчлэлд элсүүлэх тухай хэлэлцээний хувьд үүрэг амлалт авсан байдаг. 1995 оны 12 дугаар сард Чех улс PITs-д нэгдэж орсон анхны улс болж, 1996 оны 3 дугаар сард Унгар улс мөн үүний дараа элссэн байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1025	Passive reciprocity	Идэвхгүйгээр харилцан адил байх. Энэ нь худалдааны харилцан либералчлал хоёр улсад, хоёуланд нь үр ашиг өгнө хэмээн хоёр улс харилцан зөвшөөрөх боломжтой гэсэн ойлголт бий болоход хүргэсэн Уильям Р. Клайны танилцуулсан ойлголт. ДХБ-ын дүрмийн дагуу ийм либералчлал нь дараа нь, үндэсний нэн тааламжтай нөхцөлийн үндсэн дээр, Дэлхийн худалдааны байгууллагын бүх гишүүдэд хүрч ажиллах ёстой. Мөн Түрэмгийгээр харилцан адил байх (aggressive reciprocity), харилцан адил байх (reciprocity) талаар үзнэ үү.
1026	Pass-through operations	Дамжин-өнгөрөх үйл ажиллагаа. Энэ нь аль хэдийнээ хөнгөлөлттэй нөхцөлийн дагуу нэвтрэх эрхтэй болсон орны эдийн засгаар дамжуулан тухайн бүтээгдэхүүнүүдийг тээвэрлэснээр хөнгөлөлттэй нөхцөлөөр тус зах зээлд нэвтрэх боломжийг олж авах зорилготой үйл ажиллагаанууд. Ийм тохиолдолд гол зорилго бол бараа бүтээгдэхүүнийг дундын зуучлагч эдийн засагт аль болох хамгийн бага хэмжээнд өөрчлөн хувиргасан байх нь чухал. Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм (preferential rules of origin), Худалдааны хөнгөлөлтийн нөхцөл бүхий зохицуулалт (preferential trade arrangements), үлэмж хэмжээний өөрчлөлт (substantial transformation) үзнэ үү.
1027	PATCRA	Папуа Шинэ Гвиней ба Австралийн хоорондын худалдаа ба арилжааны харилцааны тухай хэлэлцээр (PATCRA). Хоёр талын худалдааны харилцааны албан ёсны бүтэц, хамрах хүрээг тодорхойлдог.
1028	Patent	Патент. Патентыг шинийг зохион бүтээгч нарт шинэ, хэрэгцээтэй, илт тодорхой бус шинэ зохион бүтээлтийг бүтээж, ашиглаж, борлуулахад нь зориулан, тодорхой заасан хугацаанд онцгой эрхтэйгээр ашиглахад нь зориулж олгосон эрх. Патентыг бүтээгдэхүүн болон үйл явцад зориулан олгох боломжтой. Мөн оюуны өмч (intellectual property), Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) үзнэ үү.
1029	Patent Cooperation Treaty	Патентын хамтын ажиллагааны олон улсын гэрээ. Гишүүн улс орнуудад олон улсын патентын өргөдөл гаргах боломж олгодог. Өргөдөл гаргагч нь тухайн улсын патентын газраар дамжуулан өргөдөл гаргах ёстой ба уг патентын газар байрлаж буй улсынхаа иргэн эсвэл оршин суугч байх бөгөөд гишүүн улсуудын хувьд тухайн улсын үндэсний патентын албанд өргөдөл гаргахтай адил үр нөлөөтэй байдаг. Уг олон улсын хэлэлцээр нь 73 гишүүнтэй. Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) удирдан ажилладаг. Мөн оюуны өмч (intellectual property), оюуны өмчийн эрхийн зөрчлийн (intellectual property infringement) тухай үзнэ үү.
1030	Pathfinder approach	Туршилтын төлөвлөгөөний арга барил. 2001 онд Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) Эдийн засгийн асуудал хариуцсан тэргүүн нарын уулзалтын (APEC Economic Leaders' Meeting) үеэр тохиролцсон хэлэлцээр бөгөөд үүнд бүлэг гишүүн улс орнууд, Богорын тунхаглалын (Bogor Declaration) зорилгуудыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхэд, "Туршилтын төлөвлөгөөний санаачилгыг" боловсруулснаар илүү түргэн урагшлуулах боломжтой болно гэж үзжээ.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1031	Peace clause	<p>Энхийн тохиролцооны нэмэлт зүйл. ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн (WTO Agreement on Agriculture) дараах нөхцөлүүдийг хэлж байгаа бөгөөд гишүүн орнууд үүнийг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд: (a) Ногоон ангилалд хамаарах татаасны бодлого (green box policies) болон үүрэг, амлалтдаа нийцүүлсэн дотооддоо үзүүлэх болон экспортод олгох татааснуудтай уялдуулан авч үзвэл, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн (Agreement on Subsidies and Countervailing Measures) хүрээнд хэрэгжүүлэх боломжтой байдаг арга хэмжээнүүдийг хэрэглэхгүй байх, (b) Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) дагуу олгосон байдаг Татаасыг саармагжуулах нөхөн тэгшитгэх татвар ногдуулах эрхийг хэрэглэхдээ, “зохих ёсны хязгаарлалт”-ыг (“due restraint”) хэрэглэх болно, (c) Үйл ажиллагааг хүчингүй болгох эсвэл үүрэг амлалтыг үл тоомсорлох/ дордуулах үйлдлийн хувьд зааж тогтоосон хязгаарлалтуудыг тэд хүлээн зөвшөөрч байгаа зэрэг болно. Эдгээр заалтууд нь есөн жилийн хугацаанд, тухайлбал 2003 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл хүчин төгөлдөр үргэлжилсэн.</p>
1032	Peak tariffs	<p>Оргил тариф. Улс орнууд өөрийн “эмзэг” буюу үнийн мэдрэмж өндөртэй бараа бүтээгдэхүүний импортод ихэвчлэн харьцангуй өндөр тариф ногдуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалдаг бөгөөд бусад бараа бүтээгдэхүүний тарифын түвшин доогуур байдаг. Аж үйлдвэржсэн орнуудын хувьд 15% ба түүнээс дээш тарифыг “тарифын оргил түвшин” гэж хүлээн зөвшөөрдөг. Улс орнуудын зөвхөн тарифын оргил түвшинг хараад дотоодын үйлдвэрлэлийн хамгаалалтыг дүгнэж болохгүй. Хэдийгээр тариф нь доогуур байгаа ч оргил түвшинтэй дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү нөлөө үзүүлэхүйц тарифын бус арга хэмжээгээр халхавч хийсэн тохиолдол байдаг. Мөн эмзэг бүтээгдэхүүнүүдийг (sensitive products) үзнэ үү.</p>
1033	PECC (Pacific Economic Cooperation Conference)	<p>Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал. Энэ нь 1980 онд байгуулагдсан. Энэ нь Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлуудаар өөрсдийн хэтийн төлөвлөгөө болон мэдлэг туршлагаасаа хуваалцахаар 22 гишүүн орны бизнес, эрдэм шинжилгээ болон засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн байдаг. Үүний ивээл дор байдаг Худалдааны бодлогын чуулга уулзалт (Trade Policy Forum) нь Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр онцгой ач холбогдолтой байсан. PECC нь АПЕК-ийн үйл явц дах бодлогын түвшний үзэл санааны хувьд гол хувь нэмэр оруулагчдын нэг юм. Уг бага хурлын нарийн бичгийн дарга нарын газар нь Сингапур хотод байрладаг байна. Мөн Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл дах Австралийн үндэсний хороог (Australian National Committee at the Pacific Economic Cooperation Council) үзнэ үү.</p>
1034	Performance requirements	<p>Гүйцэтгэлийн шаардлага. Экспортын гүйцэтгэлийн шаардлагыг (export performance requirements) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1035	Permanent Group of Experts	Шинжээчдийн байнгын бүлэг (Мэргэжилтний байнгын хэсэг (МБХ) - Уругвай). ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт (WTO Agreement on Subsidies and Countervailing Duties) заасны дагуу байгуулагдсан байгууллага. Энэ нь татаас болон худалдааны харилцааны чиглэлээр тавигдах шаардлагыг хангасан бие даасан таван гишүүнээс бүрддэг. Шинжээчдийн байнгын бүлгийн чиг үүрэг нь хориглосон татаас байсан тухай сэжиг бүхий эргэлзээтэй асуудлын маргааныг таслан шийдвэрлэхээр цугласан байж болох Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийг дэмжиж мөн санал болгож буй эсвэл одоогоор байгаа татаасны асуудлаар зөвлөгөө өгч ажиллах явдал юм.
1036	Permanent normal trade relations	Энгийн худалдааны байнгын харилцаа. Энэ нь жил бүр шинэчлэлт хийх болж байсан улс орнуудад үндэсний нэн тааламжтай байнгын нөхцөлийг (permanent most-favoured nation treatment) тохиролцон зөвшилцөх санааг илэрхийлсэн Америкчуудын үг хэллэг юм. Мөн худалдааны энгийн харилцаа (normal trade relations), худалдааны түр зуурын энгийн харилцаа (temporary normal trade relations) үзнэ үү.
1037	Permanent Secretariat of the General Treaty on Central American Economic Integration	Төв Америкийн эдийн засгийн интеграцчиллын тухай ерөнхий гэрээний Байнгын нарийн бичгийн дарга нарын газар. SIECA-г үзнэ үү.
1038	Per se conduct	Яг тухайн зүйл буюу тохиолдолд хамаарч удирдан явуулах дүрэм буюу үйл ажиллагааны дэг. Дүрэм журмын үргэлж эсрэг байдаг аж ахуйн нэгжийн зан үйлд хандаж итгэлцлийн эсрэг буюу монополын эсрэг хуулийг удирдан явуулахад энэхүү нэр томьёог ашигладаг. Яг тухайн зүйл буюу тохиолдолд хамаарч удирдан явуулах дүрэм нь тодорхой хууль эрх зүйн стандартыг бий болгох давуу талтай байдаг бөгөөд зөвхөн ийм үйлдэл хийснийг харуулах л шаардлагатай байдаг тул үүнийг хэрэгжүүлэхэд харьцангуй хямд байдаг. Мөн өрсөлдөөний бодлого (competition policy), учир шалтгааны дүрмийг (rule of reason) үзнэ үү.
1039	Pflimlin plan	Пфлимлины төлөвлөгөө. Энэ нь 1951 онд Франц улсын зүгээс гаргасан, Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) бүх гишүүн орнуудыг тарифаа дунджаар 30% бууруулах санал. Уг төлөвлөгөө нь хөгжиж буй орнуудад өргөн хүрээнд үүрэг амлалтаа цуцлах боломжийг олгосноороо, тэднийг мөн ижил хэмжээнд тарифын хувь хэмжээг хасах нөхцөлөөс чөлөөлөгдөх боломжийг олгох байлаа. Үүний талаар нэлээд өргөнөөр хэлэлцсэн боловч эцэст нь зөвхөн тухайн барааны зүйл бүрээр (item-by-item) тарифыг бууруулах асуудлыг зөвшөөрдөг АНУ-ын хэлэлцээ хийх хязгаарлагдмал эрхтэй удирдлага уг төлөвлөгөөнд төгсгөл тавьсан байна. М.Пьер Пфлимлин тухайн үед Францын Эдийн засгийн гадаад харилцааны сайд байсан. Мөн үүрэг амлалтыг цуцлах тухай баримт бичгийг (үүргээс чөлөөлөхийг - Уругвай) (waiver) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1040	Phase-in periods	<p>Аажмаар үе шаттайгаар нэвтрүүлэх хугацаа. Энэ нь заримдаа тодорхой заасан цаг хугацааны хуваарийн дагуу шинэ гэрээ хэлэлцээр эсвэл шинэ үүрэг амлалтуудыг үе шаттайгаар нэвтрүүлэхийг хэлдэг. Төгсгөлийн цэгийг хатуу тогтоосон байна. Жишээлбэл, Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр тохиролцсон тарифын бууруулалтыг жил бүр таван удаагийн тэнцүү хэмжээгээр бууруулах замаар үе шаттайгаар нэвтрүүлж болно, гэхдээ үүнээс илүү хурдан арга хэмжээг мэдээж бас авч болно. Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээр (Agreement on Textiles and Clothing) эсвэл Мэдээллийн технологийн тухай хэлэлцээрийн (Information Technology Agreement) дагуу хэрэглэж болдог Аажмаар үе шаттайгаар нэвтрүүлэх хугацааны бусад жишээ бас байна. Мөн хэрэгжилтийг (implementation) үзнэ үү.</p>
1041	Picking winners	<p>Ялагчийг сонгох. Энэ нь ирээдүйд тодорхой хэмжээний найдвар төрүүлэх зарим аж үйлдвэрийн үйл ажиллагааг тодорхойлох болон эдгээр аж үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэхэд дэмжих үүднээс дэмжлэг үзүүлэх хамрах хүрээг бий болгоход чиглэсэн засгийн газрын зүгээс гаргадаг ховор хандлага. Үүнд ялангуяа өндөр технологийн үйлдвэрлэлийн салбарыг илүүд үзсэн байдаг. Дэлхийн хэмжээнд амжилтад хүрсэн аж үйлдвэрүүдийг бүтэлгүйтсэн байдлаар нь авч үзвэл ядаж л тэнцвэржсэн байдаг бөгөөд ихэнх тохиолдолд ийнхүү сонгогдсон үйлдвэрүүд нь, онцгой анхаарал хандуулж илүү таатай хандлага авч чадаагүй дунд зэргийн аж үйлдвэр эсвэл компаниудаас илүү сайн байн гүйцэтгэлтэй байж чадаагүй байдаг байна. Адам Смитийн анхааруулгыг дахин сануулахад хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд “жам ёсоор хүртэх байсан хэмжээнээс нь илүү их хэмжээгээр нийгмийн өмч хөрөнгөөс таслан тодорхой нэг төрлийн аж үйлдвэрийн салбарт олгоход чиглэсэн эсвэл маш их хязгаарлалт тавих замаар тухайн нэг аж үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхлэх байсан ихээхэн хэмжээний капитал хөрөнгийг хүчээр салган авахыг хөхиүлэн дэмжих гэсэн энэ хоёрын аль нэгэн байдлаар нь ажиллаж байдаг аливаа систем болгоны хувьд, анх хөхиүлэн дэмжинэ гэж байсан агуу зорилгоо үнэндээ гажуудуулж байгаа юм” гэжээ. “Энэ нь нийгмийн ахиц дэвшлийг бодит баялаг болон агуу байдалд хүргэх үйл явцыг хурдасгахын оронд удаашруулдаг; ба түүний газар болон хөдөлмөрийн үр дүнд жил бүр гарч буй бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг нэмэгдүүлэхийн оронд бууруулдаг.” Мөн үндэсний аварга (national champions), худалдааны стратегийн онолыг (strategic trade theory) үзнэ үү.</p>
1042	Pipeline protection	<p>Боловсруулалтын үйл ажиллагааны явцад хамгаалах. Энэ нь албан ёсоор патент олгохоос өмнө одоогоор байгаа уг шинэ бүтээлүүдэд зориулсан оюуны өмчийн эрхийг хамгаалах явдалтай уялдуулсан арга туршлага. Энэхүү арга ажиллагаанаас ялангуяа хөдөө аж ахуйн зориулалттай химийн бүтээгдэхүүн, эм, эм зүйн бүтээгдэхүүнүүд нь их ашиг тус хүртдэг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1043	Piracy	<p>Зохиогчийн эрхийг зөрчих, хууль бусаар ашиглах. Оюуны өмчийн эрхээр баталгаажсан бүтээлийг хууль бусаар хувиран олшруулж худалдаалах хэлбэр. Ийм аргаар үйлдвэрлэсэн барааг "хууль бусаар дуурайлгасан бараа" гэдэг.</p> <p>Дуу, дүрс бичлэгийг шаглах (bootlegging), шударга хэрэглээний номлол (fair-use doctrine), оюуны өмч (intellectual property) болон оюуны өмчийн эрхийг зөрчих (intellectual property right infringements) тухай үзнэ үү.</p>
1044	Plant breeders' rights	<p>Ургамал үржүүлэгчдийн эрх. Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын конвенцийн дагуу оюуны өмчийн хамгааллын төрөл зүйлийн ховор /хосгүй/ давтагдашгүй эрхийг (a sui generis right) олгох боломжтой байдаг. Хамгаалалтад орох боломжтой байхын тулд ургамлын сорт нь: (a) бусдаас ялгаатай (жишээ нь, өөрөөр түгээмэл байдаг бусад сортуудаас ялгах боломжтой), (b) тогтвортой (өөрөөр хэлбэл давтан тариалахад нь түүний шинж чанарыг өөрчлөх ёсгүй), (c) давтан тариалалт болон үржүүлж олшруулахын хувьд гомогенийн буюу гарал нэг хэвээр байдаг, (d) [оюуны өмчийн] эрхийг эзэмшигчийн зөвшөөрөлтэйгөөр урьд өмнө тус эх оронд нь борлуулагдаж эсвэл сурталчлан таниулж байгаагүй гэдэг утгаараа шинээр бий болсон, урьд өмнө байгаагүй [сорт] байх зэрэг болно. Хамгаалалтыг ихэвчлэн арваас хорин жилийн хугацаанд олгодог. Мөн Ургамал хамгааллын олон улсын конвенцыг (International Plant Protection Convention) үзнэ үү.</p>
1045	Ploughshares War	<p>Анжисны хошууны дайн (Плафшерсийн дайн). Энэхүү ярианы хэллэг нь анх Николас Батлер ашигласан бөгөөд энэ нь хөдөө аж ахуйн ерөнхий бодлого байгуулагдсанаас хойш, АНУ болон Европын хамтын нийгэмлэгийн хооронд хөдөө аж ахуйн салбарт үүссэн худалдааны зөрчилдөөнийг тайлбарлахад ашигладаг байна. Мөн Тахианы махны Дайныг (Chicken War) үзнэ үү.</p>
1046	Plurilateral trade agreements	<p>Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээр. Энэ нь ДХБ-ын хүрээнд байгуулагдсан гэрээнүүдийг хэлж байгаа бөгөөд энэ нь ДХБ-д гишүүнээр элсэхэд тавигдах ямар нэгэн урьдчилсан нөхцөл биш. Мөн ДХБ-ын Хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн худалдааны хэлэлцээрийг (WTO plurilateral agreements) үзнэ үү.</p>
1047	Plurilateralism	<p>Хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн онол. Хоёр талт харилцааны онол (bilateralism) буюу хоёр гишүүн улсаас арай илүү тооны гишүүн улсыг хамруулсан боловч олон талт тогтолцооны онолын (multilateralism) хэмжээнд авч үзэх тооны гишүүн улсуудаас арай бага тооны гишүүн улсуудыг хамруулсан жижиг бүлгийн хэмжээнд ажил хийхийг Хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн тухай онол (plurilateralism) гэнэ. Мөн минилатерализм буюу цөөн тооны талуудын харилцааны онол (minilateralism), ДХБ-ын Хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн худалдааны хэлэлцээрийг (WTO plurilateral agreements) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1048	Policy competitiveness	Бодлогын өрсөлдөх чадвар. Засгийн газрын гол зорилт нь өөрсдийн эрх мэдэл бүхий харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд томоохон аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн шинэ барилга байгууламжийг барихад нь бусад боломжит газруудаас илүү дээр нөхцөлүүдийг санал болгох замаар уг нөхцөлийг баталгаажуулж өгөх явдал юм. Энэ нь бусдад зардал үүсгэсний хүчинд ашиг хүртэх боломжтой гэсэн үзэл бодлын үр дагавар юм. Ихэвчлэн татвар төлөгч нь бодлогын өрсөлдөх чадварын хувьд хүсээгүй андеррайтер нь болж таардаг.
1049	Policy-led integration	Бодлогод суурилсан интеграцчилал. Энэ нь ихэвчлэн бүс нутгийн түвшний хөнгөлөлттэй худалдааны зохицуулалтаар дамжуулан хийгддэг албан ёсны эрх зүйн зохицуулалтаар дамжуулан хэрэгждэг, бүс нутгийн эдийн засгийн интеграцчилал юм. Мөн зах зээлд суурилсан нэгтгэл/интеграцчиллыг (market-led integration) үзнэ үү.
1050	Polluter-Pays Principle	Бохирдуулагч нь төлдөг байх зарчим. Энэ нь байгаль орчны бодлогын талаарх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Удирдлага зарчимд тусгагдсан зарчим. Үүнд бохирдлыг бууруулах, нөөцийг илүү сайн хуваарилдаг болохын тулд төрийн байгууллагуудын шийдвэрлэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг бохирдуулагч тал хариуцах ёстой гэж заасан байдаг. Эдгээр арга хэмжээний өртгийг, үйлдвэрлэл ба /эсвэл хэрэглээний хүрээнд бохирдол үүсгэж байдаг бараа, үйлчилгээний өртөгт нь тусгаж өгсөн байх ёстой. Ийм арга хэмжээ нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад ихээхэн гажуудал үүсгэж болох татаасыг дагалдан гарч ирж болохгүй. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
1051	Portfolio investment	Портфель/багц хөрөнгө оруулалт. Энэ нь төрөлжсөн портфель хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох цөөнхийн эзэмшлийн хувьцаа, бондууд болон бусад үнэт цаас. Портфель хөрөнгө оруулалт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хоорондын гол ялгаа нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ гэж ерөнхийдөө хардаг. Эздийн өмч буюу өөрийн хөрөнгийн хэмжээ нь 10%-аас бага байх тохиолдолд, портфель хөрөнгө оруулалт гэж тооцогдоно. Мөн хөрөнгө оруулалт (investment), эздийн өмч буюу өөрийн хөрөнгөд тулгуурлаагүй хөрөнгө оруулалтыг (non-equity-based investment) үзнэ үү.
1052	Positive comity	Эерэг нийгэмлэг ба найрсаг ёс. Энэ нь өрсөлдөөний бодлогын удирдан зохицуулахад хэрэглэгддэг нэр томьёо ба тухайн нэг улс, холбогдох хоёр талт эрх зүйн зохицуулалт (relevant bilateral arrangement) дүрмийн дагуу, нөгөө улсын өрсөлдөөний тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа эхлүүлэхийг бусад улсаас хүсэж болно гэсэн үг. Энэ нь бусад улсын эрх баригч удирдлагуудын зүгээс хийхгүй байх байсан тийм арга хэмжээг авахад хүргэж болзошгүй юм. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) 9 дүгээр Зүйлд (Бизнесийн үйл ажиллагаанд) [Ажил хэргийн практикт - Уругвай] эерэг нийгэмлэгийн зарчмыг уялдуулан оруулсан байдаг. Мөн сөрөг нийгэмлэг ба найрсаг ёсыг (negative comity) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1053	Positive integration	Эерэг интеграцилал. Энэ нь тодорхой зорилготойгоор шинэ байгууллага болон зохицуулалтын тогтолцоог байгуулах замаар эдийн засгийн интеграцилалд хүрэхийг хэлнэ. Мөн сөрөг нэгтгэл буюу интеграцилалыг (negative integration) үзнэ үү.
1054	Positive listings	Эерэг жагсаалт буюу нэмж оруулах зарчмаар жагсаалтыг бүрдүүлэх. Энэ нь улс орнууд Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) дагуу хүлээсэн үүрэг, амлалтаа эерэг жагсаалт хэлбэрээр тусгаж болно гэсэн үг. Ийм арга замаар, зөвхөн бүртгэгдсэн үйл ажиллагаанууд ҮХЕХ-ийн бүх заалтуудад хамрагддаг ба үүнд зах зээлд нэвтрэх асуудал болон үндэсний нөхцөлийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтуудыг чухалчилдаг байна. Үүний сул тал нь уг Хэлэлцээрийн дагуу хэдийгээр зах зээлд нэвтрэх эсвэл үндэсний нөхцөлд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байсан ч, бүх үйлчилгээг жагсааж бичих ёстой болдог. Ихэнх улс орнууд өөрсдийн бүх жагсаалтыг энэ хэлбэрээр гаргасан байдаг. Мөн Хасалт хийх журмаар гаргадаг жагсаалт (negative listings), үйлчилгээний зах зээлд нэвтрэх (market access for services) тухай үзнэ үү.
1055	Precautionary principle	Урьдчилан сэргийлэх зарчим. Энэ нь Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио дах тунхаглалын (Rio Declaration on Environment and Development) 15 дугаар зарчимд хамаарна. Үүнд зааснаар бол, хүрээлэн буй орчинд ноцтой эсхүл нөхөх аргагүй хохирол учруулах аюул байгаа тохиолдолд, шинжлэх ухааны бүрэн үндэслэл байхгүй байна гэсний үндсэн дээр, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээ авахыг хойшлуулах шалтгаан болгохгүй байх ёстой. Мөн худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
1056	Pre-competitive development activity	Өрсөлдөөний өмнөх шатны зохион бүтээлтийн үйл ажиллагаа. Энэ нь ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт (WTO Agreement on Subsidies and Countervailing Measures) ашигладаг чухал зарчим. Компаниудын зүгээс эсвэл тэдний өмнөөс ажиллаж буй байгууллагуудын удирдан зохион байгуулж буй судалгааны үйл ажиллагаанд зориулсан дэмжлэг. Жишээ нь, татаас зэргийг хэрэв өрсөлдөөний өмнөх шатны зохион бүтээлтийн үйл ажиллагааны зардлын 50%-иас илүү хувийг хамраагүй л бол зөвшөөрдөг байна. Эдгээрийг худалдах эсвэл ашиглах зориулалтаар зориулан хийж байгаагаас үл хамааран, аж үйлдвэрийн судалгааны үр дүнг шинэ, шинэчилж өөрчилсөн, эсхүл засаж сайжруулсан бараа бүтээгдэхүүн, үйл явц эсвэл үйлчилгээнд зориулсан төлөвлөгөө, ажлын эскиз зураг төсөл, эсвэл загвар дизайн болгон хувиргах үйл явц гэж тодорхойлдог бөгөөд үүнд, арилжааны зорилгоор ашиглаж боломжтой анхны бүтээгдэхүүний загварыг зохион бүтээх үйл ажиллагаа ч хамрагдана. Үүнд мөн агуулга, үзэл санааг боловсруулах, бүтээгдэхүүний загвар дизайн, үйл явц эсвэл үйлчилгээ зэргийг хамруулж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1057	Predatory pricing	Түрэмгийгээр үнэ тогтоох. Үнийг маш түрэмгийгээр хэт доогуур тогтоох үйлдлийг мөн зардлаас ч доогуур үнэлэх гэх мэтээр сүйтгэх нөлөөтэй өрсөлдөөн гэсэн нэрээр нь мэддэг. Энэ бол ТХЕХ-т тусгасан демпингийн нөхцөлийг үндэс болгож бодолцсон агуулга. Үүнд нэгэн дуугаар санал нэгтэйгээр түрэмгийгээр үнэ тогтоох талаар нэгдмэл ганц тодорхойлолтыг гаргасан зүйл байхгүй боловч, түрэмгийлэн үнэ тогтоосон байхын тулд тухайн үйлдэл нь үр дүнтэй өрсөлдөгчдийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн байх ёстой гэдэг дээр санал нэгдсэн байдаг байна. Өрсөлдөхүйц үнэ болон түрэмгийлсэн үнэ хоёрын хооронд зааглаж буй шугам нь юу байж болох вэ гэдгийг тодорхойлоход үргэлж л хүнд байсан. Түрэмгийлэл гэдэг бол өндөр зардалтай үйл ажиллагаа бөгөөд энэ нь тухайн түрэмгийлэгчийн хувьд, эцсийн дүндээ гарсан бүх зардал болон урьдчилан тооцоолсон орлогыг нөхөж олж чадсан тохиолдолд л зөвхөн ашигтай байх болно. Энэ бол эргэлзээтэй санал юм. Мөн Арета-Тернерийн туршилт (Areeda-Turner test), үнийн бус урьдчилсан байдлыг (non-price predation) үзнэ үү.
1058	Predatory-pricing dumping	Довтолгооны демпинг. Өрсөлдөгчөө зах зээлээс шахах, монополь тогтоох зорилготой демпинг. Демпингийг (dumping) үзнэ үү.
1059	Preference erosion	Хөнгөлөлтийн элэгдэл. Энэ нь улс орнууд үл ялгаварлах нөхцөл бүхий худалдааны либералчлалыг явуулж эхлэхтэй холбоотойгоор хөнгөлөлттэй нөхцөлийнх нь ашиг аажмаар алга болох эсхүл буурах үзэгдэл. Мөн түүхэнд тэмдэглэгдсэн хөнгөлөлтийг (historical preferences) үзнэ үү.
1060	Preferences	Хөнгөлөлт. (Давуу эрх - Уругвай). Энэ нь зарим худалдааны түншүүддээ, ихэвчлэн бууруулсан хэмжээтэй тариф ногдуулах эсхүл зарим тарифын бус арга хэмжээг хэрэглэхгүй байх зэрэг хэлбэрийн таатай нөхцөлийг олгодог байна. Мөн түүхэнд тэмдэглэгдсэн хөнгөлөлт (historical preferences), Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP), Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн систем (GSTP), Үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured-nation treatment), худалдааны хөнгөлөлттэй нөхцөл бүхий зохицуулалтыг (preferential trade arrangements) үзнэ үү.
1061	Preferential investment arrangements	Хөнгөлөлттэй нөхцөл бүхий хөрөнгө оруулалтын зохицуулалт. Энэ нь сонгосон улс орнууд эсхүл бүлэг улс орнуудын хөрөнгө оруулалтын капиталд илүү сайн нөхцөлөөр нэвтрэх боломжийг олгосон албан эсвэл албан бус эрх зүйн зохицуулалтууд. Үүнд хөрөнгө оруулалтын санал хүсэлтийг шуурхай авч үзэх, бусдад хаалттай үйл ажиллагаанд хөрөнгө оруулахыг зөвшөөрөх, өөрийн хөрөнгөд эзлэх гадаадын хувь хэмжээнд хамгийн дээд хэмжээ тавих гэх зэрэг зүйлс орж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1062	Preferential market access	Зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх. Энэ нь үл ялгаварлах үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс илүү таатай нөхцөл бүхий, зах зээлд нэвтрэх аливаа нөхцөлийг худалдааны түншдээ олгох явдал. Хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх нь гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсүүдэд, эсхүл эзэнт хааны олгосон одоогоор үлдсэн хөнгөлөлттэй нөхцөл зэргээр дамжуулан, харилцан адил эсвэл тэгш хэмт байх боломжтой. Мөн Карибын тэнгисийн сав газрын санаачилга (Caribbean Basin Initiative), Ломе дах конвенц (Lome Convention), SPARTECA болон бусад адил механизмуудынх шиг харилцан адил бус эсвэл тэгш бус хэмтэй байж бас болно.
1063	Preferential rules of origin	Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм (Уругвай). Чөлөөт худалдааны хэлэлцээр болон бусад хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийн гишүүн орнууд өөр хоорондоо худалдаа хийх үед гаалийн тарифын болон бусад хөнгөлөлтийг үзүүлдэг ба уг бараа оролцогч орнуудаас гарал үүсэлтэй гэдгийг нотлох дүрэм, шалгуур бүхий систем. Хэрэв уг бүтээгдэхүүн нь хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийн гишүүн орноос гарал үүсэлтэй биш бол, жишээлбэл, уг бараанд үлэмж хэмжээний өөрчлөлт хийгдээгүй, эсхүл багахан хэмжээний нэмүү өртөг шингээсэн байна гэсэн шийдвэрийг хүлээн авагч орон гаргасан тохиолдолд хөнгөлөлттэй тариф бус үндэсний нэн тааламжтай тарифын хувь хэмжээгээр гаалийн татвар авах болно. Гарал үүслийн дүрэм нь хөнгөлөлттэй, эсхүл хөнгөлөлтгүй байснаас үл хамааран, чөлөөт худалдааны хэлэлцээр бүрд өөр өөр байдаг. Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр (NAFTA) нь олон тооны гарал үүслийн дүрэмтэй байдаг. Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм нь ихээхэн нарийн төвөгтэй байдаг ба үүнийг харилцан уялдуулах, эсхүл оновчтой болгох гэсэн бүх оролдлогууд өнөөг хүртэл бүтэлгүйтсээр дууссан байдаг. Пан-Европын нэгтгэсэн бүс (Pan-European Cumulative Area) үзнэ үү.
1064	Preferential trade arrangements	Худалдааны хөнгөлөлттэй нөхцөл бүхий зохицуулалт. Эдгээр нь гэрээний нэг тал нь зөвхөн нэг талын баримтлалын дагуу эсхүл хэлэлцээний үр дунд тохиролцсоны дагуу, нэг эсвэл түүнээс дээш тооны бусад талуудад бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийг олгохоор зөвшөөрсөн худалдааны зохицуулалт. Ийм зохицуулалтыг байгуулах хүрээ нь, хэдийгээр хөгжиж буй орнуудын хувьд илүү уян хатан байдаг боловч, ДХБ-ын харьцангуй нарийн тодорхой дүрмээр зохицуулагдана. Тэд хөнгөлөлттэй тариф олгох, тарифыг бүрэн арилгах, эсхүл үйлчилгээний хувьд хэсэгчилсэн либералчлал хийх хэлбэрээр бие биедээ хөнгөлөлт үзүүлэх боломжтой. Хөгжингүй орнууд чөлөөт худалдааны хэлэлцээр, гаалийн холбоо, эсхүл үйлчилгээний хувьд эдийн засгийн интеграцчлалын хэлэлцээрийн аль нэгийг байгуулах ёстой байдаг. Өөрөөр хэлбэл, тэд хөнгөлөлттэй нөхцөлийг хүртэж буй бүх орнуудын дунд байгаа худалдааны бүх саад тотгорыг ихээхэн хэмжээгээр арилгах ёстой байдаг гэсэн үг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Жишээлбэл, хэрэв тэд бие биндээ зөвхөн нэр төрлийн бүтээгдэхүүнд хөнгөлөлт өгөхийг хүсэж байвал, үндэсний нэн тааламжтай нөхцөлийн дүрмийн дагуу бусад бүх худалдааны түншүүддээ мөн яг ижил түвшинд [зах зээлд нь] нэвтрэх нөхцөлийг олгох хэрэгтэй болно. ДХБ-ын дүрмийн дагуу, хөнгөлөлттэй худалдааны зохицуулалт нь хөгжингүй орнуудын байгуулсан Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP) болон хөгжиж буй орнуудын Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн системийн схемд (GSTP scheme) оролцох хэлбэр бүхий хууль ёсны зохицуулалт байдаг. Эдгээрээс бусад хөнгөлөлтийн зохицуулалтад хамрагдахын тулд үүрэг амлалтыг цуцлах тухай бичиг баримт (waiver) (үүргээс чөлөөлөхийг - Уругвай) олж авах шаардлагатай байдаг. Зарим Найрамдал, арилжаа худалдаа ба хөлөг онгоцоор явах, жолоодох ухааны [навигац] тухай гэрээнүүдийг (Treaty of Friendship, commerce and navigation) хөнгөлөлттэй зохицуулалт гэж ангилдаг байна, учир нь эдгээр гэрээний талууд нөгөө талдаа худалдааны хөнгөлөлттэй нөхцөл олгохгүйгээр, зан үйлийн тодорхой стандарт хэм хэмжээний баталгаа гаргаж өгөх тохиолдол байдаг. Мөн Карибын тэнгисийн сав газрын санаачилга (Caribbean Basin Initiative), Эзэнт гүрний давуу байдлын/хөнгөлөлтийн зохицуулалт (imperial preferences arrangement), Ломе дах конвенц (Lome Convention), зах зээлд хөнгөлөлттэй нэвтрэх (preferential market access) болон SPARTECA-г үзнэ үү.</p>
1065	Preparatory work	Бэлтгэл ажил. Хүнд бэрх бэлтгэл ажлыг (travaux preparatoires) үзнэ үү.
1066	Preshipment inspection	<p>Ачилтын өмнөх хяналт шалгалт (PSI). Энэ нь бараа бүтээгдэхүүнийг бусад орнууд руу тээвэрлэгдэхээс нь өмнө тусгайлан томилогдсон компаниудаар хянуулж, шалгалт хийлгэдэг. PSI нь ДХБ-ын Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээрт (WTO Agreement on Preshipment Inspection) тодорхойлсноор бол, ДХБ-ын гишүүний хувьд өөрийн улсын нутаг дэвсгэр лүү нь экспортлогдогдох бараа бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ, үнэ, үүнд валют, валютын ханш, санхүүгийн нөхцөл болон бараа бүтээгдэхүүний тарифын ангилал зэрэгтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хэлнэ.</p>
1067	Price dumping	<p>Үнийг хэт буулгах (Үнийн демпинг). Демпингийн энэ төрлийг, одоогоор Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 6-р зүйлд хамаарагдах, Гаванагийн дүрмийг (Havana Charter) хэлэлцэх үеэр тогтоосон байдаг. Экспортлогч нь бараа бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлээс хямд үнээр гадаадад зарж борлуулах гэсэн ойлголт дээр суурилдаг бөгөөд энэ нь мөн ижил төрлийн барааг үйлдвэрлэдэг импортлогч орны аж үйлдвэрлэлд хохирол үзүүлэх магадлалтай юм. Мөн Демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1068	Price equalisation mechanism	<p>Үнэ тогтворжуулалтын тогтолцоо. Энэ нь эргээд үйлдвэрлэгч нартаа ашгаа өгөх, арилжааны шинж чанартай үйлдвэрлэгдсэн ба худалдаалагдах бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнийг хэт их хэлбэлзүүлэхгүй байх нөхцөлийг хангаж боловсруулсан механизм. Энэхүү зорилт нь үйлдвэрлэгчид илүү урьдчилан таамаглаж болохуйц урамшууллын үр ашгийг хүртэх нөхцөлийг баталгаажуулах замаар, тухайн аж үйлдвэрийн салбарыг тогтсон дэгийн дагуу зохион байгуулалттайгаар хөгжихийг хөхиүлэн дэмжих явдал. Үүний зэрэгцээ эцсийн хэрэглэгч нар хүртэл тухайн аливаа өгөгдсөн цаг мөчид байж болох үнийн хамгийн боломжийн өөрчлөлтийг урьдчилан мэдэж байх боломжийг олгосноор үр ашгаа өгөх боломжтой гэж үздэг. Ийм механизм олон янзын арга замаар ажилладаг. Эдгээрийн гол бэрхшээл нь татаас болоод хувирчихгүй байх явдал. Уг тогтолцооны санхүүжилтийг үйлдвэрлэгчид хариуцаж байгаа тохиолдолд л үүнийг хийж болно. Ийм арга замаар зах зээлийн дундаж үнийн чиг хандлагын сигналыг (price signal) үл тоомсорлох нөхцөл бүрдэхгүй юм. Мөн нөөц хувьцаа (buffer stocks), Хөдөө аж ахуйн нийтлэг бодлого (common agricultural policy), доод хязгаар үнэ (floor price), Түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрийг (international commodity agreements) үзнэ үү.</p>
1069	Price undertakings	<p>Үнийн талаар хүлээх үүрэг. Хэрэв тухайн бараа бүтээгдэхүүнийг демпинг хийсэн байна гэж тооцогдож байгаа экспортлогч нь санаа зовж буй импортын орны хүссэн хэмжээнд үнийг хангалттай түвшинд өсгөхийг зөвшөөрсөн тохиолдолд, демпингийн эсрэг үйл ажиллагааг түр зогсоож эсвэл цуцалж болно. Үнийн талаар хүлээсэн ийм үүрэг нь демпинг хийсний улмаас хүртэх байсан гэж үзэж байгаа ашгаас илүү хэтрэхгүй байх ёстой ба энэ нь дотоодын аж үйлдвэрт учруулах байсан аюулыг хангалттай хэмжээнд арилгах болно.</p> <p>Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), үүрэг багатай зарчим (бага татвар зарчим), худалдааны дарамт шахалтыг (trade harassment) үзнэ үү.</p>
1070	Price wedge	<p>Үнийн шаантаг (нэг ижил барааны хувьд худалдан авагчийн авсан үнэ болон борлуулагчийн зарсан үнэ хоёрын ялгаа). Энэ нь хамгаалалттай зах зээл дээрх бүтээгдэхүүний үнэ болон бүрэн өрсөлдөөнт [зах зээлийн] нөхцөлд бүрдсэн бүтээгдэхүүний үнэ хоёрын ялгааг хэлж байгаа юм.</p>
1071	Primage	<p>Тээврийн нэмэгдэл. Энэ нь импортын нэмэлт татварыг түр хугацаагаар ногдуулах, эсхүл гаалийн татварын хэвийн хэмжээг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэхүйц ижил төстэй арга хэмжээ авахыг илэрхийлсэн нэр томьёо.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1072	Primary products	<p>Анхдагч түүхий эд. (Түүхий эдийн бараа – Уругвай). Үүнийг ТХЕХ-ийн 16 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт (GATT Article XVI: 4) хэрэглэж болохуйц татаасны тогтолцооны зорилгоор: анхдагч түүхий эдийн бараа бүтээгдэхүүн гэдэг бол “олон улсын худалдаанд ихээхэн хэмжээгээр борлуулахад зориулан тусгай шаардлагын дагуу бэлтгэхийн тулд тийм боловсруулалт хийгдсэн, байгалийнхаа хэлбэрээр байгаа хөдөө аж ахуй, ой, загасны агнуурын түүхий эдийн бараа, аливаа эрдэс баялаг/ашигт малтмалын түүхий эдийн барааны ямар ч хэлбэртэй” байж болно хэмээн тодорхойлсон байдаг. Токиогийн үе шатны хэлэлцээний үр дүнгийн нэг хэсэг болсон, 1979 онд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6, 16 ба 23 дугаар зүйлүүдийг (Татаасны төрөлжүүлэн нэгтгэсэн хууль – the Subsidies Code) Тайлбарлаж ба хэрэглэх тухай хэлэлцээр батлагдах үед “эрдэс баялаг/ашигт малтмал”-ын тухай тайлбарыг хассан байна. Хэрэв түүхий эд материалыг байгалийнх нь төлөв байдалтайгаар экспортолж байгаа бол хэрэв татаас нь үндсэндээ боловсруулаагүй түүхий хөвөнд олгох байсан төлбөр хэлбэртэй байсан тохиолдолд, хөвөн давуун текстил (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүний экспортод зориулан татаас олгохыг зөвшөөрөх ёстой хэмээх АНУ-ын гаргасан зөвлөгөөг 1957 онд ТХЕХ-ийн гишүүн улс орнууд үл зөвшөөрсөн байна. Тэгээд, АНУ бүгдийг хуучнаараа тийнхүү үйлдэх өөрийн эрхээ хадгалж үлдсэн байдаг. Гоймонгийн тухай хэргийн (pasta case) хувьд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг, гоймон гэдэг нь анхдагч түүхий эдийн бүтээгдэхүүн бус, харин боловсруулсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болохыг олж тогтоожээ. Тухайн хэрэгт, маргаан үүсгэж байсан экспортын буцаан олголт нь үүнд ашиглаж байсан хатуу эрдэнэ шишийн (durum wheat) хувьд олгогдсон байсан талаар Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (European Economic Community) маргалдаж байлаа. Уг буцаан олголтод боловсруулалтад нь тусламж үзүүлэх замаар ямар нэгэн бүрэлдэхүүн хэсгийг хамааруулаагүй бөгөөд хатуу эрдэнэ шиш нь эргэлзээгүйгээр анхдагч түүхий бүтээгдэхүүн байсан юм хэмээн маргаж байв. Эдүгээ, ихэнх анхдагч түүхий эдийн бараанууд нь ДХБ-ын Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн дүрэм журмуудад (WTO Agreement on Agriculture) хамааралтай.</p>
1073	Principal supplier right	<p>Үндсэн ханган нийлүүлэгчийн эрх. Энэхүү эрх нь тариф ногддог тодорхой нэг зүйлийн хувьд худалдааны нөгөө нэг түнш орондоо хамгийн том ханган нийлүүлэгч орон болсон байр суурийнхаа ачаар олж авч чаддаг эрх бөгөөд үндсэн ханган нийлүүлэгчийн дүрмийн дагуу уг түншүүдээсээ тарифын хэлэлцээ хийх хүсэлт гаргах эрхтэй байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1074	Principal supplier rule	<p>Үндсэн ханган нийлүүлэгчийн дүрэм. (Үндсэн нийлүүлэгчийн дүрэм - Уругвай). Энэ нь голдуу хэлэлцээний үе шатны эхэн үед ашиглагддаг, Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) хүрээнд тарифын хэлэлцээг удирдаж байдаг системийн гол чухал шинж чанар нь. Энэхүү дүрмийн дагуу ТХЕХ-ийн тодорхой гишүүнд тарифын хөнгөлөлт үзүүлэх хүсэлтийг тухайн хэлцэж буй бараа бүтээгдэхүүний хувьд зөвхөн үндсэн ханган нийлүүлэгч л гаргаж болно. Уг дүрэм нь хөнгөлөлтийг үзүүлж байгаа тухайн улс үүнийхээ төлөө зөвхөн нэг удаа нөхөн төлбөр авах боломжтой байх бөгөөд хөнгөлөлт үзүүлэх талаар уригдсан тухайн улс нь хамгийн том ханган нийлүүлэгчтэй харьцах замаар өөрсдийн ашгаа нэмэгдүүлэх боломжтой гэсэн таамаглал дээр үндэслэсэн дүрэм. Түүнчлэн, өөр тохиолдолд өөрсдөд нь зориулаагүй уг ашгийг завшигчдыг (өөрөөр хэлбэл нөхөн төлбөр авах боломжтой) бууруулах зорилготой. Бодит байдал дээр, зөвхөн уг системд найдах нь жижиг болон хөгжиж буй орнуудыг хэлэлцээний үйл явцаас үр дүнтэйгээр хасахад хүргэсэн байдаг. Кеннедигийн үе шатны хэлэлцээ болон Токио дах үе шатны хэлэлцээн дэх тарифыг шугаман замаар бууруулах (linear tariff) арга, мөн түүнчлэн Мэдээллийн технологийн тухай хэлэлцээр (Information Technology Agreement) гэх мэт бүтээгдэхүүний өргөн хүрээг хамарсан ангиллын хүрээнд хэлэлцээ хийх практик арга туршлага нь, үндсэн ханган нийлүүлэгчийн дүрмийн ач холбогдлыг бууруулсан байна. Мөн хэлцээ хийх анхдагч эрх (initial negotiating rights), Үндсэн ханган нийлүүлэгчийн ашиг сонирхол (principal supplying interest), Салбарын хүрээний худалдааны хэлэлцээнүүдийг (sectoral trade negotiations) үзнэ үү.</p>
1075	Principal supplying interest	<p>Үндсэн ханган нийлүүлэлтийн ашиг сонирхол. (Үндсэн сонирхогч нийлүүлэгч - Уругвай). Энэ нь тухайн өгөгдсөн бүтээгдэхүүний хувьд экспортын ашиг сонирхлыг эрэмбэлэхэд тулгуурласан тодорхой бүтээгдэхүүний зүйлийн талаар тарифын хэлэлцээ хийхэд оролцох эрх. Үүнийг уг [ашиг сонирхлын] улмаас экспорт нь хамгийн их хувь хэмжээгээр нөлөөнд нь өртөөд байгаа ДХБ-ын гишүүн улс зохион байгуулдаг байна. Тэгэхээр энэ нь худалдааны урсгалын харьцангуй цар хэмжээнд тулгуурласан эрх байдаг байх нь. Үндсэн хэмжээнд ханган нийлүүлэх ашиг сонирхол нь, худалдааны урсгалын үнэмлэхүй хэмжээнд суурилсан үндсэн ханган нийлүүлэгчийн эрхээс ялгаатай юм. Энэ нь мөн хэлэлцээний замаар гишүүн нэг улсаас нөгөө улсдаа нийцүүлэн олгодог хэлэлцээ хийх анхдагч эрхтэй адилхан зүйл биш юм. Тухайн улсад үндсэн ханган нийлүүлэлтийн ашиг сонирхол байсан эсэхийг тодорхойлоход, ДХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь зөвхөн үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (MNF) дагуу арилжаалагдсан бүтээгдэхүүнүүдийг л харгалзан авч үзэж болох юм. Үндсэн ханган нийлүүлэлтийн ашиг сонирхол хэмээх ойлголтын нэг чухал зорилго бол жижиг болон жижиг дунд худалдаалагчдад тэдний хувьд нэн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүний талаар тарифын хэлэлцээг эхлүүлэх боломжийг олгох явдал юм. Мөн ихээхэн хэмжээгээр ханган нийлүүлэх ашиг сонирхлыг (substantial supplying interest) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1076	Prior informed consent	<p>Урьдчилан мэдэгдсэн зөвшөөрөл. Энэ нь эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болох эрсдэлээс болж үндэсний засгийн газраас хориглосон эсвэл хатуу хязгаарласан химийн бодис, пестицидийн худалдааг зохицуулах журам. Үүнийг Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн зүгээс (UNEP) хамтран хэрэгжүүлж байгаа. Уг процедур нь хориг, хязгаарлалтын талаар төв байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. Энэхүү мэдэгдлийг тарааж, бусад засгийн газрууд уг агентлагт ийм арга замаар жагсаасан химийн бодис, пестицидийг импортлохыг зөвшөөрсөн эсэх талаараа зөвлөгөө өгдөг байна. Экспортлогч улс орнууд эргээд эдгээр бодисыг импортлохыг зөвшөөрсөн улс орнуудад л экспортлох үүрэг хүлээдэг. Энэхүү процедур нь өөрөө химийн бодис ашиглахыг хориглох, хязгаарлах талаар өгч буй зөвлөмж биш юм. Мөн худалдаа ба байгаль орчныг (trade and environment) үзнэ үү.</p>
1077	Prisoner's Dilemma	<p>Шоронгийн хоригдлын дилемма (олон хүнд сонголтуудаас нэг сонголт хийх мухардмал байдал). Энэ нь илт ухаалаг, бодлоготойгоор гаргасан микро түвшний шийдвэрүүд нь ухаалаг, бодлоготойгоор гаргасан макро түвшний үр дүнд заавал хүргэдэггүй юм гэдгийг дүрслэн харуулсан нэг арга хэрэгсэл. Олон талт худалдааны системд хэрэгждэг хамтын үйл ажиллагааны ач тусыг тайлбарлахын тулд үүнийг тоглоомын онолд (математикийн ухааны дүн шинжилгээний нэгэн арга) ихэвчлэн ашигладаг. Олон хувилбартайгаар илэрдэг уг дилемма буюу мухардмал байдал нь дараах шинж чанаруудыг тоймлон гаргадаг. Хэдэн хоригдлуудад тус тусад нь байцаалт явуулах хэрэг гарлаа. Хэрэв бусдуудынх нь хэн нь ч гэм буруугаа хүлээхгүй юм бол үр дүнд нь бид бүгдээрээ эрх чөлөөтэй болно гэдгээ тус бүр нь мэдэж байдаг. Мөн хэрэв бусдынх нь хэн нь ч хэргээ хүлээгээгүй боловч, харин тэдний хэн нэг нь л гэм буруугаа хүлээсэн тохиолдолд, уг гэм буруугаа хүлээсэн нэг нь л эрх чөлөөтэй болно гэдгийг тэдний тус бүр нь бас мэдэж байдаг. Бусад бүх хоригдлуудад хүнд ял оноох болно. Хэрэв бүгд гэм буруугаа хүлээвэл тэд бүгд ял шийтгэл хүртэх боловч зөвхөн ганцхан нь л гэм буруугаа хүлээсэн хувилбараас арай хүнд бус ял шийтгэл хүртэх болно. Тэгэхээр хоригдол хувь хүн тус бүрийн гаргах илт ухаалаг шийдвэр бол бусдынхаа төлөө тийм ч их санаа зовж түвэг удалгүйгээр гэм буруугаа хүлээх явдал юм. Ёс суртахууны хувьд бол, хэрэв тэд бүгдээрээ ерөөсөө гэм буруугаа хүлээхгүй байхаар өөр хоорондоо тохиролцох боломжтой байсан бол гэдэг нөхцөлтэй харьцуулбал, тэд бүгд гэм буруугаа хүлээснээр илүү дордох байсан байдаг.</p>
1078	Prison labour	<p>Шоронгийн хөдөлмөр. ТХЕХ-ийн 20 (е) дугаар зүйл нь ДХБ-ын гишүүн орнуудыг, шоронгийн хөдөлмөрөөр хийсэн бараа, бүтээгдэхүүний импортод хязгаарлалт тогтоохыг зөвшөөрдөг. Олон улс орнууд ийм төрлийн бүтээгдэхүүнийг импортлохыг хориглосон хууль тогтоомжийг баталсан байдаг боловч хэрэгжүүлж байгаа цар хэмжээ нь харилцан адилгүй байна. Мөн Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ (стандартууд) (core labour standards), нийгмийн чанартай демпинг (social damping) үзнэ үү.</p>
1079	Private cartel	<p>Хувийн картель. Картелиг (cartel) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1080	Privatisation	Хувьчлал. Энэ нь урьд өмнө нь төрийн эзэмшилд, удирдлагад байсан төрийн өмчийг бүтцийн өөрчлөлт хийж, хувь нийлүүлсэн хөрөнгийг нь олон нийтэд санал болгосон, төрийн өмчит аж ахуйн нэгж болгох үйл явц. Зарим үед, засгийн газрууд хувьчлагдсан аж ахуйн нэгжийн зонхилох хувийг авч үлддэг байна. Мөн түүнчлэн, зарим тохиолдолд, хувьцааг нь нийтэд арилжих биржид бүртгэлтэй компанийг хувийн компани болгон хувиргах талаар тайлбарлахад ашигладаг нэр томьёо юм. Мөн төрийн зохицуулалтыг халах (deregulation) тухай үзнэ үү.
1081	Processes and production method	Үйлдвэрлэлийн боловсруулалт болон арга (Уругвай). Энэ нь худалдаа ба хүрээлэн буй орчинтой холбоотой хэлэлцүүлэгт ашигладаг нэр томьёо ба бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийн боловсруулалтын улмаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг авч үздэг байна. Үүнд, дараах үндсэн хоёр замаар сөрөг нөлөө нь илэрч болзошгүй: (a) бүтээгдэхүүнийг өөрийг нь хувиран өөрчлөх замаар болон (b) эцсийн бэлэн бүтээгдэхүүний шинж чанарт нөлөөлөхгүйгээр, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн боловсруулалтаар дамжуулах гэж байдаг.
1082	Process protectionism	Үйлдвэрлэлийн боловсруулалтыг хамгаалах үзэл баримтлал. Энэхүү нэр томьёог худалдааны хохирлыг арилгах арга хэмжээг ДХБ-ын тогтсон дүрмийн хүрээнд хэрэгжүүлэхээс илүү хялбархан хэрэглэхийг уриалж болох системийг тайлбарлахдаа И.М.Дестлер анх 1995 онд хэрэглэсэн.
1083	Proces-verbal	Протокол (Аман яриаг бичгээр боловсруулж тэмдэглэл хөтлөх). Энэ нь хуралдааны протокол бэлтгэх, санал нэгдсэн дүгнэлтийг тэмдэглэх, болон уулзалтын үеэр хийгдсэн хэлцлүүдийг бичгээр тайлбарлан бичих зэрэг болно.
1084	Producer subsidy equivalent	Үйлдвэрлэгчид олгосон татаасны тэнцэл (PSE). Энэ нь Хөдөө аж ахуйн хэлэлцээрт ашигладаг нэр томьёо. Засгийн газрын дэмжлэгийг арилгахын тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нарт нөхөн олговор олгох шаардлагатай болдог тэр татаасыг тодорхойлж байна. Үүнийг хувиар илэрхийлдэг бөгөөд энэ нь засгийн газрын бодлогын үр дүнд үйлдвэрлэгч нарт шилжүүлсэн нийт үнийн дүн болон үйлдвэрлэгчдийн нийт орлого хоёрын хоорондын харьцаа юм. Энэхүү харьцаа эерэг байсан тохиолдолд Үйлдвэрлэгчид олгосон татаасны тэнцэл нь үйлдвэрлэгч татаас авч байгааг илэрхийлдэг. Энэхүү харьцаа сөрөг байсан тохиолдолд, үйлдвэрлэгчээс татвар авдаг. Мөн Эцсийн хэрэглэгчид олгосон татаастай дүйцэхүйц хэмжээг (consumer subsidy equivalent) үзнэ үү.
1085	Product-by-product negotiations	Бүтээгдэхүүн тус бүрээр хэлэлцээ хийх. Мөн зүйл тус бүрээр тарифын хэлэлцээ хийхийг (item-by-item tariff negotiations) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1086	Product cycle theory	<p>Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол. Энэхүү онолыг Рэймонд Вернон (Raymond Vernon) 1966 онд санал болгов. Маш өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн улс орнууд хөрөнгө оруулалт, мэргэшсэн хүний нөөцийн хүртээмжийн хувьд илүү сайн байдаг тул шинэ бүтээгдэхүүн судлах, хөгжүүлэх талын харьцангуй давуу талыг эдэлж байдаг гэж мэдэгджээ. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг нь үйлчлүүлэгчдийн захиалгад чиглэсэн жижиг зах зээлд хийгдэж буй үйлдвэрлэлээс эхлээд хожим нь үндэстэн дамнасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны цар хүрээнд хүрч, зардал багатай улс орнуудад бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх оргил үедээ хүрсэн үеэсээ эхлээд, бүтээгдэхүүнээ анх хөгжиж гарч ирсэн орныхоо зах зээл рүү буцаагаад экспортолж эхэлдэг байна. Мөн Хеккер-Охлин теоремыг (Heckscher-Ohlin theorem) мөн үзнэ үү.</p>
1087	Profit-shifting tariff	<p>Ашиг шилжүүлэх тариф. Энэ нь экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцлийг хангаж баялаг бүрдүүлэхийг санал болгодог меркантизмын онолын нэг ойлголт бөгөөд тариф ногдуулах замаар гадаад улсаас өөрийн нутаг дэвсгэр лүү монопол түрээсийг шилжүүлэх боломжтой гэж үздэг. Нөгөө талаас нь харвал энэхүү тарифаар дамжуулан гадаадын компанийн хийж болох илүүдэл ашгийг авч байна. Эдийн засагчид ашиг шилжүүлэх тариф нь импортыг хязгаарлаж, экспортыг хөхиүлэн дэмжих меркантизмын бас нэгэн аргумент гэж тодорхойлжээ.</p>
1088	Progressive liberalisation	<p>Дэвшилтэт либералчилал. (Цаашдын чөлөөлөлт – Уругвай). Энэ нь олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн Пунта дель Эсте дах тунхаглалаас (Punta del Este Declaration) гарал үүсэлтэй. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATS) зааж өгсөн байдаг чухал зарчим. Үүнд ил тод байдал болон эдийн засгийн өсөлт нь үйлчилгээний худалдааны ирэх хэлэлцээнүүдэд зориулсан зорилтуудын нэг хэмээн тодорхойлсон байдаг. Гишүүдийг наад зах нь таван жил тутам хэлэлцээний дараагийн үе шатны хэлэлцүүлэгт орохыг шаарддаг GATS-ийн 19 дүгээр Зүйл ангид энэхүү зарчмыг шилжүүлсэн байдаг. Ийм яриа хэлэлцээний үе шатыг 2000 оны 1 дүгээр сард эхлүүлэх ёстой байлаа. Мөн ДХБ-ын Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөрийг (WTO built-in agenda) мөн үзнэ үү.</p>
1089	Prohibited subsidies	<p>Хориглосон татаас. Энэ нь ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт (WTO Agreement on Subsidies and Countervailing Measures) ашигладаг зарчим. ДХБ-ын гишүүн орнуудад энэ төрлийн татааснуудыг баталж, хэрэгжүүлэхгүй байх ёстой. Мөн эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаас (actionable subsidies), үндэсний/ дотоодын агуулгын дүрэм (local-content rules), эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаас (non-actionable subsidies), татаас (subsidies), Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Investment Measures) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1090	Prohibitive tariff	Хориотой тариф. Тарифын хувь хэмжээг маш өндөр хэмжээнд тавьсан тул энэ нь импортод давшгүй саад бэрхшээл учруулдаг байна. Мөн хамгаалалтын тарифыг (protective tariff) үзнэ үү.
1091	Proportionality	Тэнцүү чанар (Пропорциональ чанар). Энэ нь тухайн арга хэмжээний худалдааны зардлыг нь уг арга хэмжээний хувьд засгийн газрын бодлогын бусад талбарт өгсөн байж болох үр ашигтай нь харьцуулахад ашигладаг ойлголт. Үүний гол санаа нь тухайн нэг арга хэмжээний зардлын үр нөлөө ба үүний үр дүнд нь гарах магадлалтай үр ашиг хоёрын хооронд тодорхой оновчтой харилцаа холбоо байх ёстой гэсэн санаа юм. Энэ нь тухайн худалдааны арга хэмжээ байх шаардлагатай эсэхийг тодорхойлох нэг арга зам.
1092	Proprietary information	Өмчийн мэдээлэл (эд юмсын эрх зүйн мэдээлэл). Худалдааны нууцыг (trade secrets) үзнэ үү.
1093	Protection	Хамгаалалт. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчид ба тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн өрсөлдөөнөөс ямар цар хүрээнд хамгаалахыг тодорхойлсон нэр томьёо. Хамгаалалтын нөлөөлөл эсвэл зардлыг өндөр хэмжээнд нарийвчлалтайгаар хэмжиж эсвэл тооцоолж болно. Бараа бүтээгдэхүүний хувьд тариф нь эхлэлийн цэг байх боловч тарифын бус арга хэмжээг дагалдуулсан тариф, эсвэл хэрэв тухайн хамгаалалт нь бүхэлдээ тарифын бус арга хэмжээнээс бүрдсэн эсхүл үйлчилгээний салбарын хувьд засгийн газрын зохицуулалтаас бүрдсэн тохиолдолд асуудал илүү бэрхшээлтэй болж ирдэг байна. Мөн түүнчлэн, үйлчилгээний салбарыг хамгаалалтад авсны зардлыг тооцоолох аргууд байдаг боловч эдгээр нь бараа бүтээгдэхүүний зардлын тооцооллоос арай нарийвчлал муу байдаг байна. Хамгаалалт нь хамгаалалтын тухай онолоос харьцангуй их ялгаатай байдаг. Мөн тусламж (assistance), Засгийн газрын урамшуулал буюу татаас (bounty), хамгаалалтын үр дүнтэй түвшин (effective rate of protection), зах зээлийн олон улсад өрсөлдөх чадвар (international contestability of markets), хамгийн оновчтой тариф (optimal tariff) болон татаасыг (subsidy) үзнэ үү.
1094	Protectionism	Протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онол. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдийг олон улсын зах зээлийн хатуу чанга нөхцөл байдлын нөлөөнөөс хамгаалж сэргийлэхийн давуу талыг эрэлхийлсэн эдийн засгийн бодлого боловсруулалтын уур амьсгал. Үүнд хүрэх үндсэн арга бол тариф, татаас, сайн дурын хязгаарлалтын зохицуулалтууд, бусад тарифын бус арга хэмжээнүүд байх бөгөөд илт тодорхой бус арга хэмжээнүүдэд төвлөрсөн байх нь бий. Илүү нарийн төвөгтэй тохиолдлуудын хувьд соёлын, хүрээлэн буй орчны болон бусад ач холбогдолтой эргэлзээтэй зүйлсийг хамааруулж болзошгүй. Мөн, болзошгүй хамгаалалтыг маш идэвхтэйгээр ашиглах замаар хамгаалалтын тухай онолыг хөхиүлэн дэмжиж болно. Ихэнх тохиолдолд, хамгаалалтын онол нь үр ашиггүй үйлдвэрүүдийг зах зээлд зайлшгүй тохируулах үйл явцыг зүгээр л хойшлуулдаг байна. Мөн Соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанар (cultural identity), бүтцийн өөрчлөлтийн зохицуулалт (structural adjustment), болон худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment) зэргийг үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1095	Protection of fisheries resources	Загасны агнуурын нөөцийг хамгаалах. Май загас (herring) болон яргай загас (salmon), туна загас - 1982 оны Канад ба АНУ хоёр улс хоорондын маргаан (Canada-United States, 1982), 1994 оны Европын эдийн засгийн нийгэмлэг ба АНУ хоёрын хоорондын туна загасны талаарх маргаан (tuna, European Economic Community-United States, 1994) болон 1991 оны Мексик ба АНУ хоёр улс хоорондын туна загасны талаарх маргааныг (tuna, Mexico-United States, 1991) үзнэ үү.
1096	Protective tariff	Хамгаалалтын шинж чанартай тариф. Энэ нь гадаадын өрсөлдөөний бүрэн нөлөөллөөс үндэсний үйлдвэрлэлийн хүчин чадлыг хамгаалахад зориулсан тариф юм. Мөн хамгаалалт (protection) болон орлогын тарифыг (revenue tariff) үзнэ үү.
1097	Protocol of accession	Гишүүнээр нэгдэн орох тухай протокол. Энэ нь тухайн улс Дэлхийн худалдааны байгууллагад (WTO) эсхүл өөр зарим олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэх үед тавигддаг нөхцөл, болзлуудыг тогтоож өгсөн эрх зүйн акт. ДХБ-д эдгээр протоколуудыг өндөр хэмжээнд стандартчилсан байдаг боловч зарим үед элсэн орж буй тухайн орны тодорхой нөхцөл байдлыг тусгасан байх нь бий. Мөн нэгдэн орох/ гишүүнээр элсүүлэх (accession) тухай үзнэ үү.
1098	Protocol of Provisional Application	Түр мөрдөх протокол (PPA). Тийнхүү бүрмөсөн хийх шийдвэрийг хараахан эцэслэн шийдэлгүйгээр, уг хэлэлцээрийг түр хугацаагаар мөрдөж хэрэглэх зорилгоор 1947 онд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) анхдагч гишүүд үүнийг баталсан байдаг. Энэхүү шийдвэр нь хэзээ ч хэрэгжээгүй. Түр мөрдөх протокол нь 1994 онд батлагдсан ТХЕХ-ийн нэг хэсэг биш юм.
1099	Provisional anti-dumping duties	Демпингийн эсрэг түр татвар. Энэ нь демпингийн хэрэг байгаа нь илт тодорхой болсон үед ногдуулдаг гаалийн татвар болон хураамжууд. Демпингийн эсрэг арга хэмжээний тухай ДХБ-ын дүрэм журам нь засгийн газруудыг дараах гурван нөхцөлд Демпингийн эсрэг түр татвар ногдуулахыг зөвшөөрдөг. Үүнд: (a) зүй зохистой хянан магадлах ажиллагааг эхлүүлсэн байх, (b) демпинг болоод үр дагаварт нь дотоодын аж үйлдвэрт хохирол учруулсан нь урьдчилсан байдлаар тогтоогдсон бол, (c) хянан магадлах ажиллагааны явцад учруулж болох хохирлоос хамгаалахын тулд уг арга хэмжээг авах хэрэгтэй хэмээн эрх бүхий байгууллагууд үзсэн бол. Демпингийн эсрэг түр хугацааны татварын хэмжээ нь демпингийн ашгийн урьдчилан тооцоолсон дүнгээс илүү давж гарах ёсгүй. ДХБ-ын дүрэмд мөнгө эсвэл бондоор баталгаажсан үнэт цаас гаргахыг хүсэх нь илүү зохимжтой гэж онцлон заасан байдаг. Зарчмын хувьд Демпингийн эсрэг түр татварыг дөрвөн сараас илүүгүй хугацаагаар ногдуулах ёстой боловч зарим нөхцөл байдалд үүнийг есөн сар болтол сунгаж болдог.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1100	Provisional countervailing duties	<p>Татаасыг саармагжуулах буюу нөхөн тэгшитгэх түр хугацааны татвар. Тухайн нэг засгийн газар нь ДХБ-ын өөр нэгэн гишүүн улсыг татаас хэрэглэсэн байна гэж үзэж хянан магадлах ажиллагаа эхлүүлэнгүүтээ, Татаасыг саармагжуулах нөхөн тэгшитгэх татварыг тухайн татаас бүхий импортын бараанд түр хугацаагаар ногдуулж болох ба дараах 3 нөхцөлийг бүрэн хангасан байх ёстой. Үүнд: (а) хянан магадлах ажиллагааг дүрэм журмын дагуу эхлүүлсэн байх, (b) татаас олгосон байгаа болохыг урьдчилсан судалгаагаар тогтоосон ба энэ нь дотоодын аж үйлдвэрт хохирол учруулж байгаа бол, (c) хянан магадлах ажиллагааны үлдсэн хугацаанд татаас олголтыг явуулсаар байх тохиолдолд [дотоодын аж үйлдвэрт] цаашид хохирол учруулах магадлалтай гэсэн үзэлтэй байгаа бол. Уг татвар нь тус татаасны нийт дүнтэй тэнцэх мөнгөн хадгаламж эсвэл бондын хэлбэрээр байж болно. Түр хугацааны арга хэмжээг хянан магадлах ажиллагааг эхлүүлснээс хойш 60 өдрийн өмнө хэрэглэж болохгүй ба уг арга хэмжээ нь дөрвөн сараас илүү хугацаанд хүчин төгөлдөр байж болохгүй.</p>
1101	Provisional safeguard measures	<p>Хамгаалалтын тур арга хэмжээ (Уругвай). Дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл ноцтой хохирол учруулах аюул гарцаагүй бий болсон гэдэг нотолгоог урьдчилсан дүгнэлтээр тодорхойлсон, хамгаалалтын арга хэмжээг яаралтай хэрэглэхгүй байх нь дотоодын үйлдвэрлэлд дараа нь засаж залруулахад бэрхшээлтэй нөхцөл байдал үүсгэхүйц тохиолдолд импортлогч Гишүүн орон хамгаалалтын түр арга хэмжээг хэрэглэж болно (Уругвай). Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Safeguards) үзнэ үү.</p>
1102	Prudential regulation	<p>Эрсдэлээс сэргийлэх санхүүгийн зохицуулалт. [prudential measures - урьдчилан сэргийлэх арга хэмжээ – Уругвай] Энэ нь санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг болон санхүүгийн үйлчилгээ эрхлэгчдийг хамгаалах зорилготой засгийн газраас тогтоосон шаардлага, удирдамж. Эрсдэлээс сэргийлэх санхүүгийн зохицуулалт нь жишээлбэл банк болон даатгалын компаниудаас, тодорхой хөрөнгийн нөөц болон зайлшгүй шаардлагатай үндсэн хөрөнгийн хувь хэмжээг барьж ажиллахыг шаарддаг. Мөн тайлагнах хатуу шаардлага тавьдаг. Уг санаа нь тодорхой бөгөөд хэрэгжүүлж болохуйц эрсдэлээс сэргийлэх санхүүгийн зохицуулалтыг дэмжиж байдаг боловч энэ нь санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын зарим ихээхэн хэмжээний мөлжлөг эсвэл компанийн дампуурлуудаас урьдчилан сэргийлж чадаагүй байна. Эрсдэлээс сэргийлэх санхүүгийн хяналтын хамгийн оновчтой ямар түвшин байж болох талаар харилцан тохиролцсон хэлэлцээр байдаггүй байна. Санхүүгийн үйлчилгээний худалдаанд эрсдэлээс сэргийлэх санхүүгийн зохицуулалт нь саад бэрхшээл учруулдаггүй гэж үздэг тул, түүнийг зах зээлд нэвтрэх болон үндэсний нөхцөлд нөлөөлж болзошгүй арга хэмжээ гэж YXEX-т (GATS) бүртгүүлэх шаардлагагүй.</p>
1103	Public cartel	<p>Төрийн картель. Картелийг (cartel) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1104	Public international law	Олон улсын нийтийн эрх зүй. Энэхүү эрх зүй нь улс орнуудын хоорондын харилцаа, эсхүл улс орнууд ба олон улсын байгууллагуудын хоорондын харилцааг хамаардаг байна. Мөн (НҮБ-ын) Олон улсын шүүх (International Court of Justice) болон олон улсын хувийн эрх зүйг (private international law) үзнэ үү.
1105	Public procurement	Төрийн худалдан авалт. Мөн Засгийн газрын худалдан авалтыг (government procurement) үзнэ үү.
1106	Punta del Este Declaration	Пунта дель Эсте дах тунхаглал. Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн сайд нарын тунхаглал (Ministerial Declaration).
1107	Pure export cartel	Цэвэр экспортын картель. Картелиг (cartel) үзнэ үү.
1108	P-5	Номхон далайн 5 орны товчилсон нэршил (Pacific-5 or P-5). Үүнд Австрали, Чили, Шинэ Зеланд, Сингапур, АНУ багтдаг. 1999 онд Аукланд дах Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) үеэр Номхон Далайн 5 орон өөр хоорондоо чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг харгалзан авч үзэхийг Фред Бергстен зөвлөсөн байдаг байна.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1109	Quadrilaterals	<p>Дөрвөн талт хэлэлцээ. Анх үүнд АНУ, Европын хамтын нийгэмлэг, Япон болон Канад улс хоорондын худалдааны бодлогын талаар үе үе хэлэлцдэг байсан. Харин одоо бол энэхүү дөрвөн улсын хамтын ажиллагаанд хэрэглэгддэг.</p> <p>Товчхоноор Quad гэж нэрлэдэг. Мөн минилатерализм буюу цөөн тооны талуудын харилцааны онолыг (minilateralism) үзнэ үү.</p>
1110	Quantitative export restrictions	<p>Экспортын тоо хэмжээний хязгаарлалт. Экспортын квот (export quotas) болон сайн дурын хязгаарлалтын тохиролцоог (voluntary restraint arrangements) үзнэ үү.</p>
1111	Quantitative restrictions	<p>Тоо хэмжээний хязгаарлалт. (Тооны хязгаарлалт – Уругвай). Энэ нь тодорхой хугацаанд импортолж, экспортолж буй бараа бүтээгдэхүүний үнийн дүн болон тоо хэмжээнд тавьж буй хязгаар. Тодорхой заасан онцгой тохиолдолд, ялангуяа Эс хэрэглэх нийтлэг тохиолдлыг (general exceptions) хамарсан байдаг 20-р Зүйл ангид жагсаасан байдаг зүйлсийг багтаасан байдаг ТХЕХ-ийн 11 дүгээр зүйлийн [Тоо хэмжээний хязгаарлалтуудыг нийтэд нь цуцлах] (Article XI: General Elimination of Quantitative Restrictions) дагуу тоо хэмжээний хязгаарлалтыг хэрэглэхийг хориглодог байна. Мөн экспортын квот (export quota), импортын квот (import quota) болон Тоо хэмжээний хязгаарлалттай тариф (tariff quotas) үзнэ үү.</p>
1112	Quarantine measures	<p>Хорио цээрийн арга хэмжээ. Ургамал, мал, амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг (sanitary and phytosanitary measures) үзнэ үү.</p>
1113	Quint	<p>Квинт. Таван сайд нараас бүрэлдсэн бүлэг. Энэхүү баг нь Австрали, Канад, Япон улсын Хөдөө аж ахуйн сайд нар болон АНУ-ын Хөдөө аж ахуйн Төрийн нарийн бичгийн дарга, Европын Хөдөө аж ахуйн комиссар нараас бүрддэг. Энэ нь Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр байгуулагдсан бөгөөд өнөө цагт уг бүлгийн уулзалт нь ээлжит бус болон завсарлагатайгаар ховорхон уулздаг байна.</p>
1114	Quota-hopping	<p>Тоо хэмжээний хязгаарлалтын/Квотын харайлт.</p> <p>Энэ нь экспортын тоо хэмжээний хязгаарлалтаас хамаарч, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг квот олж авахад хязгаарлагдмал байдаг улс орноос, квотыг илүү хялбараар олж авах боломжтой улс руу шилжүүлэх явдал.</p> <p>Гарал үүслийн дүрмийг (rules of origin) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1115	QWERTY principle	<p>QWERTY зарчим (бичгийн машины товчлуур дээрх үсгийн стандарт байрлалын зарчим). Энэ нь хүлээн зөвшөөрсөн худалдааны бодлогын үзэл баримтлал биш боловч, ямар нэгэн шүүмжгүйгээр тогтсон санааг хүлээн зөвшөөрөхийн аюултай талыг дүрслэн харуулсан жишээ. Үүнийг анх 1982 онд эдийн засгийн түүхч Пол Дэвис (Paul Davis) санал болгосон бөгөөд 1990-ээд оны үед Пол Кругман (Paul Krugman) маш их сурталчилж байжээ. Энэ нь хамгийн анхны гар ажиллагаатай бичгийн машины түүхээс улбаатай үүссэн компьютерын гар буюу удирдлагын самбар дээрх үсгийн стандарт байрлалын зарчим буюу QWERTY-гээс энэ нь эхлэлийн цэгээ тавьсан байдаг. Сүүлийн хувилбарын хувьд шивэх нь хэтэрхий хурдан болох үед саатал гарах магадлалтай бөгөөд QWERTY зураглал нь бичээчийг удаашруулахад хүргэсэн байдаг (энэ нь үнэхээр тийм байсан уу гэдэг дээр маргаан байдаг гэдгийг анзаарах). Хожим нь үүссэн механик сайжруулалт нь QWERTY-ийн бүдүүвч схемийг шаардлагагүй болгосон боловч инерцийн сэтгэлгээ нь үүнийг компьютерын эринд тэсэж оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлжээ, учир нь энэ нь “өөрчлөгддөггүй, бат итгэл үнэмшилтэй” болж үлджээ. Кругманы тэмдэглэснээр бол үүнд зах зээл нь гуйвалтгүйгээр эдийн засгийг өвөрмөц шийдэлд хүргэдэг гэсэн ойлголтыг үгүйсгэхэд хүргэдэг бөгөөд үнэн хэрэгтээ зах зээлийн өрсөлдөөний үр дүн нь түүхэн санамсаргүй явдлаас шууд хамааралтай байдаг байна. Энэхүү зарчим нь удаан хугацаанд тогтсон байсан итгэл үнэмшил, зан үйлийн үнэн зөвийг судлах нь мөн чанартаа чухал ач холбогдолтой гэсэн санааг агуулдаг. Мөн уламжлалт мэргэн ухаан (conventional wisdom), арилж байгаа бодлыг (vestigial thought) үзнэ үү.</p>

---- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1116	Race-to-the-bottom argument	Ёроол руу уралдах тухай аргумент. Энэ нь хөдөлмөрийн зардал багатай, хөдөлмөрийн стандартаа доогуур барьж байгаа орнуудын импорттой өрсөлдөх шаардлага гарч байгаа нь өндөр хөгжсөн улс орнуудын цалин хөлс болон хөдөлмөрийн нөхцөл байдлыг бууруулах болно гэсэн айдастай байгааг илэрхийлсэн илэрхийлэл. Энэ нь нийгмийн тухай хуулийн заалт, худалдаа ба хөдөлмөрийн стандартыг хэлэлцэх үндэслэлийн нэг хэсгийг бүрдүүлж байна. Хүрээлэн байгаль орчны стандарт хэм хэмжээтэй холбоотой ижил төстэй мэтгэлцээн явагдсан бөгөөд үүнд зарим улс орнуудын байгаль орчны доогуур шаардлага нь тэдгээр улсуудад харьцангуй давуу талыг олгох боломжтой гэсэн бодол байдаг. Мөн хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээ (core labour standards), нийгмийн шинж чанартай демпинг (social dumping), худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment), Ялгавартай цалингийн тухай мэтгэлцээн (wage-differential argument), ажилчдын эрхийг (workers rights) үзнэ үү.
1117	Recidivist dumping	Демпингийн гэмт хэргийг давтан үйлдэх. Энэ нь ялангуяа Америкийн талын хэлэлцээ хийгчид, бүтээгдэхүүнээ демпинг хийсээр байгаа буюу асар хямд үнээр зах зээлд байнга нийлүүлсээр байгаа бөгөөд тэдний баталж байгаагаар бол демпинг хийх нь бизнес хийх гол арга гэж үздэг компаниудад зориулан заримдаа ашигладаг нэр томьёо. Мөн демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.
1118	Reciprocal free trade	Харилцан адил байх нөхцөлтэй чөлөөт худалдаа. Хариуд нь өөрсдийн зах зээлээ нээхэд бэлэн байгаа тэдгээр орнуудад л зориулж тухайн улс нь зах зээлээ либералчлах хэрэгтэй гэсэн санал. Өөрөөр хэлбэл, улс орнууд харилцан зах зээлээ нээх тухай зарчим. Энэ нь ихэвчлэн чөлөөт худалдаа гэж нэрлэгддэг нөхцөл байдалд заавал хүргэнэ гэсэн ямар ч далд утга агуулаагүй. Мөн харилцан адил байх (reciprocity) тухай үзнэ үү.
1119	Reciprocal free-trade area	Харилцан адил байх нөхцөл бүхий чөлөөт худалдааны бүс. Чөлөөт худалдааны бүсийг (free-trade-areas) үзнэ үү.
1120	Reciprocal Trade Agreements Program	Харилцан адил байх нөхцөл бүхий худалдааны хэлэлцээрийн хөтөлбөр. АНУ-ын харилцан адил байх нөхцөл бүхий худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийг (United States Reciprocal Trade Agreements Program) үзнэ үү.
1121	Reciprocity	Харилцан адил байх нөхцөл. Энэ нь ДХБ-ын мөрддөг практик арга туршлага боловч гэрээний шаардлага биш. Үүнд засгийн газрууд бие биедээ адилхан хөнгөлөлт (концесс) үзүүлэх, жишээ нь худалдааны түншийнх нь зүгээс ижил тэнцэхүйц хэмжээний хөнгөлөлтийг олгосных нь хариуд тухайн нэг засгийн газар импортод саад учруулж байсан тариф, эсхүл бусад саад тотгороо бууруулдаг байна. Үүнийг мөн өөрөөр хэлбэл буулт, хөнгөлөлтүүд буюу концессуудын тэнцэлд (balance of concessions) хүрэх гэж нэрлэдэг байна. Харилцан адил ашигтай худалдааны гэрээ байгуулсны үр дүнд байгуулагдсан энэхүү хөнгөлөлтийг Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөр (MNF) дамжуулан, ДХБ-ын бүх гишүүн улс орнуудад хүргэх ёстой болдог байна. Мөн толины тусгал мэт харилцан адил ашигтай байх нөхцөл (mirror-image reciprocity), ашгийн (үнэ ба өртгийн зөрүү ашиг) хувьд харилцан адил байх (reciprocity at the margin) тухай үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1122	Reciprocity at the margin	Ашгийн хувьд (үнэ ба өртгийн зөрүү ашиг) харилцан адил байх. Энэ нь Америк нэр томьёо бөгөөд худалдааны түншүүдэд санал болгосон тухайн хөнгөлөлтийн нийт үнийн дүн нь, эргээд түүний хариуд хүлээж авсан хөнгөлөлтийн үнийн дүнтэй ойролцоогоор тэнцэх ёстой гэсэн утга. Мөн Толины тусгал мэт харилцан адил байх нөхцөлийг (mirror-image reciprocity) үзнэ үү.
1123	Recognition	Хүлээн зөвшөөрөх. Энэ нь өөр нэг улсын чанарын баталгаажуулалт, стандарт хэм хэмжээ, эсвэл лиценз буюу тусгай зөвшөөрлийн шаардлагыг нөгөө нэг улс хүлээн зөвшөөрч буй үйлдлийг хэлнэ. Тийнхүү хүлээн зөвшөөрөх нь худалдаа хийхэд ихээхэн хэмжээгээр нөлөөлж болох юм. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) дагуу тийнхүү хүлээн зөвшөөрөх үйлдлийг нэг талын шийдвэрээр, харилцан хоёр талын, эсвэл харилцан уялдуулан нийцүүлсэн байдлаар хийж болно. Хэрэв тухайн нэг улс өөр нэг улсын зүгээс тавьж буй нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа бол үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (MFN) шаардах байсан шиг, энэ нөхцөлөө бусад улсуудад бас хүлээн зөвшөөрөх шаардлагагүй юм. Гэхдээ тухайн улс нь бусад улс орнуудад, тэд ч мөн тавьж буй тэдгээр шаардлагуудыг хангаж ажиллаж болно гэдгээ харуулах боломжийг нь олгох ёстой. Мөн Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (Agreement on Technical Barriers to Trade), стандартууд болон чанарын баталгаажуулалтыг уялдуулах (harmonization of standards and qualifications), харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг (mutual recognition arrangements) үзнэ үү.
1124	Re-exports	Буцаан экспортлох. Тухайн барааг түр хугацаагаар оруулж ирээд өөр гуравдагч улсын зах зээлд буцаан экспортлох үйл ажиллагаа. Зарим тохиолдолд бага хэмжээний нэмүү өртөг шингээгээд экспортлох тохиолдол байдаг. Мөн шилжүүлэн ачих боомт/хотын худалдаа (entrepot trade), чөлөөт худалдааны бүсийг (free-trade zones) үзнэ үү.
1125	Refusal to deal	Хэлцэл хийхээс татгалзах. Мөн Хориг арга хэмжээг (boycott) үзнэ үү.
1126	Regatta approach	Регатта арга/хандлага. Энэхүү нэр томьёог заримдаа Европын Хамтын нийгэмлэгийг өргөжүүлэх агуулгын хүрээнд ашигладаг. Энэхүү аргачлалын дагуу өргөдөл гаргагч бүх улс элсэн орох хэлэлцээрийг нэгэн зэрэг эхлүүлэх бөгөөд тохируулга хийхэд хамгийн бага бэрхшээлтэй улс орнууд барианы шугамд хамгийн түрүүнд хүрэх болно. Дараа нь тэдний хувьд бусад нь ижил тэгш ахиц дэвшил гаргахыг нь хүлээлгүйгээр хүлээн зөвшөөрөгдөх болно. Мөн 2000 оны Хөтөлбөрийг (Agenda 2000) үзнэ үү.
1127	Regionalism	Бүсчлэл. Энэ нь зарим үед чөлөөт худалдааны хэлэлцээр, эсхүл гаалийн холбоогоор дамжуулан бүс нутгийн түвшинд худалдааг либералчлах, эсхүл хөнгөвчлөхөөр засгийн газрын зүгээс авч буй үйл ажиллагаа. Ихэнх нь бүрэн хэмжээний олон талт үйл явцтай харьцуулахад оролцогч орнуудын эдийн засгуудад илүү хурдан арга замаар зорилгодоо хүрэх боломжийг санал болгодог тул, бүсчлэлийн онолыг олон талт харилцааны онолыг харилцан нөхөж өгдөг гэж хардаг байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Энэ нь заавал ийм байх албагүй юм. Ихэнх тохиолдолд үүсэж байдаг бүсийн түвшний либералчилалын илүү хурдтай гэж үздэг тэр хурд нь, зөвхөн олон талт харилцааны үр дүнд хүрэхийн тулд хэлэлцээ хийхэд нэлээд хугацаа шаардагддаг бодит баримттай холбоотой байдаг. Гэтэл үнэндээ, бүс нутгийн хэлэлцээ илүү хурдацтай явагддаг байдал нь, эмзэг бараа бүтээгдэхүүнийг (sensitive products) үе шаттайгаар нэвтрүүлэх өргөтгөсөн зохицуулалтын үр дүнд ихэвчлэн тэнцвэржиж ирдэг байна. Тиймээс, эцсийн зорилтот цэгт хүрэх цаг хугацааны ялгаа нь бодож байснаас бага байх магадлалтай. Мөн Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК), хаб энд спёукс буюу зангилаа төв ба салбарууд, энэ нь бусад онгоцны буудлуудаас ирэх ба очих нислэгүүдийг зохицуулахад зориулсан төв цэг болж үйлчилж буй томоохон нисэх онгоцны буудалд, нислэгийн хөдөлгөөнүүдийг чиглүүлж байхад зориулсан системтэй зүйрлэсэн худалдааны дүн шинжилгээний ойлголт (hubs and spokes), нээлттэй бүсчлэлийн онолыг (open regionalism) үзнэ үү.</p>
1128	Regional integration arrangement	<p>Бүс нутгийн түвшний интеграцчиллын зохицуулалт (RIA). Энэ нь бүс нутгийн түвшний худалдааны зохицуулалтад хүрэхээс илүү давж гарсан хоёр талт, эсхүл бүс нутгийн түвшний эдийн засгийн хэлэлцээр. RIA нь үндсэндээ жишээ нь, үндэсний олон төрлийн бодлогыг харилцан уялдуулах, эсхүл үүнтэй ижил үр дүнд хүрэхэд чиглэсэн бодлогыг батлах зэрэгт суурилсан, эдийн засгийн интеграцчиллын түвшинд хүрэхийг эрмэлздэг байна.</p>
1129	Regional trade arrangement	<p>Бүс нутгийн түвшний худалдааны зохицуулалт (RTA). Энэ нь хоёр, эсхүл түүнээс дээш улс орнуудаас бүрэлдсэн, чөлөөт худалдааны хэлэлцээр, гаалийн холбоо эсвэл нэгдсэн зах зээл (жишээ нь Австрали ба Шинэ Зеландын Эдийн засгийн харилцан ойлголцсон харилцаанд тулгуурласан худалдааны хэлэлцээр [ANZCERTA], Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр [NAFTA], буюу Европын хамтын нийгэмлэг [European Community]). Зарим шинжээчид, RTA-ыг илүү чөлөөтэй, үл ялгаварлан гадуурхах олон талт худалдааны тогтолцоог бий болгох бүтцийн элемент гэж үздэг бол, бусад нь үүнийг харин дордуулах зорилготой төлөөлөгч гэж үздэг байна. Түүхэн талаас нь авч үзвэл, хөгжиж буй орнуудын хооронд байгуулагдсан бүсийн түвшний худалдааны зохицуулалт нь анхны төлөвлөлтийн үе шатнаасаа цааш хэзээ ч гарч чадаагүй байдаг. Түүнчлэн, бусад нь ч бас үнэхээр ашиг тустай зохицуулалт болж өөрчлөгдөөгүй. Сүүлийн үеийн зарим зохицуулалтууд амжилт олох илүү магадлалтай. 1947 оноос өнөөг хүртэл, ТХЕХ-ийн 24 дүгээр зүйлийн дагуу [GATT under Article XXIV] (үндэсний нэн тааламжтай нөхцөлийг сунгах шаардлагаас хууль ёсоор чөлөөлөлдөгдөх эрхийг олгодог) 100 орчим бүсийн түвшний худалдааны зохицуулалтуудыг мэдэгдэж бүртгүүлсэн байна. Хөгжингүй орнуудын хувьд, талуудын хооронд хийгдэх бүхий л худалдааны хувьд, албан татвар болон арилжааны бусад хязгаарлалтын арга хэмжээнүүдийг нэлээд их хэмжээгээр арилгах ёстой.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Бүс нутгийн түвшний худалдааны зохицуулалтын талаарх өнөөгийн ТХЕХ-ийн дүрмүүд, үндсэн гурван дутагдлаас болж нэрвэгдэж байгаа тухай тоймчид онцгойлон тэмдэглэжээ. Нэгдүгээрт, тэд салбарын хүрээнд томоохон хэмжээнд чөлөөлөхийг зөвшөөрдөг. Хоёрдугаарт, тэд саарал бүсийн арга хэмжээ (grey-area measures), урьдчилан тооцоогүй хамгаалалт, гарал үүслийн дүрмээс (rules of origin) үүдэлтэй асуудлуудаас зайлсхийж, тойрч гардаг. Гуравдугаарт, тэд гарын үсэг зурсны дараа бүс нутгийн хэлэлцээрүүд болон хожим дүрэмд орсон аливаа нэг өөрчлөлт орсон байвал дагаж мөрдөж чаддаггүй байна. Дэлхийн худалдааны тогтолцоонд тэдний үзүүлэх цаашдын нөлөөг нягталж судлах зорилгоор, 1996 оны эхээр ДХБ нь, Бүс нутгийн түвшний худалдааны хэлэлцээрүүдийн хороог (Committee on Regional Trade Agreements) байгуулсан. Хөгжиж буй орнууд Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дагуу бүс нутгийн түвшний хэлэлцээрүүдийг байгуулж болох бөгөөд тэдний хувьд тариф болон тарифын бус арга хэмжээнүүдийг бууруулах буюу арилгах сонголт байдаг.</p> <p>Анхны бүсчилсэн үзэл баримтлалын онол (first regionalism), хаб энд спөүкс буюу зангилаа төв ба салбарууд, энэ нь бусад онгоцны буудлуудаас ирэх ба очих нислэгүүдийг зохицуулахад зориулсан төв цэг болж үйлчилж буй томоохон нисэх онгоцны буудалд, нислэгийн хөдөлгөөнүүдийг чиглүүлж байхад зориулсан системтэй зүйрлэсэн худалдааны дүн шинжилгээний ойлголт (hubs and spokes), хоёрдугаар бүс нутагт хуваах зарчим (second regionalism), болон үндсэндээ-бүх-худалдааны шалгуурыг (substantial-all-trade criterion) үзнэ үү.</p>
1130	Remissions	Багасгах (Уругвай). Хилийн татварын зохицуулалтуудыг (border tax adjustments) үзнэ үү.
1131	Renegotiation of tariffs	<p>Тарифын хэлэлцээг дахин хийх. Өнөө цагт, ихэнх тарифын хэлэлцээг олон талт худалдааны хэлэлцээний нэг хэсэг, эсхүл Мэдээллийн технологийн тухай хэлэлцээр гэх мэт (Information Technology Agreement) салбарын хүрээний хэлэлцээ хийх маягаар хийдэг болсон. Гэвч бусад үед ТХЕХ нь тарифын дахин хэлэлцээ хийх хэд хэдэн арга замыг тогтоосон байдаг байна. Олон улсын эдийн засгийн харилцааны хууль эрх зүйн асуудлууд (Legal Problems of International Economic Relations) хэмээх бүтээлдээ Жон Жэксон болон Уильям Дэйви нарын оруулсан жагсаалт нь нэн ялангуяа их ач тустай юм. Нэгдүгээрт, 28 дугаар зүйлийн 1-д: үндсэн ханган нийлүүлэгчийн сонирхол бүхий аливаа талууд эсвэл өмнө нь хоёр талт тарифын хэлэлцээтэй байсан талууд, гурван жил тутамд эдгээр хэлэлцээг дахин эхлүүлэхийг зөвшөөрдөг. Энэхүү гурван жилийн хугацаа нь анхнаасаа Ерөнхийлөгчийнхөө хэлэлцээ хийх эрхийг гурван жилд нэг удаа шинэчилдэг байсан АНУ-ын практик арга туршлагыг тусгасан байсан бөгөөд үүнийг үүрэг хүлээж, заавал биелүүлэх зарчмыг өөрчлөх боломжгүй хугацаа болгон баталсан юм. Хоёрдугаарт, 28 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт: талуудыг нөгөө талаасаа тусгай нөхцөл байдалтай холбоотой дахин хэлэлцээ хийх тухай хүсэлт гаргахыг зөвшөөрдөг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Эдгээр нь түргэн дүгнэлтэд хүргэх, цөөн тооны хэдэн зүйлд хязгаарлагддаг, жижиг хэмжээний хэлэлцээнүүд бөгөөд тэдгээр нь харьцангуй цөөн тооны анхдагч түүхий эдийн бараанд найдаж байдаг улс орнуудад эдийн засгаа төрөлжүүлэхэд туслах зорилготой юм. Гуравдугаарт, 26 дугаар зүйлийн 5 дугаар хэсэгт: урьдчилан захиалсан дахин хэлэлцээ хийх талаар урьдчилан тооцоолж авч үздэг. Энэ нь талууд дараагийн гурван жилийн хугацаанд, тарифын жагсаалтаа өөрчлөх эрхээ хадгалж үлдэх болон [авсан арга хэмжээнийх нь] нөлөөлөлд өртсөн талуудад нөхөн олговор олгох үүрэг хариуцлагаа энгийн ёс журмын дагуу хадгалан авч үлдэх боломжтой гэсэн үг юм. Дөрөвдүгээрт, хоёр ба түүнээс дээш тооны улс орнууд гаалийн холбоог (customs union) үүсгэн байгуулахаар тохиролцсон тохиолдолд, оролцогч гишүүдийн тарифын жагсаалтынх нь нэг хэсэг болоход хүргэсэн, нэгдсэн гадаад тарифыг нь өөрчлөх шаардлагатай болдог. Тиймээс 24 дүгээр зүйлийн 6 дугаар хэсэгт заасны дагуу тарифыг дахин хэлэлцэх нь, гаалийн холбооны гишүүн орнуудын тарифын нийт түвшин нь хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа тусдаа тарифын хэмжээнээс хэтрэхгүй байх шаардлагатай юм. Тавдугаарт, хөгжиж буй орнууд, 18 дугаар зүйлийн 7 дугаар хэсгийн дагуу, тодорхой заасан нөхцөлд, хөгжлийн анхан шатанд яваа эмзэг аж үйлдвэрийн салбараа (infant industry) хөхиүлэн дэмжих ажлынхаа нэг хэсэг болгож, тарифын жагсаалтаа өөрчлөх эрхтэй. Зургаадугаар, 27 дугаар зүйл нь ТХЕХ-ийн гишүүн болоогүй эсвэл гишүүн байхаа больсон улс оронтой хэлэлцсэн тарифын хөнгөлөлтөө өөрчлөх эрхийг талуудад олгодог. Долдугаарт, мөн тодорхой алдаа гарсан байсан тохиолдолд бага зэргийн техникийн засвар хэлбэрээр тарифыг дахин хэлэлцэх боломжтой юм. ТХЕХ-ийн гишүүд, ийм техникийн өөрчлөлтүүдийг хийхдээ, бусад орнууд нөхөн олговор олгоход хүргэсэн байдалтай, далдуур тарифыг ихээхэн хэмжээгээр өсгөхөд хүргэхгүй байхын тулд, маш болгоомжтой ханддаг байна. Мөн тарифын хэлэлцээ хийх (tariff negotiations) тухай үзнэ үү.</p>
1132	Repeat dumping	<p>Давтан демпинг хийх Мөн давтан демпингийн гэмт хэрэг үйлдэгчийг (recidivist dumping) үзнэ үү.</p>
1133	Requests and offers	<p>Хүсэлт ба санал болгох. Энэ нь одоо байгаа гишүүдийн хүсэлтээр хязгаарлагдаж байдаг ДХБ-д элсэх тухай хэлэлцээнээс бусад тохиолдолд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний салбарын хувьд зах зээлд нэвтрэх тухай ДХБ-ын хүрээнд болдог хэлэлцээг ихэвчлэн хоёр талт харилцааны хүрээнд гаргасан хүсэлт болон саналын үндсэн дээр явагддаг. Жишээ нь, ЧХХ-ийн нэг тал нөгөө талдаа манай улсаас гарал үүсэлтэй барааны гаалийн тарифыг ийм байдлаар бууруулж өгнө үү гэсэн хүсэлт, харин танай улсаас гарал үүсэлтэй барааны гаалийн тарифыг ийм хэмжээнд бууруулах боломжтой гэсэн саналыг харилцан гаргаж хэлэлцдэг. Худалдаалж буй тухайн бараа бүтээгдэхүүнийг хамгийн их хэмжээгээр сонирхож буй улс орнуудаас ихэвчлэн хүсэлт гардаг. Хүсэлтийн дагуу эсвэл нэгэн зэрэг хариу үйлдэл хийх замаар хариу санал болгож болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Хэрэв хоёр тал зах зээлд шинээр нэвтрэх цар хүрээнд [хөнгөлөлт] өгч ба хүлээн зөвшөөрөхийг хүсэж байгаа тохиолдолд хэлэлцээрт хүрсэн үед, уг үр дүнг ДХБ-ын бусад бүх гишүүдэд үндэсний нэн тааламжтай (most-favoured-nation) нөхцөлөөр олгох ёстой. Мөн Анхдагч ялгаатай байдалтай холбогдолтой хэлэлцээ (first-difference negotiations), Хэлэлцээ хийх анхдагч эрх (initial negotiating rights), үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured-nation treatment), үндсэн ханган нийлүүлэгчийн эрх (principal supplier rights), болон Үндсэн ханган нийлүүлэгчийн ашиг сонирхлыг (principal supplying interest) үзнэ үү.
1134	Re-regulation	Төрийн зохицуулалтыг дахин нэвтрүүлэх. Энэ нь тухайн аж үйлдвэрийн салбарын төрийн зохицуулалтыг халах үйл ажиллагааны нэг хэсэг болсон, эрх зүйн зохицуулалтын шинэ бүтэц хамрах хүрээний хууль тогтоомж буюу төрөлжүүлэн нэгтгэсэн хууль, кодекс. Энэ нь анх харахад зөрчилдөөнтэй мэт санагдаж болох ч өрсөлдөөн гэдэг нь төрийн зохицуулалтыг халсан зах зээлийн жинхэнэ шинж чанар байх нөхцөлийг хангах зорилготой. Төрийн зохицуулалтыг халах (deregulation) нь үйлчилгээ үзүүлэгч нарын монопол үүргийг багасгадаг хэдий ч энэ нь одоо бусдад нээлттэй болсон зах зээлд тэднийг чухал тоглогч хэвээр үлдээх чиг хандлагатай байдаг. Учир нь, өмнөх монопол үүрэгтэй байсан нэгнүүд нь маш тухтай сайн нуугдсан байдаг тул тэд нарт бодит монополийг (de-facto monopoly) хадгалан авч үлдэх хангалттай хэмжээний давамгайл байдал байдаг байж болох юм. Тиймээс, магадгүй өмнөх монопол нь зах зээлд тогтоосон эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахгүй байх мөн шинээр [зах зээлд] нэвтрэх оролцогчдын хувьд амьдрах чадвараа тогтооход нь зохих боломжийг олгох нөхцөлийг хангахын тулд, өрсөлдөөний тухай шинэ хуулийг батлах шаардлагатай болж болзошгүй юм.
1135	Resentment, inefficiency, bureaucracy, and stupid signals	Дургүйцэл, үр ашиггүй байдал, хүнд суртал, болон тэнэг дохионууд. Энэ нь Майкл Ахогийн тодорхойлсноор хэд хэдэн цуврал бус нутгийн худалдааны блокууд (regional trade blocs) гарч ирэхэд зориулсан бүрэлдэхүүн хэсгүүд нь юм.
1136	Reserved negotiations	Урьдчилан захиалсан хэлэлцээ. Тарифын давтан хэлэлцээ хийхийг (renegotiations of tariffs) үзнэ үү.
1137	Residual quantitative restrictions	Үлдэгдэл тоо хэмжээний хязгаарлалт. Энэ нь гадаад валютын нөөцийг (foreign exchnage reserve) хамгаалахад чиглэсэн тоо хэмжээний хязгаарлалтыг ерөнхийдөө хэлдэг боловч эдгээр саад бэрхшээл арилсны дараа нь ч гэсэн хэрэгжүүлсэн хэвээр байдаг байна.
1138	Resources diplomacy	Байгалийн нөөцийн дипломат үйл ажил. Энэ нь Засгийн газар түүхий эд материал болон түүхий эдийн зах зээлд нэвтрэх боломжийг хангах уг арга хэлбэрийг авч үздэг боловч энэхүү нэр томьёо 1970-аад оны үед онцгой утгатай болж ирсэн. Түүхий эд, боловсруулсан материалыг зах зээлийн боломжийн үнээр найдвартай олж авах боломжтой байх нь тухайн аж үйлдвэрлэлийн бааз нь хөгжиж байгаа эсвэл аль хэдийн өндөр хөгжлийн шатандаа байгаагаас үл хамааран, аж үйлдвэрлэлийн

бааз суурь бүхий бүх улс орнуудын зорилгуудынх нь нэг юм. Хариуд нь түүхий эд үйлдвэрлэгч, боловсруулагчдын бодлогын зорилтуудын нэг нь зах зээлүүдэд нээлттэйгээр, үл ялгаварлах нөхцөлийн хүрээнд нэвтрэх явдал байдаг бөгөөд үүнийг ерөнхийдөө орлого ашигтай үнэ гэж нэрлэх нь бий. Үйлдвэрлэгчид болон хэрэглэгчид ихэнхдээ эдгээр хоёр зорилгын зүй тогтлын талаар санал нийлж байдаг боловч нарийн ширийн зүйл дээр хааяа нэг санал зөрөлдөөн гарч байдаг. Иймд хоёр бүлэг бүхэлдээ нийт зорилгодоо хүрэхийн тулд зах зээлд гарахад бэлэн байдаг. Тэд, зарим нөөц баялагт нөлөөлөх хүчний хувьд бараг ямар ч хязгаарлалт байдаггүй бол бусад зарим тохиолдолд олон улсын эрх зүйн зохицуулалтууд болон [улс орнуудын] үндэсний бодлогуудын улмаас үүддэг [зах зээлийн] гажуудлын улмаас хязгаарлагддаг болохыг хүлээн зөвшөөрдөг. Нөөц баялгийн зах зээлийн хувьд маш хэлбэлзэлтэй байж болно. Тиймээс компаниуд өрсөлдөөний байр сууриа форвард (forward) нөхцөлөөр худалдаж авах, худалдах болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан сайжруулахыг хичээдэг. Засгийн газрын бодлогыг худалдаа арилжааны практиктай хослуулсан энэхүү тогтолцоо ихэнх тохиолдолд сайн ажилладаг боловч энэ талбар нь нөөц баялгийн дипломат үйл ажлын тухай ойлголтыг бий болгосон 1970-аад оны үед үүссэн улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын харьцуулалтын дүнд хямарч болох байв. Мэдээжийн хэрэг, нөөц баялгийн дипломат үзэл санаа нь ямар нэгэн шинэ зүйл байсан гэж үзэх ёсгүй. Түүхий эд материалын хүртээмжийг Үндэстний лигийн гэрээ, хэлцэлд гол самбар нь болгож оруулах ёстой гэсэн зөвлөмжүүд ч байсан. Дэлхийн II Дайн дэгдэн гарахад түүхий эд, материалын хүртээмжийн төлөө өрсөлдөөн томоохон үүрэг гүйцэтгэсэн гэдэг тал дээр холбоотон улс орнууд хоорондоо санал нэгтэй байдаг. Үүнтэй уялдуулан Атлантын дүрэм нь дэлхийн худалдаа, түүхий эдийн хүртээмжийн хувьд тэгш нөхцөлөөр хандахыг уриалав. Солонгосын дайн түүхий эдийн түр зуурын хомсдолд хүргэсэн боловч нөхцөл байдал эргээд хивэндээ ирэхэд сэтгэл зовоосон асуудлууд алга болох шиг болов. Нөөц баялгийн дипломат үйл ажил нь тухайн үед бараг хорин жилийн туршид олон улсын хувьд харьцангуй арай бага хэмжээний асуудлуудын нэг байв. Хэд хэдэн хүчин зүйлүүдийн нэгдэх үйл явцын дүнд нөхцөл байдал гэнэт өөрчлөгдсөн. Нэгдүгээрт, 1972-1974 онуудад дэлхийн эдийн засгийн огцом өсөлт түүхий эдийн түр зуурын хомсдолд хүргэв. Хоёрдугаарт, шинээр тусгаар тогтносон ихэнх улсуудын хувьд, зарим нь ч мэдээж тэр хэвээрээ байгаа, ихэвчлэн боловсруулагдаагүй түүхий эдээс экспортлох орлогоос ихээхэн хамааралтай байв. Эдгээр нь эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэхийг эрмэлзэж байв. Шинээр тусгаар тогтносон эдгээр орнуудын хувьд ихэнх тохиолдолд хуучин Европын колони улсууд байсан бөгөөд хуучны мастеруудын хувьд үйл ажиллагаа нь тогтворжсон худалдааны урсгал нь улс төрийн бодлогын нөхцөл байдлууд өөрчлөгдөхөд дагаж их хэмжээгээр өөрчлөгдөөгүй байсан учраас ханган нийлүүлэлтийн хувьд тухайн цар хүрээнд илүү баталгаатай санагдсан нөхцөл байдал байжээ.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Гуравдугаарт, эдгээр хөгжиж буй орнууд НҮБ-д гишүүнээр элссэнээр тэд одоо янз бүрийн байгууллагуудад олонх болж чадаж байна гэсэн үг юм. 1964 онд 77-ийн бүлэг байгуулагдсанаар улс төрийн нийтлэг тавцан бий болоход хүргэсэн боловч туршлагаас харахад эдийн засгийн бодит байдал нь төвөөс зугтах хүчийг үргэлж ашигласан байдаг. Хөгжиж буй орнуудын илүү радикал байдал нь 77-ийн бүлгийн гишүүдийн эв нэгдлийг дэмжих илүү нийтлэг хүсэл эрмэлзлээс ашиг хүртэв. Байгалийн нөөцийн дипломат үйл ажлын энэхүү хууч тэмцлийн эрч хүч 1976 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Худалдаа хөгжлийн бага хурлын 4-р хурлаар Түүхий эд, материалын нийтийн/хамтын сан (Common Fund for Commodities), Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөрийг (Integrated Programme for Commodities) хэрэгжүүлж эхлүүлэх үе хүртэл оршин тогтнож байсан боловч эдгээрийн хүрээнд хийгдэж байсан үйл ажиллагаа нь удаашралтай байв. Мөн Түүхий эд, материалын бодлогыг (commodity policy) үзнэ үү.</p>
1139	Restrictive business practices	<p>Бизнесийг хязгаарласан үйл ажиллагаа (RBPs). Өрсөлдөөний тухай үндэсний хууль, бодлогын хүрээнд авч үздэг хувийн хэвшлийн салбарын тодорхой төрлийн аж ахуйн нэгжийн өрсөлдөөний эсрэг зан үйл. Үүнд, хуйвалдаан, давамгайлсан байр сууриа урвуулан ашиглах, хэлэлцээрээс татгалзах, үнийн ялгаварлан гадуурхал, борлуулалтын үнийг хөдөлгөөнгүй барих, онцгой наймаа, босоо болон хэвтээ зохицуулалт гэх зэргийг хамруулдаг байна. RBPs гэж юу болох, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт гэж байдаггүй. 1980 онд НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) нь Олон талт түвшинд хүлээн зөвшөөрсөн эрх тэгш байдлын багц зарчим, Бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг хянах журмыг баталсан боловч, хуулиар үүрэг хүлээн заавал биелүүлэх үүрэг амлалтуудыг агуулдаггүй болно. Энэ чиглэлээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) хүрээнд нэлээд ажил хийжээ. Мөн Монополын эсрэг(antitrust laws), Бизнесийг хязгаарласан үйл ажиллагааны талаарх зөвлөгөөний зохицуулалт (Arrangements for Consultations on Restrictive Business Practices), өрсөлдөөний бодлого (competition policy), худалдаа ба өрсөлдөөнийг (trade and competition) үзнэ үү.</p>
1140	Retaliation	<p>Хариу арга хэмжээ. Энэ нь тухайн улс орон өөрийнх нь экспортод ногдуулах тарифаа нэмэгдүүлсэн, эсхүл экспортод нь сөргөөр нөлөөлөх бусад арга хэмжээг ногдуулсан улс орны импортод хязгаарлалт тавихын тулд авсан арга хэмжээ. Хариу арга хэмжээ авахын тулд ДХБ-ын маргааныг шийдвэрлэх бүхий л арга замыг бүрэн ашиглахыг шаарддаг хатуу дүрэм журам байдаг, гэвч заримдаа улс орнууд үүнээс гадуур үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн, АНУ-ын 301-р хэсгийн (Section 301) дагуу хариу арга хэмжээ авч болдог байна. Мөн солбицсон хариу арга хэмжээг (cross-retaliation) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1141	Retaliatory tariff	Хариу арга хэмжээ авсан тариф. Энэ нь ихэвчлэн бусад орнууд тарифаа өсгөсний эсрэг тэмцэхэд чиглэдэг бөгөөд ихэнхдээ маш өндөр буюу шийтгэлийн хэмжээнд байдаг байна. Засгийн газрууд хариу тариф ногдуулснаар үндэсний ашиг сонирхлыг (national interest) хамгаалсан гэдэгтээ сэтгэл ханамжтай санагдаж магадгүй ч, яг бодит байдал дээр тэд мөн дотоодын үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийн зардлыг адилхан өсгөсөн байж таардаг. Мөн гуйлгачин хөршийн бодлогуудыг (beggar-thy-neighbour policies) үзнэ үү.
1142	Revealed comparative advantage	Илрүүлсэн харьцангуй давуу тал. Харьцангуй давуу талыг (comparative advantage) үзнэ үү.
1143	Revenue tariff	Төсвийн орлого бүрдүүлэх тариф. Энэ нь засгийн газрын тогтвортой орлогын урсгалыг бий болгоход чиглэсэн, хамгаалалтын үүрэг хамгийн багатай тариф. Зарим хөгжиж буй орнуудын засгийн газрын хувьд тариф нь орлогын үндсэн эх үүсвэр байдаг тул, тэд хэрэв өөр орлогын эх үүсвэрийг тодорхойлохгүй л юм бол тэд тарифыг бууруулахыг хүсэхгүй байх магадлалтай. Мөн ашиггүй тарифыг (чирэгдэл болсон хэт бага тариф) (nuisance tariff) үзнэ үү.
1144	Reverse engineering	Урвуу инженерчлэл. Бүтээгдэхүүнийг дуурайн хуулбарлах замаар технологийн хүчин чадлыг олж авах тухай зөрчилдөөнтэй ойлголт бөгөөд ерөнхийдөө бүтээгдэхүүнийг хэсэг хэсгээр нь задлаад, хэрхэн ажилладаг бүтцийг нь мэдэж авахын тулд ашигладаг байна. Ийм аргын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн нь оюуны өмчийн эрхийн зөрчил үүсгэх ёсгүй байдаг. Мөн эмхэтгэсэн статистик тоон мэдээллийг задлан гаргах (decompilation) үзнэ үү.
1145	Reverse fast-track	Урвуу түргэвчилсэн шийдвэр. АНУ-ын конгресс зөвхөн хурдавчилсан арга шийдлийг хуульчлан тогтоох боломжтой байх ёстойгоос гадна, хурдавчилсан арга шийдлийг бүхлээр нь эсвэл тодорхой нэг хэлэлцээтэй холбоотойгоор эргүүлэн татах боломжтой байх ёстой талаар сенатор Макс Баукус 2000 оны 7 дугаар сард санал гаргасан байна. Мөн Худалдааг сурталчлан дэмжих эрх бүхий байгууллагыг (Trade Promotion Authority) үзнэ үү.
1146	Reverse notification	Хариу мэдэгдэл - Уругвай. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATT) ил тод байдлыг бий болгох энгийн арга бол, засгийн газруудыг авч хэрэгжүүлж байгаа худалдааны арга хэмжээгээ, эсхүл авах гэж буй арга хэмжээнүүдийнхээ талаар бусад гишүүн улс орнууддаа мэдэгдэх үүрэгтэй байдаг. Токио дах үе шатны хэлэлцээрийн (Tokyo Round) эцэст, бусдын авсан арга хэмжээний талаар засгийн газраас гаргасан мэдэгдэлд (өөрөөр хэлбэл хариу мэдэгдлээр дамжуулан) үндэслэн ТХЕХ-ийн нарийн бичгийн дарга нарын газар дотроо мэдээллийн сан байгуулагдах үед, өөр арга барилыг баталсан. Мөн мэдэгдлийг (notification) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1147	Reverse preferences	Урвуу хөнгөлөлт. Энэ нь хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнуудад олгосон хөнгөлөлт. Ийм хөнгөлөлт нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (European Economic Community) болон хөгжиж буй орнуудын хооронд байгуулсан [ЕХ-нд] Нэгдэх тухай гэрээнүүдийн (Association Agreements) нэг хэсэг байсан боловч гэрээнд тулгуурласан урвуу хөнгөлөлт одоо оршин байдаг эсэх тал дээр эргэлзээ байдаг байна. Мөн Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP), Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн системийг (GSTP) үзнэ үү.
1148	Reverse special and differential treatment	Урвуу Тусгай болон ялгавартай нөхцөл. Энэ нь хөгжиж буй орнууд хөдөлмөрийн болон хүрээлэн буй орчны хамгийн наад захын стандартын хэм хэмжээг хангах арга хэмжээнүүдийг нэвтрүүлэх ёстой гэсэн төлөвлөгөөний төслийг тайлбарлахын тулд Жагдиш Бхагватигийн боловсруулсан нэр томьёо. Гол санаа нь энэ нь тэдний зардлыг, эдгээр стандартуудыг угаасаа аль хэдийнээ мөрдөж ажиллаж байгаа хөгжингүй орнуудын гаргаж буй зардалтай илүү бодит харьцаатай болгох явдал. Мөн Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ (стандартууд) (core labour standards), худалдаа ба хүрээлэн буй орчныг (trade and environment) үзнэ үү.
1149	Reverse transfer of technology	Урвуу Технологи дамжуулалт. Энэ нь хөгжиж буй орнуудаас эрдэмтэд болон өндөр боловсролтой мэргэжилтнүүд өндөр хөгжилтэй орнууд руу чиглэж буй урсгалыг тайлбарлахын тулд ялангуяа НҮБ-ын системд ашиглагддаг нэр томьёо. Үүнийг оюуны чадамжийг нь хоослон сорох буюу өндөр боловсролтой хүмүүсийн гадагшаа чиглэсэн урсгал (brain drain) гэж нэрлэдэг. Уг сэдвээр маш олон уулзалтууд болж өнгөрсөн ч түүний учир шалтгаан эсвэл хохирлыг нөхөн төлөх арга хэмжээний алинд нь ч хэлэлцээрт хүрч чадаагүй байна. Хүлээн авагч хөгжингүй орнууд нь ямар нэгэн хэлбэрээр нөхөн төлбөр өгөх шаардлагатай гэж хөгжиж буй орнуудаас тавьсан санал нь улмаар хоосон хоцорсон байна.
1150	Revised Recommendation Concerning Cooperation Between Member Countries on Restrictive Business Practices Affecting International Trade	Олон улсын худалдаанд нөлөөлөхүйц бизнесийг хязгаарласан үйл ажиллагааны талаарх гишүүн улс орнуудын хоорондын хамтын ажиллагааны хянан засварласан зөвлөмж. Энэ нь 1967 онд анх батлагдсан зөвлөмж дээр үндэслэсэн буюу үүнээс хойш хэд хэдэн удаа шинэчлэгдсэн ба 1995 онд батлагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын эрх зүйн акт (OECD instrument). Энэ нь гишүүдийн хоорондын хамтын ажиллагааг дараах зарчмын дагуу дэмждэг, үүнд: (a) бусад гишүүн орнуудын компаниуд оролцсон тохиолдолд хязгаарлалт тавих тухай мэдэгдэл болон хүсэлт гаргах, (b) тухайн нэг компанийн эсрэг нэгээс илүү олон гишүүн улс орнууд арга хэмжээ авсан тохиолдолд зохицуулах хэрэг гарах, (c) зарим тохиолдлуудад арга хэмжээ авахыг хүсэж гишүүн улс орны зүгээс гаргасан мэдэгдэл гарсан тохиолдолд, (d) эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах. Энэхүү зөвлөмж нь хуулиар үүрэг хүлээж, заавал биелүүлэх шаардлагатай зүйл биш юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Мөн сөрөг нийгэмлэг ба найрсаг ёс буюу янз бүрийн улс эрх ба зан заншлаа харилцан хүлээн зөвшөөрөх ёс (negative comity), эерэг нийгэмлэг ба найрсаг ёс, янз бүрийн улс эрх ба зан заншлаа харилцан хүлээн зөвшөөрөх ёс (positive comity), бизнесийг хязгаарласан арга ажиллагааг (restrictive business practices) үзнэ үү.</p>
1151	Right of non-establishment	<p>Худалдааны бие төлөөлөл/төлөөлөгчийн газрын үүсгэн байгуулахгүй байх эрх. Энэ нь өөр улс оронд бизнес эрхлэхдээ тэнд байнгын үйл ажиллагаатай байгууллага үүсгэн байгуулах шаардлагагүй байх эрх.</p>
1152	Right of priority	<p>Давамгайлах эрх. Парисийн конвенцийн (Paris Convention) гарын үсэг зурсан талуудад олгосон эрх. Энэ нь нэг улсад патент авах хүсэлт гаргаж буй этгээд нэг жилийн хугацаанд өөр улсад мөн яг ижил шинэ зохион бүтээлтийн хүсэлт гаргах давамгайлах эрхтэй гэсэн үг. Бодит байдал дээр, энэ нь тухайн компани эх орондоо патент авах хүсэлт гаргасныхаа дараа нь, мөн ижил уг патентыг өөр нэгэн улсад авах хүсэлт гаргасан тохиолдолд, гадаадад гаргасан уг өргөдлийн огнооноос илүүтэйгээр эх орондоо гаргасан өргөдлийн огнооноос эхлэн уг патент нь хамгаалагдах болно. Мөн оюуны өмчийг (intellectual property) үзнэ үү.</p>
1153	Rio Declaration on Environment and Development	<p>Рио-де-Жанейро хотноо баталсан Хүрээлэн байгаль орчны болон хөгжлийн тухай тунхаглал (Уругвай). 1992 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Рио-де-Жанейро хотод болсон НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хөгжлийн бага хурлаар (UNCED – United Nations Conference on Environment and Development) батлагдсан, хүрээлэн буй орчны болон хөгжлийн тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хамгаалахад чиглэсэн багц зарчмууд. 12 дугаар зарчим (Principle 12) нь олон улсын худалдаанд хамааралтай. Үүнд, “Улс орнууд бүх улсад эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжилд хүргэх, дэмжлэг бүхий нээлттэй олон улсын эдийн засгийн системийг дэмжихийн тулд мөн хүрээлэн буй орчны доройтлын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллах ёстой гэж үздэг. Хүрээлэн буй орчны зорилгоор [боловсруулсан] худалдааны бодлогын арга хэмжээ нь дур зоргоор эсхүл үндэслэлгүй ялгаварлан гадуурхах эсхүл олон улсын худалдаанд өнгөлөн далдалсан хэлбэрээр хязгаарлалт хийх арга хэрэгсэл болох ёсгүй. Импортлогч орны шүүх эрх мэдэл хэрэгжих бүс нутгаас гадна хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлыг нэг талыг баримталсан үйл ажиллагаагаар шийдвэрлэхээс зайлсхийх ёстой.</p> <p>Хил дамнансан эсхүл дэлхийн хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэх байгаль орчны арга хэмжээнүүд нь болж өгвөл олон улсын харилцан зөвшилцөлд суурилсан байх ёстой.” ДХБ-ын Худалдаа ба хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн хорооны (WTO Committee on Trade and Environment) ажил үүргийн удирдамжид уг Тунхаглалын 12 дугаар зарчмыг холбогдох бичвэр болгон дурдсан болно. Мөн 21-р зууны Хөтөлбөрийг (Agenda 21) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1154	Rio Group	<p>Риогийн бүлэг. Аргентин, Болив, Бразил, Чили, Колумб, Эквадор, Мексик, Парагвай, Перу, Уругвай болон Венесуэл гэх улс орнуудаас бүрдсэн засгийн газар хоорондын бүлэглэл. Анх 1983 онд бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг анхаарах зорилгоор Рио-дэ-Жанейро хотод байгуулагдсан боловч энэ нь 1986 оноос ардчилал, хүний эрхийг хөхиүлэн дэмжих асуудлуудыг хамруулан үүргээ өргөжүүлсэн байна. Энэхүү шинэ эрх үүргийн дагуу тус бүлэг нь макро эдийн засгийн асуудлыг бас хэлэлцэж эхэлжээ.</p>
1155	Risk assessment	<p>Эрсдэлийн үнэлгээ. (Эрсдэлийг үнэлэх - Уругвай). ДХБ-ын гишүүн улс орнууд хүнсний аюулгүй байдал, амьтны эрүүл ахуй, ургамлын эрүүл төлөв байдлын зохицуулалтуудыг өөрсдийн олон улсын худалдаанд ашиглаж болох боловч ижил төстэй нөхцөлд буй гишүүдийн хооронд дур зоргоороо эсвэл үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах зорилгоор ашиглах ёсгүй. Үүнд хүрэхийн тулд ДХБ-ын Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт (Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр – Уругвай) (WTO Agreement on Sanitary and Phytosanitary Measures) тодорхой дүрэм журмыг зааж өгсөн байдаг. Уг хэлэлцээр нь гишүүдийг арга хэмжээнүүдийг уялдуулж мөн боломжтой нөхцөлд нь олон улсын стандарт, удирдамж ба зөвлөмжид тулгуурлан ажиллахыг хөхиүлэн дэмждэг. Хэрэв гишүүд илүү өндөр стандартыг баримтлахыг хүсвэл, тэд эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх шаардлагатай. Эрсдэлийн үнэлгээ гэдэг нь авч хэрэглэж буй эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээний хүрээнд, импортлогч гишүүний нутаг дэвсгэрийн хэмжээнд хортон шавж, өвчин эмгэг нэвтэрч халдварлах, тархах магадлалыг үнэлэх үнэлгээний ажил байж болно. Энэ нь мөн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, бохирдуулагч бодис, хорт бодис эсвэл хүнсний бүтээгдэхүүн, ус ундаа, эсвэл малын тэжээл зэрэг бүтээгдэхүүн дэх өвчин үүсгэгч организмаас үүдэлтэй, хүн болон мал амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалыг үнэлэх ажил бас байж болох юм. Эрсдэлийн үнэлгээ хийхдээ, одоогоор байгаа шинжлэх ухааны нотолгоо, холбогдох үйл явц, үйлдвэрлэлийн арга, холбогдох хяналт үзлэг, дээж авч шалгах аргачлалууд, тодорхой төрлийн өвчлөл, хортон шавжийн тархалт, хортон шавжгүй, өвчлөлгүй бүс нутгууд, холбогдох байгаль орчин ба экологийн нөхцөл байдал, хорио цээр болон бусад нөхцөл зэргийг харгалзан авч үзэх хэрэгтэй. Тухайн арга хэмжээг авсан тохиолдолд худалдааны сөрөг үр нөлөөллийг багасгах зорилгоор үүнд хамрагдсан эдийн засгийн хүчин зүйлийг үнэлэх шаардлагатай. Хэрэв тус өвчин тус улсад нэвтэрлээ гэхэд үйлдвэрлэлд учирсан хохирол, [өвчинд] хяналт тавих, арилгах зардал, боломжит хувилбар бүхий арга хэмжээний өртөг, үр ашиг зэргийг харгалзан үзэж байж, тэнцвэржүүлдэг байна. Мөн Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг (Sanitary and Phytosanitary measures) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1156	Rollback	Өмнөх төлөв рүү буцах. Энэ нь одоо оршиж буй арга хэмжээг задалж тараах замаар худалдааны саад бэрхшээлийг арилгах зорилгоор авч хэрэгжүүлсэн олон талт эсвэл нэг талын арга хэмжээ. Энэхүү арга хэмжээг ихэнх үед зогсонги байдалтай (standstill) хослуулдаг. Мөн худалдааны либералчлалыг (trade liberalization) үзнэ үү.
1157	Rome Convention	Ромын конвенц. Ромын конвенцыг 1961 оны 10 дугаар сарын 26-нд Ром хотод баталсан жүжигчин, фонограмм бүтээгч, найруулагч ба өргөн нэвтрүүлгийн байгууллагуудыг хамгаалах тухай олон улсын конвенц [Дуу авиа бичлэгийн болон радиогийн нэвтрүүлгийн гүйцэтгэгч, үйлдвэрлэгчийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц - Уругвай] гэж ойлгоно (Уругвай). Уг конвенц нь нийт 46 гишүүнтэй. Энэхүү конвенц нь урлагийн тоглолтод оролцож буй жүжигчдийн эрхийг хамгаалдаг. Фонограмм бүтээгч, найруулагчид өөрсдийнх нь фонограммыг хуулбарлах зөвшөөрөл олгох эрхтэй бөгөөд өргөн нэвтрүүлгийн байгууллагууд өөрсдийн нэвтрүүлгүүдтэй холбогдолтой эрхтэй байдаг. Энэхүү конвенцыг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) удирддаг. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) болон Зэрэгцээ эрх буюу хөршийн эрхийг (neighbouring rights) үзнэ үү.
1158	Round	Хэлэлцээний үе шат. Олон талт худалдааны хэлэлцээнүүдийг (multilateral trade negotiations) үзнэ үү.
1159	Ruinous competition	Хохиролтой өрсөлдөөн. Түрэмгийгээр үнэ тогтоох (predatory pricing) үзнэ үү.
1160	Rule of reason	Учир шалтгааны дүрэм. Энэ нь илэрхий өрсөлдөөний эсрэг бизнесийн практик арга ажиллагаа нь өрсөлдөөнийг дэмжиж тэнцвэржүүлсэн нөлөө үзүүлдэг эсэхийг тодруулахын тулд, өрсөлдөөний бодлогын удирдлага зохион байгуулалтад ашигладаг арга. Хэрэв энэ үнэн бол, өрсөлдөөний удирдах эрх баригчид тухайн хууль нь уян хатан байдлыг олгож буй тохиолдолд ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх шийдвэр гаргах боломжтой юм. Мөн Монополын эсрэг буюу итгэлцлийн эсрэг хуулиуд (antitrust laws), дангаараа дүрмийг (per se rules) үзнэ үү.
1161	Rules of origin	Гарал үүслийн дүрэм (ROO). Гарал үүслийн дүрэм нь бараа, үйлчилгээ, эсхүл хөрөнгө оруулалтын гарал үүслийн улсыг тодорхойлохын тулд аливаа гишүүн орны зүгээс мөрдөхөөр тогтсон хууль, журам болон нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрүүд. ТХЕХ 1994-ийн 1,2,3,11 болон 13 дугаар зүйлд заасан үндэсний нэн тааламжтай нөхцөл (most-favoured-nation treatment), 6 дугаар зүйлд заасан демпингийн эсрэг (anti-dumping) болон татаасыг саармагжуулах зорилготой нөхөн тэгшитгэх татвар (countervailing duties), 19 дүгээр зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээ (safeguard measures), 9 дүгээр зүйлд заасан гарал үүслийн тэмдэг тавих шаардлага (origin marking requirements) болон ялгаварлан гадуурхах аливаа тоо хэмжээний хязгаарлалт, тоо хэмжээний хязгаарлалттай тариф зэрэг хөнгөлөлтийн бус худалдааны бодлогын хэрэгслүүдийг хэрэглэхэд ашиглагддаг гарал үүслийн бүх дүрмийг багтаана.

Эдгээрт мөн засгийн газрын худалдан авалт (government procurement) болон худалдааны статистикт (trade statistics) ашиглагддаг гарал үүслийн дүрэм хамаарна (Уругвай). Хэрэв улс орнууд худалдааны бүх харилцаагаа үндэсний нэн тааламжтай (MFN) нөхцөлийн дагуу явуулах боломжтой байсан бол, гарал үүслийн дүрмийг хэрэглэх хэрэгцээ бага байх байсан. Импортлогчид өөрсдийн хэрэгцээ шаардлагад хамгийн сайн нийцсэн аливаа улс орноос бараа бүтээгдэхүүнээ худалдан авах боломжтой болох болно. Гэхдээ одоо, энэхүү нэг улс, зөвхөн ДХБ-ийн гишүүн улс орнууд л тэдний MNF тарифаас үр ашиг хүртэж байхыг хүсэж байлаа гэж төсөөлье. Энэ нь бусад орнуудад бус харин зөвхөн ДХБ-ын гишүүн улс орнуудад л илүү өндөр тариф ногдуулах замаар хэрэглэснээр, өөрийнхөө хэрэгцээг хангах боломжтой байх ёстой. Үүнийг хийхийн тулд, тэд гарал үүслийн зарим дүрэм хэлбэрээр тогтоосон тодорхой шалгуурт найдах болно. Тиймээс, ихэнх улс орнууд олон шатлалтай тарифтай (multi-column tariff) байдаг. Нэг шатлал нь ихэвчлэн үндэсний нэн тааламжтай нөхцөлийг хүртэж буй улс орнуудад хамаарах хувь хэмжээг агуулдаг. Өөр нэг шатлалд нь үндэсний нэн тааламжтай нөхцөл олгохоос татгалзсан орнуудаас гарал үүсэлтэй бараанд ногдуулсан ердийн тарифын хувь хэмжээг жагсаадаг. Гарал үүслийн дүрмийг шаарддаг гурав дах тохиолдол нь тухайн нэг худалдааны түншид олгож буй хөнгөлөлттэй нөхцөл. Жишээлбэл, Хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) дагуу хөгжиж буй буюу хөнгөлөлттэй нөхцөлөөр хөгжингүй орнуудын зах зээлд нь нэвтрэх (preferential access) эрхтэй экспортлогч орнууд бага тарифаас үр ашиг хүртэхийн тулд импортлогч орны гарал үүслийн дүрмийг дагаж мөрдөх, шалгуурыг хангах шаардлагатай болно.

Үйлдвэрлэлийн үйл явц даяаршиж чөлөөт худалдааны хэлэлцээр болон гаалийн холбоог ихээр байгуулж байгаа ч барааны гарал үүслийн дүрэм нь улам бүр нарийн төвөгтэй болж эхэлсэн. Бараа бүтээгдэхүүний гарал үүсэл нь импортын зах зээл дээрх зардлаас ихээхэн хамаарч, улмаар өрсөлдөх чадварт нь нөлөөлж байдаг тул хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад харгалзан авч үзэх ач холбогдолтой зүйлсийн нэг байж болох юм. Тухайн бараа бүтээгдэхүүн ямар орноос гарал үүсэлтэйг хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргахад гурван гол зарчмыг баримталдаг. Үүнд:

Нэгдүгээрт, тухайн бүтээгдэхүүнд экспортлогч оронд үлэмж хэмжээний өөрчлөлт буюу БТКУС-ийн бүлгийн, зүйлийн хэмжээнд өөрчлөлт орсон байх

Хоёрдугаарт, тухайн бүтээгдэхүүнд экспортлогч оронд бий болсон нэмүү өртгийг тооцоолох

Гуравдугаарт, тухайн бараа бүтээгдэхүүнд одоогийн онцлог шинж чанараа олж авахад нь шаардлагатай байсан тодорхой Боловсруулалтын нөхцөлийг нь харгалзах

Гарал үүслийн дүрмийг урт хугацаанд уялдуулан холбох зорилгоор ДХБ-ын Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээрийн хүрээнд (WTO Agreement on Rules of Origin) үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байдаг. Үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын хувьд, тухайн үйлийн лагааны хөтөлбөрийг баталсан байдаг. Үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын хувь дүрэм нийлүүлэх үйлчлүүлэх нийлүүлэх хөтөлбөр газар, эзэмшигчдийн иргэний харьяалал, тухайн компанийн толгой албан газрынх нь байршил, болон тухайн бизнесийг бодит амьдрал дээр эрхэлж байгаа газар зэрэг ордог байна. Эдгээр шалгууруудын зарим нь үндэстэнд бодит аж ахуйн нэгжүүд хамрагдсан тохиолдолд хялбархан тодорхойлчих боломжгүй байж ч болно.

Киотогийн конвенц (Kyoto Convention), гарал үүслийн хөнгөлөлттэй дүрмийг (preferential rules of origin) үзнэ үү.

---- O ----

1162 Safeguards

Хамгаалалтын арга хэмжээ. (Хамгаалалт – Уругвай). Энэ нь тодорхой үйлдвэрлэлийг гадаадын ханган нийлүүлэгчдийн зүгээс ирж буй өндөр хэмжээний өрсөлдөөнд зохицуулан нийцүүлэх боломжийг олгох зорилгоор, импортыг удаашруулахад чиглэсэн түр зуурын арга хэмжээ. Хамгийн түгээмэл утгаараа, “хамгаалалтын арга хэмжээ” нь улс орныг Зугтаах заалт буюу гэрээний хариуцлагаас чөлөөлсөн заалт (escape clause) гэж нэрлэгдэх, ТХЕХ-ийн 19 дүгээр зүйлийн [Тодорхой бараа бүтээгдэхүүний импорттой холбогдсон шуурхай арга хэмжээ] (Emergency Action on Imports of Particular Products) дагуу авсан арга хэмжээг зааж байдаг боловч, түүнээс гадна хамгаалалтын арга хэмжээг мөн 12 дугаар зүйл (Төлбөрийн тэнцлийг хамгаалахад тавих хязгаарлалт) [Төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор хийх хязгаарлалт - Уругвай] (Restrictions to Safeguard the Balance of Payments), 18 дугаар зүйлийн дагуу [Эдийн засгийн хөгжилд үзүүлэх засгийн газрын тусламж дэмжлэг - Уругвай] (Governmental Assistance to Economic Development) авч хэрэгжүүлэх боломжтой. ДХБ-ын дүрмийн дагуу хамгаалалтын арга хэмжээг тогтоож болох арга замуудын талаарх ашигтай тойм бүдүүвчийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны (IBRD) худалдааны бодлогын шинжээчид боловсруулсан боловч энэхүү арга барилыг ДХБ-ын бүх гишүүд заавал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Энэхүү үзэл санааны дагуу хамгаалалтын арга хэмжээг зургаан өөр арга замаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд эдгээрийг зөвхөн үндэслэл бүхий шалтгаант холбоо тохиолдолд тухайн арга хэмжээг авсан байх нөхцөлийг хангахаас хамаарна. Мөн, тухайн тохиолдол бүрт дагаж мөрдөх ёстой тодорхой журамласан үе шатууд гэж байдаг. Уг зургаан арга барилын эхнийх нь ТХЕХ-ийн 6 дугаар зүйлд, хэрэв демпинг бий болсон тохиолдолд засгийн газраас арга хэмжээ авахыг зөвшөөрдөг. Энэхүү зүйл ангийн заалтуудыг, ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг (Демпингийн эсрэг хэлэлцээр) хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт (Agreement on Implementation of Article VI of the GATT) цааш нь улам боловсронгуй тодорхойлсон байдаг. Хоёр дах нь, 12 дугаар зүйлийн дагуу хөгжиж буй орнуудын хувьд, 18 дугаар зүйлийн В хэсэгт (Article XVIII:B) заасны дагуу, тэд өөрсдийн гадаад санхүүгийн байр суурь болон төлбөрийн тэнцлийг (balance-of-payments) хамгаалах зорилгоор импортыг хязгаарлах боломжтой. Гурав дах нь, 18 дугаар зүйлийн А болон С хэсгүүдэд заасны дагуу, хөгжиж буй орнуудын засгийн газруудад эдийн засгийн хөгжлөө дэмжих үүднээс тусламж дэмжлэг үзүүлэх боломжийг нь олгодог. Дөрөв дөх нь, 19 дүгээр зүйлд заасны дагуу, хэрэв урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн бөгөөд хэрэв аливаа нэг бараа бүтээгдэхүүн тийм нэг их хэмжээгээр импортлогдох эсвэл түүнтэй ижил төстэй эсвэл шууд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учруулсан эсхүл хохирол учруулах аюултай болсон нөхцөлд,

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>тухайн улс орны хувьд хүлээсэн үүрэг амлалтаа түр зогсоох эсвэл либералчлах үүрэг амлалтаа өөрчлөх боломжийг нь олгодог. Урьдчилан тодорхойлсон нөхцөл байдлаас бусад тохиолдолд, 19 дүгээр зүйлд заасны дагуу авсан хамгаалалтын арга хэмжээ нь тодорхой бараа бүтээгдэхүүнийг эх үүсвэрээс нь үл хамааран уг бараа бүтээгдэхүүнд чиглэсэн байх ёстой байдаг. Гол асуудал болоод байгаа гэж үзсэн улс орнуудын эсрэг чиглэсэн ялгаварлан гадуурхах арга хэмжээ бол дүрмийн эсрэг зүйл юм. Хэрэв арга хэмжээ авсан тохиолдолд, арай бага хэмжээний тариф эсвэл бусад бараа бүтээгдэхүүний нэр төрлийн хүрээнд зах зээлд нь илүү сайн нөхцөлөөр нэвтрэх зэрэг аливаа нэгэн хэлбэрээр, уг арга хэмжээний нөлөөнд нь өртсөн оролцогч талуудад нөхөн төлбөр олгох үүрэг хүлээнэ. ТХЕХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу, Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрт (Agreement on Safeguards) хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх дүрмийг тогтоосон болно. Тав дах нь, импортоос хөнгөлөлт олж авах зорилгоор, ТХЕХ-ийн 28 дугаар зүйлд заасны дагуу үүрэг амлалтуудынхаа талаар дахин хэлцэл хийх боломжтой юм. Зургаа дах нь, ТХЕХ болон ҮХЕХ-ийн дагуу эс хэрэглэх нийтлэг тохиолдол (general exception) болон аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх тохиолдлуудыг, хамгаалалтын арга хэмжээний нэг хэлбэр гэж үзэж болно. Мөн, демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), Малгай наймаалагчдын үстэй малгайн тухай хэрэг (hatters' fur case) болон шалгарлыг (selectivity) үзнэ үү.</p>
1163	Sanitary and phytosanitary measures	<p>Ургамал, мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ (Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ - Уругвай). Энэ нь хүний эрүүл мэнд, мал амьтан, ургамлын эрүүл ахуйг хамгаалахад шаардлагатай хилийн хяналтын арга хэмжээ. Ихэнхдээ тэдгээрийг хорио цээрийн арга хэмжээ гэж нэрлэдэг. Ижил нөхцөл давамгайл үйлчилж байдаг гишүүн улс орнуудын хооронд дур зоргоороо, эсхүл үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах нөхцөл бий болгосон байдлаар ийм арга хэмжээг авч хэрэглэх ёсгүй байдаг. Ийм арга хэмжээг мөн олон улсын худалдаанд далдуур хязгаарлалт тогтоох хэрэгсэл болгон ашиглахгүй байх ёстой байдаг. ДХБ-ын Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний тухай хэлэлцээрт (SPS agreement) эдгээр шаардлагатуудыг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар заасан болно. Мөн Эпизоотик буюу амин тахлын олон улсын алба (Office of Epizootics), Ургамал хамгаалах конвенцыг (Plant Protection Convention) үзнэ үү.</p>
1164	SAPTA (SAARC Preferential Trading Arrangement)	<p>Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбооны Худалдааны хөнгөлөлттэй зохицуулалт. Үүнийг 1993 оны 4 дүгээр сард худалдааны бүс нутгийн бүлэгт чиглэсэн эхний алхам болгож, тодорхой бараа, бүтээгдэхүүн болон түүхий эд, материалын тарифыг бууруулахад чиглэсэн хөтөлбөртэй нь хамт эхлүүлсэн байдаг. Үүнтэй зэрэгцэн пара-тариф, тарифын бус арга хэмжээ, худалдааны шууд арга хэмжээ зэргийг авч үзэх хэрэгтэй болж болох юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Бүс нутгийн чөлөөт худалдааг эхлүүлэх товлосон өдөр нь 2005 онд байсан боловч зарим нэг нь 2001 онд байх тухай санал болгосон байна. Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбоо нь Бангладеш, Бутан, Энэтхэг, Мальдив, Непал, Пакистан, Шри Ланка зэрэг Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбооны (SAARC - South Asian Association for Regional Cooperation) гишүүн орнуудаас бүрэлддэг. Үүнийг SAARC удирддаг ба нарийн бичгийн дарга нарын газар нь Дакка хотод байрладаг.</p>
1165	Schedules of commitments on services	<p>Үйлчилгээний салбарт авсан үүрэг амлалтын жагсаалт (Үйлчилгээний талаарх үүрэг амлалтын дэлгэрэнгүй жагсаалт - Уругвай). Энэ нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) дагуу тавигдах гол шаардлага. Эдгээр нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) дагуу бараа бүтээгдэхүүний тарифын жагсаалттай төстэй үүргийг гүйцэтгэдэг байна. Уг жагсаалтууд нь үйлчилгээг экспортлогчдод уг зах зээлд нэвтрэх баталгаа болон үндэсний нөхцөлийн үр ашиг нь ямар цар хэмжээнд байгааг нягталж үзэх боломжийг олгодог байна. Мөн үйлчилгээний зах зээлд нэвтрэхийг (market access for services) үзнэ үү.</p>
1166	Schedules of concessions	<p>Үүрэг хүлээсэн/заавал баримтлах тарифын жагсаалт. ДХБ-ын ивээл дор хэлэлцэн тохиролцож заавал баримтлахаар үүрэг хүлээсэн үндэсний тарифын (bound tariff) жагсаалт. Өөрөөр хэлбэл, гишүүн орнууд гаалийн тарифын дээд хувь хэмжээг тохиролцож, түүнээс нэмэгдүүлэхгүй байхаар үүрэг хүлээж бараа бүрээр үндэсний тарифын жагсаалтыг гаргасан байдаг ба энэ нь бүх орнуудад ил тод нээлттэй байдаг. Мөн тарифыг (tariff) үзнэ үү.</p>
1167	Scientific tariff	<p>Шинжлэх ухаанч тариф. Энэ нь олон засгийн газрын багагүй хугацааны турш эрэлхийлж байсан тарифын хувь хэмжээний хамгийн зохистой багц. Үүний үндсэн зорилго нь тухайн бараа бүтээгдэхүүнийг олон улсын хэмжээнд бусадтай адил эрх тэгш түвшинд өрсөлдөх чадвараар хангах, дотооддоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бусдын худалдааны шударга бус гэж ойлгогдож буй арга туршлагаудыг залруулан тэнцвэржүүлэх явдал юм. Хичээл чармайлт гаргахыг хүсээгүй ч гэсэн, одоогийн байдлаар аль ч улс орон уг шинжлэх ухааны үндэслэлтэй тарифыг боловсруулж чадаагүй байна.</p> <p>Юутай ч, үүнийг боловсруулж болох байсан ч энэ нь олон улсын хөдөлмөрийн хуваарилалт болон харьцангуй давуу талын (comparative advantage) үзэл санаатай шууд зөрчилдөх байсан бөгөөд энэ тохиолдолд өөр газар олж болох үр ашгийн давуу талыг үгүйсгэх болно.</p>
1168	Seasonal tariff	<p>Улирлын чанартай тариф. Энэ нь дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг улирлын чанартай ханган нийлүүлдэгтэй холбоотой тарифын хувь хэмжээ. Өөрөөр хэлбэл, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зах зээлд гарч эхлэх үед импортын гаалийн тариф нь өндөр, харин үйлдвэрлэл багасаж, дахин үйлдвэрлэл явагдахгүй болсон үед барааны үнэ өсөхөөс сэргийлэх зорилгоор тарифыг бага байлгадаг байна. Импортын бараа бүтээгдэхүүн дотоодын бүтээгдэхүүнтэй заавал адил байх шаардлагагүй.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1169	Seattle ministerial conference	Сиатл дах сайд нарын бага хурал. Энэ бол 1999 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 3-ны хооронд Сиатл хотод явагдсан ДХБ-ын Сайд нарын бага хурал. Энэхүү бага хурал нь маш их урьдчилан бэлтгэсэн зөвлөлдөөн, хэлэлцээнүүд хийсэн боловч, олны хүрээнд хүлээгдэж байсан Мянганы үе шатны хэлэлцээг (Millenium Round) эхлүүлэх хурлыг зохион байгуулахад хүргэж чадаагүй.
1170	Secondary dumping	Хоёрдогч демпинг. Демпингийн улмаас бага үнэтэй болсон эд анги, сэлбэг гэх мэт бүрэлдэхүүн хэсгүүдийг угсарч нийлүүлсэн бүтээгдэхүүний экспортын үед яригддаг. Жишээлбэл, унадаг дугуйны рамыг демпингийн үнээр буюу зах зээлийн хэвийн үнээс доогуур үнээр импортолж, бэлэн дугуй угсран экспортлох гэх мэт. Үүнээс болоод уг аж ахуйн нэгж нь бүрэн угсарсан унадаг дугуйгаа өөрийн эдийн засагт давамгайлж байгаа зах зээлийн үнээр зарж байсан ч үнийн хувьд давуу талыг олж авсан байдаг. Хоёрдогч демпингийн нөлөөлсөн хор хохирлыг нь хангалттай үндэслэлтэйгээр нотлоход хэцүү байдаг. Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), демпинг (dumping), нуугдмал демпинг (hidden dumping), шууд бус демпингийг (indirect dumping) үзнэ үү.
1171	Second-level obligations	Хоёрдугаар түвшний үүрэг, үүрэгчлэлүүд. Энэ нь холбооны засаглалтай улсуудын төв засгийн газруудын хувьд тэдний шүүх эрх мэдэл хэрэгжүүлдэг харьяа штат эсвэл аймаг, сум, орон нутагтай нь холбоотойгоор ДХБ-ын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг, амлалт. Үүнд хоёр жишээ хангалттай байх болно. ТХЕХ-ийн заалтууд нь ДХБ-ын гишүүн улс орнуудыг ТХЕХ-ийн дүрмийг дагаж мөрдөх нөхцөлийг хангах үүднээс, тэдний нутаг дэвсгэрийн хүрээнд тэдний аймаг, сум, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын хувьд хэрэгжүүлэх боломжтой байж болох тийм зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг. ТХЕХ нь төв, бүс нутаг эсвэл орон нутгийн засаг захиргаа, эрх баригчдын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хамаарна.
1172	Second Protocol to the General Agreement on Trade in Services	Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн хоёр дугаар протокол. 1995 оны Санхүүгийн үйлчилгээний түр хугацааны гэрээнд тусгагдсан санхүүгийн үйлчилгээний худалдааны талаар авсан үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэх протокол. Энэ нь 1996 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.
1173	Sectoral commitments	Салбарын хүрээний үүрэг амлалтууд. Энэ нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATS) заасны дагуу авсан үүрэг амлалтуудын жагсаалтад орсон үйлчилгээний тодорхой салбарууд болон дэд-салбаруудыг хамарсан бичилтүүд. Үүний жишээ нь нягтлан бодох бүртгэл, тээвэр зуучлал, болон амь насны даатгал. Салбарын хүрээний үүрэг амлалтууд нь зах зээлд нэвтрэх болон үндэсний нөхцөлтэй холбогдолтойгоор ҮХЕХ-ийн илүү өндөр түвшний эрх, үүргүүдийг соронздон татдаг байна. Үүрэг амлалт өгсөн тохиолдолд үүнд ашиглаж байгаа зах зээлд нэвтрэх нөхцөлийг дор хаяж гурван жилийн хугацаанд илүү хязгаарлаж болохгүй. Мөн үйлчилгээний зах зээлд нэвтрэх хүртээмжийг (market access for services) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1174	Sectoral customs union	Салбарын хүрээний гаалийн холбоо. Мөн Салбарын хүрээний чөлөөт худалдааны бүсийг (sectoral free-trade area) үзнэ үү.
1175	Sectoral free-trade area	Салбарын хүрээний чөлөөт худалдааны бүс. Энэ нь худалдаа арилжаа эрхэлж буй зөвхөн зарим нэг тодорхой салбаруудыг хамарсан чөлөөт худалдааны бүс буюу гаалийн холбоо. Энэхүү сонголтыг Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дагуу зөвхөн хөгжиж буй орнууд ашиглах боломжтой. Хөгжингүй орнууд салбарын хүрээний худалдааны хэлэлцээнүүдийг хийж болох боловч тэд салбарын хүрээний худалдааг либералчлалын үр ашгийг үндэсний нэн тааламжтай нөхцөлд (most-favoured-nation) тулгуурлан сунгах ёстой.
1176	Sectoral trade negotiations	Салбарын хүрээний худалдааны хэлэлцээнүүд. Энэ нь олон талт худалдааны хэлэлцээний эхний үе шатуудад тухайн зүйл тус бүрээр хэлэлцдэг байсан үеэс илүүтэйгээр тарифын зүйлсийг кластераар нь шийдвэрлэх замаар худалдааны хэлэлцээний үр дүнд хүрнэ гэсэн санаа. Кеннедийн яриа хэлэлцээний үеэр үүнийг анх удаа их хэмжээгээр туршиж үзсэн. Ийнхүү хандаж ажилласан гол салбарууд нь хөнгөн цагаан, химийн бодис, даавуун нэхмэл, төмөр, ган, нухаш зутан, цаасны салбарууд байв. Үр дүн нь хоорондоо маш их ялгаатай байсан ч Дугуй ширээний яриа хэлэлцээний нэгэн анхааралтай хийгдсэн үнэлгээний хүрээнд, тарифыг бууруулах ирээдүйн боломжит арга хэрэгсэл болгох, сонгосон аж үйлдвэрлэлийн салбаруудын хооронд чөлөөт худалдаа хийхэд хангалттай ахиц гарсан гэж үзсэн байна (Preeg, 1970). Дараа нь Канад улс Токиогийн үе шатны хэлэлцээний үеэр тарифын болон тарифын бус саад тогторыг салбарын хүрээнд бууруулах, арилгахыг дэмжсэн. Зарим салбарт энэ аргаар хэлэлцээний хүлээн зөвшөөрөгдсөн арга техникээс үүдэлтэй худалдааны либералчлалаас цааш давж гарах боломжтой гэж Канад улс учирласан байдаг. Ялангуяа түүхий эдийн үе шатнаас эхлээд бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүх худалдааны саад бэрхшээлийг арилгах боломжтой гэж үзсэн байдаг. Хөгжиж буй орнууд энэ саналыг сонирхол татахуйц гэж үзсэн байдаг учир нь тэдний хувьд гол ашиг сонирхлыг нь илэрхийлдэг экспортын бүтээгдэхүүнүүдийн хувьд энэ аргыг хялбархан нэвтрүүлж болохоор санагдсан ба энэ нь мөн тарифын өсөлтийн асуудлыг шийдэх гарц байж болохоор байв. Гэвч бусад [орнуудын] эсэргүүцэл нь салбарын хүрээний уг арга хандлагыг батлаагүй юм. Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр салбарын түвшний худалдааны хэлэлцээ хоёр түвшинд явагдсан. Нэгдүгээрт, өргөн хүрээнд, Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр, Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээр, Үйлчилгээний тухай хэлэлцээрүүд хийгдэж, хөдөө аж ахуйн хэлэлцээ, сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний хэлэлцээ, үйлчилгээний хэлэлцээнүүд тус бүр хийгдсэн байдаг. Эдгээр бүх хэлэлцээрүүд нь үйлчилгээний хувьд бага зэрэг хэмжээнд боловч худалдааны зарим либералчлалд хүргэж чадсан байна. Тэдгээр нь ирээдүйн цаашдын либералчлалын хуваарийг мөн агуулсан байдаг. Хоёрдугаарт, жижиг салбарын бүлгүүдэд тарифын хэлэлцээ хийгдэж байсан.

Үүний үр дүнд худалдааны гол орнуудын дунд эм зүйн бүтээгдэхүүн, барилгын тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, шар айраг, фермийн машин, мод, цаасан бүтээгдэхүүн, зарим загасны бүтээгдэхүүн, тоглоомын бараа бүтээгдэхүүний тарифыг арилгасан байна. АНУ болон Европын хамтын нийгэмлэгийнхэн химийн бодисын үнийн тарифыг 3% хүртэл бууруулахаар тохиролцов. Олон талт гангийн хэлэлцээр хийх оролдлого бүтэлгүйтэв. Уругвайн үе шатны хэлэлцээний дараа үйлчилгээний салбар дах худалдааны хэлэлцээ үргэлжилсэн байдаг. Санхүүгийн үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлэлцээнд хязгаарлагдмал ахиц дэвшил гарч, Санхүүгийн үйлчилгээний завсрын үеийн хэлэлцээр байгуулахад хүрсэн байдаг. Далайн тээврийн үйлчилгээ эрхлэх тухай хэлэлцээрийн хувьд, гол томоохон оролцогчдын зүгээс томоохон үүрэг амлалт өгөх чадваргүй байгаа нөхцөлд 2000 он хүртэл хойшлогдоод байсан. Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээний хэлэлцээр нь тухайн салбарын хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц үр дүнг илэрхийлж байгаа боловч олон зүйлийг хийх хэрэгтэй хэвээр үлдэв. Салбарын худалдааны хэлэлцээрийн түвшинд юунд хүрч болохын тод жишээ бол Мэдээллийн технологийн хэлэлцээр юм. Энэхүү хэлэлцээрийг тийм амжилттай байгуулж чадсан гол шалтгаан нь, аж үйлдвэрлэл болон худалдааны бүх томоохон орнуудад аж үйлдвэрийнхэн болон засгийн газрын дэмжлэгийн аль алийг нь авч чадсан явдал юм. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) худалдааны сайд нар 1997 оны 5-р сард Салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх санаачилгаар дамжуулан, салбарын хүрээний худалдааны либералчлалын боломжийг судлахаар шийджээ. Тэдний зорилго нь, тариф, тарифын бус саадыг бууруулах эсвэл арилгахад АПЕК-ийн бүх орнууд санал нэгдэж чадах салбаруудыг олж тодорхойлох явдал байв. Одоо бол Тарифын хурдасгасан либералчлал хэмээн дахин нэршил өгсөн уг санаачилгын урт хугацааны үр дүн ямар байх бол гэдгийг хэлэхэд эрт байна. Салбар салбараар нь хэлэлцээ хийх нь ирээдүйн худалдааны либералчлалд хүрэх хамгийн сайн арга гэж үзэж байгаа хүмүүс байдаг. Тэр нь ажиллагаанд орохоороо үр ашигтай үр дүнд хүргэдэг. Тэдгээрийн гол сул тал бол уг тохируулгын ачааг зөвхөн тухайн нэг салбарт төвлөрүүлснээр дараа нь уг салбар бүх гарч болох зардлыг өөрсдөө үүрч байна гэж үздэг байна. Эсэргүүцлийн түвшин хэт их байвал засгийн газрууд уг асуудлыг урагшлуулахгүй байхаар шийдэж болох юм. Хэдийгээр бүх худалдааны либералчлал нь эдийн засагт үр ашиг авчирдаг ч [дээрх хувилбар яригдсан байдаг]. Иймээс олон улс орнуудын хувьд эмзэг салбар болох хөдөө аж ахуйн салбарт хийгдэх олон талт либералчлалын магадлалын хувьд зөвхөн олон талт худалдааны яриа хэлэлцээний үе шатыг тогтоох замаар урт удаан хугацаанд хийгдэх боломжтой. Яриа хэлэлцээний эдгээр үе шатууд нь засгийн газруудыг энд ч "ашиг" тэнд ч "алдагдал" харж буй салбаруудын хоорондын баланс тэнцвэрийг хадгалах боломжийг олгодог. Аж үйлдвэрийнхний хувьд "золиос" гэж үздэг зүйлийн төлөө тэднийг ганцаардуулаагүй байсан байна гэдгийг харж болно. Мөн тэг-байвал-тэг болгож тарифыг бууруулахыг (zero-for-zero tariff reductions) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1177	Security exceptions	<p>Аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх нөхцөл/тохиолдол - Уругвай. Хэрэв үндэсний аюулгүй байдлын чухал асуудлууд эрсдэлд орсон тохиолдолд Үйлчилгээ, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 14 дүгээр зүйл (GATS) болон Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) 21 дүгээр зүйлд заасны дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудаа ДХБ-ын гишүүд түр зогсоох эрхтэй юм. Дараах нөхцөл байдлуудад энэ нь үүсэж болзошгүй. Үүнд: (а) мэдээллийг задруулбал аюулгүй байдлын амин чухал эрх ашигт харшилна гэж үзэж байгаа тохиолдолд ямар нэг мэдээллийг ил болгохоос татгалзах эрх, (b) цөмийн хуваагдал/задралд ордог материал, зэр зэвсэг, галт зэвсгийн наймаа, дайны багаж зэвсэг, мөн дайн болон олон улсын бусад онцгой байдлын цаг үед аюулгүй байдлын амин чухал эрх ашгийг хамгаалахад шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагаа явуулах шаардлага, (c) олон улсын аюулгүй байдал, энх тайвныг хадгалан хамгаалах зорилгоор НҮБ-ын зүгээс авсан арга хэмжээний араас гүйцэтгэх зэрэг болно. Эдгээр заалтыг маш ховор хэрэглэдэг. Мөн Эс хэрэглэх нийтлэг тохиолдлыг (general exceptions) үзнэ үү.</p>
1178	SELA (Latin American Economic System)	<p>Латин Америкийн эдийн засгийн систем (SELA). Энэ нь Латин Америк болон Карибын тэнгисийн 27 орноос бүрэлдсэн бүс нутгийн байгууллага ба төв нь Венесуэлд байрладаг. Энэхүү байгууллагын гол зорилго нь гишүүн орнуудынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах зорилгоор бүс нутгууд хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд чиглэдэг ба олон улсын чуулга уулзалтуудад баримтлах нэгдсэн стратегийг батлахад чиглэсэн байнгын үйл ажиллагаатай байгууллагыг хангах явдал.</p>
1179	Selective safeguards	<p>Хамгаалалтын сонгосон арга хэрэгсэл. Шалгаралыг (selectivity) үзнэ үү.</p>
1180	Selectivity	<p>Сонгон хэрэглэх. ДХБ-ын дүрмийн дагуу шаарддаг ихэнх тохиолдолд ялгаварлан гадуурхалгүйгээр хамгаалалтын арга хэмжээг авахаас илүүтэйгээр, дотоодын үйлдвэрлэгчдэд гол аюул занал гэж үздэг импортын хязгаарлалтыг нэг, эсхүл хэд хэдэн улсад ногдуулахыг хэлнэ. Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн 5(b) зүйлд заасны дагуу зарим шилж сонгох байдлыг зөвшөөрсөн байдаг, хэрвээ: (i) хэлэлцэж буй хугацаанд зарим улсаас орж ирсэн импорт харьцангуйгаар их өссөн нь тодорхой бол, (ii) хамгаалалтын арга хэмжээ авах бусад бүх нөхцөл хангагдсан болно, (iii) энэ нь бусад ханган нийлүүлэгчдэд эрх тэгш байх тохиолдолд. Мөн Зугтаах заалт буюу гэрээний хариуцлагаас чөлөөлсөн заалтыг (escape clause) үзнэ үү.</p>
1181	Self-reliance	<p>Өөрийн хүчинд найдах. Энэ нь ихэвчлэн дотоодын хэмжээнд бэлэн байгаа байгалийн нөөц баялаг, капитал хөрөнгө, ур чадварт найдаж тулгуурласан эдийн засгийн хөгжлийн бодлого. Үүний нэг онцлог шинж чанар нь гадаад валютын илүү их хэмжээний урсгал шууд орж ирэх буюу шууд үр дүнд хүргэдэггүй үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдэд гадаад валютыг зарцуулах асуудлыг ихээхэн үл тоомсорлох шинж чанар.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүний нэг үр дагавар нь хэдийнээ өөр газарт бэлэн болсон бараа бүтээгдэхүүнүүд, гүн боловсруулалтуудыг дахин зохион бүтээхэд дотоодын аж ахуйн нэгж болон дээд боловсролын байгууллагууд ихэнх цаг хугацаа болон хөрөнгөө зарцуулдаг боловч тэд хэзээ ч гүйцэж түрүүлэх боломжгүй мэт харагддаг байна. Чөлөөт худалдаа, экспортын бодлоготой орнуудын эдийн засгуудын хувьд (outward-looking economies) энэхүү урхинаас зайлсхийдэг бөгөөд харин түүний оронд олон улсын худалдаа, гадаад хөрөнгө оруулалтаар дамжуулан олон улсын нарийн мэргэшлийн тогтолцооны хүрээнд байр сууриа олохыг эрмэлздэг байна. Мөн Автократ дээд эрх мэдлийг хязгаарлалтгүйгээр захирагч/ганцаар захирах ёс (autarky), харьцангуй давуу тал (comparative advantage), өөрөө өөрийгөө хангадаг байх (self-sufficiency), технологийн үндэсний үзлийг (techno-nationalism) үзнэ үү.</p>
1182	Self-sufficiency	<p>Өөрийгөө хангах чадвар. Энэ нь тухайн улс өөрөө юу хэрэглэдэг байна тэр хэмжээний томоохон цар хүрээнд үйлдвэрлэл эрхлэхийг зорьж буй эдийн засгийн бодлого. Ийм бодлого хэрэгжүүлдэг улс орнуудад гадаад худалдаа гэж байдаг боловч, тухайн улсын дотоодын зах зээлд байдаггүй нэн чухал түүхий эдийг импортлох мөн дотоодын зах зээлд хэрэгцээгүй түүхий эд материал болон бусад бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагаагаа хязгаарлах хандлагатай байдаг. Ийм бодлого нь олон улсын мэргэшлээс хүртэх үр ашгийг үл тоомсорлож, өргөн утгаараа худалдаа ба эдийн засгийг өргөжүүлэхэд тоормос дарах мэтээр үйлдэх нь бий. Мөн Автократ дээд эрх мэдлийг хязгаарлалтгүйгээр захирагч/ганцаар захирах ёс (autarky), харьцангуй давуу тал (comparative advantage), олон улсын хөдөлмөрийн хуваарилалт (international division of labour), өөрийн хүчинд найдах (self-reliance), техно-үндсэрхэг үзлийг (techno-nationalism) үзнэ үү.</p>
1183	Semi-conductor	<p>Хагас дамжуулагч. Энэ нь 1986 онд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгээс (ЕСС) ТХЕХ-ийн (GATT) зөвлөлийн өмнө АНУ болон Япон улсуудтай үүсгэсэн маргаан. ЕСС-ийг мөн Австрали, Канад, Хонконг, Сингапур, Бразиль улсуудаас ирүүлсэн илтгэлүүд дэмжсэн байна. BISD 35-т заасны дагуу ЕЕС-аас гаргасан энэхүү хэрэг нь, хагас дамжуулагчийн худалдаа хийх талаар АНУ, Японы 1986 онд хийсэн зохицуулалтаас үүдэлтэй. Энэ нь Япон улсад импортын хагас дамжуулагчийн зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулж, АНУ-д үүсэх демпингээс урьдчилан сэргийлэх зорилгоор Япон улсын засгийн газар экспортын үнэд хяналт тавьж ажилласан. Хяналт тавих, демпинг хийх гэсэн нөхцөлүүдийг гуравдагч орны зах зээлд хэрэглэж болохуйц байсан. Япон улс экспортын үнийг хянахын тулд СОСОМ-ийн журмыг сахиулах механизмыг ашигласан бөгөөд энэ нь экспортын зөвшөөрлийг олгох хугацааг хойшлуулсан. ЕЕС-ийн зүгээс (а) Японы хяналт, шинжилгээний арга хэмжээ нь, ялангуяа гуравдагч орны зах зээлд хэрэглэсэн арга хэмжээ нь 6-р Зүйл (Демпингийн эсрэг арга хэмжээ) ба 11-р Зүйлийг</p>

(Тоо хэмжээний хязгаарлалтуудыг нийтэд нь цуцлах) зөрчсөн, (b) Японы зах зээлд нэвтрэх тухай нөхцөл нь 1-р Зүйлийг (Үндэсний нэн тааламжтай [ерөнхий] нөхцөл) зөрчсөн, (c) бүх асуудлыг тойрсон ил тод байдлын асуудал хангалтгүй байгаа нь 10-р дугаар Зүйлийг (Худалдааны эрх зүйн зохицуулалтын хэвлэн нийтлэл ба удирдлага) зөрчиж байна гэж маргасан байна. Гуравдагч орны хяналт шалгалт нь одоо тухайн зохицуулалт нь АНУ-д үнэ өсөн нэмэгдэхэд хүргэсэн ба эдгээр зах зээлүүдэд АНУ-ын компаниудын хувьд таагүй нөхцөл үүсгэхгүй байхад чиглэсэн байсан гэж маргасан байна. Хяналт шалгалт гэдэг бол зөвхөн үзэж харна гэсэн үг хэмээн Япон улс хэлсэн байна. Экспорт нь өртгөөсөө “хэтэрхий бага” үнээр хийгдсэн тохиолдолд МПТ нь (Худалдаа, аж үйлдвэрийн яам) үйлдвэрлэгчдээ санаа зовниж байгаагаа илэрхийлж магадгүй юм. ЕСС нь зүгээр л харж үзэж байх нь демпингаас урьдчилан сэргийлж чадна гэдэгт эргэлзэж байв. Гуравдагч улсын хяналт шалгалт нь аль ч тохиолдолд, демпингийн эсрэг арга хэмжээ авах эсэхийг шийдэх импортлогч улсын онцгой эрхийг зааж өгсөн 6-р Зүйлийг зөрчсөн байв. Японы зүгээс бол 6-р Зүйл болон Демпингийн эсрэг төрөлжүүлэн нэгтгэсэн хуульд, демпинг хийхээс урьдчилан сэргийлэхийн тулд экспортлогч улсын хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар ямар нэгэн заалт байдаггүй гэж хариу мэдүүлсэн байна. Хэрвээ экспортлогч улс орнуудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хязгаарласан бус байгаа бол тэд ийм арга хэмжээ авахыг нь хориглоогүй. Үүний дараа ЕСС нь, засгийн газрын оролцоотойгоор Японы хагас дамжуулагчдын экспортын үнийг зохиомлоор өсгөснөөр гуравдагч орны зах зээлд хяналт шинжилгээ хийсэн нь 11-р Зүйлийг зөрчиж байна гэж үзсэн бөгөөд эдгээр хязгаарласан хүчин чармайлтын тухай дэлхий нийтээр таньж мэдсэн байна. Япон улс нь хяналт шинжилгээ нь худалдааг хориглох, хязгаарлах зорилгогүй гэж мэдэгдэв. ЕСС нь мөн Япон улс зөвхөн зарим улс орнуудад хяналт тавьдаг тул энэ нь 1-р Зүйлийг зөрчиж байсан бөгөөд Япон улс уг системийг хэрхэн удирддаг нь тодорхойгүй байсан гэж үзсэн байна. Хяналт шинжилгээ хийж буй зах зээл нь үндсэндээ түүний хагас дамжуулагчийн бараг бүх экспортыг хамаарч байсан гэж Япон улс хариулсан байна. АНУ нь Японы зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх давуу эрхийг хүртэж байгаагүй хэмээн мэдэгдэж байгаа бөгөөд ЕСС-ийн мэтгэлцэж байгаа хяналт шалгалт нь 6-р Зүйлд нийцээгүй бөгөөд ямар ч үндэслэлгүй юм гээд энэхүү эрх зүйн зохицуулалт нь 11-р Зүйлийн агуулгын хүрээнд тоон хязгаарлалт шаардаагүй, зөвлөөгүй бөгөөд Япон улс бараг бүх экспортоо хянаж байсан тул 11-р Зүйлийг зөрчихөд хүргээгүй мөн хоёр тал хоёулаа ил тод байдлын төлөө ихээхэн хүчин чармайлт гаргасан хэмээн маргалдсан байна. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг нь эхний ээлжид 11-р Зүйлтэй холбоотой гомдлыг авч үзсэн бөгөөд хяналт шинжилгээний үнийн цогц системтэй уялдуулсан, экспортын тусгай зөвшөөрөл олгох системтэй адил зүйл байсан гэх,

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Японы компаниудыг АНУ-аас бусад ТХЕХ-ийн бүх гишүүдэд хагас дамжуулагчийг тухайн компанийн зардлаас доогуур үнээр борлуулахгүй байхыг хүссэн хүсэлт нь 11-р Зүйлтэй нийцэлгүй байсан байна хэмээн үзсэн байна. Түүнчлэн өргөн барьсан нотлох баримтууд нь, АНУ-ын компаниуд үндэсний нэн тааламжтай нөхцөлийг (MFN) зөрчих замаар Японы зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтэрсэн болохыг нотлон харуулж чадсангүй гэж үзсэн байна. Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг нь демпингаас урьдчилан сэргийлэхийн тулд экспортлогч улс орнуудын авч хэрэгжүүлсэн үйлдлийн хувьд 6-р Зүйл нь дуугүй байсан тул энэ нь экспортын хязгаарлалт хийх эсвэл экспортын үнийн арга хэмжээ авах үндэслэл биш байсан гэж үзэв. Түүнчлэн 6-р Зүйл нь экспортлогч улсуудын хувьд тэд экспортын бүтээгдэхүүндээ демпингийн эсрэг арга хэмжээ ногдуулах эрхийн тал дээр дуугүй байсан байна хэмээн дурдсан байна.</p>
1184	Semi-tradeables	<p>Хагас арилжаалагдахуйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ. Онцгой шинж чанар бүхий бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнүүд нь худалдан арилжаалахад тохиромжтой болон худалдан арилжаалаад зарагддаггүй байж болох ангиллуудад хуваагддаг байна. Эдгээр ангиллуудын хоорондын ялгааг нь бодит амьдрал дээр тодорхойлоход хэцүү байж болох юм.</p>
1185	Sensitive List	<p>Эмзэг мэдрэг бүтээгдэхүүнүүдийн жагсаалт. Энэ нь боловсруулаагүй хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг хамардаг Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Чөлөөт худалдааны хэлэлцээрийн (AFTA) гишүүдийн зүгээс аргасан жагсаалт. Жагсаалтад бүртгэгдсэн бүтээгдэхүүний хувьд дотоодын хэмжээнд хийх либералчлалыг 2010 он хүртэл хийх шаардлагагүй байв. Бусад бүх бүтээгдэхүүн нь 2003 он гэхэд AFTA-ийн 0%-аас 5% хүртэлх хөнгөлөлтийн тарифын хувь хэмжээг (preferential rate) эдлэх эрхтэй. Мөн Түр хасах жагсаалтыг (Temporary Exclusion List) үзнэ үү.</p>
1186	Sensitive products	<p>Эмзэг мэдрэг бараа бүтээгдэхүүнүүд. Эдгээр нь импортын хязгаарлалттай тулгарах магадлал илүү өндөр бараа бүтээгдэхүүн. Энгийн жишээ бол хөдөө аж ахуйн олон бүтээгдэхүүн, сүлжмэл нэхмэл бүтээгдэхүүн, хувцас ба гутал, зорчигч тээврийн хэрэгсэл, химийн бодис, болон зарим үед ган төмөр зэрэг ордог. Эдгээр бүтээгдэхүүнүүдийг хүрээлсэн эмзэг мэдрэг байдлын шалтгаан нь нарийн төвөгтэй байдаг. Энэ нь үндэсний цөөнхийн уламжлалт ажил мэргэжлийг хамгаалах хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага байх боломжтой бөгөөд үүнд жишээ нь Японы арьсан эдлэл боловсруулах үйлдвэрүүд (Japanese tanneries) шиг нөхцөл байж болох юм. Бусад тохиолдолд, технологийн өөрчлөлтүүд болон шинэ хөрөнгө оруулалт нь, илүү хямд өртөгтэй гадаадын өрсөлдөгчид орж ирэх болон дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд хурдан нийцүүлж, тохируулах чадваргүй болоход хүргэж болзошгүй юм. Европын жишээнээс харахад, ялангуяа хөдөө аж ахуйн салбар нь нарийн төвөгтэй байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Улс төрийн уламжлалт хүчин чадлыг хөдөө орон нутгийн хүн ам үндэсний мөн чанарыг илэрхийлдэг тул хадгалан үлдээх ёстой гэсэн тодорхой бус олон нийтийн ойлголттой хослохоороо энэ нь хөдөөгийн салбарын аливаа шинэчлэлийг нарийн эмзэг болгож болох юм. Мөн эмзэг мэдрэг салбаруудыг (sensitive sectors) үзнэ үү.
1187	Sensitive sectors	Эмзэг мэдрэг салбарууд. Технологийн хувьд харьцангуй хоцрогдсон байдал, соёлын хүчин зүйлүүд, хэт үйлдвэрлэл эсвэл улс төрийн хүчтэй нөлөө (political clout) гэх зэрэг олон төрлийн шалтгааны улмаас, худалдааны бодлогуудыг боловсруулагч нарт онцгой бэрхшээл учруулж буй дотоодын эдийн засгийн нэг хэсгүүд. Эдгээрийн дунд, хөдөө аж ахуй, ихэнх тохиолдолд дуу дүрс бичлэгийн үйлчилгээнүүд болон соёлын үйл ажиллагаанууд, батлан хамгаалахтай холбоотой салбарууд (defence-related industries), санхүүгийн үйлчилгээнүүд, хөлөг онгоцны үйлдвэрлэл, сүлжмэл нэхмэл текстилийн бүтээгдэхүүнүүд, гутал гэх зэрэг зүйлс орно. Үнэн хэрэгтээ, аль ч салбарууд хэрэв импортын дарамт шахалтыг мэдрэсэн тохиолдолд мөн эдгээр салбарууд нь өөрсдийгөө удирдан зохион байгуулах хүсэлтэй бол эмзэг салбар болон хувирч болно. Эмзэг мэдрэг салбаруудаас үүдэлтэй асуудлуудыг шийдвэрлэх урт хугацааны шийдлүүдийг ихэвчлэн бүтцийн зохицуулалтаар дамжуулан олж авдаг эсвэл, хэрэв өөр ямар ч зүйл хийгдээгүй тохиолдолд, гол тоглогч зарим салбарын санаандгүй байдлаар аажмаар үүссэн моралийн элэгдэл (accidental obsolescence) эсвэл бүр алга болсны улмаас бий болох нь бий. Мөн соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанар (cultural identity), эмзэг мэдрэг бараа бүтээгдэхүүнүүд (sensitive products), салбарын хүрээний худалдааны хэлэлцээг (sectoral trade negotiations) үзнэ үү.
1188	Sequential foreign direct investment	Гадаадын дараалсан шууд хөрөнгө оруулалт. Энэ нь зах зээлд аль хэдийнээ байр сууриа олсон компаниудын хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас (UNCTAD) тодорхойлсон нэр томьёо. Ихэнх тохиолдолд тийм хөрөнгө оруулалт нь дахин хөрөнгө оруулсан орлогоос бүрддэг байна. Мөн Гадаадын нэгдсэн шууд хөрөнгө оруулалтыг (associated foreign direct investment) үзнэ үү.
1189	Serious damage	Ноцтой хохирол сүйтгэл учруулах. Хохирол учруулахыг (injury) үзнэ үү.
1190	Serious injury	Ноцтой хохирол учруулах. Хохирол учруулахыг (injury) үзнэ үү.
1191	Serious prejudice	Ноцтой хохирол учруулж болзошгүй байх. Татаас нь бусад гишүүн улсуудын ашиг сонирхолд тодорхой нөлөөлөл үзүүлээд ирэх үед, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн агуулгын хүрээнд ийм нөхцөл байдал үүссэн байдаг байна. Өргөн утгаараа энэ нь дараах тохиолдлуудад үүсдэг. Үүнд: (a) тухайн бүтээгдэхүүнд олгосон нийт татаасны хэмжээ 5%-иас илүү гарах үед, (b) татаасыг тухайн аж үйлдвэрийн үйл ажиллагааны алдагдлыг нөхөх зорилгоор олгосон бол, (c) урт хугацааны шийдэл боловсруулах, нийгмийн хурц асуудлаас зайлсхийх боломжийг олгохын тулд үйл ажиллагааны зардлыг татаасаар нөхөх, (d) засгийн газарт төлөх ёстой өрийг шууд өршөөх зэрэг юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Гишүүн улс эдгээр тохиолдолд зохих арга хэмжээ авах ёстой. Ноцтой хохирол учруулна гэхээс илүү ноцтой хохирол учруулж болзошгүй олон нөхцөл байдлыг энэхүү гэрээнд тодорхойлсон байдаг. Хөдөө аж ахуйн талаарх ДХБ-ын хэлэлцээрийн дагуу хөдөө аж ахуйн татаас олгоход өөр өөр дүрмийг баримталдаг. Мөн Эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаас (actionable subsidies), хориглосон татаас (prohibited subsidies), татаасыг (subsidies) үзнэ үү.</p>
1192	Service dumping	<p>Үйлчилгээний демпинг. Энэ нь тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхэд татаас ашиглах, эсхүл ялгавартай үнийн зохицуулалтыг ашигласны улмаас үүсдэг. Үр дүнд нь өртөг зардлаас бага дүнтэй ачаа тээвэр нь экспортлогчид тухайн бүтээгдэхүүнийг газардах үеийн үнэнд тусгалаа олсон давуу талыг олгодог гэж үздэг. Тухайн бүтээгдэхүүн нь өөрөө газардах үедээ хэвийн хэмжээний үнэтэй байсан байж болно гэвч тээвэрлэлтийн үнийг бууруулсан байдал нь демпингийн татвар авахад хүргэж болно. Энэхүү үзэл баримтлалыг Гаванагийн дүрмийн төслийг боловсруулах ажлын нэг хэсэг нь болгон хэлэлцсэн боловч үүнийг өнөөгийн демпингийн эсрэг дүрэмд тусгаагүй болно. Мөн демпингийн эсрэг арга хэмжээг (anti-dumping measures) үзнэ үү.</p>
1193	Service mark	<p>Үйлчилгээний тэмдэгт. Энэ нь үйлчилгээтэй холбоотой худалдааны тэмдэгт бөгөөд үүнд тэмдэгт, үг, нэр эсвэл билэг тэмдэг эсвэл тэдгээрийг хослуулан ашиглаж болдог байна.</p>
1194	Services	<p>Үйлчилгээ. Үүнд цахилгаан харилцаа холбоо, банкны үйлчилгээ, даатгал, газрын болон усан замын тээвэр, нисэх хүчин, санхүү нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүй, инженерчлэл, үзвэр үйлчилгээ гэх мэт эдийн засгийн гол үйл ажиллагаанууд багтах бөгөөд өөрсдийн эрхийн хүрээнд үйлдвэрлэж болно эсвэл зарим бүтээгдэхүүний эсвэл өөр үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг болгон үйлдвэрлэж болдог. Австрали улсад, Австралийн Статистикийн товчооны (Australian Bureau of Statistics) ашигладаг арга зүйгээр тооцвол, үйлчилгээ нь хөдөлмөр эрхлэлтийн 80% ба Дотоодын нийт бүтээгдэхүүний (GDP) 75%-ийг эзэлдэг байна. Бусад улс орнуудад өөр өөр тоон харьцаатай байдаг бөгөөд зарим хэлбэлзэл нь эдийн засгийн үйл ажиллагаа явагдахад гардаг үндсэн ялгаанаас болж бус, харин статистикийн ондоо арга барилаас шалтгаалж гардаг байна. Үйлчилгээний чухал ач холбогдлыг тэр бүр олон нийтэд хүлээн зөвшөөрдөггүй байв. Адам Смитийн үзэж байснаар бол, “нийгэм дэх хамгийн хүндэтгэлтэй хэв журмын зарим хөдөлмөр нь зарц албат шиг, ямар ч үнэ цэнгүй бүтээмжгүй байдаг бөгөөд энэ нь уг хөдөлмөр хийгдэж дууссаны дараа тэсэж үлдэхээр, үүнд нь ижил хэмжээний хөдөлмөр худалдаж авч болохоор, ямар нэгэн байнгын харьяалал эсвэл арилжих боломжтой түүхий эд, материал болгон өөрийгөө тогтоон тодорхойлж эсвэл ашиг хонжоо олдоггүй байна. Нэгэн адил ангилалд хамгийн нөлөөтэй, хамгийн чухал болон хамгийн хөнгөн хийсвэр зарим мэргэжлүүдийн аль аль нь эрэмбэлэгдсэн байх ёстой, үүнд: сүмийн лам, хуульч, эмч оточ, бүх төрлийн оюуны хөдөлмөр эрхлэгч хувь хүмүүс; тоглогч,</p>

хошин шогийн жүжигчид, хөгжимчин, дуурийн дуучин, дуурийн бүжигчин гэх мэт орно.” Хэрэв, үйлчилгээний талаарх энэхүү үзэл бодлыг хойч үеийнхэн ухамсартайгаар хадгалж авч үлдээгүй бол, эдийн засагт тэдний гүйцэтгэх үүргийг дутуу үнэлэх хандлага байнга гарч байлаа. Үйлчилгээний талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт гэж байдаггүй байна. Хэд хэдэн арга барилыг туршиж үзсэн боловч тэдний аль нь ч бүрэн батлагдаж чадаагүй байна. Нэгдүгээрт, үйлчилгээг ихэвчлэн биет бус, үл үзэгдэгч, хадгалах боломжгүй гэж шинж чанарыг нь тодорхойлон байдаг тул нэгэн зэрэг үйлдвэрлэж мөн хэрэглэх шаардлагатай болдог байна. Эдгээр шинж чанарууд нь Адам Смитийн тэмдэглэлд далд утгаараа агуулагдсан байдаг. Гэвч, технологийн ахиц дэвшил нь үүнийг хуучирч хэрэгцээгүй болсон тодорхойлолт болгосон байдаг. Хоёрдугаарт, институтийн түвшний арга хандлагын зүгээс үзвэл анхдагч эсвэл хоёрдогч аж үйлдвэрлэлийн салбарын аль нэгэнд нь ангилагдаагүй аливаа зүйлийг үйлчилгээ байх ёстой болдог. Гуравдугаарт, Т.П.Хиллийн (1977) анх санаачлан чиг үүргийнх нь хувьд авч үзсэн арга хандлагад, тэрээр үйлчилгээг ийнхүү тодорхойлжээ, “Үйлчилгээ гэдэг нь эдийн засгийн зарим нэгжид хамаатай тухайн хувь хүн эсвэл бараа бүтээгдэхүүний нөхцөл байдалд гарсан өөрчлөлт бөгөөд энэ нь өмнөх хувь хүн эсвэл эдийн засгийн нэгжийн урьдчилж хэлэлцэн тохиролцсон хэлэлцээрийн дагуу эдийн засгийн бусад зарим нэгжийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрчлөлт юм”. Зарим хүмүүс энэхүү тодорхойлолтыг дутагдалтай гэж үздэг учир нь, энэ нь жишээлбэл, аюулгүй байдлыг хангах үйлчилгээ эсвэл урьдчилан сэргийлэх эм танг хамаардаггүй хэмээн гэж маргалддаг байна. Дөрөвдүгээрт, АНУ-ын Технологийн үнэлгээний алба (United States Office of Technology Assessment) хоёр төрлийн ангиллыг санал болгов: (a) мэдлэгт суурилсан үйлчилгээ [knowledge-based services] (даатгал, мэргэжлийн болон техникийн үйлчилгээ, банкны тодорхой үйлчилгээ, мэдээллийн технологийн үйлчилгээ гэх мэт), болон (b) гуравдагч шатанд хамаарах үйлчилгээ [tertiary services] (түрээслэх, тээвэрлэх, түгээх, онцгой эрх (franchising) олгох, жижиглэнгийн худалдаа, аялал жуулчлал гэх мэт). Үндэстнүүдийн ажил хэрэг (Works of Nations) хэмээх номонд, Роберт Рейх ажил мэргэжлээс хамааран үйлчилгээний гурван өөр төрлийг санал болгодог. Эхнийх нь, цэнхэр захтнуудын ажил мэргэжлийн хүрээнд хийгддэг олон талаараа угсран бүтээх ажил бүхий, стандарт журам болон кодчилсон дүрмээр удирдуулсан, байнга давтагддаг ажил үүргийг үүсгэж байдаг үйлдвэрлэлийн хэвшил болсон үйлчилгээ (routine production services) юм. Эдгээр үйлчилгээг дэлхийн хэмжээнд худалдаалах боломжтой. Тэрээр хоёр дах ангиллыг хувийн үйлчилгээ (in-person services) гэж нэрлээд энэ нь мөн адил энгийн бөгөөд байнга давтагддаг ажил үүргийг үүсгэдэг боловч тэдгээрийг зөвхөн хүнээс хүнд үйлчилж өгөх ёстой байдаг. Роберт Рейхийн хэлснээр, эдгээр үйлчилгээ үзүүлэгчид ихэвчлэн эелдэг харьцаатай байх ёстой бөгөөд

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>хэчнээн сэтгэл гонсойсон үед ч тэд үргэлж инээмсэглэж, өөртөө итгэх итгэл болон урам зоригийг илэрхийлж байх шаардлагатай. Гурав дах ангилал бол чухал билэг тэмдгийн утгатай-дүн шинжлэх үйлчилгээ (symbolic-analytic services) юм. Үүнд асуудлыг шийдвэрлэх, үүссэн асуудлыг тодорхойлох, болон стратегийн-зуучлалын үйл ажиллагаануудыг хамруулдаг. Эдгээрийг олон улсад худалдаалах боломжтой боловч эдгээр нь стандартчилагдаагүй болно. Үүнд бизнесийн, мэргэжлийн, санхүүгийн болон инженерчлэлийн олон үйлчилгээ багтдаг. Энэхүү ангиллын системийн жагсаалт нь бүхнийг хамаарсан эцсийн жагсаалт биш юм. Үйлчилгээний талаар харилцан тохиролцсон тодорхойлолт байхгүй байсаар байгаа нь үйлчилгээний үйлдвэрлэл болон худалдааны талаар олон тооны хэрэгтэй судалгаа бий болоход саад болсонгүй. Мөн үйлчилгээний худалдааны статистикийг (trade in services statistics) үзнэ үү.</p>
1195	<p>Set of Multilaterally Agreed Equitable Principles and Rules for the Conduct of Restrictive Business Practices</p>	<p>Бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг удирдан явуулахад зориулж, олон талт түвшинд хэлэлцэн тохиролцсон шударга зарчим ба дүрмийн багц. Мөн бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг (restrictive business practices) үзнэ үү.</p>
1196	<p>Sham litigation</p>	<p>Хуурамч зарга. Мөн үнийн бус түрэмгийлэл (non-price predation), Худалдааны дарамт шахалтыг (trade harassment) үзнэ үү.</p>
1197	<p>Shelf-life restrictions</p>	<p>Хадгалах хугацааны хязгаарлалт. Бүтээгдэхүүний чанар ба аюулгүй байдлыг хэвийн хэмжээнд хангаж, баталгаатай байлгаж чадаж байгаа тохиолдолд л тухайн бүтээгдэхүүнийг дэлгүүрүүдэд зарж борлуулсан хэвээр байх баталгаа гаргахын тулд, нэн ялангуяа хүнсний бүтээгдэхүүн, химийн бодис, эм, эм зүйн бүтээгдэхүүн гэх мэт зүйлсийг хамруулсан, ихэвчлэн нийтийн эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн зохицуулалтууд байдаг. Хэрэв тухайн бүтээгдэхүүний хадгалах хугацааг нь хиймлээр богиносгосон гэдгээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай цаг хугацаа шаардагдах тул гадаадын ханган нийлүүлэгчдийн хувьд уг зах зээлд нэвтрэхэд нь саад болох магадлалтай. Энэ нь тухайн бүтээгдэхүүнийг дэлгүүрийн лангуун дээр байлгах хугацааг богиносгодог бөгөөд илүү их хаягдал гарах магадлалтай тул импортлогчийн зардлыг нэмэгдүүлдэг байна. Энэ нь дэлгүүрүүдийг бараа бүтээгдэхүүнийг нөөцлөхийг нь саатуулах боломжтой. Тиймээс хадгалах хугацааны хязгаарлалт нь худалдаанд учрах техникийн саад тотгор болдог байна. Хадгалах хугацааг хязгаарлах учир шалтгаан нь янз бүр байдаг. Тэдгээр нь дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах хүсэл эрмэлзэл, эрүүл мэнд ба аюулгүй байдлын үүднээс хадгалах хугацаа тодорхой цаг хугацаанаас хэтрэхгүй байх ёстой гэсэн жинхэнэ итгэл үнэмшил, тодорхой төрлийн савлагааны үр нөлөөг хүлээн зөвшөөрөхөөс дургүйцэх, туршилтын шинэ аргачлалын хүчин төгөлдөр байдлыг хүлээн зөвшөөрөхөөс эргэлзэх зэрэг асуудлуудад үндэслэсэн байдаг юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1198	Sheltered industries	Хамгаалалттай аж үйлдвэрүүд. Энэ нь [өөрийн] аж үйлдвэрүүдийг олон улсын бүрэн хэмжээний өрсөлдөөнд өртүүлэхгүй байлгах нөхцөлийг хангасан хамгаалалтын тариф ногдуулсан байдаг тул тэд нар нь үр ашгийг нь хүртэж байдаг байна.
1199	Short-supply products	Нийлүүлэлтийн хувьд хомсдолтой бүтээгдэхүүн. Зарим тодорхой үл хамаарах зүйл бүхий, ТХЕХ-ийн 11-р Зүйл нь импортын болон экспортын квотыг хориглодог. Эдгээр үл хамаарах зүйлсийн нэг нь, экспортлогч оронд зайлшгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн эсвэл бусад бүтээгдэхүүний ноцтой хомсдолоос урьдчилан сэргийлэх, арилгахад түр хугацаагаар шаардлагатай байгаа бол экспортын квот олгохыг зөвшөөрдөг.
1200	Short-supply regulations	Нийлүүлэлтийн хувьд хомсдолтой бүтээгдэхүүний зохицуулалт. Энэ нь АНУ-ын демпингийн эсрэг арга хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор 1977 онд хэлэлцсэн эрх зүйн зохицуулалтын бүтэц, хамрах хүрээ. Ийм эрх зүйн зохицуулалтын мэтгэлцээний хувьд, аж үйлдвэрлэлийн зарим үйл ажиллагаа нь тэдний бүтээгдэхүүний борлуулалтыг хангаж ажиллахын тулд бүрэлдэхүүн хэсгүүдийн өрсөлдөхүйц ханган нийлүүлэлтээс хамааралтай байдаг гэдэг. Заримдаа эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд дотоодын эх үүсвэрээс хийгдэх нийлүүлэлт түр зуур дутагдалтай байдаг боловч үүний зэрэгцээ тэдгээрт демпингийн эсрэг журмыг тулгах боломжтой байдаг. Ийм нөхцөл байдлын хувьд, импортлогчийн үзлээр бол демпингийн эсрэг арга хэмжээг анхаарч үзэхгүй байх хэрэгтэй. Энэ нь аж ахуйн нэгжүүдийг импортолсон бүрэлдэхүүн хэсгүүдэд төлсөн доогуур үнээс үргэлжлүүлэн үр ашиг хүртэх боломжийг олгодог ба ийм арга замаар тэд өрсөлдөх чадвараа хангаж ажиллаж чаддаг байна. Энэ маргааныг эцэст нь хууль тогтоогчид няцаасан юм.
1201	Short-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textiles	Хөвөн даавуун нэхмэл, оёмол эдлэлийн олон улсын худалдаатай холбоотой богино хугацааны зохицуулалт. Нэхмэл, оёмол эдлэлийн томоохон экспортлогчид ба импортлогчдын хооронд эдгээр бүтээгдэхүүний худалдааг сонгомол тоон хязгаарлалтаар зохицуулах талаар ТХЕХ-ийн дагуу байгуулсан зохицуулалт юм. Энэ нь 1961 онд нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр болж, 1962 онд Хөвөн нэхмэл, оёмол эдлэлийн олон улсын худалдааны урт хугацааны зохицуулалтаар солигдсон бөгөөд энэ нь эргээд 1973 онд Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрээр (Multi-Fibre Arrangement) солигдсон юм. Эдгээр бүх зохицуулалт нь, тоон хязгаарлалтыг арилгахыг шаарддаг ТХЕХ-ийн 11-р Зүйлээс хэсэгчлэн цуцалсан явдал байлаа. Мөн сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний худалдааг дахин ДХБ-ын дүрмийн ердийн журмын дагуу хийх цаг хугацааны хуваарийг агуулсан сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийг (Agreement on Textiles and Clothing) үзнэ үү. SICA: Энэхүү Төв Америкийн интеграцчиллын тогтолцоог 1991 оны 12-р сарын 13-нд Белиз, Коста-Рика, Эль Сальвадор, Гватемал, Гондурас, Никарагуа, Панамагийн баталсан

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Тегусигалпагийн протоколоор байгуулсан. Энэ нь 1993 оны 2-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. SICA-гийн үндсэн зорилтууд нь Төв Америкийг нэгтгэснээрээ энх тайван, эрх чөлөө, ардчилал ба хөгжлийн бүс нутгийг бүтээн байгуулах явдал байлаа. Үүний нэг зорилго нь эдийн засгийн нэгэн төвлөрөл болгон бүс нутгаа бэхжүүлэх, Төв Америкийн санхүүгийн тогтолцоог сайжруулах явдал юм. Мөн Гватемал хотод байрладаг Төв Америкийн эдийн засгийн нэгтгэл/интеграцчиллын тухай ерөнхий гэрээний (General Treaty on Central American Integration) байнгын нарийн бичгийн дарга нарын газрыг (SIECA) үзнэ үү.</p>
1202	<p>SIECA (Secretaría de Integración Económica Centroamericana/the Permanent Secretariat of the General Treaty on Central American Integration)</p>	<p>Энэ нь Гватемал хотод байрладаг Төв Америкийн эдийн засгийн интеграцчиллын тухай ерөнхий гэрээний (General Treaty on Central American Integration) байнгын нарийн бичгийн дарга нарын газар. Уг ерөнхий хэлэлцээр нь 1961 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ нь Коста Рика, Сальвадор, Гватемал, Гондурас, Никарагуа, болон Панам зэрэг гишүүн улс орнуудаас бүрэлддэг. 1993 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Ерөнхий гэрээнд оруулсан Гватемалын протоколд SIECA-ийн зорилтуудыг шинэчлэн тодорхойлсон. Эдгээрт, эхлээд чөлөөт худалдааны бүсийг аажмаар байгуулах, дараа нь нийтлэг арилжааны бодлого, гаалийн холбоо, болон үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн чөлөөт хөдөлгөөнийг бий болгох гэх зэрэг бусад олон зорилтууд багтдаг. Мөн Төв Америкийн интеграцчиллын тогтолцоог (SICA) үзнэ үү.</p>
1203	<p>Simplified balance-of-payments consultations</p>	<p>Төлбөрийн тэнцлийн талаарх хялбарчилсан зөвлөлдөөн. Төлбөрийн тэнцлийн талаарх зөвлөгөөнийг (balance-of-payments consultations) үзнэ үү.</p>
1204	<p>Singapore Ministerial Conference</p>	<p>Сингапур дах Сайд нарын бага хурал. ДХБ-ын хүрээнд Сайд нарын түвшинд хоёр жилд нэг удаа зохиогддог олон улсын бага хурлын анхны уулзалт нь 1996 оны 12 дугаар сард зохион байгуулагджээ. Мөн Доха дах Сайд нарын бага хурал (Doha Ministerial Conference), Сиэтл дах Сайд нарын бага хурал (Seattle Ministerial Conference), ДХБ-ын Сайд нарын бага хурлыг (WTO Ministerial Conference) үзнэ үү.</p>
1205	<p>Single-column tariff</p>	<p>Нэг шатлалтай тариф. Бүх худалдааны түншүүдэд яг ижил байдлаар хандах буюу нэг шатлалтай тарифын жагсаалт гаргасан байдаг. Уг жагсаалт ямар нэгэн давуу эрхийг түнш орнуудад олгохгүй бөгөөд импортлогчдод хамгийн сайн ханган нийлүүлэгч олох боломжийг олгодог байна. Энэхүү тарифын шатлал нь олон талт худалдааны системийн хамгийн тохиромжтой бүтцийг илэрхийлнэ. Олон шатлалтай тариф (multi-column tariff) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1206	Single-desk selling	Нэг сувгаар борлуулах арга. Зарим улс орнуудад зар сурталчилгаа, борлуулалтын мэргэшсэн удирдах зөвлөлөөр дамжуулан гадаад улс орнуудад зар сурталчилгаа явуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортлох арга туршлагыг хэрэгжүүлдэг. Эдгээр нь ихэвчлэн экспортын заримдаа импортын монопол эрхтэй байдаг. Наанадаж зах зээлийн эдийн засагтай орнуудад тэд гол төлөв зах зээлийн дохионы хариуд арилжааны зарчмаар ажилладаг. Үүнийг ингэж ашигласан бол тэр аргыг улсын худалдаа гэхгүй.
1207	Single European Act	Нэгдсэн Европын хууль/акт (SEA). Энэ нь Европын хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудын хоорондын харилцааг Европын Холбоо болгон шинэчлэн өөрчлөх болон Европын эв нэгдэлд чиглэсэн бодитой ахиц дэвшил гаргахад хувь нэмэр оруулах зорилгоор, Ромын гэрээнд (Treaty of Rome) 1987 онд хийсэн нэмэлт өөрчлөлт. Гэхдээ уг хуулийн агуулга нь голчлон эдийн засгийн шинж чанартай. Энэ нь дотоодын зах зээл, санхүүгийн бодлого, нийгмийн бодлого, эдийн засаг ба нийгмийн уялдаа холбоо, судалгаа шинжилгээ ба технологи, болон хүрээлэн буй орчин зэрэг асуудлыг хамруулснаараа [Европын] Хамтын нийгэмлэгийн эрх зүйн бүрэн чадамжийг өргөжүүлсэн. Энэ нь Европын хамтын нийгэмлэг буюу Европын Холбооны нэгдсэн зах зээлийг (European Community Single Market) бий болгох боломжийг олгосон. Мөн, Нэгдсэн Европын хууль/акт (SEA) нь Европын хамтын нийгэмлэг болон Европын улс төрийн хамтын ажиллагааны (European Political Cooperation) хооронд албан ёсны холбоос үүсгэх зэрэг хуульчлан тогтоосон чухал өөрчлөлтүүдийг агуулсан байдаг.
1208	Single-firm behaviour	Ганц компанийн ажиллах горим. Энэ нь ихэвчлэн монополын эсрэг хууль эсвэл өрсөлдөөний тухай хуулиар зохицуулдаг компанийн ажиллах горимын асуудал. Үүний гол тодорхойлолтууд нь түрэмгийгээр үнэ тогтоох, үнийн ялгаварлан гадуурхал, болон найдвартай байдлын буцаан төлөлт (fidelity rebates) зэрэг юм.
1209	Single Market	Нэгдсэн зах зээл. Мөн Европын хамтын нийгэмлэг буюу Европын Холбооны нэгдсэн зах зээлийг (European Community Single Market) үзнэ үү.
1210	Single undertaking	Нэгдсэн үүрэг амлалт. Олон талт худалдааны хэлэлцээрийн хүрээнд баримтлах зарчим. Хэлэлцээрийн бараг бүх зүйл бүр нь түүний нэгдсэн, салшгүй хэсэг бөгөөд тэдгээрийг тус тусад нь тохиролцох боломжгүй. Өөрөөр хэлбэл, бүх зүйлийг л тохироогүй бол юу ч тохиролцоогүй гэсэн үг.
1211	SITC (Standard International Trade Classification)	Олон улсын худалдааны стандарт ангилал (ОУХСА - SITC). НҮБ-аас гаргасан барааны статистик ангилал. Мөн НҮБ-ын бүтээгдэхүүний үндсэн ангиллыг (UN Central Product Classification) үзнэ үү.
1212	Sliding-scale tariff	Гулсах боломжтой тариф. Энэ нь импортын бүтээгдэхүүний үнийн дүнгийн дагуу тарифын хувь хэмжээг тогтоох байдлаар гаргасан тарифын жагсаалт. Ихэнх тохиолдолд тухайн бүтээгдэхүүний үнэ өсөх тусам тарифын хувь хэмжээг гулсуулж өсдөг байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1213	Social Chapter	Нийгмийн бүлэг. Нийгмийн дүрмийг (Social Charter) үзнэ үү.
1214	Social Charter	<p>Нийгмийн дүрэм. Албан ёсны нэр нь Ажилчдын нийгмийн үндсэн эрхүүдийн тухай Хамтын нийгэмлэгийн дүрэм (Community Charter of Fundamental Social Rights for Workers). Үүнийг Их Британиас бусад Европын хамтын нийгэмлэгийн гишүүн орнууд 1989 оны 12 дугаар сард батлав. Уг дүрмийг, Маастрихтын гэрээнд (Treaty of Maastricht) бага зэрэг өөрчилсөн хэлбэрээр нэмж оруулсан бөгөөд тухайн үед бас Нийгмийн дүрэм гэж нэршдэг байсан. 1997 оны 6 дугаар сард Амстердам хотноо болсон Засгийн газар хоорондын бага хурлаар (Intergovernmental Conference) уг хавсралтыг гэрээний албан ёсны хэсэг болгох талаар санал нэгдсэн байна. Нийгмийн дүрэм нь Европын хамтын нийгэмлэгийн бүх иргэд дан ганц бизнесээс биш, Европын нэгдсэн зах зээлээс (European Single Market) үр ашиг хүртэх боломжийг хангахыг зорьж байгаа. Дүрэмд зөрчих эрх чөлөө (freedom of movement), хөдөлмөр эрхлэлт ба урамшуулалт цалин, амьдрах ба ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн хамгаалалт, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээр, тусгай мэргэжлийн сургалт, эрэгтэй ба эмэгтэй хүмүүст эрх тэгш хандах нөхцөл, ажилчдын мэдээлэл, зөвлөлдөөн болон оролцоо; ажлын байран дах эрүүл мэнд ба аюулгүй байдал, хүүхэд, өсвөр насныхан, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай зэрэг заалтуудыг агуулсан болно. Зарим нь энэхүү дүрмийг олон улсын байгууллагуудад худалдаа ба хөдөлмөрийн стандартын талаар хэлэлцэхэд нь зориулсан боломжийн загвар гэж үздэг байна.</p>
1215	Social clause	<p>Нийгмийн шинж чанартай заалт. Энэ нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ажил хөдөлмөрийн практик үйл ажиллагааг зөрчсөн нь тогтоогдсон гишүүн улс орнуудад ДХБ-ын арга хэмжээний хэлбэрээр худалдааны торгуулийг ногдуулж болох эсэх талаарх асуултад өгсөн товч хариулт. Нийгмийн тухай хуулийн заалт нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас (International Labour Organisation - ILO) боловсруулсан хамгийн доод хэмжээний хөдөлмөрийн зарим стандартыг мөрдөж чадаагүй экспортлогчдын эсрэг хориг арга хэмжээ авахыг зөвшөөрөх замаар экспортлогч улс орнуудын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилготой. Үүнийг хэрэгжүүлэх боломж болон хүсүүштэй байдлын хувьд одоогоор ямар нэгэн хэлэлцээрт хүрээгүй байгаа ч, бусад чуулга уулзалтууд дээр үүнтэй ижил төстэй арга хэмжээнүүдийг бараг зуу гаруй жилийн турш ярьсаар байсан байна. Уг нийгмийн хуулийн заалтын талаар 1996 оны 12 дугаар сард болсон ДХБ-ын Сингапурын сайд нарын бага хурлаар (WTO Singapore Ministerial Conference) хэлэлцэж, хөдөлмөрийн стандартыг ОУХБ-ын (ILO) асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Гэсэн хэдий ч, 1954 оны элсэн чихэр ба цагаан тугалганы тухай олон улсын хэлэлцээрийг дахин дурсахад зүйтэй байх. Уг хэлэлцээрт, тухайлбал, холбогдох бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оролцож буй ажил хөдөлмөрийн хувьд шударга</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>урамшуулалт цалин, нийгмийн хамгааллын тэтгэмж болон бусад шаардлага хангасан нөхцөлийг хүртэхэд чиглэсэн “шударга хөдөлмөрийн стандарт” (“fair labour standards”) гэх заалтыг оруулсан байдаг. 1975 оны Дэлхийн Хөдөлмөр эрхлэлтийн тухай бага хурлаар (World Employment Conference) хөгжиж буй орнуудын өрсөлдөх чадвар нь шударга хөдөлмөрийн стандартыг золиослох замаар бий болох ёсгүй гэж үзсэн. Мөн, үүнээх дөрвөн жилийн дараа нийтлэгдсэн, Брендтийн анхны тайланд (first Brandt Report) худалдааны либералчлалыг хөнгөвчлөх үүднээс шударга хөдөлмөрийн стандартыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх шаардлагатай гэж зөвлөсөн байна. Мөн хүүхдийн хөдөлмөр (child labour), түүхий эд, материалын олон улсын хэлэлцээрүүд (international commodity agreements), худалдаа ба хөдөлмөрийн стандарт хэм хэмжээ (trade and labour standards), болон ажилчдын эрхийг (workers rights) үзнэ үү.</p>
1216	Social conditionality	<p>Нийгмийн шинж чанартай болзолт нөхцөл. Энэ нь худалдааны дүрмүүдэд нийгмийн зорилтуудыг хавсаргах бөгөөд нийгмийн тодорхой зан заншил, уламжлалыг дагаж мөрдөх нөхцөлтэй эдгээр дүрмүүдийг дагаж мөрдөх юм. Мөн худалдаа ба хүний эрх (trade and human rights), худалдаа ба хөдөлмөрийн стандартыг (trade and labour standards) үзнэ үү.</p>
1217	Social dimension of the liberalisation of international trade	<p>Олон улсын худалдааг либералчлах нийгмийн хэмжигдэхүүн. Энэ бол олон улсын худалдааг либералчлах замаар хийгдэж буй бүтцийн өөрчлөлтийн зүгээс хүмүүст үзүүлж буй нөлөөллийн талаарх агуулга юм. Энэхүү өөрчлөлтийн үр дүн хүн бүрд ашиг тусаа өгдөггүй, хөдөлмөрийн стандартыг хангаагүй улс орнуудын ажилчдын үйлдвэрлэсэн барааны импортоос болоод тодорхой төрлийн ажил мэргэжлийн хүрээний ажилчид аюулд өртдөг гэсэн санаа бодлыг үндэслэсэн байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллага энэхүү сэдвийг судалж үзэхээр ажлын хэсэг байгуулан ажилласан. Мөн хөдөлмөрийн үндсэн стандарт, хэм хэмжээ (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), худалдаа ба хөдөлмөрийн стандарт, хэм хэмжээг (trade and labour standards) үзнэ үү.</p>
1218	Social dumping	<p>Нийгмийн шинж чанартай демпинг. Энэ нь шоронгийн хоригдол, эсхүл хөлсний ажилчдын хүчээр үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг маш хямд үнээр экспортлох үед үүссэн гэж үзэж буй үйл ажиллагааны тодорхойгүй нэр томьёо. Гаванаагийн дүрмийн хэлэлцээрт оролцсон зарим оролцогчдын тодорхойлсноор бол энэ нь демпингийн хуурамч ангиллуудын нэг юм. Энэ төрөлд хамаарна гэж үзэж байгаа демпингд зориулсан ямар нэгэн дүрэм журам байхгүй бөгөөд энэ нь худалдааны хүлээн зөвшөөрөгдсөн бодлого биш юм. ТХЕХ нь 20(д)-р зүйлд шоронгийн хөдөлмөрөөр хийсэн бараа бүтээгдэхүүнийг хамарсан Эс хэрэглэх ерөнхий зүйлийг агуулсан байдаг. Харьцангуй сүүлийн үед “нийгмийн чанартай демпинг” хэмээх нэр томьёог техникийн бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүний хувьд стандарт хэм хэмжээг баримтлаагүй нөхцөлд үйлдвэрлэж, экспортолсон гэж үздэг бүтээгдэхүүнүүдийг ашиглах болсон нь хөгжингүй орнуудад</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>давамгайлах болсон. Мөн демпинг, ядуугийн тэтгэмжээр амьдрагчдын хөдөлмөрийн тухай мэтгэлцээн (pauper-labour argument), нийгмийн шинж чанартай заалт (social clause), худалдаа ба хөдөлмөрийн стандарт хэм хэмжээ (trade and labour standards), ажилчдын эрхийг (workers rights) үзнэ үү.</p>
1219	Social labelling	<p>Нийгмийн шинж чанартай шошгожуулалт. Энэ нь хөдөлмөрийн шударга стандарт, хэм хэмжээний нөхцөлийг баримтлан ажилласан гэдгийг илэрхийлэхийн тулд тухайн бүтээгдэхүүн дээр шошго, тэмдэглэгээг хавсаргах практик туршлага. Энэ талаар ямар нэгэн олон улсын дүрэм журам байдаггүй бөгөөд зарим хүмүүсийн үзэж байгаагаар бол нийгмийн шинж чанартай шошгожуулалт нь зарим аж үйлдвэрийн салбаруудыг хамгаалахын тулд эмзэг бүтээгдэхүүнийг ялгаварлан гадуурхах эхний алхам байх болно хэмээн эмээдэг ажээ. Энэ санааг дэмжигчид үүнийг ийм зорилготой зүйл биш юм гэдэг. Хивсэнцрийн тэмдэглэгээ нь сайн дурын шошгожуулалтын нэг жишээ юм. Ийм шошгыг хавсаргасан бүтээгдэхүүнийг хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүйгээр хийдэг. Мөн эко-шошгожуулалт (eco-labelling), генетикийн шинж чанартай шошгожуулалт (genetic labelling), нийгмийн шинж чанартай шошгожуулалтыг (social labelling) үзнэ үү.</p>
1220	Social regulation	<p>Нийгмийн дэг журам, зохицуулалт. Дэг журам, зохицуулалтын (regulation) талаар үзнэ үү.</p>
1221	Socially-responsible investing	<p>Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт. Энэ нь хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад ёс зүйн болон эдийн засгийн шалгуурыг харгалзан үзэх арга туршлага юм.</p>
1222	Social subsidies	<p>Нийгмийн шинж чанартай татаас. Зарим хүмүүс, засгийн газрууд нь ялангуяа экспортын баримжаатай аж үйлдвэрүүдэд олон улсын түвшинд хэрэглэдэг түвшингээс доогуур түвшний хөдөлмөрийн стандарттай байхыг зөвшөөрөх үед эсвэл тэд өөрсдийн стандартаа хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд эдгээр нийгмийн шинж чанартай татаас бий болдог гэж үздэг. Үр дүнд нь эдгээр арга туршлагаас үр ашиг хүртэж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардал илүү бага болдог гэсэн ойлголтыг экспортын шууд бус татаас гэж үздэг. Гэвч дүн шинжилгээнээс үзвэл хөдөлмөрийн доогуур түвшний стандарт нь экспортын өрсөлдөх чадварт багахан нөлөөтэй ба үнэндээ энэ нь үүнд саад болж болзошгүйг харуулж байна. Нийгмийн шинж чанартай татаас нь худалдааны бодлогын үгийн санд байдаг нэр томьёо ч биш. Мөн хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээ (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), ядуугийн тэтгэмжээр амьдрагчдын хөдөлмөрийн тухай мэтгэлцээнийг (pauper-labour argument) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1223	Soft law	<p>Зөөлөн эрх зүй. Энэ нь олон улсын эрх зүйн зохицуулалтад агуулагдсан арга хэмжээг түүнд элсэж орсон талуудаас хэрэгжүүлэхийг шаарддаггүй олон улсын эрх зүйн зохицуулалт гэсэн утгатай, худалдааны бодлогод зөөлөн эрх зүй хэмээн хэлэгддэг ярианы маяг. Өөрөөр хэлбэл, тэдгээр нь сургамжилсан зохицуулалт юм. Зөөлөн эрх зүйд хүргэсэн эрх зүйн актуудын жишээ бол НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) ивээл дор хэлэлцэн тохиролцсон 'Бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг хянах Олон талт түвшинд тохиролцсон шударга зарчим ба дүрмийн багц' (Set of Multilaterally Agreed Equitable Principles and Rules for the Control of Restrictive Business Practices) болон Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжийн талаар ЭЗХАХБ-ын зааварчилгаа (OECD Guidelines for Multinational Enterprises) зэрэг байна. Хэрэв зохих ёсоор батлагдсан тохиолдолд, хуулиар үүрэг хүлээж, заавал биелүүлэх шаардлагагүй хууль ёсны эрх зүйн актууд нь шинэ хэм хэмжээг бий болгоход хүргэж болзошгүй гэдэг ойлголт олон улсын хуулиар мэргэшсэн зарим эрх зүйчдийн дунд байдаг. Мөн хатуу эрх зүйг (hard law) үзнэ үү.</p>
1224	South	<p>Өмнө зүг. Хөгжиж буй орныг (developing country) үзнэ үү.</p>
1225	South Asian Association for Regional Cooperation	<p>Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбоо (SAARC). Энэ нь 1985 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулагдсан бөгөөд Бангладеш, Бутан, Энэтхэг, Мальдив, Непал, Пакистан, Шри Ланка гэх гишүүн улс орнуудаас бүрэлддэг байна. SAARC-ны зарим зорилгуудаас дурдахад тус бүс нутгийн эдийн засгийн хурдацтай өсөлт болон эдийн засгийн салбарт идэвхтэй хамтын ажиллагаа явуулах явдал юм. Үүнтэй холбогдуулан, 1993 онд Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбооны Худалдааны хөнгөлөлттэй зохицуулалтын (SAPTA: SAARC Preferential Trading Arrangement) суурь хэлэлцээрийг батлан холбооны гишүүд гарын үсэг зурсан байна. SAARC-ӨАЗБХАХ-ны Нарийн бичгийн дарга нарын газар нь Дакка хотод байрладаг.</p>
1226	Southern African Customs Union	<p>Өмнөд Африкийн гаалийн холбоо (ӨАГХ - SACU). Энэ нь анх 1910 онд байгуулагдсан бөгөөд 1969 онд үйл ажиллагаагаа шинээр эхлүүлсэн. Ботсвана, Лесото, Намиби, Өмнөд Африк, Свазиланд гэх зэрэг улс орнуудаас бүрэлддэг. Энэ нь түнш орнуудын хоорондох бараа бүтээгдэхүүний чөлөөт урсгалыг хамаарч байдаг. Гишүүн бүс орнуудын эсрэг нэгдсэн гадаад тариф хэрэглэгддэг. Гишүүд харилцан тохиролцсон орлого хуваалцах томьёоны дагуу гаалийн орлогыг хувааж авдаг байна. ӨАГХ-д байнгын үйл ажиллагаатай Нарийн бичгийн дарга нарын газар гэж байдаггүй.</p>
1227	Southern African Development Community	<p>Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэг (SADC). Үүнд найман жилийн дотор тарифыг арилгахыг эрэлхийлж, 1996 онд чөлөөт худалдаа байгуулах протоколын дагуу энэхүү холбоонд Ангол, Ботсвана, Ардчилсан Конго, Лесото, Малави, Маврикий, Мозамбик, Намиб, Сейшел, Өмнөд Африк, Свазиленд, Танзани, Замби ба Зимбабве гэсэн Өмнөд Африкийн арван дөрвөн улс орон нэгдсэн байна. Үүнд худалдааг либералчлах буюу чөлөөлөх бусад арга хэмжээг мөн тусгасан байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1228	Southern Common Market	Өмнөд Америкийн нэгдсэн зах зээл. MERCOSUR-ыг үзнэ үү.
1229	South Pacific Forum	Өмнөд Номхон далайн чуулга уулзалт. Энэ нь 1971 онд Веллингтон хотод болсон уулзалтын үеэр байгуулагдсан байгууллага. Энэ нь Австрали, Кук арлууд, Микронезийн Холбооны Улс, Фижи, Кирибати, Маршаллын арлууд, Науру, Шинэ Зеланд, Ниуэ, Палау, Папуа Шинэ Гвиней, Самоа, Соломоны арлууд, Тонга, Тувалу, Вануату гэх зэрэг улс орнуудаас бүрэлддэг. Энэ нь бүс нутгийн улс төр болон эдийн засгийн асуудлуудыг хамардаг ба үүнд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг илүү ойртуулах зорилгыг хамруулсан байдаг. Уг байгууллагад бичгээр үйлдсэн дүрэм байхгүй. Түүний нарийн бичгийн дарга нарын газар нь Сува хотод байрладаг. 2000 онд Номхон Далайн арлуудын чуулга уулзалт (Pacific Islands Forum) гэж нэрийг нь өөрчилсөн.
1230	South Pacific Regional Trade and Economic Cooperation Agreement	Өмнөд Номхон Далайн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр. SPARTECA-г үзнэ үү.
1231	South-South trade	Хөгжиж буй улс орнуудын хоорондын худалдаа. Энэ нь хөгжиж буй орнуудын хоорондын худалдаа болон дагалдах худалдааны бодлогын асуудлууд юм. Мөн Хөгжиж буй орнууд хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа (ECDC), Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн системийг (GSTP) үзнэ үү.
1232	Spaghetti-bowl effect	Шпагетти гоймонтой аяганы нөлөө. Жагдиш Багвати нь энэхүү нэр томьёог, чөлөөт худалдааны хэлэлцээрийг өргөжүүлэхийн хойноос хөөцөлдсөний улмаас буй болсон худалдааны дүрэм журмын нарийн төвөгтэй байдлыг тайлбарлахад ашиглажээ. Үүний ердийн жишээ бол чөлөөт худалдааны хэлэлцээр бүрд өөр өөр гарал үүслийн дүрмүүд үйлчилж байдаг явдал юм. Ийм төрлийн нэгээс илүү зохицуулалтын гишүүн болсон улс орнуудын хувьд тус бүрд нь өөр өөр дүрмийг мөрдөх шаардлагатай болж магадгүй юм.
1233	SPARTECA (South Pacific Regional Trade and Economic Cooperation Agreement)	Өмнөд Номхон далайн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр. Энэхүү хэлэлцээр нь 1981 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон бөгөөд Номхон далайн өмнөд хэсэгт байрладаг улс орнуудад Австрали болон Шинэ Зеланд улсууд руу хөнгөлөлттэй харилцан адил байх шаардлагагүй нөхцөлөөр нэвтрэх (preferential non-reciprocal access) боломжийг олгодог. Австралийн зах зээлд элсэн чихэх нэвтрүүлэх боломжийг хассан байдаг. Мөн тэгш хэмт бус худалдааны хэлэлцээр (asymmetrical trade agreements) болон Австралийн тарифын хөнгөлөлтийн тогтолцоог (Australian System of Tariff Preferences) үзнэ үү.
1234	Special Agreement on Commodity Arrangements	Түүхий эд, материалын зохицуулалтын тухай тусгай хэлэлцээр (SACA). Энэ нь анхдагч түүхий эд, ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хэрэглээний тэнцвэргүй байдал бүхий зах зээлийн гаднах ердийн хүчин

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>зүйлстэй харьцаж ажиллах хэлэлцээрт зориулан 1955 оны эхээр ТХЕХ-ийн гэрээлэгч талуудын дунд гарч ирсэн санал. SACA нь хэдийгээр ТХЕХ (GATT) болон SACA хоёрын эрх зүйн харилцаа нь яг ямар байх ёстой вэ гэдгийг хэзээ ч тодорхойлж байгаагүй боловч SACA нь ТХЕХ-ийн хажууд зэрэгцэн оршиж байх ёстой байсан. Анхандаа олон чухал түүхий эд, материалын худалдаачид наймаачдын дунд дэмжиж байсан боловч түүхий эдийн хамгийн том худалдаа эрхлэгч АНУ-ын зүгээс үл тоомсорлож байсан байдал нь үүний бүтэц болон бусад асуудлын хувьд хоорондоо зөрчилтэй олон өөр үзэл бодол үүсэхэд хүргэсэн байдаг. Зарим нь анхдагч түүхий эд материалын худалдаатай холбоотой асуудлыг зөвхөн ТХЕХ-ийн хүрээнд шийдвэрлэх ёстой гэж үзэж байсан байна. Энэ санал жилийн эцэс гэхэд өнгөрөн одсон байлаа. Түүнчлэн хөдөө аж ахуй ба ТХЕХ (agriculture and the GATT), ТХЕХ-ийг хянан нягтлах хуралдааныг (GATT review session) үзнэ үү.</p>
1235	Special and differential treatment	<p>Тусгай болон ялгавартай нөхцөл. Ихэвчлэн S+D гэж нэрлэдэг. Энэ нь хөгжиж буй орнуудын экспорт нь хөгжингүй орнуудын зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломжийг олгох ёстой бөгөөд худалдааны хэлэлцээнд оролцож байгаа хөгжиж буй улс орнууд нь хөнгөлттэй нөхцөл хүлээж авсныхаа хариуд бүрэн хэмжээнд харилцан адил байх зарчмыг баримтлах шаардлагагүй гэсэн ойлголт. Мөн S+D-ийн дагуу хөгжиж буй орнууд шинэ дүрмийг хэрэгжүүлэх үе шатыг илүү урт хугацаанд хэрэгжүүлэх эрхийг эдэлж мөн тус дүрмийг дагаж мөрдөх илүү доогуур түвшний үүрэг хариуцлага хүлээх боломжтой байдаг. Мөн хөгжиж буй орнууд ба ТХЕХ (developing countries and the GATT), зөвшөөрөгдөх заалт (Enabling Clause), Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP), нэн буурай хөгжилтэй орнууд (least-developed countries), ТХЕХ-ийн 4 дүгээр хэсэг (Part IV of the GATT) болон харилцан адил байхыг (reciprocity) үзнэ үү.</p>
1236	Special protection	<p>Тусгай хамгаалалт. Үүнийг, Америкийн нэгэн онцгой үзэгдэл гэж зарим Канадууд үздэг байна. Энэ нь улс төрийн утгаараа зарим, ялангуяа хүчирхэг үйлдвэрүүд гадаадын өрсөлдөгчдийг хяналтдаа байлгахын тулд худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ авах шаардлагагүй болж магадгүй гэсэн үг. Үүний оронд тэднийг конгрессын хүчтэй дарамтаар бэхжүүлсэн гүйцэтгэх засаглалаар дамжуулан “тусгай хамгаалалт” авах боломжтой гэж үздэг.</p>
1237	Special safeguards	<p>Тусгай хамгаалалтын арга хэмжээ. Тарифын бус арга хэмжээг тарифын хамгаалалтын арга хэмжээнд шилжүүлсэн ДХБ-ын гишүүн улс орнуудад Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн дагуу ашиглах боломжтой тогтолцоо. Хэрэв импортын хэмжээ нь тодорхой заасан болзолт үнийн түвшингээс даваад хэтрэх, эсхүл импортын барааны үнэ нь болзолт үнийн хэмжээнээс доогуур унах үед [ДХБ-ын] гишүүн улс орнуудыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дээр нэмэлт тариф ногдуулахыг зөвшөөрдөг байна. Тиймээс тусгай хамгаалалтын арга хэмжээ нь импортын хэмжээ огцом өсөх тохиолдолд мөн адил үйлдвэрлэгч орнуудын хувьд аюулгүй байдлын орон зайг хангаж өгдөг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тэдгээрийг ил тод байдлаар нэвтрүүлэхээр анхнаас нь бодож боловсруулсан байдаг. Мөн хамгаалалтын арга хэмжээ (safeguards), (selectivity), тарифжуулалт (tariffication), шилжилтийн үеийн хамгаалалтын арга хэмжээг (transitional safeguards) үзнэ үү.
1238	Special-structure countries	Онцгой бүтэцтэй орнууд. Олон талт худалдааны Кеннедигийн үе шатны хэлэлцээний (Kennedy Round) үеэр Австрали, Канад, Шинэ Зеланд болон Өмнөд Африк зэрэг улс орнуудад өгсөн нэр. Эдгээр дөрөв нь тохиролцсон ёсоор нэхэмжлэл гаргахдаа, дараах үндэслэлээр тарифын хувь хэмжээг шугаман зарчмын дагуу хасах хэлэлцээний хувьд ондоо байр суурьтай байв. Үүнд: тэдгээр улсын аж үйлдвэрийн салбар нь бага тарифтайгаар орж ирдэг аж үйлдвэрүүдийн импортын бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөж чадах түвшинд хүртэл хөгжиж чадаагүй байгаа бөгөөд шугаман зарчмын арга барил нь тэдний гол экспортын зах зээлүүд дэх хөдөө аж ахуйн салбарынх нь хамгаалалтын түвшинг бууруулж чадахгүй юм гэсэн үндэслэлүүд байв. Энэ тохиолдолд тэд тарифын хэлэлцээнд голчлон тухайн бараа тус бүрээр хэлэлцэх арга барилыг баримталсан байна.
1239	Specific reciprocity	Тусгай хэлбэрээр харилцан адил байх. Толины тусгал мэт харилцан адил ашигтай байхыг (mirror-image reciprocity) үзнэ үү.
1240	Specific subsidy	Тусгайлсан татаас. Энэ нь Зөвхөн тодорхой аж ахуйн нэгж, аж үйлдвэрлэл эсвэл аж ахуйн нэгж, аж үйлдвэрлэлийн нэгэн бүлэгт ашиглах боломжтой татаасыг тайлбарлахын тулд, ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт ашигласан нэр томьёо. Хэрэв тусгайлсан татаас нь ДХБ-ын өөр нэг гишүүн орны дотоодын аж үйлдвэрлэлийн салбарт хохирол учруулсан бол түүнийг хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаас гэж үзнэ.
1241	Specific tariff	Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон тариф. Энэ нь импортын барааны үнээс үл хамааран түүний нэгж (ширхэг, литр гэх мэт) тутамд тогтоосон дүнгээр тооцож татвар ногдуулах хэлбэр. Жишээ нь ямар үнэтэй байхаас үл хамааран компакт дискний ширхэг бүрээс нэг ам доллар, гахайн махны 100 кг тутам 10 долларын татвар авах гэх мэт. Барааны үнийн дүнгээс хувиар тооцох тариф (ad valorem tariff) үзнэ үү.
1242	Springboarding	Трамплинаар гулгах арга буюу патентын хамгаалалтад байсаар байгаа зүйлийг арилжааны зориулалттай үйлдвэрлэлд оруулж, борлуулалт хийхээр тухайн аж ахуйн нэгж бэлтгэж эхлэх гэсэн үг. Мөн Патентгүйгээр гулгах аргыг (generic springboarding) үзнэ үү.
1243	Spurious dumping	Хуурмаг демпинг. Энэхүү нэр томьёог Жэйкоб Винер “Демпинг: олон улсын худалдаан дах асуудал” судалгааны бүтээлдээ ашигласан байдаг. Янз бүрийн өөр зах зээлд хэрэглэгдэж байгаа үнийн зөрүүтэй байдал нь, үнийг ухамсартайгаар ялгаварлан тогтоосон гэхээсээ илүү, захиалгын янз бүрийн хэмжээ, зээлийн эргэн төлөгдөх хугацаа, зээлийн эрсдэлийн цар хүрээ, борлуулалтын аргачлал, тухайн зах зээлтэй холбоотой тээврийн болон сав баглаа боодолд тавигддаг шаардлагууд зэргийн үр дүнгээс хамаарч тогтдог нөхцөл байдлыг тайлбарласан.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1244	STABEX (Stabilization of Export Earnings)	<p>Экспортын орлогыг тогтворжуулах систем. Үүнийг АСР-ын бүсийн улс орнуудын экспортын орлогыг тогтворжуулах зорилготой Европын Комиссын нөхөн олговрын санхүүжилтийн схем (STABEX) гэдэг. Энэхүү схем нь Ломе-ийн конвенцоор дамжуулан Европын хамтын нийгэмлэгтэй холбогдсон хөгжиж буй орнуудын экспортын орлогыг тогтвортой байлгахыг эрэлхийлсэн Ломе-ийн Конвенцын дагуу байгуулагдсан байдаг. Энэхүү схемд хөгжиж буй орнуудын ашиг сонирхлыг илэрхийлсэн экспортын 49 төрлийн түүхий эд, материал болон түүхий эд, материалаар хийсэн бүтээгдэхүүнийг хамруулсан байдаг. Энэ нь, хэрвээ тэд нийт орлогынхоо ихээхэн хэсгийг зөвхөн нэг бүтээгдэхүүнээс олдог бол тэдний Европын хамтын нийгэмлэгтэй хийдэг худалдаанд нь учирсан экспортын орлогын тасалдлыг нөхөн төлөх/нөхөн олговор олгох зорилготой юм. Ерөнхий тогтсон дүрмээр бол тэдний хараат байдлыг илтгэх босго үзүүлэлт нь 5% бөгөөд харин нэн буурай хөгжилтэй оронд бол 1% байдаг. Нөхөн олговрыг буцалтгүй тусламж хэлбэрээр олгодог. Үүнд тавигддаг нөхцөл нь хязгаарлагдмал байдаг бөгөөд гол зорилго бол уг санхүүжилт нь бэрхшээлийг үүсгэж байгаа уг салбарт бодитоор ашиглах нөхцөлийг баталгаажуулж ажиллах явдал юм. Энэхүү боломжийг хүртэх нөхцөл нь ихэвчлэн энэхүү зорилгоор хэлэлцэж тохиролцсон Харилцан үүрэг хүлээх хоёр талт эрх зүйн бүтэц, хамрах хүрээнд тодорхойлж өгсөн байдаг. Мөн Түүхий эд, материалын нийтийн/хамтын сан (Common Fund for Commodities), нөхөн олговрын санхүүжилтийн зохицуулалт (compensatory financing arrangements), Ашигт малтмалын олборлолт ба экспортыг дэмжих систем буюу Уул уурхайн бүтээгдэхүүнүүдээс олох экспортын орлогыг тогтворжуулах системийг (SYSMIN) үзнэ үү.</p>
1245	Staging	<p>Шатлал / үе шат. Энэ нь нэг талт эсвэл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хуваарийн дагуу тарифыг бууруулах эсвэл худалдааг чөлөөлөх арга хэмжээг нэвтрүүлэх үе шат юм.</p>
1246	Standards	<p>Стандарт хэм хэмжээ. Энэ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний техникийн нэгдсэн үзүүлэлт болон онцлог шинж чанарыг нь хангаж өгөх аргачлал. Энэхүү аргачлалыг ерөнхийд нь техникийн стандарт (жишээ нь хамгийн бага эсвэл хамгийн дээд хэмжээ, өнгө, найрлага гэх мэт) эсвэл гүйцэтгэлийн стандарт (бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ нь дор хаяж тодорхой чадвартай байх ёстой) гэж хуваагддаг байна. Үүнд нэмж дурдахад, стандарт нь зайлшгүй эсвэл сайн дурын байж болдог байна. Мөн Худалдаан дах техникийн саад тоггорын тухай хэлэлцээр (Agreement on Technical Barriers to Trade), тохирлын үнэлгээ (conformity assessment), Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission), Олон улсын стандартчиллын байгууллага (International Organisation for Standardisation), СОУБ 9000 (ISO 9000), СОУБ 14000-г (ISO 14000) үзнэ үү.</p>
1247	Standards code	<p>Стандарт хэм хэмжээний код. Токиогийн үе шатны хэлэлцээрүүд (Tokyo Round agreements), Худалдаан дах техникийн саад тоггорын тухай хэлэлцээрийг (Agreement on Technical Barriers to Trade) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1248	Standstill	Зогсонги байдал. Энэ нь тодорхой өдрөөс ялангуяа энэхүү үүрэг амлалт авсан өдрөөс хойш худалдааны шинэ эсвэл илүү хязгаарласан арга хэмжээ ногдуулахгүй байх үүрэг амлалт. Зогсонги байдлыг ихэнхдээ өмнөх төлөв рүү буцах үйлдэлтэй (rollback) хослуулсан байдаг.
1249	State trading	Төрийн зүгээс хийх худалдаа. Төрийн зүгээс хийх худалдааны үндсэн хоёр төрөл байдаг. Нэгдүгээрт, зах зээлийн эдийн засагтай улс орнуудад төрийн өмчит, төрийн хяналттай эсвэл төрөөс олгосон тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд олон улсын худалдаа эрхэлдэг бөгөөд энэ хүрээнд заримдаа тодорхой бүтээгдэхүүний хувьд онцгой эрхтэйгээр худалдаа эрхэлдэг. Аж ахуйн нэгжүүд ердийн арилжааны компани шигээр худалдаа эрхэлдэг ба зах зээлийн зүгээс ирж буй дохио мэдээлэлд хариу үйлдэл үзүүлж ажилладаг. Хоёрдугаарт, төрийн зүгээс хийх худалдаа нь импортын болон экспортын талаар шийдвэр гаргахад үнэ гэдэг нь цорын ганц эсвэл давамгайлан авч үзэхээр хүчин зүйл биш байж болдог зах зээлийн бус эдийн засгийн нэг онцлог шинж чанар. Энэ тохиолдолд ихээхэн хэмжээний зах зээлийн гажуудал үүсэж, ил тод байдал бага байдаг. Төрийн зүгээс хийх худалдааг засгийн газрын өөрийнх нь хэрэгцээнд зориулан худалдан авалт хийдэг засгийн газрын худалдан авалтаас ялгаж авч үзэх ёстой. Мөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орнууд (centrally-planned economies), маркетинг, борлуулалтын удирдах зөвлөл (marketing boards), нэг сувгаар борлуулах аргыг (single-desk selling) үзнэ үү.
1250	State-trading dumping	Төрийн эзэмшлийн компанийн демпинг (State-trading dumping) – Хатуу валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилго бүхий демпинг. Демпинг (dumping) тухай үзнэ үү.
1251	Statism	Статизм буюу төрийн онол. Энэ нь үндэсний эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжихэд төрийн чухал ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн онолууд болон бодлогууд юм. Статизм нь хэт их дүрэм журам гэдэгтэй ойролцоо утгатай биш ч боловч, ихэнхдээ тэр зүгт чиглүүлж байдаг байна.
1252	Stolper-Samuelson theorem	Столпер-Самуэлсонийн теорем. Энэ нь 1941 онд Вольфганг Столпер ба Паул Самуэлсен нарын эдийн засагчид гаргасан санал. Энэ нь тодорхой төсөөллийн хүрээнд (хамгийн гол нь газар болон хөдөлмөр эрхлэлт нь үйлдвэрлэлийн цорын ганц хүчин зүйлс гэдэг) ямар ч худалдаагүй байдлаас чөлөөт худалдаа руу шилжих нь, үнэ өсөх нь ажиглагддаг экспортын аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэлийг эрчимтэй ашиглагддаг хүчин зүйл руу чиглэдэг, орлого өсөн нэмэгдэхэд хүргэдэг болохыг харуулдаг. Эсрэгээрээ, ийм алхам хийх нь үнэ буурахад нөлөөлж, тус салбарт эрчимтэй ашиглагдсан хүчин зүйлийн [хөрөнгө оруулалтын] өгөөж буурахад хүргэх болно. Мөн харьцангуй давуу тал (comparative advantage), Хеккер-Охлиний теорем (Heckscher-Ohlin theorem), Леонтиевын парадоксыг (Leontief Paradox) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1253	Strategic business alliances	Стратегийн бизнесийн холбоотнууд (СБХ - SBAs). Энэ нь аж ахуйн нэгжүүдийг нийтлэг зорилгын төлөө ажиллахыг шаардсан, тэдний хоорондох хамтын ажиллагааны зохицуулалт юм. Ерөнхийдөө ийм холбоотны түншүүд өөр бусад түншүүдэд хөрөнгө оруулалт хийдэггүй байна. Хэрэв хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд, нөгөө талдаа маш бага хувь эзэмшүүлэхээр тэд хязгаарлаж магадгүй юм. Бүхий л тохиолдолд гол зорилт нь, бүх түншүүдийн өрсөлдөх байр суурийг дээшлүүлэхэд оршино. SBA-г үүсгэн байгуулах нь, үндэсний өрсөлдөөний бодлого эсхүл монополын эсрэг хуулиудын нөхцөлөөс хамаарч байдаг.
1254	Strategic dumping	Стратегийн демпинг. Монопол болон олигопол ашиг орлох зорилгоор дотоодын зах зээлээ хаалттай байлгахын зэрэгцээ экспортын үнийг хямд тогтоох стратеги. Демпингийг (dumping) үзнэ үү.
1255	Strategic exports	Стратегийн экспорт. Энэ нь тухайн бүс нутагт цэрэг армийн тэнцвэрт байдалд бодит эсвэл байж болохуйц нөлөө бүхий бараа, үйлчилгээг хэлдэг. Мөн давхар/хоёрдмол зорилготой экспортууд (dual-purpose exports), Экспортын олон талт хяналтыг зохицуулах хороо (COCOM), Ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологийн экспортын хяналтын Вассенаарын хэлэлцээрийг (Wassenaar Arrangement on Export Controls for Conventional Arms and Dual-Use Goods and Technologies) үзнэ үү.
1256	Strategic trade theory	Стратегийн худалдааны онол. Энэ нь засгийн газрууд томоохон экспортлогч болох магадлалтай үйлдвэрлэлийг бий болгож, хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжсэн дотоодын бодлогыг баталж болно гэсэн санаа юм. Уг онолыг хэрэгжүүлэх нь бараг ихэнх тохиолдолд татаас эсвэл өөр нэгэн эсвэл ямар нэгэн төрлийн хамгаалалтад тулгуурласан байдаг хэдий ч, үүнийг дэмжигчид нь ийм бүрэн боловсруулаагүй түүхий үйл ажиллагааг ерөнхийдөө дэмждэггүй байна. Мөн харьцангуй давуу тал (comparative advantage), худалдааны шинэ онол (new trade theory) болон ялагчдыг сонгохыг (picking winners) үзнэ үү.
1257	Strengthening the functioning of markets	Зах зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэх. Энэ нь Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) гишүүн орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилготой хөтөлбөр. Энэхүү ажлын гол чиглэл нь худалдаа ба хөрөнгө оруулалт, өрсөлдөөн ба эрх зүйн зохицуулалтын шинэчлэлт өөрчлөлт, болон чадавх бүрдүүлэх юм.
1258	Structural adjustment	Бүтцийн өөрчлөлтийн зохицуулалт. Энэ нь хэрэглэгчийн сонголтын давуу эрх, технологийн инноваци, тарифын бууралт, татаасыг урт хугацаанд аажмаар халах, аливаа бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгүүд болон түүхий эд материалын өртөг зардалд гарах урт хугацааны өөрчлөлтүүд зэргээс хамаараад эдийн засгийн болон арилжаа, худалдааны шинээр үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн дасан зохицох шаардлагатай бүхий л салбарт явагддаг тасралтгүй үйл явц.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Заримдаа энэ нь, жишээ нь механик аналог компьютерийн үйлдвэрлэлийн салбарт (slide-rule production) гарсан шиг, бүхэл бүтэн салбарыг тэр чигээр нь эрчтэйгээр алга болгоход хүргэдэг байна. Зарим сүлжмэл, нэхмэл, оёмол зэрэг аж үйлдвэрийн салбаруудад уг бүтцийн өөрчлөлтийн тохируулга нь тодорхой хугацааны дагуу тохирсон дээд түвшний дэмжлэг үзүүлэх, ажилчдыг нь давтан сургах, бусад арга хэмжээнээс бүрдэх засгийн газрын дэмжлэгтэй үйл явцын хэлбэрээр хэрэгжиж болдог. Ийм арга хэмжээ авах эсэх нь тухайн аж үйлдвэрийн салбарын улс төрийн онцлогоос хамаарна. 1980-аад оны дунд үеэс эхлэн энэхүү нэр томьёо нь Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (Дэлхийн банк), Олон улсын валютын сан (IMF) зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын хувьд хөгжиж буй орнуудаас шаардсан бодлогын тодорхой заавруудыг авч үзэх болсон байна. Эдгээр байгууллагуудаас олгох буцалтгүй тусламжийн багц нь, төсвийн бодлогыг чангатгах, инфляцын эсрэг хатуу бодлого хэрэгжүүлэх замаар макро-эдийн засгийн тогтвортой байдлыг хурдацтай хангасан байх зэрэг нөхцөлийг ерөнхийдөө тавьдаг байна. Мөн протекционизм буюу гаалийн тарифаар дамжуулан хамгаалах онолыг (protectionism) үзнэ үү.</p>
1259	Structural impediments	<p>Бүтцийн саад тотгор. Энэ нь тухайн эдийн засгийн бүтэц, тогтолцоо нь бүрэн дүүрэн өрсөлдөхүйц зах зээл бий болоход саад болж байгаа нөхцөлийг илэрхийлдэг. Эдгээр нь зохисгүй буюу эрх зүйн хэт их зохицуулалт, татаасыг хавтгайруулан ашиглах, хувийн хэвшлийн эсвэл засгийн газрын монопол аж ахуйн нэгжүүд байх, хөдөлмөрийн хатуу зах зээл, бизнесийг хязгаарласан үйл ажиллагаанд тавих сахилгын арга хэмжээ хангалтгүй, бусад ижил төстэй хүчин зүйлсийн улмаас шалтгаалан үүсэж болно.</p>
1260	Structural Impediments Initiative	<p>Бүтцийн саад тотгорыг арилгах санаачилга (SII). Энэ нь Японы зах зээлийг Америкийн фирмүүдэд нээх зорилготойгоор АНУ-ын 1989 онд гаргасан санаачилга. Худалдаа хийх уламжлалт саад тотгорыг арилгах нь хангалтгүй байсан бөгөөд энэ нь Японы дотоодын бодлого, арга ажиллагаанд өөрчлөлт оруулах замаар ач холбогдолтой өөрчлөлтүүдийг бий болгох ёстой гэсэн санал дээр үндэслэсэн болно. Японы засгийн газар ба бизнесийн хоорондын харилцааг онцолж байсантай адил, Японы зах зээл болон [бараа бүтээгдэхүүний] түгээлтийн системийг нь онилж байсан байдаг. Энэхүү [санаачилгыг] өмгөөлөгчид гэж байх боловч, зарим цөөнх нь одоо бол, SI-ийн зорилтот байных нь талаар магадгүй хангалттай сайн ойлголт байгаагүй учраас SII нь амжилттай хэрэгжсэн хэмээн гомдоллох байх. Мөн Зах зээлийн чиг баримжаатай тусгайлсан салбарын талаарх яриа хэлэлцээ (Market-Oriented Specific-Sector talks), кэйрэцү (keiretsu), АНУ-Японы эдийн засгийн шинэ түншлэлийн бүтэц, хамрах хүрээг (United States-Japan Framework for a New Economic Partnership) үзнэ үү.</p>
1261	Structuralism	<p>Бүтцийн арга барилын онол. Худалдааны бүтцийн онолыг (structural trade theory) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1262	Structural trade theory	Худалдааны бүтцийн онол. Энэ нь, олон улсын худалдаан дах бүтцийн хүрээний хүчин зүйл нь анхдагч түүхий эд болон түүхий эд, материалын үйлдвэрлэл ба экспортоос хамааралтай байдаг улс орнуудын хөгжилд саад болж, хүндрэл учруулж байна гэж үздэг маргаан дагуулсан онол бөгөөд энэ нь 1950-аад оны үед гарч ирсэн байдаг. Иймэрхүү үйлдвэрлэгчдийн худалдааны нөхцөлийг урт хугацаандаа доройтуулж байгаа учраас тийм үйлдвэрлэгчдийн эсрэг байнгын ялгаварлан хандах хандлага байдаг гэж энэхүү онолыг сурталчлан дэмжигчид маргадаг байна. Санал болгож буй шийдлүүд нь, хөнгөлөлттэй нөхцөлд тулгуурласан Өмнөд-Өмнөд чиглэлийн худалдааг (хөгжиж буй улс орнуудын хоорондын худалдааг) хөхиүлэн дэмжих асуудлыг хамруулдаг байна. Энэхүү хязгаарлагдмал орчинд хөгжиж буй орнууд харьцангуйгаар илүү өрсөлдөх чадвартай болж, тэдний аж үйлдвэр нь хангалттай хөгжсөн цагт аж үйлдвэржсэн орнууд руу ханган нийлүүлэхэд бэлэн болох боломжтой болно гэж үзэж байсан байна. GSP буюу Хөнгөлөлтийн ерөнхий системээр дамжуулан, хөгжиж буй улс орнуудын экспортын ашиг сонирхол бүхий бүтээгдэхүүнүүдийг хөгжингүй орнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр зах зээлд нь нэвтрүүлэхийг мөн сурталчилж байв. Үр дүнд нь, хангалттай хэмжээнд бодит өөрчлөлт хийж чадах цөөхөн хэдэн хөнгөлөлттэй/давуу тал олгосон худалдааны бүсүүд бий болсон боловч, бүтцийн зохион байгуулагчид худалдаа ба хөгжлийн чухал асуудлуудад анхаарал хандуулах дал дээр амжилт олж чадсан байна. Мөн Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн систем (Global System of Trade Preferences - GSTP), НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлыг (UNCTAD) үзнэ үү.
1263	Stumbling blocks	Хэцүү даваа буюу эргэлзээтэй хэсэг. Энэ нь олон талт худалдааны либералчлалыг хөгжүүлэхэд саад болж буй чөлөөт худалдааны бүсийг тайлбарлахад ашигладаг нэр томьёо ба үүнийг Жагдиш Бхагватийн нэрээр томъёолсон байдаг. Мөн Бүтцийн элементийн арга барилыг (building blocks approach) үзнэ үү.
1264	Sub-national obligations	Орон нутгийн түвшинд хүлээсэн үүрэг хариуцлага. Хоёрдугаар түвшний үүрэг, үүрэгчлэлүүдийг (second-level obligations) үзнэ үү.
1265	Sub-regional economic zones	Дэд бүс нутгийн эдийн засгийн бүс. Өсөлтийн гурвалжныг (growth triangles) үзнэ үү.
1266	Subsidies	Татаас. Бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид, эсхүл экспортлогчдод засгийн газрын зүгээс санхүүгийн болон мөнгөн бус хэлбэрээр үзүүлсэн дэмжлэг. Татаасыг олон шалтгаанаар төлдөг. Үүнд: үр ашиггүй үйлдвэрлэлийн бүтэц тогтолцоог хөшүүрэгдэн дээш нь хөгжүүлэх, жишээ нь хөдөө аж ахуйн салбар гэх мэт нэг салбарын хэмжээний орлогыг нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэл, бүс нутгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих хүсэл эрмэлзэл, экспортын зах зээлийг хөгжүүлэх зорилго гэх мэт. Өргөн утгаараа, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт татаасыг дараах хэлбэрээр тодорхойлсон байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүнд: засгийн газрын, эсхүл төрийн байгууллагын зүгээс үзүүлсэн санхүүгийн тусламж хандив, хөрөнгийн шууд шилжүүлэлт, эсхүл хөрөнгийг шууд шилжүүлэх боломж (жишээ нь, буцалтгүй тусламж, зээл, хувьцаагаар хөрөнгө оруулах), засгийн газар авах ёстой орлогоосоо зайлсхийх, эсхүл орлогоо татвараар цуглуулахгүй байх, ерөнхий дэд бүтцээс бусад бараа, үйлчилгээний талаарх засгийн газрын нөхцөл/хангамж, санхүүжилтийн механизм дах төлбөр, эсхүл хувийн хэвшлийн салбарын хуулийн этгээд эдгээр чиг үүргийг гүйцэтгэх, орлогын эсхүл үнийн дэмжлэг зэрэг болно. Хөдөө аж ахуйн татаасыг Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрт тусгасан байдаг. Мөн Засгийн газрын урамшуулал буюу татаас (bounty), татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах арга хэмжээ (countervailing measures), тусгайлсан татаас (specific subsidy), улсын татаас/төрийн тусламжийг (state aids) үзнэ үү.</p>
1267	Subsidies Code	<p>Татаасны Код. Токиогийн үе шатны хэлэлцээ (Tokyo Round agreements), Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Subsidies and Countervailing Measures) үзнэ үү.</p>
1268	Substantially-all-discrimination criterion	<p>“Үндсэндээ /дийлэнх”- ялгаварлан гадуурхах шалгуур. ҮХЕХ нь тодорхой нөхцөлд үйлчилгээний салбарт чөлөөт худалдааны бүс байгуулахыг зөвшөөрдөг. Эдгээрийн нэг нь, тухайн хэлэлцээрт нэгдсэн талууд уг хэлэлцээрт хамруулсан үйлчилгээний дийлэнх салбаруудад үндсений нөхцөл олгосон байх ёстой. “Үндсэндээ/дийлэнх” гэсэн нэр томьёог ҮХЕХ-т цааш нь нарийвчлан тодорхойлоогүй байдаг.</p>
1269	Substantially-all-trade criterion	<p>Үндсэндээ/дийлэнх- худалдааны шалгуур. ТХЕХ-ийн 24-р Зүйлд гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийг Гэрээнд нийцүүлэн байгуулж болох нөхцөлийг заасан байдаг. Хөнгөлөлттэй нөхцөл/давуу эрх олгох хэлэлцээрт нэгдсэн талуудын хооронд хийгдэж байгаа үндсэндээ бүх/дийлэнх худалдааг уг дүрмийн дор шалгуур хангах нэг хэсэг болж хамрагдсан байхыг шаарддаг. ТХЕХ нь үүнийг хэрхэн ойлгож, тооцоолон бодох талаар хэлээгүй байдаг. Шалгуур гэж байгаа нь юу гэсэн утгатай болох талаар оюун сэтгэлгээний хоёр хэсэг уламжлал байдаг. Эхнийх нь тоон арга хандлагыг баримталдаг бөгөөд энэ нь “үндсэндээ бүх/дийлэнх худалдаа” гэдгийг нийт худалдааны үнийн дүнгийн утгаар тодорхойлдог. ТХЕХ-ийн дараагийн маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг, энэ нь нийт худалдааны 80%-90% байх ёстой гэж үзсэн байдаг. Энэхүү арга барилын дагуу, хөдөө аж ахуйн болон бусад эмзэг мэдрэг салбаруудыг энэхүү хэлэлцээрт хамруулахгүй байж болох боловч, үлдсэн худалдаа нь шалгуур үзүүлэлтийг хангалттай хэмжээнд илэрхийлж чадна гэдэг. Хоёрдогч арга барил нь чанарын арга барил юм. Үүнд бол бүх салбаруудыг хамруулсан байх ёстой ба жишээ нь хөдөө аж ахуйн салбарыг орхигдуулна гэдэг нь шалгуур үзүүлэлтийг автоматаар зөрчиж байна гэдэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Хэдийгээр Уругвайн үе шатны яриа хэлэлцээний үеэр ДХБ-ын гишүүн улс орнууд, хэрэв худалдааны томоохон салбаруудыг хасвал дэлхийн худалдаанд оруулах чөлөөт худалдааны хэлэлцээрийн хувь нэмэр буурах болно гэж тохиролцсон боловч, оюун сэтгэлгээний аль уламжлал нь давамгайлах ёстой вэ гэдэг талаар тогтсон хэлэлцээр харагдахгүй л байна. Үйлчилгээний салбар дах чөлөөт худалдааны хэлэлцээрийг хамарсан ҮХЕХ-ийн 5-р Зүйлд мөн үндсэндээ бүх/дийлэнх худалдааны шалгуур гэж байдаг. Энэ хэсэгт, үйлчилгээний салбарын үндсэн бүх салбарыг хамруулах эрэлт хэрэгцээ болон үндэсний нөхцөлийн хувьд (НТ) үндсэндээ бүх ялгаварлан гадуурхалт байхгүй байх эсвэл алга болгох гэж хуваагдсан байдаг. “Үндсэндээ бүх салбаруудыг хамруулах” гэдэг нь салбаруудын тоо хэмжээ, нөлөөнд өртсөн худалдааны цар хэмжээ, үйлчилгээ үзүүлэх горимууд гэж ойлгогдох болно. Нэмж дурдахад ханган нийлүүлэлтийн ямар ч горимыг наана нь хасаж болохгүй.</p>
1270	Substantial sectoral coverage	<p>Үндсэн чухал салбарыг хамруулах. Үйлчилгээний худалдаанд хөнгөлөлттэй/давуу нөхцөл олгосон эдийн засгийн интеграцчиллын хэлэлцээр нь үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (MFN) шаардлагаас чөлөөлөгдөхийн тулд ҮХЕХ-ийн 5-р Зүйлд заасан шаардлагад нийцэх ёстой гэсэн шалгуурын нэг. “Үндсэн чухал” гэдэг үгийг тоон утгаар тодорхойлоогүй байдаг боловч хуулийн Зүйлд уясан эшлэлд үүнийг салбарын тоо, нөлөөлөлд өртсөн худалдааны цар хэмжээ, үйлчилгээг хүргэх горимууд гэдэг утгаар ойлгоно гэсэн байдаг. Ханган нийлүүлэлтийн ямар ч горимыг өмнө нь хасаж болохгүй.</p>
1271	Substantial supplying interest	<p>Ханган нийлүүлэлтийн үндсэн чухал ашиг сонирхол. ТХЕХ-ийн 28-р Зүйлд заасан тарифыг бууруулах тухай хэлэлцээр хийх журмын дагуу, ханган нийлүүлэлтийн үндсэн ашиг сонирхол бүхий талтай хэлэлцээг ихэвчлэн явуулдаг. Хуулийн уг Зүйлд тухайн бүтээгдэхүүнийг худалдаалах ихээхэн ашиг сонирхолтой талын ашиг сонирхлыг харгалзан үзэх хэрэгтэй гэсэн байдаг. Тайлбар тэмдэглэлд “үндсэн ашиг сонирхол” гэсэн ойлголтыг яг нарийн тодорхойлох боломжгүй боловч үүнийг зах зээлийн томоохон хувь хэмжээ эсвэл тийм хувь хэмжээг хүсэн хүлээх гэж ойлгогдохоор төлөвлөсөн болно. Мөн тарифын дахин хэлэлцээ хийхийг (renegotiation of tariffs) үзнэ үү.</p>
1272	Substantial transformation	<p>Үлэмж хэмжээний өөрчлөлт. Энэ нь гарал үүслийн дүрмийг хэрэгжүүлэх болон гаалийн татварыг хэрэглэхтэй холбогдолтой нэр томьёо. Хил дээр тухайн бүтээгдэхүүнд ногдуулах тариф нь тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн орныг тодорхойлохоос хамаарна. Заримдаа уг бүтээгдэхүүн нь өөрийн сүүлийн шинж чанараа олж авахаасаа өмнө хэд хэдэн улс орноор дамжсан байж болно. Ийм тохиолдолд сүүлийн үндсэн чухал үлэмж хэмжээний өөрчлөлт хийгдсэн улсыг гарал үүслийн улс гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн барааны гарал үүслийн оронд БТКУС-ийн бүлгийн болон зүйлийн түвшинд өөрчлөлт орсон байх ёстой.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Тухайлбал, БТКУС-ийн 03 бүлэгт багтаж буй хөлдүү загасыг боловсруулж 16 бүлэг буюу лаазалсан бүтээгдэхүүн гарган авах гэх мэт. Бүтээгдэхүүнийг зөвхөн дахин савлаж, боосноор эсхүл үүнийг нэг давхар өнгөөр будсанаар үндсэн чухал өөрчлөлт хийгдсэн гэж үзэхгүй.
1273	Sui generis right	Төрөл зүйлийн ховор/хосгүй/давтагдашгүй эрх. Оюуны өмчийн хамгааллын энэхүү хэлбэрийг зохиогчийн эрхийн хамгааллын нэгэн хэлбэр болгож ихэвчлэн ашигладаг. Тухайн утга, агуулгыг (эх хувь, гар бичмэл гэх мэт) ховор/хосгүй зүйл хэмээн хамгаалж, ийм үндэслэлээр түүнд тусгай хамгаалалт шаарддаг. Ховор/хосгүй/давтагдашгүй шинж чанараар нь хамгаалалтад авах аргыг ихэвчлэн компьютерын программ хангамж болон холбогдох судлагдахуунд ашигладаг. Үүний хэрэглээний нэг жишээ бол мэдээллийн сангийн хууль ёсны хамгааллын асуудлыг хөндсөн удирдамжийг Европын холбооны хамтын нийгэмлэгээс гаргасан байдаг. Энэхүү удирдамжийн дагуу, мэдээллийн санд их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн гэдгээ нотолж буй мэдээллийн санг боловсруулан гаргагчид нь мэдээллийн санг бүхэлд нь буюу түүний ихээхэн хэсгийг олборлох, дахин ашиглах үйлдлээс урьдчилан сэргийлэх эрхтэй. Мөн Интеграл цахилгаан шугам бүхий микро схемийн зураг төсөл (lay-out design of integrated circuits), ургамал үржүүлэгчдийн эрхийг (plant breeders' rights) үзнэ үү.
1274	Sunrise industries	Мандан хөгжиж буй шинэ аж үйлдвэрлэлийн салбарууд. Энэ нь шинэлэг арга барил, технологийн ололт дэвшлийг ашиглах замаар, аливаа зүйлийг илүү үр дүнтэй хийх эсвэл бүхэлдээ цоо шинэ төрлийн бүтээгдэхүүнүүдийг бий болгоход амжилт гаргаж, ихэнхдээ оюуны өмчийн өндөр агууламжтай шинээр өсөн хөгжиж буй аж үйлдвэрийн салбарууд юм. Ялангуяа мэдээллийн технологи нь мандан хөгжиж буй шинэ аж үйлдвэрлэлийг салбаруудыг олшруулсан байна. Зарим талаараа оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаас болж мөн стратегийн худалдааны онол дээр үндэслэсэн зарим арга хэмжээ авах замаар засгийн газрууд заримдаа ялагчдыг сонгож онцлох (picking winners) аргаар тэдгээр салбарыг дэмжихийг хүсдэг тул мандан хөгжиж буй шинэ аж үйлдвэрлэлийн салбаруудын худалдааны бодлогын ашиг сонирхол үүсдэг байна. Энэхүү хоёр ашиг сонирхол нь хоёулаа худалдааг гажуудуулах нөлөө үзүүлж болзошгүй. Мөн жаргаж байгаа буюу хуучирч, буурч буй аж үйлдвэрлэлийн салбарыг (sunset industries) үзнэ үү.
1275	Sunset clause	Жаргаж байгаа буюу хуучирч буй хууль зүйн заалт. Энэ нь тухайн гэрээний нөхцөлийн дагуу тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа, эсхүл хэрэв тодорхой заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд, засгийн газраас авсан арга хэмжээний хугацаа нь автоматаар дуусах тухай заалт. Демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures) болон татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ногдуулахтай (countervailing duties) холбоотой ДХБ-ын хэлэлцээрт жаргаж буй хууль зүйн

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		заалт багтсан байдаг бөгөөд үүний дагуу, нягталж шалгасны үр дүнд холбогдох арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэх ёстой гэж мэдэгдээгүй тохиолдолд, 5 жилийн дараа тэдгээр арга хэмжээний хугацаа нь дуусгавар болдог байна. Мөн АНУ-ын хууль тогтоомж дах жаргаж буй хууль зүйн заалтын улмаас үүссэн маргаанд зориулсан үйлдвэрлэлийн заалтыг (manufacturing clause) үзнэ үү.
1276	Sunset industries	Жаргаж байгаа буюу хуучирч, буурч буй аж үйлдвэрлэлийн салбар. Энэ нь эдийн засгийн бусад салбарууд дах технологийн дэвшил, эсхүл хэрэглэгчдийн сонголтод өөрчлөлт орсон учраас бөхөж унтарч буй аж үйлдвэрийн салбарууд гэж тооцогддог. Зарим үед эдгээр аж үйлдвэрүүдийг жишээгээр тайлбарлавал ашиггүй болсон хуучин хэв загвартай төмөрлөгийн үйлдвэрүүд хаагдсанаар орон нутагт ажилгүйдэл өргөнөөр тархдаг. Зарим төмөрлөгийн шинэ үйлдвэрүүдийг мэдээж хэрэг мандан хөгжиж буй шинэ аж үйлдвэрлэлийн салбар гэж ангилж ч болно. Жаргаж байгаа аж үйлдвэрийн статусыг олж авах нь хэдхэн сарын хугацааны асуудал байж болно, жишээ нь цахим өврийн тооны машин анх гарч ирэх үед логарифмын шугам үйлдвэрлэгчдийн (slide-rule producers) дунд болсон үйл явдал байлаа. Бас нэг өөр тохиолдолд, аж үйлдвэрүүд шинэчлэл хийхэд хангалттай хэмжээний үр өгөөж бүтээж чадаагүй, шинэ хөрөнгө оруулалт татах чадваргүй ч зардлаа хэмнэх, аажмаар ажлын орон тоогоо бууруулах замаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд хангалттай хэмжээний ашиг олдог сунжирсан (drawn-out) үйл явц ч байж болох юм. Энэ үед дотоодод үйлдвэрлэсэн агуулгыг шаардах, импортын хязгаарлалт хийх, бүтцийн өөрчлөлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ, татааснууд, сайн дурын хязгаарлалтын арга хэмжээ гэх мэт хамгаалалтын хэлбэрээр дамжуулан, засгийн газрын зүгээс үйлдвэрийн тасалдлыг хөнгөвчилж өгөхийг хүсдэг.
1277	Superfund	Супер сан. 1987 онд ТХЕХ-т Канад, Мексик, Европын хамтын нийгэмлэг нар АНУ-ын эсрэг энэхүү хэргийг үүсгэсэн байна. Энэ нь 1986 онд баталсан АНУ-ын Супер сангийн нэмэлт өөрчлөлт болон Дахин эрх мэдэл олгох тухай хуулийн дагуу ногдуулах татвартай холбоотой байв. Энэхүү маргаан эхэлсэн үед татвар нь хүчин төгөлдөр болоогүй байв. Уг хууль нь тухайлбал, татвар ногдуулах аж үйлдвэрийн түүхий эдийн химийн бодисыг ашиглан үйлдвэрлэсэн эсвэл үйлдвэрлэлийн аргаар гүн боловсруулан гаргаж авсан тодорхой нэр төрлийн химийн бодист шинэ татвар ногдуулсан байна. Хэрвээ эдгээр химийн бодисыг импортын химийн бодисын үйлдвэрлэлд ашиглахаар АНУ-д борлуулж байсан бол химийн бодисын орц бүрэлдэхүүн хэсгүүдэд төлөх байсан татварын хэмжээ нь зарчмын хувьд импортын химийн бодист ногдуулах татвартай ижил тэнцүү байсан байна. Импортлогчид импортын бодисын химийн бүрэлдэхүүн хэсгүүдийнхээ талаар хангалттай мэдээлэл өгөөгүй тохиолдолд торгууль ногдуулж болно. Гомдол гаргагчид импортын бүтээгдэхүүний татвар нь дотоодын ижил төрлийн бүтээгдэхүүнд ногдуулдаг татвараас өндөр байсан тул ТХЕХ-ийн 111: 2-р Зүйлийн (Үндэсний нөхцөл) заалтыг зөрчсөн гэж үзэж байлаа.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Энэ нь, "Аливаа нэг гэрээлэгч талын нутаг дэвсгэрээс гаралтай бүтээгдэхүүнийг гэрээлэгч ямар нэгэн бусад талын нутаг дэвсгэр лүү импортлоход нь шууд болон шууд бусаар дотоодын татвар эсвэл ямар нэгэн төрлийн дотоодын татвар хураамж ногдуулахдаа, дотоодын ижил төрлийн бүтээгдэхүүнд шууд болон шууд бусаар ногдуулдаг татварын хэмжээнээс илүү давсан хэмжээтэй байж болохгүй" гэдгийг хэлдэг. Маргаан шийдвэрлэх бүлэг нь 111: 2-р Зүйлийн утга агуулгын хүрээнд импортлоход болон дотоодын бүтээгдэхүүнүүд ижил төрлийн бүтээгдэхүүнүүд байсан байна гэж үзсэнээс гадна, дотоодын болон импортын бараа бүтээгдэхүүнтэй харьцах тал дээр ялгаа байсан тул газрын тосонд ногдуулдаг татвар нь тэгэхээр 111: 2-р Зүйлийн дагуу АНУ-ын хүлээсэн үүрэг амлалттай нийцэлгүй байна гэж үзсэн байна. Энэхүү хууль нь АНУ-ын эрх баригчдад үндэсний нөхцөлийн зарчимтай зөрчилдсөн татвар ногдуулахад чиглүүлсэнд Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсэг харамсаж байлаа. Үүний зэрэгцээ, уг Хууль нь тэдэнд татвар ногдуулахдаа үзэмжээрээ шийдвэр гаргах боломж олгосны дагуу үүссэн байгаа торгуулийн хувь хэмжээний заалтууд нь ТХЕХ-ийн дагуу АНУ-ын хүлээсэн үүргийг зөрчсөн гэж үзээгүй болохыг тогтоожээ.</p>
1278	Support prices	<p>Үнийн дэмжлэг. Энэ нь ялангуяа анхдагч түүхий эдүүдийг үйлдвэрлэгчдэд хамгийн бага хэмжээний баталгаатай ашиг өгөх нэг арга хэрэгсэл. Үүнийг жишээ нь доод үнэ, зээлийн хүүгийн хувь хэмжээ, татаас болон хувьсах татвар хураамж, зарим тохиолдолд импортын хязгаарлалтын тусламжтайгаар олгох боломжтой. Үнийн дэмжлэг нь үнийн дохионд тодорхой хэмжээгээр хариу үйлдэл үзүүлдэг тул тэдгээр нь тухайн зах зээлийн үнэтэй холбоотой байж болох юм. Ийм нөхцөлд зах зээлийн үнийг тодорхойлох нь асуудалтай болдог байна. Үнийн дэмжлэг нь зах зээлийн үнэтэй холбоогүй байх ч боломжтой. Тэдгээрийн зорилго нь тэгэхээр зөвхөн үйлдвэрлэгчдэд баталгаатай орлого өгөх явдал юм. Бусад улс орны дотоодын хэрэглэгчид болон үр ашигтай үйлдвэрлэгч нар өөр хоорондоо тооцоогоо хуваалцдаг байна.</p>
1279	Surtax	<p>Импортын нэмэлт татвар. Импортын нэмэлт төлбөр (import surcharge), тээврийн нэмэгдлийг (prime) үзнэ үү.</p>
1280	Surveillance	<p>Хяналт, тандалт. Энэ нь ДХБ-ын гишүүн орнуудын зүгээс бусад гишүүн орнуудын үндэсний худалдааны бодлого нь олон талт худалдааны тогтолцооны дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг болон тэдгээр үндэсний худалдааны бодлого нь тухайн гишүүн улс орнуудын хүлээсэн үүрэг амлалтуудыг тусгаж байгаа эсэхэд тогтмол хяналт шалгалт хийж байдаг. Уг зорилгоор ашигладаг үндсэн механизм нь Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоо (Trade Policy Review Mechanism) боловч, ДХБ-ын удирдаж байдаг олон хэлэлцээрүүдэд, тодорхой хэлэлцээрийн нөхцөлүүдийн дор хийгдсэн бодлого эсвэл арга хэмжээнд өөрчлөлт оруулсан бол энэ талаар мэдэгдэх шаардлагатай гэсэн заалтуудыг агуулсан байдаг. Мөн, мэдэгдэл (notification) болон ил тод байдлыг (transparency) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1281	Sustainable development	Тогтвортой хөгжил. Дэлхийн хүрээлэн буй орчин, хөгжлийн хорооноос тодорхойлсноор, хөгжил гэдэг бол өнөө үеийнхний хэрэгцээг, ирээдүй хойч үеийнхэн өөрсдийн хэрэгцээгээ хангах нөөц боломжийг нь алдагдуулахгүйгээр хангах нөхцөл гэсэн байна.
1282	Sweatshop-labour argument	Эрчимжүүлсэн ашиглалттай үйлдвэрийн хөдөлмөрийн тухай маргаан. Ядуугийн тэтгэмжээр амьдрагчдын хөдөлмөрийн тухай маргаан (pauper-labour argument), худалдаа ба хүний эрх (trade and human rights), худалдаа ба хөдөлмөрийн стандарт (trade and labour standards), Ялгавартай цалингийн тухай мэтгэлцээнийг (wage-differential argument) үзнэ үү.
1283	Swing mechanism	Солбих механизм. ДХБ-ын зарим гишүүд үүнийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын татаасыг ашиглах эрх хэмээн тайлбарлан орчуулах нь бий. Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрт гишүүн орнуудын хэрэглэж болох экспортын татаасны түвшингийн жилийн хязгаарыг тогтоож өгдөг. Зарим нь хэрэв тухайн улс аливаа өгөгдсөн жилд хамгийн дээд тааз түвшин хүртлээ бүрэн ашиглахгүй бол, нийт зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гараагүй тохиолдолд, ашиглагдаагүй хэмжээгээ өөр жилд ашиглах боломжтой байх ёстой гэж хэлж байлаа. Энэхүү санал нь өргөн цар хүрээтэй дэмжлэг авч чадаагүй байна. Нөгөө талаар Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийн дагуу бол савлуурын механизм нь хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл юм. Уг хэлэлцээр нь тодорхой тогтоосон удирдамж, практик туршлагыг харгалзан солбихыг (нэг бүтээгдэхүүний экспортын квотын нэг хэсгийг нөгөө бүтээгдэхүүнд шилжүүлэх) зөвшөөрдөг байна.
1284	Swiss formula	Швейцар томьёо. “Энэ нь Токиогийн үе шатны хэлэлцээний (Токуо Round) үеэр Швейцар улсаас санал болгосон шугаман зарчмаар тарифыг бууруулахад хүргэж болох харилцан буулт хийх томьёо. Энэ нь илүү өндөр түвшний тарифыг доогуур түвшний тарифтай харьцуулахад их хувь хэмжээгээр бууруулах зорилготой байсан. Томьёо нь: $Z = AX / A + X$ Үүнд: X-тарифын анхны хувь хэмжээг илэрхийлэх бөгөөд A - харилцан тохиролцоонд хүрэх коэффициент [илтгэлцүүр]. Z - үр дүнд нь хүрсэн доогуур түвшний тарифын хувь хэмжээ. Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг, Скандинавынорнууд болон Австрали улс орнууд коэффициент 16-г ашигладаг бөгөөд, АНУ, Япон болон Швейцар улс орнууд коэффициент 14-ийг ашигладаг байна. Шинэ Зеланд улс нь зүйл тус нэг бүрчлэн (item-by-item) гэсэн техник аргачлалыг ашигладаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1285	Symbolic deals	<p>Билэг тэмдгийн чанартай хэлцэл. Энэ нь илэрхий, эсхүл ямар ч эргэлзээгүй үндэслэлгүй, бодитой бус болсон, харилцан тохиролцсон хэлцээний үр дүнг тайлбарлах зорилгоор Бернард Хоекман гэгчийн хувьд “Худалдааны тухай хууль ба институтууд: Сайн туршлага ба Дэлхийн Худалдааны Байгууллага” (Trade Laws and Institutions: Good Practices and the World Trade Organization) хэмээх номд ашигласан нэр томьёо. Ийм хэлэлцээнүүд дараах нөхцөлд бий болох боломжтой, жишээ нь бодитой үндэслэлтэй асуудлуудын хувьд тохиролцоонд хүрэх нь тухайн цаг үед боломжгүй гэдгийг хэлэлцээр хийгч нар ойлгосон нөхцөлд ийм хэлэлцээрүүд бий болж болох боловч ямар нэг тохиролцоогүйгээр хэлэлцээний ширээг орхиод явах нь илүү муугаар харагдаж магадгүй юм. Мөн үүнээс өөрөөр хийх нь хэлэлцээг дахин эхлүүлэхэд илүү хүндрэл учруулж болзошгүй юм. Иймэрхүү хэлцээг заримдаа улс төрийн үр дагавартай (political outcome) гэж нэрлэдэг.</p>
1286	<p>YSMIM (System for the Promotion of Mineral Production and Exports, or sometimes System for Safeguarding and Developing Mineral Production)</p>	<p>Ашигт малтмалын олборлолт ба экспортыг дэмжих систем буюу Уул уурхайн бүтээгдэхүүнүүдээс олох экспортын орлогыг тогтворжуулах систем (YSMIM). Өөрөөр хэлбэл ашигт малтмалын олборлолт ба экспортыг дэмжих систем буюу ашигт малтмалын олборлолтыг хамгаалах болон хөгжүүлэх систем. Экспортын орлогыг тогтворжуулах системийн (STABEX) дагуу ашигт малтмалыг олж ирдгээс өөр хувилбар байдлаар, 1980 онд Европын эдийн засгийн нийгэмлэгээс бүхнийг хамарсан Ломе-11-ийн гэрээний дагуу энэхүү түүхий эдийг тогтворжуулах механизмыг байгуулсан. Энэ нь Африкийн, Карибын тэнгисийн, Номхон далайн бүсийн улс орнуудыг (ACP states) уурхайн олборлолт буурахын эсрэг, улмаар экспортын орлогын гачигдлаас хамгаалах зорилготой. Ломе-4-ийн дагуу (1990 онд арван жилийн хугацаатайгаар дахин хэлэлцэж тохирсон), зэс (үүнд кобальт орно), фосфат, мангаан, хөнгөн цагааны хүдэр ба исэл, цагаан тугалга, төмрийн хүдэр, уран зэрэг экспортын хувьд хараат байдлын босго хэмжээ нь 15% ба түүнээс дээш байдаг. Энэ хувь хэмжээ нь алт, газрын тос болон байгалийн хийнээс бусад бүх уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогын хувьд 20% ба түүнээс дээш байдаг. Мөн Харилцан үүрэг хариуцлага хүлээх эрх зүйн бүтэц, хамрах хүрээ (Framework of Mutual Obligations) болон Ломе дах конвенцыг (Lome Convention) үзнэ үү.</p>
1287	Systemic issues	<p>Системийн хүрээний асуудлууд. Энэ нь олон талт худалдааны системийн үйл ажиллагаа буюу өргөн цар хүрээний дүрэм журамтай холбоотой асуудлууд. Үүнтэй ихэвчлэн холбогддог жишээ гэвэл, маргаан зохицуулах тухай нөхцөл заалтууд, хамгаалалтын арга хэрэгслийн механизм, ил тод байдлын дүрэм зэрэг болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1288	TAFTA (Trans-Atlantic Free Trade Agreement)	Атлантын далай дамнасан Чөлөөт худалдааны хэлэлцээр (TAFTA). Энэ нь АНУ болон Европын хамтын нийгэмлэгийн хооронд чөлөөт худалдааны бүс байгуулах санал бөгөөд энэ талаар засгийн газрын өндөр түвшинд хэлэлцсэн боловч хараахан албан ёсны хэлэлцээрийн хөтөлбөрт ороогүй байгаа. Мөн Атлантын далай дамнасан Шинэ хөтөлбөрийг (New TransAtlantic Agenda) үзнэ үү.
1289	Tailor-made tariffs	Тухайн нөхцөлд тааруулсан тариф. Тусгай захиалгаар, тодорхой хэмжээнд тааруулсан тариф (made-to-measure tariffs) үзнэ үү.
1290	Targeting	Цохилт өгөх байг тодорхойлох. Мөн Ялагчдыг сонгох (picking winners), худалдааны стратегийн онолыг (strategic trade theory) үзнэ үү. АНУ-ын худалдааны тухай хуульд зааснаар бусдад цохилт өгөх байг тодорхойлох нь 301-р хэсэгт заасны дагуу арга хэмжээ авахад хүргэх магадлалтай.
1291	Tariff	<p>Тариф. Энэ нь гаалийн нэг нутаг дэвсгэрээс (ихэнх тохиолдолд нэг улс орноос) нөгөө гаалийн нутаг дэвсгэрт шилжиж буй бараа бүтээгдэхүүнд хил дээр ногдуулсан гаалийн татвар, эсхүл албан татварын хэмжээ. Үүнийг барааны нэгжид мөнгөн илэрхийллээр (specific tariff) буюу импортын барааны үнийн тутамд тогтоосон дүнгээр, эсхүл импортын барааны үнийн дүнгээс хувиар (ad valorem tariff) тооцон ногдуулж болно. Цөөн тохиолдолд, эдгээр хоёр хэлбэрийг хосолсон тарифыг (compound tariff) хэрэглэдэг. Тарифыг ихэвчлэн импортод ногдуулдаг боловч экспортод ногдуулах тохиолдлууд ч байдаг. Тариф нь дотоодын ижил төрлийн бараа үйлдвэрлэгчид үнийн өрсөлдөөний давуу талыг бий болгох өөрөөр хэлбэл, импортын барааны үнийг өсгөж, импортлогч улс орны зах зээлд тэдгээр импортын барааны өрсөлдөх чадварыг нь багасгахаас гадна улсын төсвийн орлогыг нэмэгдүүлдэг. Эдийн засгийн утгаараа, тариф нь хэрэглээний татвар болон үйлдвэрлэлийн татаасыг нэгэн зэрэг ногдуулсантай тэнцэх хэмжээ юм.</p> <p>Барааны үнийн дүнгээс хувиар тооцох тариф (ad valorem tariff), Лернерийн тэгш хэмийн теорем (Lerner's symmetry theorem), барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон тариф (specific tariff) үзнэ үү.</p>
1292	Tariff anomaly	Тарифын гажил. Зарим нь үүнийг нийтлэг хэлж заншсан Өсөн нэмэгдэх тарифын бүтэц (tariff escalation) гэж өөрөөр нэрлэдэг.
1293	Tariff binding	Тарифын тохиролцоо. Тарифын хувь хэмжээг тохиролцсон түвшингээс дээш нэмэгдүүлэхгүй байх үүрэг хүлээх. Тарифын хөнгөлөлтийг (tariff concession) үзнэ үү.
1294	Tariff concession	Тарифын хөнгөлөлт, буулт. Энэ нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATT) хавсаргасан үндэсний тарифын жагсаалтад заасан түвшингээс дээш гаалийн тарифыг өсгөхгүй байх тухай ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг, заавал биелүүлэх амлалт. Бүх барааны хувьд тарифыг ийм байдлаар заавал үүрэг хүлээж хязгаарлах шаардлагагүй.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1295	Tariff Conference	Тарифын бага хурал. Энэ нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT) дагуу зохион байгуулагдсан олон талт худалдааны хэлэлцээнүүдийн эхний дөрвөн үе шатны албан ёсны нэр. Эдгээр нь 1947 оны Женевын бага хурал (Geneva Convention, 1947), 1949 оны Аннеси бага хурал (Annecy Convention), 1950-1951 оны Торкуэй бага хурал (Torquay Convention) болон 1955-1956 оны Женевийн бага хурлууд (Geneva Convention 1955-1956) юм.
1296	Tariff equivalent	Тарифтай адилтгасан хэмжээ. Тарифын бус арга хэмжээг (non-tariff measure) энгийн тариф руу шилжүүлсэн тохиолдолд ямар үр нөлөө үзүүлэх талаар тогтсон томьёолол дээр үндэслэн гаргасан тооцоолол. Ийм тооцоолол нь худалдааны дэглэмийн ил тод байдлыг нэмэгдүүлдэг байна. Мөн тарифжуулалтыг (tariffication) үзнэ үү.
1297	Tariff escalation	Өсөн нэмэгдэх тарифын бүтэц. Энэ нь бараа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин нэмэгдэхийн хэрээр тариф нь мөн адил дагаж өсдөг тохируулга юм. Жишээлбэл, автомашины их биеийг хийхэд зориулсан ган төмөрт 5%-ийн тариф ногдуулах бол, яг ижил төрлийн гангаар хийсэн машины их биеийн хэсгүүдэд 15%-ийн тариф, бэлэн болсон автомашинд 30%-ийн тарифыг тооцоолон ногдуулах магадлалтай гэсэн үг. Энэхүү хандлагыг дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хамгаалах, өсөлтийг дэмжих замаар нэмүү өртгийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна. Хэдийгээр тарифын зардлыг ихэвчлэн худалдан авагч нар төлдөг ч энэ арга хэмжээ нь ажлын байр бий болгох, технологийг шилжүүлэхийг хөхиүлэн дэмждэг хэмээн бараг ихэнх тохиолдолд зөвтгөдөг байна. тусламжийн үр дүнтэй хувь хэмжээг (effective rate of assistance) үзнэ үү.
1298	Tariffication	Тарифжуулалт. Энэ нь тарифын бус арга хэмжээнүүдийг тарифтай адилтгасан хэмжээ рүү (tariff equivalents) хөрвүүлэхийг үүрэг болгон, дагаж мөрдүүлэх тухай юм. Уругвайн үе шатны хэлэлцээний (Uruguay Round) үеэр, тарифжуулалтыг ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд хэрэглэгддэг байсан бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүдийн хувьд зах зээлд нэвтрэх өнөөгийн боломж эсвэл хамгийн бага хэмжээний боломжуудыг нээхэд ашигладаг байсан. Мөн Зах зээлд нэвтрэх хамгийн доод түвшний тарифын квот (minimum access tariff quotas) болон тарифын усыг (water in the tariff) үзнэ үү.
1299	Tariff-jumping investment	Тарифын саадыг давах зорилготой хөрөнгө оруулалт. Энэ нь өндөр тарифын саад тогтор болон бусад хилийн арга хэмжээнүүдийг давж гарах зорилгоор, өөр улсад үйлдвэрлэлийн байгууламжид хөрөнгө оруулалт хийх. Иймэрхүү тохиолдолд, худалдаа ба хөрөнгө оруулалт нь харилцан бие биеэ нөхөж дэмждэг эсэх, эсвэл тарифын өсөлт нь худалдааг орлодог эсэх талаар үзэл бодол харилцан адилгүй байдаг. Ихэнх хүмүүсийн үзэж байгаагаар, худалдаа ба хөрөнгө оруулалт нь одоогоор бараг бүх тохиолдолд уялдан нэгтгэгдсэн байдалтай байдаг бөгөөд тэдний ялгааг нь практик амьдрал дээр хялбархан даван туулж болно. Мөн өсөн нэмэгдэх тарифын бүтцийг (tariff escalation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1300	Tariff negotiations	<p>Тарифын хэлэлцээ. Энэ нь ТХЕХ болон ДХБ-ын ажлын гол чиглэл нь бөгөөд бараа бүтээгдэхүүний тарифыг хэлэлцэн бууруулах асуудал юм. ТХЕХ нь 1948 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноос хойш буюу 1960-1961 оны Диллоны үе шатны хэлэлцээ (Dillon Round) хүртэл, хүсэлт гаргах-ба-санал тавих системийн (request-and-offers system) дагуу тарифуудыг зүйл тус бүрээр нэг бүрчлэн (item-by-item) эсвэл бүтээгдэхүүн тус бүрээр (product-by-product) хэлэлцдэг байсан байна. ТХЕХ-ийн гишүүн орон өөр нэг гишүүн орны хувьд тухайн бараа бүтээгдэхүүний үндсэн ханган нийлүүлэгч гишүүн орон бол тарифыг бууруулах талаар хүсэлт гаргах эрхтэй байв. Кеннедигийн үе шатны хэлэлцээнээс (Kennedy Round) хойш, шугаман зарчмаар тарифыг бууруулах нь үндсэн гол арга барил болсон. Үүнтэй холбогдуулан, тарифын бүхэл бүтэн хэсгүүдийг тохиролцсон томьёоны дагуу нэгдсэн байдлаар бууруулж байв. Токиогийн үе шатны хэлэлцээнд, шугаман зарчмаар тарифыг бууруулах Швейцарын томьёог (Swiss formula) ажлын таамаглал болгон ашигласан бөгөөд үүний дагуу, өндөр хэмжээтэй тарифыг бага хэмжээний тарифтай харьцуулахад илүү их хэмжээгээр бууруулсан байна. Уругвайн үе шатны хэлэлцээний үеэр тарифын хэлэлцээ нь зарим талаар бүтээгдэхүүн тус бүрээр болон нөгөө талаар тарифыг тэглэсэн тохиолдолд тэглэх зарчмын дагуу тарифыг бууруулах замаар явагдаж байсан бөгөөд энэ хүрээнд, бараа бүтээгдэхүүний бүх ангиллын хүрээнд тарифыг тэг болгож бууруулдаг байв. Мөн, тарифыг уялдуулан бууруулах (harmonized tariff reductions), Мэдээллийн технологийн тухай хэлэлцээр (Information Technology Agreement), үндсэн ханган нийлүүлэгчийн эрх (principal supplier rights), тарифын дахин хэлэлцээ хийх (renegotiation of tariffs) болон салбарын хүрээний худалдааны хэлэлцээг (sectoral trade negotiations) үзнэ үү.</p>
1301	Tariff preferences	<p>Тарифын хөнгөлөлт / Хөнгөлөлттэй тариф. Улс орнууд ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд бие биедээ үндэсний нэн тааламжтай нөхцөлийг олгодог хэдий ч тодорхой нөхцөл байдалд сонгогдсон худалдааны түншүүддээ бага болон "тэг" тарифыг (zero-tariff) олгох боломжтой.</p> <p>Тухайлбал, Хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) дагуу хөгжингүй улс орнуудаас хөгжиж буй орнуудад тарифын хөнгөлөлт эдлүүлдэг Гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны хэлэлцээрийн гишүүд өөр хоорондоо харилцан тарифын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт. Мөн ТХЕХ-ийн 4 дүгээр хэсэг болон Зөвшөөрөгдөх заалтын (Enabling Clause) дагуу, хөгжиж буй улс орнууд бие биедээ тарифын хөнгөлөлт үзүүлж болно. Эзэнт гүрний хөнгөлөлтийн зохицуулалтыг (imperial preferences arrangement) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1302	Tariff quota	Тоо хэмжээний хязгаарлалттай тариф. Тогтоосон тоо хэмжээний импортын бараанд бууруулсан тариф хэрэглэх ба энэхүү хэмжээнээс давсан хэсэгт нь өндөр тариф ногдуулах үйл ажиллагаа. Зарим хүмүүс үүнийг импортын тоо хэмжээний хязгаарлалттай (квоттой) харьцуулбал импортын дээд хэмжээний хязгаарлалт тавьдаггүй тул худалдааг либералчилна гэж мэтгэлцдэг ч ихэнх нь хүлээн зөвшөөрдөггүй. Тоон хязгаарлалт доторх тариф (in-quota tariff) болон гадуурх тариф (out-of-quota tariff) хооронд зөрүү маш өндөр байдаг тул аливаа худалдааг их хэмжээгээр хийхээс урьдчилан сэргийлэх болно. Мөн зах зээлд урсгал түвшинд нэвтрүүлэх тарифын квот (current access tariff quotas) болон зах зээлд нэвтрэх хамгийн доод түвшний тарифын квотыг (minimum access tariff quotas) үзнэ үү.
1303	Tariff rate quota	Тоо хэмжээний хязгаарлалттай тарифын хувь хэмжээ. Тоо хэмжээний хязгаарлалттай тариф (tariff quota) үзнэ үү.
1304	Tariff schedule	Тарифын жагсаалт. Тухайн улсын зүгээс импорт болон экспортод ногдуулдаг тарифын хувь хэмжээг зааж өгсөн баримт бичиг. Мөрдөж буй (бодитоор ногдуулсан) тарифын хувь хэмжээ (applied tariff rates), Үүрэг хүлээсэн тарифын хувь хэмжээ (bound tariff rates), олон шатлалтай тариф (multi-column tariff), хөнгөлөлтийн жагсаалт (schedule of concessions), нэг шатлалтай тариф (single-column tariff) үзнэ үү.
1305	Tariff wedge	Тарифын тооцооллын гурван өнцөгт призм. Тарифын тооцооллын хувьд өсөн нэмэгдэх тарифын бүтцийн хүрээнд тавигддаг нөхцөлийн дагуу үүсдэг гурван өнцөгт призмээр илэрхийлсэн график тооцоолол. Өөрөөр хэлбэл энэ нь илүү гүн боловсруулсан бүтээгдэхүүнд ногдуулдаг тариф болон аажмаар илүү сайн боловсруулсан бүтээгдэхүүн болгон хувиргах ёстой арай бага хэмжээнд боловсруулсан бүтээгдэхүүнд ногдуулдаг тариф хоёрын хоорондын ялгаа гэсэн үг.
1306	Taxes occultes	Нууцлаг татвар. Энэ нь шууд утгаараа, далд нуусан татвар гэсэн үг. Энэ нь тухайн компани бүтээгдэхүүн үйлдвэрлэх үед хуримтлагдсан шууд бус татварууд. Жишээлбэл үйлдвэрлэлийн үйл явцад ашигласан үндсэн тоног төхөөрөмжид нийт ногдуулсан татварууд байж болно. Үүнд тухайн бүтээгдэхүүнд орсон эд ангиудад ногдуулсан татвар ордоггүй байна.
1307	Technical barriers to trade	Худалдаан дах техникийн саад тотгор. Стандарт, тохирооны үнэлгээний систем гэх энэхүү хоёр тогтолцооноос үүдсэн үр дагаврын улмаас худалдаанд учирсан саад тотгор гэж үздэг. Худалдаан дах техникийн саад тотгорын тухай ДХБ-ын хэлэлцээрт эдгээр саад тотгоруудыг уялдуулан зохицуулах, бууруулах, арилгах заалтууд орсон байдаг. Мөн Стандартуудыг бэлтгэл ажлыг хангах, батлах, хэрэгжүүлэх Зохистой дадлын хэм хэмжээ (Code of Good Practice for the Preparation, Adoption and Application of Standards), Цахилгаан техникийн олон улсын комисс (International Electrotechnical Commission) (Олон улсын цахилгаан холбооны комисс - Уругвай), Олон улсын стандартчиллын байгууллагыг (International Organisation for Standardisation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1308	Technical regulation	<p>Техникийн зохицуулалт. ДХБ-ын Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 1-р Зүйлд мөрдөгдөж болохуйц захиргааны заалтыг багтаасан, бүтээгдэхүүний шинж чанарыг эсвэл тэдгээртэй холбогдолтой үйл явц болон үйлдвэрлэлийн аргуудын дүрмийг гаргаж өгсөн баримт бичиг хэмээн тодорхойлсон байдаг бөгөөд тэдгээрийг заавал дагаж мөрдөх ёстой байдаг. Тийм баримт бичигт мөн нэр томьёо, тэмдэгтүүд, сав баглаа боодол, тухайн бүтээгдэхүүнд тавигдах тэмдэглэгээ эсвэл шошгожуулалтын шаардлагууд, боловсруулалтын болон үйлдвэрлэлийн арга зэргийг багтаасан эсвэл гагцхүү тэдгээртэй хамааралтай байж болно.</p>
1309	Techno-nationalism	<p>Техно - үндсэрхэг үзэл. Энэ нь хоёр үндсэн утгатай. Нэгдүгээрт, хэдийгээр [технологийн дэвшил] хаа нэгтээ аль хэдийнээ оршин байгаа ч гэсэн, технологийн дэвшлийг зөвхөн дотоодын хүчин чармайлтаар олж авсан тохиолдолд л ашигтай байдаг гэсэн санаа. Эдгээр дэвшлийг ихэвчлэн технологийг арилжааны аргаар импортолсноос хамаагүй их өртгөөр олж авдаг. Үр дүн нь ихэвчлэн муу байдаг. Энэ төрлийн технологийн үндсэрхэг үзлийн шалтгаанд, гадаад валютын хомсдол, үндэсний өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх хэрэгцээ, батлан хамгаалах асуудал болон “энд үйлдвэрлээгүй” гэх синдром зэрэг багтдаг. Хоёрдугаарт, энэ нь өрсөлдөөний давуу талыг бий болгоно гэж найдаж байгаа технологийн дэвшлийг уг гарал үүслийн улсынхаа хүрээнд байлгахад чиглэсэн бодлогыг илэрхийлж байгаа болно. Мөн Автократ дээд эрх мэдлийг хязгаарлалтгүйгээр захирагч/ганцаар захирах ёс (autarky), харьцангуй давуу тал (comparative advantage), өөрөө өөртөө найдах (self-reliance), өөрийгөө хангах чадварыг (self-sufficiency) үзнэ үү.</p>
1310	Telecommunications	<p>Цахилгаан холбоо. Цахилгаан холбооны үндсэн үйлчилгээний тухай хэлэлцээр (Agreement on Basic Telecommunications Services), Олон Улсын цахилгаан холбооны байгууллагыг (International Telecommunication Union) үзнэ үү.</p>
1311	Temporary Exclusion List	<p>Түр хугацаанд хасах жагсаалт. Энэ нь Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Чөлөөт худалдааны хэлэлцээрийн (AFTA) дүрмийн дагуу тухайн гишүүн улс нь бусад гишүүн улс орнуудад бүрэн хэмжээний хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх эрхийг олгоход хараахан бэлэн болоогүй байгаа бараа бүтээгдэхүүнийх нь жагсаалт. Харилцан зөвшилцсөн хуваарийн дагуу эдгээр бүх зүйлсийг 2003 он гэхэд жагсаалтаас хассан байх ёстой боловч зарим хөдөө аж ахуйн эмзэг мэдрэг бүтээгдэхүүний хувьд үүнд илүү урт хугацаа шаардагдана. Мөн эмзэг мэдрэг бүтээгдэхүүнүүдийн жагсаалтыг (sensitive list) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1312	Temporary normal trade relations	Худалдааны түр зуурын энгийн харилцаа. Энэ нь тухайн улс оронд үзүүлж буй үндэсний нэн тааламжтай нөхцөлтэй холбогдуулан, худалдааны түр зуурын энгийн харилцааг үе үе шинэчлэх ёстой болохыг илэрхийлсэн, АНУ-ын ашигладаг нэр томьёо. Мөн худалдааны хэвийн харилцаа (normal trade relations) болон худалдааны байнгын хэвийн харилцааг (permanent normal trade relations) үзнэ үү.
1313	Terms of trade	Худалдааны нөхцөл. Энэ нь нэг барааны үнийг ихэвчлэн өөр улс орнуудаас гарал үүсэлтэй байдаг өөр нэг барааны үнийн хувьд харьцуулсан харьцангуй үнийг (relative price) илэрхийлж байдаг. Хэрэв А улс нь В улсын үйлдвэрлэж буй эд зүйлд өөрийн бараа бүтээгдэхүүнээс илүү ихийг санал болгох шаардлагатай болсон тохиолдолд худалдааны нөхцөлүүд нь А улсын эсрэг чиглэдэг байна. Хэрэв худалдааны нөхцөлүүд нь А улсын талд нааштайгаар хандвал, дээр дурдсаны урвуу нөхцөл байдал үнэн болж хувирдаг. Мөн түүхий эд, материалын худалдааны нөхцөлийг (commodity terms of trade) үзнэ үү.
1314	Textiles and the GATT	Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн ба Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр. Мөн 1961 оны Хөвөнгийн сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний тухай Олон улсын худалдааны Богино хугацаат хэлэлцээр (Short-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textile), 1962-1973 оны Хөвөнгийн сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний тухай Олон улсын худалдааны урт хугацаат хэлэлцээр (Long-Term Arrangement Regarding International Trade in Cotton Textiles), 1974-1994 оны Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр (Multi-Fibre Arrangement), 1995 оны Текстиль (сүлжмэл, нэхмэл, оёмол) бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийг (Agreement on Textiles and Clothing) үзнэ үү.
1315	Textiles Monitoring Body	Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний Хяналт шалгалтын байгууллага (ТБХШБ - TMB). [Сүлжмэлийн мониторинг хийх байгууллага - Уругвай]. ДХБ-ын сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрт (WTO Agreement on Textiles and Clothing) тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэхэд хяналт тавих зорилгоор уг хэлэлцээрийн дагуу байгуулагдсан байгууллага. Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний худалдааг 2005 он гэхэд ДХБ-ын үндсэн заалтуудын дагуу эргээд хивэнд оруулах зорилгодоо хүрэхэд чиглэсэн ахиц дэвшлийн талаар Барааны худалдааны зөвлөлд тогтмол тайлагнах нь уг байгууллагын нэг үүрэг юм. Мөн Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийг (Multi-Fibre Arrangement) үзнэ үү.
1316	Textile Surveillance Body	Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний Хяналт, тандалтын байгууллага (ТБХТБ - TSB). [Сүлжмэлийн хяналт шалгалтын байгууллага - Уругвай]. Энэ нь Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрт (Multi-Fibre Arrangement) хяналт шалгалт хийж, удирдан явуулдаг байгууллага.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1317	Theory of hegemonic stability	Ноёрхогчийн тогтвортой байдлын онол. Энэхүү саналыг анх Чарльз Киндлебергер (1973) боловсруулсан бөгөөд үүнээс хойш бусад хүмүүс үүнд дасан зохицож, өргөжүүлсэн байдаг. Тэрээр 1930-аад оны Их хямралын шалтгаан болон түүний үргэлжлэн оршин тогтносоор байгаа байдалд хийсэн дүн шинжилгээндээ, дайн хоорондын жилүүдийн гол сургамжийн хувьд “дэлхийн эдийн засгийг тогтворжуулахын тулд үүнд тогтворжуулагч хэрэгтэй, нэг тогтворжуулагч” хэмээн дүгнэж хэлж байжээ. Энэхүү онолыг захиалагчдын үзэж байгаагаар бол, үүний мадаггүй зөв байдал нь ТХЕХ-ээр жишээ авч болох олон талт худалдааны тогтолцоог буй болгоход гол үүрэг гүйцэтгэсэн гэх АНУ-ийн үүрэг харуулсан байна.
1318	Theory of second-best	Хоёр дах шилдэг шийдлийн тухай онол. Энэ нь [нөөц бололцоог дээд зэргээр ашигласан] оновчтой худалдааны хамгийн анхны шилдэг шийдэл гэдэг бол гажуудуулах хүчин зүйлүүд болох татвар, монополууд эсвэл тарифууд зэргийн дарамтад ороогүй чөлөөт худалдаанд оршиж байдаг гэж үздэг олон улсын эдийн засгийн ухааны онол. Энэ онол нь, байж болох хамгийн төгс шийдэлд хүргэж чадахгүй байж болох ч гэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх замаар [нөөц бололцоог дээд зэргээр ашигласан] оновчтой түвшинд хүрэх зорилгод хүрэх боломж байсаар байгаа гэж үздэг байна. [Худалдааны] хамгийн анхны шилдэг шийдэл боломжгүй гэж үзвэл, хоёр дах шилдэг шийдэл бүхий үр дүн гаргах боломжтой ямар арга хэмжээнүүд байж болох вэ гэдэг нь тухайн хэрэг тус бүрээр хийсэн дүн шинжилгээнээс хамаарна. Мэдээж хэрэг хоёр дах шилдэг шийдлийн тухай онолыг эдийн засгийн бусад олон салбарт ашигладаг.
1319	Third-country dumping	Гуравдагч улсад хийх демпинг. Энэ нь өрсөлдөгч улс орнууд нь гуравдагч орны зах зээлд демпинг хийдэг арга туршлага бөгөөд тус улс нь мөн өөрсдийнх нь сонирхож буй зах зээл байдаг байна. Үүнд ДХБ-ын демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрт ийм гуравдагч улсад хийх демпингийн асуудлыг хамардаггүй байна.
1320	Third-country problem	Гуравдагч орны асуудал. Энэ нь тарифыг шугаман тооцооллын аргачлалаар бууруулах тухай Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний үеэр тодорхой асуудлыг хөндсөн худалдааны хуурамч нөлөөнд оноосон нэр. Улс орнууд өндөр тариф ногдуулдаг экспортын ашиг сонирхол бүхий цөөхөн хэдэн бүтээгдэхүүнтэй байдаг гэсэн таамаглал дээр уг асуудал тулгуурласан байдаг. Тиймээс бага тарифтай улс эдгээр бүтээгдэхүүнүүд дээр ижил хувь хэмжээгээр тарифаа бууруулахгүй байсан ч гэсэн тэд үүнд тийм ч их санаа зовдоггүй. Энэ нь дор хаяж загварчлалын тооцооллын дасгал хийхэд харагддаг, үүнд: гуравдагч орнуудыг тарифандаа тохиргоо хийхийг нь хүчлэх замаар, үр дүнд нь үүссэн худалдааны дэглэмийн үндсэн гол ачаалал бүхий дарамтыг тэдгээр гуравдагч орнууд руу шилжүүлэхэд нөлөөлж магадгүй юм. Тэгэхээр тухайн өгөгдсөн нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд тус улсын тогтоосон тарифын хувь хэмжээтэй хамаатуулсан зэрэглэлтэй холбоотой үүссэн асуудал гэж гарч ирж байгаа юм. Эдийн засгийн хэтийн төлөвийн үүднээс энэхүү асуудлыг илүү сайн ойлгох зорилгоор хийх аливаа оролдлого маш үр ашигтай зүйл байх болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1321	Third-line forcing	<p>Гуравдагч сувгаар шахах. Энэ нь Монополын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ашигладаг нэр томьёо. Энэ нь, яг зэрэгцээд хэрэв худалдан авагч нь тухайн бараа бүтээгдэхүүнийг гуравдагч эх үүсвэрээс худалдан авна гэсэн тохиолдолд л бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг ханган нийлүүлнэ гэсэн арга туршлагыг тайлбарлаж өгч байгаа юм. Хэрэв худалдан авагч энэ нөхцөлийг зөвшөөрөхгүй тохиолдолд, тухайн ханган нийлүүлэгч нь түүнтэй харьцахаас бүхэлдээ татгалздаг байна. Мөн хориг арга хэмжээг (boycott) үзнэ үү.</p>
1322	Third world	<p>Гуравдагч ертөнцийн орнууд. Энэ нь tiers-monde хэмээх Франц үгний орчуулга бөгөөд Англи хэл дээр ихэвчлэн “хөгжиж буй орнууд” гэж нэрлэх болсон тул нэг их түгээмэл хэрэглэгдэхээ больсон. Энэ нь ерөнхийдөө аж үйлдвэржсэн ардчилсан засаглалтай орнууд (анхдагч ертөнцийн улс орнууд) эсвэл коммунист орнуудын (хоёрдогч ертөнцийн улс орнууд) бүлэгт багтдаггүй улс орнуудыг хамруулдаг гэсэн ойлголттой байдаг. Иймэрхүү олон ерөнхий малгайлсан нэр томьёонуудын (umbrella term) адил энэ нь тухайн сэдвийн хувьд хэрэглэгдэхүйц анхны арга хандлагыг илэрхийлдэг боловч Харрисын Тайланд (Harries Report) харуулснаар бол энэ бүлэгт багтсан улс орнуудын дунд байдаг эдийн засгийн хөгжил, улс төрийн үзэл бодлын маш олон талт байдлуудыг бүрхэгдүүлэн далдалсан байдаг байна. Мөн Хөгжиж буй орнууд ба Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийг (Developing countries and the GATT) үзнэ үү.</p>
1323	Thirty : ten formula	<p>Гуч: арвын томьёо. Тарифыг шугаман аргачлалын дагуу хасахад чиглэсэн томьёоны анхны энэхүү саналыг Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний үеэр Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЕС) зүгээс санал болгосон байдаг. Уг санаа анхандаа оролцогч тус бүрийн тарифын хувь хэмжээний харьцуулалт байх болно гэж үзэж байсан ба хожим нь бага зэрэг өөрчлөөд: Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕСС), Япон, АНУ, Их Британи зэрэг улсуудыг хамгийн томоохон худалдаалагчид хэмээн засвар өөрчлөлт оруулсан байдаг. Өндөр түвшинтэй тарифын хэмжээ нь 30%-ийн ад валорем тарифаас (Импортлож эсвэл экспортлох барааны үнийн дүнгийн тодорхой хувиар илэрхийлсэн тарифын хэмжээтэй дүйцэхүйц) илүү их болж мөн бага хэмжээтэй тарифтай харьцуулсан зөрүү ялгаа нь 10%-ийн онооноос илүү гарсан тохиолдол бүрт, энэ нь хараахан бүрэн боловсруулж амжаагүй байгаа, шугаман аргачлалаар бууруулах томьёонд хамаарахаар байлаа. Энэ томьёог худалдааны бодит урсгалд ашиглах үед энэ нь учир утгагүй, нийцэмжгүй үр дүнд хүргэх байх гэж бодож байсан тул үүнийг орхисон байдаг. Энэ нь Давхар ялгаатай томьёогоор (double ecart formula) амжилтад хүрсэн байдаг. Мөн үнийн хэмжээнд албан ёсны хязгаар тогтоох бодлого (ecretement), Оргил тариф (peak tariffs) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1324	Tied aid	Уяж холбосон буцалтгүй тусламж. Энэ нь хөгжлийн албан ёсны тусламжийг хөгжиж буй орнуудад зээл хэлбэрээр олгохдоо тодорхой нөхцөл заадаг бөгөөд уг хөрөнгийн зарим хэсгийг нь тодорхой хэлбэрээр ба ихэнх тохиолдолд хандивлагч улсаас капитал бараа худалдан авах нөхцөл байдаг. Мөн холимог зээл (mixed credits), худалдаа ба тусламжийг (trade and aid) үзнэ үү.
1325	Tokyo Declaration	Токиогийн тунхаглал. Энэхүү тунхаглалыг 1973 оны 9-р сарын 14-ний өдөр Токио хотод болсон ТХЕХ-ын сайд нарын уулзалтын үеэр баталсан бөгөөд цаашид Олон талт худалдааны хэлэлцээний Токиогийн үе шатны яриа хэлэлцээ (Tokyo Round of Multilateral Trade Negotiations) гэж нэрлэгдэх болсон байна.
1326	Tokyo Round	Токиогийн үе шатны хэлэлцээ. Энэ нь 1973-1979 оны хооронд явагдсан ТХЕХ-ийн (GATT) олон талт худалдааны яриа хэлэлцээний долоо дах үе шатны яриа хэлэлцээ. Энэхүү үе шатанд 102 улс оролцов. Оролцооны үүднээс болон хэлэлцээний өргөн хүрээг хамарсан хэлэлцэх асуудлынх нь хувьд ч гэсэн энэ бол тухайн үеийн хамгийн томоохон яриа хэлэлцээний үе шат байв. Токиогийн яриа хэлэлцээний үе шатыг 1973 оны 9-р сарын 14-ний өдөр Токиод болсон Сайд нарын уулзалтаар эхлүүлсэн боловч уг яриа хэлэлцээний ихээхэн хэсэг нь Женев хотод явагдсан байдаг. Сайд нарын тунхаглалын дагуу яриа хэлэлцээний цар хүрээг дараах зорилтуудад чиглүүлсэн байна гэж зааж өгсөн байдаг, үүнд: (a) томьёоны аргачлалыг ашиглан тарифын хэлэлцээг хийх, (b) тарифын бус арга хэмжээг бууруулах, арилгах, (c) сонгосон салбаруудад бүх саад тотгоруудыг бууруулж, арилгах боломжийг судалж үзэх, (d) олон талт хамгаалалтын тогтолцоог хангалттай хэмжээнд нийцэлтэй байх эсэхийг судалж үзэх, (e) хөдөө аж ахуйн салбар дах онцлог шинж чанар болон түүний асуудлуудыг харгалзан үзэх замаар хөдөө аж ахуйн салбарт хэлэлцээ хийх, (f) халуун орны бүтээгдэхүүнийг онцгой бөгөөд тэргүүлэх ач холбогдолтой салбар хэмээн авч үзэх зэрэг болно. Сайдууд хэлэлцээг 1975 онд эцэслэн байгуулах ёстой гэж үзсэн байлаа. Токиогийн үе шатны яриа хэлэлцээнд АНУ, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС), Япон улсууд ба тэдгээрийн хоорондын харилцааны хүрээний үйл явдлууд давамгайлж байв. [АНУ-ын] Ерөнхийлөгч 1974 оны Худалдааны тухай хууль батлагдах хүртэл 1975 оны 1-р сар хүртэл хэлэлцээ хийх бүрэн эрхгүй байв. Хэлэлцээр хийх энэхүү эрх нь 1980 оны 1-р сарын 3-нд дуусах байсан. 1976 он бол Ерөнхийлөгчийн сонгуулийн жил байсан тул уг нөхцөл байдлыг хүндрүүлсэн байна. ЕЕС нь гишүүнчлэлээ 1973 оны 1-р сарын 1-ний өдрөөс ес хүртэл болгон өргөжүүлсэн бөгөөд өргөтгөсөн тогтолцооны ажил хийхэд хамаг анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байжээ. Үүний дагуу дотоод зохицуулалтын тогтолцоо нь илүү нарийн төвөгтэй болсон. Япон улс нэгдүгээр зэргийн худалдааны гүрэн болж хувирсан бөгөөд олон улс орнуудын хувьд протекционист дарамтын субъект болох болов.

Нарийвчилсан түвшний хэлэлцээ хийгдэх хэлэлцээний олон төрлийн бүлгүүд дөнгөж 1975 оны 2-р сард байгуулагдсан байна. Үүний ихэнхийг нь ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын албаны ажилтнууд удирдаж байлаа. Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний үед байснаас илүүтэйгээр хөгжиж буй улс орнууд яриа хэлэлцээнд татагдан оролцох болжээ. Энэ цаг үе бол хөгжиж буй улс орнуудын хүсэн хүлээлт улам бүр нэмэгдсэн үе байсан бөгөөд энэ нь Олон улсын эдийн засгийн шинэ дэглэмийн санаачилгыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон Умард-Өмнөд яриа хэлэлцээ эрчимжсэн үетэй давхцаж байв. 1973 он ба 1977 оны эхэн үе хоёрын хооронд нэлээд их хэмжээний шаардлагатай бэлтгэл ажил хийгдсэн боловч АНУ-ын шинэ засаг захиргаа өөрийн бодлогоо боловсруулж мөн хэлэлцээний шинэ багаа томилох хүртэл хэлэлцээнд ямар нэгэн бодит өөрчлөлт гарах боломж байсангүй. Хэлэлцээ нь 1977 оны 7-р сард, бодлого болон процедурын хувьд байсан гол томоохон ялгаануудаа тэгшитгэн шийдэж чадсан, АНУ болон Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг хоёрын хооронд болсон уулзалтаас хойш итгэл үнэмшилтэйгээр эхлэв. Хоёр тал 1978 оны 1-р сард эцэслэн байгуулсан байх дөрвөн үе шатаас бүрдсэн хурдасгасан цаг хугацааны хуваарьтай байхаар тохиролцоонд хүрчээ. Эхний үе шат нь, ажлын таамаглал болгосон Швейцарын томьёоллыг ашиглан тарифыг бууруулах томьёо болон хөдөө аж ахуйн салбарыг авч үзэх тусгай удирдамж зэргийг хамруулсан тарифын ерөнхий төлөвлөгөөнөөс бүрдсэн байх болно. Хоёрдох үе шат нь, тарифыг бууруулах хүсэлтүүд болон тарифын бус арга хэмжээг арилгах хүсэлтүүдийг хүснэгтлэн авч үзэх болно. Гуравдугаар үе шатанд, тарифын бус арга хэмжээний талаарх кодчиллолд зориулан [хуулийн] бичвэрийн төслийг хүснэгтлэх ажлыг авч үзээд, дөрөвдөх үе шатанд [ирсэн] саналуудыг хүснэгтлэх замаар [ирсэн] хүсэлтүүдэд оролцогчид хариу өгч ажиллах болно. 1978 оны 7-р сар гэхэд, хэлэлцээний үр дүнг тэнцвэржүүлэхэд шаардлагатай гэж үзсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг зааж өгсөн “Эрх зүйн бүтэц, хамрах хүрээний Харилцан ойлголцлын суурь баримт бичиг”-ийг өндөр хөгжилтэй орнуудын томоохон бүлэг гаргаж тавих боломжтой болсон байна. Хөгжиж буй орнууд энэхүү багц баримт бичгийг агуулгын талаас нь болон процедурынх нь хувьд эсэргүүцэж байсан. Тэд ялангуяа хэлэлцээний зах хязгаарт нь тэднийг орхихыг оролдсон байдлыг хараад эсэргүүцэж байжээ. Гэсэн хэдий ч уг баримт бичгийн багц нь 1978 оны 12-р сарын 15-ны өдөр хэлэлцээг эцэслэн хэлэлцээр байгуулах тохиролцоонд хүрснээр чухал хүчин зүйл болж өгсөн байдаг. Үүний дараа, 1979 оны 1-р сарын 3-нд дуусах дөрвөн жилийн хугацааны турш, татаасны дэмжлэг авсан импортын бүтээгдэхүүнүүдэд Татаасыг сөргүүлэн тэнцэтгэж, импортод татвар ногдуулах шаардлагыг цуцлах хүсэлт гаргах эрхийг Ерөнхийлөгчид олгосон байдаг, АНУ-ын Худалдааны тухай хуулийн нэг хэсэг болсон хэлбэрээр томоохон бэрхшээл гарч ирсэн байдаг. Хэрэв одоогоор байгаа үүрэг амлалтаа цуцлах хүсэлтийн хугацаа нь дуусаж, хүчингүй болбол, Татаасыг сөргүүлэн тэнцэтгэж, импортод ногдуулах татвар нь автоматаар хэрэгжих юм.

Конгресс уг цуцлах хүсэлтийг шинэчлэхэд дурамжхан байсан мэт боловч АНУ эхлээд дотоодынхоо асуудлыг шийдэхгүй юм бол хэлэлцээг эцэслэн байгуулахгүй хэмээн Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЕС) мэдэгдэнгүүт, АНУ тийнхүү үйлдсэн байна. Энэ явдал 1979 оны 3-р сарын сүүлчээр болсон бөгөөд Токиогийн үе шатны яриа хэлэлцээ 1979 оны 4-р сарын 12-нд албан ёсоор өндөрлөв. Хэлэлцээрийн үр дүнд өндөр хөгжилтэй орнуудын зүгээс аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд ногдуулах тарифыг дунджаар 35% -иар бууруулж, дундаж тарифыг найман жилийн хугацаанд үе шаттайгаар бууруулахаар 4.7%-д хүргэж бууруулав. Токиогийн үе шатны яриа хэлэлцээний үр дүнд есөн тусдаа хэлэлцээр (үүний зургаа нь “код буюу хуулийн эмхэтгэл” гэж нэрлэгдэх болсон), ТХЕХ-ийн зорилго, үйл ажиллагааны талаар дөрвөн харилцан ойлголцлын баримт бичигтэй боллоо. Эдгээр хэлэлцээрүүд болон харилцан ойлголцлын баримт бичгүүд нь ТХЕХ-ийн хуульд нэлээд ихээр нэмэгдэж орж ирсэн байна. Тэдний ихэнх нь цаашлаад Уругвайн үе шатны яриа хэлэлцээнд илүү дасан зохицож, уг яриа хэлэлцээний үр дүн болох албан ёсны [эрх зүйн баримт бичигт] тусгагдсан байна. Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний худалдаанд системчилсэн асуудлаар бага зэрэг ахиц гарсан байна. Энэхүү [хөдөө аж ахуйн] маш эмзэг салбарт улс төрийн болон худалдааны үргэлжилсэн сөргөлдөөн гарахаас зайлсхийхэд чиглэсэн, Хөдөө аж ахуйн олон талт эрх зүйн суурь бүтэц, хамрах хүрээг боловсруулах яриа хэлэлцээний дараа хэлэлцээг үргэлжлүүлэн явуулах ёстой гэдэг тохиролцоонд тэд хүрсэн байна. Бодит байдал дээр энэ нь яриа хэлэлцээг бүхэлд нь дүгнэж дуусгах боломжийг олгосон нэгэн арга хэрэгслээс илүү зүйл болж чадаагүй бөгөөд олон хүмүүсийн хүлээж байсанчлан, хэлэлцээг үргэлжлүүлсний дараа энэ нь хаашаа ч хөтөлсөнгүй. Халуун орны бүтээгдэхүүний талаар хийсэн хэлэлцээрийн үр дүн жигд бус байсан ч, эдгээр бүтээгдэхүүний бүх хүрээнд нь тарифын болон тарифын бус арга хэмжээнүүдийг бууруулсан тохиолдлууд гарсан байна. Хамгаалалтын олон талт тогтолцооны талаар ямар нэгэн тохиролцоонд хүрээгүй боловч тийм ч их амжилтгүй боловч хэлэлцээ амжилттай өрнөсөн байна. Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд ач холбогдолтой гэж харсан нэг үр дүн бол Зөвшөөрөгдөх заалт (Enabling Clause) байлаа. Энэ нь дэлхийн худалдааны тогтолцоонд хөгжиж буй орнуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд ТХЕХ-ийн өндөр хөгжсөн гишүүн улс орнуудыг, тарифын болон тарифын бус чиглэлээр хөгжиж буй орнуудын ашиг тусын тулд ялгавартай нөхцөлөөр нийцэж ажиллахыг зөвшөөрсөн байна. Үүний хувьд төлөвлөөгүй байсан нөлөөний нэг нь, ТХЕХ-т дүрэм журам боловсруулах үйл ажиллагаанд хөгжиж буй улс орнуудын цаашдын нөлөөллийг бууруулсан явдал байлаа. Мөн шугаман аргачлалын дагуу тарифыг бууруулах (linear tariff cuts), тусгай болон ялгавартай нөхцөл (special and differential treatment), Токиогийн үе шатны хэлэлцээрийг (Tokyo Round agreements) үзнэ үү.

1327 Tokyo Round agreements

Токиогийн үе шатны хэлэлцээр. Үүнийг Токиогийн үе шатны яриа хэлэлцээний нэг хэсэг болж эцэслэн батлагдсан, заримдаа эрх зүйн бүтэц, хамрах хүрээний суурь хэлэлцээр хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь тарифын бус арга хэмжээний зургаан код, салбарын хэмжээний гурван хэлэлцээр болон дөрвөн шийдвэрийг хамруулан нийтэд нь өгсөн нэршил. Өргөн утгаараа, засгийн газрууд эдгээр хэлэлцээрүүдийн алинд нь нэгдэж орох тал дээр сонголт хийх боломжтой юм. Төрөлжүүлэн нэгтгэсэн хууль буюу кодууд нь: (a) Ихэвчлэн “стандартуудын хуулийн эмхэтгэл” хэмээн нэрлэдэг Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээрт техникийн зохицуулалт, стандарт, чанарын хяналтын сорил, баталгаажуулалт зэрэг нь худалдаанд учруулах саад тотгор болохгүй байхыг эрэлхийлдэг, (b) Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр, энэ нь засгийн газрын хийж буй худалдан авалтад үл ялгаварлал, өрсөлдөөн, ил тод байдлыг авчрахад чиглэгдсэн, (c) ихэвчлэн “татаасан тухай хуулийн эмхэтгэл” гэж нэрлэдэг 6,16, 23-р Зүйл ангиудыг тайлбарлаж, хэрэглэх тухай хэлэлцээр, энэ нь татаас нь худалдааны бусад түнш орнуудын ашиг сонирхлыг хохироохгүй байх нөхцөлийг хангахад чиглэдэг, (d) “гаалийн үнэлгээний хуулийн эмхэтгэл” хэмээн нэрлэдэг 7-р Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр нь гаалийн зорилгоор бараа бүтээгдэхүүний үнэлгээ хийх шударга, нэгэн жигд, төвийг сахисан тогтолцоог эрэлхийлдэг, (e) Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр, энэ нь импортын тусгай зөвшөөрөл олгох шаардлага нь өөрөө худалдаанд саад хязгаарлалт болохгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн, (f) “демпингийн эсрэг хуулийн эмхэтгэл” хэмээн ихэвчлэн нэрлэдэг 6-р Зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр бол Кеннедигийн үе шатны яриа хэлэлцээний үеэр хэлэлцэж тохиролцсон демпингийн эсрэг хуулийн эмхэтгэлийн шинэчилсэн найруулга юм. Салбарын хүрээний гурван хэлэлцээрүүд бол: (a) Үхрийн махны тухай хэлэлцээр, энэ нь мах болон амьд малын худалдааг өргөжүүлж, либералчилж, тогтворжуулахад чиглэсэн, (b) Олон улсын сүү, цагаан идээн бүтээгдэхүүний зохицуулалт нь сүү, цагаан идээний дэлхийн худалдаанд мөн ижил нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг, (c) Иргэний агаарын тээврийн онгоц худалдаалах тухай хэлэлцээрийн дагуу үүнд оролцогчид нь иргэний агаарын тээврийн онгоц болон түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгүүдэд ногдуулах гаалийн татваруудыг арилгасан байдаг. Гаргасан дөрвөн шийдвэрүүд нь, хөгжиж буй улс орнуудад ялгавартай хандах, төлбөрийн тэнцлийн зорилгоор авч хэрэгжүүлж буй худалдааны арга хэмжээ, хөгжлийн чиглэлээр худалдааны арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь хөгжиж буй орнуудад зориулан илүү уян хатан боломж олгох, маргаан шийдвэрлэх арга хэмжээг сайжруулахтай холбоотой ойлголт зэрэг болно. Мөн ДХБ-ын Хязгаарлагдмал оролцогчидтой олон талт харилцааны онцгой хэлбэрийн хэлэлцээр (WTO plurilateral agreements), Дэлхийн худалдааны байгууллагыг (WTO) байгуулах Марракешийн хэлэлцээрийг (Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1328	Tokyo Round codes	Токиогийн үе шатны хэлэлцээрийн төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн актууд. Токиогийн үе шатны хэлэлцээрийг (Tokyo Round agreements) үзнэ үү.
1329	Top-down approach	Дээрээс доошоо чиглэсэн арга хандлага. Энэ нь худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийн ерөнхий хэлбэрийг тодорхойлон гаргахын тулд эхлээд худалдааны хэлэлцээний хөтөлбөрийг бэлдэж, дараагаар нь бие даасан бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар үргэлжлүүлэн авч үзэх нь илүү дээр гэж үзсэн зарчим. Мөн доороос дээш чиглэсэн арга хандлагыг (bottom-up approach) үзнэ үү.
1330	Torquay Tariff Conference	Торкий дах тарифын бага хурал. Энэ нь Нэгдсэн Вант улсын Торкий хотод, 1950 оны 9 дүгээр сараас 1951 оны 4 дүгээр сар хүртэл болсон бага хурал. Ажлын хөтөлбөр нь зургаан орныг (Австри, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Солонгос, Перу, Филиппин, Турк) Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрт (GATT) элсүүлэх талаар хэлэлцээнүүд, мөн оролцогч улс орнуудын хооронд тарифын хэлэлцээнүүд зэргээс бүрдсэн байлаа. Үүнийг одоо бол олон талт худалдааны хэлэлцээрүүдийн гурав дах үе шат гэж үздэг болсон. Эцэст нь Солонгос улс 1967 онд, Филиппин улс 1979 онд ТХЕХ-т элссэн байна.
1331	TPRM (Trade Policy Review Mechanism)	Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоо. Худалдааны бодлогыг хянан үзэх байгууллагыг (Trade Policy Review Body) үзнэ үү.
1332	Trade	Худалдаа. Энэ нь ихэвчлэн олон улсын хил дамнуулан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах болон түгээх асуудлыг илэрхийлж байдаг. Үүнийг хийх олон янзын арга байдаг боловч "худалдаа" гэж тодорхойлогдохын тулд хэлцлийн хувьд арилжааны бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Бартерын худалдаа (barter), арилжаа, худалдааны үйл ажиллагаа (commerce), нөхөн төлөх худалдаа (compensation trade), Угтвар худалдаа (countertrade) үзнэ үү.
1333	Tradeables	Арилжаалагдахуйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ. Энэ нь олон улсын зах зээлд арилжаалагдаж болохуйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ. Үүнд хамрагддаг жишээлбэл үйлчилгээний хувьд, агаарын тээврээр аялах, цахилгаан харилцаа холбоо, менежментийн зөвлөгөө гэх зэрэг зүйлс орох боловч, үс засах үйлчилгээ нь арилжаалагдахуйц үйлчилгээнд ихэвчлэн тооцогддоггүй байна. Мөн арилжаалагдаад байдаггүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ (non-tradeables) болон хагас арилжаалагдахуйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг (semi-tradeables) үзнэ үү.
1334	Trade agreement	Худалдааны тухай хэлэлцээр. Хоёр талын худалдааны хэлэлцээрийг (bilateral trade agreement) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1335	Trade and aid	<p>Худалдаа ба буцалтгүй тусламж. Энэ нь хөгжингүй орнуудын худалдааны бодлого ба буцалтгүй тусламжийн бодлогуудыг илүү сайн уялдуулан холбох замаар хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор дэвшүүлсэн бодлогын өргөн хүрээний асуудлуудыг хамардаг. Ихэнхдээ энэ нь өөрсдөө арилжааны хувьд ашиггүй, гэхдээ хүлээн авагч орны экспортын гүйцэтгэлд хувь нэмэр оруулж болох төслүүдийг санхүүжүүлэхэд зориулсан уяж холбосон буцалтгүй тусламж (tied aid), холимог зээл (mixed credits) олгох замаар хийгддэг. Хэдий тийм боловч, зарим нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилго болон, хандивлагч орнуудын хувьд (donor countries) шинээр үйлдвэрлэл ба экспортын хүчин чадал нь өсөн нэмэгдэж буй нөхцөлд тэдгээр улсын зах зээлүүдийг нээх хүсэл эрмэлзэл хоёрын хооронд салшгүй зөрчилдөөн байж болзошгүй гэж онцолжээ. Тиймээс, худалдаа болон тусламжийн тухай ойлголт нь хандивлагч улс орнуудын экспортлогчдод татаас олгох арга замаас өөрцгүй юм гэсэн үзэл юм. Мөн хөгжлийн албан ёсны тусламжийг (official development assistance) үзнэ үү.</p>
1336	Trade and competition	<p>Худалдаа ба өрсөлдөөн. Энэ нь олон улсын янз бүрийн чуулга уулзалтаар хэлэлцэгдэж буй худалдааны шинэ асуудлуудын нэг боловч Хаванагийн Дүрмийн (Havan Charter) үеэр аль хэдийн хэлэлцээний сэдэв болсон байлаа. Үүний ач холбогдолтой хоёр шалтгаан бий. Нэгдүгээрт, нээлттэй, өрсөлдөөнт зах зээлийн орчинд хөнөөлтэй дотоодод чиглэсэн арга хэмжээгээр дамжуулан, олон улсын худалдааны либералчлалын ашиг тусыг эсэргүүцэж болох талаар илүү ихээр хүлээн зөвшөөрөх болсон юм. Ийм саад тотгор нь өрсөлдөөний эсрэг хувийн зан төлөв, монопол болон давамгайл ханган нийлүүлэгчийн эрх мэдлээ урвуулан ашиглах, эсхүл засгийн газрын зохисгүй эрх зүйн тогтолцоо зэрэг хэлбэрээр байж болох юм. Зарим улс оронд, өрсөлдөөний сул бодлого эсвэл дотоодын эдийн засгийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн хамруулж чадаагүйгээр болж үүссэн асуудлууд улам дорддог. Хоёрдугаарт, худалдааны бодлого ба өрсөлдөөний бодлогын алийг нь эн тэргүүнд тавьснаас шалтгаалан, хоёр бодлогын алийг нь ч ашигласан өөр өөр үр дүнд хүргэж болзошгүй юм. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг жишээ бол, өрсөлдөөний тухай хуулийн дагуу явуулах үйл ажиллагааны туршилтын шаардлага хангахуйц байдал нь, санал болгосон демпингийн эсрэг арга хэмжээнд ашиглах туршилтаас илүү хэцүү байдаг. Энэ нь олон орны эдийн засгийн хувьд үнэн байдаг боловч дээр турдсанд хоёр багц хууль нь нэгэн ижил багц асуудлыг шийдвэрлэх гэж заавал ч хичээгээд байдаггүй. Ийм зөрчилдөөний байж болохуйц нөлөөллийг судалж шинжлэх нь олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны урсгалыг илүү жигдрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлоход тус болох магадлалтай. Өрсөлдөөний тухай хуулиуд нь үнэн хэрэгтээ олон улсын өрсөлдөөнийг дэмжих хамгийн шилдэг арга хэрэгсэл биш байж болзошгүй гэж үздэг, бүрэн үндэслэл бүхий, сайн мэтгэлцэн гаргаж ирсэн үзлийн талаар онцлох нь зүйтэй. Игнасио Де Леон шиг зарим хүмүүс юуг дутагдал гэж үзэж байгаа талаараа тайлбарлажээ.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Нэгдүгээрт, Де Леоны хэлж буйгаар, төгс өрсөлдөөний загвар болон монополийн эсрэг бодлогын дагуу явагддаг статик/хөдөлгөөнгүй зах зээл гэдэг нь бодит амьдралын өрсөлдөөнийг тийм сайн илэрхийлж чаддаггүй юм гэжээ. Хоёрдугаарт, тэрбээр, монополийн эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхэд улс төрийн эрх баригчдад (political actors) нүүрлэж байдаг сөрөг нөлөөнд анхаарал хандуулахыг хүссэн байна. Гуравдугаарт, итгэлцлийн эсрэг/монополийн эсрэг бодлого нь эдийн засгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн арилжааны хэлцлийн талаар туйлын эргэлзээ төрүүлдэг гэж үздэг, учир нь хууль сахиулагч агентлагуудын ялгаварлан гадуурхаж чадах эрх мэдлийг шүүхийн хяналтад үр дүнтэйгээр хянан хэлэлцүүлэхээр өгөх боломжгүй юм. Бусад нь үзэхдээ, ялангуяа газар зүйн хүрээнд авч үздэг зах зээлүүдийг бий болгоход, өрсөлдөөн болон худалдааны бодлого хоёрын хоорондын орлогдох чанар нэлээд хязгаарлагдмал байдаг гэж үздэг байна. Зах зээлийн бүтэц нь үндэсний болон олон улсын түвшний аль алинд нь өрсөлдөхүйц байдаг, олон улсын хэмжээнд арилжаалагдаж болохуйц бараа бүтээгдэхүүний жагсаалт нь үнэндээ маш цөөхөн байдаг гэж тэд үздэг. Энэхүү асуудлыг судлах зорилгоор 1996 оны 12 дугаар сард, ДХБ-ын Сингапурын Сайд нарын бага хурлаас (WTO Singapore Ministerial Conference), Худалдаа ба өрсөлдөөний бодлого хоёрын хоорондын харилцан үйлчлэлийн асуудлыг хариуцсан Ажлын хэсгийг (Working Group on the Interaction between Trade and Competition Policy) байгуулсан байна. Мөн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Худалдаа ба өрсөлдөөний тухай Хамтарсан бүлэг (Joint Group on Trade and Competition) нь, худалдаа ба өрсөлдөөний бодлого хоёрын хоорондын харилцааг тодруулах зорилготой ажиллаж байна. Мөн Монополийн эсрэг (antitrust laws), өрсөлдөөний бодлого (competition policy), зах зээлийн олон улсад өрсөлдөх чадвар (international contestability of markets), болон бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг (restrictive business practices) үзнэ үү.</p>
1337	Trade and corruption	Худалдаа ба авлига, хээл хахууль. Худалдаа ба хууль бус төлбөрийг (trade and illicit payments) үзнэ үү.
1338	Trade and culture	Худалдаа ба өв соёл. Энэ нь худалдааны боломжит шинэ асуудлуудын нэг болох боловч хараахан ямар нэгэн хэлэлцээний хөтөлбөрт ороогүй байгаа. Энэ нь олон улсын худалдаа нь соёлын хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлог шинж чанарт хэрхэн нөлөөлж буй асуудлыг харгалзан үздэг. Нарийн утгаараа, уг сэдвийн хүрээнд аудио [авиа дууны систем] болон дуу, дүрс бичлэгийн хэрэгслийн (audiovisual) худалдаа, жишээ нь, үүнд хэрэглэдэг дотоодын агууламжийн дүрэм зэрэг засгийн газрын арга хэмжээнүүдийг хамардаг. Зарим хүмүүс үүнийг, тухайн улс орны соёлын өвөрмөц онцлог шинж чанарт олон улсын худалдаа болон хөрөнгө оруулалтын зүгээс үзүүлэх нөлөөллийг илүү өргөн хүрээнд хамардаг гэж үздэг байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Энэхүү ач холбогдолтой асуудлын хэсэг нь Худалдаа ба хөрөнгө оруулалт нь орон нутгийн уламжлал, ёс заншлыг устгаж, бусад улс орны соёлын өвөрмөц онцлог шинж чанарыг живүүлэхээр заналхийлж байдаг гэж үздэг соёлын империализмын (cultural imperialism) онолыг бүрэлдүүлж буй санааг илэрхийлдэг байна. Энэ байдлаар ойлгосноор, уг асуудал нь өөр тохиолдолд байж боломгүй хамгаалалтын протекционист арга хэмжээг (protectionist actions) зөвтгөх шалтгааныг бий болгож магадгүй юм. Мөн дуу, дүрс бичлэгийн үйлчилгээнүүд (audiovisual services), өргөн нэвтрүүлгийн удирдамж (broadcasting directive), болон Канадын тогтмол хэвлэлүүдийг (Canadian periodicals) үзнэ үү.
1339	Trade and debt	Худалдаа ба өр зээл. Тухайн улсын худалдааны бодлого болон түүний экспортын зорилтод учирч буй саад бэрхшээл мөн эрт дээр үед хэзээ нэгэн цагт авсан зээлээ эргэн төлөх хэрэгцээ шаардлага зэрэг асуудлын дунд үүсдэг харилцааг авч үздэг. Эдгээр асуултуудын үйл явц нь удаашралтай байх өндөр магадлалтай, учир нь зарим талаараа худалдааны яам болон сангийн яамдыг тэдний бодсоноос илүү ойр дөт хамтран ажиллахыг шаардах болно.
1340	Trade and Development Act of 2000	2000 оны Худалдаа ба Хөгжлийн тухай хууль. Энэхүү АНУ-ын хууль бөгөөд морин тойруулгын гэгддэг хууль тогтоомжийг (carousel legislation) агуулсан байдаг.
1341	Trade and Development Board	Худалдаа ба Хөгжлийн зөвлөл (TDB). Энэ нь дөрвөн жилд нэг удаа хуралддаг бага хурлуудын хооронд үүрэг гүйцэтгэдэг, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын гүйцэтгэх байгууллага. Уг байгууллага нь ээлжит хуралдаанаар жилд нэг удаа уулздаг бөгөөд макро эдийн засгийн бодлогууд, мөнгөний болон санхүүгийн асуудлууд, худалдааны асуудлууд, худалдааны бодлогууд, бүтцийн өөрчлөлтийн тохиргоо, эдийн засгийн шинэтгэл болон холбогдох асуудлууд гэх зэрэг асуудлуудын олон улсын үр дагаврыг авч үздэг. Мөн, голчлон менежмент болон институтийн талаар асуудлуудыг авч үзэх үүднээс жилд гурван удаа хүртэл, нэг өдрийн удирдлагын шатны хуралдаан хийх нөхцөл гэж байдаг.
1342	Trade and Development Report	Худалдаа ба хөгжлийн тайлан. Энэ нь жил бүр НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас (UNCTAD) гаргадаг тайлан. Энэ нь тухайн үедээ ягшмал сургаалын шинж чанарт баригддаг байсан, хөгжиж буй орнуудын тухай хуучин хэтийн төлөвлөгөөгөө ихээхэн хэмжээгээр хаягдуулсан бөгөөд үүнийг өнөөгийн худалдааны бодлогын асуудлуудыг дүн шинжилгээнд ашигтайгаар ашиглах боломжтой болсон.
1343	Trade and employment	Худалдаа ба ажил эрхлэлт - Уругвай. Энэ нь 1947-оос 1948 оны хооронд болсон НҮБ-ын Худалдаа ба хөдөлмөр эрхлэлтийн тухай бага хурал (United Nations Conference on Trade and Employment) болон түүний бэлтгэл уулзалтуудын хөтөлбөрт орсон хэлэлцэх зүйлсийн нэг юм. Үүнийг хамруулах болсон шалтгаан нь гуйлгачин хөршийн бодлогуудын (beggar-thy-neighbour policies) улмаас улам бүр нэмэгдэж байсан дайны өмнөх ажилгүйдэл нь дайныг эхлүүлэх гол хүчин зүйл болж байсан талаар хүлээн зөвшөөрснөөр үүссэн юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Уг бага хурал эхэлснээс хойш зөрчилдөөн үүссэн бөгөөд хоёр тал болж хуваагдсан байлаа. Үүнд, нэг тал нь үр дүнтэй хөдөлмөр эрхлэлтийн тухай заалтуудыг өнөөдрийн нэрлэж заншсанаар бол Гаванагийн дүрэм гэх болсон дүрэмд (Havana Charter) оруулахыг хүсэж байсан бол нөгөө тал нь бүрэн бүтэн хөдөлмөр эрхлэлтийг адилхан хүсэж байсан ч гэсэн, НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийг (ECOSOC), ялангуяа мөчлөгийн шинжтэй ажилгүйдэл болон түүнтэй тэмцэх арга хэмжээг зохицуулж чадах зохистой байгууллага гэж үзсэн хүмүүс байлаа. Хаванагийн дүрэм нь гишүүддээ дараах үндсэн үүргүүдийг хүлээлгэсэн: (a) өөрсдийн нутаг дэвсгэртээ иж бүрэн хөдөлмөр эрхлэлтийг бий болгох ба үүнийгээ барьж хадгалах; (b) дүрмийн бусад заалтуудтай нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой байлгах тухай арга хэмжээ авах; (c) бусад улс оргуудад төлбөрийн тэнцэл (balance-of-payments) бий болгох хүндрэл, бэрхшээл бий болгох арга хэмжээ авахаас зайлсхийх; (d) шударга бус хөдөлмөрийн нөхцөлийг арилгах талаар боломжтой арга хэмжээ авах; (e) төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой байнгын гардаг асуудлуудыг арилгахад бусад оролцож буй улс орнуудтай хамтран ажиллах; болон (f) хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ECOSOC-ээс ивээн тэтгэж буй үйл ажиллагаануудад оролцох юм. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр (Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation) болон Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрүүд (General Agreement on Tariff and Trade - GATT) нь бүрэн хөдөлмөр эрхлэлтийг хангах тухай оршил буюу удиртгал хэсэгтээ зорилт болгон тусгаж оруулсан байдаг. Зарим нь үүнийг ДХБ-д худалдаа болон хөдөлмөрийн асуудлуудыг нягталж судлах эрх мэдлийг өгдөг гэж үздэг боловч, энэхүү дүгнэлт нь нөхцөл байдлыг гуйвуулан тодорхойлдог байна.</p>
1344	Trade and environment	<p>Худалдаа ба хүрээлэн буй орчин. Энэ нь зарим хүмүүсийн үзэж буйгаар худалдааны шинэ асуудлуудын нэг. Олон улсын худалдааг өргөжүүлэх арга хэмжээ болон хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ хоёрын хоорондын харилцан үйлчлэлээс үүдэж гарсан асуудлуудад хамаатай юм. Пирсоны (1993) хэлж буйгаар бол, үнэн хэрэгтээ өнөөгийн бүх худалдаа ба хүрээлэн буй орчны асуудлууд дараах ангиллуудын аль нэгэнд нь багтдаг байна, үүнд: (i) хүрээлэн буй орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтын худалдаанд үзүүлэх үр нөлөө, (ii) хүрээлэн буй орчинтой холбоотой бараа бүтээгдэхүүний стандартын худалдаанд үзүүлэх үр нөлөө, (iii) олон улсын хүрээлэн буй орчны зорилтуудыг баталгаажуулахын тулд худалдааны арга хэмжээг ашиглах, болон (iv) худалдаа ба худалдааны либералчлалын зүгээс хүрээлэн буй орчинд үзүүлэх үр нөлөө зэрэг орно. Хүрээлэн буй орчны стандартуудын хоорондын ялгаа нь бага зардалтай байх боломжийг эдэлж буй хүмүүсийн хувьд ашиглаж болох үнийн ялгавартай байдалд хүргэх магадлалтай талаар нэлээд их маргаан үүссэн байдаг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Хүрээлэн буй орчны стандартуудын хоорондын ялгаа нь эцэстээ бага зардалтай байх нөхцөлийг ашиглагч нарын дуртай, зардлын ялгаатай байдалд хүргэж болзошгүй юм гэсэн ихээхэн маргаан байдаг. Хүрээлэн буй орчны зорилтуудыг дэмжих зорилгоор худалдааны арга хэмжээг ашиглах нь зүйтэй гэсэн саналд бодлого боловсруулагч нар ерөнхийдөө нааштайгаар ханддаггүй байна, учир нь, энэ нь хүрээлэн буй орчныг хамгаалах зорилготой хариугүй байдлаар уялдаатай цоо шинэ цуврал протекционист [буюу байгаль орчныг хамгаалах үзэлтэн] (protectionist) арга хэмжээнд хүргэж болзошгүй юм. Юутай ч, зарим хүрээлэн буй орчны олон талт хэлэлцээрүүдэд олон улсын худалдааг хамарсан чухал арга хэмжээнүүдийг агуулсан байдаг. Эдгээр асуудлуудаар ДХБ-ын Худалдаа ба хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн хороонд (WTO Committee on Trade and Environment) одоогийн байдлаар ажлын хөтөлбөр боловсруулж байгаа. Уг хороо нь бараа болон үйлчилгээг хамардаг байна. Мөн 21-р зууны Хөтөлбөр (Agenda 21), Базелийн конвенц (Basel Convention), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), ДХБ дах хүрээлэн буй орчны арга хэмжээ (environmental measures in the WTO), Эс хэрэглэх нийтлэг тохиолдол (general exceptions), Олон улсын худалдаан дах химийн бодисын тухай мэдээллийг харилцан солилцох тухай Лондонгийн зааварчилгаа (London Guidelines for the Exchange of Information on Chemicals in International Trade), Монреалын протокол (Montreal Protocol), ёроол руу уралдах тухай мэтгэлцээн (race to the bottom argument), Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаглал (Rio Declaration on Environment and Development), болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцийг (United Nations Framework Convention on Climate Change) үзнэ үү.</p>
1345	Trade and foreign exchange	<p>Худалдаа ба гадаад валют. Үүнийг ДХБ-ын хүрээнд (WTO) худалдааны шинэ асуудал болгож анхааралдаа авч үзэхийг санал болгосон байдаг. Энэ нь олон улсын худалдаа болон валютын ханшийн тогтолцоо хоёрын хоорондын харилцаанд хамаарна. Үүнийг дэмжигч нар валютын ханшны чөлөөтэй хөрвөх (floating exchange rate) систем нь худалдааны системд протекционист буюу хамгаалалтын үзлийн дарамт болж байдаг шалтгаануудын нэг гэдэгтэй санал нийлэх чиг хандлагатай байдаг. Бусад нь харин хатуу тогтоосон валютын ханшны систем нь (fixed exchange rate system) протекционист буюу хамгаалалтын үзэлд хүргэсэн гэж үздэг байна. Цөөн тооны хүмүүс эртхэн хэлэлцээр эхлүүлэх хүсэлтэй байгаа бололтой.</p>
1346	Trade and human rights	<p>Худалдаа ба хүний эрх. Энэхүү илэрхийлэл нь гурван өргөн хүрээний асуудлуудыг хөнддөг. Тэдний хувьд, олон улсын худалдаа нь оролцогч улс орнуудад хүний эрхийг эдлэх, эсхүл хэрэгжүүлэхэд нь нөлөөлж болно гэсэн нийтлэг үзэл бодолтой байдаг. Эхний асуудал нь, хөгжиж буй орнууд худалдаагаа либералчлах нь тэдэнд эдийн засгийн үр ашигаас нь даван гарсан нийгмийн зардал үүсгэхэд хүргэдэг гэсэн гутранги үзэл байдаг.</p>

Мөн, эдгээрийн үр ашигийн ихэнх нь гагцхүү давуу эрх бүхий цөөн тооны хотын оршин суугч нарт олгогддог бөгөөд нийгмийн бусад бүлгүүд нь амьжиргааны түвшингээс улам хол хоцорч байна гэж үздэг байна. Даяарчлалыг хөгжиж буй орнуудын нийгмийн бүтцийг дордуулж, тэднийг хөгжингүй орнуудаас илүү хамааралтай болгодог гэж үздэг хүмүүс ялангуяа энэхүү үзэл бодлыг тээж явдаг байна. Худалдааны либералчлал нь үргэлж бүтцийн зарим нэг өөрчлөлтөд хүргэдэг боловч энэ нь мэдээж үүний цорын ганц шалтгаан биш юм. Бүтцийн өөрчлөлт хийх шаардлагаас болж зарим ажил мэргэжлүүдийн хувьд сөргөөр нөлөөлөх боловч эдийн засгийн хөгжил цэцэглэлт нэмэгдэхийн хэрээр хүний эрхийг баримталж мөрдөх байдал сайжирч байгааг бүх баримт нотолгоо ерөнхийдөө харуулж байна. Мөн, уламжлалт ажил мэргэжилтэй хүмүүс орчин үеийн салбарт ажиллаж байгаа хүмүүсээс илүү хөрөнгөтэй, амьдрал нь дээшилсэн гэдэг ташаа ойлголт байдаг. Хоёрдугаар асуудал нь, худалдаа ба хүний эрх гэдэг нь хүний эрхийг дэмжих эсвэл хэрэгжүүлэхэд худалдааны арга хэмжээнүүдийг ашиглах ёстой гэсэн байр суурийг илэрхийлдэг. Энэ нь ихэнхдээ хөдөлмөрийн гол үндсэн стандарт хэм хэмжээг (core labour standards) илүү сайн баримталж мөрдөхөд чиглэсэн байдаг. Уг үзэл бодлыг баримталдаг хүмүүс, янз бүрийн хүчин зүйлээс хамаарч хэлэлцэн тогтож болдог [хэлэлцээрийн] нэг талын эрх зүйн актууд учраас энэхүү зорилгын үүднээс Хөнгөлөлтийн ерөнхий системийн схемийг ашиглахыг дэмжих хандлага байдаг байна. Гуравдах асуудал нь, хөдөлмөрийн гол үндсэн стандарт хэм хэмжээ гэдэг байдлаар хүний эрхийг дагаж мөрдөхгүй байх нь тухайн экспортлогч улсын экспортлогчдийн хувьд илүү бага зардалтай байдаг гэж үздэг тул, экспортлогч улс оронд шударга бус давуу талыг бий болгодог гэсэн бодол санаа байдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь зарим талаараа ядуугийн тэтгэмжээр амьдрагчдын хөдөлмөрийн маргаан (rauper-labour argument) юм. Хэдийгээр практик туршлага дээр үндэслэсэн судалгаанууд энэхүү саналын үндэслэлд эргэлзээ төрүүлж байсан ч, импортлогч улс орнууд ийм төрлийн шударга бус практик үйл ажиллагаанаас өөрсдийгөө хамгаалахын тулд худалдааны арга хэмжээг ашиглах боломжтой байх ёстой гэсэн шийдлийг ихэвчлэн дэмждэг юм. Энэ нь нийгмийн демпингийн (social dumping) эсрэг дүрмүүдийг уриалах гол үндэс суурь юм. Хөгжлийн бүхий л үе шатандаа байгаа улс орнуудад тулгарч буй хүний эрхийн асуудлуудыг хэрхэвч дутуу үнэлж болохгүй. Гэвч харамсалтай нь, олон тохиолдолд худалдаа ба хүний эрхийн дүрмүүдийг уриалах нь үнэн хэрэгтээ, хөгжиж буй орнуудын эсрэг протекционист арга хэмжээ авах тухай уриалахаас өөрцгүй зүйл үгүй юм. Мөн нийгмийн тухай дүрэм (Social Charter), олон улсын худалдааны либералчлалын нийгмийн хэмжүүр (social dimension of the liberalization of international trade), болон ялгавартай цалингийн тухай мэтгэлцээнийг (wage-differential argument) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1347	Trade and illicit payments	<p>Худалдаа ба хууль бус төлбөр. Энэ нь худалдааны шинэ асуудлуудын нэг. Энэ нь засгийн газрын худалдан авалт дах хээл хахууль, авлига болон хангалтгүй хэмжээний ил тод байдал зэргийг хамаарна. Уг асуудлаарх хэлэлцээний гол санаачлагч нь АНУ байв. Ийм хэлэлцээний зорилго нь өөрийн хууль тогтоомжийн дагуу хууль бус төлбөрийг хориглох арга хэмжээг дэмжих явдал бөгөөд энэ нь тийм төлбөрийг Гадаад дах авилгын хэргийн тухай хуулийн/актын (Foreign Corrupt Practices Act) дагуу зөрчил гэж үздэг байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад (OECD) хэлэлцсэн, Олон улсын бизнесийн хэлцээнүүдэд гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх конвенц (Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions) нь 1999 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд ДХБ-д үүнтэй ижил төстэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг шаардсан уриалгыг ихээхэн багасгасан байдаг. Уг конвенц нь олон улсын бизнесийн хэлэлцээний явцад гадаадын төрийн албан тушаалтанд хээл хахууль санал болгох, амлах эсвэл өгөхийг гэмт хэрэг гэж тооцдог болгосон. Мөн Хууль бус төлбөрийн тухай олон улсын хэлэлцээрийн төслийг (Draft International Agreement on Illicit Payments) үзнэ үү.</p>
1348	Trade and investment	<p>Худалдаа ба хөрөнгө оруулалт. Хэдийгээр Гаванагийн дүрмийн (Havana Charter) нэг хэсэг болгож хөрөнгө оруулалтын талаарх зарим анхан шатны дүрмүүд бий болсон ч, энэ нь худалдааны шинэ асуудлуудын нэг. Энэхүү асуудал нь олон улсын эдийн засгийн харилцааны хүчин зүйл болох худалдаа ба хөрөнгө оруулалтын хоорондын харилцаа холбоо болон хөрөнгө оруулалт нь зах зээлд нэвтрэх асуудал болох болсонтой хамааралтай. Өргөн утгаар нь яривал, урт хугацааны туршид худалдаа болон хөрөнгө оруулалтыг тус тусдаа байдаг бодлогын асуудлууд гэж авч үзэх хандлагатай байдаг байсан. Өнөө үед, энэ хоёулаа бие биенээ харилцан нөхдөг гэж улам их үзэх болжээ. Хил хамгаалалт буурч байгаа тохиолдолд, хөрөнгө оруулалтын урсгал нь худалдааны шинэ хэлбэрийг идэвхижүүлж, хуучныг бэхжүүлж чаддаг байна. Бусад тохиолдолд, өндөр тарифууд нь импортыг бодиттой бус сонголт болгодог тул компаниудыг зорилтот зах зээлдээ их бага хэмжээгээр хөрөнгө оруулж мөн үйлдвэрлэл эрхлэхийг шаардах болсон байна. Энэхүү асуудлыг судлах зорилгоор ДХБ-ын Сингапур дах Сайд нарын бага хурлын үеэр (WTO Singapore Ministerial Conference), 1996 оны 12 дугаар сард Худалдаа, хөрөнгө оруулалт хоорондын харилцааг судлах Ажлын хэсгийг (Working Group on the Relationship between Trade and Investment) байгуулсан. Мөн даяаршил (globalization) болон Хөрөнгө оруулалтын талаарх олон талт хэлэлцээрийг (Multilateral Agreement on Investment), тарифыг огцом өсгөхийг (tariff-jumping) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1349	Trade and Investment Access Facility	Худалдаа ба хөрөнгө оруулалтын хүртээмжийг дэмжих арга механизм. Энэ нь хөгжиж буй улс орнуудад даяаршлын боломжуудад дасан зохицох болон завшааныг ашиглах үйл явцад туслах зорилгоор Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн төр засгийн тэргүүнүүдийн уулзалтаас (CHOGM) 1997 оны 10 дугаар сард байгуулсан механизм. Энэхүү арга механизм нь улс орнуудад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаа болон хөрөнгө оруулалтын либералчлалын эдийн засгийн болон нийгмийн боломжит нөлөөллийг тодорхойлох, зохицуулахад туслах, орлогын шинэ эх үүсвэр болон зах зээлийн боломжуудыг тодорхойлох, болон улс орнуудад ДХБ-ын шаардлагуудыг гүйцэтгэн хэрэгжүүлэхэд нь дэм болох техникийн туслалцаа үзүүлэх зэрэгт техник туслалцаа үзүүлэх болно. Энэ нь Хамтын нөхөрлөлийн (Commonwealth) дор ажиллах болно.
1350	Trade and Investment Facilitation Agreement	Худалдаа ба Хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх тухай хэлэлцээр. Энэ нь өнөөгийн дүрэм, журмыг илүү жигдрүүлэн хэрэгжүүлэх замаар түншүүдийн хооронд худалдаа ба хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөхөд чиглэсэн гэрээ юм.
1351	Trade and Investment Framework Agreement	Худалдаа ба Хөрөнгө оруулалтын тухай эрх зүйн бүтэц, хамрах хүрээ бүхий суурь хэлэлцээр. Энэ нь талуудын хооронд худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдан явуулахад чиглэсэн өргөн хүрээний зарчмууд ба зорилгыг тодорхойлсон олон улсын гэрээ. Уг гэрээг дагалдаад илүү нарийвчилсан нөхцөлүүдийг шаардсан асуудлуудын талаар, илүү нарийвчилсан дэд эрх зүйн актууд гарч болох юм.
1352	Trade and labour standards	Худалдаа ба хөдөлмөрийн стандарт. Энэ нь худалдааны шинэ асуудлуудын нэг. Энэ нь экспортлогч орнуудад хөдөлмөрийн стандарт хэм хэмжээний хамгийн доод түвшинг дэмжихэд худалдааны дүрмийг ашиглах эсэх талаар тавьдаг асуудлыг хамаардаг байна. Эдгээр худалдааны шинэ асуудлуудыг хөнддөг бусдын нэгэн адил, энэ асуудлыг үнэн хэрэгтэй тодорхой хугацааны туршид ярьсаар ирсэн байдаг. Зарим нь үүнийг 19 дүгээр зууны боолчлолын эсрэг кампанит үйл ажиллагааны үеэс эхэлсэн гэж үздэг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (International Labour Organisation-ILO) 1919 оны үндсэн хууль нь хөдөлмөрийн стандарт хэм хэмжээг батлах болон хөхиүлэн дэмжих гол зорилттой байв. Зарим хүмүүсийн хувьд “Хөдөлмөрийн шударга стандартууд” гэсэн ойлголт нь, гишүүн улс орнууд “эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүдийн хөдөлмөрийн шударга болон хүнлэг нөхцөлийг өөрийн улс орондоо болон өөрсдийн арилжаа худалдаа, үйлдвэрлэлийн харилцаагаа өргөжүүлж буй бүх улс орнуудад хангаж, хадгалж ажиллахад” хүчин зүтгэл гаргасан, Үндэстнүүдийн Лигийн тухай пакт/ гэрээ хэлцлийн (Covenant of the League of Nations) 23 дугаар зүйлийн (a) хэсгээс гарал үүсэлтэй гэж үздэг.1941 онд батлагдсан Атлантын дүрмэнд тусгаснаар бол “бүгдэд, хөдөлмөрийн стандарт хэм хэмжээг сайжруулж, эдийн засгийн ахиц дэвшил болон нийгмийн хамгаалал, аюулгүй байдлыг” хангахыг эрэлхийлсэн байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>1943 онд, Олон улсын хөдөлмөрийн газраас “өнөөгийн нөхцөл байдал нь хангалтгүй байгаа ямар ч тохиолдолд, хяналтанд буй түүхий, эд материалын үйлдвэрлэлд хөдөлмөр эрхэлж буй хүмүүст шударга цалин урамшуулал хүртээх, зохих нийгмийн хамгаалал аюулгүй байдлын хамгаалалтаар хангах зохицуулалт байх ёстой бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлүүд хангалттай байх” талаар зөвлөмж гаргасан. Гаванагийн дүрмийн (Havana Charter) 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт олон улсын худалдаа болон хөдөлмөрийн стандартын хэм хэмжээний хоорондын уялдаа холбоог илүү нарийвчлан тодорхойлсон бөгөөд үүнд “ялангуяа экспортын үйлдвэрлэлийн хүрээнд байгаа шударга бус хөдөлмөрийн нөхцөл нь олон улсын худалдаанд асуудал үүсгэдэг бөгөөд иймээс, гишүүн бүр өөрийн нутаг дэвсгэрийнхээ хүрээнд ийм нөхцөл байдлыг арилгахад тохиромжтой болон хэрэгжиж болохуйц аливаа арга хэмжээг авах ёстой” гэж тэмдэглэсэн байдаг. Мөн, олон улсын түүхий эд, материалын зарим зохицуулалтад хөдөлмөрийн шударга стандарт хэм хэмжээг хөхиүлэн дэмжихийг гишүүддээ уриалсан заалтуудыг агуулсан байдаг. Мөн, хүүхдийн хөдөлмөр (child labour), хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээ (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), нийгмийн дамнинг (social dumping), нийгмийн шинэ чанартай татаас (social subsidies), болон худалдаа ба хүний эрхийг (trade and human rights) үзнэ үү.</p>
1353	Trade and social conditions	<p>Худалдаа ба нийгмийн нөхцөл байдал. Хүүхдийн хөдөлмөр (child labour), хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээнүүд (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), нийгмийн шинж чанартай шошгожуулалт (social labelling), худалдаа ба хөдөлмөрийн стандарт хэм хэмжээнүүд (trade and labour standards), болон ажилчдын эрхийг (worker rights) үзнэ үү.</p>
1354	Trade and taxation	<p>Худалдаа ба татвар ногдуулалт. Энэ нь олон талт худалдааны хэлэлцээнүүдийн ирээдүйн үе шатны яриа хэлэлцээний хөтөлбөрт оруулахаар зарим хүмүүсийн санал болгосон асуудал. Энэ нь татвар ногдуулах тогтолцоог тухайн улсын олон улсын худалдааг гажуудуулахад ашиглаж болох юм гэсэн ойлголтод үндэслэсэн. Уг асуудлын хэтийн түвэгтэй байдал гэдэг бол, худалдаа ба албан татвар ногдуулах арга хэмжээ хоёрын хоорондын шууд харилцааг хүлээнзөвшөөрдөг тэдгээр хүмүүсийн ихэнх нь энэ талаар юу хийж болох талаар хэлэлцүүлэг эхлүүлэхийг бараг хүсэхгүй байгаа нь харагддаг юм. Мөн худалдааны шинэ асуудлууд (new trade issues) болон үнэ шилжүүлэлтийг (transfer pricing) үзнэ үү.</p>
1355	Trade-balancing requirement	<p>Худалдааг тэнцвэржүүлэх шаардлага. Ийм нөхцөлийг заримдаа өөр улсад хөрөнгө оруулалт хийхэд олгодог зөвшөөрөлтэй хамт хавсаргасан байдаг. Энэ нь аж ахуйн нэгжийг экспортлож чадах хэмжээнээс нь мөнгөн дүнгээрээ илүүгүй хэмжээгээр импортлохыг зөвшөөрдөг тул гадаад валютыг ашиглах боломжийг олгодог байна. Ингэж тавьдаг нөхцөл нь тухайн компанийн өсөлтөд үргэлж хязгаарлалт тавьдаг бөгөөд ингэснээр хүлээн авагч улс орны эдийн засгийн өсөлтөд мөн адил нөлөөлдөг байна.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Худалдааг тэнцвэржүүлэх шаардлага нь ДХБ-ын Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн (WTO Agreement on Trade-Related Investment Measures) заалттай зөрчилддөг байна. Худалдааг тэнцвэржүүлнэ гэдэг нь голдуу Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) туршлага дээр тулгуурласан байдаг.
1356	Trade-chill effect	Худалдааг-хөргөх үр нөлөө. Энэ нь худалдааг туйлдуулах (trade harassment) гэх мэт үйл ажиллагааны үр дүн бөгөөд тодорхой улс руу чиглэсэн тогтсон бараа бүтээгдэхүүний экспортыг гэнэт агшихад хүргэдэг байна.
1357	Trade coverage	Худалдааны хамрах хүрээ. Энэ нь хэлэлцэж буй тарифыг бууруулах замаар тухайн улс орны худалдааг хэр хэмжээнд либералчилж болохыг илэрхийлэх үүднээс, тарифын хэлэлцээнд ашигладаг нэр томьёо.
1358	Trade creation	Худалдааг бий болгох. Энэ нь чөлөөт худалдааны хэлэлцээр болон гаалийн холбооны үзүүлэх нөлөөг үнэлэхэд ашигладаг шалгуур. Хэрэв гадаадын саад тогтор нэгэн зэрэг нэмэгдээгүй тохиолдолд, худалдааны саад тогторыг бууруулах буюу арилгах нь гишүүд болон гишүүн бус улс орнуудын хоорондын худалдаа нэмэгдэхэд хүргэдэг гэсэн худалдааны онол байдаг байна. ТХЕХ-ийн тогтолцооны (GATT system) арга туршлага болон түүний дагуу худалдааг өргөжүүлсэн байдлыг харвал энэ онолыг эмпирик нотолгоогоор баталж байгааг харуулж байна. Бодит амьдрал дээр, уг тайлбарын үндэслэлийг бусад харилцан нөлөөлөх хүчин зүйлүүд, ялангуяа технологийн дэвшил, хөрөнгө оруулалтын бүтцийн өөрчлөлт гэх мэт дэлхийн өөрчлөлтүүдээс шалтгаалан, аль нэг талаас нь нотлон харуулахад нэлээд хэцүү байдаг. Мөн Худалдааны урсгалыг өөр чиглэл руу хазайлгахыг (trade diversion) үзнэ үү.
1359	Trade defence instruments	Худалдааг хамгаалах эрх зүйн акт. Мөн болзошгүй хамгаалалтыг (contingent protection) үзнэ үү.
1360	Trade deficit	Худалдааны алдагдал. Энэ нь өгөгдсөн цаг хугацаанд тухайн нэгний импортын үнийн дүн нь экспортын үнийн дүнгээс давж хэтэрсэн тохиолдолд үүсдэг зүйл байна. Ихэвчлэн, энэхүү тооцоололд зөвхөн бараа бүтээгдэхүүний худалдааг авч үздэг байна. Дангаар нь авч үзэхэд, худалдааны алдагдал гэдэг нь тухайн улсын эдийн засгийн эрүүл төлөв байдлын талаар ямар нэгэн ашигтай ойлголт өгөхгүй юм. Хэдий тийм боловч, худалдааны байнгын алдагдал нь залруулах шаардлагатай эдийн засагт давамгайлсан нөхцөл байдлын зарим дутагдлыг тусгасан байж болох юм. Зарим үед, худалдааны алдагдлаас үүдэлтэй бухимдал түгшүүр нь зүгээр л худалдаа арилжааны практик [меркантилизмын] шинж тэмдгийг тусгадаг байна. Мөн худалдааны тэнцэл (balance of trade) болон худалдааны илүүдлийг (trade surplus) үзнэ үү.
1361	Trade deflection	Худалдааны урсгалыг сарниулах. Мөн худалдааны урсгалыг өөр чиглэл руу хазайлгахыг (trade diversion) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1362	Trade deviation	Худалдааг гажуудуулах. Энэ нь тухайн улс орон чөлөөт худалдааны хоёр хэлэлцээрт гишүүнээр элссэнтэй холбоотойгоор үүссэн асуудлыг тодорхойлоход зарим үед ашигладаг нэр томьёо. Гарал үүслийн зохистой дүрэм байхгүй тохиолдолд, эдгээр чөлөөт худалдааны аль нэг хэлэлцээрийн гишүүн орноос гаралтай бараа бүтээгдэхүүн нь ийм арга замаар эхний улсын гаалийн нутаг дэвсгэрт орж ирсний дараа нөгөө чөлөөт худалдааны хэлэлцээрийн гишүүн оронд чөлөөтэй эргэлдэж болох юм. Энэхүү ойлголт нь бүс нутгийн худалдааны хэлэлцээр байгуулагдмагц тухайн улсын худалдааны бодлогын үндсэн зорилт болдог, ийм төрлийн асуудал үүсдэг болохыг харуулдаг байна. Мөн хаб энд спөүкс (hub and spokes) хаб энд спөүкс буюу зангилаа төв ба салбарууд, энэ нь бусад онгоцны буудлуудаас ирэх ба очих нислэгүүдийг зохицуулахад зориулсан төв цэг болж үйлчилж буй томоохон нисэх онгоцны буудалд, нислэгийн хөдөлгөөнүүдийг чиглүүлж байхад зориулсан системтэй зүйрлэсэн худалдааны дүн шинжилгээний ойлголтыг үзнэ үү.
1363	Trade diversion	Худалдааны хазайлт. Өөрөөр хэлбэл, худалдааны урсгалыг өөр чиглэл руу хазайлгах. Үүнийг мөн худалдааны гольдролыг сарниулах (trade deflection) гэж нэрлэдэг. Энэ нь чөлөөт худалдааны хэлэлцээр болон гаалийн холбооны үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд ашигладаг шалгууруудын нэг. Эдгээр хэлэлцээрийг байгуулах нь өөрсдийнх нь гишүүн улс орнуудын хоорондын худалдааг өргөжүүлэхэд хүргэдэг, гэвч эдийн засгийн онолын үүднээс бол үүнд оролцогчдын хүртэж буй өсөн нэмэгдсэн худалдааны хувь хэмжээ нь эрх зүйн зохицуулалтын улмаас худалдаа өсөн нэмэгдсэн явдал биш харин зөвхөн тэд худалдааны чиглэлээ өөрчилсөнтэй холбоотой болохыг баталдаг. Энэхүү нөлөөллийг туршилтын загвараар үнэмшилтэйгээр батлан харуулж болно. Бодит амьдрал дээр, бусад хүчин зүйлээс шалтгаалан худалдааны урсгалын чигийн өөрчлөлтийг бусдаас нь ялгаж авч үзэхэд үргэлж маш бэрхшээлтэй байсан. Үүнд, технологийн шинэчлэл, дэлхийн хэмжээнд тариф буурах, хөрөнгө оруулалтын бодлогод орсон өөрчлөлтүүд гэх мэт орно. Мөн худалдааг бүтээн бий болгохыг (trade creation) үзнэ үү.
1364	Trade Efficiency Programme	Худалдааны үр ашгийн тухай хөтөлбөр. Энэ нь олон улсын хэмжээнд мэдээллийн технологийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ба худалдаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах, мөн олон улсын худалдаанд процедурын зардлыг бууруулах чадвартай загварыг ашиглан дэмжих зорилготой НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) хөтөлбөр.
1365	Trade embargo	Худалдааны хориг. Энэ нь ихэвчлэн НҮБ-ын шийдвэрээр, заримдаа нэг талт, эсхүл бүс нутгийн арга хэмжээнд үндэслэн, тодорхой улс оронтой худалдаа хийхийг хориглох хориг. Худалдааны хориг тавих үндэслэл бүхий жишээ гэвэл, хэрэв үүнийг НҮБ-ын шийдвэртэй нийцүүлэх шаардлагатай бол уг хэлэлцээрүүдийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа түр зогсоохыг зөвшөөрсөн ҮХЕХ (GATS) болон ТХЕХ-д (GATT) бичигдсэн аюулгүй байдлын үүднээс эс хэрэглэх тохиолдлуудад (security exceptions) заасан байдгийг олж үзэж болно. Мөн НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээг (United Nations economic sanctions) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1366	Trade Expansion Act	Худалдааг өргөжүүлэх тухай хууль/акт. Кеннедигийн үе шатны хэлэлцээ (Kennedy Round) болон АНУ-ын худалдааны хэлэлцээрийн тухай хууль тогтоомжийг (United States trade agreements legislation) үзнэ үү.
1367	Trade facilitation	Худалдааг хөнгөвчлөх. Хилээр нэвтрүүлэх барааны хөдөлгөөнд учрах саад тотгорыг арилгах буюу багасгах. Жишээ нь, гаалийн горимыг хялбарчлах. Өргөн утгаар нь авч үзвэл, олон улсын худалдааны урсгалыг жигдрүүлэх замаар түүнийг өргөжүүлэхийг дэмжихэд чиглэсэн эдийн засгийн бус өргөн хүрээний арга хэмжээнүүд. Жишээ нь, худалдааны удирдамжуудыг хэвлэн нийтлэх, техникийн стандарт, гааль болон хорио цээрийн асуудлуудаар хамтран ажиллах, худалдааны асуудлуудыг үе үе хэлэлцэх, худалдааны яармаг үзэсгэлэн, худалдааны төлөөлөгчийн газар гэх мэт. Сингапурын Сайд нарын бага хурлаас (Singapore Ministerial Conference) худалдааг хөнгөвчлөх чиглэлээр ДХБ-ын ажлын хөтөлбөр боловсруулан гаргасан. Мөн, АПЕК буюу Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК Худалдааг хөнгөвчлөх болон худалдааг хөхиүлэн дэмжих зарчмуудыг (APEC Principles on Trade and Facilitation and trade promotion) үзнэ үү.
1368	Trade - finance - currency linkage	Худалдаа, санхүү, валют гурвын холбоо. Энэ нь Уругвайн үе шатны хэлэлцээг дуусгах үед, 1994 оны 4 дүгээр сард Марракеш хотноо хийсэн Сайд нарын тунхаглалын (Ministerial declaration) бүрэлдэхүүн хэсэг. Худалдаа, мөнгө, санхүүгийн салбар дах бодлогуудын дэлхийн илүү сайн уялдаа холбоог хангах үүднээс Дэлхийн Худалдааны байгууллага (WTO), Олон улсын валютын сан (IMF) болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (IBRD) нарын хоорондын хамтын ажиллагааг урьдчилан тооцоолсон юм. Мөн худалдаа ба гадаад валют (trade and foreign exchange), болон худалдаа ба татвар ногдуулалтыг (trade and taxation) үзнэ үү.
1369	Trade harassment	Худалдааны дарамт шахалт. Энэ нь бараа бүтээгдэхүүний импортыг санаатайгаар бэрхшээлтэй болгох арга хэрэгсэл болгон дотоодын илт болон далд арга хэмжээг ашиглах явдал. Илт арга хэмжээнд демпингийн эсрэг арга хэмжээ, хамгаалалтын арга хэмжээ, эсхүл Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах гэх зэрэг зүйлс багтана. Зарим үед, ийм арга хэмжээ авах зарим аюул заналхийлэл нь импортлогчдыг гаднын улс орнуудаас худалдан авалт хийхийг бууруулах буюу зогсооход хүргэхэд хангалттай байдаг. Бусад үед, үнийн үүрэг амлалтын (price undertakings) үзүүлэх үр нөлөө нь импортлох үйл ажиллагааг нэлээд үр ашиггүй [эдийн засгийн бус] болгох магадлалтай байдаг. Мөн, худалдааны дарамт шахалт нь хуурамч заргаар дамжуулан тохиолдож болох юм. Мөн, түрэмгий бус үнийг (non-price predation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1370	Trade in cultural property	Соёлын өмчийн худалдаа. Соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөлийг нь шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенцийг (Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property) үзнэ үү. ТХЕХ-ийн 10 дугаар зүйлийн (f) хэсэгт (Article XX(f) of the GATT) заасны дагуу, ДХБ-ын гишүүн орнууд урлагийн, түүхэн, археологийн чухал ач холбогдолтой үндэсний үнэт баялгийг хамгаалах үүднээс шаардлагатай худалдааны арга хэмжээг авч болно. Мөн худалдаа ба өв соёлыг (trade and culture) үзнэ үү.
1371	Trade-induced competition	Худалдаанаас үүдэлтэй өрсөлдөөн. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүнээс үүдэлтэй дотоодын зах зээл дэх өрсөлдөөнийг эрчимжүүлсэн нөхцөл байдал юм. Гадаадын компани аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн бараа бүтээгдэхүүн тухайн зах зээлд ямар түвшинд нэвтэрч байгаагаас хамааран, худалдаанаас үүсэлтэй өрсөлдөөн бий болох цар хүрээ хамаарч байдаг. Мөн импортын дэг журмын тухай таамаглал (import discipline hypothesis) болон зах зээлийн олон улсад өрсөлдөх чадварыг (international contestability of markets) үзнэ үү.
1372	Trade in services	<p>Үйлчилгээний худалдаа. Энэ нь хил дамнасан худалдаа (cross-border trade), эсхүл арилжааны төлөөллөөр (commercial presence) дамжуулан бусад улс орны оршин суугчдад арилжааны нөхцөлөөр үйлчилгээ нийлүүлэх.</p> <p>Үйлчилгээний худалдаан дах цахим өгөгдлийг хамгаалах (data protection in trade in services), үйлчилгээний нийлүүлэх хэлбэр (modes of services delivery), үйлчилгээ (services), арилжаалагдахуйц үйлчилгээ (tradeable services), болон үйлчилгээний хэлцэл (transactions in services) үзнэ үү.</p>
1373	Trade in services statistics	Үйлчилгээний худалдааны статистик. Олон улсын худалдааны шинжээчдийг нэн даруй гайхшруулдаг зүйл бол үйлчилгээний худалдааны статистик нь бараа бүтээгдэхүүний худалдааны статистикаас хамаагүй бага байдаг явдал. Үүний гол шалтгаан нь бараа бүтээгдэхүүний худалдаатай адилаар үйлчилгээг хил дээр тоолж, хянаж шалгаж чаддаггүй явдал юм. Түүхэндээ энэ төрлийн худалдааг тийм ч чухал ач холбогдолтой гэж үзээгүй тул цөөн хүн л үйлчилгээний худалдаанд нарийвчилсан ангилал боловсруулах шаардлагагүй гэж үзсэн байна. Үнэн хэрэгтээ, боловсруулах үйлдвэрлэгчдийн экспортыг өргөмжлөн магтаж байдаг худалдаа арилжааны практикийг [буюу меркантилизмыг] дагаж мөрдсөний нэг үр дүнг эндээс харж болох юм. Мөн түүнчлэн, олон үйлчилгээг зөвхөн харьцангуй богино хугацаанд худалдаалж байсан тул энэ нь худалдааны урсгалыг маш өндөр хуримтлагдсан дүнгээр тайлагнахад хангалттай урт хугацаа шаардагджээ. Өнөөдрийн байдлаар, гадаадын валютын гүйлгээ эсвэл компаниудын судалгаан дээр үндэслэн үйлчилгээний худалдааны статистикийг боловсруулж, илүү нарийвчлалтай зөв мэдээллийг авахын тулд ихэвчлэн хоёуланг нь хослуулан авч үздэг болсон. Өнөө цагт, олон улс орнууд Олон улсын валютын сангийн Төлбөрийн тэнцлийн гарын авлагын дөрөв дэх нийтлэлийн дагуу үйлчилгээний худалдааны тухай статистик мэдээгээ тайлагнадаг байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Энэ нь үйлчилгээний гүйлгээг дөрвөн төрөлд ангилдаг бөгөөд, үүнд: (a) тээвэрлэлт: бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нэг хэсэг болсон ачаа тээврийн болон даатгалын үйлчилгээ; (b) тээврийн бусад үйлчилгээнүүд: тээврийн операторын зорчигчдод үзүүлэх үйлчилгээ ба үүнийг олон улсын аялал жуулчлал, усан онгоцны зогсоол буюу боомтын үйлчилгээнд зорчих тасалбар борлуулах замаар хэмждэг; (c) аялал жуулчлал: гадаадын аялагчдын худалдан авсан бараа болон үйлчилгээ; (d) бусад үйлчилгээнүүд, үүнд: даатгал, мэргэжлийн, цахилгаан холбоо, барилга, уул уурхай, тооцоолол, зугаа цэнгээний болон бусад үйлчилгээнүүд орно. Сүүлийн ангилалд үнэн хэрэгтээ, худалдааны хамгийн хурдацтай өсөлтийг харуулдаг үйлчилгээнүүдийг хамруулсан байдаг. 1993 онд нийтлэгдсэн ОУВС-гийн Гарын авлагын тавдугаар хэвлэлд үүнийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүний ангилал нь хэдийгээр ихээхэн өргөн хэвээр байгаа ч, энэ нь үйлчилгээг илүү сайн бүрэлдэхүүн хэсгээр нь хувааж харуулахыг санал болгосон байна.</p> <p>Ихэнх үндэсний үйлчилгээний талаарх статистикийг одоогоор дээрх тав дугаар хэвлэлд заасан ангиллын дагуу эсвэл илүү нарийвчлалтай тоон мэдээлэлтэйгээр нийтэлдэг болсон боловч, бусад тохиолдолд зөвхөн өмнөх дөрвөн ангилалд үндэслэсэн тоо баримтуудыг үндэслэн тоон мэдээллийг л гаргах боломжтой байдаг байна. Үйлчилгээг худалдаалах тухай ОУВС-ын ангиллыг Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага (OECD) дах Европын хамтын нийгэмлэгийн статистикийн албаны ангилалд (EUROSTAT) нэмж боловсруулж байгаа. Олон улсын гол хүчин чармайлт бол Үйлчилгээний статистикийн агентлаг хоорондын Ажлын хэсэг (Inter-Agency Task Force on Services Statistics) юм. Уг Ажлын хэсэг нь НҮБ-ын ивээл дор хуралдаж, ЭЗХАХБ даргалдаг бөгөөд үүнд EUROSTAT, ОУВС, ЮНКТАД, ОУСБХБ (Дэлхийн Банк) болон ДХБ зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрддэг. Энэхүү ажлын хэсэг нь үйлчилгээний статистикийг сайжруулах өргөн хүрээний эрх үүрэгтэй бөгөөд ҮХЕХ-ийн статистикийн хэрэгцээ шаардлагад эн тэргүүний ач холбогдол өгөөд байна. Мөн, албан бус Вурбургийн бүлэг (Voorburg Group) нь үйлчилгээний статистикийг сайжруулахад хувь нэмэр оруулж байна. Мөн, үйлчилгээний худалдааны талаар статистикийн хамрах хүрээг сайжруулах чиглэлээр олон улс оронд ажлууд хийгдэж байгаа. Тэгэхдээ, үйлчилгээний бүх чухал худалдаалагчдад зориулж нарийвчилсан статистик бэлэн болоход хэсэг хугацаа шаардагдах болно. Тэр хооронд, арилжаалагдаж буй бүтээгдэхүүнүүдийг бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ гэж хуваах нь үнэн хэрэгтээ, эдийн засагт бодитоор юу болоод байгаа талаас нь авч үзвэл улам бүр утгагүй болж байна гэсэн үзэл бас байдгийг дурдах нь зүйтэй болов уу. Мөн төлбөрийн тэнцлийг (balance-of-payments) үзнэ үү.</p>
1374	Trade intensity	<p>Худалдааны эрчимжилт. Тухайн эдийн засагт худалдаа хир чухал ач холбогдолтой болохыг илэрхийлсэн хэмжүүр. Өөрөөр хэлбэл, нийт эдийн засагт бараа болон үйлчилгээний импорт, экспортын эзлэх хувь хэмжээ.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1375	Trade liberalisation	Худалдааны либералчлал/Худалдааг чөлөөлөх – Уругвай). Энэ нь бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний худалдаанд тулгарч буй саад тотгорыг аажмаар, эсхүл бүр мөсөн арилгах тухай ерөнхий нэр томьёо. Үүний эцсийн зорилго нь чөлөөт худалдаа байж болох боловч энэ нь түүнээс ч илүү чөлөөтэй худалдаа руу чиглэх хандлагатай. Хэрвээ зах зээлд үр ашигтайгаар нэвтрэхийн тулд зорилтот зах зээлд хөрөнгө оруулах шаардлагатай бол, хөрөнгө оруулалтын хязгаарлалтын асуудлыг энэхүү нэр томьёонд хамруулж болох юм.
1376	Trademark Law Treaty	Барааны тэмдгийн (худалдааны тэмдэг, үйлдвэрийн тэмдэг) тухай хуулийн олон улсын гэрээ. Энэ нь үндэсний болон бүс нутгийн барааны тэмдгийн тогтолцоог ашиглахад илүү хялбар болгох зорилгоор Дэлхийн оюуны өмчийн байгууллагын (WIPO) ивээл дор, 1994 онд байгуулсан гэрээ юм. Процедурыг хялбарчилж, уялдуулах замаар үүнийг хийхийг зорьдог. Уг олон улсын гэрээ нь хараахан хүчин төгөлдөр болоогүй байна. Мөн Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх худал ба хуурамч үзүүлэлтүүдийг таслан зогсоох Мадридын хэлэлцээр (Madrid Agreement for the Repression of False or Deceptive Indications of Source on Goods) болон Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай [Франц улсын] Ниццийн хэлэлцээрийг (Nice Agreement Concerning the International Classification of Goods and Services for the Purpose of Registration of Marks) үзнэ үү.
1377	Trademarks	Барааны тэмдэг. Боловсруулах үйлдвэрлэгчид болон худалдаачдын хувьд өөрсдийн бараа, үйлчилгээг өрсөлдөгчдийнхөө бүтээгдэхүүнээс ялгах үүднээс үг, оноосон нэр, билэг тэмдэг, арга хэрэгсэл, эсхүл тэдгээрийг хослуулсан хэлбэрээр ашигладаг байна. Мөн оюуны өмч (intellectual property), Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), болон үйлчилгээний тэмдгийг (service marks) үзнэ үү.
1378	Trade negotiations between developing countries	Хөгжиж буй улс орнуудын хоорондын худалдааны хэлэлцээ. 1971 оны 11 дүгээр сард ТХЕХ-ийн гишүүд нь хөгжиж буй орнууд бие биендээ хөнгөлөлттэй нөхцөл олгохын тулд үндэсний нэн тааламжтай нөхцөлийн (MFN) дүрмээс татгалзах/чөлөөлөгдөх хүсэлтийг нь хүлээн зөвшөөрсөн байна. Хөгжиж буй арван тав орчим улс орнууд энэхүү боломжийг ашиглах болсон. ТХЕХ-ийн ивээл дор удирдан явуулсан эдгээр худалдааны хэлэлцээнүүд нь бага зэрэг үр дүнд хүргэсэн. Мөн Бангкокийн хэлэлцээр (Bangkok agreement), хөгжиж буй орнууд ба ТХЕХ (developing countries and the GATT), Хөгжиж буй орнууд хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа (ECDC) болон Худалдааны хөнгөлөлтийн дэлхий нийтийн системийг (GSTP) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1379	Trade Negotiations Committee	Худалдааны хэлэлцээний хороо. Энэ нь ихэвчлэн худалдааны олон талт яриа хэлэлцээний эхэнд байгуулсан хороо юм. Уг хороо нь бүх оролцогчдоос бүрддэг бөгөөд голдуу ил тод байдал болон дахин хянаж үзэх механизмын зорилгоор ажилладаг. Үүний хэмжээ нь бодит хэлэлцээ хийхэд хэтэрхий нүсэр тул тохиромжгүй болгодог. Мөн олон талт худалдааны хэлэлцээг (multilateral trade negotiations) үзнэ үү.
1380	Trade-neutral measures	Худалдааны саармаг арга хэмжээнүүд. Энэ нь худалдааны урсгалд ямар нэгэн нөлөө үзүүлдэггүй, олон улсын худалдааны эрх зүйн зохицуулахтай холбогдолгүй шалтгаанаар, засгийн газраас авч буй арга хэмжээнүүд.
1381	Trade pledge	Худалдааны барьцаа. Энэ нь зогсонги байдлын (standstill) санааг илэрхийлэхэд зарим үед хэрэглэдэг нэр юм. Уг нэр томьёо анх 1974 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагаас (OECD) ашигласан.
1382	Trade Policies for a Better Future	Илүү сайхан ирээдүйд чиглэсэн худалдааны бодлогууд. Лютвэйлерийн тайланг (Leutwiler Report) үзнэ үү.
1383	Trade policy	Худалдааны бодлого. Энэ нь дотоодын аж ахуйн нэгжүүдэд зориулан хуулиар үүрэг хүлээж, заавал биелүүлэх нөхцөлийн дагуу зах зээлд нэвтрэх боломжийг нь хангаж өгөх зорилгоор, засгийн газраас баталсан хууль тогтоомжууд, дүрэм журам, олон улсын хэлэлцээрүүд болон хэлэлцээний байр суурийн иж бүрэн бүтэц хамрах хүрээ юм. Мөн, худалдааны бодлого нь аж ахуйн нэгжүүдэд зориулан урьдчилан таамаглахуйц боломж болон аюулгүйн байдлыг хангах дүрэм журмыг боловсруулахыг эрэлхийлдэг. Худалдааны бодлогын үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь үндэсний нэн-тааламжтай нөхцөл, үндэсний нөхцөл, ил тод байдал болон харилцан хөнгөлөлт буултыг харилцан солилцох (exchange of concessions) зэрэг юм. Үр дүнтэй байхын тулд, худалдааны бодлого нь инноваци болон олон улсад өрсөлдөх чадварыг дэмжихийн тулд дотоодын бодлогуудаар дэмжиж өгөх шаардлагатай бөгөөд үүнийг уян хатан ба прагматизмтай [практик хэрэглээ] хэрэгжүүлэх хэрэгтэй. Дэлхийн худалдааны тогтолцооны улс төрийн эдийн засаг (The Political Economy of the World Trading System) гэсэн бүтээлд Бернард Хоекман ба Майкл Костеки нарын ажигласнаар бол, худалдааны бодлого гэдэг бол гадаадын үйлдвэрлэгчдийн эсрэг ялгаварлан гадуурхдаг үндсэрхэг бодлого юм гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, энэ нь дотоодын учир шалтгаанд нийцүүлсэн үндэсний бодлогуудын олон улсын хэмжигдэхүүнийг илэрхийлдэг. Үүний нэг үр дүн бол худалдаа нь заримдаа улс төрийн дараа хоёрдугаарт ордог байж болно. Мөн, арилжаа, худалдааны бодлого (commercial policy), арилжаа худалдааны нийтлэг бодлого (common commercial policy) болон худалдааны либералчлалын дөрвөн тулгуур баганыг (four pillars of trade liberalization) үзнэ үү.
1384	Trade Policy Review Body	Худалдааны бодлогыг хянан үзэх байгууллага (TPRB). Энэ нь Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцооны (Trade Policy Review Mechanism) дагуу үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж буй ДХБ-ын Ерөнхий зөвлөл (WTO General Council) юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1385	Trade Policy Review Mechanism	Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоо. (TPRM). Энэ нь Уругвайн үе шатны яриа хэлэлцээний дунд хугацааны тайланг удирдан зохион байгуулж Монреал хотод болсон Сайд нарын бага хурлын үеэр (Montreal Ministerial Meeting), 1988 оны 12 дугаар сард байгуулагдсан ДХБ-ын хяналтын механизм. Үүнийг Худалдааны бодлогыг хянан үзэх алба зохион байгуулж байдаг. TPRM нь ДХБ-ын гишүүн орнуудын худалдааны дэглэмд дотоодын болон олон улсын илүү ил тод байдлыг хангах замаар олон талт худалдааны тогтолцоог илүү жигд ажиллуулахад чиглэгддэг. ДХБ-ын дүрэмд хамрагдсан эсэхээс үл хамааран асуудлыг авч үзэж болох боловч эдгээр нь шалгагдаж буй улсын худалдааны бодлоготой холбоотой байх ёстой гэсэн ойлголт байдаг. Хянан үзэх ажлыг огтоосон цагийн дагуу явуулдаг. Хянан үзэх давтамж нь дэлхийн худалдаанд эзлэх хувь хэмжээтэй холбоотой бөгөөд томоохон худалдаачдыг илүү олон удаа нягталж үздэг. TPRM нь ДХБ-ын тодорхой үүрэг амлалтуудыг биелүүлэх эсвэл маргаан шийдвэрлэх процедурын үндэс суурь болдоггүй юм. Мөн хяналт тандалтыг (surveillance) үзнэ үү.
1386	Trade promotion	Худалдаанд дэмжлэг үзүүлэх. Энэ нь компаниуд болон улс орны экспортын худалдааг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд юм. Үүнд худалдааны үзэсгэлэн, худалдааны төлөөлөгчийн газар, сурталчилгааны кампанит ажилд (аян) оролцох зэрэг орно. Мөн худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг (trade facilitation) үзнэ үү.
1387	Trade Promotion Authority	Худалдаанд дэмжлэг үзүүлэх эрх бүхий байгуулага. Энэ нь АНУ-ын Конгрессоос Ерөнхийлөгчид өгсөн, түргэвчилсэн шийдвэрийн эрх (fast-track) гэж нэрлэдэг байсан бөгөөд хэлэлцээ хийх эрх бүхий байгууллагад 2001 өгсөн нэр юм.
1388	Trade protection	Худалдааны хамгаалалт. Энэ нь худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ (trade remedies) гэх нэр томьёоны оронд Европын хамтын нийгэмлэгээс заримдаа ашигладаг нэр томьёо юм.
1389	Trade-related antitrust principles	Худалдаатай холбогдсон монополийн эсрэг зарчмууд. Энэ нь худалдаа ба өрсөлдөөний тухай ирээдүйн олон талт хэлэлцээрт тусгагдах магадлалтай өрсөлдөөний бодлогын асуудлуудад зориулж Бернад Хоекманы ашигласан нэр томьёо юм.
1390	Trade-related aspects of competition law and policy	Худалдаатай холбогдсон өрсөлдөөний хууль ба бодлогын асуудлууд (TRACLAP). Энэ нь худалдаа болон өрсөлдөөнийг илэрхийлэхэд зарим эрдэмтдийн ашигладаг нэр томьёо юм. Мөн Худалдаа ба өрсөлдөөний бодлого хоорондын харилцан үйлчлэлийн талаарх Ажлын хэсгийг (Working Group on the Interaction between Trade and Competition Policy) үзнэ үү.
1391	Trade-related aspects of economic development	Худалдаатай холбогдсон эдийн засгийн хөгжлийн асуудлууд. Энэ нь дэлхийн худалдааны тогтолцоонд, ялангуяа ТХЕХ-ийн Зөвшөөрөгдөх заалт (Enabling Clause) болон 4 дүгээр хэсэг (Part IV of the GATT) зэрэгт хөгжиж буй орнуудын оролцооны талаарх ДХБ-ын заалтуудыг тайлбарлахад Курешигийн (1996 он) ашигласан томьёо юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1392	Trade-related aspects of intellectual property rights	Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудал (TRIPS). Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) үзнэ үү.
1393	Trade-related aspects of monetary measures	Худалдаатай холбогдсон валютын арга хэмжээний асуудлууд. Энэ нь валютын зохицуулалтын талаар ТХЕХ-ийн 15 дугаар зүйлд (GATT Article XV) агуулагдсан заалтуудад хамаарах, зарим хүмүүсийн ашигладаг томьёо юм.
1394	Trade-related aspects of sustainable development	Худалдаатай холбогдсон тогтвортой хөгжлийн асуудлууд. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын (Food and Agricultural Organisation) хүрээнд хэлэлцэж буй сэдэв юм. Энэ нь худалдааны бодлогод хүрээлэн буй орчны асуудлуудыг бүрэн тусгах хүсэл эрмэлзэлээс үүдэлтэй асуудлуудаас гадна, хүрээлэн буй орчны арга хэмжээг худалдааны хязгаарлалт болгон ашиглаж болохгүй гэж үздэг бусдын санаа зовнилыг мөн авч үздэг байна. Мөн тогтвортой хөгжил (sustainable development) болон худалдаа ба хүрээлэн буй орчинг (trade and environment) үзнэ үү.
1395	Trade-related investment measures	Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээ (TRIMS). Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Investment Measures) үзнэ үү.
1396	Trade relief	Худалдааны тусламж. Энэ нь худалдааны хохирлыг арилгах арга хэмжээг (trade remedies) ашиглан дотоодын компаниудад учирч буй өрсөлдөөний дарамтыг хөнгөвчлөх юм.
1397	Trade remedies	Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ. Энэ нь голдуу бусдын худалдааны үйл ажиллагааны үр нөлөөтэй харьцаж ажиллахын тулд демпингийн эсрэг арга хэмжээ, Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах, болон хамгаалалтын арга хэмжээнүүдийг ашиглах асуудлыг хамаардаг. АНУ-д, энэ нь бусад улс орнуудын шударга бус гэж үзсэн худалдааны үйл ажиллагааны үр нөлөө, эсхүл импортын огцом өсөлтийн улмаас үүдсэн хохирлын нөлөөтэй тулж харьцаж ажиллахын тулд худалдааны тухай хуульд заасны дагуу авсан арга хэмжээг тайлбарлах нэр томьёо юм. Худалдааны хохирлыг арилгах арга боломжит арга хэмжээг сонгох нь тухайн нөхцөл бүрт хамаарах худалдааны тухай хуулийн хэсгээс хамаарна. Үүнд, тарифын өсөлт, импортын квот, Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах, хариу арга хэмжээ авах гэх мэт зүйлс орно. Мөн 201-р хэсэг (Section 201), 301-р хэсэг (Section 301), 301-р тусгай хэсэг (Special 301) болон Супер 301-ийг (Super 301) үзнэ үү.
1398	Trade-restrictive environmental measures	Худалдааг хязгаарласан хүрээлэн буй орчны арга хэмжээ. Энэ нь худалдааг хязгаарласан үр нөлөө бүхий хүрээлэн буй орчныг хамгаалах арга хэмжээ юм. Нөлөө нь шууд санаатай бөгөөд санаатай бус байж болно, жишээ нь дельфин буюу далайн гахайг хамгаалах АНУ-ын арга хэмжээний хувьд, эсхүл нөлөө нь санамсаргүй байж болно.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Мөн худалдаа ба хүрээлэн буй орчин (trade and environment), 1982 оны Канад ба АНУ хоёр улсын хоорондын туна загасны талаарх маргаан (tuna, Canada-United States, 1982), 1994 оны Европын эдийн засгийн нийгэмлэг ба АНУ хоёрын хоорондын туна загасны талаарх маргаан (tuna, European Economic Community-United States, 1994), болон 1991 оны Мексик ба АНУ хоёр улсын хоорондын туна загасны талаарх маргааныг (tuna, Mexico-United States, 1991) үзнэ үү.</p>
1399	Trade secrets	<p>Худалдааны нууц. Энэ нь үндсэндээ тухайн бизнесийн хувьд онцгой, үнэтэй аливаа мэдээллүүд. Тухайн мэдээллийг задруулж, эсхүл ашигласнаар ашиг тус хүртэж болох олон нийт, өрсөлдөгчид болон бусад этгээдүүдэд мэдэгдүүлэхгүй байснаараа тухайн мэдээллийн үнэ цэнэ бий болж байдаг байна. Австрали улсад, худалдааны нууц нь арилжааны шинж чанартай нууц мэдээллийг хамардаг байна.</p> <p>Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights), Үйлчилгээний худалдаан дах цахим өгөгдлийг хамгаалах (data protection in trade in services) болон материал шилжүүлэх тухай хэлэлцээрийг (material transfer agreement) үзнэ үү.</p>
1400	Trade suppression	<p>Худалдааг дарах, хорих. Уг нэр томьёог Жакоб Вэйнер танилцуулсан бөгөөд Макс Корден олон нийтэд түгээж дэлгэрүүлсэн байна. Энэ нь гаалийн холбоо эсвэл чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулагдсаны дараа, эдгээр хэлэлцээрээс гадуурх илүү хямд үйлдвэрлэлийн эх үүсвэрийг, шинээр байгуулсан хөнгөлөлттэй бүс доторх илүү үнэтэй эх үүсвэрээр орлуулан солих байдлыг тайлбарласан болно. Мөн худалдааг бүтээн бий болгох (trade creation), худалдааны урсгалыг өөр чиглэл руу хазайлгахыг (trade diversion) үзнэ үү.</p>
1401	Trade surplus	<p>Худалдааны илүүдэл. Энэ нь өгөгдсөн цаг хугацаанд тухайн нэгний экспортын үнийн дүн нь импортынх нь үнээс давж хэтэрсэн үед үүсдэг зүйл юм. Үүнийг ихэнх засгийн газрууд баримтлахыг хүсдэг зорилт боловч ямар ч тохиолдолд зөвхөн бараа бүтээгдэхүүний арилжаа хийхэд л анхаардаг, ялангуяа зөрүүдлэн байж, заримдаа утга учиргүй байдлаар Экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулан, худалдааны ашигтай тэнцвэрийг хангаж баялаг бүрдүүлэх эдийн засгийн онол буюу Меркантилизмын онол (mercantilism) л баримталдаг хүмүүс ч мөн үүнийг зорьдог байна. Худалдааны илүүдэл нь мөн чанартаа сайн зүйл, харин худалдааны алдагдал (trade deficit) нь автоматаар муу зүйл гэдэг бол ташаа ойлголт юм. Худалдааны ихээхэн хэмжээний илүүдлийн ач холбогдлыг бодитой үнэлэх нь зөвхөн эдийн засгийн нийт төлөв байдлыг харгалзан үзэж байж хийх боломжтой юм. Мөн худалдааны тэнцлийг (balance of trade) үзнэ үү.</p>
1402	Trade war	<p>Худалдааны дайн. Энэ нь худалдааны чухал түншүүдийн хоорондох томоохон худалдааны маргаантай үеийг тайлбарласан сэтгэл зүйн хэтрүүлэг. Эдгээр маргааныг шийдвэрлэхийг оролдсон оролцогчид ихэвчлэн хоёр тал хоёулаа хүлээн зөвшөөрөх хэлэлцээтэй үр дүнг эрэлхийлдэг</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>бөгөөд энэ нь холбогдох олон талт худалдааны дүрэмд нийцсэн байх шаардлагатай. Тэд хааяа өөрсдийгөө дайн байлдаанд оролцож байгаа гэж үздэг байна. Үнэн хэрэгтээ, "Уругвайн үе шатны хэлэлцээний дараа Америкийн худалдааны тухай хуулиуд (American Trade Laws)" бүтээлд Грег Мастел ийнхүү өгүүлжээ: "худалдааны дайн бол цөмийн дайнаас илүү оновчтой сүүдэр, эхлүүлэхэд хэцүү, эхлүүлэхэд илүү хэцүү, олиггүй гэж болох зүйл юм."</p>
1403	Trade-weighted average tariffs	<p>Худалдааны жигнэсэн дундаж тариф. Энэ нь тухайн тарифын ангилалын хүрээнд хийгдсэн худалдааны хэмжээтэй уялдуулан тарифыг жигнэж үзэх замаар, тарифын дундаж нөлөөллийг тооцоолох арга барил. Тийм учраас их хэмжээгээр арилжаалагдаж буй бараа нь бага хэмжээгээр, эсхүл ховорхон арилжаалагддаг бараанаас илүү их нөлөөллийг дундаж тарифыг тооцоолоход үзүүлдэг байна. Дүн шинжилгээний энэхүү арга барилын (analytical approach) гол бэрхшээл бол өндөр тарифууд эхний ээлжинд худалдааг мохоодог бөгөөд энэ аргаар тооцоолсон дундаж тариф нь тарифын хамгаалалтын бодит түвшинг үргэлж дутуу илэрхийлэх магадлалтай байдаг. Гэсэн хэдий ч, тарифын түвшингийн нийт тохиолдлын үзүүлэлт гэдэг утгаараа үүний нийтлэг ашиг тусын хувьд эргэлзэх зүйлгүй юм.</p>
1404	Trading rights	<p>Худалдааны эрх. Энэ нь ялангуяа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай (centrally-planned economies) эсхүл зах зээлийн эдийн засаг руу шилжиж буй (transition to market economy) улс орнуудын сонгогдсон компаниудад, импортлох ба экспортлох зөвшөөрөл олгосон эрх юм. Худалдааны эрх нь бараа бүтээгдэхүүн экспортлох эсвэл бүтээгдэхүүний тодорхой ангиллын хүрээнд худалдаа хийх хүрээнд хязгаарлагдаж болно. Уг эрхийг эдлэхийн тулд компаниуд төрийн өмчийн компани байх шаардлагагүй. Мөн улсын худалдааг (state trading) үзнэ үү.</p>
1405	Traditional expressions	<p>Уламжлалт илэрхийлэл. Энэ нь ялангуяа дарс, спирт, хоол хүнстэй холбоотой байж болох оюуны өмчийн эрхийн удирдлагад хэрэглэгддэг нэр томьёо юм. Дарсны хувьд хэрэглэдэг уламжлалт илэрхийллүүдийн жишээ гэвэл, Спийтлэза (Spiitlese), Куалитацвайн (Qualitatswein), Гронг Кхгү (Grand Cru), вон примойр (vin primeur), вино генеросо де ликор (vino generoso de licor), диноминационе де орижене контролатто (denominazione di origine controllata), etc. Иймэрхүү илэрхийллүүд нь хоёр талт хэлэлцээрийн дагуу оюуны өмчийг хамгаалах болзлыг хангаж байж болно. Мөн Гарал үүслийн нэршил (appellations of origin), газар зүйн заалтыг (geographical indications) үзнэ үү.</p>
1406	Traditional knowledge	<p>Уламжлалт мэдлэг. Энэ нь оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудалтай холбоотой хэлэлцүүлэгт гарч ирсэн шинэ сэдэв юм. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын мэдэгдсэнээр үүнд ямар нэгэн хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байхгүй боловч үүнийг эм, эмчилгээний, хөдөө аж ахуйн, экологийн мэдлэг, хөгжим, бүжиг, үлгэр, яруу найраг (ардын аман зохиол), эд өлгийн зүйлс, сүнслэг байдлын илэрхийлэл гэж үздэг.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Уламжлалт мэдлэгийг үеэс үед дамжуулж аман хэлбэрээр болон үлгэр дуурайллаар дамжуулж ирсэн байдаг. Энэ нь хамтын хариуцлага, хамтын өмчлөлд хамаарах бөгөөд хувьсан өөрчлөгдсөөр байдаг. Оюуны өмчийн эрхийг кодчилсон болон баримтжуулсан материалд тулгуурлан ашиглахад илүү тохиромжтой байдаг тул дээрх бүх шинж чанарууд нь хамгаалалтын эрх зүйн бүтэц, хамрах хүрээний суурь баримт бичгийг боловсруулах ажлыг хүндрэлтэй болгож байдаг. Мөн ижил төстэй асуудлуудыг хөндөж байдаг фермерүүдийн эрх (farmers' rights) болон ардын аман зохиолыг (folklore) үзнэ үү.</p>
1407	Traffic light approach	<p>Замын дохионы гэрлийн арга зам. Энэ нь Уругвайн үе шатны яриа хэлэлцээний үеэр татаасыг бууруулах, эсхүл арилгах тухай аливаа хэрэг, асуудлыг хянан шийдвэрлэх талаар тогтоосон журамлалын бүтэц, хамрах хүрээ юм. Эцсийн дүндээ хэлэлцээрт оролцогчид хориглосон татаасыг улаан өнгөөр, хариу арга хэмжээ авах үндэслэл болох татаасуудыг (зарим татаас бусад улсад байгаа үйлдвэрлэгч нарт хохирол учруулахад хүргэсэн учраас түүний эсрэг саармагжуулах арга хэмжээ буюу Татаасны эсрэг нөхөн тэгшитгэх татвар авахад хүргэж болох) шар өнгөөр, хариу арга хэмжээ авах үндэслэл болохгүй татаасуудыг (саармагжуулах арга хэмжээг авч болохгүй) ногоон өнгөөр ангилсан тогтолцоог харилцан хүлээн зөвшөөрөхөд хүрсэн байдаг. Хөдөө аж ахуйн татаас энэхүү эрх зүйн бүтэц, хамрах хүрээнд ороогүй бөгөөд Хөдөө аж ахуй тухай хэлэлцээрийн нэг хэсэг болгож энэ талаар тусдаа журмыг хэлэлцэн тохиролцсон байна. Үүнтэй ижил төстэй арга барилыг Токиогийн үе шатны яриа хэлэлцээний үеэр амжилттайгаар туршиж чадаагүй бөгөөд үнэндээ энэ нь АНУ ба Канад улсын Чөлөөт худалдааны хэлэлцээрт чиглүүлсэн яриа хэлэлцээний эхний үе шатанд нь яригдаж байсан байна.</p>
1408	Transactions in services	<p>Үйлчилгээний хэлцэл. Энэ нь зарим шинжээчдийн үзэж буйгаар үйлчилгээний худалдааны (trade in services) өөр хувилбар юм. Учир нь тэд үүнийг, үйлчилгээний хүрээнд явагдаж байгаа ихэнх олон улсын үйл ажиллагаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хамаардаг бөгөөд энэ нь зүгээр нэг хил дамнанас худалдаа (cross-border trade) биш гэдгийг онцолж байгаа юм. Уг нэр томьёог Австралийн статистикийн товчоо (Australian Bureau of Statistics), өөрсдийн хэвлэл нийтлэлдээ ашигласан байна. Худалдааны бодлогыг боловсруулахад үйлчилгээний худалдаа, түүний өрсөлдөгч ялалт байгуулсан бололтой юм.</p>
1409	Transaction value	<p>Хэлцлийн үнэ - Уругвай. Энэ нь гаальд төлбөл зохих татварыг тооцоолох зорилгоор импортлох барааг үнэлэх үндсэн аргачлал юм. Хэлцлийн үнэ нь, 1994 оны Тариф, худалдааний тухай ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар зүйлийг [гаалийн үнэлгээ – customs valuation] хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн дагуу, импортолж байгаа орон руу экспорт хийхэд, өрсөлдөөнт нөхцөлд зарагдсан тохиолдолд, тухайн бараа бүтээгдэхүүнд бодитоор төлсөн, эсхүл төлбөл зохих үнэд үндэслэх ёстой. Энэ арга барил нь одоо Дэлхийн гаалийн байгууллага</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		(World Customs Organisation) гэж нэрлэгддэг болсон, өмнө нь Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн (Customs Cooperation Council) ивээл дор боловсруулсан Үнэ цэнийн тухай Брюсселийн тодорхойлолтод (Brussels Definition of Value) суурилсан болно. Мөн гаалийн үнэлгээг (customs valuation) үзнэ үү.
1410	Transatlantic Business Dialogue	Атлантын Далай дамнасан бизнесийн яриа хэлэлцээ. Энэ нь Европ болон АНУ-ын бизнесийн удирдагчдыг оролцуулж, нийтлэг ашиг сонирхлын худалдаа болон арилжааны асуудлуудыг хэлэлцэх мөн Атлантын далайг дамнасан худалдаа ба хөрөнгө оруулалтад учирч буй саад бэрхшээлийг арилгах шийдвэрүүдийг санал болгох энэхүү механизмыг 1995 онд байгуулсан. Мөн Атлантын Далайг дамнасан шинэ хөтөлбөр (New Transatlantic Agenda) болон Атлантын Далайг дамнасан шинэ зах зээлийг (New Transatlantic marketplace) үзнэ үү.
1411	Transatlantic Free Trade Agreement	Атлантын Далайг дамнасан Чөлөөт Худалдааны хэлэлцээр. TAFTA-г үзнэ үү.
1412	Transfer of technology	Технологийг дамжуулах. Бүтээгдэхүүнийг аж үйлдвэрлэлийн аргаар боловсруулж үйлдвэрлэх, тухайн үйл явцын хэрэглэх боломж, үйлчилгээ үзүүлэх зэрэгт зориулсан системчилсэн мэдлэгийг дамжуулахад зориулан, Технологи дамжуулах тухай олон улсын төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн төсөлд үүнийг тодорхойлсон байдаг. Энэ нь бараа бүтээгдэхүүнийг зөвхөн худалдах эсвэл түрээслэх асуудлыг хамарсан хэлцлүүдээр хязгаарлагдахгүй.
1413	Transfer pricing	Үнэ шилжилт. Энэ нь зах зээлийн үнэд суурилахгүй ба татварт төлөх төлбөрөөс хэмнэлт үүсгэх, гадаад валютын нөөцийг оновчтой байдлаар ашиглах, эсхүл бусад шалтгаанаар харилцан хамаарал бүхий талууд үнэ тогтоох бодлогыг ашиглах арга туршлага. Үнэ шилжилт явагдсан эсэхийг тогтоохын тулд эшлэл болгон ашигласан үнэ гэдэг бол сунгасан гарын (arm's length) зарчмаар тогтоосон үнэ байдаг. Энэ нь огт хоорондоо харилцан хамааралгүй этгээдүүдийн дундаас гаргаж авсан үнэ юм. Корпораци хоорондын хэлцэл болон харилцан хамаарал бүхий талуудын хооронд хийгдсэн хэлцэл нь ихэвчлэн үнэ шилжилтэнд өртөх илүү их эрсдэлтэй гэж үздэг. НҮБ-ын Үндэстэн дамнасан корпорациудын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн төслийн 33 ба 34-р Зүйлс нь ийм зүйл гарах явдлыг багасгахыг хичээдэг. Мөн сунгасан гарын зарчмаар үнэ тогтоохыг (arm's-length pricing) үзнэ үү.
1414	Transitional dumping	Шилжилтийн үеийн демпинг. Үүнийг зарим нь борлуулалтыг нэмэгдүүлж мөн зах зээлийн хувь хэмжээг өргөжүүлэхийн тулд ахиу зардлаас (marginal cost) доогуур үнээр бараа бүтээгдэхүүний үнийг тогтоох явдал гэж нэрлэсэн байдаг. Энэ нь ялангуяа удаан хугацаанд үргэлжилэхээр байгаа бол ийм практик туршлага нь түрэмгийгээр үнэ тогтоож (predatory pricing) болох эсэх талаар маргаан гарах боломж бий. Мөн демпинг (damping), демпингийн эсрэг арга хэмжээг (anti-damping) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1415	Transitional measures	Шилжилтийн үеийн арга хэмжээ. Энэ нь ихэвчлэн хуучин болон шинэ системүүд нэгэн дор хамт байж байгаа үед худалдааны шинэ хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ юм. Ийм арга хэмжээ нь цаг хугацаатай байдаг. Заримдаа шилжилтийн үеийн арга хэмжээ нь хөгжиж буй орнуудад шинэ дэглэмд дасан зохицоход нь илүү цаг хугацаа олгох зорилготой байдаг.
1416	Transitional safeguards	Шилжилтийн үеийн хамгаалалтын арга хэмжээ. Сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүн болон бэлэн хувцасны тухай хэлэлцээрийн дагуу (Agreement on Textiles and Clothing) уг хэлэлцээрт хамруулсан текстилийн импорт нь дотоодын аж үйлдвэрт аюул учруулсан, эсхүл ноцтой аюул учруулах нь тодорхой болбол уг импортыг түр хугацаагаар хязгаарлах механизмийг хэрэгжүүлэх боломжтой байдаг. Эдгээр хамгаалалтын арга хэмжээг ногдуулж байгаа улс орнууд нь, тухайн барааны нэмэгдсэн импорт болон аж үйлдвэрт учирсан хохирол хоёрын хооронд шалтгаант холбоос байсан гэдгийг нотлон харуулах ёстой. Тэд үүнийг хэрэгжүүлэхдээ технологийн өөрчлөлт, хэрэглэгчийн давуу байдал бүхий сонголтод гарсан өөрчлөлт эсвэл импортыг нэмэгдүүлэхтэй холбоогүй бусад хүчин зүйлүүд дээр үндэслэн хийх ёсгүй. Шилжилтийн үеийн хамгаалалтын арга хэмжээг хатуу чанд нөхцөлд удирдаж, хяналт шинжилгээ хийх ёстой бөгөөд үүнийг гурван жилээс илүү хугацаагаар хэтрүүлэхгүй байх ёстой. Мөн хамгаалалтын арга хэмжээ (safeguards), хамгаалалтын тусгай арга хэмжээг (special safeguards) үзнэ үү.
1417	Transition economies	Шилжилтийн үеийн эдийн засагтай орнууд. Өмнө нь ЗСБНХУ-ын (USSR) бүрэлдэхүүнд байсан, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай (centrally-planned economies) улс орнууд буюу Төв ба Зүүн Европын орнуудыг нэрлэж буй нэр юм. Одоо тэд бүгд зах зээлийн эдийн засаг руу шилжиж байгаа. Мөн шинээр либералчилагдаж буй эдийн засагтай улс орнуудыг (newly liberalizing economies) үзнэ үү.
1418	Transit zone	Дамжин өнгөрөх бүс. Энэ нь барааг эцсийн хүрэх газар руугаа явах хүртэл түр хугацаагаар ачуулсан байгаа газар юм. Ихэвчлэн дамжин өнгөрөх бүсэд бараанд дахин нэмж өөрчлөлт оруулдаггүй бөгөөд холбогдох боомтын, эсхүл ачиж буулгах зардал хураамжаас бусад татваруудаас чөлөөлөгдсөн байдаг. Мөн шилжүүлэн ачих боомт/хотын худалдаа (entrepot trade) үзнэ үү.
1419	Transnational corporations	Үндэстэн дамнасан корпораци (TNC). Мөн олон үндэстэний корпораци (MNC), Үндэстэн дамнасан аж ахуйн нэгж (MNE) гэж нэрлэдэг. Эдгээр нь том, маш томоохон корпорациуд болон конгломератууд (conglomerates) буюу өөр хоорондоо хамааралгүй олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулагч томоохон корпорациуд бөгөөд, салбарууд, охин компаниуд, эсхүл нэгжүүд байгуулах замаар олон улс орнуудад үйлдвэрлэлийн байгууламжууд ба борлуулалтын оффисуудтай байдаг. Бие даасан нэгжүүд нь ихэвчлэн толгой компани байж болох толгой оффис руугаа тайлагнадаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Тодорхой тохиолдолд TNC доторх нэгжийг хянах үр дүнтэй хяналт хаана байгааг тогтооход нэлээд хэцүү байх болно. Өнөөдөр тэдний өмчлөл нь маш олон төрөлжсөн байж болох бөгөөд бүрэлдэхүүн хэсгүүд нь бизнесээ явуулахдаа ихээхэн бие даасан байдалтай байж болно. TNC-ийн нэгжүүд дэлхийн зах зээл дээр бие биетэйгээ өрсөлдөж байж ч магадгүй юм. Гэсэн хэдий ч TNC нь олон газарт үйл ажиллагаагаа явуулж байдаг боловч, Би-Эйч-Би (ВНР) Австралийнх, Эрикссон (Ericsson) Шведийнх, Форд (Ford) Америкийнх, Мицуй (Mitsui) Японых, Ай-Си-Ай (ICI) Их Британийнх гэх мэтээр TNC нь нэг улс үндэстний харьяалалд байдаг гэсэн ойлголт байдаг. Ихэнх тохиолдолд ийм компаниуд эхлээд нэг зах зээл дээр нэр хүндтэй болж тэр үедээ тэдний улсын харьяалал нь тодорхой байдаг. TNC-гийн хувьд тэдний зах зээлийн хүч болон үйлдвэрлэлийн хэв маягт нөлөөлөх чадвартай байдгийнх нь улмаас зарим хүрээлүүдийн зүгээс тэдэнд маш их сэжигтэй хандаж ирсэн байдаг. Жишээлбэл, тэдний үйл ажиллагаанд илүү сайн хяналт тавихыг уриалах болсон нь НҮБ-ын Хил дамнасан корпорациудын төрөлжүүлэн нэгтгэсэн хуулийн төсөл боловсруулахад хүргэсэн боловч энэ хуулийн төсөл нь маргаантай хэвээр байгаа бөгөөд ойрын ирээдүйд хүчин төгөлдөр болох шинжгүй байна. Тун саяхан TNC-гийн хувьд хөрөнгө оруулалтын сангуудыг дайчлах, технологи дамжуулалтыг хөхиүлэн дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг буй болгох талын чадавхитай байдаг учраас зохион байгуулагч болох боломжтой орнууд болон хөгжлийн асуудал хариуцсан олон улсын байгууллагуудын зүгээс илүү таатай уур амьсгалын хүрээнд хандах болсон байна. TNC-уудтай холбоотой асуудлуудын дүн шинжилгээний анхаарал хандуулж буй гол зүйл бол НҮБ-ын худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) харьяа Хөрөнгө оруулалт, технологи, холбогдох санхүүгийн үйлчилгээ эрхлэх комисс бөгөөд энэ нь мөн Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланг гаргаж байдаг. Гэсэн хэдий ч энэ сэдвээр бусад олон гайхалтай, хялбархан олдох боломжтой эрдэм шинжилгээний судалгаанууд бас байдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн улс орнууд TNC-уудыг засаглах тэдний нэгэн эрх зүйн актын нэг болгож, Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдэд зориулсан удирдамжийг баталсан байдаг. Мөн хараат байдлын онол (dependence theory), Фордизм буюу Хенри Фордын санаачилсан томоохон хэмжээний механикжуулалтын хүрээнд массын үйлдвэрлэл явуулдаг боловсруулах аж үйлдвэрлэлийн арга (Fordism), Нэг компанийн нэгжүүд хооронд явагддаг олон улсын худалдаа (intra-firm trade), Үндэстэн дамнасан боловч дотоодын зах зээлд бие даасан корпорациуд (multi-domestic corporation), Пост-Фордизм буюу Фордизмийн дараах үеийг (Post-Fordism) үзнэ үү.</p>
1420	Transparency	<p>Ил тод байдал. Энэ нь бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний худалдаатай холбоотой аливаа хууль тогтоомж, дүрэм журам, шүүхийн шийдвэр, нийтлэг хэрэглээний захиргааны журам, олон улсын хэлэлцээр болон эдгээр эрх зүйн актуудыг ухаалаг бөгөөд шударга байдлаар зохицуулах үүрэг юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Ид тод байдлын үүргийг ТХЕХ-ийн 10-р Зүйл, ҮХЕГ-ийн 3-р Зүйл, ДХБ-ын удирдан зохицуулж байдаг хэлэлцээрүүдийн бусад зүйл заалтуудад тусгаж өгсөн байдаг. Мөн мэдэгдэл (notification), хяналт тандалт (surveillance), Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоог (Trade Policy Review Mechanism) үзнэ үү.
1421	Travaux preparatoires	Бэлтгэл ажил. Энэ нь олон улсын гэрээ, конвенцийн хэлэлцээнд бэлтгэл ажил хариуцсан хороод, мэргэжилтнүүдийн бүлэг, хэлэлцээ хийх эрх бүхий бүлгүүд гэх мэтийн боловсруулж гаргасан тайлан. Эдгээр бүртгэлүүд нь хожим орчуулан тайлбарлах хэрэг гарахуйц хоёрдмол утгатай үг хэллэг гарах үед эрх зүйн баримт бичгийн төслийн боловсруулагч нарт саналаа боловсруулахад нь чухал ач холбогдолтой удирдамж болж өгдөг боловч энэ нь зөвхөн нэгдсэн саналд хүрсэн баримт бичигтэй хамт хавсаргаж байж зөв зохистойгоор хэрэглэгддэг. Тухайн хэлэлцээрийн бие даасан гишүүн улсууд нь маргааны үеэр гаргаж тавьсан өөрсдийн асуудлаа дэмжүүлэхийн тулд бусад, хараахан тохиролцоогүй, бэлтгэл ажлыг (travaux preparatoires) ашиглаж болох боловч тэд өөрсдийнх нь тайлбарыг яагаад илүүд авч үзэх ёстойг мөн л нотлон харуулах хэрэгтэй болно. Олон улсын гэрээний эрх зүйн (Law of Treaties) Венийн конвенцийн 32-р Зүйлд бэлтгэл ажлыг үзэмжээр хийж болох зүйл гэж үзсэн байдаг бөгөөд олон улсын гэрээний бичвэр нь өөрөө ганц удаагийн тайлбарлалтын хүрээнд хангалттай хэмжээнд ойлгомжтой байж чадаагүй эсвэл үнэхээр манифестийн хувьд утгагүй, эсвэл утгагүй байдалд хүргэх тохиолдолд л гол асуудал болж босч ирдэг.
1422	Treaty of Maastricht	Маастрихтын гэрээ. 1992 оны 2 дугаар сарын 7-нд хожим Европын Холбоог байгуулсан Европын хамтын нийгэмлэгийн тухайн үеийн арван хоёр гишүүн орнуудын хооронд байгуулсан гэрээ. Уг гэрээ нь 1993 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Энэхүү гэрээ нь ганц институтийн бүтэц тогтолцоогоор дамжуулан гадаад харилцаа, аюулгүй байдал, эдийн засаг болон хөгжлийн тухай бодлогын асуудлуудын хүрээнд Европын Холбооны гадаад үйл ажиллагааг бүхэлд нь нийцүүлэн хангах чухал арга замаар Ромын Гэрээнээс (Treaty of Rome) хавьгүй илүү цааш даван гарсан байдаг. Эдгээрийг биелүүлэх үүрэг хариуцлага нь Европын Холбооны зөвлөл (Council of the European Union), (Сайд нарын зөвлөл) [Council of Ministers] болон Европын Комиссоос (European Commission) хамааран оршино. Мөн, уг гэрээ нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг гэсэн нэр томьёог Европын Холбооны үндсэн тулгуур багана болох Европын хамтын нийгэмлэгээр сольсон. Зөвхөн Европын хамтын нийгэмлэг нь хууль зүйн субъект бөгөөд олон улсын гэрээ байгуулах боломжтой. Мөн түүнчлэн, уг гэрээ нь Европын холбооны бусад хоёр тулгуур багана болсон хууль зүй болон дотоодын хэрэг зэрэг салбаруудад, нийтлэг гадаад бодлого, аюулгүй байдлын бодлого, хамтын ажиллагааг тодорхойлж өгсөн байдаг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1423	Treaty of Rome	<p>Ромын гэрээ. 1957 оны 3 дугаар сарын 25-нд зургаан анхны гишүүдээр гарын үсэг зурснаар Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (European Economic Community) үүссэн бөгөөд 1958 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Уг зургаан улс орон нь Бельги, Холбооны бүгд найрамдах Герман улс, Итали, Люксембург болон Нидерланд юм. Энэхүү гэрээнд, бараа бүтээгдэхүүний чөлөөтэй шилжилт хөдөлгөөн [урсгал], гаалийн холбоог байгуулах, тоон хязгаарлалтыг арилгах, хөдөө аж ахуй, хувь этгээдийн зорчих эрх чөлөө, үйлчилгээ ба хөрөнгийн чөлөөт хөдөлгөөн [урсгал], тээврийн нийтлэг бодлого, өрсөлдөөн ба албан татварын бодлого, эдийн засаг ба худалдааны бодлого, нийгмийн бодлого, Европын хөрөнгө оруулалтын банк байгуулах, гэрээний дагуу хилийн чанад дах улс орнууд ба нутаг дэвсгэртэй хамтран ажиллах, болон институцийн хуульчилагдсан арга хэмжээнүүд гэх зэрэг асуудлуудыг хамарсан зүйл ангиуд байдаг. Ром хотод нэгэн зэрэг гарын үсэг зурсан бас өөр нэг гэрээ нь Европын атомын энергийн нийгэмлэг (European Atomic Energy Community - Euratom) байгуулсан явдал байв. Энэхүү толь бичиг Euratom-д цаашид анхаарал хандуулахгүй бөгөөд Ромын гэрээ нь үргэлж Европын эдийн засгийн нийгэмлэг байгуулсан гэрээтэй хамаатай байдаг. Мөн Европын нүүрс ба гангийн хамтын нийгэмлэг (European Coal and Steel Community), Европын Хамтын нийгэмлэг (European Community), Хөдөө аж ахуйн нийтлэг бодлого (Common Agricultural Policy), дөрвөн эрх чөлөөний горим (four freedoms) болон 113 дугаар зүйлийн Хороог (Article 113 Committee) үзнэ үү.</p>
1424	Treaty on Intellectual Property in Respect of Integrated Circuits	<p>Интеграл цахилгаан шугам бүхий микро схемүүдтэй холбоотой Оюуны өмчийн тухай олон улсын гэрээ. (Интеграл ороомогтой холбоотой оюуны өмчийн тухай гэрээ - Уругвай). Энэ нь Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) дагуу хэрэглэгдэх хамгаалалтын стандарт хэм хэмжээг агуулсан гэрээнүүдийн нэг. Үүнийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ивээл дор, 1992 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Вашингтон хотноо байгуулагдсан боловч өнөөг хүртэл хүчин төгөлдөр болоогүй байсан. Интеграл цахилгаан шугам бүхий микро схем нь хуулийн зүйл ангид багтсан эсэхээс үл хамааран, бүх талууд интеграл цахилгаан шугам бүхий микро схем (топографи)-ийн (topographies) зураг төслийн (lay out) эх хувьд оюуны өмчийн хамгаалалтыг олгох шаардлагатай. Мөн, гэрээнд оролцогч талууд, бусад бүх талуудын хувь этгээд/ харъяат иргэдэд болон хуулийн этгээдүүдэд үндэсний нөхцөлийг (NT) олгох ёстой. Интеграл цахилгаан шугам бүхий микро схемүүдийн [оюуны өмчийн] хамгаалалт нь наад зах нь найман жил байх шаардлагатай. Хамгийн багадаа, зураг төслийн загварыг хуулбарлах болон арилжааны зорилгоор зураг төслийн загварыг импортлох, борлуулах эсвэл түгээх эсвэл түүнийг ямар нэгэн зүйлд угсран оруулж багтаах зэргийг хэрэв оюуны өмчийн эрхийг эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр хийсэн бол хууль бус гэж тооцно. Мөн төрөл зүйлийн ховор/ хосгүй/давтагдашгүй эрхийг (a sui generis right) үзнэ үү.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1425	Treble damages	Гурав дахин их хохирол. АНУ-ын монополийн эсрэг хууль тогтоомжийн эрх зүйн суурь бүтэц, хамрах хүрээнийн нэг хэсэг болох 1894 оны Вилсоны Тарифын тухай хуулийн 77 дугаар хэсэг, 1914 оны Клэйтоны тухай хуулийн 4-р хэсэгт, хориглосон практик арга туршлагын улмаас хохирсон хүн учирсан хохирлоо гурав дахин нугалж төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гаргуулах замаар хохирлоо барагдуулж болно. Төлбөл зохих хохирлын хэмжээнд ямар ч дээд хязгаар гэж байхгүй. Шерманы тухай хууль буюу анхны монополийн эсрэг хууль нь гэм буруутай этгээдэд зөвхөн хамгийн дээд торгууль эсвэл шоронд хоригдох хугацааг тогтоож өгсөн байдаг. Мөн Улсын тэтгэлгийг нэмэгдүүлэхэд гарсан зардлыг, татвар нэмэгдүүлэх замаар нөхөх нөхцөлүүдийг (clawback provisions) үзнэ үү.
1426	Trigger price	Болзолт үнэ (1986-1988 оны лавлагааны дундаж үнэтэй тэнцүү болзолт үнэ). Энэ нь дотоодод үзүүлэх дэмжлэгийн зохицуулалтын хүрээнд тогтоосон үнийн түвшин бөгөөд ялангуяа хөдөө аж ахуйн салбарын хувьд олон улсын хэлэлцээрт хүрсэн тохиолдолд автоматаар, зарим тохиолдолд албан журмаар, зааварласан арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх болно. Мөн Нөөц хувьцаа (buffer stocks), Түүхий эд, материалын талаарх олон улсын хэлэлцээр (international commodity agreements), аюулд эрсдүүлэх цэг (peril points), тусгай хамгаалалтын арга хэмжээг (special safeguards) үзнэ үү.
1427	TRIMS (Trade-Related Investment Measures)	Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээ. Үүнд экспортын зорилт, импортын хязгаарлалтууд, өөр нэг улсад хөрөнгө оруулах зөвшөөрөл авах хүрээнд уг аж ахуйн нэгжид тавигддаг орон нутгийн худалдан авалтын шаардлагууд, эсхүл орон нутгийн агуулгын шаардлагууд, судалгаа хөгжүүлэлтийн шаардлагууд болон үүнтэй ижил төстэй нөхцөлүүдийг хамардаг. Мөн Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-Related Investment Measures) үзнэ үү.
1428	TRIPS (Trade-related aspects of intellectual property rights)	Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудал. Мөн Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийг (Agreement on Trade-related aspects of Intellectual Property rights) үзнэ үү.
1429	Tropical products	Халуун орны бүтээгдэхүүн. Энэ нь бүрэн гүйцэт тодорхойлогдсон бүлэг бүтээгдэхүүн биш боловч, Уругвайн үе шатны яриа хэлэлцээний үед эн тэргүүнд ач холбогдол өгч авч үзэх ёстой гэж үзсэнийг дурдвал үүнд халуун орны ундаа (кофе, какао, цай, тэдгээрт суурилсан бүтээгдэхүүн), халуун ногоо, тайрсан цэцэг, халуун орны ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, газрын тосны ургамал, ургамлын тос болон ургамлын тосон бялуу, тамхи, будаа, маниок болон бусад халуун орны ургамлын үндэс, халуун орны жимс, самар, халуун орны мод ба резин, джут, сисал болон бусад хатуу ширхэгтүүд багтдаг байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1430	Unbound commitments	Хуулиар үүрэг хүлээгээгүй, заавал биелүүлэх шаардлагагүй амлалт. Энэ нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (YXEX – General Agreement on Trade in Services - GATS) дагуу хүлээх үүрэг амлалтууд бөгөөд үүнийг хийсэн улс орнууд нэг талын баримтлан дангаараа шийдвэр гарган өөрчилж болно. Тэд жагсаалтад орсон улс оронд нөхөн олговор санал болгохгүйгээр, нөлөөлөлд өртсөн үйл ажиллагааныхаа худалдааны дэглэмийг өөрчлөх бүрэн уян хатан байдлыг олгодог. Тиймээс, хуулиар үүрэг хүлээгээгүй, заавал биелүүлэх шаардлагагүй амлалт нь Үүрэг болгосон, заавал биелүүлэх (binding/bound) үүрэг амлалтуудаас (binding commitments) хамаагүй бага ач холбогдолтой боловч энэ нь зарим тохиолдолд ил тод байдалд дэмжин тусалдаг байна.
1431	UNCITRAL (United Nations Commission on International Trade Law.)	НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн хороо (ЮНСИТРАЛ - UNCITRAL). Уг хороо нь олон улсын худалдааны урсгал дах хууль эрх зүйн саад хоригийг багасгах, эсхүл арилгах мөн олон улсын худалдааны эрх зүйг аажмаар уялдуулан нэгтгэх зорилгоор 1966 онд байгуулагдсан. UNCITRAL нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар (United Nations General Assembly) сонгогдсон 36 гишүүнтэй. Энэ нь олон улсын худалдааны эрх зүйн салбарт, НҮБ-ын системийн хүрээнд гол хуулийн байгууллага юм. UNCITRAL нь ялангуяа олон улсын арилжааны арбитр [маргааныг хөндлөнгийн шүүхээр шийдвэрлүүлэх] (arbitration), эвлэрүүлэх процедур (conciliation) болон олон улсын тээвэрлэлт, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг хамарсан сэдвээр өргөн хүрээний ажлын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тухайн байгууллага Вена хотод байрладаг.
1432	UNCPC (United Nations Central [Provisional] Product Classification)	НҮБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн [түр зуурын] ангилал. Энэ нь үйл ажиллагааны оронд, бараа бүтээгдэхүүн дээр анхаарал хандуулдаг байна. Үүнд 600 гаруй үйлчилгээний бүтээгдэхүүнийг жагсаасан болно. Энэ нь Худалдаа, үйлчилгээний тухай ерөнхий хэлэлцээрийн (GATS) заавал биелүүлэх, үүрэг амлалтуудын жагсаалт (schedules of commitments) дах анхдагч жагсаалт гаргахад суурь үндэс болгон ашигладаг боловч тэдний шаардлагыг бүрэн дүүрэн хангадаггүй байна. Уг ангиллын шинэчилсэн хувилбар нь 1997 оны сүүлээр бэлэн болохоор тооцоолсон байдаг.
1433	UNCTAD (United Nations Conference on Trade and Development)	Нэгдсэн үндэстний байгууллагын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD). Энэ нь Дэлхийн худалдааны тогтолцоонд (world trading system) хөгжиж буй орнуудын илүү их оролцоог хөхиүлэн дэмжиж, улмаар тэдний эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор, 1964 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн (United Nations General Assembly) 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан. Нийт 195 гишүүн улс оронтой юм. ЮНКТАД нь сул дорой эдийн засагтай орнуудын өсөлтийг хурдасгах зорилгоор бүх бүс нутагт тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлогын дүн шинжилгээ, хэлэлцүүлэг, болон зөвшилцөл байгуулах үндсэн чуулга уулзалт юм гэж өөрийгөө тодорхойлдог байна. Хөгжиж буй орнууд өөрсдийн эдийн засгийн хөгжлийг ахиулахад учирч буй хүндрэл бэрхшээлүүд болон энэхүү тулгамдсан асуудлуудад нь дэмжлэг үзүүлж болох олон улсын

төрөлжсөн байгууллагууд байхгүй байсан явдал нь ЮНКТАД-ыг үүсгэн байгуулахад хүргэсэн өргөн хүрээний шалтгаан байжээ. 1960-аад оны эхээр колонийн эзэмшилд байсан олон улс орнууд эрх чөлөөтэй, хараат бус болсноор тэдний асуудлуудад зохих анхаарал хандуулах шаардлага улам ихэссэн. 1961 онд, олон улсын худалдааны асуудлаар дэлхийн бага хурал зохион байгуулах боломжийн талаар зөвлөлдөхийг Эдийн засаг ба нийгмийн зөвлөлийн 2 дугаар хорооноос (Second Committee of ECOSOC) НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад (United Nations Secretary-General) хүсэлт гаргасан бөгөөд, улмаар 1962 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Женев хотод 1964 онд энэхүү бага хурлыг зохион байгуулахаар шийдвэр гаргажээ. Үүнийг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн анхны бага хурал (UNCTAD I) гэж нэрлэдэг болсон. Уг бага хурлын хамгийн эхний үр дүнгүүдийн нэг болох [хөгжиж буй орнуудын] 77-гийн бүлгийг (Group of 77) байгуулсан явдал бөгөөд тэд ЮНКТАД-ын ажлын хөтөлбөрийг (UNCTAD work program) боловсруулах санаачлагыг шуурхай гартаа авсан байдаг. Энэ бага хурлаар бараа түүхий эдийн худалдаа ба зохицуулалт, үйлдвэрлэл, хөрөнгийн шилжүүлэлт болон тээвэрлэлт зэрэг эцсийн дүндээ ЮНКТАД-ын ажлыг бүрэлдүүлсэн олон асуудлуудыг хэлэлцсэн байна. Ажлын хөтөлбөрт өр төлбөр, даатгал, Хөгжиж буй орнуудын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа (economic cooperation between developing countries - ECDC), бизнесийг хязгаарласан үйл ажиллагаа, технологи дамжуулалт, нэн буурай хөгжилтэй орнуудын асуудлууд болон бусад асуудлууд хожим нэмэгдсэн болно. Хөгжиж буй орнуудын хөгжилд оруулсан ЮНКТАД-ын хувь нэмрийг эс тооцвол, энэ нь бүхэлдээ тэднийг дэмжигчдээс хүсэн хүлээж байсан ажил үүрэгтээ хүрч чадаагүй байна. Хамгийн эртдээ, 1968 оны үед, ЮНКТАД нь өөрийн дүрмэнд нь тусгасан олон худалдааны асуудлаар хэрэгжүүлэх бодит арга хэмжээ авч ажиллахын тулд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн улс төрийн уур амьсгал болон мэтгэлцээний практик арга барилаас өөрийгөө хангалттай хэмжээнд чөлөөлж чадах эсэх талаар асуудал дэвшүүлж байсан байна. Эдгээр бодит байдлыг тусгаж ажиллахад илт амжилтгүй байсан зөндөө шалтгаан байдаг бөгөөд тэдгээр нь өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг. ЮНКТАД нь нийтээр хүлээн зөвшөөрсөн [универсал] байгууллага бөгөөд өөрсдийн гишүүддээ ямар нэгэн холбогдох үүрэг хариуцлага оноолгүйгээр, олон эрхийг олгодог байна. Энэ нь бодит бус хүлээлтүүдийг өдөөж болох юм. Үүний эрх үүргийн цар хүрээ нь анхнаасаа гайхалтай байсан бөгөөд олон хөгжиж буй орнууд анхнаасаа тэднийг олон улсын худалдааны байгууллагын хувьд (International Trade Organisation) зориулагдсан үүрэгтэй ижил төстэй үүргийг авч хэрэгжүүлэх байх гэж найдаж байгаа боловч тэдний хувьд хөгжлийн онцгой асуудал гэж үзсэн зүйл рүүгээ хүчтэй хазайсан шинжтэй байдаг. Мөн Түүхий эд, материалын нийтийн/ хамтын сан (Common Fund for Commodities), Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP), Түүхий эд, материалын нэгдсэн хөтөлбөр (Integrated Programme for Commodities), болон Худалдааны үр ашгийн талаарх хөтөлбөрийг (Trade Efficiency Programme) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1434	UNCTAD BIOTRADE initiative	<p>НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал дах БИО худалдааны тухай санаачилга. Энэ нь Биологийн олон янз байдлын тухай конвенцийн (Convention on Biological Diversity) зорилгуудыг дэмжих зорилгоор НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) ивээл дор 1996 онд байгуулагдсан механизм. Энэ нь биологийн олон янз байдлын нөөцөд үнэ цэнэ авчрах, зохистой технологиудыг шилжүүлэх болон эдгээр нөөцийн экспортын боломжийг бий болгохын тулд эдийн засгийн арга хэрэгсэл, стратегийн түншлэлийн тохирох хэрэглээг дэмжих зорилготой. Уг санаачилга нь долоон бүрэлдэхүүн хэсэгтэй, үүнд: (i) биологийн материалаас арилжааны хувьд үнэ цэнэтэй нийлмэлийг илрүүлэх боломж гэж тодорхойлсон, шинээр хөгжиж буй биохимийн материалын олборлолт судалгааны зах зээлийн чиг хандлагад эдийн засгийн болон зах зээлийн судалгаа явуулах, (ii) биологийн нөөцөд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратегийн судалгаа шинжилгээ, (iii) байгаль хамгаалал ба тогтвортой хөгжлийн боломжуудын үнэлгээ, (iv) биохимийн материалын олборлолт судалгааны үйл ажиллагаанд зориулсан өөр хувилбар бүхий гэрээтэй зохицуулалт, (v) сургалт ба чадавх бүрдүүлэх, (vi) хувийн хэвшлийн салбарын хамтын ажиллагаа, болон (vii) мэдээллийг түгээн дамжуулах ба сүлжээ үүсгэж ажиллах зэрэг болно.</p>
1435	Understanding on financial services	<p>Санхүүгийн үйлчилгээний тухай харилцан ойлголцох баримт бичиг [ойлголт]. Энэ нь ДХБ-ын зөвхөн хөгжингүй гишүүн орнуудын баталсан Үйлчилгээ, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн (YXEX - GATS) хавсралт юм. Үүнд, YXEX-ийн нөхцөлд санхүүгийн үйлчилгээний шударга худалдааг хэрхэн ойлгогдох ёстой талаар лавшруулан тодорхойлсон байдаг. Уг ойлголт нь үүрэг амлалтын жагсаалтад (schedules of commitments) хасалтын аргаар жагсаадаг жагсаалтын үндэс суурийг бий болгодог байна.</p>
1436	Understanding on Rules and Procedures Governing the Settlement of Disputes	<p>Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг (WTO understanding on dispute settlement) үзнэ үү.</p>
1437	Understanding on the Balance-of-Payments Provisions of the GATT	<p>Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (TXEX) төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтын тухай харилцан ойлголцох баримт бичиг (Уругвай). Энэ нь Уругвайн үе шатны хэлэлцээнээс гарсан үр дүнгийн нэг. TXEX-ийн 12 дугаар зүйл (Article XII), 18 дугаар зүйлийн Б-д (Article XVIII:B) заасны дагуу өөрсдийн төлбөрийн тэнцлийн нөхцөлийг сайжруулахын тулд, ДХБ-ын гишүүн орнуудын зүгээс хэрэглэх боломжтой арга хэмжээг ногдуулах журмыг тодруулах зорилготой юм. Ялангуяа, мэдэгдэл гаргах болон зөвлөгөөний сайжруулсан тогтолцоогоор дамжуулан илүү ил тод байдлыг бий болгохыг эрэлхийлдэг.</p>
1438	Unfair business practices	<p>Шударга бус бизнесийн арга ажиллагаа. Мөн бизнесийг хязгаарласан үйл ажиллагааг (restrictive business practices) үзнэ үү.</p>
1439	Unfair pricing practices	<p>Шударга бусаар үнэ тогтоох арга ажиллагаа. Зарим хүмүүс демпингийн утгыг илэрхийлэхдээ ашигладаг нэр томьёо.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1440	Unfair trading practices	Шударга бус худалдааны арга туршлагауд. Энэ нь ДХБ-ын дүрмийн дагуу Татаасны зохисгүй, эсхүл хууль бус хэрэглээ, эсхүл бараа бүтээгдэхүүнийг хэт хямд буюу демпинг хийсэн үнээр экспортлохыг хэлнэ. Мөн демпингийн эсрэг арга хэмжээ (anti-dumping measures), Татаасны хохирлыг сөргүүлэн тэнцэтгэж импортод ноогдуулсан татвар (countervailing duties), болон демпингийг (dumping) үзнэ үү.
1441	Unforeseen development	Урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдал (Уругвай). Энэ нь ямар нэг худалдааны бодлогын зохистой байдал болон хариу үйлдэл үзүүлэх чанарыг туршиж өгөх боломжтой урьдчилан мэдэх боломжгүй үйл явдал. Энэ нь ТХЕХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу авах боломжтой хамгаалалтын арга хэмжээг хэрэглэхэд хүргэж болох хүчин зүйлүүдийн нэг юм. Мөн Малгай наймаалагчдын үслэг малгайн тухай хэргийг (Hatters' fur case) үзнэ үү.
1442	Unilateralism	Нэг талыг баримталсан харилцааны онол. Уг нэр томьёо нь худалдааны бодлогод нэлээд өөр хоёр утгатай байдаг. Эхнийх нь, бусдын харилцан адил арга хэмжээ авахыг хүлээлтгүйгээр, нэг талыг баримтлан тарифыг бууруулах арга хэмжээ авах, эсхүл худалдаанд учирч буй бусад саад тогторыг арилгах арга хэмжээ авах зэрэг магтахуйц бодлогыг илэрхийлж байдаг. Хоёр дах нь, дэлхийн худалдааны бодлогын (global trade policy), эсхүл тодорхой нэг бараа бүтээгдэхүүний худалдааны хүсүүштэй шинж чанаруудын талаарх өөрийн үзэл бодлыг бусдад тулгах, тэднээр үүнийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэл. Ийм төрлийн нэг талыг баримталсан зарчим нь зөвхөн их эдийн засгийг маш их давамгайлсан давуу байдалтай байгаа тохиолдолд үр дүнтэй байдаг боловч яг тийм үед ч гэсэн амжилтад хүрнэ гэсэн баталгаагүй юм. Уг зарчим нь тухайн зорилтуудын заримд нь хүргэх боловч ихэнх тохиолдолд энэ нь сунжирсан барьцалдсан өрсөлдөөнтэй уур амьсгалд хүргэдэг байна. Ихэнх улс орнуудын хувьд, ашиглагдах нөөц эх үүсвэрүүд болон олж болох үр ашгийн нарийн тооцсон зардлыг харвал үүнийг сонголт болгож авч үзэхгүй л байх. Мөн 301-р хэсэг (Section 301), 301-р тусгай хэсэг (Special 301), Супер 301 (Super 301), хоёр талт харилцааны онол (bilateralism), олон талт тогтолцооны онол (multilateralism) болон харилцан адил байх (reciprocity) тухай үзнэ үү.
1443	United Nations Conference on Environment and Development	НҮБ-ын хүрээлэн буй орчин, хөгжлийн бага хурал. Мөн Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн асуудлаарх Риогийн Тунхаглалыг (Rio Declaration on Environment and Development) үзнэ үү.
1444	United Nations Conference on Trade and Employment	НҮБ-ын Худалдаа, хөдөлмөр эрхлэлтийн бага хурал. Энэ нь 1947 оны 11 дүгээр сараас 1948 оны 3 дугаар сар хүртэл Гавана хотод болсон бага хурал бөгөөд, түүнд Гаванагийн дүрмийн (Havana Charter) төслийг хэлэлцэж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан. Бэлтгэл ажлыг хангах зорилгоор тус бага хурлын өмнө гурван хорооны уулзалт болсон. Анхдугаар уулзалт нь 1946 онд Лондон хотноо болсон Гаванагийн бага хурлын (Havana Conference) анхны бэлтгэл хуралдаан бөгөөд Олон улсын худалдааны байгууллагын дүрмийн (International Trade Organisation - ITO) төсөл гэж үздэг.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Хоёрдугаар уулзалт нь 1947 оны 1 дүгээр сараас 2 дугаар сар хүртэл Нью Йорк мужын Лэйк Саксес (Lake Success) хотод болсон төсөл боловсруулах хорооны уулзалт бөгөөд үг хэллэгийг нь дүрмийн төслөөс найруулгыг авснаар үр дүнд нь Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрийн (GATT) анхны бүрэн төслийг боловсруулж гаргасан. Гуравдугаар уулзалт нь 1947 оны 4 дүгээр сараас 8 дугаар сар хүртэл Женев хотноо болсон Гаванагийн бага хурлын 2 дах бэлтгэл хуралдаан бөгөөд Гаванагийн бага хурал руу дамжуулах зорилгоор, дүрмийн төслийг цааш нь гүйцээж дуусгасан. Мөн түүнчлэн, ТХЕХ-ийг эцэслэн боловсруулж дуусгасан бөгөөд зарим тарифын хэлэлцээ хийсэн. Мөн 1947 онд батлагдсан ТХЕХ (GATT 1947), Олон улсын худалдааны байгууллага (ITO) болон худалдаа ба хөдөлмөр эрхлэлтийг (trade and employment) үзнэ үү.</p>
1445	<p>United Nations Convention on the Law of the Sea</p>	<p>Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенц. Энэ нь 1982 оны 12 дугаар сарын 10-нд батлагдсан бөгөөд 1994 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Уг конвенц нь далай тэнгис, далайн ёроол ба хөрсний доод давхарга, мөн түүнчлэн түүний дээрх агаарын орон зайг хамгаалах эрх зүйн хүрээг бүрдүүлдэг. Энэ нь далай тэнгис (seas), далайг (ocean) аюулгүй ашиглах, тэдгээрийн нөөцийг шударга үр ашигтайгаар ашиглах, далайн хүрээлэн буй орчныг судлах, хамгаалах ба хадгалахыг дэмжих зорилготой. Конвенцын 5 дугаар хэсэг нь худалдааны бодлогын хувьд хамгийн их ач холбогдолтой. Энэ нь ихэвчлэн эргийн суурь газраас далай тэнгисийн 200 миль уртаас (nautical miles) хэтэрдэггүй, далайн эргийн дагуу усны түвшин бага зурвас суурь газар болох Эдийн засгийн онцгой бүсийг (Exclusive Economic Zone - EEZ) бий болгодог. Эдийн засгийн онцгой бүсэд, далайн эргийн улс орон нь далай тэнгис ба далайн ёроолд байгаа байгалийн нөөц баялагт хайгуул хийх, ашиглах, хадгалан хамгаалах болон удирдан зохицуулах зорилгын хувьд бүрэн эрхтэй юм. Мөн, уг конвенц нь ус, усы урсгал ба салхинаас эрчим хүчийг үйлдвэрлэх гэх мэт Эдийн засгийн онцгой бүсийн (EEZ) эдийн засгийн ашиглалт ба эрэл хайгуул хийхийн хувьд адил эрх эдэлнэ. Браунлигийн үзэж буйгаар (1995), энэхүү конвенц нь урьд хожид байгаагүйгээр, олон улсын хууль эрх зүйд хууль тогтоожмийг төрөлжүүлэн нэгтгэж, (codification) дэвшилттэйгээр хөгжүүлэн боловсруулсан, хамгийн ихээр идэвхи хүч шаардсан тогтолцоог илэрхийлдэг байна.</p>
1446	<p>United Nations economic sanctions</p>	<p>НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээ. НҮБ-ын дүрмийн 39 дүгээр зүйлд заасны дагуу, Аюулгүйн зөвлөл (Security Council) нь энх тайван байдалд ямар нэгэн аюул занал, энх тайван байдлыг зөрчсөн асуудал эсхүл түрэмгий үзэгдэл бий эсэхийг тодорхойлох боломжтой бөгөөд энэ талаар зөвлөмж гаргах боломжтой. Мөн түүнчлэн, 41 дүгээр зүйлийн дагуу, шийдвэрээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчнийг ашиглахгүйгээр арга хэмжээ авах талаар шийдвэр гаргах бөгөөд мөн эдгээр арга хэмжээг хэрэглэхийг НҮБ-ын гишүүдэд уриалж болно.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>Үүнд эдийн засгийн харилцааны болон төмөр замын, далайн, агаарын, цахилгаан шуудангийн, радио болон бусад харилцааны хэрэгслүүдийн бүрэн эсвэл хэсэгчилсэн түр тасалдал, мөн түүнчлэн, дипломат харилцааг таслах зэрэг арга хэмжээнүүд орно. Гадаад бодлогын арга хэрэгсэл болгодог эдийн засгийн хориг арга хэмжээний (economic sanctions) үр ашгийн талаар олон жилийн турш тэсгэлгүй маргалдсаар ирсэн. Бараг ихэнх тохиолдолд, уг асуудалд ихээхэн ашиг сонирхол бүхий НҮБ-ын бүх гишүүдийг оролцуулах нөхцөлийг баталгаажуулна гэдэг боломжгүй юм. Энэ нь, тэдний экспортлогчдын хувьд, хориг арга хэмжээг чиглүүлсэн тухайн улсын аж үйлдвэрлэлийн салбартай адилханаар эсвэл илүү ихээр хохирол амсахгүй гэж улс орнуудад ятган итгүүлэх нь хэцүү байдагтай зарим талаараа холбоотой юм. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 21 дүгээр зүйлд (GATT Article XXI) жагсаасан аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх тохиолдлуудын нэг нь, НҮБ-ын шийдвэрийг дагаж мөрдөх шаардлагатай хэмжээнд ДХБ-ын (WTO) гишүүн орнуудад хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг байна.</p>
1447	<p>United Nations Industrial Development Organisation</p>	<p>НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (НҮБҮХБ - UNIDO). НҮБ-ын хүрээнд хараат бус бие даасан байгууллагаар 1966 онд байгуулагдсан ба 1986 онд төрөлжсөн байгууллага болсон. Уг байгууллагын эрх, үүрэг бол хөгжиж буй орнуудад аж үйлдвэрийн хөгжил болон орчин үеийн шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хурдасгах явдал бөгөөд хамтын ажиллагаа болон хөгжлийг дэлхийн, бүс нутгийн, үндэсний түвшинд мөн бие даасан аж үйлдвэрийн салбаруудын түвшинд дэмжих явдал юм. Мөн UNIDO нь аж үйлдвэрийн хөгжилтэй холбогдолтой бүх үйл ажиллагаагаа НҮБ-ын тогтолцоотой уялдуулдаг байна. Тус байгууллага Вена хотод байрладаг. Мөн НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудыг (United Nations specialised agencies) үзнэ үү.</p>
1448	<p>United Nations regional economic commissions</p>	<p>НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн комиссууд. Энэ нь гишүүн улсуудынхаа эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих, тэдгээрийн хоорондын эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, сайжруулах зорилгоор НҮБ-ын тогтолцооны хүрээнд байгуулагдсан байгууллагууд. Зарим нь нийгмийн асуудлаар үйл ажиллагааны хөтөлбөртэй байдаг. Тэд ихэвчлэн худалдааны талаар хуулиар үүрэг хүлээж, заавал биелүүлэх дүрэм журмыг боловсруулах үйл ажиллагаад оролцоод байдаггүй. Тэдний хувьд ойрхон байдаг толгой байгууллага нь НҮБ-ын Эдийн засаг ба нийгмийн зөвлөл (ECOSOC) юм. Одоогоор оршин байгаа бүс нутгийн эдийн засгийн комиссууд гэвэл, Африкийн эдийн засгийн комисс (1958 онд байгуулагдсан), Европын эдийн засгийн комисс (1947), Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудын эдийн засгийн комисс (1948), НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) (1947), Баруун Азийн эдийн засаг, нийгмийн комисс (1973) юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1449	United Nations specialised agencies	<p>НҮБ-ын [системийн хүрээний] төрөлжсөн байгууллагууд. Энэ нь өөрсдийн зохицуулалтын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай холбоотойгоор байгуулагдсан тусдаа, хараат бус бие даасан, засгийн газар хоорондын байгууллагууд. Эдгээр байгууллагууд нь өөрсдийн хууль тогтоох, гүйцэтгэх захиргаа, гишүүнчлэл болон төсөвтэй байдаг байна. Тэд бие биетэйгээ болон НҮБ-тэй Эдийн засаг ба нийгмийн зөвлөлөөр (ECOSOC) дамжуулан хамтран ажилладаг байна. Төрөлжсөн байгууллагууд нь: Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ-FAO); Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСББ - Дэлхийн Банк); Олон улсын валютын сан (ОУВС-IMF); Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO); Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (IFAD), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO); Олон улсын далайн байгууллага (IMO); Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU); НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO); НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (UNIDO); Дэлхийн шуудан холбоо (UPU); Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO); Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO); болон Дэлхийн цаг уурын байгууллага (WMO).</p>
1450	Universal Copyright Convention	<p>Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенц. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас (ЮНЕСКО - UNESCO) удирдан хэрэгжүүлж байдаг конвенц. Энэхүү конвенцийн олон үндсэн зарчим нь, зохиогчийн эрхтэй бүтээлийн өөр дээр нь зохиогчийн эрхийн тэмдэглэгээ тавих шаардлагаас бусад тохиолдолд, Бернийн конвенцид (Berne Convention) агуулагдсан утгатай адил байдаг. Мөн зохиогчийн эрхийг (copyright) үзнэ үү.</p>
1451	Upper-middle-income economies	<p>Дээд-дунд орлого бүхий эдийн засагтай улс. Энэ нь Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (IBRD) болон Дэлхийн хөгжлийн тайланд (World Development Report) ийм замаар тус тус ангилагдсан эдийн засаг бүхий 38 улсын бүлэг юм. Эдгээр улс орнуудад нэг хүнд ноогдох (per-capita) Үндэсний нийт орлого – ҮНО (gross national income - GNI) \$2,996-аас \$9,265 долларын хооронд хэлбэлздэг байна. Мөн өндөр орлоготой эдийн засаг бүхий улс (high-income economies), бага орлоготой эдийн засаг бүхий улс (low-income economies), болон бага-дунд орлоготой эдийн засаг бүхий улсыг (lower-middle-income economies) үзнэ үү.</p>
1452	Upward harmonisation	<p>Дээш чиглэсэн уялдаа холбоо. Энэ нь уялдуулах арга хэмжээнд оролцогчдын дунд давамгайлж буй хамгийн өндөр стандартад нийцүүлнэ гэсэн зарчмын дагуу стандартуудыг уялдуулах юм. Мөн стандартууд болон чанарын баталгаажуулалтыг уялдуулах (harmonisation of standards and qualifications) тухай үзнэ үү.</p>
1453	Uruguay Round	<p>Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээ. Энэ нь 1986 оны 9-р сарын 25-ны өдөр Уругвай улсын Пунта дель Эсте хотноо худалдааны сайд нарын уулзалтаар эхэлсэн бөгөөд 1994 оны 4-р сарын 15-ны өдөр Марракешийн Сайд нарын уулзалтаар өндөрлөсөн юм. Хэлэлцээний зорилго нь (i) дэлхийн худалдааг цаашид либералчлах, өргөжүүлэх, (ii) Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT-TXEX)</p>

гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх, олон талт худалдааны тогтолцоог сайжруулах, (iii) ТХЕХ-ийн олон улсын эдийн засгийн орчинд үзүүлэх хариу үйлдлийг нэмэгдүүлэх, (iv) олон улсын хамтын ажиллагааны хүрээний эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих зэрэг болно. Оролцогчид хэлэлцээрийн үеэр худалдааг хязгаарлах арга хэмжээ авахаа больж, [ижил төстэй өмнөх тохиолдолд, нарийвчилсан үнийн хэлэлцээрийн дагуу тохиролцсон олон улсын хэлцлийн үнийн хувьд баримталж байсан байр суурийг] буцаан ашигладаг заалтыг зогсоов. ТХЕХ-ийн хамгийн өргөн хүрээг хамарсан хэлэлцээний сэдэв нь тариф, тарифын бус арга хэмжээ, тэргүүлэх чиглэл болох халуун орны бүтээгдэхүүн, байгалийн нөөцөд суурилсан бүтээгдэхүүн, текстиль эдлэл (нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүн) болон бэлэн хувцас, хөдөө аж ахуй, ТХЕХ-ийн зүйл ангиудыг хянан нягталж үзэх, хамгаалалтын арга хэмжээ, Токиогийн үе шатны хэлэлцээрүүд болон эрх зүйн зохицуулалтууд, татаас болон Татаасны эсрэг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхөн тэгшитгэх татвар ноогдуулах арга хэмжээ (саармагжуулах арга хэмжээ), маргаан шийдвэрлэх, оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдолтой асуудал, худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээ, ТХЕХ-ийн тогтолцооны үйл ажиллагаа (FOGS) зэрэг байлаа. Эдгээр сэдэв тус бүрийг уг зорилгоор нь байгуулсан хэлэлцээний бүлгүүд удирдаж байв. Үйлчилгээг ТХЕХ-т хамруулах ёстой гэсэн байр суурийг хүлээж аваагүй хөгжиж буй орнуудын бүлгийн шахалт шаардлагаар үйлчилгээний худалдааны тухай хэлэлцээг хууль зүйн хувьд тусдаа чиг замаар удирдан явуулах ёстой байлаа. Дөрвөн жилийн дотор уг хэлэлцээнүүдийг эцэслэн дуусгана гэж сайд нар санал нэгдсэн байв. Хэлэлцээг гурван үе шатанд хувааж болно: (a) Пунтадель-Эсте хотод болсон нээлтээс эхлүүлээд 1988 оны 12-р сард Монреаль хотод болсон дунд хугацааны тойм үнэлгээ, (b) түүнээс хойш, хэлэлцээ эцэслэн дууссаныг тэмдэглэн ёстой байсан 1990 оны 12-р сард Брюссель хотод болсон Сайд нарын уулзалт, (c) 1994 оны 4-р сард Марракеш хотод болсон Сайд нарын уулзалт болоход хүргэсэн үйл явдлууд зэрэг болно. АНУ-ын хэлэлцээ хийх эрх бүхий байгууллагад олгосон байсан “хурдны замын” шийдлийн хоёр дах удаагийн сунгалтын хугацаа дуусгавар болох үед буюу 1993 оны 12-р сарын 15-ны өдөр томоохон хэлэлцээрүүд дуусав. Тиймээс Уругвайн үе шатны яриа хэлэлцээ гэдэг бол олон талт худалдааны хэлэлцээний хувьд илт хамгийн урт хугацаанд үргэлжилсэн яриа хэлэлцээ байсан юм. Гэвч үүнийг тасралтгүй үргэлжлэх багц хэлэлцээ гэж үзэх нь буруу байх болно. Оролцогчид болон оролцогчдын бүлэг, хэлэлцээний байр сууриндаа өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагатай болзлын хүрээнд тохиролцоонд хүрэхийн тулд урт удаан сунаж үргэлжилсэн долоон жил хагасыг зарцуулсан юм. Энэ нь ялангуяа Блэйр хууль тогтоох хурлын зөвшилцлийг хэлэлцэж, дараа нь дахин хэлэлцэх үед буюу гурав дах үед тохиолдсон явдал байв. (The Blair House Agreement буюу Блэйр хууль тогтоох хурлын хэлэлцээр гэдэг бол, Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээний үед АНУ болон Европын Холбоо хоёр, экспортын татаас болон дотоодын татаасыг

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		<p>бууруулах үүрэг амлалтын тал дээр 1992 оны 11-р сард тохиролцож чадсан хэлэлцээр юм.) ТХЕХ-ийн Ерөнхий захирал 1990 оны 12-р сард Брюссель хотод болсон Сайд нарын уулзалтад оруулж өргөн барьсан, Уругвайн үе шатны яриа хэлэлцээний “Бага хурлын төгсгөлийн актын анхны хууль тогтоомжийн ойртолтын бичвэр нь (first approximation to the Final Act)” хэрэг дээрээ 1994 оны 4-р сард Марракеш хотод эцэст нь батлагдсан хэлэлцээртэй тун ойрхон байсан юм. Уругвайн үе шатны яриа хэлэлцээний гол ололт амжилт бол худалдааны жигнэсэн дундаж тарифын хэмжээг 38%-иар хасаж, анх удаа Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATT-THEX) бүрэн сахилга, дэг журмын дор хөдөө аж ахуйн худалдааг оруулж ирж чадсан Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийг эцэслэн баталж, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийг (GATS-YHEX) баталж, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр болон Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг баталж, нэгтгэж жигдрүүлсэн ба урьдчилан таамаглаж болохуйц маргаан шийдвэрлэх тогтолцоог буй болгож, Худалдааны бодлогыг хянан үзэх тогтолцоог (Trade Policy Review Mechanism) баталгаажуулж, 15 ширхэг олон талт худалдааны хэлэлцээрүүд болон 4 ширхэг Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрийг удирддаг Дэлхийн худалдааны байгууллагыг (WTO) байгуулсан явдал юм. Яриа хэлэлцээний уг үе шатны бусад үр дүн гэвэл демпингийн эсрэг нөхцөл, татаас, хамгаалалтын арга хэмжээний нөхцөлүүдийг бэхжүүлж чадсан явдал байлаа. Текстиль (нэхмэл, сүлжмэл, оёмол эдлэл) ба бэлэн хувцасны тухай шинэ хэлэлцээр нь Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийг (Multi-Fibre Arrangement) орлон сольж, энэ салбарыг ТХЕХ-ийн дүрэм журмын дор авчирсан байна. Мөн Уругвайн үе шатны яриа хэлэлцээр дэх дуу, дүрсний үйлчилгээ (audiovisual services in the Uruguay Round), Каэрнс групп (Cairns Group), санхүүгийн үйлчилгээний түр хугацааны хэлэлцээр (financial services interim agreement), Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах Марракешийн хэлэлцээрийг (Marrakesh Agreement Establishing the World Trade Organization) үзнэ үү.</p>
1454	Uruguay Round acquis	<p>Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээний багц хуулиуд (аки). Энэ нь Олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээний үр дүнг бүрдүүлсэн хэлэлцээрүүд болон шийдвэрүүдийг тайлбарлахад, ялангуяа Европын хамтын нийгэмлэгийн ашигладаг нэр томьёо юм. Мөн Аки Куммунитэй буюу Багц хуулиуд, ЕХ-ны хууль тогтоомжуудыг (Acquis communautaire) болон Дэлхийн Худалдааны Байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийг (Marrakesh Agreement Establishing the World Trade organization) үзнэ үү.</p>
1455	USTR (United States Trade Representative)	<p>АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар (USTR - АНУ-ын Худалдааны яам). Энэ нь АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар болон түүнийг хариуцсан засгийн газрын хэрэг эрхлэх газрын түвшний албан тушаалтан хоёрын хоёуланд нь хамаарна.</p>

Анх 1962 онд Худалдааны тусгай төлөөлөгчийн газар (Special Trade Representative) гэж байгуулагдаж, 1974 онд засгийн газрын хэрэг эрхлэх газрын түвшинд хүрч дээшилсэн байна. 1980 онд АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар болж нэрийг нь өөрчилсөн. USTR нь худалдааны бодлогыг зохицуулах, гэрээ хэлцэл хийх, үүнд түүхий эд, материалын хэлцэл хийхэд АНУ-ын гол газар нь юм. Санхүүгийн үйлчилгээнд, USTR нь даатгалын асуудлыг хариуцдаг боловч Төрийн сангаас (Treasury) банкны үйлчилгээ, хөрөнгийн менежмент болон үнэт цаасыг хариуцдаг байна. АНУ-ын бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний экспортод нөлөөлж байгаа хамгийн чухал гэж үзсэн саад тотгорын жагсаалт, АНУ-ын хувь хүмүүсийн гадаад руу чиглэсэн шууд хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын талаар USTR-аас жил бүр, Гадаадын худалдааны саад тотгорын талаарх Үндэсний худалдааны үнэлгээний тайланг (National Trade Estimate Report on Foreign Trade Barriers) гаргадаг. Мөн [Худалдааны] хяналт шинжилгээ ба хууль сахиулах хэсэг (Monitoring and Enforcement Unit), 301-р хэсэг (Section 301), 306-р хэсгийн хяналт шинжилгээ (Section 306 monitoring), 301-р тусгай хэсэг (Special 301), супер 301 (Super 301) болон АНУ-ын худалдааны хэлэлцээрийн хууль тогтоомжийг (United States trade agreements legislations) үзнэ үү.

---- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1456	Variable levies	Хувьсах татвар хураамж. Энэ нь дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс үл хамааран дотоодын зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөхгүй байх нөхцөлийг хангах зориулалттай импортын нэмэлт хураамжийн нарийн төвөгтэй систем бөгөөд энэ нь үргэлж дэлхийн үнээс хамаагүй дээгүүр байдаг. Хувьсах татвар хураамж нь Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын (Common Agriculture Policy) онцлог шинж чанар юм. Уругвайн үе шатны хэлэлцээний (Uruguay Round) үр дүнгийн дагуу хувьсах татвар хураамжийг тариф руу шилжүүлэх шаардлагатай болсон. Мөн хувьсах татвар хураамжийг нэвтрүүлснээс үүдэлтэй худалдааны хурцадмал байдлын жишээ болсон Тахианы махны дайн (Chicken War), Тослог ургамлын үрийн тухай хэргийг (Oilseeds case) үзнэ үү.
1457	VER (voluntary export restraint)	Сайн дурын экспортын хязгаарлалт. Мөн сайн дурын хязгаарлалтын тохиролцоог (voluntary restraint arrangement) үзнэ үү.
1458	Vertical arrangements	Босоо бүтэцтэй зохицуулалт. Өрсөлдөөний бодлогын (competition policy) талаар үзнэ үү.
1459	Vertical foreign direct investment	Босоо бүтэцтэй гадаадын шууд хөрөнгө оруулалт. Энэ нь тухайн компанийн өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нэмүү өртөг шингээх гинжин сүлжээнийхээ анхан шатанд, (upstream) эсхүл эцсийн үе шатанд (downstream) чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг илэрхийлж байдаг. Жишээлбэл, даавуу үйлдвэрлэгч нь түүхий хөвөн боловсруулах үйлдвэр эсвэл бэлэн хувцас үйлдвэрлэх үйлдвэрт хөрөнгө оруулж болно.
1460	Vertical keiretsu	Босоо тэнхлэгийн кэйрэцү. Мөн кэйрэцү харилцааг (keiretsu relationships) үзнэ үү.
1461	VIE	Сайн дурын импортын өргөжүүлэлт (voluntary import expansion) үзнэ үү.
1462	Virtuous circle	Буянтай тойрог. Энэ нь үр ашигтай дараалсан арга хэмжээнүүдийг тайлбарлах зорилгоор бодлогын түвшний олон талбарт ашигладаг арга юм. Худалдааны бодлогод дахин дахин яригддаг зүйлсийн нэг бол эдийн засгийн хөгжил, худалдааны өсөлт болон нийгмийн дэвшлээс бүрэлддэг. Мөн Олон улсын худалдааны либералчлалын нийгмийн хэмжигдэхүүнийг (social dimension of the liberalization of international trade) үзнэ үү.
1463	Voluntarism	Сайн дурын зарчим. Энэ нь Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК-АРЕС) үйл ажиллагааг дэлгэрүүлж байдаг зарчмуудын нэг. Ерөнхийдөө, Богорын тунхаглалд (Bogor Declaration) тусгагдсан худалдааг бүрэн либералчлах сүүлчийн хугацаанд багтаан биелүүлж л байгаа тохиолдолд, АПЕК-ийн олон дэд хөтөлбөрүүд болон ажлын хэсгүүдэд оролцох нь сайн дурын хэрэг юм. Гэвч бодит байдал дээр, гишүүн орнуудын ихэнх нь уг зарчмыг хэрэгжүүлэхэд бэлэн байгаа үед үйл ажиллагаанд оролцохоос татгалзахад нэлээд хэцүү байх болно гэж үздэг. Үүний тод жишээ бол АРЕС-ын гаргасан Салбарын хүрээний либералчлалыг сайн дураараа эрт үед нь хийх (EVSL) санаачилга юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		EVSL-ын зорилгыг хэрэгжүүлж байх явцдаа АПЕК нь ДХБ-тай ижил төстэй хэлэлцээний сөрөг орчинг буй болгосон талаар зарим АПЕК-ийн гишүүд гомдол гаргасан байдаг. Тэдний үзэж байгаагаар хамтын ажиллагаа бол АПЕК-ийн үндэс суурийг бүрдүүлдэг байна.
1464	Voluntary import expansion	Сайн дурын импортын өргөжүүлэлт (VIE). Энэ нь өөр улсын хувьд экспортын тодорхой ашиг сонирхол бүхий импортын бүтээгдэхүүнийг дэмжсэн арга хэмжээг хүлээн зөвшөөрөхийн тулд, тухайн нэг улс нь харваас сайн дураараа зөвшөөрсөн хоёр талт хэлэлцээр юм. Энэхүү зохицуулалт нь одоо ДХБ-ын дүрмийн дагуу бол хууль бус болсон саарал бүсийн арга хэмжээ (grey-area measures) орохоор болж байгаа бололтой. Мөн АНУ болон Японы хоорондох автомашины маргааныг (United States-Japan autos dispute) үзнэ үү.
1465	Voluntary restraint arrangement	Сайн дурын хязгаарлалтын тохиролцоо (VRA). Энэ нь тухайн улс тодорхой нэг бүтээгдэхүүнийг өөр нэгэн улс руу экспортлохдоо тодорхой хугацаанд хязгаарлалт хийхээр тохиролцсон тохиолдолд үүсч байгаа арга хэмжээ юм. Эмзэг мэдрэмтгий хэмээн нэрлэдэг салбаруудад энэхүү сайн дураараа хязгаарлалт хийх арга хэмжээг ган, автомашин, хагас дамжуулагч болон бусад бүтээгдэхүүнд ашиглаж байсан байна. Өөрийнх нь худалдаанд илүү их аюул учрах нөхцөлийг зайлуулахыг хүссэн экспортлогч улсын хувьд хоёр чөтгөрийн арай бага аюултайг нь сонгох хэрэгтэй болж таардаг тийм хэмжээнд л эдгээр зохицуулалтыг сайн дураараа хэрэгжүүлдэг ажээ. Сайн дураараа хязгаарлалт хийх арга хэмжээ (VRA) нь үр дүнтэй ханган нийлүүлэгчид хүртэх харьцангуй давуу талын үр ашгийг үгүйсгэдэггүй. Тэдгээрийн нөлөөнд өртсөн салбарууд тэдгээр зах зээлд нэвтрэх боломжоо хадгалж авч үлдэхийн тулд арай үр ашиг багатай зах зээлд хөрөнгө оруулахаас өөр аргагүй болох тул эдгээр арга хэмжээ нь нөөцийг үр ашиггүй хуваарилахад хүргэдэг. Өөр бас нэг боломжит үр дүн нь гэвэл, өрсөлдөөн буурах тул экспортлогч, импортлогчдод гэнэтийн ашгийг өгдөг тал бий. Майкл Костецки (Miachael Kostecki) нь VRA-ийн дагуу экспортын квот ногдуулахтай холбоотой шалтгааныг авч үзэхэд зориулж хэрэгцээтэй гурван хэсгээс бүрдэх эрх зүйн бүтэц, хамрах хүрээг санал болгосон байна. Нэгдүгээрт, дотоодын аж үйлдвэрлэлийн аргачлал гэж байдаг бөгөөд үүнд төсөөлөн тооцоолсон дотоодын эрэлт хэрэгцээний тодорхой хэмжээний хамгийн бага түвшинг импортлогч улсын үйлдвэрлэгч нарт үлдээж хуваарилдаг байна. Хоёрдугаарт, экспортлогчдод түрүүлж хандах аргачлал гэж байдаг бөгөөд тодорхой түвшний экспортын хамгийн дээд хэмжээг хатуу тогтоогоод харин зах зээлийн үлдсэн хэсгийг импортлогч улсын үйлдвэрлэгч нарт үлдээдэг байна. Гуравдугаарт, импортлогч улсад эрэлт хэлбэлзэх эрсдлийг дотоодын үйлдвэрлэгчид болон гадаадын ханган нийлүүлэгчдийн хооронд ижил тэгш хуваарилдаг. ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр нь шинэ VRAs-ийг хууль бус болгосноос гадна ДХБ байгуулагдах үед буюу 1995 оны 1-р сарын 1-ний өдөр гэхэд хүчин төгөлдөр байсан бүгдийг таван жилийн хугацаанд үе шаттайгаар арилгах шаардлагатай болсон байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1466	Voting rights in the WTO	<p>ДХБ дах санал өгөх эрх. Энэ нь ДХБ-ын гишүүн тус бүр худалдаа эрхэлдэг улсын хувьд тогтсон зэрэглэлээсээ үл хамааран нэг санал өгөх эрхтэй. Европын хамтын нийгэмлэгийн хувьд түүний гишүүн улсуудын тооноос хамааран түүнтэй нь тэнцэх тооны санал өгөх эрхтэй байдаг. Мөн ДХБ-ын хэлэлцээрүүдэд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (amendments to WTO agreements), Зөвшилцөл, тохиролцоо, нэгдмэл санал (consensus) болон ДХБ-д шийдвэр гаргах (decision-making in the WTO) талаар үзнэ үү.</p>
1467	Vulnerability index	<p>Эмзэг байдлын индекс. НҮБ-ын чуулганаар хэлэлцэж байгаа уг үзэл баримтлал нь нэн буурай хөгжилтэй орнуудын эрэлт хэрэгцээ, тэдгээрийг нэн буурай хөгжилтэй орон гэж авч үзэхэд сонгогдох боломжийг нь илүү бодитой үнэлэх боломжийг олгодог. Эмзэг байдлын индексийг боловсруулж гаргах талаар төрөл бүрийн санал дэвшүүлсэн байдаг боловч аль нь ч өргөн хүрээний дэмжлэг аваагүй байна.</p>

--- 0 ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1468	Wage-differential argument	Ялгавартай цалингийн тухай мэтгэлцээн. Энэ нь бага цалинтай улс орнууд өндөр цалинтай улс орнуудын үнийг унагах боломжтой бөгөөд ингэснээрээ өрсөлдөхүйц давуу талыг эдлэх болно гэсэн санал юм. Энэ бол тийм биш юм гэдэг байдлаар эдийн засагчид сүүлийн 150 жилийн турш сэтгэл ханамжтай байж ирсэн бөгөөд цалингийн ялгааг хөдөлмөрийн бүтээмжийн зөрүүгээр тооцож болно гэж үзэж байв. Худалдааны бодлогод энэхүү маргаан нь үргэлжилсээр байгаа. Энэ нь худалдаа болон хөдөлмөрийн стандартын талаарх мэтгэлцээний нэгэн хэсэг болсон хэвээр байгаа бөгөөд үүнд нийгмийн шинж чанартай заалт (social clause) шаардлагатай гэж үзэж байна. Мөн ёроол руу уралдах тухай мэтгэлцээнийг (race-to-the-bottom argument) үзнэ үү.
1469	Waiver	Үүрэг амлалтыг цуцлах тухай баримт бичиг (үүргээс чөлөөлөх - Уругвай) (түдгэлзэх - Оч). Энэ нь ДХБ-ын гишүүн улс орнуудаас нөгөө нэг гишүүн улсынхаа тухайн тодорхой олон улсын худалдаатай нь холбоотой тодорхой заалтыг хэрэгжүүлэх үүрэг амлалтаас нь чөлөөлөх замаар олгосон чөлөөлөлт юм. ДХБ-ын дүрмийн дагуу, [үүрэг амлалтаас] татгалзах/чөлөөлөгдөх тухай баримт бичгийг ДХБ-ын гишүүн орнуудын дөрөвний гурав нь хүлээн зөвшөөрөх ёстой болдог. Уг эрхийг олгосны дараа түүнийг үе ше нягталж үздэг. Татгалзах/чөлөөлөгдөх тухай баримт бичиг нь Хөнгөлөлтийн ерөнхий системийн схемийнх нь дагуу АНУ-ын олгодог өрсөлдөх чадварын хэрэгцээний хязгаарлалтыг түдгэлзүүлэх тохиолдол байсан байна. Мөн ASTP болон 22-р хэсэгт тусгасан Үүрэг амлалтыг цуцлах тухай баримт бичгийг (22 waiver) үзнэ үү.
1470	Washington consensus	Вашингтоны зөвшилцөл. Энэ нь 1993 онд эдийн засагч Жон Уильямсон болон бусад олон этгээдүүд, үүнд Вашингтон хотод байрадаг Олон Улсын сэргээн босголт, хөгжлийн банк (IBRD) болон Олон улсын валютын сан (IMF) зэрэг байгууллагуудын үзэж байгаагаар бол, эдийн засгийн сайн менежментийн үндэс суурийг бүрдүүлэх багц зарчмуудын хувьд санал болгосон нэр томьёо юм. Эдгээр зарчмуудад: худалдааны либералчилал, дотогшоо чиглэсэн шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, төсвийн сахилга бат, улсын төсвийг үр ашигтай зарцуулахад (public expenditure) тэргүүлэх ач холбогдол өгөх, татварын шинэчлэлт, санхүүгийн либералчилал, өрсөлдөх чадвартай валютын ханш, хувьчилал, төрийн зохицуулалтыг халах, болон өмчийн баталгаатай эрх гэх зэрэг ордог. Мөн, олон даяаршлыг эсэргүүцэгчид эдгээр зарчмын үндэслэлийг эсэргүүцдэг байна.
1471	Wassenaar Arrangement on Export Controls for Conventional Arms and Dual-Use Goods and Technologies	[Үй олноор хөнөөх зэвсгээс бусад] Ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологийн экспортын хяналтын Вассенаарын хэлэлцээр. Энэхүү 1996 оны 7 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, 1996 оны 11 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон зохицуулалт нь Экспортын олон талт хяналтыг зохицуулах хорооны (COCOM) залгамжлагч юм. Уг хэлэлцээрийн гол зорилго нь ердийн зэвсэг ба хос хэрэглээ бүхий бараа, технологи шилжүүлэхэд ил тод байдал болон илүү хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих явдал юм.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
		Энэхүү хэлэлцээр нь аливаа нэгэн улс эсвэл бүлэг улс орны эсрэг чиглэгдээгүй бөгөөд гишүүн улс бүр өөрсдийн экспортын хяналтын тухай хууль тогтоомжоо хэрэгжүүлдэг. Уг хэлэлцээр 33 гишүүнтэй, үүнд Варшавын гэрээ/пактын гишүүд багтсан байдаг. Мөн хоёрдмол хэрэглээний зориулалттай экспортыг (dual purpose exports) үзнэ үү.
1472	Watch list	Ажиглалтын жагсаалт. Мөн тэргүүлэгч гадаад орон (priority foreign country) болон 301-р тусгай хэсгийг (Special 301) үзнэ үү.
1473	Water in the tariff	Тарифын ус. Энэ нь эртнээс үүссэн боловч Уругвайн үе шатны хэлэлцээнд тарифжуулалтын (тарифын бус арга хэмжээнүүдийг тариф руу шилжүүлэн хувиргах) талаар хийх хэлэлцээ хийхэд ашигласан илэрхийлэл. Эдгээр арга хэмжээнүүдийн үр нөлөө болон хэрэгжүүлэх арга зүйн хувьд хууль ёсны ялгаа байдаг учраас хэлэлцээ хийгч нарын хувьд ийнхүү шилжүүлэн хувиргах нь хэзээ ч бүрэн хэмжээний нарийвчлалтай байх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хэдий тийм боловч, улс орнууд илт хөөрөгдсөн тарифтай адилтгасан хэмжээг (tariff equivalent) санал болгосон тохиолдлууд байсан байна. Хамгаалж болохуйцаар тарифыг (defensible tariff) хувирган шилжүүлсэн байдал болон бодитоор санал болгосон тариф хоёрын хоорондох ялгааг "тарифын ус" буюу "бохир тарифжуулалт" (dirty tariffication) гэж тайлбарладаг.
1474	West African Economic and Monetary Union	Баруун Африкийн Эдийн Засаг болон Валютын Холбоо. Энэ нь нэгдсэн гадаад тариф, худалдааны нийтлэг бодлого, эдийн засгийн уялдуулсан бодлогуудыг ашиглан эдийн засгийн бүрэн интеграцчилалд хүрэх зорилгоор 1994 онд байгуулагдсан. Бенин, Буркина Фасо, Кот д'Ивуар, Мали, Нигер, Сенегал, Того гэх Баруун Африкийн улс орнуудаас бүрэлдсэн гишүүдтэй юм. Үүний Нарийн бичгийн дарга нарын газар нь Буркина Фасогийн Уагадугу хотод байрладаг.
1475	West African Economic Community	Баруун Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг. Энэ нь 1966 онд байгуулагдсан бөгөөд Бенин, Буркина Фасо, Коте д'Ивуар, Мали, Мавритан, Нигер, Сенегал улсуудаас бүрддэг. Мөн Баруун Африкийн улсуудын эдийн засгийн хамтын нийгэмлэгийг (ECOWAS – Economic Community of West African States) үзнэ үү.
1476	Western Hemisphere Free Trade Agreement	Дэлхийн баруун бөмбөрцөгийн чөлөөт худалдааны хэлэлцээр. Америкийн чөлөөт худалдааны бүсийн (FTAA) тухай үзнэ үү.
1477	Wider competition policy	Өрсөлдөөний илүү өргөн хүрээний бодлого. Энэ нь одооны байдлаар зохисгүй гэж үзэж байгаа өнөөгийн эрх зүйн зохицуулалтаас ашиг хүртэж байгаа салбаруудад өрсөлдөөнийг дэмжиж, мөн жинхэнэ монополиудыг өрсөлдөөнд нээж байгаа засгийн газрын арга хандлагын тухай юм. Мөн Монополийн эсрэг(antitrust laws), өрсөлдөөний бодлого (competition policy), төрийн зохицуулалтыг халах (deregulation), өрсөлдөөний явцуу бодлого (narrow competition) болон төрийн зохицуулалтыг дахин нэвтрүүлэхийг (re-regulation) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1478	Wine gallon assessment	<p>Дарсны галлоны үнэлгээ. (1 галлон = англиар 454 литр, америкаар 378 литр). Энэ бол хэрэв бондоос (архи, согтууруулах ундаанд ногдуулдаг татварыг урьдчилан төлдөг нэг төрлийн даатгалын хэлбэр) эргүүлэн татсан тохиолдолд 100 нэгж бүхий хатуу чанараас доогуур чанартай дотоодын спиртэд хэрэглэх байсан мөн ижил журам байдаг тул, 100 нэгж бүхий хатуу чанараас доогуур чанартай спиртийн импортыг, 100 нэгж бүхий хатуу чанартай байсан мэтээр үнэлдэг, одоогоор ашиглахаа больсон АНУ-ын арга туршлага юм. Импортлогч нь 100 нэгж бүхий эсвэл түүнээс өндөр хатуу чанартай спирт худалдаж авчаад, дараа нь шингэлэх замаар энэ журмыг тойрч гарах боломжтой. Энэ нь нэг үгээр бол АНУ-д [спиртыг] бөөнөөр импортлож оруулаад тэгээд савлана гэсэн үг юм. Гэсэн хэдий ч үйлчлүүлэгчид нь гарал үүслийн оронд нь савласан спиртыг илүүд үздэг. Хэдийгээр дотоодод ижил төрлийн бүтээгдэхүүнд хандах горимд ямар ч ялгаа байхгүй ч гэсэн энэхүү дүрэм журам нь гадаадын бүтээгдэхүүнийг мухардалд оруулсан байв. Хэрхэн яг ижилхэн албан ёсны үндэсний нөхцөл нь (NT) ялгаварлан гадуурхаж бас болох вэ гэдгийг харуулахын тулд дарсны галлоны үнэлгээг үргэлж дурьддаг байна. Мөн далдуур ялгаварлан гадуурхахыг (implicit discrimination) үзнэ үү.</p>
1479	Wine lake	<p>Дарсны нуур. Энэхүү нэр томьёо нь Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогоор дамжуулан Европт бий болсон дарсны илүүдлийг хэлдэг түгээмэл ярих хэлэх маяг юм.</p>
1480	WIPO (World Intellectual Property Organization)	<p>Дэлхийн Оюуны өмчийн Байгууллага (ДООБ - WIPO). Энэ нь оюуны өмчийн эрхийг хамгаалах, үүгээр дамжуулан инноваци, эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих үүрэгтэй засгийн газар хоорондын гол байгууллага. ДООБ-аас удирдаж буй хамгийн чухал хоёр хэлэлцээр бол Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн конвенц (Paris Convention for the Protection of Industrial Property) болон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (Berne Convention for the Protection of Literary and Artistic Works) юм. WIPO-гийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Женева хотод байрладаг. Мөн Патент олгох журамлалын зорилгоор микро организмуудыг хадгалах газрыг олон улсад хүлээн зөвшөөрөх тухай Будапештийн гэрээ (Budapest Treaty on the International Recognition of the Deposit of Microorganisms for the Purposes of Patent Procedure), ардын аман зохиол (folklore), Женевийн Конвенц (Geneva Convention), Лиссабоны хэлэлцээр (Lisbon Agreement), Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр (Madrid Agreement Concerning the International Registration of Marks), Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх худал ба хуурамч үзүүлэтүүдийг таслан зогсоох Мадридын хэлэлцээр (Madrid Agreement for the Repression of False or Deceptive Indications of Source on Goods), ёс суртахууны эрх (moral rights), Патентын хамтын ажиллагааны тухай олон улсын гэрээ (Patent Cooperation Treaty) болон Ромын конвенцийг (Rome Convention) үзнэ үү.</p>
1481	Withdrawal of trade benefits	<p>Худалдааны үр ашгийг халах. Энэ нь худалдааны хориг ногдуулах, эсхүл хариу арга хэмжээ авах гэсэн утгатай илэрхийлэл юм.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1482	Worker rights	<p>Ажилчдын эрх. Энэ нь илүү тэгш шударга худалдааны арга ажиллагаа болон бодлого бий болж байгаатай хамааралтайгаар, АНУ-ын Конгрессийн хэсгүүдээс тодорхойлж гаргасан асуудлууд юм. Зарим засгийн газрууд, АНУ-д хэвийн гэж үздэг нөхцөлүүдийг, өөрсдийн ажиллах хүчинд олгохоос татгалзсанаас болж өрсөлдөөний давуу талыг олж авдаг гэсэн үзэл баримтлал дээр зарим талаараа суурилсан байдаг. Мөн түүнчлэн уг асуудал нь хүний эрхийн илүү ерөнхий цар хүрээ, хэмжигдэхүүнтэй байдаг. Практикт энэхүү хоёр асуудлыг салгахад хэцүү байдаг ч, олон этгээдийн хувьд хүний эрхийн асуудлын тал нь илүү чухал зүйл байдаг. 1988 онд батлагдсан Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хууль (United States Omnibus Trade and Competitiveness Act), Уругвайн үе шатны хэлэлцээрийн тухай хууль (Uruguay Round Agreements Act - URAA) болон бусад АНУ-ын худалдааны хууль тогтоомжид ажилчдын эрх тасралтгүй зөрчигдөж байгаа тохиолдолд, Хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) үр ашгийг буцааж татах зэрэг авч хэлэлцэхээр өгөгдсөн болгоомжтой арга хэмжээнүүдийг зөвшөөрсөн заалтуудыг тусгасан байдаг. Мөн, Худалдаа ба өрсөлдөх чадварын тухай төрөлжүүлэн нэгтгэсэн эмхэтгэл хуульд Америкийн хэлэлцээ хийгч нар мөрдөх шаардлагатай гурван хэлэлцээний зорилтуудыг агуулсан байдаг. Эдгээр нь (i) ажилчдын эрхийг хүндэтгэхийг дэмжих, (ii) ТХЕХ (GATT) болон холбогдох дүрэмд нь ажилчдын эрх хэрхэн харилцан уялдаж байгааг хянан нягталж байх, болон (iii) ажилчдын эрхээс татгалзах нь тухайн улс эсвэл аж үйлдвэрийн салбаруудад нь олон улсын худалдаанд өрсөлдөөний давуу талыг олж авах арга хэрэгсэл болгон ашиглахгүй байх ёстой зарчмыг батлах явдал юм. Хэрэв гадаад улс орон үйл ажиллагааны дараах тасралтгүй хэв шинжийг харуулж байвал, 301-р хэсэг нь АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрыг (USTR) арга хэмжээ авахыг шаарддаг, үүнд (a) ажилчдын эвлэлдэн нэгдэх эрхийг үгүйсгэх, (b) хамтын зохион байгуулалтанд орж хэлэлцээ хийх эрх, (c) ямар нэгэн хүчээр болон албадан хөдөлмөр эрхлэх хэлбэрийг зөвшөөрөх, (d) хүүхдийн хөдөлмөр эрхлэхэд насны доод хэмжээг заагаагүй байх, эсхүл (e) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цаг болон ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартуудыг хангаагүй байх. Уругвайн үе шатны хэлэлцээний тухай хуулийн (URAA) 131-р хэсэгт Олон улсын худалдаа болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ажилчдын эрх хоёрын хоорондын холбоог судлах зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагад (WTO) ажлын хэсэг байгуулахыг Ерөнхийлөгчөөс шаарддаг. Мөн хөдөлмөрийн үндсэн стандарт хэм хэмжээнүүд (core labour standards), нийгмийн шинж чанартай заалт (social clause), худалдаа ба хүний эрх (trade and human rights), болон худалдаа ба хөдөлмөрийн стандартыг (trade and labour standards) үзнэ үү.</p>
1483	Working Group on the Relationship between Trade and Investment	<p>Худалдаа ба хөрөнгө оруулалт хоёрын хоорондын харилцааны талаарх Ажлын хэсэг. 1966 оны 12 дугаар сард ДХБ-ын Сингапур дах Сайд нарын бага хурлаар, худалдаа ба хөрөнгө оруулалт хоёрын хоорондын харилцааг судлан шинжлэх зорилгоор байгуулагдсан.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1484	Working Group on the Interaction between Trade and Competition Policy	Худалдаа ба өрсөлдөөний бодлого хоёрын хоорондын харилцан үйлчлэлийн талаарх ажлын хэсэг. 1996 оны 12 дугаар сард ДХБ-ын Сингапур дах Сайд нарын бага хурлаар, худалдааны бодлого ба өрсөлдөөний бодлого хоёрын хоорондын харилцан үйлчлэлийн асуудлыг судлах зорилгоор байгуулагдсан, үүнд өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа бас орсон байдаг. Үүний гол үүрэг нь ДХБ-ын бүтэц хамрах хүрээнд цаашид тусгагдах шаардлагатай байгаа талбаруудыг тодорхойлох юм. Мөн худалдаа ба өрсөлдөөний (trade and competition) талаар үзнэ үү.
1485	Working Group on Transparency in Government Procurement	Засгийн газрын худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаарх Ажлын хэсэг. 1996 оны 12 дугаар сард ДХБ-ын Сингапур дах Сайд нарын бага хурлаар засгийн газрын худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг судлах чиглэлээр байгуулагдсан бөгөөд энэ нь зохих хэлэлцээрт оруулах бүрэлдэхүүн хэсгийг бэлтгэн гаргасан боловч тэдэнд хэлэлцээр хийх бүрэн эрх үүрэг байдаггүй.
1486	Working Party on Domestic Regulation	Дотоодын эрх зүйн зохицуулалтын талаарх ажлын хэсэг. (Дотоодын зохицуулалтын ажлын хэсэг - Уругвай). Энэ нь 1999 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгийн эрх, үүрэгт Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (General Agreement on Trade in Services) 6 дугаар зүйлийн 4 дүгээр хэсгийг ихээхэн хэмжээнд тусгасан байдаг байна. Энэ нь лиценз авах шаардлага, техникийн стандарт, мэргэжлийн шаардлага, чанарын шаардлага хангах шаардлага зэрэг нь үйлчилгээний худалдаанд шаардлагагүй аливаа саад тотгор бий болгохгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн дэг журмыг боловсруулах үүрэгтэй. Мөн Мэргэжлийн үйлчилгээний талаарх Ажлын хэсгийг (Working Party on Professional Services) үзнэ үү.
1487	Working Party on Professional Services	Мэргэжлийн үйлчилгээний талаарх Ажлын хэсэг (WPPS). (Мэргэжлийн үйлчилгээний ажлын хэсэг - Уругвай). ДХБ-ын уг ажлын хэсэг нь 1995 онд байгуулагдсан байна. Энэхүү ажлын хэсэг нь мэргэжлийн чанарын шаардлага, лиценз болон стандарт хэм хэмжээнд тавигдах шаардлагууд нь мэргэжлийн үйлчилгээний салбарын худалдаанд нэмэгдэл саад тотгор болохгүй байх явдлыг хангахад шаардлагатай дүрмийг судлах буюу энэ талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэжлийн үйлчилгээний худалдаанд саад тотгор болж байгаа эсэхийг нягтлан шалгаж, улмаар олон талт түвшний зохих дүрэм дэглэмийг боловсруулах зорилгоор байгуулагдсан. Маш их хөдөлмөр зарцуулсны дараа Нягтлан бодох бүртгэлийн салбарт харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр буюу зохицуулалтын зааварчилгааг (Guidelines for Mutual Recognition Agreements or Arrangements in the Accountancy Sector) боловсруулж гаргасан. WPPS нь 1999 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүчингүй болж, үүний оронд Дотоодын эрх зүйн зохицуулалтын талаарх ажлын хэсэг гэж байгуулагдсан. Мөн харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг (mutual recognition arrangements) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1488	World Association of Investment Promotion Agencies	Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын дэлхийн холбоо. Энэ нь 1995 оны 4 дүгээр сард НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) ивээл дор байгуулагдсан. Уг холбооны зорилго бол: (a) хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагуудын хооронд харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, (b) хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагуудын хооронд мэдээлэл цуглуулах болон мэдээлэл солилцох систем бэхжүүлэх, (c) хөрөнгө оруулалтыг татах талаар үндэсний болон бүс нутгийн түвшний туршлагаадаас хуваалцах, (d) хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагуудад туслалцаа үзүүлэх зохих агентлагуудтай холбож өгч, тэдэнд техник туслалцаа болон сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, (e) хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд зориулан зохих хоёр-талт болон олон талт агентлагуудад холбож өгөх замаар санхүүжилт болон бусад тусламжаас хүртэх боломжийг хөнгөвчилж өгөх, мөн (f) хөрөнгө оруулалтыг дэмжих зохистой бодлого болон стратегийг боловсруулахад хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагуудад өөрсдийнх нь засгийн газарт зөвлөгөө өгөх замаар туслах зэрэг болно. Энэхүү холбооны Нарийн бичгийн дарга нарын газар нь Женев хотод байрладаг.
1489	World Bank	Дэлхийн Банк. ОУСБХБ - Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкныг (IBRD – International Bank for Reconstruction and Development) үзнэ үү.
1490	World Bank Guidelines on the Treatment of Foreign Direct Investment	Гадаадын шууд хөрөнгө оруулалттай харьцах тухай Дэлхийн Банкны удирдамж. Энэ нь үнэнч шударга байдлаар (good-faith) гадаадын хөрөнгө оруулагчдад засгийн газрын зүгээс хандах хандлагыг шийдвэрлэхийн тулд 1992 оны 9 дүгээр сард батлагдсан сайн дурын багц зарчим юм. Удирдамж нь гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг авч хэлэлцдэггүй байна. Удирдамжийн өргөн хүрээний зорилт нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих явдал юм, учир нь илүү их өрсөлдөөн, хөрөнгийн шилжүүлэг, технологи болон менежментийн ур чадвар, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, болон олон улсын худалдааг өргөжүүлэх замаар хүлээн авагч улсын урт хугацааны үр ашгийг сайжруулах ач холбогдолтой юм. 1 дүгээр зүйлд, ижил төстэй нөхцөл байдалд хөрөнгө оруулагчидтай адил тэгш харьцах, тэдгээрийн хооронд чөлөөт өрсөлдөөн бий болгох нь зэрэг хөрөнгө оруулалтын орчны урьдчилсан нөхцөл гэж үзсэн ерөнхий зарчим дээр уг удирдамж суурилна гэж заасан байна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагч нарт үндэсний хөрөнгө оруулагч нараас илүү хандаарай гэсэн зөвлөмж байхгүй юм. 2 дугаар зүйлд тусгаснаар, хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөх нээлттэй орчныг бий болгохыг зорьж байна. 3 дугаар зүйлд тусгаснаар, бусад аль ч улсын иргэний хөрөнгө оруулалтад шударга, эрх тэгш байдлыг хангах зарчмыг өргөжүүлэхийг уриалдаг. 4 дүгээр зүйлд тусгаснаар, хөрөнгийг албадан хураах болон гэрээнд нэг талын өөрчлөлт хийх эсхүл цуцлах асуудлуудыг авч хэлэлцэх болно. 5 дугаар зүйлд тусгаснаар, маргааныг үндэсний шүүхээр эсхүл бусад тохирсон механизмуудын аль нэгээр дамжуулан, зүй зохистой шийдвэрлэхийг зорьж байна. Мөн Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг (Multilateral Investment Guarantee Agency) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1491	World Customs Organisation	Дэлхийн Гаалийн Байгууллага. Өмнө нь үүнийг Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл (Customs Cooperation Council – CCC) гэж нэрлэдэг байсан. ДГБ нь Брюссель хотод байрладаг бөгөөд энэ нь гаалийн асуудлыг хариуцдаг олон улсын хамтын ажиллагааны үндсэн байгууллага юм. Түүнчлэн ДГБ нь нийцүүлсэн Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийг боловсруулан, удирдаж байдаг бөгөөд мөн Истанбулын Конвенц, Киотогийн Конвенц хоёрыг удирддаг байна.
1492	World Development Report	Дэлхийн хөгжлийн тайлан. Энэ нь Дэлхийн Банкнаас жил бүр нийтэлдэг хөгжлийн үйл явцад онцгой хамааралтай асуудлын талаар гаргадаг тайлан бөгөөд ихэвчлэн Худалдааны бодлогын асуудлаар хэрэгцээтэй судалгаа дүн шинжилгээг агуулдаг байна. Мөн Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг (IBRD – International Bank for Reconstruction and Development) үзнэ үү.
1493	World Economic Forum	Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт. Энэ нь Женев хотод байрладаг, 1971 онд байгуулагдсан хараат бус, ашгийн бус байгууллага бөгөөд өнөөгийн улс төр, нийгэм болон эдийн засгийн асуудлаар судлах зорилгоор улс төрчид, бизнес эрхлэгчид, шинжлэх ухааны эрдэмтэд болон бусад хүрээний хүмүүсийг нэгэн дор хамтад нь цуглуулж чаддаг.
1494	World Food Programme	Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP). Энэхүү байгууллагыг нь анх 1961 онд НҮБ байгуулан, 1963 оны 1 дүгээр сарын 1-ээс үйл ажиллагаа нь эхэлсэн байдаг. WFP -ын гол зорилго нь бага орлоготой, хоол хүнсний хомсдолд орсон улс орнууд болон байгалын гамшгийн улмаас хохирсон хүмүүст хүнсний тусламж үзүүлэхэд чиглэсэн байдаг. Түүнчлэн энэхүү зорилгоос гадна, тусалж буй улс орнуудынхаа эдийн засаг болон нийгмийн хөгжилд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай (Food and Agricultural Organisation) нягт хамтран ажилладаг бөгөөд WFP-ийн удирдлага нь Ром хотод байрладаг байна.
1495	World Investment Report	Дэлхийн Хөрөнгө оруулалтын тайлан. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын (UNCTAD) Хөрөнгө оруулалт, технологи, холбогдох санхүүгийн үйлчилгээний комиссоос (Commission on Investment, Technology and Related Financial Services) жил бүр дэлхийн хөрөнгө оруулалтын хандлагууд болон түүнтэй холбоотой асуудлаар гаргадаг тайлан юм. Үүнд маш их хэрэгцээтэй судалгаа, шинжилгээний үр дүнг агуулсан байдаг бөгөөд сүүлийн үед хэвлэгдэн гарсан дугаарууд нь уншихад илүү хялбар болсон. Зарим үед, хөгжиж буй орнуудад тулгарч буй зарим асуудлуудыг үндэстэн дамнасан корпорациудын (transnational corporations) авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлээгүй арга хэмжээтэй холбон тайлбарласан хэвээр байдаг боловч одоо бол ерөнхийдөө, уг тайлан болон олон хөгжиж буй орнуудын зүгээс эдгээр корпорациудын хийж буй гадаадын хөрөнгө оруулалтыг сайн зүйл гэж үзэж байна.
1496	World Organisation for Animal Health	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага. Мөн Эпизоотик буюу амин тахлын олон улсын албыг (International Office of Epizootics) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1497	World Summit for Social Development:	Нийгмийн хөгжлийн төлөөх дэлхийн дээд хэмжээний уулзалт. Копенхагений тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөрийг (Copenhagen Declaration and Programme of Action) үзнэ үү.
1498	WTO (World Trade Organization)	Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ – WTO). Дэлхийн худалдааны байгууллагыг 1995 оны 1-р сарын 1-нд Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (GATT) ба түүний Нарийн бичгийн дарга нарын газрынх нь залгамжлагч болгож байгуулсан. GATT гэдэг бол одоо ДХБ-ын удирдаж байдаг хэлэлцээрүүдийн нэг юм. ТХЕХ-ээс гадна, ДХБ-аас удирдан хэрэгжүүлж байдаг хоёр үндсэн хэлэлцээр бол Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр [YXEX] (General Agreement on Trade in Services) болон Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights) юм. ДХБ нь ойролцоогоор 130 орчим гишүүдтэй юм. ДХБ нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болон оюуны өмчийг хамарсан худалдааны асуудлуудыг харилцан хэлэлцэж, хэлэлцээ хийн мөн шийдвэр гаргах зорилготой байгууллага юм. Үүний онцгой чухал чиг үүргүүд нь ДХБ-ыг бүрдүүлж буй олон талт болон харьцангуй олонхийн худалдааны хэлэлцээрүүдийг удирдаж, хэрэгжүүлэх, олон талт худалдааны хэлэлцээнүүдэд зориулсан яриа хэлэлцээний талбарын үүрэг гүйцэтгэх, худалдааны маргааныг шийдвэрлэхийг эрэлхийлэх, үндэсний худалдааны бодлогуудыг нягтлан дүгнэх, болон дэлхийн эдийн засгийн бодлого боловсруулахад оролцдог бусад олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм. Дэлхийн худалдааны байгууллага нь хэрхэн ажилладаг талаар хамгийн хэрэгтэй тайлбар мэдээллийг www.wto.org албан ёсны цахим хуудасны “Ирээдүйн худалдаа” хэсгээс сонирхоно уу. Мөн Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийг (Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation) үзнэ үү.
1499	WTO Agreement	Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээр. Мөн Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийг (Marrakesh Agreement Establishing the World Trade Organisation) үзнэ үү.
1500	WTO built-in agenda	Дэлхийн Худалдааны Байгууллагын салшгүй хэсэг нь болсон хөтөлбөр. Мөн Салшгүй хэсэг нь болсон хөтөлбөрийг (built-in agenda) үзнэ үү.
1501	WTO Ministerial Conference	ДХБ-ын Сайд нарын бага хурал. Энэ нь ДХБ-ын бүх гишүүдийн төлөөлөгчдөөс бүрдэх Сайд нарын түвшний бага хурлыг зохион байгуулах бөгөөд бага хурал нь хоёр жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Сайд нарын бага хурал нь, өөрийн эрх мэдлийн харьяаллын хүрээнд, олон талт худалдааны аль ч хэлэлцээрийн хүрээнд хамаарах бүх асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна. Мөн Сиатл дах Сайд нарын бага хурал (Seattle Ministerial Conference) болон Сингапур дах Сайд нарын бага хурлыг (Singapore Ministerial Conference) үзнэ үү.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1502	WTO plurilateral trade agreements	<p>ДХБ-ын Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээр. Эдгээр нь Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтад (Annex 4) орсон хэлэлцээрүүд. Үүнд: Иргэний агаарын тээврийн онгоц худалдаалах тухай хэлэлцээр (Agreement on Trade in Civil Aircraft), Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр (Agreement on Government Procurement), Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр (International Dairy Agreement), Үхрийн махны асуудлаарх олон улсын хэлэлцээр (International Bovine Meat Agreement) зэрэг хэлэлцээрүүд ордог. Токио дах үе шатны хэлэлцээний үеэр эдгээр хэлэлцээрүүдийг анх "төрөлжүүлэн нэгтгэсэн хууль тогтоомжийн акт" ("codes") гэх нэрэн дор хэлэлцэж байсан. Эдгээр нь хамрах салбар тус бүрт зориулсан нэмэлт журмуудыг агуулдаг. Уг хэлэлцээрт гишүүнээр элсэж орох нь ДХБ-д гишүүнээр элсэх урьдчилсан нөхцөл биш юм. Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр болон Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээрүүд нь 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс цуцлагдаж, улмаар 4-р хавсралтаас хасагдсан байна. Мөн Токиогийн үе шатны хэлэлцээрийг (Tokyo Round agreements) үзнэ үү.</p>
1503	WTO understanding on dispute settlement	<p>Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг. (Маргааныг шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг - Уругвай). Энэ бол Уругвайн үе шатны яриа хэлэлцээний үр дүнгийн нэг юм. Үүний гол сэдэв нь маргааныг хурдан шийдвэрлэх нь ДХБ-ын зохих ёсоор ажиллахад чухал үүрэгтэй юм. Иймд харилцан ойлголцох баримт бичиг нь маргааныг шийдвэрлэхэд мөрдөх журам, цаг хугацааг нарийвчлан тодорхойлж өгдөг. Хойшлуулах тактикийн хувьд боломж бага байдаг. Маргааныг шийдвэрлэх эхний шат нь талуудын хоорондын хэлэлцүүлгээс бүрдэж болох бөгөөд тэд ДХБ-ын Ерөнхий захирлыг уг асуудалд зуучлахыг уриалж болно. Хэрэв хэлэлцүүлэг нь амжилтанд хүрэхгүй бол Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн зөвлөлийг (panel) бараг автоматаар байгуулдаг. Хэрвээ талууд Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн/хөндлөнгийн хэсгийн судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол тэд давж заалдах шатны байгууллагад (Appelite Body)давж заалдаж болно, гэвч тийнхүү давж заалдах үндэслэл нь хууль эрх зүйн асуудлаар хязгаарлагдах ёстой. Зарим нь шинэ механизмын автоматчилагдсан байдал нь ДХБ-д динамик "шүүхийн хэрэг"-ийг (case law) бий болгоход хүргэх магадлалтай гэж үзэж байгаа боловч, энэ нь одоогоор нотлогдоогүй байна.</p> <p>Маргаан шийдвэрлэх байгууллагын (МШБ) зөвлөмж буюу шийдвэр нь хамрагдсан хэлэлцээрүүдэд тусгагдсан эрх, үүргийг өргөжүүлэх, эсхүл багасгах ёсгүй. МШБ нь хөндлөнгийн зөвлөл (маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн - Panel) байгуулах, хөндлөнгийн хэсэг болон давж заалдах шатны байгууллагын (Appelite Body) илтгэлийг батлах, шийдвэр буюу зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих болон хамрагдсан хэлэлцээрийн дагуух буулт болон үүрэг амлалтыг зогсоох асуудлыг шийдвэрлэх эрх эдлэнэ.</p>

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1504	X-ing out	Чагтлан тэмдэглэх буюу хэрэгсэхгүй болгох. Энэ нь зарим нэгэн бусад асуудлууд шийдэлд хүрэх хүртэл, хэлэлцээний зарим хэсгийг нь түр орхих шийдвэр (carve-out) эсвэл орхих талаар шийдвэр гаргах гэсэн утгатай.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1505	Yaounde Convention	Яунде дах Конвенц. Энэ нь Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг болон Африкийн арван найман хөгжиж буй орнуудын хооронд байгуулсан худалдаа, эдийн засгийн хүрээнд ашиг тус үзүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр юм. Энэ нь 1963 оны 7 дугаар сарын 20-нд байгуулагдсан бөгөөд дараа нь 1975 онд Ломе дах Конвенцоор (Lome Convention) солигдсон.

--- O ---

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1506	Zero binding	Үүрэг хүлээсэн, заавал биелүүлэх “0” тариф. Энэ нь тодорхой заасан бүтээгдэхүүнүүдэд ногдуулсан гаалийн тарифыг бүхэлд нь тэглэхээр ДХБ-ын өмнө хуулиар хүлээсэн үүрэг амлалт.
1507	Zero-for-zero tariff reductions	Тэг-байвал-тэг болгож тарифыг бууруулах. Энэ бол эм, эм зүйн бүтээгдэхүүн болон модон эдлэл гэх мэт бүхэл бүтэн салбарт харилцан адил байх нөхцөлд тулгуурлан тарифыг тэг болгож бууруулах зорилтод [хэлэлцээрийн] талууд нэгдсэн байдаг, тарифыг бууруулахад хүргэх хүсэлт гаргах/санал болгох тогтолцоо юм.
1508	Zero-margin harmonisation	Тэг ашигтайгаар уялдуулсан зохицуулалт. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагааны нэг эсвэл түүнээс олон чиглэлээр хууль тогтоомж, дүрэм журам, стандарт гэх мэтийг бүрэн дүүрэн уялдуулж нийцүүлсэн тийм нөхцөл байдал юм.
1509	Zero option	Тэг сонголт. Энэ нь ихэвчлэн арван жилийн хугацаанд хөдөө аж ахуйн худалдаа, эсхүл үйлдвэрлэлийг гажуудуулж байгаа бүх төрлийн татаасыг арилгасан байх ёстой гэсэн уриалгыг, хөдөө аж ахуйн чиглэлээр хийгдсэн Уругвайн үе шатны яриа хэлэлцээний үеэр АНУ-ын зүгээс гаргасан саналтай хамаатуулан эшлэсэн байдаг.
1510	Zero-price knowledge	Тэг үнийн тухай мэдлэг. Энэ нь оюуны өмчийг хамгаалах үндэслэлийн нэг хэсэг болгон ашигладаг ойлголт. Хэрэв мэдлэг үргэлж үнэгүй байвал, жишээ нь тэг үнээр олдох боломжтой байдаг бол, мэдлэгийн санд нэмж мэдлэг нэмэрлэх үйлсийг шагнаж урамшуулахгүйгээс хойш урамшил илүү багатай байх болно. Оюуны өмчийн эрхийг хамгаалах замаар мэдлэгийг үүсгэн бий болгогч нарт тэтгэлэг олгох нь тэрхүү урамшууллыг олгож өгөх болно.
1511	Zero rating	Тэг үнэлгээ. Энэ нь ямар нэгэн гаалийн татвар ногдуулдаггүй улс руу орж ирэх бараа бүтээгдэхүүнүүдийг татаж байдаг гэж үздэг.
1512	Zero-sum nationalism	Нийлбэр нь тэг буюу ямар нэгэн эцсийн ялагч үгүй үндсэрхэг үзэл. Энэ нь, олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаа явагдаж байх үед улс орнууд нэг бол ялж нэг бол ялагддаг гэсэн ойлголт юм. Хэдий түр хугацаанд ч гэсэн өөр нэг улсын ялалт нь харьцуулалт хийж буй бас нэг улсын хувьд алдагдал гэж авч үздэг. Энэ нь үндсэндээ, худалдаа арилжааны зорилгыг мөнгөн зоос болон гадаад валютыг хуримтлуулж, аж үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг дээд зэргээр нэмэгдүүлж, аж үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүний импортыг хамгийн доод хэмжээнд байлгах зорилготой гэж үздэг, илүү өргөн хүрээтэй, илүү улс төрийн шинж чанартай, худалдаа арилжааг үндэслэж байгаа ойлголтыг дахин батлан илэрхийлж буй хэлбэр юм. Энэ нь олон улсын хөдөлмөрийн хуваарилалт болон олон улсын эдийн засгийн даяршлын нөлөөгөөр дамжин ирэх боломжтой үр ашгийг бүхэлд нь үл ойшоодог байна.

Д/д	Англи нэр томьёо	Монгол нэр томьёо ба тайлбар
1513	Zollverein	<p>Золверейн. 19-р зууны үеийн Герман улсуудын гаалийн холбоо. Энэ нь хэд хэдэн орон нутгийн гаалийн холбоодыг нэгтгэх замаар 1834 онд Пруссийн удирдлага дор байгуулж байсан байна. Шинээр байгуулагдсан Германы эзэнт гүрэнд үүнийг багтаах үед буюу 1871 он хүртэл бусад Герман улсуудыг нэгтгэх замаар үүний өсөлт үргэлжилсээр байсан байна. Золверейнийг 13-р зууны эхний хагаст Германы эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг. Гэсэн хэдий ч, түүний эхний жилүүд Герман дахь аж үйлдвэрийн хувьсгалтай давхцаж байсан тул, хэдийгээр маш бодитой байсан ч, түүний эдийн засгийн хөгжилд оруулсан бодит хувь нэмрийг үнэлж дүгнэхэд хэцүү байдаг. Мөн гаалийн холбоог үзнэ үү.</p>

---- O ---

